Шигтгээ 1.4.1. ТХЗ-4.3-ыг хангах арга замын нэгэн хувилбар.....	169
Шигтгээ 1.4.2. Жендэрийн тэгш байдлыг хангах арга замын зарим хувилбар.....	172
Шигтгээ 1.4.3. Үл алагчлалыг хангах арга замын зарим хувилбар.....	173
Шигтгээ 2.1.1. Дохионы хэлний сургалт зохион байгуулсан тухай.....	209
Шигтгээ 2.1.2. Тайгын иргэдэд тэтгэмж олгох тухай.....	216
Шигтгээ 2.1.3. Тува хэлний сургалтын тухай.....	218
Шигтгээ 2.1.4. Аав нарт гарсан дам үр дүн.....	221

### Хавсралтын жагсаалт

Хавсралт 1.1.1. Мастер төлөвлөгөөнд туссан СӨБ-ын талаарх зорилтуудын хэрэгжилт 2009, 2015... 360	360
Хавсралт 1.1.2. “Тогтвортой хөгжил - Сургуулийн өмнөх боловсрол” үндэсний зөвлөгөөнөөс гарсан саналын матриц.....	364
Хавсралт 1.1.3. СӨБ-ын хамран сургалтын цэвэр, бохир жин (2006/07-2017/18 оны хичээлийн жил) ....	368
Хавсралт 1.1.4. СӨБ-ын суралцагч (2006/07-2017/18 оны хичээлийн жил).....	368
Хавсралт 1.1.5. СӨБ-ын хамран сургалтын бохир жин (2006/07-2017/18 оны хичээлийн жил).....	369
Хавсралт 1.1.6. СӨБ-ын бүлэг дүүргэлт (2006/07-2017/18 оны хичээлийн жил).....	369
Хавсралт 1.1.7. СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн тоо, бүлгийн тоо (2006/07-2017/18 оны хичээлийн жил).....	369
Хавсралт 1.2.1. Цогц чадамжуудын харгалзаа.....	370
Хавсралт 1.2.2. ЕБС-д мөрдөгдсөн сургалтын төлөвлөгөөнүүдийн агуулгын үндсэн бүтцийн харьцуулалт (1998-2018).....	375

<i>Хавсралт 1.2.3. Ерөнхий боловсролын сургуулийн тоо (өмчийн хэлбэр, ангилал, байршил, оноор) (2006/07-2017/18 оны хичээлийн жил)</i> .....	378
<i>Хавсралт 1.2.4. БДБ-ын элсэлтийн жин (бохир, цэвэр жин, он, түвшингээр) (2006/07-2017/18 оны хичээлийн жил)</i> .....	378
<i>Хавсралт 1.2.5. БДБ-ын хамран сургалт (Цэвэр, бохир жин, түвшин, оноор) (2006/07-2017/18 оны хичээлийн жил)</i> .....	379
<i>Хавсралт 1.2.6. Дотуур байранд амьдарч буй суралцагчид (2006-2017, малчдын хүүхэд, хөгжлийн бэрхиээлтэй суралцагч, оноор)</i> .....	380
<i>Хавсралт 1.2.7. БДБ-ын төгсөлтийн хувь (түвшин, хүйс, оноор) (2006/07-2017/18 оны хичээлийн жил)</i> .....	380
<i>Хавсралт 1.2.8. БДБ-ын цөм хөтөлбөр</i> .....	381
<i>Хавсралт 1.2.9. ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнүүдийн агуулгын үндсэн бүтцийн харьцуулалт (1998-2018)</i> .....	381
<i>Хавсралт 1.2.10. БДБ-ын сургалтын төлөвлөгөө</i> .....	383
<i>Хавсралт 1.2.11. БДБ-ын стандарт ба сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандарт хоорондын харгалзаа</i> .....	384
<i>Хавсралт 1.2.12. БДБ-ын сурах бичгийн талаар баримтлах бодлого, чиглэл ба журмын жагсаалт (1998-2009)</i> .....	385
<i>Хавсралт 1.3.1. Магадлан итгэмжлэл нь хүчинтэй байгаа сургууль, сургалтын хөтөлбөрүүдийн нэр (2013 оны 9 сарын байдлаар)</i> .....	387
<i>Хавсралт 1.3.2. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт тавьсан сургалтын байгууллагын нэр (2017.04.27 байдлаар)</i> .....	387
<i>Хавсралт 1.4.1. ДБСБ-ын тоо, магадлан итгэмжлэгдсэн ДБСБ-ын хувь (2006/07-2018/19 оны хичээлийн жил)</i> .....	388
<i>Хавсралт 1.4.2. ДБСБ-д шинээр элсэгчдийн тоо: Бүс нутаг, боловсролын түвшингээр (2006-2018)</i> .....	388
<i>Хавсралт 1.4.3. ДБСБ-д тухйн мэргэжилээр суралцагчдын эзлэх хувь (2006-2018)</i> .....	388
<i>Хавсралт 1.4.4. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцагчид: Элсэн оноор (2012-2018)</i> .....	389
<i>Хавсралт 1.4.5. Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу 2018 онд гадаадын их, дээд сургуульд элсэгчдийн тоо (улс орноор)</i> .....	389
<i>Хавсралт 1.4.6. ДБСБ-д суралцагчдын тоо: Бүс нутгаар (2010/11-2018/19 оны хичээлийн жил)</i> .....	390
<i>Хавсралт 1.4.7. Монгол Улсын Засгийн газрын шугамаар гадаадад суралцагчидын тоо (2012-2018)</i> .....	390
<i>Хавсралт 1.4.8. ДБСБ-д суралцагчдын тоо: Боловсролын зэргээр (2006/07-2018/19 оны хичээлийн жил)</i> .....	390
<i>Хавсралт 1.4.9. ДБСБ-д суралцагчдын тоо: Насны ангилалаар (2006/07-2018/19 оны хичээлийн жил)</i> ..	390
<i>Хавсралт 1.4.10. Гадаададын улс орноос Монголын ДБСБ-д суралцагчдын тоо: Боловсролын зэргээр, сургалтын төлбөрийн эх үүсвэрээр (2008/09-2012/13 оны хичээлийн жил)</i> .....	391
<i>Хавсралт 1.4.11. ДБСБ-ыг төгсөгчдийн тоо: Боловсролын зэргээр (2013/14-2017/18 оны хичээлийн жил)</i> ..	391
<i>Хавсралт 1.4.12. ДБСБ-д нийт ажиллагчдын тоо: Өмчийн хэлбэр, байршлаар (2014/15-2018/19 хичээлийн жил)</i> .....	391
<i>Хавсралт 1.4.13. ДБСБ-ын үндсэн багшийн тоо: Өмчийн хэлбэрээр (2014/15-2018/19 хичээлийн жил)</i> ..	391
<i>Хавсралт 1.4.14. ДБСБ-ын үндсэн багшийн нас (2014/15-2018/19 оны хичээлийн жил)</i> .....	391
<i>Хавсралт 1.4.15. ДБСБ-ын багш оюутны тооны харьцаа (2014/15-2018/19 оны хичээлийн жил)</i> .....	391
<i>Хавсралт 1.4.16. Бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ (2014/15-2018/19 оны хичээлийн жил)</i> .....	392
<i>Хавсралт 1.5.1. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхиээлтэй хүүхдийн тоо: Аймаг, дүүргээр</i> .....	392
<i>Хавсралт 1.5.2. Албан бус болон насан туршийн боловсролын үйлчилгээний эрх зүйн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн бодлогын матриц</i> .....	393
<i>Хавсралт 1.5.3. Албан бус болон насан туршийн боловсролын үйл ажиллагаа, үйлчилгээг бий болгоход чиглэсэн бодлогын матриц</i> .....	394
<i>Хавсралт 1.5.4. Албан бус боловсролын салбарын эрх зүйн үндэс</i> .....	397
<i>Хавсралт 1.5.5. Аймаг, дүүргийн насан туршийн боловсролын төвүүдийн байрны судалгаа</i> .....	399
<i>Хавсралт 1.5.6. Аймаг, дүүргийн насан туршийн боловсролын төвүүдийн материаллаг баазын судалгаа</i> ..	400
<i>Хавсралт 1.5.7. Аймаг, дүүргийн НТБ-ын багш боловсон хүчний мэдээлэл</i> .....	401
<i>Хавсралт 1.5.8. Хэрэгжүүлсэн төслүүд (1997-2018)</i> .....	402
<i>Хавсралт 2.1.1. Эрх зүйн акт, баримт бичиг</i> .....	409

<i>Хавсралт 2.3.1. Мэргэжлийн багшийн хангалтын хувь, мэргэжлээр (2018 оны байдлаар) .....</i>	<i>413</i>
<i>Хавсралт 2.3.2. ЕБС-ийн багш нарын боловсролын түвшин (2012/13-2017/18 оны хичээлийн жил).....</i>	<i>413</i>
<i>Хавсралт 2.3.3. ЕБС-ийн багшийн мэргэжлийн зэрэг (2012/13-2017/18 оны хичээлийн жил).....</i>	<i>414</i>
<i>Хавсралт 2.3.4. ЕБС-ийн багш нарын боловсролын түвшин (2017/18 оны хичээлийн жил).....</i>	<i>414</i>
<i>Хавсралт 2.3.5. ЕБС-ийн багш нарын мэргэжлийн зэрэг (2017/18 оны хичээлийн жил).....</i>	<i>416</i>
<i>Хавсралт 2.3.6. ЕБС-ийн багш нарын мэргэжлийн зэргийн эзлэх хувь (2017/18 оны хичээлийн жил).....</i>	<i>416</i>
<i>Хавсралт 2.3.7. ЕБС-ийн багш нарын боловсролын түвшин (Аймаг, нийслэлээр) .....</i>	<i>416</i>
<i>Хавсралт 2.3.8. ЕБС-ийн багш нарын боловсролын түвшин (Аймаг, нийслэлд эзлэх тоо ) .....</i>	<i>417</i>
<i>Хавсралт 2.3.9. ЕБС-ийн багш нарын боловсролын түвшин (аймаг, нийслэлд эзлэх хувь) .....</i>	<i>417</i>
<i>Хавсралт 2.4.1. ЕБС, цэцэрлэгийн удирдах ажилтны хүйсийн харьцаа (2010/11-2018/19 оны хичээлийн жил).....</i>	<i>421</i>
<i>Хавсралт 2.4.2. ЕБС, цэцэрлэгийн удирдах ажилтны боловсролын зэрэг (2010/11-2018/19 оны хичээлийн жил).....</i>	<i>421</i>
<i>Хавсралт 2.4.3. ЕБС, цэцэрлэгийн удирдах ажилтны мэргэжлийн зэрэг (2010/11-2018/19 оны хичээлийн жил).....</i>	<i>422</i>
<i>Хавсралт 2.4.4. Цэцэрлэгийн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэлт (2010/11-2018/19 оны хичээлийн жил).....</i>	<i>422</i>
<i>Хавсралт 2.4.5. ЕБС-ийн удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэлт (2014/15-2018/19 оны хичээлийн жил).....</i>	<i>423</i>
<i>Хавсралт 2.4.6. ЕБС-ийн удирдах ажилтны мэргэжлийн чиглэл (2019 оны байдлаар).....</i>	<i>424</i>
<i>Хавсралт 2.4.7. МБС-ын удирдах ажилтны зарим мэдээлэл (2019 оны байдлаар).....</i>	<i>424</i>
<i>Хавсралт 2.5.1. Боловсролын салбар дахь МХХТ-ийн хөгжлийн бодлого, эрх зүйн баримт бичгүүдийн жагсаалт.....</i>	<i>425</i>
<i>Хавсралт 2.5.2. Интернет холбогдсон цэцэрлэгийн тоо: Бүсээр, аймгаар (2006-2017).....</i>	<i>429</i>
<i>Хавсралт 2.5.3. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн багш, компьютерийн харьцаа: Бүсээр, аймгаар (2006-2017).....</i>	<i>430</i>
<i>Хавсралт 2.5.4. Интернетэд холбогдсон сургуулийн тоо: Бүсээр, аймгаар (2006-2017) .....</i>	<i>431</i>
<i>Хавсралт 2.5.5. ЕБС дэх нэг компьютерт ногдох сурагчдын тоо: Бүсээр, аймгаар (2006-2017) .....</i>	<i>432</i>
<i>Хавсралт 2.5.6. ЕБС-ийн сургалтад хэрэглэгдэж буй компьютерын тоо: Бүсээр, аймгаар (2006-2017) ....</i>	<i>433</i>
<i>Хавсралт 2.5.7. ЕБС-ийн нэг компьютерт ногдох багшийн тоо: Бүсээр, аймгаар (2006-2017).....</i>	<i>434</i>
<i>Хавсралт 2.5.8. ЕБС-ийн багш нарын МХХТ ашиглах чадварын үнэлгээ: (2018 оны байдлаар, 1-7 оноогоор) .....</i>	<i>435</i>
<i>Хавсралт 2.5.9. Багшийн хөгжил портал сайтад байришиж буй агуулгын тоо: Судлагдахуунаар (2019 оны 01 сарын 25-ны өдрийн байдлаар).....</i>	<i>437</i>
<i>Хавсралт 2.5.10. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт МХХТ дахь агуулгаар сургалтад хамрагдсан багш, ажилтны тоо (2013-2018).....</i>	<i>437</i>
<i>Хавсралт 2.5.11. МХХТ-ийн чиглэлээр сургалт явуулах эрх олгогдсон төрөлжсөн сургалтын хөтөлбөрүүд (2015-2018) .....</i>	<i>437</i>

### Товчилсон үгийн жагсаалт

<b>№</b>	<b>Товчилсон нэр</b>	<b>Тайлбар</b>
1.	ААН	Аж Ахуйн Нэгж
2.	ААНБ	Аж, Ахуйн Нэгж Байгууллага
3.	АББ	Албан Бус Боловсрол
4.	АББЗСҮТ	Албан Бус Боловсрол, Зайны Сургалтын Үндэсний Төв
5.	АБСХЭ	Албан Бус Салбарт Хөдөлмөр Эрхлэгчид
6.	АИХ	Ардын Их Хурал
7.	АНУ	Америкийн Нэгдсэн Улс
8.	АХБ	Азийн Хөгжлийн Банк
9.	АХИС	Английн Хүүхдийг Ивээх Сан
10.	АЦБ	Ариун Цэврийн Байгууламж
11.	БАЗТ	Бүсийн Арга Зүйн Төв
12.	ББ	Бага Боловсрол
13.	БДБ	Бүрэн Дунд Боловсрол
14.	БЗС	Боловсролын Зээлийн Сан
15.	БМДИ	Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт
16.	БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөл
17.	БНБ	Бүх Нийтийн Боловсрол
18.	БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
19.	БНПУ	Бүгд Найрамдах Польш Улс
20.	БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
21.	БНУУ	Бүгд Найрамдах Унгар Улс
22.	БНХ	Бага Насны Хүүхэд
23.	БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
24.	БНХХ	Бага Насны Хүүхдийн Хөгжил
25.	БОНХАЖЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын Яам
26.	БОНХЯ	Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам
27.	БОУСА	Боловсролын Олон Улсын Стандарт Ангилал
28.	БСГ	Боловсрол, Соёлын Газар
29.	БСМС	Боловсролын Салбарын Мэдээллийн Систем
30.	БСМТ	Боловсролын Суурь Мэдээллийн Тайлан
31.	БСС	Боловсролын Судлалын Сургууль
32.	БСУГ	Боловсрол, Соёл, Урлагийн Газар
33.	БСХХ	Боловсролын Салбарын Хөгжлийн Хөтөлбөр
34.	БСШУСЯ	Боловсрол, Соёл Шинжлэх Ухаан, Спортын Яам
35.	БСШУЯ	Боловсрол, Соёл Шинжлэх Ухааны Яам
36.	БУМС	Боловсролын Удирдлагын Мэдээллийн Систем
37.	БҮТ	Боловсролын Үнэлгээний Төв
38.	БХ	Боловсролын Хүрээлэн
39.	БХАН	Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
40.	БХХ	Боловсролын Хөгжлийн Хөтөлбөр
41.	БШУЯ	Боловсрол, Шинжлэх Ухааны Яам
42.	ГОУХАН	Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
43.	ГХЯ	Гадаад Харилцааны Яам
44.	ГЯ	Гэгээрлийн Яам
45.	ДБ	Дээд Боловсрол
46.	ДБСБ	Дээд Боловсролын Сургалтын Байгууллага
47.	ДБХС	Дэлхийн Байгаль Хамгаалах Сан
48.	ДБШТ	Дээд Боловсролын Шинэчлэлийн Төсөл



49. ДГХБО	Далайд Гарцгүй Хөгжиж Буй Орнууд
50. ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
51. ДХ	Дүйцсэн Хөтөлбөр
52. ДХН	Дэлхийн Худалдааны Байгууллага
53. ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
54. ЕАБХАБ	Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага
55. ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
56. ЖАЙКА	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
57. ЖДӨ	Жилийн Дундаж Өөрчлөлт
58. ЗГ	Засгийн Газар
59. ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
60. ИБУИНВУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
61. ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
62. ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
63. МАХН	Монгол Ардын Хувьсгалт Нам
64. МБС	Мэргэжлийн Боловсрол, Сургалт
65. МБСБ	Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Байгууллага
66. МБСБДС	Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Байгууллагыг Дэмжих Сан
67. МБСБЗГ	Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар
68. МБСДС	Мэргэжлийн Боловсролын Сургалтыг Дэмжих Сан
69. МБСҮЗ	Мэргэжлийн Боловсрол, Сургалтын Үндэсний Зөвлөл
70. МННХ	Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн
71. МСК	Мянганы Сорилтын Корпорац
72. МССМ	Мянганы Сорилтын Сан-Монгол
73. МСТК	Монгол-Солонгосын Техникийн Коллеж
74. МСҮТ	Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн Төв
75. МУБИС	Монгол Улсын Боловсролын Их Сургууль
76. МУЗГ	Монгол Улсын Засгийн Газар
77. МУИС	Монгол Улсын Их Сургууль
78. МУУХТХҮБ	Монгол Улсын Урт Хугацааны Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал
79. МХГ	Мэргэжлийн Хяналтын Газар
80. МХЗ	Мянганы Хөгжлийн Зорилт
81. МХСТӨК	Мэдээлэл Харилцааны Сүлжээ Төрийн Өмчит Компани
82. МХХТ	Мэдээлэл Харилцаа, Холбооны Технологи
83. НБГ	Нийслэлийн Боловсролын Газар
84. НДШ	Нийгмийн Даатгалын Шимтгэл
85. ННФ	Нээлттэй Нийгэм Форум
86. НТБ	Насан Туршийн Боловсрол
87. НТБҮТ	Насан Туршийн Боловсролын Үндэсний Төв
88. НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
89. НХ	Нийгмийн Хамгаалал
90. НХХЯ	Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам
91. ОТ ХХК	Оюу Толгой ХХК
92. ОУБ	Олон Улсын Байгууллага
93. ОУВС	Олон Улсын Валютын Сан
94. ОХУ	Оросын Холбооны Улс
95. РД	Регистрийн Дугаар
96. СӨБ	Сургуулийн Өмнөх Боловсрол
97. СӨББ	Сургуулийн Өмнөх Боловсролын Байгууллага
98. СӨБҮХ	Сургуулийн Өмнөх Боловсролын Үндэсний Хөтөлбөр


99. СӨН	Сургуулийн Өмнөх Нас
100. СЯ	Сангийн Яам
101. ТББ	Төрийн Бус Байгууллага
102. ТВ	Телевиз
103. ТМБ	Техник Мэргэжлийн Боловсрол
104. ТМБС	Техник, Мэргэжлийн Боловсрол, Сургалт
105. ТМС	Техник Мэргэжлийн Сургууль
106. ТХ	Тогтвортой Хөгжил
107. ТХБ	Тогтвортой Хөгжлийн Боловсрол
108. ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилго
109. ТХЗБ	Тогтвортой Хөгжлийн Зорилгын Төлөөх Боловсрол
110. ТХТБ	Тогтвортой Хөгжлийн Төлөө Боловсрол
111. ТХХ	Тусгай Хэрэгцээт Хүүхэд
112. ТХХТ	Төр Хувийн Хэвшлийн Түншлэл
113. УАӨҮЙ	Уур Амьсгалын Өөрчлөлтийн Үнэлгээний Илтгэл
114. УБ	Улаанбаатар
115. УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
116. УИХ	Улсын Их Хурал
117. УМХГ	Улсын Мэргэжлийн Хяналтын Газар
118. ҮБСЗ	Үндэсний Бүтээмж Стандартын Зөвлөл
119. ҮНБ	Үндэсний Нийт Бүтээгдэхүүн
120. ҮСГ	Үндэсний Статистикийн Газар
121. ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
122. ХАА	Хөдөө Аж Ахуй
123. ХАС	Хүн Амын Сан
124. ХАХНХЯ	Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яам
125. ХБИ	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэн
126. ХБИЭТК	Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэний Эрхийн Тухай Конвенц
127. ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
128. ХБХ	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэд
129. ХБХЭТХ	Хөгжлийн Бэрхшээлтэй Хүний Эрхийн Тухай Хууль
130. ХДХВ/ДОХ	Хүний Дархлал Хомсдлын Вирус/Дархлалын Олдмол Хомсдол
131. ХЗДХЯ	Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам
132. ХЗЗМНС	Хөдөлмөрийн Зах Зээлийн Мэдээллийн Нэгдсэн Систем
133. ХИС	Хүүхдийг Ивээх Сан
134. ХНХ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгаалал
135. ХНХСИ	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Судалгааны Институт
136. ХНХЯ	Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам
137. ХС	Хүүхдийн Сан
138. ХХИ	Хүний Хөгжлийн Илтгэл
139. ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани
140. ХЭДС	Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сан
141. ХЭҮГ	Хүний Эрхийн Үндэсний Комисс
142. ЧСС	Чадамжид Суурилсан Сургалт
143. ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
144. ШУТС	Шинжлэх Ухаан Технологийн Сан
145. ШХА	Швецарийн Хөгжлийн Агентлаг
146. ЭЕШ	Элсэлтийн Ерөнхий Шалгалт
147. ЭЗИХА	Эдийн Засгийн Идэвхтэй Хүн Ам
148. ЭЗХЯ	Эдийн Засгийн Хөгжлийн Яам


149. ЭМ	Эрүүл Мэнд
150. ЭМНХЯ	Эрүүл Мэнд, Нийгмийн Хамгааллын Яам
151. ЭМХТ	Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв
152. ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
153. ЭША	Эрдэм Шинжилгээний Ажилтан
154. ЮНЕСКО	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын Байгууллага
155. ЮНИСЕФ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан
156. ЯБҮХ	Ядуурлыг Бууруулах Үндэстний Хөтөлбөр


### Түлхүүр үгийн жагсаалт


№	Монгол	Англи
1.	Албан бус боловсрол	<i>Non formal education</i>
2.	Алсын хараа	<i>Vision</i>
3.	Ахуй, амьдралаас суралцах боловсрол	<i>Informal education</i>
4.	Амьдрах ухааны сургалт	<i>Life skills training</i>
5.	Арга зүй	<i>Methodology</i>
6.	Асуулгын судалгаа	<i>Questionnaire Survey</i>
7.	Байгаль орчин	<i>Natural environment</i>
8.	Бичиг үсгийн дараах сургалт	<i>Post literacy Education</i>
9.	Бичиг үсгийн үндэстний хөтөлбөр	<i>National programme on literacy education</i>
10.	Бичиг үсгийн чадвар	<i>Literacy skills</i>
11.	Бичиг үсэг	<i>Literacy</i>
12.	Бичиг үсэг үл мэдэгч	<i>Illiterate</i>
13.	Бичиг үсэгт тайлагдалтын түвшин	<i>Literacy rate</i>
14.	Бичигтэн/бичиг үсэг мэддэг хүн	<i>Literate</i>
15.	Бодлого	<i>Policy</i>
16.	Боловсролын стандарт	<i>Educational standard</i>
17.	Дам үр дүн (Хүлээгдэж буй үр дүн)	<i>Outcomes</i>
18.	Дүйцсэн хөтөлбөр	<i>Equivalency programme</i>
19.	Задлан шинжилгээ	<i>Analyses</i>
20.	Зайн сургалт	<i>Distance education</i>
21.	Зорилтууд	<i>Objectives</i>
22.	Индикаторууд (илрүүлэгч)	<i>Indicators</i>
23.	Насан туршийн боловсрол	<i>Lifelong education</i>
24.	Насан туршийн суралцахуй	<i>Lifelong learning</i>
25.	Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын түвшин	<i>Adult literacy rate</i>
26.	Насанд хүрэгчдийн боловсрол	<i>Adult education</i>
27.	Насанд хүрэгчдийн сургалт	<i>Adult learning</i>
28.	Насанд хүрэгчдийн тасралтгүй боловсрол	<i>continuing education for adults</i>
29.	Нийц	<i>Relevance</i>
30.	Ногоон хөгжил	<i>Green Development</i>
31.	Нотлох (баримтат үндэслэн) үнэлгээ	<i>Verification</i>
32.	Нөлөөт үр дүн	<i>Impacts</i>
33.	Нээлттэй боловсрол	<i>Open education</i>
34.	Олон янз байдал	<i>Diversity</i>
35.	Оношилгоо	<i>Diagnoses</i>
36.	Оролцоо	<i>Participation</i>
37.	Орчлын нэгдсэн үнэлгээ	<i>Assessment</i>
38.	Стандарттай (загвартай) харьцуулсан үнэлгээ	<i>Benchmarking</i>
39.	Суралцахуйн арга техник	<i>Learning Method and Techniques</i>
40.	Суралцахуйн арга хандлага	<i>Learning Approaches</i>


41.	Суралцахуйн зорилт	<i>Learning Objectives</i>
42.	Суралцахуйн хүлээгдэж буй үр дүн	<i>Learning outcomes</i>
43.	Сургалтын төлөвлөгөө	<i>Syllabus</i>
44.	Сургалтын хөтөлбөр	<i>Curriculum</i>
45.	Сургууль завсардалт	<i>School drop out</i>
46.	Сургууль завсардалтын түвшин	<i>School drop out rate</i>
47.	Сургуульд хамрагдаагүй хүүхдүүд/ сургуулийн гадна байгаа хүүхэд	<i>Out of school children</i>
48.	Сурлагын амжилт (суралцахуйн)	<i>Learning achievements</i>
49.	Тасралтгүй боловсрол	<i>Continuing education</i>
50.	Товлосон зорилтууд	<i>Targets</i>
51.	Тогтвортой байдал	<i>Sustainability</i>
52.	Тогтвортой байдлын түлхүүр цогц чадамж	<i>Key Competencies for Sustainability</i>
53.	Тогтвортой хөгжил	<i>Sustainable Development</i>
54.	Тогтвортой хөгжлийн боловсрол	<i>Education for Sustainable Development</i>
55.	Тогтвортой хөгжлийн боловсролын цогц чадамж	<i>Competencies for ESD</i>
56.	Тогтвортой хөгжлийн зорилгууд	<i>Sustainable Development Goals</i>
57.	Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол	<i>Education for Sustainable Development Goals</i>
58.	Тоймт үнэлгээ	<i>Review</i>
59.	Тохироц (шалтгаалалын логик шалгах)-ын үнэлгээ	<i>Validation</i>
60.	Төвлөрлийг сааруулах	<i>Decentralization</i>
61.	Төвлөрлийг сийрэгжүүлэх	<i>Deconcentration</i>
62.	Төвлөрлийг шилжүүлэх	<i>Devolution</i>
63.	Төслүүд	<i>Projects</i>
64.	Инклюзив боловсрол	<i>Inclusive education</i>
65.	Тэгш байдал/боломж/нөхцөл	<i>Equality</i>
66.	Тэгш бус байдал/нөхцөл	<i>Inequality</i>
67.	Үйлийн бүтэцчилсэн хүрээ	<i>Framework</i>
68.	Үл алагчлах байдал/нөхцөл	<i>Equity</i>
69.	Үл алагчлах шударга	<i>Equitable</i>
70.	Үр дүн	<i>Results</i>
71.	Функционал бичигтэн	<i>Functional literate</i>
72.	Холимог бүлгийн сургалт	<i>Multi-grade teaching</i>
73.	Хөгжлийн зорилго	<i>Goal</i>
74.	Хөтөлбөрүүд	<i>Programs</i>
75.	Хувьсагчид	<i>Variables'</i>
76.	Хүртээмж	<i>Access</i>
77.	Хүрээлэл орчин	<i>Environment</i>
78.	Хэрэгцээ	<i>Needs</i>
79.	Хяналт-шинжилгээ	<i>Monitoring</i>
80.	Чанар	<i>Quality</i>
81.	Чанарын үнэлгээ	<i>Quality assessment</i>
82.	Шалгуур	<i>Criteria</i>
83.	Шалтгаант зорилго	<i>Purpose</i>
84.	Шинж чанар	<i>Characteristic</i>
85.	Шууд үр дүн	<i>Outputs</i>
86.	Эрхэм зорилго	<i>Mission</i>
87.	Явцын төлөв байдал, үе шатуудын үнэлгээ	<i>Evaluation</i>
88.	Ялгаварлах байдал/нөхцөл	<i>Disparity</i>
89.	Ялгаварлан гадуурхах	<i>Discrimanation</i>


 1.1. Сургуулийн өмнөх боловсрол


 1.2. Бага, дунд боловсрол


 1.3. Мэргэжлийн боловсрол, сургалт


 1.4. Дээд боловсрол


 1.5. Насан туршийн боловсрол


 2.1. Боловсролын инклюзив ба үл алагчлах байдал


 2.2. Боловсролын чанарын үнэлгээ


 2.3. Багшийн хангалт ба хөгжил

 2.4. Сургалтын байгууллагын удирдлага

 2.5. Боловсрол дахь мэдээлэл харилцаа, холбооны технологи

 2.6. Боловсролын салбарын төсөв, санхүү, хөрөнгө оруулалт

 2.7. Боловсролын статистик хяналт – шинжилгээ, үнэлгээ

 2.8. Боловсролын сектор дамнасан бодлого, төлөвлөлт




## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### I. Товч танилцуулга

#### Судалгааны үндэслэл, эрх зүйн орчин

Монгол Улсын “Боловсролын суурь мэдээллийн тайлан (БСМТ)” буюу “Country Background Report (CBR)” боловсруулах судалгааны ажил нь Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг тоймлон үнэлж дүгнэх үндсэн дээр “ТХЗ 4-Боловсрол 2030 үйлийн хүрээ”-нд баримжаалан Монгол Улсын боловсролыг 2019-2030 онд хөгжүүлэх 4 дэх Мастер төлөвлөгөөг боловсруулах цогц ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн томоохон ажлын нэг юм (Зураг 1).

Зураг 1. БСМТ-ийн салбарын үнэлгээ ба төлөвлөлтийн зарим гол судалгаатай холбогдох байдал (2018-2019)



БСМТ боловсруулах ажил дараах 2 түвшний эрх зүйн орчны зохицуулалттайгаар хийгдсэн.

#### Яамны түвшний зохицуулалт

1. ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комиссод хандсан БСШУЯ-ны хүсэлт
2. “Тайланг дахин ирүүлэх тухай” БХ-ийн захиралд ирүүлсэн БСШУС-ын Сайдын 2018 оны 4/12195 албан тоот даалгавар
3. “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” БСШУС-ын Сайдын 2018-оны А/720 дугаар тушаал
4. “Зардал батлах тухай” БСШУС-ын Сайдын 2018-оны А/768 дугаар тушаал

#### Боловсролын Хүрээлэнгийн түвшний зохицуулалт

1. “БСМТ боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай” Боловсролын Хүрээлэнгийн Захирлын 2018 оны А/44 дугаар тушаал
2. “Ажил гүйцэтгэх тухай” Боловсролын Хүрээлэнгийн захирал болон Ажлын хэсгийн хооронд байгуулсан 18/1204 тоот гэрээ

#### Судалгаанд тавигдсан шаардлага

БСМТ нь дээрх цогц үйлийн эхний үе шатны суурь судалгаа болох учраас захиалагчдын зүгээс түүнд дараах шаардлагууд тавигдсан. Үүнд:

1. Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн суурь мэдээллийг хамруулах. Тухайлбал, байгаль цаг уурын онцлог, хүн амын өсөлтийн пирамид, прогноз, нийгэм эдийн засгийн гол үзүүлэлтүүд, улс төрийн тогтолцоо болон нөхцөл байдал, засаг захиргааны нэгж, засаглалын тогтолцооны онцлог, шийдвэр гаргах эрх мэдлийн хуваарилалт г.м
2. Боловсролын тогтолцоо, түүний онцлогийг тайлбарлах
3. Мэдээлэл нь боловсролын тогтолцооны бүх хэлбэр (албан, албан бус, ахуй амьдралын, насан турш)-ийг хамрах.
4. Боловсролын тогтолцооны бүх түвшин (БНХ, СӨБ, БДБ, ТМБ, ДБ)-г хамрах
5. Мэдээллийг үндэсний, бүсийн, аймаг нийслэлийн, сум дүүрэг, нэгж байгууллага гэх мэт аль болох түвшинчлэн боловсруулах

6. 2030 он хүртэлх дэлхий нийтээр баримтлах үзэл баримтлалын өнцгөөс 2006-2015 он хүртэлх мэдээллийг боловсруулан үнэлж, дүгнэх, мөн цаашдын зорилт, санал зөвлөмжийг гаргах
7. Мэдээллийг дараах 3 шалгуурын айгаар бүтэцчилэн, боловсролын түвшин бүрээр болон дэд сектор дамнасан асуудлуудаар боловсруулж, ай бүрээр ерөнхий дүр зураг, өөрчлөлтийн чиг хандлага, үнэлгээ, дүгнэлт, санал зөвлөмж гэсэн үндсэн бүтэцтэйгээр боловсруулах. Тухайлбал, нийгмийн сорилтууд нь боловсролд хэрхэн нөлөөлж, түүнийг даван туулахад боловсрол ямар үүрэг, ач холбогдолтойг тодруулах. Үүнд:
  - а) Боловсролын чанар, нийц
  - б) Боловсролын инклюдив ба үл алагчлах байдал
  - в) Боловсролын бодлого, төлөвлөлт
8. Тайлангийн төслийг тодорхой зорилтот бүлгүүд (гадаад улсын болон өөрийн орны боловсролын болон холбогдох бусад салбарын мэргэжлийн байгууллагууд, судлаач экспертүүд; нийгмийн бусад бүлгүүд, олон нийтийн төлөөллүүд; хэвлэл мэдээллийн ажилтнууд)-аар хэлэлцүүлэн тохирцыг шалгаж сайжруулах. Ингэхдээ, сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага гэх мэт процессын аргуудыг оновчтой хэрэглэх
9. Тайланд олон улсад болон Монголд сүүлийн үед хийгдсэн томоохон судалгаануудын үр дүн, зөвлөмжүүдийг ашиглах

### Судалгааны зорилго, зорилтууд

Монгол Улсын “Боловсролын суурь мэдээллийн тайлан (БСМТ)” боловсруулах судалгааны шалтгаант зорилго (purpose) нь боловсролын бодлогын тоймт үнэлгээ (ББТҮ) хийх, салбарын орчлын нэгдсэн анализ хийх, шинэ Мастер төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай боловсролын бүх дэд секторууд болон тэдгээрийг дамнасан гол асуудлуудыг бүрэн хамарсан 2006 он болон аль болох урт хугацааны бүрэн бүтэн өгөгдөл мэдээллийг цуглуулж, тэдгээрийн өөрчлөлтийн динамик, харилцан хамаарлыг харуулах, улмаар тэдгээрт анхан шатны ерөнхий дүгнэлт, зөвлөмж гаргахад оршино.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын БНБ-ын хөгжлийн өнгөрсөн цаг үеийн ололт амжилт, сургамж, өнөө үеийн төлөв байдал, ирээдүйн хандлагын талаар үнэлгээ дүгнэлт гаргах, мөн системийн ажиллагаа ба үр дүнгийн давуу сул тал, боломж, аюул занал, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтооход шаардлагатай мэдээллийг цуглуулан боловсруулж, боловсролын хөгжлийн өнөөгийн болон ойрын үед тохиолдож болзошгүй дутагдал, хомсдлоос улбаатай сорилт, бэрхшээлийг тодруулах, өнгөрсөн үеийн үйлийн сургамжийг тоймлон ялгахад тус тус оршино.

Судалгааны зорилтууд (objectives) нь дараах асуудлаар мэдээлэл цуглуулах, боловсролын бодлого, төлөвлөлтөд болон хэрэгжилтэд шинжилгээ хийх, үнэлгээ, дүгнэлт өгөх, цаашид анхаарах санал зөвлөмж гаргахад чиглэсэн. Үүнд:

- Нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал ба бодлогын нөлөөлөл
- ТХЗ 4-Боловсрол 2030-ын өнцгөөс харсан Дакарын үндсэн 6 зорилт, 12 стратеги, ТХБ-10 жилийн зорилтуудын хүрээнд дэвшүүлсэн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтийн байдал
- 2030 он хүртэл ТХЗ 4 ба товлосон 10 зорилтод хүрэхээр тодорхойлсон хөгжлийн бодлого, стратегийн сонголт
- Засгийн газрын манлайлал, нэгдмэл удирдлага, зохицуулалтын түвшин
- Боловсролын хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөрүүдийн төлөвлөлтийн хэрэгжилт
- НҮБ, олон улсын болон бусад байгууллагын хамтын ажиллагаа, түншлэлийн үр өгөөж, мэдээлэл, хяналт-шинжилгээний тогтолцоо
- Материаллаг бодит нөөц боломж
- Салбарын болон байгууллагын хүний нөөцийн чадавх гэх мэт

## Судалгааны үе шатууд, алхмууд

- Судалгааны зорилго, зорилт, агуулга, арга зүйн хүрээг тогтоох
- Шаардлагатай мэдээллийг цуглуулах, боловсруулах арга аргачлал боловсруулах, мэдээллээ цуглуулах
- Цуглуулсан мэдээллээ сонгосон шалгуур, индикатор, арга аргачлалын дагуу боловсруулах, дизайнчлах
- Боловсруулсан мэдээлэлдээ шинжилгээ хийх, гарсан үр дүнг унших, тайлбарлах
- Шинжилгээний үр дүнг нэгтгэх, судалгааны үр дүнд тулгуурлан хөгжлийн бодлого, төлөвлөлт болон тогтолцооны ажиллагаа, үр дүнгийн талаар баталгаа, нотолгоо бүхий зарим оношилгоо хийх
- Тулгарч буй асуудлуудыг ялган тодорхойлох, боломжийн хэмжээнд эрэмбэлэх
- Судалгааны зорилго, агуулгын хүрээнд ерөнхий дүгнэлт, зөвлөмж гаргах
- Тогтолцоонд ажиллагчид болон оролцогч, хандивлагчидтай зөвлөлдөж, судалгааны үр дүнгийн тохирцыг шалгах

## Тайлангийн агуулга, бүтэц, арга зүй

### Агуулгын ерөнхий хүрээ

(БСМТ) боловсруулах судалгааны судлагдахуун-агуулга нь Монгол Улсын хүний нөөцийн хөгжилд хамаарах нийгэм, эдийн засаг, улс төрийн хам нөхцөлтэй холбоотой болон боловсролын тогтолцоо ба түүний үйлчилгээ, үр дүнг үнэлж судалдаг олон улсын нийтлэг хийгээд өөрийн орны өвөрмөц хэрэгцээ бүхий дараах асуудлуудыг хамарсан.

Нийгэм, эдийн засгийн орчны асуудлууд	Боловсролын салбарын асуудлууд
<ul style="list-style-type: none"> <li>• <b>Байгаль, уур амьсгал</b> (бүс нутгууд, уур амьсгал, эрхлэх аж ахуй, хүн амын суурьшил, нягтрал)</li> <li>• <b>Эдийн засаг</b> (ДНБ, улсын төсвийн орлого, тэдгээрт эзлэх боловсролын хувь хэмжээ, боловсролын улсын төсөв, санхүүжилт, хөрөнгө оруулалт)</li> <li>• <b>Засаглал</b> (төрийн бүтэц, засаг захиргааны нэгж, боловсролын удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийн хуваарилалт, шийдвэр гаргалт, оролцоо, байгууллагын чадавх)</li> <li>• <b>Хүн ам, түүний хөгжил</b> (хүн амын өсөлт, насны ангилал, тэдгээрийн харьцаа, боловсролын үйлчилгээнд хамрагдагчид, тэдний тооны ба хүйсийн харьцаа, хүн амын боловсролын түвшин, бичиг үсэгт тайлагдалт)</li> <li>• <b>Нийгмийн байдал</b> (хүн амын эрүүл мэнд, эмэгтэйчүүд, хүүхдийн амьдрал, оролцоо, ядуурал, ажилгүйдлийн түвшин, хүн амын шижилт, хөдөлгөөн, хүний хөгжлийн индекс)</li> <li>• <b>Соёлын байдал</b> (хэл, зан заншил, өв соёл, үндэстний бүтэц, харьцаа)</li> <li>• <b>Хүн амын боловсролын түвшин</b> (боловсролын бүх түвшнүүд, тэдгээрийн хоорондын залгамж холбоо, хүйсийн харьцаа)</li> <li>• <b>Үндэсний түвшинг хамарсан өөрчлөлт шинэчлэлийн бодлого, стратеги</b> (залгамж холбоо, хийдэл, тогтвортой байдал)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Боловсролын хөгжлийн бодлого, стратеги, төлөвлөлт</b> (боловсролын хууль, эрх зүйн орчин, шинэчлэлийн бодлого, стратегиуд, сектор дамнасан төлөвлөлт, боловсролын хөгжлийн үе шатууд бүх шатны сургалтын байгууллагын бүтэц, тогтолцоо, боловсролын удирдлагын тогтолцоо, бие даасан байдал)</li> <li>• <b>Бүх шатны сургалтын байгууллага</b> (цэцэрлэг, бүх шатны сургуулиуд, сургууль цэцэрлэгийн зураглал: байршил, хэмжээ, бүтэц, хэв шинж, өмчийн хэлбэр)</li> <li>• Боловсролын хүртээмж, оролцоо (сургуулийн насны хүн ам, хамран сургалт, элсэлт, төгсөлт, дотуур байрны хамрагдалт, хувийн сургуулийн хамрагдалт, алдагдал гэх мэт)</li> <li>• <b>Боловсролын чанар</b> (суралцахуйн онол, арга зүйн шийдлүүд, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурлагын амжилт ба чанарын үнэлгээний тогтолцоо; мэргэжлийн багшийн хангалт, багшийн хөгжил: багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо; сурах бичиг, хэрэглэгдэхүүний хангамж; МХХТ-ийн нэвтрэлт, бүлэг дүүргэлт, багш сурагчийн харьцаа; сургууль, цэцэрлэг, дотуур байрын барилга, хүчин чадал, ээлжийн коэффициент, тэдгээрийн ашиглалтын нөхцөл)</li> <li>• <b>Боловсролын инклюзив ба үл алагчлах байдал</b> (насан туршийн болон албан бус боловсролын үйлчилгээ; малчдын хүүхэд, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гадаадад амьдарч буй монгол иргэдийн хүүхэд зэрэг тусгай зорилгод бүлгүүдийн боловсролын асуудлууд; суралцагчид, салбарт ажиллагчид болон жендэрийн тэгш байдал)</li> <li>• <b>Боловсролын төсөв, санхүүжилт, түншлэл</b> (боловсролын төсвийн төлөвлөлт, хуваарилалтын механизм, санхүүжилт, хөрөнгө оруулалт; салбар хоорондын болон нэг ба олон талт түншлэл; багшийн цалин хөлс, нийгмийн асуудал; хувийн хэвшлийн үүрэг, оролцоо; нийгмийн түншлэл, эцэг эх, иргэдийн оролцоо)</li> </ul>




## Тайлангийн бүтэц

БСМТ нь Хураангуй, Монгол Улсын хам нөхцөл ба онцлог, Боловсролын тогтолцоо ба дэд секторууд, Боловсролын сектор дамнасан асуудлууд гэсэн үндсэн 4 хэсэгтэй. Тайлангийн эхний хоёр хэсэг нь танилцуулгын шинжтэй, сүүлийн хоёр хэсэг нь судалгааны шинжтэй (Зураг 2).

Хураангуй хэсэгт судалгааны зорилго, зорилтууд, агуулга, арга зүй болон судалгаагаар олж илрүүлсэн зүйлс, өмнөх үйл ажиллагаанаас ялгасан зарим сургамжийг танилцуулсан бол “Монгол Улсын хам нөхцөл, онцлог” хэсэгт Монголын боловсролын тогтолцооны онцлогийг нөхцөлдүүлэгч улс орны хам нөхцөлийг газар зүйн байрлал, онцлог; уур амьсгал, түүний өөрчлөлтийн хандлага; газар ашиглалт; хүн ам зүй; гадаад харилцаа; хүний хөгжил; засаглалын хэлбэр; засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага; нийгэм, эдийн засгийн байдал; хөдөлмөрийн зах зээлийн байдал; нийгмийн даатгал, халамж; эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний хүрээнд тус тус тоймлон оруулсан.

Боловсролын тогтолцоо ба дэд секторууд гэсэн нэгдүгээр бүлэг нь боловсролын тогтолцоог түвшинчлэн (босоо чиглэлд) авч үзсэн Сургуулийн өмнөх боловсрол, Бага, дунд боловсрол, Мэргэжлийн боловсрол сургалт, Дээд боловсрол, Насан туршийн боловсрол гэсэн 5 дэд бүлэгтэй. Харин Боловсролын Сектор дамнасан асуудлууд гэсэн хоёрдугаар бүлэг нь дээрх дэд тогтолцоонуудад нийтлэгээр хамаардаг (хөндлөн чиглэлд) зарим асуудлуудыг авч үзсэн. Тухайлбал, Боловсролын инклюзив ба үл алагчлах байдал, Боловсролын чанарын үнэлгээ, Багшийн хангалт ба хөгжил, Сургалтын байгууллагын удирдлага, Боловсрол дахь МХХТ, Боловсролын төсөв, санхүүжилт ба хөрөнгө оруулалт, Боловсролын статистик ба хяналт-шинжилгээ, үнэлгээ, Сектор дамнасан бодлого, төлөвлөлт гэсэн 8 дэд бүлэгтэй.

Зураг 2. БСМТ-ийн бүтэц, товч агуулга




## Тайлан бичсэн арга зүй

Тайлангийн бүлэг бүрийн бичилтийг “бодлогын циклд баримжаалсан” логик бүтэцтэйгээр гүйцэтгэсэн (Зураг 3). Өөрөөр хэлбэл, тухайн дэд бүлэгт хамаарах бодлого, эрх зүйн үндэслэл болох онол, арга хандлагын шийдлийг тодруулж, тухайн тогтолцооны статик ба динамик бүтэц, түүний институтчилагдсан эсэх, ажиллагаа нь тогтвортой эсэхийг танилцуулж, тухайн тогтолцоо нь боловсролын гол зарчмууд болсон хүн бүрийн боловсрол эзэмших эрх, боловсролын чанар, нийц, инклюзив, үл алагчлах байдлыг боломжийнхоо хэмжээнд үнэлж, үйл явцын хөгжлийн үе шатуудыг ялгаж тэдгээрийн төлөв байдал, шинж чанарыг тодорхойлон бичихийг хичээсэн

болно. Мөн тодорхой цаг хугацааны туршид тухайн бодлого өөрчлөгдсөн эсэх, түүний нөлөөлөл нь хэрэгжилтэд нөлөөлсөн эсэхийг харуулахын тулд бодлого, эрх зүйн өөрчлөлтийг ч өгөгдөл, мэдээллийн өөрчлөлтийн динамикийг ч уншигчдад харах боломж олгохыг зорьсон.

Зураг 3. Тайлангийн бүлэг бүрийн бичилтийн “бодлогын цикл суурилсан” логик бүтэц



Тайлангийн дэд бүлэг бүрийн агуулгыг тодорхойлохдоо тухайн дэд сектор болон сектор дамнасан асуудлыг үнэлдэг ерөнхий болон тусгай шалгуур, индикаторууд ашиглан мэдээлэл ба үр дүнгээ боловсруулсан. Дэд бүлэг бүрийн эцэст дээрх боловсруулалт дээрээ үндэслэн Дүгнэлт ба Зөвлөмжийг гаргасан болно. Дүгнэлтийг Ололт амжилт, Алдаа дутагдал, Сорилт, бэрхшээл гэсэн 3 хэсэгтэй ялгахыг хичээв. Зөвлөмжид цаашид юунд анхаарал төвлөрүүлж, яаж ажиллавал илүү зохистой талаар өгүүлсэн. Тайлангийн Дүгнэлт ба Зөвлөмж нь ББТҮ, БСА, МТБ дараагийн ажлуудад шууд авч хэрэглэх боломжтой. Гэхдээ тэдгээрийг сектор анализ, бодлогын тоймт үнэлгээ, хөгжлийн стратегийн төлөвлөлт хийдэг тусгай арга техникийн дагуу шалтгаанцлал ба агуулгын хүрээгээр нь эрэмбэлж ашиглах шаардлагатай.

Тайланд өгөгдсөн Дүгнэлт, Зөвлөмж, шаардлагатай бол бусад өгөгдөл, мэдээллүүд нь нотолгоонд суурилсан гэж үзэх бүрэн үндэстэй. Учир нь бүх төрлийн мэдээллийн эх үүсвэр, ишлэлийг хангалттай түвшинд хийж өгсөн бөгөөд энэ болон бусад судалгаанд ашиглах боломжтой нэлээд үнэ цэнтэй мэдээлэл бүхий 83 нүүр 73 хавсралтыг тусад нь бэлдэж тайланд хавсаргасан.

### Түлхүүр нэр томьёо, тэдгээрийн хэрэглээ

Боловсролын 2030 он хүртэлх алсын хараа буюу ТХЗ 4-т хүн бүр боловсрол эзэмших түгээмэл эрхээ эдлэхдээ боловсролын мөн чанар, зориулалтыг илэрхийлдэг дараах түлхүүр нэр томьёог чухалчилсан. Хэдийгээр бид эдгээр нэр томьёог өргөн хэрэглэж ирсэн боловч түүний утга агуулгыг тэр бүр бүх нийтээрээ нэг мөр ойлгож, хэрэглэж ирээгүй талтай. Ялангуяа, англи үгний орчуулга нь тэр бүр оновчтой зөв байгаагүйгээс, мөн тэдгээр үгний тайлбаруудын талаар өргөн хэлэлцүүлэг явуулдаггүйгээс хүмүүст ойлголтын зөрөө бий болдог. Энэ нь ихээхэн хор уршигтай байдаг. Өөрөөр хэлбэл, “Буруу замаар будаа тээвэл, буцахдаа шороо тээнэ” гэсэн зүйр үгтэй утга нэг юм. Иймд 2030 он хүртэлх ТХЗ 4-т тодорхойлсон боловсролын шинэ алсын хараанд баримжаалан боловсролоо бүхэлд нь хувирган өөрчилж гэж байгаа бол энэ алсын харааг томьёолсон түлхүүр нэр томьёоны утга агуулгыг бүх нийтээрээ сайн ойлгох хэрэгтэй. Бид тэдгээр нэр томьёог дараах утгаар ойлгож, тайлангийн боловсруулалтдаа хэрэглэсэн болохыг цохон тэмдэглэж байна. Үүнд:

- **“Quality of education”** буюу “Боловсролын чанар” гэдгийг боловсролын зорилтуудаас эхлэн гаралтын дам үр дүнгүүд хүртэлх маш өргөн хүрээний асуудлыг хамарсан интерактив шинжтэй, өндөр эрэмбийн ерөнхий шалгуур гэж
- **“Real relevance of education”** буюу “боловсролын бодит нийц” нь хувь хүний болон боловсролын секторын хөгжлийн хэрэгцээг хэрхэн хангаж байгааг илэрхийлэх чанараас илүү өргөн утгатай шалгуур гэж
- **“Inclusive education”** буюу “Инклюзив боловсрол” нь хүн бүр боловсролын үйлчилгээний гадна орхигдохгүйгээр түүнд хамрагдаж, ингэхдээ өөртөө шаардлагатай байгаа боловсролын тусгай хэрэгцээгээ хангах боловсрол гэж
- **“Equitable education”** буюу “Үл алагчлах боловсрол” гэж боловсролын үйлчилгээг хүртэхдээ үл алагчилагдах шударга зарчим хангагдахыг

БСМТ-г боловсруулсан хүмүүс бид “inclusive” ба “equity” гэсэн англи түлхүүр үгийг олон улсын байгууллагууд болон бусад байгууллагаас гаргасан баримт бичгүүдэд “тэгш хамран сургах, тэгш боломж” гэж орчуулан хэрэглэж байгаа нь тэдгээрийн агуулгын хоорондох ялгааг бүрэн тодруулж чадахгүй, тус бүрийнх нь утга санааг шууд илэрхийлж чадахгүй, хэт тойруу, бүрхэг утга илэрхийлж байна гэж үзсэн. Тухайлбал, “equity”-г тэгш боломж гэвэл “equality”-г юу гэх вэ? Агуулгаараа бол “equality” нь тэгш боломж баймаар гэх мэт олон асудал байна. Тэгээд дээрх түлхүүр үгүүдийн оновчтой монгол нэр томъёог олж, нийгэмд эдгээр ойлголтууд цэгцэртэл мөн чанар, агуулгаар нь тайлбарлаж хэрэглэх нь илүү өгөөжтэй гэж үзээд “inclusive”-ийг инклюзив гэж галиглан, “equity”-г үл алагчлах байдал/нөхцөл гэсэн хэллэгээр орчуулж хэрэглэсэн болно. Үл алагчлах нь үл ялгаварлах (discrimination)-аас ялгаатай ойлголт болно.

## II. Судалгаагаар илрүүлсэн зүйлс

Тайлангийн нэгдүгээр бүлэгт Монгол Улсын боловсролын тухайн түвшний боловсролын 1990 оноос хойших хөгжлийн түүхэн замнал болон хөгжлийн бодлого стратеги, бүтэц, тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтийн үр дүнг “ТХЗ 4 Боловсрол-2030 үйлийн хүрээ”-ний өнцгөөс харж судлан, өнгөрсөн хугацаанд олсон амжилт болон тулгарч буй сорилт, бэрхшээлийг нотолгоонд суурилан ялган тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх зарим зөвлөмжийг санал болгосон.

### 1. Боловсролын тогтолцоо, дэд секторууд

#### 1.1. Сургуулийн өмнөх боловсрол

Ололт амжилтаас: Сургуулийн өмнөх боловсролын талаар хэрэгжүүлсэн бодлогод хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд төрөөс авч хэрэгжүүлсэн бодлогыг дэмжих төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, эрх зүйн дэмжлэг нь бусад улсуудад туршлага болохуйц эерэг туршлага үлдээгээд байна. 2005 оноос хойших хугацаанд сургуулийн өмнөх боловсролын хүртээмж тасралтгүй өсөж хамран сургалтын цэвэр жин 2018 оны байдлаар 79,8% хүрсэн амжилт гаргажээ. Сүүлийн 10 гаруй жилд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын өсөлтөөс үүдэн сургуульд элсэн орж буй I ангийн хүүхдийн хамрагдалт (97.9%), түүний дотор цэцэрлэгт хүмүүжсэн хүүхдийн эзлэх хувь (70.5%) нэмэгдэж, бага ангидаа сургуульд завсардах хүүхдийн тоо буурсан зэрэг СӨБ-ын нөлөөлөх чанарын үзүүлэлтүүд сайжирчээ.

**Сорилт бэрхшээлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж. Үүнд:**

- *Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд нийт хүүхдүүдийн 20,2% буюу 5 хүүхдийн нэг нь хамрагдаж чадахгүй байгаа ба эдгээрт хот суурин газрын ядуу болон шилжин суурьшсан өрхийн хүүхдүүд, хөдөөгийн малчдын хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд зонхилж байна.* Тийм учраас цаашид эдгээр хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах ялгаатай стратегийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал цэцэрлэгийн эрэлт илүү их байгаа төвлөрсөн хүн ам бүхий хот суурин газарт цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах хүчин чадлыг ихэсгэх, Засгийн газраас хэрэгжүүлж буй цэцэрлэг барих, өргөтгөх хөтөлбөрийг үргэлжлүүлэх, хөдөөгийн алслагдсан багуудад малчдын хүүхдэд зориулсан хувилбарт сургалтын үйлчилгээг гэр бүлд түшиглэсэн болон явуулын багш, гэр цэцэрлэгийн хэлбэрээр үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэгт суралцах, нэмэлт тусалцаа дэмжлэг авах бололцоог хангах хэрэгтэй.

Мөн төрийн бус өмчийн цэцэрлэгийн хүртээмжийн өсөлтөд (17.6%) оруулж буй хувь нэмэр их байгаа учраас тэдгээр цэцэрлэгийн үйлчилгээний санхүүжилт, чанарт хийх магадлан итгэмжлэл, хяналтын тогтолцоог сайжруулах замаар нийт СӨБ-ын хүртээмжид эзлэх хувийг бууруулахгүй байх нь чухал юм.

- *Судалгаанаас үзэхэд хот, хөдөөгийн цэцэрлэг болон төр ба хувийн хэвшлийн цэцэрлэгүүд, хувилбарт сургалтын тухайд үйлчилгээний чанар, хүүхдийн хөгжлийн үзүүлэлт харилцан адилгүй ялгаатай байна. Үүнд хэдийгээр цэцэрлэгийн байршил, хамрагдаж буй хүүхдийн эцэг эхийн боловсрол, амьжиргааны түвшин зэрэг хүчин зүйлсүүд нөлөөлж байгаа боловч цэцэрлэгийн багшийн хөгжил, хүүхэдтэй ажиллах мэргэжлийн ур чадвар, сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөр, арга зүйн тогтвортой байдал, шинэчлэлийн бодит үр дүнд илүү анхаарах хэрэгтэй болсныг харуулж байна. Өөрөөр хэлбэл, СӨБ-ын үйлчилгээний чанарыг сайжруулах, ялангуяа хүүхдийн хөгжлийн сургуульд суралцах бэлэн байдлыг жигд хангахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.*
- *Сургуулийн өмнөх боловсролын талаар дэвшүүлсэн зорилтуудыг бүрэн хангах, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нийгэм, эдийн засгийн салбаруудын бодлогын уялдаа, оролцооны үр өгөөж хангалттай түвшинд тогтвортой байж чадахгүй байна. Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогод СӨБ-ын талаар дэвшүүлсэн зорилтуудыг хангах, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нийгмийн салбаруудын оролцоо, бодлогын уялдаа, бүх талын түншлэлийг нэмэгдүүлэх, энэ салбарт тохиолдсон сорилтуудад хариу үйлдэл үзүүлэх бодлого стратегийг хэрэгжүүлэх нь зохистой.*

## 1.2. Бага, дунд боловсрол

Монгол Улсын бага дунд боловсролын 1990 оноос хойших хөгжлийн үйл явц дараах үе шаттайгаар явагдаж байна. Үүнд:

1. Хөгжлийн бодлого, стратегиуд тодорхойлогдон эрх зүйн шинэ орчин бүрэлдэж, БНБ-ын хүрээнд бага, дунд боловсролын шинэ тогтолцоо үүсэн бүрэлдэх үе шат (1995-2004)
2. ТХБ-ын үнэт зүйлсийг чухалчлан тэдгээрийг сургалтын хөтөлбөр, сургалтын арга зүйдээ интеграцчилж, хүүхэд бүрийн хөгжлийг эрхэмлэн “ТХБ-10 жил”-ийн хүрээнд БНБ-ын тогтолцоог бэхжүүлэх үе шат (2005-2015)
3. Дэлхий нийтийн ТХЗ-2030 ба ТХЗ 4-Боловсрол 2030 үйлийн хүрээ болон Монгол Улсын боловсролын хөгжлийн шинэ стратегийн төлөвлөлтийн хүрээнд бага, дунд боловсролыг бүхэлд нь ТХЗ-ын төлөөх боловсрол болгон хувирган өөрчлөх эхлэлийн үе шат (2016-аас хойш)

**Ололт амжилтаас:** Мянганы хөгжлийн зорилтод дэвшүүлсэн бага боловсролын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх дэлхий нийтийн зорилтыг хангахдаа Монгол Улс бага, дунд боловсролын тогтолцоогоо олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор ЕБС-д 7 ба 6 настай хүүхдийг сургуульд элсүүлж, сургуульд суралцах хугацааг 10 жилээс 11 ба 12 жилийн тогтолцоонд богино хугацаанд багтаан шилжүүлэх онцгой төвлөсөн зорилтыг амжилттай хэрэгжүүлж чадсан. Энэ явдал нь Монгол Улсын боловсролын тогтолцоог олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөх суурь нөхцөлийг хангахад гаргасан томоохон амжилтын нэг юм. 2017 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 20.1 хувь нь бага, дунд боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна. Сургуульд элсэх насыг доошлуулсан хэдий ч бага боловсролын элсэлтийн хувь буураагүй өндөр хэвээр байгаа бөгөөд 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар бага боловсролын хамран сургалтын бохир жин 97.6, цэвэр жин 96.2; суурь боловсролын хамран сургалтын бохир жин 98.5, цэвэр жин 94.7; бүрэн дунд боловсролын хамран сургалтын бохир жин 100.3, цэвэр жин 95.2 хувьтай тус тус байна.

Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд заагдсан “2008-2014 онд багтаан батлагдсан графикайн дагуу бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө ба хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх замаар ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх, 6 ба 7 настай хүүхдийг сургах агуулга, арга зүй, сургалтын орчныг бүрдүүлэх” зорилтууд амжилттай хэрэгжсэн байна.

Боловсролын үйл хэргийн цөм болсон хоорондоо амин холбоотой, нарийн нийлмэл үйл явцын үр дүнд Монгол Улсын бага, дунд боловсролын стандарт, кинрикулимийн хөгжил үндсэндээ дэлхийн нийтийн боловсролын хөгжилд баримжаалсан хөгжлийнхөө зам дээр (on the way) гарч, боловсролын

стандартууд, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрүүд цогц чадамжид суурилж, тэдгээрт ТХБ зорилго, агуулга харьцангуй сайн интеграцчилагдаж чадсан гэж үзэх боломжтой. Гэхдээ бодлогын тогтворгүй байдал, мөн менежментийн зарим доголдол зэргээс хамаарч багагүй алдаа дутагдал, сорилт, бэрхшээлийг дагуулсаар байна.

Дээрх томоохонд тооцогдох амжилтуудад хүрэхэд Монгол Улсын ЗГ болон гадаад улсын ЗГ-ууд, НҮБ-ын төрөлжсөн болон олон улсын байгууллагууд хоорондын техник туслалцааны, мөн хөрөнгө оруулалтын талбар дахь түншлэл чухал үүрэг гүйцэтгэж, их хувь нэмэр оруулсаар иржээ.

**Сорилт бэрхшээлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж. Үүнд:**

- *Сургуулийн ангилал, байришилд зохистой бус өөрчлөлт гарч, багийн бага сургуулийн тоо буурч, суманд цөөн сурагчтай ахлах сургуулийн тоо олишрсноор мэргэжлийн багийн далд хомсдол үүсэж, сумын багш олон ангид, олон төрлийн хичээл зааж, ажлын ачаалал нь нэмэгдэх, бие даан хөгжих боломж нь хязгаарлагдах зэргээр багийн үл алагчлагдах байдал болон сургалтын чанар, суралцагчдын сурлагын амжилтад тус тус сөргөөр нөлөөлөх болсон.* Тухайлбал, хөдөө орон нутгаас нийслэлд болон аймгийн төвд шилжин ирж буй иргэдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага түүний дотор ЕБС-ийн суудлын тоо, хүчин чадал хүн амын өсөлтийг гүйцэж, шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийг бүрэн дааж чадахгүй болсноос 3 ээлжээр хичээллэж буй сургуулийн тоо буурахгүй байна. Мөн бүлэг дүүргэлт улсын хэмжээнд хэвийн байгаа ч бүс нутаг, байршлын хувьд харилцан адилгүй байна. Багийн сургуульд хамгийн бага, хотын сургууль хамгийн их бүлэг дүүргэлттэй байна.

Иймд шилжилт хөдөлгөөн ихсэж, бүлэг дүүргэлт хот, хөдөөд ялгаатай болж, боловсролын үйлчилгээний чанар, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь зөвхөн боловсролын салбарын төдийгүй нийгэм, эдийн засгийн шинжтэй томоохон асуудал болохыг харгалзан ЕБС-ийн бүтэц, хэв шинж, байршлыг Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн оновчтой болгож, сургуулийн шинэ зураглал (School mapping)-ыг хийх шаардлагатай байна. Түүнчлэн сургалтын орчин болон дотуур байрны нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүнд нарийвчилсан үнэлгээ хийж, суралцахуйн зарчмууд хэрэгжих боломжтой, суралцагчид бүтээлч үйлээрээ мэдлэг бүтээхэд шаардлагатай сургалтын шинэ орчин, эрүүл, аюул осолгүй суралцаж, амьдрах нөхцөлийг хангасан байхаар сургуулийн болон дотуур байрны барилгын зураг дизайныг үе шаттайгаар шинэчлэн сайжруулах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

- *Сургалтад мөрдөх сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг, суралцахуйн үр дүнг үнэлэх үнэлгээний журам зэрэг нь ойр ойрхон өөрчлөгдөж байгаа нь сургууль багш нарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэж, анги танхим дахь хичээлийн үр өгөөжийг бууруулж байна.* Тухайлбал, 1998-2014 оны хооронд сургуулийн бүтцэд 4 удаагийн, 1998-2019 оны хооронд сургалтын хөтөлбөрт 3 удаагийн (сүүлийн 10 жилд 2 удаагийн), 1998-2009 оны хооронд бага, дунд боловсролын сурах бичиг хангамжийн талаар баримтлах бодлогод 3 удаагийн эрх зүйн зохицуулалтад 12 удаагийн тус тус өөрчлөлт хийгдсэн бөгөөд тэдгээр өөрчлөлт бүр дэх шинэчлэлийн бодлогыг тусгасан сургалтын төлөвлөгөөнүүд боловсрогдон хэрэгжиж иржээ. Сүүлийн 20 жилийн хугацаанд сургалтын төлөвлөгөөг өөрчилсөн нийт 21 удаагийн шийдвэр гарсан байна. Түүнчлэн 2007-2013 онд боловсруулан мөрдсөн бага, дунд боловсролын нийт 252 үндэсний болон цөм хөтөлбөрийн 70 гаруй хувь, мөн 2009-2018 оны хооронд шинээр бэлтгэсэн нийт 217 сурах бичгийн 48,8 хувийг хүчингүй болжээ. Ялангуяа 2013 оноос хойш хэвлэгдсэн V, VI, VII, X, XI, XII ангийн 80 орчим сурах бичиг 3-2 жил хэрэглэгдээд хүчингүй болсон (дунд анги) бөгөөд хүчингүй болохоор (ахлах анги) байна. Энэ байдал нь онол, арга зүйн хувьд ч үндэслэл нь бүрхэг, улсын төсвийн зарцуулалтын хувьд ч үрэлгэн хандсан байдлыг харуулахын зэрэгцээ сургалтын хөтөлбөр, сурах бичгийн чанарт ч сөргөөр нөлөөлж байна.

Эдгээр өөрчлөлтүүд нь нэг талаас, ЕБС-ийн сургалтын хугацааг 10 жилээс 11 жилд, улмаар 12 жилд шилжүүлэн сургуулийн бүтцийг өөрчлөх, мөн цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн шинэчлэлийн зэрэгцсэн 2 чухал стратегийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой боловч нөгөө талаас, Боловсролын талаар баримтлах төрийн бодлого, шийдвэр нь улс төрөөс хүчтэй хараат, тогтворгүй байгаа байдал; богино хугацаанд дорвитой судалгаа, шинжилгээний үндэслэлгүйгээр эдийн засгийн тооцоололгүйгээр, зохих

бэлтгэлийг бүрэн хангахгүйгээр сүүлийн 10 жилийн дотор 2 удаагийн сургалтын хөтөлбөр ба сурах бичгийн шинэчлэл хийгдсэн явдал; мөн мэргэжлийн удирдах боловсон хүчний тогтвор суурьшилгүй ажиллаж буй байдалтай бас холбоотой юм.

Боловсролын салбарын ТХ-ийг хангахад онцгой анхаарч, шинжлэх ухааны үндэслэл бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх үндсэн дээр тодорхойлсон бодлогоо тууштай баримталж, ойр ойрхон “шинэчлэх” биш, тасралтгүй “сайжруулах” стратеги баримталж ТХБ-ын хөгжилд бодит ахиц гаргах, багш нарын тогтвортой хөгжлийг хангахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, олон жилийн туршид дээдх нь суудлаа ололгүй “шинэчилсээр” байтал доодох нь гүйдлээ олохгүй “бужигнасаар” байгааг анхаарах ёстой.

Цаашид сургалтын үндсэн баримт бичгүүдийг уялдаа холбоотойгоор сайжруулан боловсруулахдаа эхлээд тэдгээрийг бүтээх онол, арга зүйн шийдлийг тодорхой болгон баталгаажуулж, дараа нь боловсролын чанар нь боловсролын стандартаар, стандарт нь цогц чадамжаар, цогц чадамж нь ТХБ-ын хүрээний цогц чадамжуудаар, эдгээр цогц чадамжууд нь ТХЗ-ыг хангах агуулга, арга зүйгээр эрэмбэлэгдэх ерөнхий зүй тогтолд баримжаалан үйлдэх нь зохилтой. Өөрөөр хэлбэл, “Эх нь булингартай бол адаг нь булингартай” гэдэг зүйрлэлийг санаж байхад илүүдэхгүй.

- *Өнөөг хүртэл сурах бичиг хангамжийн найдвартай, тогтвортой тогтолцоо төлөвшиж чадаагүй байгаагаас сурах бичгийн чанар тасралтгүй сайжирч байх, хөрөнгө оруулалт үр ашигтай байх зарчмууд алдагдаж, сурах бичгийн хангамжийн асуудал бүрэн шийдэгдээгүй байна.*

Юуны өмнө өнөөгийн сурах бичгийн хангамжийн хэрэгжилтийн менежментэд өргөн хүрээний иж бүрэн суурь судалгаа хийж, сурах бичгийн агуулга, арга зүй, хэвлэн нийтлэл, түгээлт, ашиглалтын талаар үнэлгээ, дүгнэлт гаргах, сургамж ялгах шаардлагатай. Улмаар сурах бичиг хангамжийн хэлхээн дэх төрийн оролцооны хэсгийг маш оновчтой тогтоох замаар олон улсын жишигт нийцсэн төрийн зохих оролцоо бүхий сурах бичиг хангамжийн хэвлэн нийтлэл төвтэй тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх нь зүйтэй юм.

- *Сүүлийн жилүүдэд үндэсний түвшинд хийгдсэн судалгаануудаас харахад сурагчдын сурлагын амжилтад ахиц огт ажиглагдахгүй байгаа бөгөөд бага, суурь, бүрэн дунд боловсролын шатлал бүр дэх сурлагын амжилт 60-аас доош хувьтай, ялангуяа дунд, ахлах ангийн сурлагын амжилтын үзүүлэлтүүд бага боловсролынхоос доогуур байна. Энэ байдал нь олон хүчин зүйлээс хамаарах боловч түүнд нэг талаас, сургалтын хөтөлбөр, ба төлөвлөгөөний онол, арга зүйн суурь шийдлүүддээ нийцсэн боловсруулалтыг бүрэн гүйцэт хийгээгүй нөгөө талаас, улс төрөөс хамаарсан бодлогын тогтворгүй байдал зохих хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж болно.*

Боловсрол судлалын шинжлэх ухааны байгууллагын бие даасан байдал бүрэн хангагдаагүй, бүтэц, чадавх нь хангалттай түвшинд бэхжээгүйн улмаас боловсролын салбарт боловсрол, хүний хөгжлийн чиглэлээр баримтлах төрийн бодлогын үндэс, суурь болчихоор чанартай суурь судалгаанууд үгүйлэгдэж байна. Өнөөдөр хийгдэж байгаа ихэнх судалгаанууд нэгдсэн зохицуулалтгүйгээр тодорхой төсөл хөтөлбөрийн хүрээнд тухайн нэг асуудалд төвлөрсөн, салангид байдлаар хийгдэж байна. Хэдийгээр боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, тэдгээрийн сайжруулахад чиглэсэн шинжлэх ухааны үндэслэл бүхий үндэсний хэмжээний иж бүрэн судалгаанууд хийгдэж эхэлсэн ч тэдгээрийг нэгдмэл зорилтын хүрээнд цогц байдлаар тогтвортой явуулахад нэгдсэн бодлого, зохицуулалт, хөрөнгө санхүү, хүний нөөцийн дутагдал хомсдол нөлөөлсөөр байна.

“ТХЗ 4 Боловсрол 2030 Үйлийн хүрээ”-нд баримжаалан суралцахуйн үзэл баримтлал, боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг ба сургалтын бусад материалаг орчин, багшийн хөгжил, үнэлгээг багтаасан сургалтын тогтолцоог гадаад, дотоод хүчин зүйлсийн холбоо хамаарал, бүхэл бүтэн, дотоод саланги чанарынх нь нэгдэл, оршин байх олон төрөл хувилбарынх нь нэгдэлд нь авч үзэж, бүрэлдэхүүн хэсэг тус бүрийнх нь үүрэг зориулалт, агуулга, арга зүй, үр дүн хоорондын үл хувиран хадгалагдах (инвариант) чанар ба тэдгээрийн бие биедээ шатлан эрэмбэлэгдэх (иерархи) чанарын шүтэлцээг тус тус хангаж чадахуйц нэгдсэн онол, арга зүйн шийдэлтэй байхаар сургалтын баримт бичгүүдийг боловсруулах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, сургалтын үндсэн баримт бичгүүдийг систем сэтгэлгээний арга барилын дагуу боловсруулж үйлдвэл илүү тустай байна. Ингэж чадвал боловсролд ТХБ-ыг үр өгөөжтэй

интеграцчилж, сургалт тогтвортой хөгжиж байх суурь нөхцөл хангагдана.

- *Хүн төрөлхтний ТХ, түүнд хүрэх арга хэрэгсэл болсон ТХБ-ын талаарх дэлхий нийтийн үйлийн замнал, өрнөлийн шинэ үе шат эхэлж, танин мэдэхүйн болон практик үйлийн түвшинд гарч буй өөрчлөлтийг анхаарах мэдрэмж үндэсний хэмжээнд нийгмийн зохион байгуулалтын бүх түвшинд сул, жигд бус байгаагаас энэ талаарх бүх нийтийн ойлголт хангалтгүй, үйл ажиллагаа, хүчин чармайлтын үр өгөөж, үр нөлөө харьцангуй чамлалттай байна.*

Иймээс дэлхий нийтийн ТХБ-ын үйл явцтай хөл нийлүүлэн урагшлахын тулд ТХБ-ын хөгжилд гарч буй мэргэжлийн болон төрийн захиргааны түвшин дэх хөгжлийн онол, арга зүйн ахиц, ололтоос суралцаж, өөрсдийн өв соёл, үнэт зүйлсээ уламжлан хөгжүүлэх замаар бүтээгдэх инновацийг үйл хэрэг, бодит үр дүн болгож байх менежментийг хэрэгжүүлж, боловсролын суурь судалгаануудыг тасралтгүй явуулж, улмаар судалгааны үр дүнд суурилсан шинэчлэлийн бодлого, стратегийг дэвшүүлэн хэрэгжүүлж байхыг шийдвэр гаргалтын суурь зарчим, гол хариуцлага болгож байх шаардлагатай.

### 1.3. Мэргэжлийн боловсрол, сургалт

**Ололт амжилтаас:** МБС нь Монгол Улсын боловсролын 90 гаруй жилийн түүхтэй ууган салбаруудын нэг юм. Монгол Улсад аж үйлдвэр, үйлчилгээний салбарууд үүсэн хөгжихтэй зэрэгцэн 1921 оноос анхны мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэж эхэлсэн бөгөөд тэд эх орныхоо хөгжил дэвшилд бодитой хувь нэмэр оруулж ирсэн. Харин 1990 оноос хойш энэ салбар нийгмийн өөрчлөлт, зах зээлийн шилжилтийн хүнд үеийг туулж, тодорхой хэмжээгээр ухралтад орсон хэдий ч нийгмийн хөгжлийн сорилтуудыг даван туулсаар байна. 2002 онд “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” анхны бие даасан хууль гарч, төрөөс энэ салбарын хөгжилд онцгой анхаарал хандуулах болсон. 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар нийт МБС-ын нийт 86 байгууллага (төрийн өмчийн 51, хувийн 35), 4520 багш, ажилчидтай, 193 мэргэжлээр жилд дунджаар 20 орчим мянган мэргэжилтэй ажилтныг бэлтгэдэг салбар болж өргөжин хөгжиж байна.

**Сорилт бэрхшээлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж. Үүнд:**

- *МБСБ-ын эрх зүйн зохицуулалт дутмаг ба хийгдсэн гол зохицуулалтуудын хэрэгжилт хангалтгүй байгаагаас нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээг хангахуйц түвшинд энэ дэд тогтолцооны бие даан тогтвортой хөгжих боломж хязгаарагдмал байна. Тухайлбал,*
  - *МБС-ын удирдлагын тогтолцоо оновчгүй, салбар дундын зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж хязгаарагдмал байна. МБС-ыг эрхлэх төрийн захиргааны байгууллагыг салбар дундын зарчмаар байгуулах, тогтвортой ажиллуулах замаар олон улсын жишигт нийцсэн, удирдлагын илүү оновчтой, үр дүнтэй тогтолцоонд шилжих шаардлагатай. Энэ шилжилтийг МБСҮЗ-ын статусыг өндөржүүлэх замаар шийдвэрлэх боломжтой. Энэ шийдэл нь мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог шинэчлэх, улмаар мэргэжлийн боловсрол, сургалтын төдийгүй нийгмийн хөгжлийн зангилаа асуудлуудыг шийдвэрлэх оновчтой шийдэл болно.*
  - *МБС-ын тухай хуулийн санхүүжилтийн шинэлэг зохицуулалтууд (20.3, 22.1.5, 23.1.2, 24.2, 24.3) хэрэгжээгүй нь салбарын шинэчлэл, түншлэл-олон талын оролцоо, сургалтын чанар, суралцагч, төгсөгчийн мэргэшлийн үр чадварт сөргөөр нөлөөлж байна. МБС-ын тухай хуулийн дээрхи зохицуулалтуудыг хэрэгжүүлэх, үүний тулд “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан” (МБСДС)-г бие даалгаж ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлэх нь зайлшгүй шийдвэрлэх асуудал болсон. Санхүүжилтийн хүрээний эл асуудлуудыг шийдвэрлэснээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх ачааг зөвхөн төр, сургалтын байгууллага төдийгүй хувийн хэвшил, ажил олгогчид хамтарч үүрэлцэх, ингэснээр хөдөлмөрийн зах зээлийн болон үйлдвэрлэгчдийн эрэлтээр хөтлүүлж, дэмжүүлсэн цоо шинэ тогтолцоо бүрдэх болно. Иймээс ижил төстэй орнуудын туршлага өөрийн орны онцлогт тохирсон сургалтын байгууллагын бие даасан хөгжлийг хангахуйц эрх зүйн шинэчлэл хийх, МБСБ-ын өөрийн орлогоо өөрөө захиран зарцуулах, түүнд хяналт тавих эрх зүйн орчин бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ байна. Ингэснээр сургалтын байгууллагын бие даасан байдал, бүтээлч санаачилгыг хөгжүүлэх боломж өргөжинө.*
  - *Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоо бүрэн төлөвшөөгүй байна. Талуудын үүрэг хариуцлага, оролцоог тодорхой болгох замаар чанарын удирдлагын тогтолцоо, механизмыг*

бий болгож, уялдааг хангах, эрх зүйн орчин бүрдүүлэх, хэрэгжүүлэх нь чухал юм.

- *Хот, хөдөөд МБСБ-ууд харьцангуй оновчтой байришиж, сургуулиудын хүчин чадал хангалттай түвшинд нэмэгдэж, сургалтын орчин, арга технологи орчин үеийн шаардлагын дагуу сайжирч, тэдгээрээс иргэдэд үзүүлэх сургалтын төрөл, хэлбэрүүд олишрч, суралцагчдад олгох, тэтгэмж, тэтгэлэг хүртээмж хангалттай нэмэгдэж байгаа боловч МБСБ-ын элсэлт, түүний дотор эмэгтэй суралцагчдын тоо буурах хандлагатай байна. Өөрөөр хэлбэл, боловсрол-хөдөлмөр, нийгмийн хамгаалалын тогтолцоон дахь эрэлт, нийлүүлэлтийн зарчим хангагдахгүй байна. Тухайлбал,*
  - *МБСБ-ын элсэлтийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, тогтвортой байлгах, ялангуяа элсэгчдийн “хүртээмж, чанар, инклюзив ба үл алагчлах байдал”-ыг сайжруулах чиглэлээр баримталж буй бодлого, авч байгаа арга хэмжээг сургалтын байгууллагын түвшин дэх ЕБС-ийн төгсөлт ба МБСБ, Их дээд сургуулийн элсэлтийн бие даасан салангид бодлогоос БСШУСЯ болон ХНХЯ хамтын оновчтой, үр өгөөжтэй зохицуулалтад бүхий үндэсний түвшиний бодлогод нийцүүлэн шилжүүлэх хэрэгтэй байна. Үүний тулд нэг талаас, ерөнхий суурь боловсролоос бүрэн дунд боловсрол ба их, дээд сургуульд элсэгчдэд тавих мэдлэг, чадварын шаардлагыг өндөржүүлэх нөгөө талаас, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд болон элсэгчид өөрсдийн авьяас, сонирхол, бодит хэрэгцээндээ нийцүүлэн насан туршдаа суралцах боломжоор хангаж, цаашдаа тогтвортой ажилтай, өндөр бүтээмжтэй, хүрэлцээтэй орлоготой амьдрах үндэс суурийг цогцлоох нь энэ шатны боловсролд инклюзив ба үл алагчлах байдлыг хангахад чухал чиглэл болно.*
  - *Багш, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоо бий болгох хэрэгцээтэй байна. МБС-ын багшийг тасралтгүй сургаж чадваржуулах, мэргэжлүүлэх, давтан бэлтгэх тогтолцоо бий болгох, “Багшийн хөгжлийн төв” ажиллуулах шаардлагатай байна. Багш нарыг өндөр хөгжилтэй орны адил төстэй аж ахуйн нэгж, сургалтын байгууллагуудад явуулж сургах, дадлагажуулах ажлыг өргөжүүлэх хэрэгтэй байна.*
  - *МБСБ-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг элсүүлэх, сургах, хөгжүүлэх нэгдсэн бодлого дутагдалтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг аймаг, нийслэл, сум дүүргийн бүх түвшинд МБС-д хамруулж, ажил, хөдөлмөр эрхлэх бодит боломж, нөхцөлөөр хангах эдийн засаг, хамтын ажиллагааны тодорхой механизмууд бүхий тусгайлсан бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сургах сургалтын байгууллагуудад зохих дэд бүтэц бий болгох, холбогдох тоног төхөөрөмж нийлүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах, багш бэлтгэх зэрэг цогц арга хэмжээ авах нь зүйтэй юм.*

#### 1.4. Дээд боловсрол

**Ололт амжилтаас:** Улаанбаатар хотод 1942 онд МУИС анх байгуулагдсанаар Монгол Улсад дээд боловсролын тогтолцооны суурь тавигдаж, энэ сургуулиас төрийн өмчийн бусад их, дээд сургуулиуд төрөн гарч төрөл бүрийн мэргэжлийн дээд боловсролтой үндэсний боловсон хүчин бэлтгэхийн зэрэгцээ Орос буюу ЗХУ, социалист нийгмийн бусад улс орнуудад олон төрлийн мэргэжлээр дээд боловсролтой мэргэжилтнүүдийг бэлтгэж ирсэн уламжлалтай. Дотоод, гадаадын их дээд сургуульд бэлтгэгдсэн мэргэжилтнүүд улс орныхоо улс төр, эдийн засаг, нийгэм хүмүүнлэг, соёл урлаг, үйлдвэр, аж ахуйн бүтээн байгуулалтын хөгжил дэвшлийг үе үеэрээ түүчээлж ирсэн баялаг түүхтэй.

Монгол Улс 1990 оноос ардчилал, зах зээлийн нийгэмд шилжиж, төрийн бус өмчийн сургуулиудыг зөвшөөрөх болсноор олон тооны их дээд сургуулиуд байгуулагдаж байсан бол өнөөдөр тэдгээр сургуулийн тоо 2 дахин буурч, 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар дээд боловсролын 94 сургалтын байгууллагад нийт 157625 суралцагч суралцаж, 12.633 хүн ажиллаж байгаагийн 52.8 хувь нь үндсэн багш нар байна. Нийт суралцагчдын 37.2 хувь нь их сургуульд, 52.1 хувь нь дээд сургуульд, 7.4 хувь нь коллежид, 3.2 хувь нь гадаадын салбар сургуульд тус тус суралцаж байна.

100,000 хүн амд ноогдох ДБСБ-ын тоогоор Монгол Улс нь ОХУ-аас 5 дахин, Японоос 5,4 дахин, Туркээс 15 дахин их байна. Дэлхийн өрсөлдөх чадварын 2016-2017 оны тайланд дурдсанаар дээд боловсролд хамрагдалтаар дэлхийн 138 орноос 38 дугаарт, математик, шинжлэх ухааны боловсролын чанараар 40 дүгээрт эрэмбэлэгджээ. Мөн өрсөлдөх чадварын 12 үзүүлэлтийн нэг болох дээд боловсрол ба мэргэжлийн сургалт гэсэн үзүүлэлт 2007-2009 онд 3.8-3.5 болж буурч байсан бол 2010-2016 онд жил бүр 0.1-0.3 оноогоор тогтмол өсөж 2017 оны байдлаар 4.6 болжээ.



Монгол Улсын 1990 оноос хойших дээд боловсролын хөгжлийн байдлыг тоймлон авч үзвэл, олон улсын чиг хандлагын дагуу тооны өсөлтөөс агуулгад, агуулгаас чанарт, чанарын сайжруулалтаас баталгаажуулалт руу чиглэн хөгжих байна. Дээд боловсролд хийгдсэн том шинэчлэлийн нэг нь 1998 оноос дээд боловсролын зэрэг олгох сургалтын агуулгыг кредит цагаар хэмждэг америк стандартад нийцсэн дээд боловсролын сургалтын систем руу шилжсэн явдал юм. Энэ шинэчлэл нь суралцахуйн үр дүнд суурилсан, суралцагч төвтэй боловсролын шинэ үзэл баримтлалын хэрэгжилтийг эхлүүлсэн байна. Улмаар 2003-2013 онд 130 мэргэжлээр дээд боловсролын стандартыг баталж мөрдсөн бөгөөд эдгээр стандартууд нь төгсөгчдийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон нь өнөөдрийн “суралцахуйн хүрээ”, “суралцахуйн үр дүн” гэдэг ойлголтын үндэс суурь болжээ. Боловсролын бусад дэд салбараас анхлан дээд боловсролын салбарт 1998 оноос байгууллагын, 2004 оноос хөтөлбөрийн, 2017 оноос хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийг тус тус хэрэгжүүлсэн байна. Өнөөдөр БМИҮЗ-өөр 72 их дээд сургууль, 250 гаруй хөтөлбөр, олон улсын магадлан итгэмжлэх байгууллагаар 18 сургалтын байгууллага, 90 гаруй хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн явдал нь дээд боловсролын чанарыг сайжруулах бодлогын гол үр дүн юм.

***Сорилт бэрхшээлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж. Үүнд:***

- *Сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн стандарт, сургалтын төлөвлөгөөгөөр орлуулан мөрдөж байсантай холбоотой үүссэн асуудлуудыг шийдвэрлэхэд гарч буй сорилтыг даван туулах хэрэгцээ бий болсон. Их дээд сургуулиуд сургалтдаа 2003-2013 онд 130 мэргэжлээр дээд боловсролын стандартыг батлан мөрдөж байгаад 2014 оноос “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага” ба “Магистр, докторын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг мөрдөж байна. Өмнө нь ДБСБ-ууд суралцахуйн үр дүнд бус судлах цөм агуулгад суурилсан тодорхой хугацаанд өөрчлөлтгүй мөрдөх “мэргэжлийн стандарт”-ыг мөрдөж байгаад нийгмийн болон хувь хүний эрэлт хэрэгцээнд шуурхай нийцүүлэн тасралтгүй сайжруулж байх илүү уян хатан тогтолцоог бий болгох зорилгоор 2014 оноос стандартаас “сургалтын хөтөлбөр”-т шилжиж, сургалтын байгууллагууд академик байдлынхаа хүрээнд төгсөгчдийн эзэмших ур чадвар, хичээлийн агуулгаа суралцахуйн хүрэх үр дүнгээр тодорхойлж, хөтөлбөрөө дээрх нийтлэг шаардлагуудын дагуу боловсруулан баталгаажуулж, мөрдөж эхэлжээ. Энэ нь сургалтын чанарыг үнэлэх, сайжруулах, баталгаажуулах үйл явцыг ч мөн өөрчлөн шинэчлэхэд хүргэсэн байна. Гэвч энэ шинэчлэлийг хэрэгжүүлэхийн тулд их, дээд сургуулийн багш, удирдлагууд, бусад оролцогч талуудыг чадавхжуулах системтэй үйл ажиллагаа явуулаагүйн улмаас шинэчлэл нь сургууль бүрд харилцан адилгүй хэрэгжиж, үр дүнгээ өгөх нь удаашралтай байна. Иймээс дээд боловсролын чанарыг хангах чухал хэрэгсэл болох сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн явц, үр дүнд гүн гүнзгий судалгаа хийж, судалгаанд тулгуурлан ололт амжилтыг баталгаажуулах, алдаа дутагдлыг засаж залруулах шаардлагатай.*
- *Дээд боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED) ба Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, бэлчээрийн мал ахуй зэрэг үндэсний онцлог хоорондын тохирцыг үнэлж, мэргэжлийн үндэсний хүрээ (national qualification framework)-г боловсуулан батлахгүйгээр сургалтын хөтөлбөрийн хөгжил бүрэн хангагдах боломжгүй байна. НҮБ-ын ЮНЕСКО байгууллагаас 2013 онд шинээр баталсан боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED)-ын дагуу БСШУ-ны Сайдын 2010 оны 235 тоот тушаалаар мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн боловсруулж баталсан бөгөөд 2014 оны А/78 дугаар тушаалаар бакалаврын хөтөлбөрийн индексийг баталгаажуулсан байна. Энэ дагуу сургуулиудын академик эрх чөлөөг нэмэгдүүлэх үүднээс мэргэжлийн нэрийг БСШУЯ-аас тогтоохгүй, зөвхөн хөтөлбөрийн нэр, индексийг баталж, хянахаар эрхзүйн зохицуулалт хийгдсэн. Өмнө нь 24 салбарын 417 мэргэжил, нэмэлт хавсралтаар 400 орчим мэргэжил байсныг шинэ тушаалаар 10 чиглэл 181 хөтөлбөрт багцалснаар ДБСБ-ууд хэт олон мэргэжлээр сургалт эрхлэх бус цөөн хөтөлбөрөөр хөрвөх болон насан турш суралцах ур чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд анхаарах болсон.*
- *Гэвч эдгээр хөтөлбөрийн нэр, индекс нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, бэлчээрийн мал ахуй зэрэг үндэсний онцлогт тохирсон эсэхэд үнэлгээ хийж, шинэчлэх шаардлагатайг ДБСБ-ууд санал болгож байгааг анхаарч үзэх шаардлагатай. Тухайн нэг хөтөлбөрөөр суралцсан төгсөгч нь ямар ажлын байруудад ажиллах боломжтой өөрөөр хэлбэл, мэргэжлийн нэрийг заасан тодорхойлолтыг хийж, дипломын нэмэлт хавсралт өгдөг Europass Diploma Supplement Европын жишээг ашиглан хөтөлбөрийн болон төгсөгчийн чанар, нийцийг сайжруулах боломжтой юм. Олон*

улс болон бүс нутаг, Монгол Улсын хөдөлмөрийн хуваарилалт, хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, эрэлтэд нийцүүлэн дээд боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийг ул үндэстэйгээр эрчимжүүлэх нь зүйтэй.

- *Хэдийгээр бодлогын удаа дараагийн баримт бичгүүдэд дээд боловсролын хамран сургалт, гадаад, дотоодод бэлтгэх мэргэжилтний мэргэжлийн чиглэлээр тодорхой зорилтууд дэвшүүлдэг ч тэдгээрийн хэрэгжилт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, үндэсний хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдахгүй байна.* Анх сургалтын төлбөрийн зээлийг 1997 оноос эхлэн хэрэгжүүлэхдээ ямар нэгэн мэргэжил харгалзалгүйгээр төрийн албан хаагч, яам тамгын газар, бодлого боловсруулдаг газрын хүмүүсийг нэр хүндтэй сургуулиудад мэргэшүүлэх чиглэлээр сургаж байсан бол сүүлийн жилүүдэд Монгол Улсад хэрэгцээтэй гэж батлагдсан инженер, технологич, байгалийн ухаан зэрэг 40 гаруй мэргэжлээр түлхүү сургах чиглэл баримталж байна. Монгол Улсын ажиллах хүчний 2018 оны судалгаанд дурдсанаар ажилгүй иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл, тодорхой мэргэжил эзэмших түвшний буюу техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой ажилгүй иргэд нийт ажилгүй иргэдийн 75.0 хувь байгаа бол үлдсэн 25.0 хувь нь бүрэн дунд, түүнээс доош болон боловсролгүй иргэд байна. Хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам нь ажилгүй байдаг бол манай улсад боловсролтой иргэд илүү ажилгүй байх хандлагатай байгаа нь манайд ажилгүйдэл ба боловсролын хоорондох хамаарал эсрэг дүр зурагтай байна. Судалгааны дүнгээс харахад их, дээд сургууль төгсөгчдийн 68.4% нь хөдөлмөр эрхэлж байгаагаас 69.6% нь эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Их, дээд сургууль төгсөгчдийн хувьд барилга архитектурын мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр буюу 83.2% байгаа бол компьютер, анагаах ухаан, физик, хими, биологи, газар зүй, математик статистик, нийгэм, эдийн засаг, тээвэр, багш, боловсрол судлал зэрэг мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 70.9-76.5% байна.

Иймд цаашид улс орны хатуу болон зөөлөн дэд бүтэц, үйлдвэр, аж ахуй, үйлчилгээ, нийгмийн салбарын хөгжлийн хэрэгцээтэй нягт уялдуулсан мэргэжилтэй ажилчид, дээд боловсролтой мэргэжилтний эрэлт хэрэгцээг үндэсний хэмжээнд алсын хараатай төлөвлөж, улмаар их дээд сургуулиуд түүнд баримжаалсан хүний нөөц бэлтгэх хөтөлбөрөө илүү чанартай, уян хатан, болгон тасралтгүй сайжруулж, магадлан итгэмжилж байх өөрийн болон хөндлөнгийн тогтолцоог хөгжүүлэх нь чухал юм.

### 1.5. Насан туршийн боловсрол

**Ололт амжилтаас:** 1991 онд Боловсролын тухай хуульд АББ-ын тухай анх тусгайлсан заалт орсноос хойш удаа дараагийн үндэсний хөтөлбөр, мастер төлөвлөгөөнд тусгагдаж ирснээр Монголд НТБ-ын тогтолцоо бүрдэж, хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрчээ. Үндэсний ба орон нутгийн түвшинд салбар нэгжүүд ажиллан, олон улсын болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа өргөжин, сургалтын хөтөлбөр, агуулга арга зүй боловсруулагдаж, зах зээлийн дараах үед гарч ирсэн бичиг үсэг үл мэдэгч, сургууль завсардагчдад зориулсан боловсролын үйлчилгээ үзүүлж, Монгол улсад бичиг үсгийн боловсролын асуудлыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмэр оруулсан.

**Сорилт бэрхшээлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж. Үүнд:**

- *Насанд хүрэгчдийн насан туршийн суралцахуйг дэмжсэн онлайн нээлттэй суралцахуйн тогтолцоо хөгжиж төлөвшөөгүй мөн НТБ-ын үйлчилгээ нь ихэнхдээ зөвхөн бичиг үсгийн сургалт ба сургууль завсардсан хүүхдүүдэд зориулсан бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар хязгаарлагдаж байна.* Энэ байдлыг өөрчилж, НТБ-ын үйлчилгээг өргөн хүрээнд авч үзэх, бусад иргэд, ялангуяа насанд хүрэгчдийн хэрэгцээнд тохирсон төрөл бүрийн боловсролын үйлчилгээ явуулдаг болгож өөрчлөх; шаардагдах санхүү, менежментийн тогтолцоог шинэ шатанд гаргахын тулд тусгайлсан бодлого эрх зүйн орчин бүрдүүлэх цаг болсон байна. Тухайлбал, боловсролын тасралтгүй байдлыг хангах үүднээс насанд хүрэгчдийн боловсролын хууль, НТБ-ын үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлснээр дээрх асуудлыг шийдвэрлэх боломжтой.
- *НТБ-ын төвүүд байгууллагын хувьд бэхжиж, чадавхижаагүй байна. Улсын хэмжээгээр 354 НТБ-ын төв ажиллаж байгаа хэдий ч орон байр, сургалтын орчин, багшлах боловсон хүчин хангалтгүй, 90 орчим хувь нь өөрийн гэх байргүй, сургуулийн нэг танхимд үйл ажиллагаа явуулж байна.* Иймд

тухайн газрын оршин суугчдын тооноос хамаарч, нийслэлийн дүүрэг ба аймгийн төв, хот суурин газар буй НТБ-ын төвүүдийг тусдаа байртай болгох, багш нарыг бие даасан орон тоогоор тусгайлсан бодлого, түүнийг хэрэгжүүлэх бодит дэмжлэг туслалцаа зайлшгүй хэрэгтэй байна. Онлайн нээлттэй суралцахуйн тогтолцоо зохих түвшинд хөгжөөгүй байна.

- *Насан туршийн боловсролын үйлчилгээ хүртэгчдийн эрэлт хэрэгцээ ба НТБ-ын төвийн боловсролын үйлчилгээ хоорондын нийцэл бүрэн хангагдахгүй байна.* Тухайлбал, НТБ-ын үйлчилгээний нэг төрөл болох дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй ба сүм хийдэд шавилан суудаг лам хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх НТБ-ын төвийн багш нарын чадавх хүрэлцэхгүй, тэд тусгай хэрэгцээт боловсролын болон өөр мэргэжлийн хичээл заах боломжгүй байгаа нь энэ дэд салбарын шийдвэрлэх ёстой асуудал болж байна. Иймд албан ба албан бус боловсролын үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах, сургууль ба НТБ-ын төв хамтран ажиллах, удирдлагуудын санаачилга, оролцоог дээшлүүлэх, НТБ-ын талаар олон нийтийн болон шийдвэр гаргагчдын ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн дорвитой арга хэмжээ авах шаардлага байна.

## 2. Дэд сектор дамнасан асуудлууд

### 2.1. Боловсролын инклюзив ба үл алагчлах байдал

БСМТ-ийн энэ дэд бүлэгт Монгол Улс дахь инклюзив боловсролын талаарх шаардлагатай мэдээ, мэдээллийг аль болох найдвартай, хэд хэдэн эх сурвалжаас цуглуулж тайлагнахыг зорьсон. Ингэхдээ инклюзив болон болон үл алагчлах боловсролыг Саламанкагийн тунхаглалд тодорхойлсон байдал болон Тогтвортой хөгжил 2030-ын хүрээнд тодорхойлсон тэдгээрийн агуулгыг иш үндэс болгон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид, үндэсний цөөнхийн бүлгийн хүүхдүүд, малчдын хүүхдүүд, лам хүүхдүүдийн боловсролын байдлыг тусгахыг хичээлээ. Тайланд дээр дурдсан тодорхой бүлгийн хүүхдийн боловсролын асуудлыг авч үзсэн нь бусад тусгай болон ялгаатай хэрэгцээтэй бүлэг байгааг үгүйсгэсэн хэрэг бус болохыг тэмдэглэж байна.

**Ололт амжилтаас:** Монгол Улс орчин үеийн суурин болон уламжлалт нүүдлийн хосломол соёлын иргэншилтэй улс юм. Иймээс Монголын төрөөс сүүлийн 100 гаруй жилийн туршид нүүдэлчин малчдын хүүхдэд бүх шатны боловсролд тэгш хамрагдах боломж, нөхцөлийг үе шаттайгаар хангаж, тэдэнд чанартай боловсрол эзэмшүүлэх өөрийн гэсэн өвөрмөц тогтолцоог бүрэлдүүлж чадсан бөгөөд нийгмийн хөгжлийн сорилтуудыг даван туулах явцдаа арвин туршлага, үнэтэй сургамжууд хуримтлуулсаар ирсэн онцлогийг тодотгож байна. Мөн Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх тогтолцоо бүрэлдэж, тэдний боловсрол ба нийгмийн хамгааллын чиглэлээр цогц бодлого баримтлан хэрэгжүүлэхийг чармайж байна. Энд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, хөгжил, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхдээ зөвхөн “анагаахын загвар”-ыг бус “нийгмийн загвар”-ыг баримтлах хандлага ажиглагдаж байгааг тэмдэглэж байна.

**Сорилт бэрхшээлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж. Үүнд:**

- *Монгол Улсад өөр хэл, соёл бүхий угсаатны цөөнхийн хүүхдүүд төрөлх хэлний орчинд олон хэл эзэмших боломжийг дэмжсэн сургалтын дидактик, оновчтой сургалтын хөтөлбөр одоогоор байхгүй байгаагийн зэрэгцээ хос хэлт болон олон хэлний боловсролын багш нарыг бэлтгэж, тэдний мэргэжлийг дээшлүүлж ирсэн туршлага хомс байна.* Эдгээр бүлгийн хүүхдүүд нь боловсролын гадна үлдэх эрсдэл бүхий бүлэг бөгөөд хүн амын дотор цөөнх болдог байна. Тухайлбал, Үндэсний статистикийн хорооны 2017 оны албан ёсны тайланд дурдсанаар Монгол Улсын хүн амын 3.2 хувь нь (103630) ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй, тэдгээрийн 11 орчим хувийг (11453) 0-17 насны хүүхэд эзэлж байна. Монгол Улсад казах угсаатан нийт хүн амын 3.9 хувийг, тува (түрэг) угсаатан 0.1 хувийг эзэлдэг бөгөөд казах иргэдийн 2.9 хувь, тува (түрэг) иргэдийн 3.1 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Мөн Хөвсгөл аймгийн Цагаануур суманд амьдарч буй тувачууд (духа, цаатан) болон тайланд дурдагдаагүй боловч бусад орон нутагт амьдарч буй казах иргэдийн хүүхдүүд хэл, соёлоо мартал байдалтай байгааг тэмдэглэж байна.
- *Инклюзив боловсрол болон боловсрол дахь үл алагчлалын талаарх олон салбарын мэргэжлийн хүмүүсийн ойлголтын зөрөө хэдийгээр багасаж байгаа боловч нийгэмд боловсролын эдгээр*

*суурь зарчмын талаар нэгдсэн ойлголт, түүнийг илэрхийлэх тохиролцсон нэр томъёо хараахан тогтоож хэвшээгүй байна.*

Хүүхэд бүрийн түүний дотор боловсролын гадна үлдэх, түүний үйлчилгээг тэгш хүртэх боломж хязгаарлагдмал бүлэг, тэдний ялгаатай хэрэгцээг ойлгож хүлээн зөвшөөрөхөд инклюзив боловсрол болон боловсрол дахь үл алагчлалын талаарх ойлголт, хандлага чухал болохыг бодлого тодорхойлогчид болон хэрэгжүүлэгчид анхааралдаа авах шаардлагатай. Үүний тулд өнөөдрийг хүртэл хийж буй үйл ажиллагааг үндэсний хэмжээнд дэмжиж, компанит ажил өрнүүлэх боломжтой.

- *Тайланд нэр дурдсан хөгжлийн бэрхшээлтэй болон хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн хүүхдүүд, бусад ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хувьд бодлого, зохицуулалт гэхээсээ илүү эхлэлийн төдий салангид үйл ажиллагаа явуулж байгаа дүр төрх харагдаж байна.*

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, үндэсний цөөнхийн хүүхдийн боловсролын талаар урт хугацаанд тууштай, тогтвортой бодлого баримталж ирсэн хэдий ч боловсролын үйлчилгээний гадна хэнийг ч орхигдуулахгүй байхын тулд инклюзив боловсрол болон боловсрол дахь үл алагчиллын талаар баримтлах бодлого, зохицуулалтыг илүү өргөн хүрээтэй, тодорхой болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг илүү үр өгөөжтэй байхаар нарийвчлах шаардлага байна.

- *Боловсролын инклюзив болон үл алагчлах байдлыг ханган ажиллах хүний нөөц, түүний дотор сургалтын байгууллагын багшийн хангалт хомсдолтой, багш, удирдах ажилтан мэргэжлийн үр чадвар хангалтгүй байна.*

Багш нарт боловсролын инклюзив ба үл алагчлах байдлыг тооцон хэл соёлын ялгаатай орчинд ажиллах мэдлэг, үр чадвар эзэмшүүлэхэд анхаарах шаардлагатай. Тухайлбал, тусгай сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах инклюзив боловсролын багш хүрэлцээгүй байдаг бол ердийн ЕБС-ийн багш нарт энэ талын тусгай хэрэгцээтэй суралцагчтай ажиллах мэдлэг чадвар хомс байна. Мөн хэл соёлын ялгаатай бүлгийн суралцагчтай сургуулийн багш нарын энэ талын мэдлэг, үр чадвар хангалтгүй байдаг нь судалгаагаар илэрсэн байна. Иймд зөвхөн боловсролын тусгай хэрэгцээтэй ялгаатай зорилтод бүлгийн суралцагчидтай ажилладаг багшид бус бүх багш нарт энэ талын мэдлэг, үр чадвар шаардлагатай болж байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Иймээс багш бэлтгэх сургуулиудын болон багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих сургалтын хөтөлбөрүүдэд инклюзив боловсролын үзэл санаа, ойлголт, суралцахуйн тусгай, ялгаатай хэрэгцээ бүхий суралцагчидтай ажиллах арга зүйг тусгах боломжтой. Мөн боловсролын болон сургалтын байгууллагын удирдлагууд хэл соёлын ялгаатай сурагчид болон инклюзив боловсрол шаардсан ялгаатай бүлгийн суралцагчид ажиллах мэдлэг, үр чадварт суралцах хэрэгтэй болж байна.

- *Боловсролын албан ёсны мэдээллийн санд боловсролын инклюзив болон үл алагчлах байдлыг үнэлэх зорилтод бүлэг бүрийн бүрэн бүтэн өгөгдөл, мэдээлэл бүртгэгдээгүй байна.*

Монгол Улсын хувьд СӨБ-оос эхлээд дээд боловсрол, НТБ хүртэлх боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй, хэл соёлын ялгаатай болон бусад ялгаатай бүлгийн суралцагчдын талаарх тоон болон чанарын мэдээллийг цуглуулах нэгдсэн бодлого бүхий өгөгдөл, мэдээллийн санг бүрдүүлэхэд анхаарах цаг болсон байна. Ялангуяа, мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд энэ талаар онцгой анхаарах шаардлагатай байгаа нь тайлан боловсруулах явцад илт харагдсан болно. Нэгдсэн мэдээллийн сан нь бодлого боловсруулах, хэрэгжилтийн мониторинг, үнэлгээ хийх, шаардлагатай дэмжлэг туслалцаа хаана хэрэгтэй байгааг илрүүлж холбогдох арга хэмжээг авахад чухал ач холбогдолтой.

## 2.2. Боловсролын чанарын үнэлгээ

**Ололт амжилтаас:** Монгол Улс сүүлийн 20 гаруй жил бүх төрлийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэн боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг зохион байгуулах менежментийг бүтээж хэрэгжүүлэх явцад боловсролын үйлчилгээний оролтын төлөв байдал, явцын хяналт-шинжилгээ, гаралтын үр дүн болон боловсролын тодорхой шатлал бүрийн суралцахуйн үр дүнгүүдийг үнэлэх бололцоотой, боловсролын бүх түвшнийг хамарсан, боловсролын харилцаанд оролцогч гол субъектүүдийн үйл ажиллагаанд төвлөрсөн, боловсролын чанарын өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрэлдүүлж чадсан байна.

Тухайлбал, боловсролын хяналт-шинжилгээ, үнэлгээний хэд хэдэн байгууллагууд институтчилагдан байгуулагдаж, чанарын үнэлгээний чиглэлээр харилцан уялдаатай тодорхой чиг үүргүүдийг гүйцэтгэж байна. Мөн боловсролын бүх түвшний суралцахуйн үр дүнг үнэлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа хийх орчин үеийн арга зүйнүүд нутагшиж, үнэлгээний шалгалт ба судалгаануудын өгөгдөл, мэдээллийн цуглуулалт, боловсруулалт, тайлагналтад цахим технологи нэвтэрч, даалгаврын сан бүрэлдэж, үнэлгээний давтамж тогтмолжиж эхэлсэн бөгөөд улмаар олон улсын чанарын үнэлгээний TIMSS, PISA зэрэг судалгаанд оролцох бүх талын бэлтгэл хангагдаж байна.

- *Хөндлөнгийн үнэлгээ болон олон улсын сурлагын амжилтын үе үеийн судалгаагаар сурлагын амжилт харьцангуй доогуур түвшинд байгаа нь тогтоогдсон бөгөөд сүүлийн жилүүдэд тодорхой ахиц ажиглагдахгүй байгаад нөлөөлөх нэг хүчин зүйл нь боловсролын чанарын үнэлгээний талаар баримтлах бодлогын тогтворгүй байдал, онол, арга зүйн сул үндэслэл хэмээн гэж үзэж болно.* Товчоор хэлбэл, боловсролын чанарын үнэлгээний бүтэц тогтолцоо, арга хэлбэр, технологийн хувьд хөгжиж байгаа ч агуулга мөн чанарынхаа хувьд доголдолтой, зарим тохиолдолд алдаатай байх магадлалтай байна. Үүнийг ЕБС-ийн суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээ, дүнгийн шатлал 4 удаа, багш нарын ажлыг үнэлэх шалгуур, үзүүлэлтүүд 3 удаа ойр ойрхон өөрчлөгдсөн ч эдгээр асуудал өнөөдөр ч оновчтой шийдлээ бүрэн олоогүй байгаа байдал гэрчилнэ. Энэ байдал нь суралцах болон багшлах үйлийн гаралтын үр дүнгүүдэд тогтвортой өсөлт хангагдахгүй байх хүчин зүйлсийн нэг байх үндэслэлтэй. Хэдийгээр боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого, стратеги эрх зүйн зохицуулалтын түвшинд хангалттай зорилтууд тодорхойлогддог ч тэдгээрийг хэрэгжүүлэх онол арга зүй, менежментийн нэгдсэн зохицуулалт, хүний болон санхүүгийн нөөцийн чадавх сулаас өнөөг хүртэл сурагчдын сурлагын амжилт, багшийн ажлын үнэлгээ, сургалтын байгууллагын үнэлгээний шалгуур, индикаторууд, үнэлж дүгнэх арга зүйг бүрэн оновчилж чадаагүй байна. Тухайлбал, ЕБС-д 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөгдөж буй суралцагчийн үнэлгээний журмын сурлагын амжилтыг үнэлэх шалгуур, дүнгийн шатлал нь эрдэмтэн судлаач болон ЕБС-ийн багш нарын дунд маргаан дагуулж байна.

Иймд юуны өмнө боловсролын бүх түвшний чанарын үнэлгээний шалгуур, индикатор, арга зүйд харьцуулсан судалгаа мөн үнэлгээний журмын хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлсийн тандах судалгаанууд явуулан нэгдсэн дүгнэлт гаргаж, түлхүүр үг нэр томъёог жигдэлж, тогтвортой, туйлбартай баримтлах үзэл баримтлалтай болох хэрэгтэй юм. Улмаар тэрхүү үзэл баримтлалдаа нийцүүлэн боловсролын түвшин бүрийн суралцахуйн үр дүнгийн онцлогийг тусгасан, түвшин хоорондын залгамж холбоог хангасан, боловсролын түвшин бүрийн суралцахуйн үр дүнг үнэлж дүгнэх чадалтай чанарын үнэлгээний багаж хэрэгсэл (үнэлгээний шалгуур үзүүлэлт, арга зүй)-ийг бүтээх зайлшгүй хэрэгцээ байна. Жишээлбэл, МБС-ын болон дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн хөгжүүлэлтийг бодит ажил болгох, хөтөлбөрт тавигдах шаардлага, үнэлэх аргачлалыг боловсронгуй болгож, хөтөлбөрийн өөрийн болон хөндлөнгийн магадлан итгэмжлэлээр дамжуулан сургалтын чанарыг сайжруулах, төгсөгчид нь ажлын байран дээр гарч шууд ажиллах чадвар, чадамжтай байх боломжийг бий болгох тогтолцоог хууль эрх зүйд тусгах, үйл ажиллагааг тогтворжуулах шаардлагатай.

- *Боловсролын тогтолцооны хөгжлийн зорилтууд, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн хоорондын менежментийн циклд эргэх холбоо үүсэж, үйл ажиллагаанд сайжруулалт хийгдэж, үр дүнд дорвитой ахиц дэвшил гарч чадахгүй байна.* Тухайлбал, улсын хэмжээнд боловсролын чанар, сурлагын амжилтыг үнэлж эхэлснээр сургалтын хөтөлбөр, сурах бичгийн боловсруулалт болон хэрэгжилтийг дэмжих үйл ажиллагааг судалгаанд суурилан сайжруулах суурь тавигдсан боловч судалгааны үр дүнг хэрэглэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх ажил бүх шатны байгууллагад дутмаг байна. Жишээ нь ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн удирдамж, аргачлал батлагдсан ч түүнийг мөрдөх талаар мэргэжлийн байгууллага хоорондын нэгдсэн төлөвлөгөө, зохицуулалт өнөөг хүртэл хийгдээгүй байна.

Иймд бүх түвшний боловсролын хамрагдалт, чанар, инклюзив ба үл алагчилах байдлын судалгааг тодорхой давтамжтайгаар тогтмол явуулж, үр дүнг боловсролын салбарыг бүхэлд нь болон дэд салбаруудын хөгжлийн талаар баримтлах бодлого, стратеги, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээг тасралтгүй сайжруулах баталгаа, нотолгоо болгон

ашиглаж байх зарчмыг баримтлах шаардлагатай. Үүний тулд тухайн жилийн судалгаанд сонгогдсон боловсролын түвшин болон ангийн хүрээнд бүх сургуулийг хамруулж, судалгаанд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт суулган батлуулж, санхүүжүүлж байх нь зүйтэй. Бас нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлт болон хяналт-шинжилгээний тогтолцоог бий болгохын тулд холбогдох байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, солилцоог идэвхжүүлэх түншлэлийн шинэ соёлыг бий болгох хэрэгцээ байна.

- *Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний зөрүүх байна.* Тухайлбал, 2018 оны чанарын судалгаа ба улсын шалгалтын хөндлөнгийн болон сургуулийн өөрийн үнэлгээ хоорондоо бага боловсролд 31.1–41.1, суурь боловсролд 29.4–46.8, бүрэн дунд боловсролд 30.1–51.5 хувийн зөрүүтэй тус тус байсан байна. Энэ их зөрүү нь сургуулийн багш нарт үнэлгээний даалгавараа боловсруулах, даалгаврын гүйцэтгэлийг үнэлэх мэдлэг, чадвар, арга зүй дутагдаж байгаатай үндсэндээ холбоотой. Үнэлгээний өндөр эрэмбийн даалгавар боловсруулах нь мэргэшил шаардсан нарийн чимхлүүр ажил байдаг тул багш нэг бүрд ийм ахадсан үүрэг хүлээлгэж, тэдний ачаалалыг нэмэгдүүлэх шаардлагагүй юм.

Иймд стандартчилагдсан даалгаврын нээлттэй сан бий болгох нь суралцахуйн үр дүн ба суралцагчдийн сурлагын амжилтыг үнэлэх хөндлөнгийн болон өөрийн үнэлгээний зөрүүг багасгахад чухал ач холбогдолтой. Иймээс даалгаврын ийм санг хөгжүүлэхэд зориулж, улсаас тодорхой хэмжээний төсөв, хөрөнгө зарцуулах шаардлагатай. Ингэснээр, стандартчилагдсан даалгаврын нээлттэй санг үүсгэх төдийгүй, шаардлага хангасан даалгаваруудаар тасралтгүй баяжиж, хэрэглээ нэмэгдэж, багш нарын ачаалал багасах практик ач холбогдолтой.

Харин ЕБС-ийн багш нарт болон их, дээд сургуульд багш хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад суралцахуйн үе шат бүрийн үр дүн, тэдний төлөвлөлийн үнэлэх ялгаатай хоёр арга зүйг эзэмшүүлэх, сургалтын хөтөлбөрт суурилсан үнэлгээний даалгавар боловсруулах арга, аргачлалыг таниулах, танин мэдэхүйн түвшний доод эрэмбийн даалгавраас илүүтэй дээд эрэмбийн ур чадварыг сорьсон асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах, боловсруулах, бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн даалгавар боловсруулах аргазүйг эзэмших нээлттэй боломжийг олгох хэрэгтэй.

### 2.3. Багшийн хангалт, хөгжил

**Ололт амжилтаас:** Монгол Улсад бүх түвшний боловсролын багшийн хангалт, ялангуяа багшийн хөгжилд 1990-ээд оны сүүлчээр эргэлтийн шинжтэй өөрчлөлт шинэчлэл хийгдсэн онцлогтой. Учир нь боловсролын, түүний дотор суралцахуйн төлөвлөлтийг оролтод бус гаралтад баримжаалан тодорхойлсон боловсролын стандарт, сургалтын нээлттэй хөтөлбөрүүд, сонголттой сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилт нь “шинжлэх ухааны бэлэн мэдлэг дамжуулдаг багш төвтэй арга зүй”-гээс “суралцагчдын бүтээлч үйлээр шинэ мэдлэг бүтээлгэх суралцагч төвтэй арга зүйг шилжих шинэчлэлийг шаардсан. Өөрөөр хэлбэл, багшийн албан тушаалын үндсэн чиг үүрэг, багшлах үйлийн агуулга, зарчим, хөдөлмөрийн харилцааг цоо шинээр авч үзэж, шийдвэрлэх хүндхэн сорилтыг бий болгосон юм.

Иймээс өнгөрсөн хугацаанд Монголын төрөөс энэ сорилтыг даван туулах чадвартай багш бэлтгэх, давтан бэлтгэх, тэдний тасралтгүй хөгжлийг хангах хөгжлийн бодлого баримталж, суралцахуйн орчин үеийн конструктив ба когнетив онолын суурь зарчмууд, хүн судлалын шинжлэх ухаануудын интеграцид суурилсан дидактикийн стратегиудийг тодорхойлон баталж, багшийн ажлыг хэмжих нэгжийг томсгон, багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх, урамшуулах, багшлах эрх олгох, мэргэжлийн зэрэг олгох, мэргэжил дээшлүүлэх, цалин хөлсийг тооцож олгох хөшүүргүүдийг цогцоор нь уялдаа холбоотойгоор авч үзсэн эрх зүйн шинэ орчинг бүрдүүлж, тэдгээрийн хэрэгжилтийг хангахын тулд боломжийн хэрээр хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн байна. Энэ том сорилтыг үе үеийн багш нар нэр төртэйгөөр даван туулж, боловсролын хөгжлийн өнөөдрийн түвшинд хүрснийг цохон тэмдэглэх нь зүйтэй.

Өнөөдөр бүх түвшний боловсролын сургалтын байгууллагууд мэргэжлийн багшаар 95-аас дээш хувьтайгаар хангагдаж, багшийн ил хомсдол арилсан байна. 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг, ЕБС, НТБ-ын төв, МСҮТ, их, дээд сургууль коллеж гэсэн бүх түвшний сургалтын 2748 байгууллагад нийт 46,303 багш ажиллаж, нийт хүн амын 32,4 хувьд

(Статистикийн үндэсний хороо, 2018) бүх шатны боловсролын үйлчилгээ үзүүлж байна.

***Сорилт бэрхиэлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж. Үүнд:***

Монгол Улсын Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай болон Боловсролын тухай багц хуулийн хүрээнд 1990 оноос хойш өнөөг хүртэл багштай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт тодорхой үе шатуудыг туулан боловсронгуй болж байгаа ч хөгжлийн өнөөгийн шатанд боловсролын бүх түвшний багш бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох ажил удааширч, багшийн хөгжлийг дэмжсэн олон талт харилцааны эрх зүйн нэгдсэн зохицуулалт алдагдаж, тэдний цалин хөлс, нийгмийн тулгамдсан асуудлууд архагшиж нэн даруй шийдвэрлэх нэлээд асуудлууд хуримтлагдаад байна. Тухайлбал,

- *Боловсролын бүх түвшний сургалтад мөрдөх сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг, үнэлгээний журам нь ойр ойрхон үндэслэл султай өөрчлөгдөж байгаа нь сургууль багш нарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэж байна.*

Энэхүү ул суурь муутай олон өөрчлөлтийн шалтгаан нь шинжлэх ухааны судалгаанд гүн бат суурилагагүй, өргөн олны бүтээлч, бодит хэлэлцүүлэг, зөвшилцлийг оромдсонд оршиж байна гэж үзэж болно. Тухайлбал, олон улсад өргөн хэрэглэж буй “action oriented”, “competence/competency based” ба “learning outcomes” гэсэн нэр томьёо, тэдгээрийн агуулгыг манай улсын СӨБ-д “үйл ажиллагаанд суурилсан”; бага, дунд боловсролд “цогц чадамжид суурилсан; МСҮТ-д “чадамжид суурилсан”; их дээд сургуульд “хөтөлбөр ба хичээлийн суралцахуйн үр дүнд суурилсан” гэх мэтээр янз бүрийн нэр томьёо хууль, тогтоомжинд тусгаж албажуулан хэрэглэж байгаа нь нэгдмэл нэг үзэл баримтлал бүхий суралцахуйн гаралтын үр дүнд суурилсан төлөвлөлтийн үзэл санааг боловсролын түвшин бүрд ялгаатай өөрчлөлт явагдаж байгаа мэт зөрүү ойлголтыг хүмүүст төрүүлж, түвшин хоорондын залгамж холбоог бүдгэрүүлэх хандлагатай байгааг анхаарах хэрэгтэй. Иймд Боловсролын тухай багц хуулийн үзэл баримтлалыг өргөн хэлэлцүүлэг, зөвшилцлийн үндсэн дээр нягт нямбай боловсруулж, түүнийгээ хууль, тогтоомжоор баталгаажуулан, чанд мөрдөх нь зүйтэй.

- *Мөн их дээд сургуулийн багш нар мэргэжилтэн бэлтгэх стандартад суурилсан сургалтаас академик эрх чөлөөнийхөө хүрээнд тасралтгүй сайжруулж байх сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлт шилжиж байгаатай холбоотойгоор сургалтын менежментийн шинэчлэлийн арга зүйд суралцах шаардлага тулгарч байна.* Тухайлбал, багшийг их дээд сургуулиудаар бэлтгэх тогтолцоотой боловч төрийн болон хувийн хэвшлийн 40 гаруй их дээд сургуулиуд багш бэлтгэх магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөрүүдээр сургалт явуулж байгаа нь бэлтгэж буй багшийн чанарт сөргөөр нөлөөлөхөд хүргэж байна.

Иймд юуны өмнө багш бэлтгэхдээ үндэсний хэмжээний багш мэргэжлийн үйлийн хүрээг багш бэлтгэх мэргэжлийн хослол, индекс ба ЕБС-ийн зураглал (байршил, хэмжээ, хэв шинж), сургалтын төлөвлөгөөний бүтэц, агуулгын нийцлийг бүрэн хангаж чадахаар боловсруулж батлах хэрэгтэй байна. Шинэчлэн батлах үйлийн хүрээгээ үндэслэн багш мэргэжлийн хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх замаар суралцахуйн оролтын тэгш боломжийг хангах, улмаар багш мэргэжлээр төгсөгчдийн суралцахуйн гаралтын үр дүнг харьцуулан хөтөлбөрүүд тасралтгүй сайжирч байх хүчин зүйлс болох байгууллагын ба хүний нөөцийг чадавхыг бэхжүүлж байх шаардлага байна.

- *Багш нар эрхэлж буй ажлынхаа нарийн нийлмэл чанар, гүйцэтгэлийн бодит ачаалал, өндөр ур чадвар, нийгмийн өмнө хүлээх өндөр хариуцлагадаа нийцээгүй нийгмийн статус, үнэлэмж, цалин хөлстэйгөөр олон жил ажиллаж байна.* Тухайлбал, 2019 оны байдлаар багшийн 1 сарын үндсэн цалин (цалингийн 1-р шатлалаар) 648,980 төгрөг буюу тухайн үеийн харьцуулсан долларын ханшаар 245.48 ам.доллартой тэнцэх хэмжээтэй байна. СҮХ-ны Статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн 1212.mn сайтад байгаа мэдээллээс харахад 2018 оны боловсролын салбарын ажилтны дундаж цалин 2014 оноос хойш 55.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, харин 96.5 ам доллараар буурсан дүнтэй байна.

Цаашид багшийн цалин хөлсийг эрс нэмэгдүүлэх, ингэхдээ үндсэн цалинг эрс нэмэгдүүлэх нэг удаагийн интервенц хийх замаар, багш ба бусад албан хаагчдын цалин хөлсний хоорондох харьцаанд бодитой өөрчлөлт гаргаж, цаашид тэр харьцааг тогтвортой мөрдөх хэрэгтэй. Ингэснээр багшийн хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн статус, нэр төр өргөгдөж, чадварлаг элсэгчид татагдаж, багшлахуйн чанарын төлөө өрсөлдөөн үүсэж, жендэрийн харьцааны оновчтой бус

байдлын асуудал ч шийдвэрлэгдэж эхэлнэ. Мөн багшийг сургалтын үндсэн үйл ажиллагаанаас хөндийрүүлэхгүй байх, улс төрийн болон захиргааны олон төрлийн нэмэлт ажилд дайчлахаас хамгаалах шаардлагатай.

- *Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо институтчилагдаж, БМДИ нь ЕБС, цэцэрлэгт 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш нарт зориулсан үндэсний хэмжээний үндсэн сургалтыг зохион байгуулж, тус сургалтад жилд дунджаар нийт багшийн 13.7 хувийг хамарч байгаа боловч 10-аас дээш жил ажиллаж буй багш нар мэргэжил дээшлүүлэх албан ёсны сургалтад хамрагдаж байхаар үйлчилгээнийхээ хүрээг өргөжүүлж чадахгүй байгаагаас багшийн хөгжил дэх үл алагчлах байдал үргэлжилсээр байна.* Тухайлбал, 10-аас дээш жил ажилласан багш нар өөрсдөө хүсвэл сургалтын зардал, төлбөрөө өөрөө хариуцаж, сургалтад хамрагдаж болдог зохицуулалттай байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлын төсөв жил бүр буурсаар байна. Багш нарын хөгжлийг хангах эрх зүйн зохицуулалтад их дээд сургуулийн харьяа лицей сургууль, МСҮТ, НТБ-ын төвд ажиллаж буй ижил мэргэжлийн багш нарын асуудал орхигдсон байна. Мөн нийслэл, орон нутгийн боловсролын газар, төрөлжсөн сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлж буй багш нарын нэгдсэн мэдээлэл улсын хэмжээнд нэгтгэгдэхгүй байгаагаас төрөлжсөн сургалтын үр ашиг, үр өгөөжийг тооцох боломж хязгаардагдаж байна.

Цаашид хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, бүх төрлийн сургалтын хэрэгцээг тодорхойлох, оролцогчдын талаар урьдчилсан мэдээ гаргах, зардал төсвөө төлөвлөн санхүүжилтийн эх үүсвэрүүдийг баталгаажуулах, сургалтын хөтөлбөрөө чанаржуулах, сургагч багш бэлтгэх, сургалт зохион байгуулах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах зэрэг цогц үйл ажиллагааны менежментийг улам боловсронгуй болгож байх ёстой. Багшийн хөгжих хэрэгцээнд суурилсан нээлттэй, сонголттой онлайн сургалтын хөтөлбөр, модулиудыг санал болгодог төр, төрийн бус байгууллага, их дээд сургуулиудыг оролцоог хангасан үйлчилгээний тогтолцоо бий болгох хэрэгтэй юм.

#### 2.4. Сургалтын байгууллагын удирдлага

Боловсролын бүх түвшний сургалтын байгууллагад удирдах албан тушаалтныг бэлтгэх, сонгон шалгаруулах, томилох, тэднийг мэргэшүүлэх, хөгжүүлэх оновчтой тогтолцоо бүрдээгүй, энэ асуудлаар баримтлах хөгжлийн тогтвортой бодлого байхгүй байна.

##### **Сорилт бэрхшээлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж**

- *Сургалтын байгууллагын удирдах ажилтны томилгоонд мэргэжлийн карьерийн зарчим бодитой хэрэгжихгүй байна.* Тухайлбал, ЕБС-ийн захиралд 5 хүртэлх жилдээ ажиллаж байгаа удирдах ажилтны эзлэх хувь сүүлийн 10 жилийн хугацаанд 41.5 хувиас тасралтгүй өссөөр 2018-2019 оны хичээлийн жилд 70 хувьд хүрсэн байна. Мөн багш бус мэргэжлийн захирлын тоо нийт захирлын 32 хувийг эзэлж байна. Энэ нь ажлын арга туршлага багатай, мэргэжил, онол, арга зүйн хангалттай бэлтгэлгүй хүмүүсийг удирдах албан тушаалд томилж, боловсролын салбарт хийгдэж буй нарийн нийлмэл, гүн гүнзгий өөрчлөлт шинэчлэлд “нэмэр болохоосоо илүү нэрмээс” болж байгааг харуулна. Хэдийгээр өргөн уудам газар нутаг, тархай суурьшсан хүн амтай, дэд бүтцийн хөгжлөөс хамаарч хөдөө, орон нутагт ажиллах удирдах албан тушаалтны ажлын байрны сонгон шалгаруулалтад орж буй иргэд ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байх боломж, нөхцөл хомс байгаа ч 2018 оны байдлаар нийт захирлын 32 хувь, сургалтын менежерийн 19.4 хувь нь багш бус мэргэжлийнх байгаа нь сонирхол татахгүй байхын аргагүй байна.

Иймд боловсролын мэргэжлийн удирдах ажилтны нөөцийг бэлтгэх, тэднийг мэргэшүүлэх талаар баримтлах оновчтой бодлогыг тодорхойлж, тэд үр бүтээлтэй, тогтвортой ажилладаг байх тогтолцоог бүрдүүлэх замаар удирдах ажилтны томилгоог өнөөдөр хүчээ аваад байгаа улс төрийн шууд нөлөөллөөс хамгаалах арга хэмжээ авах нь салбарын яамны хойшлуулашгүй зорилтын нэг болсон байна. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг зөв, бодитой тодорхойлж, шаардлага хангасан иргэнийг сонгон шалгаруулалтад оруулах, томилох талаар эрх зүйн зохицуулалтад байсан өндөр оноо авсан ч гэсэн албан тушаалд томилогддоггүй байсан цоорхойг арилгах, мөн тухайн шаардлагыг хангаагүй хүнийг томилсон тохиолдолд уг шийдвэрийг гаргасан эрх бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгож баталгаажуулж, түүнийгээ мөрддөг байх хэрэгтэй байна.



- *Сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн цалин хөлсний асуудал оновчтой шийдлээ ололгүй удаж байна.* Тэдний цалин хөлс дийлэнх тохиолдолд тухайн сургалтын байгууллагын багш, сургалтын менежер, арга зүйчдээс доогуур байна. Учир нь багш нар тушаал дэвшиж сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллах тохиолдолд сүлжээгээр тогтоосон албан тушаалын үндсэн цалин нь хэдийгээр харьцангуй өндөр боловч энэ албан тушаалд тохирсон зохих нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгогдохгүй байгаагаас нийт цалин хөлс буурдаг талаар тэд гомдол гаргадаг. Захирал, эрхлэгч нар цалин хөлсөө нэмэгдүүлэх илүү баталгаатай арга зам нь багшийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл авах явдал гэж үздэг ч энэ нь нэг талаас, 2 өөр албан тушаалыг албан ёсоор хавсран гүйцэтгэснээр аль аль ажлынх нь чанарт сөргөөр нөлөөлөх, сонирхлын зөрчлүүд үүсэх нөхцөл бүрдэх нөгөө талаас, нийт захирлын 30 гаруй хувь нь багш бус, боловсролын салбарт ажиллаагүй хүмүүс ажиллаж байхад тэднээр хичээл заалгаж, мэргэжлийн зэрэг олгох нь утгагүй бөгөөд боломжгүй юм.

Иймд сургалтын байгууллагын удирдах албан тушаалтанд ажил олгогч нь тэдэнтэй жил бүрийн гэрээ байгуулан ажиллаж, үр дүнг үнэлж дүгнэх үндсэн дээр холбогдох нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал олгох арга механизмьг эрх зүйн хувьд оновчлон баталгаажуулж, мөрдөх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчдийн цалин хөлсний хэмжээг ямар ч тохиолдолд тухайн сургалтын байгууллагын бусад албан тушаалтнаас харьцангуй өндөр байлгах бодлого баримтлах нь зүйтэй.

- *Боловсролын бүх түвшний сургалтын байгууллагын удирдах ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх институтчиглагдсан тогтолцоо байхгүй бөгөөд удирдах ажилтныг томилогдсоны дараа мэргэжлийг нь дээшлүүлэх, удирдлага, арга зүйн зөвлөмж өгөх үйл ажиллагаа давамгайлж байна.* Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх үйл ажиллагаа нь боловсролын удирдлага, менежментийн чиглэлээр боловсролын зэрэг ахиулах магистр, докторын зэрэг горилсон сургалтуудаар хязгаарлагдаж, энэ чиглэлийн төрийн нэгдсэн үйлчилгээ дутагдалтай байна. Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоо бий болгох, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны хүртээмж, давтамжийг нэмэгдүүлэх тухайлбал, сургалтын менежерүүд тухайн сургуулийнхаа нийт багшид сургалт, арга зүйн зөвлөмж, чиглэл өгч ажилладгийнх нь хувьд 5 жил тутамд бус харин ч 2-3 жил тутамд үндэсний хэмжээнд мэргэжлийг нь дээшлүүлэх албан ёсны сургалт, үйл ажиллагаанд хамруулдаг байх нь чухал байна.

## 2.5. Боловсрол дахь мэдээлэл, харилцаа, холбооны технологи

**Ололт амжилтаас:** Монгол Улсын төрөөс боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлж, сүүлийн 20 гаруй жил тодорхой бодлого, хөтөлбөрүүд баглан хэрэгжүүлсний дүнд МХХТ нь боловсролын аль ч түвшинд өдөр тутмын ажил, амьдралын төдийгүй сургалтын хэрэглээ болж чадсан байна. Тухайлбал, БСМС-ийг хөгжүүлж, үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлснээр салбарын хэмжээний өгөгдөл, мэдээллийг нэгтгэж, МХХТ-ийг боловсролын салбарын бодлого, төлөвлөлт, удирдлагын менежментэд үр дүнтэй хэрэглэж, их дээд сургууль, ЕБС, цэцэрлэгийн мэдээлэл, суралцагч, суралцагчдын сурлагын амжилт, хүний нөөцийн хуваарилалт гэх мэт бүхий л мэдээллийг нэгтгэж хэрэглэх боломжийг бий болгож эхлээд байна. Мөн онлайн орчин дахь сургалтын цахим агуулга, нөөц өсөн нэмэгдэж, БСШУСЯ, боловсролын мэргэжлийн байгууллагуудын цахим агуулгын тоо 1,000 гаруй, багш нар өөрсдөө бүтээж онлайн орчинд байршуулсан агуулгын тоо 27,000-д хүрсэн байна. Их дээд сургуулийг багш мэргэжлээр төгсөгчдийн болон ЕБС-ийн багш нарыг чадавхижуулах МХХТ-ийн чадварын стандартын төсөл боловсруулагдан батлагдах шатандаа явж байна. 2017 оны байдлаар СӨБ-ын байгууллагын 78.7 хувь интернетэд холбогдож, нэг компьютерт ногдох багшийн тоо 1.2 байгаа бол ЕБС-ийн 86.5 хувь нь интернетэд холбогдож нэг компьютерт ногдох сурагчийн тоо 12.5, багшийн тоо 1.6 болсон байна.

**Сорилт бэрхиэлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж. Үүнд:**

- *Боловсролын салбар дахь МХХТ-ыг хөгжүүлэхэд алсын хараатай нэгдсэн бодлого, үгүйлэгдэж байна.* Өөрөөр хэлбэл, боловсролын салбар дахь МХХТ-ыг хөгжүүлэх чиглэлээр 2015 оноос хойш хүчин төгөлдөр мөрдөж буй бодлого, хөтөлбөрүүдийн хугацаа дуусаж, өнөөдрийн байдлаар алсын хараатай нэгдсэн бодлогогүй явж байна. Боловсролын салбарын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөөнд МХХТ-ийг нэвтрүүлэх талаар тусгах болон боловсролын салбарт МХХТ-ийн баримтлах бодлого, хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, багш, боловсролын байгууллагын ажилтны МХХТ-ийн чадварын стандартыг бүх шатны боловсролын сургалтын

байгууллагын түвшинд мөрдөх шаардлагатай.

- *Нэг талаас, БСМС-ийн мэдээллийн болон техник технологийн боломж нөгөө талаас, сургалтын байгууллагын түвшин дэх хэрэглэгчийн энэ системийг ашиглах техник, технологийн боломжийн хоорондох зөрөө их байна. Өөрөөр хэлбэл, хуримтлуулж цэгцэлсэн мэдээллийг ашиглах мэдээллийн урсгал, солилцоо удаан, түгжрэлтэй байна*

Иймд нэг талаас, БСМС-ийн модулиудыг бүрэн гүйцэт хөгжүүлж, боловсролын бүх түвшний сургалтын байгууллагын багш, ажилтны мэдээллийн сан, сургалтын хөтөлбөрийн сан, төгсөгчдийн мэдээллийн сан зэрэг үнэн бодит мэдээллийн санг зөв үүсгэн бүрдүүлж, хэрэглэгчдэд мэдээллийн хялбар шуурхай үйлчилгээг үзүүлдэг байхаар тус системийн тогтвортой ажиллагааг хангаж ажиллах бүтэц, тогтолцоог институтчилах шаардлага байна. Нөгөө талаас, боловсролын салбар дахь БСМС-ийн үр өгөөжтэй, хэвийн ажиллагааг хангахад ялангуяа ЕБС, цэцэрлэгийн түвшинд байршил харгалзахгүйгээр бүх суралцагч, багш нарын хэрэглээг хангахад сургалтын байгууллагын интернетийн хурдыг нэмэгдүүлж, компьютер, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг тодорхой давтамжтайгаар хийж байх дунд хугацааны тооцоолол, төлөвлөлттэй байж, санхүүжилтийн эх үүсвэрийн баталгааг ханган ажиллах хэрэгтэй. Түүнчлэн хүний нөөцийг чадавхижуулах сургалтуудын хүртээмжийг нэмэгдүүлэх, сурагчдад МХХТ-ийг зүй зохистой хэрэглэх чадвар, дадал эзэмшүүлэх, цахим орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах нь зүйтэй.

## 2.7. Боловсролын статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээ

**Ололт амжилтаас:** Боловсролын статистик нь аливаа үйл ажиллагааны өнгөрсөн үеийн түүхийг, одоо байгаа бодит байдлыг, нөгөө талаас ирээдүйн төлөв байдлыг тоон хэлээр илэрхийлдэг. Монгол Улсад 1920-иод оноос эхлэн боловсролтой холбоотой мэдээллийг цуглуулан үзүүлэлтийг гаргаж эхэлсэн түүхтэй. Тухайн цаг үе бүрийн боловсролын бодлого, эрх зүйтэй холбогдуулан мэдээллийг цуглуулах, боловсруулах болон тооцох шалгуур индикаторууд, арга аргачлалыг сайжруулж ирсэн. 1990-ээд оны дунд үеэс салбарын статистикийг харьцангуй эрчимтэй хөгжүүлж, боловсролын мэдээллийг олон улсад нийтлэг хэрэглэгддэг шалгуур, индикатор, үнэлгээний арга аргачлалыг ашиглан аль болох бүрэн гүйцэд цуглуулж, боловсролын үзүүлэлтүүдийг тооцоолон боловсруулж, Монголын боловсролыг бусад улс орны боловсролтой харьцуулах боломжийг бий болгож иржээ.

Аливаа бодлогын шийдвэр, зорилго зорилтын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай боловсролын түвшин бүрийн онцлогт нийцсэн статистикийн албан ёсны болон захиргааны маягыг багтруулан салбарын хэмжээнд мөрдөн ажиллаж байгаа нь үнэн бодит мэдээллийг нэг эх үүсвэрээс цуглуулан боловсруулж, хэрэглэгчдийг чанартай мэдээллээр хангах боломжийг бүрдүүлж байна.

Боловсролын мэдээллийг цуглуулах, боловсруулах үйл ажиллагаанд 2000 оноос эхлэн мэдээллийн технологийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд сүүлийн жилүүдэд боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх ажил эрчимтэй явагдаж байна. Үүний үр дүнд мэдээллийн хамгийн их цэгэн задаргаатай өгөгдлийг бий болгох, богино хугацаанд эдийн засгийн үр ашигтай бодлогын судалгаа хийх боломжийг бүрдүүлсэн нь нотолгоо бүхий үр дүнд суурилсан бодитой төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд томоохон ахиц дэвшил гарчээ.

**Сорилт бэрхшээлүүд тэдгээрийг даван туулах арга замын талаарх зарим зөвлөмж.**

- *Мэдээллийн цуглуулах маягыг сайжруулах үйл явц удаашралтай байгаа нь ТХЗ-ын биелэлт, цаг үеийн онцлог, бодлогын томоохон өөрчлөлт, тэдгээрийн хэрэгжилтийг зохицуулсан дүрэм, журмын хэрэгжилтийг үнэлэх боломжгүйд хүрч байна.*

Боловсролын статистик маягт нь 2008 оноос хойш өөрчлөгдөөгүй бөгөөд бодлогын томоохон өөрчлөлт, шинэчлэлттэй холбоотой үзүүлэлт тусгагдаагүй, тогтвортой хөгжлийн зорилтыг хэмжиж, үнэлж, дүгнэхэд ихээхэн хүндрэл бэрхшээл учирч буй тул маягт, аргачлал, арга зүйг шинэчлэх асуудалд онцгой анхаарал хандуулан ажиллах шаардлагатай байна.

- *Мэдээллийн эх үүсвэр тодорхой бус, өгөгдөл оруулагч, цуглуулагчдын статистикийн тухай ойлголт, ур чадвараас шалтгаалан мэдээлэл нэгжээсээ зөрүүтэй ирэх, хэрэглэгчдийн ойлголт, хандлагаас шалтгаалан мэдээллийг буруу хэрэглэх, тайлбарлах асуудал байсаар байна.*

Иймд статистик мэдээний мөн чанар, үр дүн, мэдээллийг хэрхэн хэрэглэх талаарх ойлголт, ур чадварыг сайжруулах, хүний нөөцийг чадавхжуулах талаар сургалтыг тогтмол явуулах, түвшин бүр дэх хүний нөөцийн тогтвортой байдлыг хангахад анхаарах шаардлага байна. Мэдээллийг хэрхэн ашиглах, арга зүйн талаар хэрэглэгчдийн ойлголт, чадварыг сайжруулах үүднээс БСШУСЯ нь, ҮСХ-той хамтран “Статистикийн арга зүйн гарын авлага (ЕБС-ийн багш нарт зориулав)-ыг гаргасан бөгөөд цаашид ч тасралтгүй ном, гарын авлагаар хангах, ойлголт хандлагыг сайжруулах чиглэлээр боловсролын бүх түвшинд бодлого боловсруулагч, менежерт зориулсан сургалтыг хийх шаардлагатайгаас гадна удирдах ажилтан, багш нарын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт тусгах нь зүйтэй.

- *Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан мэдээлэлд боловсруулалт хийх болон програмжуулалттай холбогдуулан мэдээлэл алдагдах, мэдээллийн нууцлал, аюулгүй байдалд хүндрэл учирч байна.*

Мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглан цахимжуулснаар мэдээллийн аюулгүй байдал, өгөгдлийг нөөцлөх болон нууцлалыг хангах, энэ чиглэлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг гаргах шаардлагатай байна. Мэдээллийн нууцлал болон гадны халдлагаас хамгаалах, цахим болон цаасан мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг хослуулан хийх шаардлагатай байна.

## 2.8. Боловсролын сектор дамнасан бодлого, төлөвлөлт

Энэ дэд бүлэг дэх бодлогын судалгааны сэдвийн хүрээнд дараах 5 чиглэл (аспект)-ээр баримт, өгөгдлийн тойм үнэлгээ (desk review) хийж, чиглэл бүрийн хувьд түлхүүр асуудал, сургамж, ээдрээт сорилууд (key issues, lessons and challenges)-ыг тодорхойлсон болно. Үүнд:

- Бодлого, Стратеги
- Төр засгийн манлайлал, Эзэмшилт эрх бүрдэмж
- Санхүүжилтийн хамааралт арга хэрэгсэл, Төрийн зардлын менежмент
- Зохицуулалт, Түншлэл
- Ядуурал бууруулалт, Өргөн хүрээт санаачилга

Мөн төрийн бодлогын үнэлгээ, судалгааны ажил гүйцэтгэх үндэсний хэмжээн дэх чадавхын хөгжил ахиц–боловсронгуйжилт (Developing national research and evaluation capacities for public policies), боловсролын талаар төрөөс баримталж буй бодлогод болон боловсролын сектор дэх инновац дэмжлэгийн ахиц [жишээлбэл, түүнд үзүүлэгч чадавхын хөгжлийн хөтөлбөрийн тусламжтай] (Promoting innovations in education and public policy)-ын талаар авч үзсэн. Энд бас олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэмжээний баримт бичгүүд хоорондоо хэрхэн нийлэмжтэй байгаа (inter-sectoral approaches towards policy and planning, aligned with national, regional and international agendas) тухайд дурдсан.

Монголын хувьд боловсролын сектор дамнасан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн судалгаагаар дараах гол сорилтуудыг илрүүлсэн. Үүнд:

- Хэрэгжилтийн төлөвлөгөө баримталж хэвшээгүй;
- Зохицуулалтын тогтолцоо, бүтэц, механизм боловсронгуй биш;
- Явцын үнэлгээ, төрөлжсөн зориулалттай бусад үнэлгээ тогтмолжоогүй;

Харин цаашид дараах түлхүүр асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай. Үүнд:

- Сектор дамнасан арга хандлагаар боловсруулсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц дахь үнэлгээ (verification, бусад төрөлжсөн зориулалтат), хамтран хэрэгжүүлэгч талуудын хоршилт, түншлэл болон шаардлагатай бусад үйлийн зохицуулалтын үндэсний тогтолцоо төлөвшүүлэх;
- Хэрэгжилтийн явцыг шинжиж байх нарийвчлал бүхий хэмжээсжүүлсэн илрүүлэгч заалтуур (indicators) боловсруулж хэрэглэж хэвших;
- Хэрэгжилтийн үйл явцын илтгүүр индикаторуудыг хэмжих, баталгаажуулах үнэлгээ хийх үүрэгтэй сонирхогч-ашиг тус хүртэгч (stakeholders) талуудыг тодорхойлох;
- Эрх мэдлийн төвлөрлийг зохистой сааруулах, санхүүжилтийн уян хатан арга хэрэгсэл ашиглах, хоршин түншилж, хэрэгжүүлэгч талуудын бодит оролцоо бүхий шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох.

### III. Судалгаагаар илрүүлсэн сургамжууд

Боловсролын цогц суурь судалгаанд бүрэн суурилагагүй улс төрийн шийдэл давамгайлсан, зохих бэлтгэлийг бүрэн хангаагүй богино хугацаанд хэрэгжүүлэхийг зорьсон сүүлийн жилүүдийн боловсролын шинэчлэлийн бодлого, стратеги, тэдгээрийн хэрэгжилтийн менежментийн зарим алдаа, дутагдлагаас шалтгаалж, Монгол Улсын боловсролын тогтолцоо өнөөдөр хямралын байдалтай байна. Энэхүү хямралаас бид харилцан бие биетэйгээ нөхцөлдсөн дараах сургамжуудыг ялгаж болохоор байна. Үүнд:

#### 3.1. Дуугарвал дуу нэг, дугтарвал хүч нэг байдгийн сургамж

Энэ хямралд хүргэсэн олон хүчин зүйлсийн нэг нь боловсрол, суралцахуй, багшлахуй, хүний хөгжил зэрэг боловсролын үндсэн нэр томьёо, түлхүүр үгийн агуулгын ба холбоо хамаарлын мөн чанарт гарч буй хурдацтай гүнзгийрэл, өргөжилт, тэдгээрийн тайлбар, орчуулга, практик хэрэглээтэй холбоотой зарим алдаа, дутагдлаас үүдэлтэйгээр Монголд түгээмэл шинжтэй болсон нийгмийн хөгжил, боловсролын хөгжил, хүний хөгжлийн талаарх хүмүүсийн *ойлголтын зөрөөнүүд* юм. Тодруулбал, боловсролын хөгжлийн асуудлыг шийдвэрлэхдээ түүний амин сүнс болсон дор хаяж дараах үндсэн нэр томьёо, түлхүүр үгийн талаар олон улстай ойлголцох түвшинд нийгмээрээ нэг ойлголттой болох шаардлага байна. Өөрөөр хэлбэл, *суралцахуйн* орчин үеийн онол арга зүйд суурилсан Монгол хүний хөгжлийн үзэл баримтлалаа тодруулан баталж, энэ үзэл баримтлалаа тулгуурлан боловсролын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлогоо үнэлэн чамбайруулах шаардлага байна. Үүний тулд боловсролд хамаарах дараах үндсэн нэр томьёо, түлхүүр үг, ухагдахууны агуулга, мөн чанарыг бүх түвшиндээ нэг мөр ойлгох, хэрэглэх зайлшгүй хэрэгцээ байна. Үүнд:

Суралцахуй (learning), эзэмшихүй (acquire), шинэ мэдлэг бүтээх (creating new knowledge), багшлахуй (teaching), боловсролын стандарт (educational standard), сургалтын хөтөлбөр (curriculum), цогц чадамж (competence/competency), суралцахуйн зорилтууд (learning objectives), суралцахуйн үр дүн (learning outcomes), суралцахуйн орчин (learning environments), боловсролын чанар (quality of education), боловсролын нийц (relevance of education), инклюзив боловсрол (inclusive education), үл алагчлах боловсрол (equitable education), тэгш боломж олгосон боловсрол (equality in education), насан туршийн суралцахуй (lifelong learning), бүх нийтийн боловсрол (education for all), хүүхэд бүр суралцах чадвартай (every child learn), тогтвортой хөгжил (sustainable development), тогтвортой хөгжлийн боловсрол (education for sustainable development), тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол (education for sustainable development goals), суралцахуй ба багшлахуйг хувирган өөрчлөх (transformative learning and teaching) гэх мэт.

Бүх нийтээрээ суралцахуй ба боловсролын талаарх ойлголтын зөрөөгөө багасгахын тулд бүх салбарын бүх түвшний бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон боловсролын салбарын судлаачид, мэргэжилтнүүд, багш, удирдах ажилтнууд нийт суралцагчид, эцэг эх, асран хамгаалагчид тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсролын болон хүн яаж суралцаж, хэрхэн хөгжиж төлөвшдөг талаарх ерөнхий мэдлэг, зүй тогтлын талаарх орчин үеийн бичиг үсэгт тайлагдах аянг зарлаж, хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Ингэх нь суралцахуй ба боловсролыг ТХЗ-ын төлөөх боловсролд, бас Монголоо тогтвортой хөгжлийн төлөөх улс орон болгон хувирган өөрчлөх гарааны шанг татах чухал ач холбогдолтой.

#### 3.2. “Дээдэх нь суудлаа олохгүй бол доодох нь гүйдлээ олохгүй”-н сургамж

Боловсролын тогтолцоо хямарсаны шинж тэмдэгүүдийн нэг нь бүх түвшний боловсролын үндсэн үйлдвэрлэл болсон “суралцахуй”-ын үзэл баримтлалын тусгал болсон боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, багшлах эрх, гэдний үндсэн чиг үүрэг, үнэлгээг сайжруулах зорилгоор 2012 оноос хойш боловсролын тухай багц хуульд болон холбогдох дүрэм, журмууд, эрх зүйн актуудад тухайн асуудлуудын *шалтгаанд бус тэдгээрийн үзэгдэлд төвлөрч*, мөн үнэн хэрэгтээ өөр өөр зорилготой, ялгаатай хам нөхцөлд боловсорсон туршлагыг гүйцэт судлан хэлэлцэж, тохиргоо хийлгүйгээр шууд хуулбарлаж хийсэн өөрчлөлтүүдийг богино хугацаанд хэд хэдэн удаа хийсэн явдал юм. Шийдвэр гаргах аль ч түвшинд уламжлал шинэчлэлийн залгамжгүйгээр, авч гээхийн ухаангүйгээр, хөгжлийн алсын хараагүйгээр товчоор хэлбэл, шинжлэх ухааны үндэслэл тооцоололгүйгээр гаргаж байгаа дээр дурдсан өөрчлөлтүүд нь сургууль, багш нарт ойлгомжгүй, төвөгтэй байдлыг үүсгэхийн зэрэгцээ анги танхимын түвшинд багш, сурагчдын ачаалал нэмэгдэж, хичээлийн үр өгөөж багасаж,

сурлагын амжилт доогуур үзүүлэлттэй болоход нөлөөлсөн гэж үзэж болно. Өөрөөр хэлбэл, өнөөдөр Монголын сургалтын байгууллагууд дахь анги танхимын түвшний сургалт нь “нэг үхрийн эвэр доргивол мянган үхрийн эвэр доргих”-той агаар нэгэн байна. Иймд энэ төлөв байдлаас гарахын тулд Боловсролын тухай багц хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулж батлахаар бэлтгэж байгаа энэ цаг үед хуулийнхаа үзэл баримтлалыг ул үндэстэй боловсруулан хэлэлцүүлж, тэдгээрт эрх бүхий хууль санаачлагч субъектүүд хүссэн цагтаа хүссэн зүйлээ өөрчилж болдоггүй дархлааг бий болгох зайлшгүй хэрэгцээ байна.

### 3.3. “Эх нь булингартай бол адаг нь булингартай” байдгийн сургамж

Аливаа хөгжил, хөдөлгөөний тулгуур зарчмуудын нэг болсон тодорхой нэг өөрчлөлт, шинэчлэлийг хийхдээ тухайн асуудлыг үүсгээд байгаа шалтгаан болсон түүний *арга билгийн талуудын динамикийн шилжилтийг туйлшруулснаас* үүсдэг алдаа нь боловсролын салбар дахь заавал авч үзэх ёстой нэг сургамж болоод байна. Тухайлбал, боловсролын аль ч түвшин дэх хувийн өмчийн сургалтын байгууллагуудад тавигдах шаардлагыг оновчлоогүй, суралцагчдынх нь суралцахуйн үр дүнд үнэлгээ дүгнэлт гаргаж, хүлээн зөвшөөрөх механизмгүйгээр ашгийн төлөө байж болохоор хуульчилсан явдал; төрийн өмчийн сургалтын байгууллагууд дахь суралцагчдын цаашдын суралцахуй, ирээдүйн ажил, амьдрал, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтгүйгээр хийгдэж буй хичээлийн сонголтууд; боловсролын байгууллагуудын удирдлагуудад ойр ойрхон хийгдэж буй намын гишүүнчлэл дагасан халаа сэлгээ зэрэг нь шинэчлэн сайжруулахыг зорин цогцлоож байгаа боловсролын тогтолцоогоо эргээд хямруулах хүчин зүйлс болж байна. Энэ нь боловсролд төдийгүй нийгэмд маш их хор уршигтай. Учир нь хэдий чинээ их туйлширна, төдий чинээ их ялгаа үүсдэг тул ашиг орлогын хуваарилалтын ч, үр өгөөжийг хүртэгчдийн ч аль алинд нь нөлөөлж, хот хөдөөгийн, баян ядуугийн, үзэл бодлын, итгэл үнэмшлийн том ялгаа, зөрчилд хүргэж, нийгмийг бүхэлд нь хамарсан тогтворгүй байдлыг бий болгодог. Товчоор хэлбэл, “нуухыг нь авах гээд нүдийг сохлов” гэдэгтэй утга нэг юм. Иймд юуны өмнө боловсролоос шалтгаалан үүсэж бий болдог энэ ялгаралд хүрэхгүй байхын тулд асуудалд тогтолцоон сэтгэлгээгээр хандаж, тулхтай цогц бодлого, хууль, эрх зүйн хүчирхэг зохицуулалттай болох шаардлага байна. Тухайлбал, боловсролын үндсэн асуудлуудаар шийдвэр гаргах эрх мэдлийн сааруулалт, шилжүүлэлт, сийрэгжүүлэлтийг илүү оновчтой болгох, тухайн орон нутгийн хам нөхцөлийг тооцсон инвариант болон хувилбарт сонголтууд бүхий бүтэцтэй сургалтын төлөвлөгөөнүүд нь чанартай, үр өгөөжтэй хэрэгжих, түүнчлэн бэлтгэгдсэн багш нар сургуулийн хэмжээ, байршлаас үл хамааран тогтвортой, үр өгөөжтэй ажиллах боломж олгосон байхаар ЕБС-ийн зураглалыг шинэчлэн мөрдөх, боловсролын албан тушаалын томилгоонд карьерийн зарчмыг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг нэн түрүүнд авах шаардлага байна.

### 3.4. “Өчигдөр бол өнөөдрийн багш, өнөөдөр бол маргаашийн багш” байдгийн сургамж

Шинжлэх ухааны *үндэслэл бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоогүйгээр, стратегийн төлөвлөлт, хэрэгжилтийн менежментийн циклийн үр өгөөжтэй эргэх холбоогүйгээр* боловсролын үйл хэрэгт дорвитой бодит ахиц дэвшил гарах боломж хязгаарлагдаж байгаа сургамж ялгарч байна. Цаашид боловсролын шатлал бүр дэх суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үнэлгээний шалгуур (бенчмарк), сургалтын байгууллагын үнэлгээ болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, багш, холбогдох бусад субъектийн ажлын үнэлгээг боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй нягт уялдуулсан онол, арга зүйн нэгдмэл нэг үзэл баримталтайгаар, залгамж холбоотойгоор, тус бүрийнх нь онцлогтойгоор, суралцахуй төлөв байдал, үе шат бүр (оношлох, явцын, үр дүн)-ийн зорилтууд нь хэмжигдэхүйцээр, хэрэглэгчдэд ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байхаар тус нягтлан боловсруулах шаардлага байна. Өөрөөр хэлбэл “авч гээхийн ухаан”-д суралцах хэрэгтэй байна. Үүний тулд юуны өмнө нэгд, боловсролын чанарын үнэлгээний шалгуур, индикатор, тэдгээрийг хэрэглэх арга аргачлалын талаар хоёрт, боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хөгжлийн асуудлуудаар гуравт, суралцагчдын нас, бие бялдар, сэтгэц, оюун ухаан, сэтгэл хөдлөл, нийгэмшихүйн онцлогоор тус тус нэгдсэн зохицуулалттай цогц судалгааг явуулах шаардлагатай. Ингэснээр боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг хэрэглэгдэхүүн, багшийн хөгжил, сургалтын материаллаг орчин, боловсролын чанарын үнэлгээнд тус тус тавигдах шинжлэх ухааны үндэслэлтэй нэгдсэн шаардлагууд, стандартууд тэдгээрийг хангах

төлөвлөлт, хэрэгжилт, хяналт-шинжилгээ үнэлгээний цикл ажиллагааны гол шийдлүүд нь оновчтой зөв тодорхойлогдсон үндэсний хэмжээний хөгжлийн үзэл баримтлалтай болно. Улмаар энэ үзэл баримталынхаа шийдлүүдийг хууль тогтоомжоор баталгаажуулан тогтвортой мөрдөж чадвал Монгол улсад боловсролын үйлчилгээний оролт, явц, гаралтын төлөв байдлууд жигдэрч тогтвортой, үр ашигтай, үр өгөөжтэй ажиллах үндсэн нөхцөл хангагдах боломжтой.

Дашрамд тэмдэглэхэд Боловсролын салбар дахь чанарын төлөө өрсөлдөөний гол механизм нь нэг талаас, боловсролын түвшин бүрийн гаралт дээрх хүлээгдэж буй үр дүн болж суралцагчдад төлөвшсөн байх ёстой цогц чадамжуудаар тодорхойлогдох хувь хүн болон нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээг илэрхийлдэг боловсролын стандартууд нөгөө талаас, энэ эрэлт хэрэгцээг хангах нийлүүлэлт болох боловсролын үйлчилгээний оролтод хамаарах суралцагчийн эзэмших мэдлэг, чадвар, төлөвшилд тавигдах суралцахуйн зорилт, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн ба орчин, үнэлгээ бүхий сургалтын хөтөлбөр (киррикулим) хоорондын харилцан шүтэлцээ юм. Товчоор хэлбэл, нээлттэй зах зээл, ардчилсан нийгмийн тогтолцоонд чанарын баталгааг хангадаг эрэлт, нийлүүлэлийн гол механизм нь боловсролын салбарт бол боловсролын стандарт ба сургалтын хөтөлбөрийн шүтэлцээгээр тодорхойлогдох учиртай. Боловсролын суурь харилцаа болох энэ шүтэлцээг хангах болон зохицуулах шийдлийг 1995 онд анх Боловсролын тухай хуульд тусгаж өгсөн байдаг. Тухайлбал, тус хуулийн 10.2-т заасан “*Боловсролын стандарт нь зохих түвшин (бага, дунд, дээд)-д суралцагчдын зайлиггүй эзэмшсэн байх боловсролын агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын байгууллагад тавигдах үндсэн шаардлагыг тус тус тодорхойлно*” гэсэн заалт 1995-2002 он хүртэл хадгалагдан үйлчилсэн байна. Хожим тус хуульд 2002 оны өөрчлөлтөөр сургуулийн өмнөх боловсролын түвшний стандартыг, 2009 оны өөрчлөлтөөр мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын стандартыг тус тус нэмжээ. Мөн 2007 оны өөрчлөлт (заалт 11.2)-өөр “*Боловсролын стандарт нь суралцагчдын зайлиггүй эзэмшсэн байвал зохих боловсролын агуулгын түвшин, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно*” хэмээн шинээр найруулж, харин 2016 оны 4 ба 12-р сард тус хуулийн хоёрдугаар бүлэгт дараах зарчмын өөрчлөлтүүдийг оруулжээ. Үүнд:

- Боловсролын агуулгын стандартыг сургалтын хөтөлбөрөөр орлуулж, боловсролын агуулга, үнэлгээний стандартгүй болгосон. (Заалт 10.2 ба 11.1, 11.4, 11.5)
- Боловсролын стандартыг хэн боловсруулж, хэн батлахыг хуульчилсан заалтыг хүчингүй болгосон (Заалт 11.3)
- Боловсролын стандартыг зөвхөн багшийн мэргэжлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагаар хязгаарлахын зэрэгцээ тэдгээрийг ямар субъектүүд боловсруулж батлахыг эзэнгүйдүүлсэн байна. (Заалт 11.2 ба 11.3)

Түүнчлэн “Бага дунд боловсролын стандарт ба киррикулимийг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал (2002)”-д боловсролын стандарт, ба сургалтын хөтөлбөрийн харилцан хамаарал болон тус бүрийнх нь үүрэг зориулалт, онцлог шинжийн талаар маш тодорхой тусгасан байдаг. Иймээс “Бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй” гэсэн сургамжийг сахиж явах нь зүйтэй.

Өнөөдөр энэ суурь шийдлүүд саармагжиж, боловсролын бүх түвшний хамгийн чухал хэсэг болох агуулгад тавигдах шаардлага (стандарт)-ыг боловсролын салбар хуулиудад заагдсан хэмжигдэх боломжгүй ерөнхий заалтууд, сургалтын цөм хөтөлбөрийн Блумын таксономын түвшингүүдээр нэрлэсэн суралцахуйн зорилтуудаар орлуулах болсон байна. Өөрөөр хэлбэл, боловсролын чанарын баталгааг хангах нийгмийн болон хувь хүний хөгжлийн эрэлт хэрэгцээг урьдчилан тогтоож, боловсролын тодорхой чиглэлийн агуулга ба ажил мэргэжлийн *түвшин бүрийн гаралт дээр хүлээгдэж буй суралцахуйн үр дүнг* хүний хөгжлийн тодорхой хүрээгээр айлж нарийвчлан тодорхойлсон, тодорхой хугацаанд нийтээрээ даган мөрдөж, чанарын баталгааг хангадаг боловсролын *стандарт* ба суралцахуйн үе шат буюу *анги* (дээд боловсролд *улирлаар*) *бүрээр судлах хичээл бүрийн сургалтын хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг* тодорхойлдог *сургалтын хөтөлбөрийг* бие биеэр нь оновчгүй орлуулснаас үүдэлтэй ойлголтын болон үйлийн түвшин дэх тодорхой сорилт, бэрхшээлүүд тулгараад байна. Тухайлбал, сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг үнэлэх, багш бэлтгэх, тэдний ажлыг үнэлэх, сургалтын байгууллагын үйл ажиллагааг үнэлэх *стандартууд буюу нийтлэг шаардлагууд* олонтоо өөрчлөгдөж, байгаагаас хяналт-шинжилгээ, үнэлгээний үр өгөөж сул байх нэг шалтгаан болж байна.

## МОНГОЛ УЛСЫН ХАМ НӨХЦӨЛ, ОНЦЛОГ

Монгол Улсын байгаль, цаг уур, улс төр, эдийн засаг, нийгэм соёлын хам нөхцөл, онцлогийн өнөөгийн төлөв байдлыг дараах агуулгаар товч танилцуулав. Үүнд:

### Газарзүйн байрлал, онцлог

Монгол Улс нь Зүүн хойд Азид хойд өргөргийн 41°35'-52°08", зүүн уртрагийн 87°44'-119°55'-ын хооронд, нийт 1,564,116 км<sup>2</sup> талбайг эзлэн орших ба газар нутгийн хэмжээгээр дэлхийд 19 дүгээр байрт (German watch, 2014) эрэмбэлэгддэг (Үндэсний статистикийн хороо, 2018).

Улсын хилийн нийт урт 8,252.7 км (хуурай газраар 7351.6 км, усаар 901.1 км) бөгөөд үүнээс хойд талаараа ОХУ-тай 3543 км (хуурай газраар 2863 км, усаар 680 км), өмнөд талаараа БНХАУ-тай 4709.7 км (хуурай газраар 4488.6 км, усаар 221.1 км) тус тус хиллэнэ. Улсын нийслэл Улаанбаатар хот. Албан ёсны хэл монгол хэл. (Үндэсний статистикийн хороо, 2018).

Монгол Улс далайн түвшнээс дээш дунджаар 1,580 м өндөрт орших ба хамгийн өндөр цэг нь Хүйтэн уул (Монгол Алтайн нуруу, 4,374 м), хамгийн нам цэг нь Хөх нуурын хотгор 532 м юм. Монголын газар нутаг нь ойт хээр, хээр, цөлөрхөг хээр, цөл гэсэн байгалийн 4 бүсэд хуваагддаг. Нутгийн баруун хойд болон төвийн хэсэг нь өндөр уулын бүс, зүүн хэсэг нь өргөн тал нутаг, өмнөд хэсэг нь цөл, цөлөрхөг бүс нутаг (Монголын говь) юм.

### Уур амьсгал ба түүний өөрчлөлтийн чиг хандлага

Монгол орон эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд хоорондоо эрс ялгарах 4 улиралтай. Жилийн дундаж температур 0.2°C (32°F), өвлийн улирлын дундаж температур -10°...-30°C (14°...22°F), зуны улирлынх нь 10°...27°C (50°...80°F) байна. Цэлмэг өдрийн тоо жилдээ 230-260 хоног буюу 2600-3300 цаг нар гийгүүлдэг. Хур тунадасны нийт хэмжээ бага, газар нутаг бүхэнд харилцан адилгүй байдаг. Тухайлбал, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар жилийн хур тунадасны хэмжээ 250-390мм байхад, Алтайн уулархаг нутгаар 90-130мм болон тал хээрийн нутгаар 180-280мм, говийн нутгаар 70-150мм орчим байна (Уур амьсгал: Монгол орны уур амьсгал, 2017).

1993-2012 оны хоорондох жилийн дундаж үзүүлэлтэд тулгуурлан боловсруулсан урт хугацааны доторх уур амьсгалын өндөр эрсдэлийн индексээр Монгол орон 8 дугаарт орсон (German watch, 2014) нь хэр хатуу ширүүн уур амьсгалтай болохыг гэрчинэ. Урт хугацааны уур амьсгалын эрсдэлийн индекс<sup>1</sup>-ээр Монгол 31.33 байна.

Монголын эмзэг экосистем нь нийгэм эдийн засгийн амьдрал болон уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий. Сүүлийн 70 шахам жилийн дотор Монгол орны жилийн дундаж агаарын температур 2.14C-аар нэмэгдсэн нь дэлхийн дунджаас 3 дахин эрчтэй байна (Л.Нацагдорж нар, 2018).

Улс орны эдийн засаг хөгжихийн хэрээр гадаргын болон гүний усны нөөц, ой мод, хөрс, бэлчээр зэрэг байгалийн нөхөн сэргээгдэх нөөцийн зарцуулалт, хэрэглээний хувь хэмжээ зарим тохиолдолд хүрэлцэхүйц хэмжээнээсээ хэтрээд байна. Хэрвээ одоогийн уур амьсгалын өөрчлөлтийн энэ хандлага цаашид үргэлжилж, байгалийн нөөцийг хамгаалах, ашиглах тодорхой арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэхгүй бол уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл улам бүр идэвхжиж цаашид бүр ч ноцтой байдалд хүрч болзошгүй (Монгол Улсын Байгаль орчин, Аялал жуулчлалын яам, 2009, хууд. 55).

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн 2011 оны тайланд уур амьсгалын өөрчлөлт ба хотжилтын хурдацтай үйл явц нь хүн амын бараг талаас илүү хувийг ундны усаар хангаж чадахгүй байгаа нь Монгол улсад ундны усны нөөцийн асуудалд аюул учруулж байгаа талаар онцлон тэмдэглэсэн байна<sup>3</sup>.

### Газар ашиглалт

Монгол Улсын нийт газрын 73.4% хөдөө аж ахуйн газар, 16.1% улсын тусгай хэрэгцээний газар, 0.5% хот суурин; 9.2% ойн сан бүхий; 0.4% нь усан сан бүхий, 0.3%- ийг зам, шугам сүлжээний газар байна (Үндэсний статистикийн хороо, 2018). Монгол орны ойн сан нийт нутаг дэвсгэрийн

<sup>1</sup>Тухайн хугацааны хооронд тохиолдсон цаг агаарын гаралтай онцлог үзэгдлийн тоо, 100 мянган хүн тутамд нас барсан хүний тоо болон учирсан хохирлын хэмжээгээр тооцож гаргадаг индекс

11.89 хувийг эзлэх<sup>2</sup> ба үүнээс ойгоор бүрхэгдэн талбай нь 8.03 хувийг эзэлж байна (Энхсайхан.Д, 2014).

Монгол Улсын эдийн засаг, хүнсний хангамж нь хөдөө аж ахуйн салбараас шууд хамааралтай, уул уурхай зэрэг бусад салбарууд ч мөн газрын нөөц баялагт тулгуурлан үйл ажиллагаа явуулдаг. Монголын газар нутгийн 78,2 хувь нь дунд ба түүнээс эрчимтэй цөлжилтөд өртсөн тооцоо гарчээ (Цогтбаатар. Ж., Даш. Б нар (ред), 2013). Цөлжилтөд ямар нэгэн байдлаар өртсөн газар нутаг 80 гаруй хувийг эзэлж байхад 12.1 хувь нь л цөлжилтөд өртөөгүй байна. Үүнээс 6.7 хувьд цөлжилт хүчтэй явагдсан байна. Харин сул болон дунд зэргийн цөлжилт явагдсан газар нь 61.2 хувийг эзэлж байна.


### Хүн ам зүй

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны (ҮСХ) ны 2017 оны дүнгээр Монгол Улсын нийт хүн ам 3.2 сая бөгөөд жилийн дундаж өсөлт 1.9 хувьд хүрсэн (Үндэсний статистикийн хороо, 2018). Нийт хүн амын 64.19 хувь нь 35 хүртэл насны залуучууд байна. Тодруулбал, нийт хүн амын 30.46 хувь (967,896) нь 0-14 насныхүүхэд, 63.17 хувь (2,007,430) нь 15-59 насны хүмүүс, 6.37 хувь (202,573) нь 60 ба түүнээс дээш насны өндөр настан байна.

2017 оны байдлаар хүн амын дундаж нягтшил улсын хэмжээнд 2.0 хүн/км<sup>2</sup>, Улаанбаатар хотод 311.3 хүн/км<sup>2</sup> байна (Үндэсний статистикийн хороо, 2018).

Хүн амын 85 гаруй хувийг монгол, 4.3 хувийг казак, үлдсэн 1 орчим хувийг бусад үндэстэн (хятад, орос, чантуу г.м) эзэлдэг. Монгол үндэстэн дотор Халх ястан давамгайлах ба бусад ястнууд голдуу авиа зүйн дуудлагаараа ялгагдах боловч бичгийн болон бусад хэрэглээний хэл нь халх монгол хэл юм.

Зураг 4. Монгол Улсын хүн амын нас, хүйсийн суварга (2017) (Статистикийн мэдээллийн сан, 2017)



Эх сурвалж: [https://www.1212.mn/stat.aspx?LIST\\_ID=976\\_L03](https://www.1212.mn/stat.aspx?LIST_ID=976_L03)

### Гадаад харилцаа

Монгол Улсын Гадаад Харилцааны Яам (ГХЯ)-наас гаргасан *Монгол Улсын гадаад бодлогын хөх ном-2017*-д дурдсанчлан 2018 оны 12-р сарын 28-ны өдрийн байдлаар Монгол Улс нь дэлхийн 156 улстай гадаад худалдаа хийж, 191 оронтой дипломат харилцаатай бөгөөд хилийн чанадад нийт 46 дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

Мөн Монгол Улсын улс төрийн гадаад харилцааны тэргүүлэх чиглэлд БНХАУ болон ОХУ-тай хоёр талын харилцаагаа илүү гүнзгийрүүлэх, мөн АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг улс орнуудтай “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд иж бүрэн түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх бодлого баримталдаг. Түүнчлэн, олон улсын түвшинд олон талт гадаад бодлого явуулдаг бөгөөд 2012 оноос Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ)-ын гишүүн, 2014 оноос НҮБ-ын Хүн амын хөгжлийн

<sup>2</sup>Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээ нь юуг ойд хамааруулж байгаа тодорхойлолтоос хамааран өөр өөр тоо бий. Ой судлаачдын мэдээгээр бол ойн сан бүхий газар 11.89 % байхад газрын нэгдмэл сангийн мэдээнд ойн сан бүхий газар 9.14% гэж орсон.



комисс (2014-2018), Эмэгтэйчүүдийн аж байдлын комисс (2015-2019), Хүний эрхийн зөвлөл (2016-2018)-д тус тус сонгогдон ажиллаж байна (Монгол Улсын Гадаад Харилцааны Яам, 2018). 2002 оноос Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн НҮБ-ын Энхийг сахиулах ажиллагаанд оролцон олон улсын энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулж байгаа бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар НҮБ-д цэрэг хандивлагч дэлхийн 125 орноос 23 дугаарт жагсаж байна.

2016 оны 7-р сард Улаанбаатар хотноо АСЕМ-ын дээд түвшний 11 дүгээр уулзалт, 2018 оны 5 дугаар сард Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (ДГХБО)-ын Олон улсын судалгааны төв (ОУСТ)-ийн Захирагчдын зөвлөлийн анхдугаар хурал, мөн оны 7 дугаар сард Азийн Сайд нарын бага хурлыг Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулсан (Монгол Улсын Гадаад Харилцааны Яам, 2018).

### Хүний хөгжил

Дэлхийн Хүний хөгжлийн илтгэлд тооцоолсноор 2014 онд сургуульд орж буй хүүхэд 14.6 жил сургуульд суралцах боломжтой байгаа нь хүний хөгжлийн түвшин өндөртэй нэлээд хэдэн улсынхаас дээгүүр үзүүлэлт юм (Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл, 2016).

2017 оны байдлаар Монгол Улсын бичиг үсгийн боловсролын түвшин 98.5 хувь (БСШУСЯ, 2018) бөгөөд хүний хөгжлийн индекс (0.727)-ээр 189 орноос 92 дугаар байрт эрэмблэгдэн хүний хөгжлийн түвшин өндөртэй орнуудын ангилалд орсон байна (UNDP, 2018).

2017 оны байдлаар хүний хөгжлийн бүрэлдэхүүн индексийг авч үзвэл хүн амын дундаж наслалт 69.89 (эрэгтэй 65.88, эмэгтэй 75.44), боловсролын түвшний индекс 0.722 ба нэг хүнд ноогдох үндэсний орлого 0.712272613 болсон байна. Мөн жендэрийн хөгжлийн индекс 1.043, жендэрийн тэгш бус байдлын индекс 0.282 байна (Үндэсний статистикийн хороо, 2018, хууд. 176).

### Засаглалын хэлбэр

Монгол Улс нь өвөрмөц статустай ерөнхийлөгчийн институт бүхий парламентын бүгд найрамдах улс мөн (Чулуунбаатар, Г (ред), 2013, хууд. 11). Монгол Улсын Үндсэн хуульд төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн 3 засаглалд хуваарилсан байна.

*Хууль тогтоох эрх мэдэл:* Хууль тогтоох (батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах) дээд байгууллага нь Монгол Улсын Улсын Их Хурал (УИХ) бөгөөд нэг танхимтай, 76 гишүүнтэй байдаг. УИХ-ын гишүүнийг дөрвөн жилийн хугацаагаар бүх нийтийн сонгуулиар сонгоно.

*Гүйцэтгэх эрх мэдэл:* Монгол Улсын Засгийн Газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага бөгөөд УИХ-аас томилсон Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий Сайд Засгийн Газрыг удирдан зохион байгуулж, төрийн бодлогыг хэрэгжүүлж, хууль сахиулах ажлыг УИХ-ын өмнө хариуцан тайлагнадаг.

*Шүүх эрх мэдэл:* Шүүх эрх мэдлийг шүүх хэрэгжүүлэх бөгөөд Монгол Улсын Дээд Шүүх нь шүүхийн дээд байгууллага юм. Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх (хяналтын шатны шүүх), аймаг, нийслэлийн шүүх (давж заалдах шатны шүүх), сум буюу сум дундын, дүүргийн шүүх (анхан шатны шүүх)-ээс бүрдэнэ.

*Төрийн тэргүүн:* Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн бөгөөд монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч, улс үндэстний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын баталгаа байж, улс төрийн янз бүрийн хүчнүүдийн хоорондын маргааныг зохицуулах үүрэг хүлээнэ. Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлэн, бүх нийтийн сонгуулиар (2 шаттай), 4 жилд нэг удаа ерөнхийлөгчийг сонгох ба УИХ-аар дахин баталгаажуулдаг (Монгол Улсын Үндсэн Хууль, 1992).

### Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлага

Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд; аймаг нь суманд, сум нь багт; нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд тус тус хуваагдана (Үндсэн хууль, 1992). Монгол улсад 2017 оны байдлаар 21 аймаг, 330 сум, 1615 баг байх ба нийслэл Улаанбаатар нь 9 дүүрэг, 152 хороод тус тус ажиллаж байна (Үндэсний статистикийн хороо, 2018). Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгждэг (Монгол Улсын Үндсэн Хууль, 1992). Тодруулбал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал

(ИНХ) нь нутгийн өөрөө удирдах байгууллага болох бөгөөд Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч болно (Г.Чулуунбаатар, 2013).

Монгол улсыг нийгэм-эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалын хувьд Баруун бүс (Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд); Зүүн бүс (Дорнод, Сүхбаатар, Хэнтий); Төвийн бүс (Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв); Хангайн бүс (Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл); Улаанбаатар (Улаанбаатар) гэсэн 5 бүсэд ангилдаг бөгөөд энэ ангилалыг статистикийн тоо мэдээг гаргахад ашигладаг (Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлал).

### Нийгэм-эдийн засгийн өнөөгийн байдал

2017 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 5.1 хувьд хүрч, 1 хүнд ногдох ДНБ нь \$ 3,779<sup>3</sup>, инфляцын түвшин 6.4% байна.

ДНБ-ийг салбарын бүтцээр авч үзвэл хөдөө аж ахуй 10.6%, уул уурхай 22.6%, аж үйлдвэр, барилга 16.8%, үйлчилгээ 50.0% болж байна (Үндэсний статистикийн хороо, 2018).

*Ядуурал, өрхийн орлого, зарлага:* 2016 оны хүн амын ядуурлын түвшин 29.6% байна. 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар өрхийн сарын дундаж орлогохотод 1.1 сая төгрөг, хөдөөд 896.4 мянган төгрөг буюу хотынхны орлого хөдөөнийхнөөс 216.8 (24.2%) мянган төгрөгөөр их байна. Харин нэг өрхийн сарын дундаж зарлагахотод 1.2 сая төгрөг, хөдөөд 980.6 мянган төгрөг буюу хотынхны зарлага хөдөөнийхнөөс 208.7 (21.3%) мянган төгрөгөөр их байна.

Хүн амын хэрэглээний тэгш бус байдлыг тодорхойлох Жини коэффициент 2017 оны 4 дүгээр улиралд улсын дунджаар 0.351 болсон нь өмнөх оны мөн үеэс 0.002 нэгжээр, өмнөх улирлаас 0.011 нэгжээр нэмэгдсэн байна. Орлогын ялгаатай бүлгүүдийн хувьд тэгш бус байдлыг илэрхийлэх тухайн бүлэг доторх болон бүлэг хоорондох тэгш бус байдлыг харуулах Тейлийн индекс 2017 оны 4 дүгээр улиралд 0.212 болж, өмнөх оны мөн үеэс 0.017 нэгжээр буурч, өмнөх улирлаас 0.003 нэгжээр нэмэгдсэн байна (ҮСХ, 2018 оны 2 сар).

*Ажилгүйдэл:* 2017 оны байдлаар нийт ажилгүй иргэдийн тоо 119.1 мянга, үүнээс бүртгэлтэй ажилгүй иргэд 25.5 мянга, ажилгүйдлийн түвшин 8.8% байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 53.0% (13.2 мянга)-ийг эмэгтэйчүүд ба 50.9%-ийг 15-34 насны залуучууд эзэлж байна (Үндэсний статистикийн хороо, 2018, хууд. 5)

### Хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдал

*Хүн амын эдийн засгийн идэвх*

2017 оны 4 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны 2,189.91 мянган хүн (48.4% эрэгтэй, 51.6% эмэгтэй) байгаагийн 62.4% (1367.2 мянган хүн) нь эдийн засгийн идэвхтэй хүн ам (ЭЗИХА), 37.6% (822.7 мянган хүн) нь эдийн засгийн идэвхгүй хүн ам байна. ЭЗИХА-ын 58.6% (801.7 мянган хүн) нь хот, суурин газарт, 41.4% (565.6 мянган хүн) нь хөдөө орон нутагт амьдарч байна (Үндэсний Статистикийн Хороо, 2018, хууд. 5).

Ажиллах хүчний оролцооны түвшин 2017 оны 4 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд 62.4 хувь бөгөөд хотод 55.6, хөдөөд 75.5 хувьтай байна. АХОТ хүйсээр авч үзвэл улсын хэмжээнд эрэгтэйчүүд 68.2 ба эмэгтэйчүүд 57.0 хувьтай болж байна (Үндэсний Статистикийн Хороо, 2018).

*Ажиллагчид:* Нийт ЭЗИХА-ын 92.7% (1266.9 мянга хүн) нь ажиллагчид, 7.3% (100.3 мянган хүн) нь ажилгүй иргэд бөгөөд нийт ажиллагчдын 58.2% (737.92) нь хотод, 41.8% (529.1) нь хөдөөд нь ногдож байна (Үндэсний Статистикийн Хороо, 2018).

Нийт ажил эрхлэгчдийн 379.8 (30.0%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт (эрэгтэй 222.2 мянга, эмэгтэй 157.6 мянга), 233.1 (18.4%) мянга нь үйлдвэрлэл, 654.0 (51.6%) мянга нь үйлчилгээний салбарт ажиллаж байгаа бөгөөд улсын хэмжээнд 339.2 мянга хүн мал аж ахуй эрхэлж байна. Үлдсэн 927.7 мянган ажиллагчдыг байгууллагын төрлөөр авч үзвэл, 349.6 (37.7%) мянга нь хувийн аж ахуйн нэгж байгууллагад, 292.3 (31.5%) мянга нь хувь хүн, иргэнд, 224.6 (24.1%) мянга нь төсөвт байгууллагад, 39.3 (4.3%) мянга нь төрийн өмчит үйлдвэрийн газарт, 17.0 (1.9%) мянга нь төрийн бус байгууллагад, 4.9 (0.5%) мянга нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт тус тус ажиллаж байна (Үндэсний Статистикийн Хороо, 2018).

<sup>3</sup> Дэлхийн банкны атласын аргаар тооцоолсон дүн

*Албан бус салбар дах хөдөлмөр эрхлэлт:* 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчид (АБСХЭ)<sup>4</sup> 223.2 мянга байгаагийн 134.9 (60.5%) мянга нь эрэгтэй, 88.2 (39.5%) мянга нь эмэгтэй байна. АБСХЭ-ийн 75.4 хувь нь хот, суурин газарт, 24.6 хувь нь хөдөөд ноогдож байна. Албан бус салбарт хөдөлмөр эрхэлсэн нийт хүн амын 100.7 (45.1%) мянга нь бөөний болон жижиглэн худалдаа, машин засвар үйлчилгээний салбарт, 43.5 (19.5%) мянга нь тээвэр, агуулахын үйл ажиллагааны салбарт, 38.8 (17.4%) мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт тус тус ажиллаж байна (Үндэсний Статистикийн Хороо, 2018, хууд. 12).

2017 оны байдлаар ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 8.8 хувь байгаа бөгөөд үүнийг хүйсээр авч үзвэл, эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 7.8 хувь, эмэгтэйчүүдийнх 6.8 хувь байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 7.9 хувь буюу улсын дунджаас 0.6 пунктээр дээгүүр байгаа бол харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин 6.5 хувь байгаа нь улсын дунджаас 0.8 пунктээр, хот суурин газрынхаас 1.4 пунктээр тус тус доогуур байна. Насны бүтцийн хувьд нийт ажилгүй иргэдийн 24.8 хувийг 15-24 насныхан, түүнчлэн 17.4 хувь нь 25-29 насныхан байгаа бол 29.7 хувийг 35-49 насныхан, 10.4 хувийг 50-59 насныхан эзэлж байна.

Нийт ажилгүй иргэдийн 66.0 хувь техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой ажилгүй иргэд байгаа бол үлдсэн 34.0 хувь нь бүрэн дунд, түүнээс доош болон боловсролгүй иргэд байна. Хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам ажилгүй байдаг бол манай улсад боловсролтой иргэд илүү ажилгүй байх хандлагатай байна (Үндэсний Статистикийн Хороо, 2018, хуудсд. 15-16)

Ажилгүйдлийн шалтгааныг авч үзвэл, 49.5 (49.3%) мянга нь ажил хайгаад олдохгүй, 12.3 (12.2%) мянга нь мэргэжилд тохирох ажил олдохгүй, 11.2 (11.1%) мянга нь мэргэжил, дадлага туршлага байхгүй учраас ажилгүй байгаа гэсэн иргэд хамгийн өндөр хувийг эзэлж байна (Үндэсний Статистикийн Хороо, 2018, хууд 18-19).

*Залуучуудын ажилгүйдэл:* Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл 2016-д 25-34 насны залуучуудын талаас илүү нь тогтвортой ажил хайсаар, 40 гаруй хувь нь сургуулиас ажилд шилжиж амжаагүй байдалтай байгаа, зарим залуучуудын хувьд анхныхаа тогтвортой ажилд ортлоо 2.9 жил хүртэл хугацаа зарцуулж байгаа талаар дурдсан байна (Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл, 2016).

Залуучуудын ажилгүйдлийн түвшин 15-34 насны бүлэгт 2013 онд 10.8 хувьтай, 20-24 насны бүлэгт хамгийн өндөр буюу 17.0 хувьтай байсан нь улсын хэмжээний ажилгүйдлийн түвшингээс бараг хоёр дахин илүү байна. Аймаг, сумдын төвд залуучуудын ажилгүйдлийн түвшин 17.0-19.0 хувь буюу улсын дунджаас өндөр байна (Монгол Улсын хүний хөгжлийн илтгэл, 2016).

### **Нийгмийн даатгал, халамж**

Монгол улсад иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст холбогдох хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгодог хуваарилалтын системтэй.

2018 онд ДНБ-ий 5.7 хувийг (1548.5 тэрбум төгрөг) нийгмийн даатгалын сангийн орлого, 7.0 хувийг (1901.7 тэрбум төгрөг буюу) нийгмийн даатгалын сангийн зарлага эзэлж байна.

Нийгмийн даатгалын сангаас 2017 онд олгосон нийт тэтгэврийн 73.9 хувийг өндөр насны, 14.6 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.5 хувийг тэжээгчээ алдсаны, 7.0 хувийг цэргийн тэтгэвэр эзэлж байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдсан хүний тоо 2017 онд 1834.5 мянга болж, өмнөх оноос 74.4 мянган буюу 3.9 хувиар буурсан байна. Нийгмийн хамгааллын сангаас 2017 онд 18 хүртэлх насны 1076.4 мянган хүүхдэд 257.7 тэрбум төгрөгийг “Хүүхдийн мөнгө”-нд олгожээ.

### **Эрүүл мэнд**

Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл Мэндийн Хөгжлийн Төвийн (ЭМХТ) 2017 оны албан ёсны статистик мэдээгээр ДНБ-д эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь 2016 онд 2.8 хувь (657.5 тэрбум төгрөг) байснаас 2017 онд 2.5 хувь (674.4 тэрбум төгрөг) болж буурсан<sup>5</sup> байна. 2017 оны

<sup>4</sup> Албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хөдөө аж ахуйн бус бөгөөд хуулиар хориглоогүй ажил үйлчилгээ эрхэлж буй иргэд.

<sup>5</sup> Дотоодын нийт бүтээгдэхүүнд эрүүл мэндийн салбарын зардлын эзлэх хувь буурсан дүнтэй гарсан ч мөнгөн дүнгээрээ өссөн байна.

байдлаар улсын нэгдсэн төсвийн зарлагад эрүүл мэндийн зардлын эзлэх хувь 7.5, нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардал 217.9 мянган төгрөг болсон (Эрүүл мэндийн хөгжлийн төв, 2018, хууд. 110).


Мөн нэг эмчид ноогдох хүн 2000 онд 361 байсан бол 2017 онд 298 болж буурчээ. Харин эмнэлгийн орны тоо 2000 оны 17,974 байсан бол 2017 онд 23,897 болж 1.6 дахин өссөн байна. 2016 онд 100,000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 48.6 байснаас 2017 онд 26.9 болж өмнөх оноос 21.7-оор буурсан үзүүлэлттэй байна. Нялхсын эндэгдэл 2013 онд 1 000 амьд төрөлтөд 14.6 болсон ба 2017 онд 13.6 болж буурсан.

Хүн амын нас баралтын ерөнхий коэффициент 1990 онд 7.9 байсан бол 2017 онд уг үзүүлэлт 5.1 болж 1990 онтой харьцуулахад 2.8-аар буурсан үзүүлэлттэй байна. 2017 оны байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 4005 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв 13, бүсийн оношилгоо эмчилгээний төв 5, аймгийн нэгдсэн эмнэлэг 16, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв 12, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг 6, сум дундын эмнэлэг 39, сумын эрүүл мэндийн төв 273, өрхийн эрүүл мэндийн төв 218, ортой хувийн эмнэлэг 240, үүдэн эмнэлэг 1226 ажиллаж эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Эрүүл мэндийн салбарт 2017 онд нийт 50,519 ажилчид байгаа нь өмнөх онтой харьцуулахад 4.8 хувиар өссөн байна (ЭМХТ, 2018)

### Боловсрол

Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролоос бүрдэнэ (Боловсролын тухай хууль, 2002).

Зураг 5. Монгол Улсын боловсролын тогтолцоо нас



Тайлбар: ISCED (2011) Боловсролын олон улсын стандарт ангиллыг үндэслэн зурав.

Боловсролын түвшингээр нь сургуулийн өмнөх боловсрол (2-5 нас) болон бага боловсрол (5 жил), суурь боловсрол (4 жил), бүрэн дунд боловсрол (3 жил), мэргэжлийн болон дээд боловсрол гэж ангилна (Зураг 5).

БСШУСЯ-ы статистик мэдээлэлд дурдсанаар 2017-2018 оны хичээлийн жилд бүх шатны боловсролын байгууллагын тоо 2,393 бөгөөд нийт суралцагчдын тоо 1.029 саяд хүрсэн байна (БСШУСЯ, 2018).

Сургуулийн өмнөх боловсрол (СӨБ)-д 2-5 насны 256,720 хүүхэд хүмүүжиж байгаа бөгөөд үүнээс 233,015 хүүхэд 1416 цэцэрлэгийн үндсэн сургалт, 23,705 хүүхэд хувилбарт сургалтад хамрагдаж байна. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын цэвэр жин 2017-2018 оны хичээлийн жилд 79.8 хувь болж, өмнөх оны хичээлийн жилээс 1.7 пунктээр өсжээ. СӨБ-ын түвшинд нийт 7,745 үндсэн багш ажиллаж байгаагийн 6,174 нь төрийн өмчийн, 1,571 нь төрийн бус өмчийн байгууллагад харьяалагдаж байна.

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 798 сургууль (төрийн өмч 81.7 %, хувийн өмчийн 18.3%-дсуралцагчдын тоо 581.2 мянга (эрэгтэй 57%, эмэгтэй 49%), үндсэн багшийн тоо 29.24 мянга болсон. Сургууль завсардсан 682 хүүхэд байгаагийн 514 (75.4%) нь сургуульд огт ороогүй, 168 (24.6%) нь сургуульд ороод завсардсан хүүхэд байна.

2017-2018 оны хичээлийн жилд 83 (төрийн өмч 50, хувийн өмч 33) мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд нийт 2230 үндсэн багш (төрийн өмчийн сургуульд 1,785, хувийн өмчийн сургуульд 445) ажиллаж, 35831 (эрэгтэй 61.1 хувь, эмэгтэй 38.9 хувь) оюутан суралцаж байгаа бөгөөд нийт оюутны 25.7 мянга нь төрийн өмчийн сургуульд, 10.1 мянга нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна.

2017-2018 оны хичээлийн жилд 94 их сургууль, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаагийн 18 нь төрийн, 73 нь төрийн бус өмч, 3 нь гадаадын их сургуулийн салбар байна. Дээд боловсролын түвшинд 6,724 үндсэн багш ажиллаж, 155,248 оюутан суралцаж байна. Нийт 35 их сургууль (төрийн 14, төрийн бус 21)-д 5,435 үндсэн багш, 136,673 оюутан, 52 дээд сургууль (төр өмчийн 4, төрийн өмчийн бус 48)-д 1,215 үндсэн багш, 17,982 оюутан, 6 коллеж (төрийн өмчийн бус 6)-д 446 оюутан болон 3 гадаадын их сургуулийн салбарт 147 оюутан тус тус суралцаж байна (БСШУСЯ, 2018).

Боловсролын салбарт 92.6 мянган хүн ажиллаж байгаа бөгөөд СӨХ-д 27.2 мянга, ЕБС-д 48 мянга, техник мэргэжлийн боловсролд 4.28 мянга, дээд боловсролд 12.7 мянга, насан туршийн боловсролын сургалтын байгууллагад 0.47 мянган хүн тус тус ажиллаж байна.

2017 оны байдлаар ДНБ-д эзлэх шинжлэх ухааны салбарын зардал 0.2 хувь (47.6 тэрбум), улсын нэгдсэн төсвийн нийт зардал (8,980,976.8 сая төгрөг)-д эзлэх боловсролын зардлын эзлэх хувь 13.1% (1,204,209.2 сая төгрөг) бөгөөд нэг хүнд ноогдох боловсролын зардал 384.5 мянган төгрөг болж байна (Үндэсний статистикийн хороо, 2018, хууд. 141)



1.1. Сургуулийн өмнөх боловсрол

A purple arrow-shaped box pointing right. On the left is a white icon of a school building with two children running towards it.

1.2. Бага, дунд боловсрол

A blue arrow-shaped box pointing right. On the left is a white icon of two children, a boy and a girl, standing side-by-side.

1.3. Мэргэжлийн боловсрол, сургалт

An orange arrow-shaped box pointing right. On the left is a white icon of two figures: one holding a tool and the other holding a diploma.

1.4. Дээд боловсрол

A green arrow-shaped box pointing right. On the left is a white icon of a graduation cap (mortarboard) on a book.

1.5. Насан туршийн боловсрол

A red arrow-shaped box pointing right. On the left is a white icon of three people, one at the top and two at the bottom, all appearing to be reading or studying.

## 1.1. Сургуулийн өмнөх боловсрол

### 1.1.1. Өмнөтгөл

Сургуулийн өмнөх боловсролын нөхцөл байдлыг тодруулсан энэхүү тойм судалгааг гүйцэтгэхдээ Бодлого, эрх зүй; Хэрэгжилт, үр дүн; Дүгнэлт, зөвлөмж гэсэн 3 үндсэн бүлэг, 9 дэд бүлэг, 26 дэд сэдэвт багтаан боловсруулсан бөгөөд тоон боон чанарын өөрчлөлтийг 12 хүснэгт, 34 зураг схем хийж үзүүлээ.

Хүний хөгжил нь хүүхэд эхийн хэвлийд олдсон цагаас эхлэн тасралтгүй явагдах бөгөөд хүүхэд хэдийчинээ бага наснаас эхлэн эрүүл бойжиж, нийгмийн үйлчилгээнд хамрагдах нь хувь хүний болон улс орны хөгжилд чухал нөлөөтэй гэдэг үзэл ойлголт олон улсын түвшинд чухлаар тавигдаж байгаа билээ. Нийт хүн амын 12.3 хувийг 5 хүртэлх насны хүүхэд эзэлдэг залуу хүн амын бүтэц бүхий Монгол Улсын хувьд бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээнд төрийн анхаарал бодлогыг чиглүүлж ирсэн нь сүүлийн арваад жилийн үйл явцаас харагдаж байна. Энэхүү авч хэрэгжүүлсэн **хөгжлийн бодлогыг үндэсний, нийгмийн салбаруудын, боловсролын салбарын гэсэн 3** түвшинд авч үзэж УИХ, Засгийн Газар, салбарын яамнаас батлан гаргаж хэрэгжүүлсэн бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж үзлээ. Түүнчлэн НҮБ-ын төрөлжсөн байгууллагаас бага насны хүүхдийн хөгжлийн талаар дэвшүүлж байсан бодлого, зорилтуудтай хэрхэн уялдсан байдлыг харьцуулан дүгнэсэн болно.

СӨБ-ын үйлчилгээний хүртээмж, санхүүжилтэд дүн шинжилгээ хийхдээ ҮСХ, БСПУСЯ-аас эрхлэн гаргадаг сургуулийн өмнөх насны хүн ам, СӨБ-ын хамран сургалтын талаарх статистик мэдээнүүд, СӨБ-ын төсвийн гүйцэтгэлийн 2005-2018 оны, тайлангуудыг тус тус мэдээллийн эх сурвалж болгон ашиглалаа.

СӨБ-ын үйлчилгээний чанарт дүн шинжилгээ хийхдээ дэд салбарын *оролтын нөөцүүд* буюу цэцэрлэгийн барилга байгууламж, сургалтын орчин, багшийн хангамж *үйл явц* буюу сургалтын хөтөлбөр, стандарт, үйл ажиллагаа, чанарын хяналтын механизм, багшийн мэргэжил дээшлүүлэх, ажлын ачаалал, *гаралтын үр дүнгүүд* буюу хяналт үнэлгээ, хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, хөгжлийн үр дүн зэрэг асуудлуудыг авч үзэж, өнөөгийн одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийлээ.

### 1.1.2. Бодлого, Эрх зүй

#### 1.1.2.1. Үндэсний хөгжлийн бодлого

Энэхүү түвшинд УИХ-аас баталсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого” (2007-2021), “Мянганы хөгжлийн үндэсний зорилт” (2005), “Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтын үзэл баримтлал-2030” (2016) гэсэн хөгжлийн стратегийн баримт бичгүүдэд хөтөлбөрүүдийн бага насны хүүхдийн хөгжлийн чиглэлээр дэвшүүлсэн товлосон зорилт, хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийв.

Монгол Улсын УИХ-аас баталсан “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын (УИХ, 2007-2021) эхний шатанд буюу 2007-2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн “Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ” гэсэн зорилт 1-ийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр:

- Бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамрагдах боломж нөхцөлийг бүрдүүлэх;
- Хөдөөгийн малчин өрхийн 0-6 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох үйл ажиллагааг нүүдлийн аж байдалд нь тохируулан зохион байгуулах;
- 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах гэсэн зорилтууд тавьжээ.

Гэхдээ энэ хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтэд эдгээр зорилтуудын шалгуур үзүүлэлтийг бага боловсролын хамран сургалт, чанараар төлөөлүүлэн үнэлэхээр тусгасан байна. Хөтөлбөрт тусгагдсан дээрх зорилтууд тухайн үеийн ЗГ-аас дэвшүүлэн хэрэгжүүлсэн зорилтуудтай нийцэж байжээ. Энэхүү хөтөлбөрийн заалтууд тухайн үеийн Засгийн Газрын мөрийн хөтөлбөр, салбар бүрийн бодлогын баримт бичгүүдэд тусгалаа олж байсан боловч түүний хэрэгжилтэд тусгайлан үнэлгээ хийгдээгүй байна. Үндэсний хөгжлийн яамны 2013 оны мэдээлэлд (Батхүрэл, 2013) тус хөтөлбөрийг хэт олон зорилтуудыг нэгтгэсэн, хэтийн төлвийн шинжилгээ хийгдээгүй, мянганы хөгжлийн зорилтуудтай нягт уялдаагүй байна гэсэн дүгнэлт хийж байжээ.

УИХ-аас баталсан “Мянганы хөгжлийн үндэсний зорилтууд” (2005)-д (УИХ, Мянганы хөгжлийн үндэсний зорилтууд, 2005) “2015 он гэхэд Бүх нийтээрээ анхан шатны боловсрол эзэмших” гэсэн гол зорилтыг дэвшүүлсэн. Энэ зорилтыг хангахын тулд СӨБ-ын салбарт ойрын болон дунд хугацаанд хүүхдийг зохих насанд нь сургуульд бүрэн элсүүлэх, СӨБ-ын үйлчилгээнд 2-5 насны хүүхдийг бүрэн хамруулж, сургуульд элсэх бэлтгэлийг хангах зорилтуудыг дэвшүүлжээ.

Энэхүү мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаар 2009 онд хийсэн үнэлгээний тайланд (Үндэсний гурав дахь илтгэл, 2009) дээрх зорилтын хэрэгжилт 91.5 хувьтай байгаа ба ЗГ-аас хэрэгжүүлсэн олон арга хэмжээний үр дүнд СӨБ-ын хамрагдалт 14.2 хувиар ахисан үзүүлэлттэй байгааг дурджээ. Мөн 5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн талаарх зорилтын хэрэгжилт нь бага насны хүүхэд цаашид эсэн мэнд байх, боловсрол эзэмших, хөгжих эрхийг хангахад чухал нөлөөтэй байдаг. Иймд 2015 он гэхэд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 4 дахин бууруулах гэсэн зорилтын хэрэгжилт 2006 онд 23.2 хувь болон буурч хангагдсан ба 2015 онд 21 хувьд хүргэх зорилт тавигдаж, 2017 оны байдлаар 16.9 хувьд (ЭМХТ, 2017) хүрч биелжээ. Мөн 5 хүртэлх насны өсөлтийн хоцрогдолтой хүүхдийн эзлэх хувь 2005 онд 20.9 байсан бол 2010 онд 15.9 хувь (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2019) болж буурчээ.

УИХ-ын түвшинд хэлэлцэж 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д (УИХ, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016) “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилгын хүрээнд дараах товлосон зорилтуудыг дэвшүүлсэн байна. (Хүснэгт 1.1.1)

Хүснэгт 1.1.1. “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилгын хүрээнд СӨБ-ын чиглэлээр дэвшүүлсэн товлосон зорилтууд

	I үе шат (2016-2020) Товлосон зорилт, хэрэгжилт	II үе шат (2021-2025)	III үе шат (2026-2030)
Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж, монгол хэл, сэтгэлгээний үндсийг эзэмшүүлнэ.	СӨБ-ын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж, чанарыг сайжруулан СӨБ-ын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх	СӨБ-ын тогтолцоог төгөлдөржүүлж, нэг багшид ногдох хүүхдийн тоог 25 хүртэл бууруулж, СӨБ-ын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 80 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.	СӨБ-ын нэг багшид ногдох хүүхдийн тоог 20 хүртэл бууруулж, СӨБ-ын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 90 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.
	2018 оны байдлаар СӨБ хамран сургалтын цэвэр жин 79,8% байна (БСШУСЯ, 2018). СӨБ-ын хүртээмжийг өргөтгөх зорилт хэрэгжиж байгаа боловч чанарын талаар тавигдсан зорилт хэрэгжих шатандаа, биелэлтийг дүгнэх хугацаа хараахан болоогүй байна.		

Тус хөтөлбөрийн бага насны хүүхдийн боловсрол, хөгжилд хамаарах нэг үзүүлэлт бол “сургуульд элсэх албан ёсны насанд хүрэхээс нэг жилийн өмнө зохион байгуулалттай сургалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь” ба энэ үзүүлэлт БСШУСЯ-ны статистик мэдээллээр 78.5%-тай байна. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний үе шат дуусаагүй байгаа тул дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилтийн үнэлгээ хийгдээгүй байна.

Дээрх Үндэсний түвшний хөгжлийн бодлого, эрхзүйн баримт бичгүүдэд бага насны хүүхдийн талаарх зорилтуудыг нийгмийн болон боловсролын салбарын зорилтуудад нэгтгэн тусгаж хэрэгжүүлсэн байна. Тухайлбал сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсролын үйлчилгээ хүрч чадахгүй байгаа хүн амын бүлгийн сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд хүрч ажиллах түүнд нийцсэн арга хэлбэрийг хөгжүүлэх, цэцэрлэгийн материаллаг орчин, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх асуудлууд тусгагджээ. Мөн дээрх баримт бичгүүдэд сургуулийн өмнөх насны хүүхдийн асуудлыг хүний хөгжил, нийгэм эдийн засгийн болон боловсролын дотоод зорилтуудтай уялдуулахыг чармайжээ. Тухайлбал, ядуурлыг бууруулах, нийгмийн үйлчилгээний чанарыг сайжруулах, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, хот хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах, 12 жилийн боловсролын тогтолцоонд шилжих зэрэг зорилтуудтай холбогдуулан бага насны хүүхдийн хөгжлийн индикаторуудын үзүүлэлтүүдийг дээшлүүлэхэд анхаарлаа хандуулжээ. Харин Тогтвортой хөгжлийн боловсролын үндэсний хөтөлбөрт хамран сургалтын зорилтоос гадна чанарын зорилтууд болох хүүхдийн хөгжлийн түвшин, сургалтын чанар, бүлэг дүүргэлтийг тусгасан зорилт болон хэмжигдэхүүнийг тусгажээ.



**1.1.2.2. Нийгмийн салбарын хөгжлийн бодлого**

Нийгмийн салбарын хөгжлийн бодлогын түвшинд дүн шинжилгээ хийж үзэхдээ “Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль (2015)” (УИХ, 2015) “Хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010), “Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр 2017-2021”, (ЗГ, 2017) Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого (2005) зэрэг баримт бичгүүдийг тус тус шинэчлэв.

“Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг 2015 онд УИХ-аас баталсан бөгөөд уг хууль нь цэцэрлэгт хамрагдахгүй байгаа болон нийгмийн асаргаа шаардлагатай хүүхдүүдэд асран хамгаалах, хөгжлийн үйлчилгээ үзүүлэх зорилготой юм. Тус хууль нь хүүхэд асрах үйлчилгээнд тавигдах эрүүл мэнд, аюулгүй байдал, хөгжлийн шаардлагуудыг тусгаж өгснөөс гадна хүүхдийн хоол, нормативт зардлыг хүүхдийн цэцэрлэгтэй нэгэн адил улсын төсвөөс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна. 2018 оны байдлаар улсын төсвөөс 5.8 тэрбум төгрөгийн санхүүжилт зарцуулж хүүхэд харах үйлчилгээний 431 төвд 5275 хүүхэд хамарч, 1024 хүн ажиллаж байсан мэдээтэй байна (ЗГ-ын 382 дугаар тогтоол, 2018). Уг хуульд 2018 онд орсон өөрчлөлтөөр энэхүү үйлчилгээний удирдлага, санхүүжилтийн тогтолцоо нь НХХЯ-нд хамаарч байсныг бол БСШУЯ-нд шилжүүлсэн. Хүүхэд асрах үйлчилгээ үзүүлэгчдийн мэргэжлийн чадвар, үйлчилгээний эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөлийг сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг МХГ-ын хяналт үнэлгээний тайланд дурддаг.

“Хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр” (2002) нь хүүхдэд ээлтэй эрхзүйн шинэтгэл, амьдралын эрүүл аюулгүй орчин, чанартай боловсрол, төлөвшил, гэр бүлд түшиглэсэн хүүхэд хамгаалал, хүүхэд өсвөр үеийнхний оролцоо, мэдээллийн хүртээмж гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийн дагуу БНХХ-тэй холбоотой 6 дэд зорилтыг дэвшүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн үргэлжлэл болгож Монгол Улсын ЗГ-аас 2017 онд “Хүүхдийн хөгжил, хамгаалал” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийг “Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бусад салбарын оролцоотойгоор бэхжүүлж, хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлэх” зорилгоор хэрэгжүүлж байгаа ба нийт 5 дэд зорилтыг дэвшүүлжээ. СӨБ-ын тусгайлсан зорилтуудад хамаарах “3.2.1.5. сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж, сургуульд бэлтгэх”, “3.2.1.8. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд хүүхдийн хөгжлийг дэмжих асуудлыг тусгах, уг үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт, төсөв, хяналтын тогтолцоог оновчтой болгох” гэсэн үйл ажиллагааг тусгажээ.

Дээрх хөтөлбөрүүдийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг СӨН-ны хүүхдэд хамаарах заалтуудын хэрэгжилтийн байдлыг Хүснэгт 1.1.2 ба 1.1.3-т үзүүлэв. “Хүүхэд хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн СӨБ-ын боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн эндэгдэл бууруулах талаар дэвшүүлсэн зорилтууд биелсэн байна.

Хүснэгт 1.1.2. “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002)”-ийн хэрэгжилт

	2010 он хүртэл	2012 он
Хүүхдийн эмчийн тоог (10000 хүүхдэд ногдох) 5,0 болгоно.	Сүүлийн арваад жилд хүүхдийн эмчийн тоо 3.5 дахин буурсан төдийгүй нийт аймгийн дөнгөж 25% нь хүүхэд, өсвөр үеийн эрүүл ахуйч эмчтэй байна.	2015 оны мэдээгээр 310 хүнд 1 их эмч ноогдож байна.
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг (1000 амьд төрөлтөд) 35 хүртэл бууруулна.	2008 оны байдлаар тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 23.2 хувь хүртэл буурчээ.	24.2%
Тав хүртэлх хүүхдийн тураал (өсөлтийн хоцрогдлын хувийг) 10 хүртэл бууруулна.	Хоол гэжээлийн дутагдлын хурц хэлбэр тураал 6,4% хувь, архаг хэлбэр болох өсөлт хоцролт 19.2% хувь, туранхай хүүхэд 9.6%-ийг тус тус эзэлж байна.	Өсөлтийн хоцрогдол 6.2%
Хүүхдийн 6 сар хүртэл хугацаанд зөвхөн эхийн хөхөөр хооллодог хувийг 90 хувьд хүргэх	6 сар хүртлээ дан эхийн сүүгээр хооллож байгаа хүүхэд 37 хувьтай байна.	2013 оны байдлаар 47% байна
СӨН-ны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалтын хувийг 72 хувьд хүргэнэ.	2010 оны боловсролын статистикийн мэдээгээр СӨБ-д хамрагдалт 76% хүрсэн ба үүнээс цэцэрлэгт 58.6% хувилбарт сургалтад 17.6% тус тус хамрагдаж байна.	77.6%

Хүснэгт 1.1.3. “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2017)”-ийн хэрэгжилт

Хамаарах зорилт, хүрэх үр дүн	2016-2017 он
СӨБ-ын хамран сургалтыг 2019 онд 80.9 хувьд хүргэнэ.	2018 оны СӨБ-ын хамрагдалт 80.9 хувьтай байна.
СӨН-ы хүүхдийн өсөлтийн хоцрогдолтыг 2019 он гэхэд 8 хувьд хүргэнэ	2018 оны байдлаар энэ үзүүлэлт 19.8 хувьтай байна
БНХ-ийн хөгжлийн үнэлгээ 2017 онд хийгдэж тооцсон үнэлгээнээс нэмэгдсэн байна.	Мэдээлэл байхгүй

2005 онд “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого” (БСШУЯ, ЭМЯ, НХХЯ, 2005, 116.83.45) батлагдан гарч түүнд БНХ-ийн хөгжилд цогц байдлаар хандах бодлогын суурь тавигджээ. Энэ бодлогын БНХ-эд үзүүлж буй эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, боловсролын үйлчилгээг хүүхэд бүрд нэгдмэл байдлаар хүргэж, эдийн засгийн болон нийгмийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн байна. Энэхүү бодлогын хэрэгжилтэд БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сангаас 2007 онд үнэлгээ хийсэн бөгөөд энэхүү үнэлгээний дүгнэлт болон зөвлөмж хэсэгт дурдсанаар “хэдийгээр бага насны хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр тавигдсан зорилтууд хэрэгжиж байгаа боловч эдгээр нь урьдын адил салангид хүчин чармайлтаар хэрэгжиж байгаа ба ЗГ болон орон нутгийн салбарын асуудал хариуцсан агентлагуудын оролцоо, зохицуулалтыг сайжруулах, дэвшүүлсэн зорилтуудад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тусгах, салбар хоорондын менежмент, зохицуулалтын бүтэц, механизмыг сайжруулах ёстой” гэсэн дүгнэлт хийсэн байна.

Нийгмийн салбарын хөгжлийн түвшинд баримталж байгаа бодлогууд нь БНХ-ийн хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн эрүүл мэнд, асаргаа хамгаалал, боловсролын талаарх зорилтуудыг нэгдмэл байдлаар дэвшүүлжээ. Уг бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд зохих шалгуур, индикаторын үзүүлэлтүүд ахисан эерэг үр дүнтэй гарсан байна. Гэхдээ дээрх бодлогуудыг хэрэгжүүлэхэд үндэсний болон орон нутгийн түвшинд нийгмийн салбаруудын хамтын хүчин чармайлт, тэдгээрийн зохицуулалт, дэмжлэг шаардагдаж байна. Харин нийгмийн салбарын асуудал хариуцсан яамдын түвшинд хүүхдийн цогц хөгжилд тулгуурласан мэдээлэл, хяналт шинжилгээний нэгдсэн механизм бүрдүүлэх санаачилгууд “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бий болж байгаа нь сайшаалтай байна. Жишээлбэл: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, тогтвортой хөгжлийн мэдээллийн сан гэх мэт нэгдсэн мэдээллийн тогтолцоо бүрдүүлж байгаа нь салбар хоорондын бодлогын уялдааг хангахад чухал ач холбогдолтой.

**1.1.2.3. Боловсролын салбарын хөгжлийн бодлого**

Боловсролын салбарын хөгжлийн бодлогын түвшинд Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрүүд (2008-2012), (2012-2016), (2016-2020), Боловсролын салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөө (2006) (ЗГ, 2006), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008) (УИХ, 2008) зэрэг баримт бичгүүдийг сонгон авч СӨБ-ын талаар дэвшүүлсэн зорилтуудыг шинжлэх замаар бодлогын шинжилгээ хийлээ.

Доорх хүснэгтэд 2008 оноос хойших Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд СӨБ-ын талаар дэвшүүлсэн зорилт, авч хэрэгжсэн гол арга хэмжээг харуулав. Эндээс үзвэл СӨБ-ын хамран сургалтыг нэмэгдүүлэх талаар ЗГ-аас нэлээд хүчин чармайлт гаргаж хандивлагчдын төсөл хөтөлбөр болон улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр дэвшүүлсэн тоон зорилтууд нь биелсэн үр дүнтэй байна.

Хүснэгт 1.1.4. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд СӨБ-ын талаар дэвшүүлсэн зорилтуудын хэрэгжилт

	2008-2012	2012-2016	2016-2020
ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрүүд	“Баг бүрд гэр цэцэрлэг байгуулах, хувилбарт сургалтын төрөл, хэлбэрийг олшруулах замаар СӨБ-ын хамран сургалтыг 2012 он гэхэд 70 хувьд хүргэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>Сургууль, цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх, өргөтгөх замаар хүүхдийн ая тухтай сурч, хүмүүжих орчныг бүрдүүлэх;</li> <li>“Зөв монгол хүүхэд” хөтөлбөр боловсруулж, цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг монгол бахархалтай, үндэсний соёл уламжлалыг дээдэлсэн иргэн болгон хүмүүжих нөхцөлийг агуулсан сургалтын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>“Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно.</li> <li>Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг</li> </ul>


		<p>стандарттай болох</p> <ul style="list-style-type: none"> <li>• Орон нутагт гэр цэцэрлэгийг шаардлагатай багт байгуулах ажлыг зохион байгуулж СӨБ-ын хамрах сургалтыг нэмэгдүүлэх</li> <li>• СӨБ-д зориулан хүүхэд асран хүмүүжүүлэх төв, өдөр өнжүүлэх бүлэг байгуулах</li> </ul>	<p>бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ.</p>
Хэрэгжилтийн зарим үр дүн	<p>Дэлхийн банк, БСШУЯ-ны хамтран хэрэгжүүлсэн “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” төсөл, НҮБ-ын ХС, АХБ-ны СӨБ төслүүдийн хүрээнд нүүдлийн гэр цэцэрлэгийн үйлчилгээг дэмжих зорилгоор сургалтад зориулсан олон тооны иж бүрэн гэрийг хөдөөгийн сумдын цэцэрлэгүүдэд нийлүүлжээ. Монгол Улс 1500 гаруй багтай бөгөөд 4 жилийн хугацаанд дээрх төсөл, арга хэмжээний хүрээнд нийт багийн 60 гаруй хувьд гэр цэцэрлэг нийлүүлэгдэж, СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээг өргөжүүлжээ. 2012 оны байдлаар СӨБ хамран сургалт 79,0 хувьд хүрч, дээрх зорилт хэрэгжжээ.</p>	<p>2012-2014 онд 119 цэцэрлэгийг шинээр барьж, 436 гэр цэцэрлэг нийлүүлснээр 29505 орны тоогоор цэцэрлэгийн хүчин чадлыг ихэсгэсэн мэдээ байна (БСШУСЯ, 2017). 2016 оны байдлаар хамран сургалт бохир жингээр 80,9 %-д хүрчээ. Мөн СӨБ-ын сургалтын орчны стандарт, сургалтын цөм хөгөлбөрийг 2015 онд тус тус батлан мөрдүүлжээ. 2015 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг УИХ-аар батлуулан мөрдүүлсэн байна.</p>	<p>2016 оны мөн үетэй харьцуулахад цэцэрлэгийн хамран сургалтын цэвэр жин 2% хувиар ахижээ. 2017-2018 онд 16420 хүүхдийн хүчин чадалтай 106 цэцэрлэгийн барилга барихаар төлөвлөгдсөн ба нийслэлд 9665 хүүхдийн хүчин чадалтай 54 цэцэрлэг барихаар төлөвлөсөн байна.</p>

2005 оны үеэс эхлэн Боловсролын салбарт нийгмийн тэгш бус байдлыг бууруулах, хөдөө орон нутагт боловсролын үйлчилгээг өргөжүүлэх замаар хот, хөдөөгийн ялгааг арилгах, ЕБС-ийн тогтолцоог 12 жилд шилжүүлэх зорилтуудыг хэрэгжүүлж байсантай холбогдуулан цэцэрлэгийн 6 ба 7 настай хүүхдүүд бага сургуульд суралцах насны хүүхдүүд болон өөрчлөгдөж, цэцэрлэгт 2 наснаас хамрагдах хүүхдийн тоо ихэссэнээр 2-5 настай хүүхдүүдийн эрүүл ахуй, хоол тэжээл, сургалтын орчныг сайжруулах, цэцэрлэгийн багш нарт бага насны хүүхэдтэй ажиллах сургалтын агуулга, арга зүйд суралцах шинэ эрэлт хэрэгцээ бий болжээ. Ялангуяа, хэлд сайн ороогүй, өөртөө үйлчилж сураагүй 2 настантай ажиллах шинэ хэрэгцээ багш нарт ур чадварын шинэ сорилт болсон байна. Эдгээр хэрэгцээнд нийцүүлэн улсын төсвөөс болон олон улсын төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтуудыг чиглүүлж байсан онцлогтой байжээ.

Боловсролын салбарыг 2015 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг 2006 онд Монгол Улсын ЗГ-аас батлан хэрэгжүүлсэн бөгөөд БСШУСЯ тус төлөвлөгөөний бага насны хүүхдийн боловсролын дэд салбарын зорилтуудын хэрэгжилтэд 2009 (ADB, 2009 ) болон 2015 онд тус тус үнэлгээ хийж дүгнэлт гаргаж байсан. (Хавсралт 1.) Энэхүү үнэлгээгээр 2015 оны байдлаар СӨБ-ын дэд салбарт нийтдээ 29 зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 17 зорилт буюу 58.6% нь бүрэн биелсэн, 10 зорилт (34.5%) хэсэгчлэн хэрэгжсэн ба хэрэгжих шатандаа байгаа харин 2 зорилт (6.9%) хэрэгжээгүй гэсэн дүгнэлт гарсан байна. Бүрэн биелсэн зорилтуудын хувьд хамран сургалтыг нэмэгдүүлэх, цэцэрлэгийн барилга, сургалтын хэрэглэгдэхүүн, орчныг бэхжүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах зорилтууд сайн хэрэгжилттэй гарчээ. Харин хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах, бага насны хүүхдийн хөгжлийн стандартад суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бий болгох, хүүхдийн эрүүл ахуй, хоол тэжээлийн талаарх бодлого, эрх зүйн зорилтууд нь хэсэгчлэн биелсэн, хэрэгжилтийн шатандаа байна гэж үнэлэгджээ.

2006 онд ЗГ-аас Боловсролын салбарын Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээр хандивлагчдын хүч хөрөнгийг СӨБ-ын хүртээмж, чанарыг сайжруулах зорилтод төвлөрүүлэх боломжтой болсон ба төрөөс зарцуулах санхүүжилт өсөхийн хэрээр огцом нэмэгдсэн цэцэрлэгийн хамран сургалтын өсөлтийг хангах цэцэрлэгийн барилга барих, засварлах замаар хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, хөдөөд малчдын хүүхдэд зориулсан гэр цэцэрлэгүүдийг байгуулах асуудлуудад чиглүүлсэн байна. 2000 оноос хойш СӨБ-д гадаад орон, олон улсын байгууллагуудын зүгээс буцалтгүй тусламжийн хүрээнд 15,2 сая ам.долларын өртөгтэй төсөл хөтөлбөр хэрэгжсэн баримт байна (ЭЗХЯ, 2014). 2005 оноос хойш СӨБ-д хамгийн их 9 сая америк доллар буюу нийт зардлын 52.3 хувийг зарцуулжээ (Зураг 1.1.1). Өөрөөр хэлбэл, энэ үе нь хамран сургалтын өндөр өсөлтийн үетэй давхцаж байгаа бөгөөд энэ үед цэцэрлэгийн барилга шинээр барих, өргөтгөх, малчдын хүүхдийг сургуульд бэлтгэх хэрэгцээ ихэссэнтэй уялдуулан төсөл хөтөлбөрүүдээр дамжуулж СӨБ-д хөрөнгө оруулалтын интервенц хийгдсэн байна.

Зураг 1.1.1. СӨБ-ын хамран сургалт ба хандивлагчдын хөрөнгө оруулалт (1994-2012)



1995 оноос хойш зарцуулсан СӨБ-ын төслүүдийн нийт санхүүжилтийн 41.9% нь цэцэрлэгийн барилга барих, засварлах, хөдөөд гэр цэцэрлэг байгуулах, 16.5% нь багш болон бусад ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх сургалтын үйл ажиллагаа, 5.5% нь хүүхдэд шаардлагатай тоглоом, сургалтын материал, хэрэглэгдэхүүнээр хангах, 1.3% нь тоног төхөөрөмжид, 34,8% бусад үйл ажиллагаанд тус тус зарцуулагджээ.

Энэ үед гарсан томоохон амжилт бол 2008 онд УИХ-аар СӨБ-ын тухай хуулийг батлан мөрдөх болсноор эцэг эхээс гарах цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг төр хариуцах болж, доогуур орлоготой ядуу өрхийн хүүхдийн хамрагдалтыг хязгаарлаж байсан хүчин зүйлийг арилгасан юм. Мөн энэ хуулиар өмчийн хэлбэр харгалзахгүйгээр төрийн болон төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийг улсын төсвөөс нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын зарчмаар санхүүжүүлэх, хувилбарт сургалтын хэлбэрүүдийг хуульчилах заалтууд оруулж мөрдсөнөөр үйлчилгээний тэгш байдлыг бий болгоход бодит дэмжлэг болсон юм. Мөн Боловсролын тухай хуулийн удаа дараагийн өөрчлөлтөөр цэцэрлэгийн багш, ажилчдын нийгмийн баталгааг хангах, нэмэгдэл, тэтгэмж, урамшуулал авах мэргэжил дээшлүүлэх зардлыг улсын төсвөөс даах тухай заалтуудыг оруулж өгсөн байна.

**1.1.2.4. Сургуулийн өмнөх боловсролын бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг хангах бүтэц, тогтолцоо**

Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хууль тогтоох эрх мэдэл бүхий төрийн дээд байгууллага бөгөөд Нийгмийн Бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд СӨН-ны хүүхдийн асуудал хамаарагддаг.

Засгийн газрын түвшинд Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нь сургуулийн өмнөх боловсролын асуудлыг хариуцаж байдаг.

Орон нутгийн түвшинд Аймаг, нийслэлийн Засаг дарга нар СӨБ-ын үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах үүргийг Боловсролын тухай хуулийн дагуу хүлээж, харьяалах Засгийн газрын гишүүнтэй үр дүнгийн гэрээ байгуулан ажилладаг. Мөн аймаг, нийслэлийн түвшинд Засаг даргын

дэргэдэх Боловсрол, соёлын газар СӨБ-ын талаарх төрөөс баримтлах бодлого эрхзүйн актыг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг хүлээнэ.

Сум, дүүргийн Засаг дарга нар төрөөс үзүүлэх боловсролын үйлчилгээг хүргэх үр дүнгийн гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргатай хийх бөгөөд түүнийг хэрэгжүүлэхдээ тухайн сум, дүүргийн цэцэрлэг, сургууль болон тухайн төрлийн үйлчилгээ явуулах эрх бүхий байгууллагын удирдлагатай үр дүнгийн гэрээ байгуулах замаар гүйцэтгүүлнэ. Нийслэлийн дүүргийн Засаг дарга нар өөрийн бүтцэд хамаарах Боловсролын хэлтсээр дамжуулан орон нутгийн төрийн ба төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангах үүргийг хүлээнэ.

Баг, хорооны Засаг дарга нь “Боловсролын тухай” болон “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуульд зааснаар сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа өрхийн хүүхдийг хамруулах үүргийг хүлээнэ.

**1.1.2.5. Бага насны хүүхдийн хөгжлийн асуудлыг олон улсын байгууллагаас баримталдаг бодлого, зорилтуудтай уялдуулдаг байдал**

ЮНЕСКО-оос боловсруулсан Бүх нийтийн боловсролын үнэлгээний тайланд (2007) (UNESCO, 2007)-нд бага насны хүүхдийн хөгжил, боловсролын талаарх үндэсний бодлогыг сайжруулахад улс орнуудад хандан дараах хүснэгтэд тусгасан зөвлөмжийг өгч байсан юм. Энэхүү зөвлөмжийн дагуу манай орны СӨБ-ын нөхцөл байдлын талаар харьцуулсан дүн шинжилгээ хийхэд дараах байдалтай байна. (Хүснэгт 1.1.5)

Хүснэгт 1.1.5. СӨБ-ын хөгжлийн зарим үзүүлэлтүүдээр хийсэн судалгааны дүгнэлтүүд

Бодлогын орчин	Манай орны нөхцөл байдал
Дээд түвшний улс төрийн бодлогын зөвшилцөл, баталгаа	Монгол Улсын улс төрийн гол хүчин (МАН, АН)-үүд СӨБ-ын талаарх бодлогын талаар нэгдмэл байр суурьтай байдаг. Тухайлбал СӨБ-ын тухай хуулийг (2008) улс төрийн зөвшилцлөөр баталсан ба СӨБ-ын хүртээмж чанарыг сайжруулах зорилтууд улс төрийн намууд, үе үеийн ЗГ-ын хөтөлбөрүүдэд тогтвортой тусган хэрэгжүүлсэн байдаг.
СӨБ-ын бодлогын зохицуулалт, удирдан манлайлах үүрэг бүхий байгууллагатай байх	ЗГ-ын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуулийн дагуу нийгмийн бодлогын асуудлыг БСШУС, ЭМ, НХХ-ийн яамдууд хариуцдаг ба тус тусын чиглэлээр бага насны хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, халамж, хамгааллыг хариуцдаг тогтолцоотой. Хэдийгээр дээрх яамдын бодлого ЗГ-ын хөтөлбөр, стратегийн баримт бичгүүдэд нэгдмэл байдлаар тусч хэрэгждэг боловч үйл ажиллагаа нь тус тусын чиглэлийн салбарын байгууллагуудаар дамжин салангид хэрэгжүүлдэг бөгөөд өөрт хамаарах тоон болон чанарын мэдээллээ өөрийн бүтцээр дамжуулан цуглуулдаг. Сүүлийн үед эдгээр мэдээллийг үндэсний түвшинд цуглуулдаг мэдээллийн системүүд бий болсон. Цаашид салбар хоорондын бодлогын нэгдмэл байдлыг хангах хэрэгцээ шаардлагатай.
Үндэсний хөгжлийн бодлогод энэ талын зорилтуудыг тусгаж интеграцчилсан байх	Монгол Улсын УИХ, ЗГ-аас баримтлан хэрэгжүүлсэн үндэсний хөгжлийн баримт бичгүүдэд бага насны хүүхдийн хөгжлийн зорилтууд тусгасан байдаг. Тухайлбал, Мянганы хөгжлийн зорилт (2005), Үндэсний хөгжлийн цогц бодлого (2008-2021), Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030–д хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, СӨБ-ын талаар тодорхой товлосон зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлжээ. Цаашид шинээр боловсруулж байгаа үндэсний болон салбарын хөгжлийн бодлогуудад энэ дэд салбарын бодлогыг шинээр төлөвлөж тусгах шаардлагатай.
Үндэсний түвшинд бодлогын бүлэг түлхүүр тоглогчидтой болсон байх	ЗГ, олон улсын байгууллагууд түлхүүр тоглогчийн байр суурьтай, цаашид бусад оролцогч талууд, үндэсний тоглогчдыг бэхжүүлэх шаардлагатай.
<i>Бодлогын элементүүд</i>	
Өмчийн бүх хэвшлийн үйлчилгээ үзүүлэгчид нэгэн адил мөрдөх, минимум стандарттай байх	СӨБ-ын хууль, сургалтын агуулгын болон орчны стандарт, хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, барилга байгууламж, тоглоом, аюулгүй байдлын норм, стандартыг хувийн хэвшлийн болон улсын цэцэрлэгүүд нэгэн адил мөрдөж байгаа боловч үйлчилгээний чанарт тавих хяналт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог сайжруулах шаардлагатай.

Тус салбарт зарцуулах санхүүжилтийг өсгөх, зорилтот бүлэгт чиглэсэн тусламж үзүүлэх	2000 оноос хойш СӨБ-ын санхүүжилт тогтмол өсөж ирсэн ба сүүлийн 8 жилд боловсролын салбарын нийт төсөвт эзлэх хувь 22-25%-д хүрч байна. Санхүүжилтийн өсөлтийн шалтгаан нь СӨБ-ын хамран сургалт нэмэгдсэнээр хувьсах зардлын санхүүжилт нэмэгдсэн, хөрөнгө оруулалтын зардал, багш ажилтны цалин хөлс нэмэгдсэн, мөнгөний инфляц зэргээс шалтгаалж байна. СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа малчдын болон ядуу өрхийн хүүхдүүдэд чиглэсэн хувилбарт сургалтын үйлчилгээг улсын төсвөөс санхүүжүүлж байна.
Ядуу, нийгмийн эмзэг бүлэгт зориулсан үйлчилгээ бий болгох	Малчин айл өрх, ядуу өрхийн хүүхдүүдэд үйлчлэх СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээ сүүлийн 10 гаруй жилийн турш тогтвортой бий болж, эрх зүй, санхүүжилтийн хувьд институтчлэгдсэн. Гэхдээ үйлчилгээний чанарыг дээшлүүлэн, үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай.
Төр, хувийн сектор, ОУБ-ын хамтын ажиллагааны түншлэлийг дэмжих	Хүүхдийн цэцэрлэг барих, зарим хөрөнгө оруулалт хийх чиглэлээр төрөөс хувийн хэвшилтэй түншлэл (концесс гэрээ) хөтөлбөр хэрэгжүүлж ажилладаг туршлага бий болсон. Мөн уул уурхайн чиглэлийн компаниуд орон нутгийн СӨБ-ын үйлчилгээг дэмжих чиглэлээр төртэй хамтран ажиллаж байна. Цаашид бусад чиглэлээр төрөөс хувийн хэвшил, ОУБ-тай хамтын ажиллагаа түншлэлийн хэлбэрүүдийг туршиж хэрэгжүүлэх боломжтой.
<i>СӨБ-ын үйлчилгээний чанар, санхүүжилтийг дэмжих</i>	
Төрөөс хувийн болон улсын хэвшлийн секторыг нэгэн адил санхүүжүүлэх	Хувийн хэвшлийн цэцэрлэгүүдийг нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын жишгээр санхүүжүүлж байна. Хувийн хэвшлийн салбар СӨБ-ын нийт санхүүжилтийн 5.7% авдаг. (2010 он)
Боловсролын салбарт зарцуулж буй төсвийн 10%-аас доошгүй хувийг СӨБ-д зарцуулах	2016 оны байдлаар төрөөс СӨБ-д улсын төсвийн 4%, боловсролын салбарын төсвийн 25.1% тус тус зарцуулж байсан байна.
Хүүхдийг СӨБ-д тэгш хамруулахад анхаарах	ЗГ хувилбарт сургалтад хамрагдаж буй ядуу өрхийн хүүхдийн хувьсах зардлыг орон нутгийн цэцэрлэгээр дамжуулан санхүүжүүлж байна. Одоогоор эмзэг бүлгийн хүүхдийг бусад хүүхдийн нэгэн адил төрөөс цэцэрлэгт үнэ төлбөргүй хамруулж байна. Гэвч малчин болон ядуу айл өрхийн хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хамрагдалт бусад бүлгийн өрхийн хүүхдүүдээс доогуур байна.
СӨБ-ын салбарын багш ажилчдад зориулсан чанартай сургалтад дэмжлэг үзүүлэх	СӨБ-ын багшийг бэлтгэх, давтан бэлтгэх тогтолцоог улсын болон хувийн хэвшлийн дээд боловсролын байгууллага, төрийн мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэж байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын зарим зардлыг сургалтын байгууллагад ажилласан жилээр сонгож төр хариуцаж байна (1,5,10 жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтууд). Хувийн хэвшлийн дээд боловсролын байгууллагуудын цэцэрлэгийн багш, туслах багш бэлтгэж буй чанарыг сайжруулах, багш, удирдах ажилтанг ажлын байран дээрээ суралцах, хөгжих боломжийг олгосон хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай.
Сургууль + ба цэцэрлэгийн залгамж холбоог хангах	Сургуулийн өмнөх болон бага боловсролын стандарт, цөм хөтөлбөр, нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрт агуулгын залгамж холбоог тусган хэрэгжүүлж байна. Харин сургууль, цэцэрлэгийн бүтэц, багш бэлтгэх тогтолцоогоор дамжуулан залгамж холбоог хангах шинэчлэл туршилтын шатандаа байна.

Дээрх харьцуулсан дүн шинжилгээ болон доорх Хүснэгт 1.1.6-аас үзэхэд манай орны СӨБ-ын хамран сургалт ба санхүүжилтийг нэмэгдүүлэх, хувилбарт сургалтын үйлчилгээний хэлбэрүүдийг дэмжиж институтчлэх талаар бүс нутаг, дэлхийн түвшний үзүүлэлтүүдтэй ойролцоо буюу дээгүүр түвшинд байна. Харин нэг багшид ноогдох хүүхдийн тоо, сургалтын хөтөлбөрт зарцуулж буй дундаж цагийн үзүүлэлтээр доогуур ангилалд багтаж байна.

Хүснэгт 1.1.6. Дэлхийн болон зарим бус нутагтай харьцуулсан Монгол Улсын СӨБ-ын зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	Дэлхий	Хойд Америк, Баруун Европ	Бүс нутаг (Төв Ази)	Монгол
Боловсролын салбарт СӨБ-ын төсвийн эзлэх санхүүжилт	10%	5-12%	4-8%	25,19% (2016 оны байдлаар)
БНХАБ-ын хөтөлбөрийн долоо хоногт ноогдох дундаж цаг	24	30	40	40
Нэг багшид ноогдох хүүхдийн тоон харьцаа	Нэг багшид 15-24 хүүхэд ноогдох ангилалд дэлхийн улс орнуудын 40 гаруй хувь нь багтаж байна	Нэг багшид 15 хүртэлх хүүхэд ноогдох ангилалд, ихэнх орнууд, 15-24 хүүхэд ноогдох ангилалд цөөн орон багтаж байна	Нэг багшид 15-24 хүүхэд ноогдох ангилалд бүх орнууд багтаж байна	Нэг багшид 25-39 хүүхэд ноогдох ангилалд багтаж байна. Бүлэг дүүргэлтийн улсын дундаж 2018 оны байдлаар 33,4 байна.
СӨБ-ын нийт хамран сургалтад хувийн хэвшлийн цэцэрлэгийн хамран сургалтын эзлэх хувь	Энэ үзүүлэлтээр 32 хүртэлх хувийг эзэлж байгаа ангилалд дэлхийн бүх улсын 50 гаруй хувь нь харин 33-66 хүртэлх хувийг эзэлж буй ангилалд 21 % нь тус тус хамаарч байна.	Энэ үзүүлэлтээр 32 хүртэлх хувийг эзэлж буй ангилалд тус бүс нутгийн ихэнх орнууд, харин 66 хүртэлх хувийг эзэлж буй ангилалд цөөн улс орон багтаж байна.	Энэ үзүүлэлтээр 32 хүртэлх хувийг эзэлж буй ангилалд тус бүс нутгийн ихэнх орнууд нь багтаж байна.	Манай улс 32 хувь хүртэлх ангилалд багтаж байгаа ба СӨБ-д хамрагдаж буй нийт хүүхдийн 16,8% нь хувийн хэвшлийн СӨБ-ын үйлчилгээнд хамрагдаж байна.

Эх сурвалж: UNESCO, 2007, .EFA Global Monitoring report

Энэ нь манай улсад бага насны хүүхдэд хоол тэжээл, асаргаа хамгаалал, эрүүлжүүлэх, чийрэгжүүлэх, боловсролын цогц үйлчилгээг бүтэн өдрийн хөтөлбөрөөр үзүүлдэг “хүүхдийн цэцэрлэг”-ийн уламжлалт тогтолцоо бий болж бэхжсэнтэй, мөн энэ салбарт төрөөс санхүүжилтийн тогтвортой дэмжлэг үзүүлдэгтэй холбоотой. Харин СӨБ-ын үйлчилгээний чанарыг сайжруулах, ялангуяа хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийн ахицыг дэмжсэн цогц бодлого хэрэгжүүлэх, энэ талаар бусад орны туршлагаас суралцах хэрэгтэй нь харагдаж байлаа.


### 1.1.3. Хэрэгжилт, Үр дүн

#### 1.1.3.1. Хүртээмж, оролцоо

#### Сургуулийн өмнөх боловсролын санхүүжилт


СӨБ-ын дэд салбарын төсвийн санхүүжилт 2000 оноос хойш тогтмол өсөж ирсэн ба 2005 оныг 2013 онтой харьцуулбал улсын төсвийн санхүүжилт даруй 7,8 дахин өсжээ. (Зураг 1.1.2)

Зураг 1.1.2. СӨБ, Боловсролын салбарын жил бүрийн төсөв (2000-2013, тэрбум төгрөг)




Дээрх хугацаанд СӨБ-ын төсвийг боловсролын салбарын нийт төсөвт эзлэх хувиар нь авч үзвэл 18.3% -иас 31.3% хүртэл 13 хувиар өссөн байна. (Зураг 1.1.3) Үндэсний нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээгээр 2% орчим хувь байна. Эдгээр үзүүлэлтээр бүс нутгийн орнуудын дундажтай ойролцоо түүнээс ч дээгүүр үзүүлэлттэй байна (Зураг 1.1.4).

Зураг 1.1.3. Монгол Улсын боловсролын нийт төсөвт СӨБ-ын салбарын төсвийн эзлэх хувь (2004-2016)



Зураг 1.1.4. Зарим улс орны боловсролын нийт төсөвт СӨБ-ын төсвийн эзлэх хувь (2011)



Эх сурвалж: UNESCO, 2011

СӨБ-ын тухайн жилийн төсвийг задлан авч үзвэл, 2013 оны байдлаар 194 тэрбум төг зарцуулснаас хувьсах зардал буюу цэцэрлэгийн багш, ажиллагчдын цалин хөлс, урамшуулал болон бусад урсгал зардалд нийт зардлын 67 хувийг, тогтмол зардал буюу цэцэрлэгүүдийн дулаан, эрчим хүч, халаалт зэрэг тогтмол зардалд 9 хувийг, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд 17 хувийг, багш нарын буцалтгүй тусламжид 6.7 хувийг тус тус зарцуулж байсан байна. Сүүлийн жилүүдийн төсвийн өсөлтийн 50-иас илүү хувийг ажиллагсдын цалин хөлс эзэлж байгаа бөгөөд энэ нь сүүлийн 10 жилд ЗГ-аас төрийн нийт албан хаагчдын цалин хөлсийг удаа дараа нэмэгдүүлсэн болон багш ажилчдад нэг удаагийн болон 5 жил тутамд тэтгэмж олгох шийдвэрүүд хэрэгжсэнтэй холбоотой.


ЗГ-ын тогтоолоор СӨБ эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг жилд дунджаар аймгийн төв, суманд 905.3 мян төг, нийслэлд 807.8 мян.төг тооцож санхүүжүүлж байгаа бөгөөд 2016 оны ЗГ-ын 242 дугаар тогтоолын дагуу хувилбарт сургалтын ээлжийн болон нүүдлийн бүлгийн үйлчилгээнд хамрагдаж буй суралцагчид ноогдох хувьсах зардлыг тооцон олгож байна. 2008 онд СӨБ-ын тухай хууль батлагдан гарснаар хүүхдийн хоолны зардлын 50 хувийг эцэг эх даадаг байсан зардлыг төр даах шийдвэр хэрэгжиж эхэлсэн юм. Нэг хүүхдэд ноогдох хоолны зардлыг ЗГ-рын тогтоолоор тогтоодог ба зах зээлийн үнийн өсөлт, инфляцын өөрчлөлтөөс хамаарч байнга нэмэгдүүлж байдаг. Одоо хүүхдийн хоолны мөнгийг нэг өдөрт 1650 төгрөгөөр (ЗГ, 2012) тооцон санхүүжүүлж байна. Хүүхдэд шууд хамаарах хувьсах зардал, ба хоолны төсвийг авч үзвэл, эдгээр нь тогтмол өсөлттэй байгаа ба энэ нь хамрагдах хүүхдийн тоо өсөх тутам эдгээр зардлын санхүүжилт өссөнтэй холбоотой (Хүснэгт 1.1.5). Гэхдээ төсвийн санхүүжилтийн өсөлтийн дийлэнх хувийг багш ажиллагчдын цалингийн өсөлт эзэлж байна. Цэцэрлэгийн 2006, 2017 оны төсвүүд харьцуулбал жилийн нийт төсөвт эзлэх цалингийн зардал 2017 онд 2006 оны үеэс бараг 20% -иар өссөн дүнтэй байгаа бол хувьсах зардлын эзлэх хувь бага зэрэг буурсан (2%) байна (Зураг 1.1.5).



Зураг 1.1.5. Хүүхдийн цэцэрлэгийн төсвийн тогтмол болон хувьсах зардлын санхүүжилтийн динамик өөрчлөлт. (2006-2017, тэрбум төгрөг)



Зураг 1.1.6. Цэцэрлэгийн төсвийн 2006 ба 2017 оны зардлын харьцуулалт: Хувиар




2005 оноос хойших хугацаанд төр засгаас авч хэрэгжүүлсэн бодлогын хэрэгжилтээс хамаарч СӨБ-ын хамран сургалтын бохир жин 25.4% цэвэр жин 31.8% хувиар цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо 2.4 дахин тус тус өсөж иржээ (Зураг 1.1.7). Энэ өсөлтөд доорх хүчин зүйлс нөлөөлжээ.

Нэгдүгээрт, ЕБС-ийн тогтолцоог 12 жилд шилжүүлсэнтэй холбогдуулан СӨБ-д хамруулах насны бүлгийг 2-6, 2-5 нас болгон өөрчилснөөр цэцэрлэгт хамрагдах насны хүүхдийн тоог багасган тооцох болсон.

Хоёрдугаарт, цэцэрлэгийн суурь хүчин чадлыг шинээр цэцэрлэг барих, өргөтгөх замаар 2005 оноос хойш төрийн өмчийн 241, төрийн бус өмчийн 488 цэцэрлэг баригдаж, нийт 4802 анги бүлэг нэмэгдэж, цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах хүчин чадал 72362 орны тоогоор нэмэгджээ.


Зураг 1.1.7. СӨБ-ын хамран сургалтын цэвэр ба бохир жин (2006-2017)




*Гуравдугаарт*, 2008 онд УИХ-аас баталсан “Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль”-иар эцэг, эхээс гарах хоолны зардлыг төрөөс хариуцах болсноор дунджаас доогуур орлоготой өрхийн хүүхдийн хамран сургалтыг хязгаарлаж байсан хүчин зүйлийг арилгасан нь хамрагдалтад чухал нөлөө үзүүлсэн. Мөн энэхүү хуулиар СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээг нэгэн адил төрөөс санхүүжүүлэхээр хуульчилсанаар нь энэ үйлчилгээнд хамрагдах хөдөө орон нутгийн хүүхдийн тоо нэмэгдэхэд хүргэсэн юм. Түүнчлэн хамран сургалт нэмэгдсэнтэй холбогдуулан СӨБ-д зарцуулах улсын төсвийн санхүүжилт жил тутам өсөж 2017 оны байдлаар 284 тэрбум төгрөгт хүрчээ.

*Дөрөвдүгээрт*, хувийн хэвшлийн цэцэрлэг (төмөр зам мэтийн байгууллагын цэцэрлэгүүд багтана)-ийн тоо 2005 онд 50 байсан бол 2018-2019 оны хичээлийн жилд 546 болж, цэцэрлэгийн тоо 11 дахин өссөн ба тэдгээрт 39204 хүүхэд хамрагдаж байгаа ба нийт цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн 16,8 хувийг эзэлж байна. Нийт цэцэрлэгүүдийн 80% Улаанбаатар хотод байршиж байна. Цэцэрлэгт хамрагдсан нийт хүүхдийн 40 гаруй хувь нь зөвхөн Улаанбаатар хотод байгаа бөгөөд үлдсэн хэсэг нь баруун, төв, хангайн бүсэд бараг жигд тархалттай байна. Тус хугацаанд бүс нутгийн СӨБ-ын хамрагдалтыг авч үзвэл баруун бүс нутагт 38.1, хангайн бүс нутагт 29.6, төвийн бүс нутагт 32.2, зүүн бүс нутагт 36.6, Улаанбаатарт 29 хувиар тус тус ахижээ. (Зураг 1.1.8) Энэ нь цэцэрлэгийн тооны болон хүн амын өсөлт, шилжин суурьшилгаас шалтгаалж байна. Сүүлийн 12 жилийн хугацаанд УБ хотын СӨН-ы хүн амын тоо 85046-аар өссөн бол баруун бүс нутагт 3.7 дахин бага буюу 16411 хүүхдээр нэмэгдсэн байна. (Зураг 1.1.9)

Зураг 1.1.8. СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин: Бүс нутгаар (2006-2017)




Зураг 1.1.9. СӨБ-ын 2006 ба 2017 оны хамран сургалтын харьцуулалт: Бүс нутгаар




Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал батлагдан гарч хэрэгжиж эхэлснээс хойш олон улсын шалгуурын дагуу цэцэрлэгт үү? Сургуульд уу? элсэн орохоос өмнөх насанд СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн хамрагдалтыг тооцож гаргадаг болсон. (Зураг 1.1.10) Үүгээр манай улс 2017 онд 92.1 хувьтай байгаа нь бүс нутагтаа өндөр үзүүлэлттэй орны тоонд багтаж байна.

Зураг 1.1.10. СӨБ-д 5 настай хүүхдийн хамрагдсан байдал (2006-2017)




СӨБ-д хамрагдаж буй хүүхдүүдийг насаар авч үзвэл 3-5 насны хүүхдүүд 76%, 2 нас хүртэлх хүүхэд 20% тус тус эзэлж байна. Цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдүүд ясли, бага, дунд, ахлах, бэлтгэл бүлэгт бараг тэнцүү хувиар хамрагдсан байна. (Зураг 1.1.11)

Зураг 1.1.11. СӨБ-д хамрагдсан хүүхдийн тоо (2018)



Үндэсний статистикийн газраас хийсэн хүн амын хэтийн тооцооноос үзэхэд СӨН-ны бүлгийн хүн ам 2020 он хүртэл 45 мянгаар өсөх боловч 2030 он хүртэлх хугацаанд өсөлт ажиглагдахгүй нэг түвшиндээ байх магадлалтай байна. Иймд СӨБ-д хамрагдалтын цэвэр жин 2030 он хүртэл жил бүр 2 хувиас илүү өсөлт үзүүлэхгүй байх магадлалтай. (Зураг 1.1.12)

Зураг 1.1.12. Хүн амын 0-4, 5-9 насны бүлгийнхний 2015-2045 он хүртэлх өсөлтийн хэтийн төлөв




### Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалт

Монгол Улсын сумдын 80 гаруй хувь нь аймгийнхаа төвөөс 100 км-ээс хол оршдог. Хүн амын 40 шахам хувийг эзэлдэг малчин айл өрхүүд сумын төвөөс дунджаар 10-55 км алслагдан нүүдлийн мал аж ахуй эрхлэн амьдардаг. Мөн хүн амын ядуурал ба төв рүү чиглэсэн шилжилт

хөдөлгөөнөөс хамаарч хот суурин газрын захын хорооллын айл өрхийн хүүхэд цэцэрлэгт хамрагдах боломж бусад бүлгийн хүүхдээс доогуур байдаг. Хүн амын эдгээр бүлгийн бага насны хүүхдүүдэд СӨБ-ын үйлчилгээг үзүүлэхэд уян хатан арга, хэлбэрийг шаарддаг. Энэхүү хэрэгцээг хангахын тулд цэцэрлэгийн үндсэн сургалтаас гадна хувилбарт сургалтын үйлчилгээг бий болгож хөгжүүлсэн явдал үндэсний онцлогтой бодлого, шийдэл болж чадсан юм. СӨБ-ын тухай хуульд (ЗГ, 2008) цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдаж чадахгүй байгаа хүүхдэд зориулсан ээлжийн, явуулын, нүүдлийн бүлгийн сургалтын хэлбэрээр СӨБ эзэмшүүлэх хувилбарт сургалтыг, “цэцэрлэгийн нэгэн адил улсын төсвөөс санхүүжүүлэх” тухай заасан байдаг.

СӨБ-ын үйлчилгээний эдгээр хэлбэр сүүлийн 20 жилийн хугацаанд сургалтын хэлбэр, агуулга, арга зүй, орчны хувьд нэлээд бэхжиж хууль эрх зүйн хувьд ч тодорхой статустай болголоо хөгжиж байна. Тухайлбал, эхний үед голчлон төсөл хөтөлбөрийн хөрөнгө, хүч оролцоотойгоор СӨБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх хувилбарт сургалтын санаачилгуудыг дэмжиж байсан бол дунд үеийн хугацаанд хувилбарт сургалт нь туршигдаж биеллээ олсон сургалтын хэлбэрүүдийг улсын төсвөөс санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар дэмжлэг үзүүлэх болжээ. Харин сүүлийн жилүүдэд хувилбарт сургалтын үйлчилгээний санхүүжилт, сургалтын орчин, багш зэрэг асуудлуудад цогцоор хандаж дэмжих бодлого хэрэгжүүлж ирсэн байна. Жишээлбэл: 2012 онд БШУЯ-наас хувилбарт сургалт зохион байгуулах журам батлагдан гарч мөрдөгдсөнөөр чанарын хяналт бий болж, энэ үйлчилгээг институтчлах талаар тавьсан зорилтыг (Боловсролын салбарыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө, СӨБ дэд салбарын зорилт, 2006) хангахад чухал алхам хйгджээ.

Зураг 1.1.13. СӨБ-ын хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн динамик өөрчлөлт (2004/05-2017/18 оны хичээлийн жил)




Сүүлийн жилүүдэд цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо тогтмол өсөж байгаатай холбогдуулан СӨБ-ын хамран сургалтад хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь буурч 9,2% байна. (Зураг 1.1.13) СӨБ-ын хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдийн тоо 2011 он хүртэлх (35076) хугацаанд өсөж байсан бол 2018 хүртэлх хугацаанд 13,7 хувиар буурчээ. 2018 оны байдлаар 23705 хүүхэд хувилбарт сургалтын үйлчилгээнд хамрагдаж, жилд 3.0 тэрбум орчим төгрөгийн санхүүжилт улсын төсвөөс авч байна. 2018 оны байдлаар хувилбарт сургалтад хамрагдсан хүүхдүүдийн 69% нь нүүдлийн гэр цэцэрлэгт, 19% нь ээлжийн бүлэгт, 12% нь явуулын багшийн сургалтад тус тус хамрагдаж байна.

### 1.1.3.2. Чанар, нийц

СӨБ-ын үйлчилгээний чанарын асуудлыг авч үзэхдээ ЮНЕСКО-оос зөвлөмж болгосон боловсролын үнэлгээний “чанар”-ын схемийг тулгуур болгон авч үзлээ. Өөрөөр хэлбэл, дэд салбарын оролтын нөөцүүд болох сургалтын хөтөлбөр, сурах бичиг хэрэглэгдэхүүн, цэцэрлэгийн барилга байгууламж, сургалтын орчин, багшийн бэлтгэл; үйл явц буюу цэцэрлэгийн бүтэц, тогтолцоо, сургалтын үйл ажиллагаа, менежмент, чанарын хяналтын механизм, манлайлал, урамшуулал, багшийн мэргэжил дээшлүүлэх зэрэг асуудлууд; гаралтын үр дүн буюу хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, хөгжлийн үнэлгээ зэрэг асуудлуудыг тус тус авч үзэж дүн шинжилгээ хийлээ. Зураг (1.1.14)

Зураг 1.1.14. Боловсролын чанарын схем.



**Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанарт тавигдах шаардлага, стандарт**

Манай орны-СӨБ-ын үйлчилгээний чанарт тавигдах шаардлага, түүнийг хэмжих үндэсний стандартын баримт бичгүүдэд салбарын хууль тогтоомж, стандарт, норм, журам, дүрмийг багтаахаас гадна хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хоол тэжээл, эрүүл ахуйн талаарх салбар дамнасан норм стандартууд байдаг. (Хүснэгт 1.1.7) Эдгээр баримт бичгүүдийг үндэслэн Улсын Мэргэжлийн Хяналтын газар, Онцгой байдлын газар, ЭМЯ, тэдгээрийн бүтцийн байгууллагууд цэцэрлэгийн орчин, үйлчилгээнд салбар дамнасан чанарын хяналтыг хийдэг бол БСШУСЯ-аас СӨБ-ын салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, нэгжийн түвшинд цэцэрлэгийн удирдлагын зүгээс хүүхдийн хоол хүнсний үйлчилгээ, эрүүл ахуй, сургалтын болон багшийн үйл ажиллагаанд тус тус хяналт тавих чиг үүрэгтэй ажилладаг. Дээрх байгууллагууд доор дурдсан баримт бичгүүдэд заасан норм, хэм хэмжээг үнэлэх чанарын үнэлгээний тус тусын гарын авлагууд ашигладаг. Жишээлбэл: УМХГ “Сургууль, цэцэрлэгийн эрсдэлийн үнэлгээний хуудас”, БСШУЯ-аас “Цэцэрлэг, багшийн үйл ажиллагааг үнэлэх журам” гэх мэт.

Хүснэгт 1.1.7. СӨБ үйлчилгээний чанарт хяналт тавихад ашиглаж буй гол стандарт, эрх зүйн баримт бичгүүд

	Гол баримт бичиг, стандарт
Хүүхдийн эрүүл мэнд	<ul style="list-style-type: none"> <li>• СӨБ-ын тухай хууль, 2008</li> <li>• “Хүүхэд, өсвөр үеийнхний сургалт хүмүүжлийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх эрүүл ахуйн үлгэрчилсэн дүрэм”, 1995</li> <li>• “Цэцэрлэг, ЕБС, дотуур байрны ус ариун цэвэр, эрүүл ахуйн норм, шаардлага” 2015</li> </ul>
Хүүхдийн аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> <li>• СӨБ тухай хууль, 2008</li> <li>• “Хүүхдийн цэцэрлэгийн аюулгүй байдлын дүрэм” 2008</li> </ul>
Хүүхдийн хоол тэжээл	<ul style="list-style-type: none"> <li>• “Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм” 2008</li> <li>• Хувьсах зардлын дундаж норматив батлах тухай ЗГ тогтоол, 216</li> </ul>
Хүүхдийн цэцэрлэгийн Барилга байгууламж, сургалтын орчин	<ul style="list-style-type: none"> <li>• “Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга төлөвлөлтийн норм”</li> <li>• “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчин. Ерөнхий шаардлага” MNS 6558: 2015                         <ul style="list-style-type: none"> <li>○ СӨББ-ын орчны нөхцөл: гадна орчин, барилга, байгууламж, бүлгийн өрөө, ариун цэврийн өрөө, угаагуур, суултуурт тавих шаардлага, хөгжим, биений тамирын танхим, гал тогоонд тавих шаардлага</li> <li>○ Сургалтын хэрэглэгдэхүүнд тавих шаардлага: техник хэрэгсэл, тоглоом, наадгай, ном, бичгийн хэрэгсэлд тавих шаардлага</li> </ul> </li> <li>• Хүүхдийн тоглоомын стандарт, MNS ISO 8124: 2011</li> </ul>
Хүүхдийн хөгжил, сургалт	<ul style="list-style-type: none"> <li>• СӨБ тухай хууль, 2008</li> <li>• Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт, 2011</li> <li>• Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр, 2014</li> <li>• Сургуулийн өмнөх боловсролын сургалтын бодлого</li> <li>• Цэцэрлэг, багшийн ажлыг үнэлж дүгнэх журам гэх мэт</li> </ul>

СӨБ-ын чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны талаар хийгдсэн судалгаа ховор байдаг. Харин 2016 онд Дэлхийн Банкнаас хийсэн судалгаагаар “Монгол Улсад СӨБ-ын чанарын бүтцийн болон үйл явцын талуудыг зохицуулах тун боломжийн стандартууд байна. Стандартууд нь цэцэрлэгийн дэд бүтэц ба сургалтын буюу хөгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах хэрэглэгдэхүүн, материалуудыг хянахад зориулсан бол цөм хөтөлбөр нь хүүхдэд танин мэдүүлэх, эзэмшүүлбэл зохих гол ухагдахуунууд, хөгжүүлэх үйл ажиллагаан үр дүнд хүүхдийн хөгжилд ямар үр дүн гарах ёстой болохыг харуулдаг. Гэвч стандартыг мөрдөж байгаа үйл явц, чанарын үнэлгээг тогтмол хийхгүй бол сайжруулах шаардлагатай зүйлсийг зөв тодорхойлж, тэдгээрт чиглэсэн хөрөнгө оруулалтыг хийх боломжгүй юм” (Дэлхийн банк, 2016) гэсэн дүгнэлт хийж байжээ.


Дээрх мэдээллээс үзвэл, манай оронд боловсролоос бусад салбаруудад мөрдөж буй бага насны хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд хамаарах стандарт, норматив байгаа боловч СӨБ-ын үйлчилгээний чанарыг үнэлэх, үр дүнг хэмжихдээ салбар бүрийн байгууллагууд өөр өөрийн бүтэц тогтолцооны хэмжих үр дүнг гол болгосон чанарын хяналт- үнэлгээний тогтолцоотой байна.

СӨБ-ын үйлчилгээний гаралт дээрх чанарыг үнэлэх гол хэмжүүр бол бага насны хүүхдийн хөгжлийн үзүүлэлтүүд ба сургуульд бэлтгэгдсэн байдал бөгөөд боловсролын салбарын болон салбар дамнасан байгууллагууд энэ үр дүнд суурилсан нэгдмэл стандарт хяналтын тогтолцоог бий болговол илүү үр дүнтэй байх болно.


**Цэцэрлэгийн барилга байгууламж, гадаад, дотоод орчин**

Монгол улсад 2005 оноос хойш бодлогын үр нөлөөгөөр нэмэгдсэн СӨБ-ын хамран сургалтын өсөлт мөн хот суурин газар луу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөний өсөлтөөс шалтгаалан хүүхдийн цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинээр цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засварлах асар их хэрэгцээ бий болсон билээ. Энэ өсөлтөд харгалзсан нийлүүлэлтийн динамикийг 2004-2016 хооронд бий болсон цэцэрлэгийн (2) болон анги бүлгийн тооны өсөлтөөс (2.5 дахин) харж болно. (Зураг 1.1.15). Гэхдээ бүлэг дүүргэлт (33.4) өндөр байгаагаас барилгын суурилагдсан хүчин чадлаасаа даруй 32.8% иар илүү хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байна. Энэ нь төвлөрсөн суурин газарт цэцэрлэг барих хэрэгцээ их байгааг харуулж байна. БСШУЯ-нд бүртгэгдсэн цэцэрлэгийн барилгын хүчин чадал 2006 оноос хойш жилд дунджаар 7.9%- иар өссөн бол хамран сургалт 31% өссөн байна (Зураг 1.1.16). Бүс нутгаар авч үзвэл, Улаанбаатарт хүүхдийн цэцэрлэгийн барилгын хүчин чадал өнгөрсөн 10 жилд хамгийн их өссөн байна (Зураг 1.1.17).


Зураг 1.1.15. Цэцэрлэгийн болон анги бүлгийн тооны динамик өөрчлөлт (2004/05-2015/16 оны хичээлийн жил)



Зураг 1.1.16. Цэцэрлэгийн барилгын хүчин чадал ба цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тооны динамик өөрчлөлт (2007-2017)



Зураг 1.1.17. Цэцэрлэгийн барилгын хүчин чадлын өсөлт (2008-2017)



Дээрх хэрэгцээг хангахын тулд улсын төсвөөс цэцэрлэгийн барилга байгууламжийг шинээр барих талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж 2012 он хүртэлх хугацаанд жилд дунджаар 3500 (БНБ-ын үнэлгээний тайлан, 2014)-аас доошгүй цэцэрлэгийн ор шинээр хүлээн авсан байна. Засгийн Газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланд (БСШУЯ, 2016) 2009-2014 онд нийт 153 цэцэрлэг шинээр баригдаж, нийтдээ 35285 орны тоогоор барилгын суурилагдсан хүчин чадлыг нэмэгдүүлсэн гэсэн мэдээтэй байна. Энэ ажлын хүрээнд сүүлийн 10 жилд хямд өртгөөр, шинэ технологид суурилсан барилгуудыг богино хугацаанд хөдөөгийн сумдад болон нийслэлийн захын гэр хороололд түлхүү барьсан байна. Жишээлбэл: 75-150 хүүхдийн хүчин чадалтай, хүүхдийн эрүүл ахуйн шаардлага хангасан, цэвэр бохир усны системтэй, хөгжим, биеийн тамир, гал тогоо, анги танхим, багш ажиллагчдын өрөө тасалгааг тусад нь бүрэн шийдсэн угсармал модон барилгуудыг барьжээ.

Зураг 1.1.18. Нийслэлийн Сүхбаатар, Баянзүрх дүүргийн захын хороолол, Хэнтий аймгийн Батицэрээт сум, Булган аймгийн Орхон суманд ашиглалтад орсон шинэ цэцэрлэгүүд



БСШУЯ-ны 2018 оны мэдээгээр 16420 хүүхдийн ортой 106 цэцэрлэгийн барилгыг шинээр барих, худалдан авах замаар ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Энэ нь 2016-2020 онд Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн “хүүхэд бүрд” цэцэрлэг гэсэн зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг хангахад чиглэсэн бөгөөд дээр дурдсан 2012 он хүртэлх хугацаанд гарсан

цэцэрлэгийн орны дундаж өсөлтөөс 3 дахин өндөр түвшинд хүчин чадлыг нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.

Түүнчлэн СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээг дэмжих чиглэлээр нэлээд их хөрөнгө оруулалт хийсэн ба төсвийн болон төсвийн бус хөрөнгөөр хөдөөгийн малчин айл өрхийн хүүхдүүдэд үйлчлэх иж бүрэн гэр цэцэрлэгийг олон тоогоор нийлүүлж, нийт сумдын 60 гаруй хувьд нь нүүдлийн гэр цэцэрлэгийн хөрөнгө оруулалт хийжээ. Нийлүүлсэн гэр цэцэрлэгүүд нь нарны зайн цахилгаан үүсгүүр, гал тогоо, сургалтын хэрэглэгдэхүүн, номын сан, цагаан хэрэглэл, хоолны хэрэгсэл зэрэг шаардлагатай зүйлээр бүрэн хангасан хөдөөгийн хүүхдэд асаргаа халамж, хоол тэжээл, сургалтын үйлчилгээ үзүүлэхэд бүрэн нийцэж байгаа ажээ. БШУЯ-наас 2009-2013 онд хэрэгжүүлсэн “Хөдөөгийн, нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох” төслийн хүрээнд 136 гэр цэцэрлэгийг 2,758 сая төг хөрөнгө оруулалтаар (“Хөдөөгийн, нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох” төслийн тайлан, 2014) байгуулж, ажиллуулсан байна ( Зураг 1.1.19). Нүүдлийн гэр цэцэрлэгийн дотоод, гадаад орчин).

Энэ төслийн үр дүнд нүүдлийн болон суурин гэр цэцэрлэгийн үйл ажиллагааг 6-9 сарын урт хугацаанд улсын төсвөөс санхүүжүүлэн ажиллуулсан нь хөдөөгийн бага насны хүүхдэд хөгжлийн цогц үйлчилгээ үзүүлэхэд чанарын ахиц бий болгожээ.

Зураг 1.1.19. Нүүдлийн гэр цэцэрлэг, сургалтын орчин



2017 оны хичээлийн жилийн мэдээгээр (БШУЯ-ны статистик мэдээлэл, огноо байхгүй) 156448 хүүхдийн хүчин чадалтай төрийн өмчийн 904, төрийн бус өмчийн 204 цэцэрлэгийн байр ашиглагдаж байгаа ба үүнээс өөрийн эзэмшилд 1061 объект хамрагдаж байна. Судалгаанаас үзэхэд (БШУЯ) дээрх төрийн өмчийн цэцэрлэгийн барилгын 23% нь 30–аас дээш жил ашигласан, ашиглалтын хугацаа дууссан тул тэдгээр барилгыг нурааж, шинээр барих шаардлагатай болсон байна. Гэвч ашиглалтад орж буй барилгын хүчин чадал нь дээрх өсөлтийг гүйцэхгүй байгаа ба цаашид 44000 ор бүхий 443 цэцэрлэгийн барилга (БШУЯ, 2013) шинээр барих хэрэгцээ байна гэж дүгнэжээ.

2015 онд Барилгын хөгжлийн төвийн хийсэн судалгаагаар нийт цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах хүчин чадал 113.152 байгаа бөгөөд цаашид 158.099 хүүхдийн хүчин чадалтай барилга шинээр барих шаардлагатай гэж дурджээ. Тухайлбал, Улаанбаатар хотод 86861, орон нутагт 71236 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилга барих шаардлагатай гэжээ.

Хүн амын шилжин суурьшилт болон хамран сургалтын дундаж өсөлтөөс үзвэл төвлөрсөн хот суурин газарт сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан цэцэрлэгийн барилга барих хэрэгцээ ойрын 10 жил буурахааргүй байна.

### Цэцэрлэгийн барилгын төлөвлөлт

Цэцэрлэгийн барилгыг барих, засварлах ажил нь Барилгын, Байгаль орчны хамгаалалтын, Галын аюулгүй байдлын, Газрын, Геодези, зураг зүйн, Стандартчилал, чанарын баталгаажуулалтын, Технологи дамжуулалтын, Усны, Хот байгуулалтын, Цахилгаан, дулааны эрчим хүчний зэрэг хуулиудын хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэх талаар гаргасан заавар, дүрэм, журмыг баримтлахын хамт барилгын зураг төсөл боловсруулах, материал үйлдвэрлэх, барилга угсралт, засварын ажил гүйцэтгэх норм, дүрэм, стандартын тухай бие даасан цогц нормативын бааз баримт бичгээр тус тус тодорхойлогддог. Мөн хөрөнгө оруулалт, барилгын төлөвлөгөөг боловсруулахдаа “Барилгын хөрөнгө оруулалтыг төлөвлөх ба санхүүжүүлэх журам”-ыг баримтлан хийж байгаа ба тухайн орон нутаг, суурин газар оршин суугчдын тоо, түүнд шаардагдах хүчин чадал, иргэдийн суурьшил, шилжилт хөдөлгөөний динамик үзүүлэлтүүдийн судалгаа, барилгын элэгдэл хуучралтын байдал зэрэгт үндэслэж байна. Барилгын хөрөнгө оруулалт, их засварын ажлын төлөвлөлт нь анхан



шатны нэгж байгууллага болох цэцэрлэгийн хэрэгцээ болон сум, орон нутгийн саналыг тусгахаас гадна БСШУСЯ нь ирэх онуудад шинээр барих ба өргөтгөх цэцэрлэгийн барилгын жагсаалтыг урьдчилан гаргаж, жил жилд нь түүнийгээ тодотгон төлөвлөж байна (БШУЯ).

Барилгын зураг төслийг зохиохдоо зохих техник эдийн засгийн үндэслэлээр боловсруулсан зургийн даалгаврыг батлан гаргасны дараа зөвлөх үйлчилгээний тендер зарлаж, зураг зохиох гүйцэтгэгчийг сонгон авна. Зураг зохиогч нь батлагдсан даалгаврын дагуу зургийг боловсруулж, эрүүл ахуй, гал түймэр эсэргүүцэх байгууллага, захиалагчаар хянуулан улсын экспертизээр шалгуулж баталгаажуулна. Бэлэн болсон зургийн дагуу төсөв (өртөг, зардлын тооцоо)-ийг одоогийн мөрдөж байгаа зардлын нормативын баримт бичгүүдийг баримтлан тооцож гаргадаг. Гэхдээ энэхүү зураг төсөл зохиох явцад СӨБ-ын мэргэжилтний оролцоо, орчин үеийн сургалтын орчны шийдлүүдийг тусгах явдал хязгаарлагдмал байгаа юм.

Цэцэрлэгийн үндсэн барилгууд ихэнхдээ 50, 100, 150, 200, 280, 330 гэсэн хүүхдийн орны хүчин чадалтай барилгууд баригдсан байдаг ба дээрх хүчин чадалд тохирсон нийтлэг хэв загварын зураг төслөөр цэцэрлэгүүд баригдсан байдаг. Харин сүүлийн жилүүдэд архитектур төлөвлөлтийн норм, стандартыг баримтлан төлөвлөлтийн өөр өөр шийдлээр зураг төсөл боловсруулж, шинэ технологид суурилсан барилгууд хуучин барилгуудаас өөр зураг төсөл, дизайнаар баригдаж байна.

**Цэцэрлэгийн эдэлбэр газар**

Судалгаанаас үзэхэд цэцэрлэгүүдийн эдэлбэр газар дунджаар нэг цэцэрлэгт 3,896.8 м<sup>2</sup>, нэг хүүхдэд 30 м<sup>2</sup> хүртэлх талбай ногдож байна. Улаанбаатар хотод байршилтай зарим цэцэрлэгүүд гадны нөлөөгөөр эдэлбэр газраасаа алдах явдал байхын зэрэгцээ гэр хороололд байрладаг цэцэрлэгийн 73.5 хувь нь хөрсний ариун цэврийн шаардлага хангахгүй байна (МХГ-ын үнэлгээний тайлан, 2013). Улаанбаатар хотын цэцэрлэгийн 61.9 хувь, хөдөө орон нутгийн цэцэрлэгийн 61.3 хувийн тоглоом хэрэглэл нь хүүхдийн аюулгүй байдал, стандарт шаардлагад нийцэж байна. Шинээр ашиглалтад орж буй цэцэрлэгүүдийг ихэнхдээ эдэлбэр газартай, талбайн тохижилттой хүлээлгэж өгч байгаа ба цэцэрлэгүүд ч өөрийн хүч бололцоогоор стандартын шаардлагад нийцсэн гадаад орчныг бүрдүүлэхийг чармайж байгаа билээ. Эдэлбэр газрын ногоон байгууламжид орчны бохирдлоос үүдэн ургамлын бүтэц, ногоон бүрхэвч устах явдал их байна.

**Цэцэрлэгийн бүлгийн анги танхимын үзүүлэлт**

Цэцэрлэгийн анги бүлгийн талбай нормативын дагуу нэг хүүхдэд 3.1 м<sup>2</sup> ноогдох ёстой байгаа боловч бүлэг дүүргэлт өндөр байгаа одоогийн нөхцөлд 2 хүртэлх м<sup>2</sup> ноогдож байгаа нь хангалтгүй байгаа ба ялангуяа, сургалтын, ариун цэврийн, унтлагын хэсэг эрүүл ахуйн нормативтаагдсан хэмжээнээс доогуур байгаа юм.

*Хүснэгт 1.1.8. Цэцэрлэгийн ашигтай талбай (2011)*

	Бүлгийн талбай	Хүлээн авах хөлийн өрөө	Сургалтын хэсэг	Ариун цэврийн өрөө	Унтлагын өрөө
Улсын дундаж (СӨББ-ын сургалтын орчны өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан, 2011)	78.1	68.2	32.4	85.2	25.6

**Сургуулийн өмнөх насны хүүхдийн ном, гарын авлага**

Судалгаанаас үзэхэд (Сургуулийн өмнөх боловсролын нөхцөл байдлын дүн шинжилгээ тайлан, 2010) нийт худалдаалж буй номын дийлэнх хувийг (70 хүртэлх) дотоодын үйлдвэрлэгч хэвлэлийн компаниудын хэвлэж буй ном эзэлдэг ба эдгээр номын 68% нь хүүхдийн нас, хөгжлийн онцлогт нийцсэн байдаг байна. Түүнчлэн СӨН-ны хүүхэдтэй эцэг эхчүүдийн 60-70 хувь нь хүүхдэдээ үлгэрийн номыг голлон сонгож авдаг. Монголд хүүхдийн ном, хэвлэлийн үйлдвэрийн тухай болон цэцэрлэгийн насны хүүхдийн сургалтад ашиглах номын нэгдсэн каталог, жагсаалт түгээмэл биш боловч зарим төслийн хүрээнд энэ төрлийн материалыг боловсруулан гаргасан байна. Ашиглаж буй ном гарын авлагын агуулгыг авч үзвэл ихэнх нь орчуулгын бүтээл зонхилдог бөгөөд үүнээс хамаарч тухайн насны хүүхдэд агуулга, зураг дүрслэл зохицохгүй байх явдал түгээмэл байдаг байна.

Судалгаанаас үзэхэд ("Хүүхдэд ээлтэй цэцэрлэг" төсөл, 2012) цэцэрлэгийн анги бүлэгт байх хүүхдийн номын тоо харилцан адилгүй байна. Цэцэрлэгийн нэг ангид байх номын тоо дунджаар 15–20 байсан бөгөөд хөдөөд 5-10 байсан ба нийт номын 52% нь хүүхдэд зориулсан, 48% нь

мэргэжлийн сэдэвтэй ном байсан байна. Ангид ашиглагдаж байгаа номын дундаж хэрэглээ 1-2 жил байгаа ба хуучин номууд эрүүл ахуйн шаардлага хангахгүй байгаа талаар Мэргэжлийн хяналтын газрын үнэлгээнд дурдагджээ.

Цэцэрлэгийн ангиудад ихэнхдээ үлгэр, буддаг ном, дасгал ажлын төрлийн номууд байсан ба хүүхдийн ажлын дэвтэр, дасгал ажлын дэвтрийн хүртээмж хязгаарлагдмал, багш нар зөвхөн хэл ярианы хөгжилд зориулсан номууд ашигладаг бусад математик, урлан бүтээх, хөдөлгөөн хөгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах хүүхдэд зориулсан гарын авлага, суралцахуйн материалын хүрэлцээ хангалтгүй байна. Харин 2012 оноос хэрэгжүүлсэн “Ном” хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгийн анги бүлгийн номын буланд нийлүүлэх номын хангалт багагүй нэмэгдсэн ба багш нарын ном ашиглан сургалт явуулах арга зүй сайжирч байгаа мэдээтэй байна (БШУЯ, 2013).

СӨБ-ын тухай хуульд ном, гарын авлагаар цэцэрлэгүүдийг өмчийн хэлбэр харгалзахгүй хангах тухай заалт байгаа боловч үүнийг хэрэгжүүлэх зардлыг жил бүр улсын төсвийн санхүүжилтэд тусгаж чадахгүй байна. Мөн СӨН-ны хүүхдийн ном, гарын авлагыг бэлтгэх талаар зарим төслийн санаачилгыг эс тооцвол төрөөс өгөх захиалга ховор байна. Мөн СӨН-ны хүүхдийн гарын авлагыг боловсруулах, түгээх, түүнд тавигдах эрүүл ахуйн шаардлагыг эс тооцвол энэ харилцааг зохицуулах бусад журам алга байна.

**Цэцэрлэгийн анги бүлгийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж**

Цэцэрлэгийн анги бүлэгт хэрэглэгддэг наад захын тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, тавилга, төхөөрөмжийн нөхцөл байдлыг сургалтын орчны талаарх статистик мэдээлэлд үндэслэн тооцож үзэхэд хүүхдийн сандал, ширээ, ангийн тавилга хэрэгсэл, тоглоомын хүртээмж сургалтын орчны баримт бичигт туссан нормативт тоо хэмжээ, нэг ангид ноогдох хүүхдийн бодит тооноос доогуур байгаа юм.

*Хүснэгт 1.1.9. Цэцэрлэгийн ангид ногдох, сургалтын хэрэглэгдэхүүний улсын дундаж үзүүлэлт (2013-2014)*

Анги танхимын орчин нөхцөлийн стандарт	Сандал, ширээ	Сургалтын цахилгаан хэрэгсэл (Хөгжим, проектор, ТВ г.м)	Сургалтын тавиур, шкаф, хувцасны шүүгээ	Ариун цэврийн угаалтуур суултуур	Тоглоом
Өрөөний дундаж температур 19.6 <sup>0</sup> С, Өрөөний гэрэлтүүлэг дундаж 423.9 люкс Чийглэг дунджаар 36.4 % (Мэргэжлийн хяналтын албаны шалгалтын тайлан, 2013)	Улсын дунджаар Ширээ-7.3 Сандал-30 (БШУЯ, 2013)	Хөгжим-0.5 Телевиз-0.4 Проектор - 0.5	Тавиур 3-4, Шкаф 1.5-2, Шүүгээ0.5-1	Улсын дундаж: Угаалтуур- 2.8 Суултуур – 2.0	Нэгж тоглоом 40.6

Дээрх дундажад нөлөөлж буй хүчин зүйл нь цэцэрлэгийн хүүхдийн тоо эрс өсөлтөд хангахуйц хөрөнгө оруулалтын зардлыг бүрэн санхүүжүүлж чадахгүй байгаатай холбоотой. Гэхдээ хувийн хэвшлийн байгууллагууд анги танхимын орчны үзүүлэлт төрийн өмчийн хэвшлийн байгууллагаас дээгүүр байна. Харин хувийн хэвшлийн цэцэрлэгийн гадаад орчны талбай, аюулгүй байдалд анхаарах шаардлагатай байдаг байна (Мэргэжлийн хяналтын газрын хяналтын тайлан, 2014).

Түүнчлэн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн нь хүүхдийн хөгжлийн олон талт хэрэгцээг хангах, сургалтын үйл ажиллагааны төрөл хэлбэрүүдэд нийцсэн үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг үзүүлэлтээр цэцэрлэгийн сургалтын орчинг сайжруулах шаардлагатай байна. Жишээлбэл, нэг бүлэгт ноогдож буй нэгж тоглоом 40.6 байгаа боловч дээрх шалгуурт нийцсэн оюун ухаан, бие бялдрын хөгжлийг дэмжих олон төрөл зүйлийн тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн болон ангид хүүхдүүдийг ганцаарчлан болон жижиг бүлгийн зохион байгуулалтаар сургалтын үйл ажиллагаа зохион байгуулахад шаардлагатай тоглоом, хэрэглэгдэхүүн нь хүрэлцдэггүй тохиолдол элбэг байдаг. Мөн анги танхимын орчин нь хүүхдийн тоо ихэссэнээс шалтгаалж стандартын шаардлагаа хангаж чадахгүй байгаа нь зарим эрсдэлд хүргэж байна. Жишээлбэл, цэцэрлэгүүдийн эрүүл ахуй, халдвар хамгаалал, аюулгүй байдлын хувьд 45.8% нь дунд, 28.8% нь их эрсдэлтэй үнэлэгдэж байсан байна (Мэргэжлийн хяналтын газрын хяналтын тайлан, 2014).


Судалгаанаас үзэхэд ("Хүүхдэд ээлтэй цэцэрлэг" төсөл, 2012) багш нарын ихэнх хувь цэцэрлэгийн сургалтын орчинг сайжруулах хэрэгтэй гэж үнэлж байжээ. Сургалтын материал, техник хэрэгслийн хангамж, хуучин цэцэрлэгийн барилга болон инженерийн байгууламжийн

ашиглалтын нөхцөл муудсан, бусад эд хогшил хүрэлцээгүй, эрүүл ахуйн болон сургалтын орчинтой холбоотой хүчин зүйлүүд хангалтгүй гэж тэд үзэж байв. Судалгаанд хамрагдсан цэцэрлэгүүдийн сургалтын тоног төхөөрөмжийн боломж ихээхэн ялгаатай. Зарим цэцэрлэг төгөлдөр хуур, компьютер, принтер, хувилах машин (сургалтын материал бэлтгэх зориулалттай) боломжийн түвшинд байхад зарим цэцэрлэгт эдгээр тоног төхөөрөмж цөөн байна. Мөн цэцэрлэгт хүүхдийн ор, зөөлөн эдлэлийн хангамж дутагдалтай талаар олон багш, туслах багш нар танилцуулж байв.

### Сургуулийн өмнөх боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр

Боловсролын салбарыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд “Бага насны хүүхдийн хөгжлийн стандарттай болох, түүнд нийцсэн хөтөлбөр, арга зүйн шинэчлэл хийх” гэсэн зорилтууд дэвшүүлсэн байдаг. Энэ зорилттой уялдуулан БСШУСЯ-наас 3 удаа СӨБ-ын стандартыг боловсруулж батлан мөрдүүлсэн бөгөөд стандарт тус бүр тухайн үеийн боловсролын агуулга, арга зүйн шинэчлэлийг тусгасан баримт бичгүүд байлаа. (Зураг 1.1.20) (Боловсролын хүрээлэн, 2018)

Зураг 1.1.20. СӨБ-ын стандартууд



“Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт”-ыг боловсруулж 2011 онд Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөр батлуулан мөрдүүлж, уг стандартыг хэрэгжүүлэх багш нарын гарын авлага, зөвлөмжийг боловсруулан сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байсан. Уг стандарт нь цэцэрлэгүүд бие даан сургалтын хөтөлбөрөө боловсруулах, хүүхдийн хөгжилд цогцоор хандах, сургалтын үйл ажиллагаанд гэр бүл, эцэг эхийн оролцоог татан оруулахад анхаарах болсон нь давуу талтай. Түүнчлэн уг стандартыг хэрэгжүүлэх талаар БСШУЯ-аас багш нарт зориулсан арга зүйн сургалтуудыг үе шаттай зохион байгуулж байжээ. Гэвч 2014 онд уг стандартыг мөрдүүлэх явдлыг зогсоосон нь стандартын хэрэгжилт болон цаашдын сайжруулалтад сөргөөр нөлөөлсөн байна.

БСШУЯ-наас 2014 онд СӨБ-ын цөм хөтөлбөрийг боловсруулан баталж мөрдүүлсэн. Уг цөм хөтөлбөрийн агуулгыг хөдөлгөөн-эрүүл мэнд, зан чанар-харилцаа, хэл яриа-хүрээлэн буй орчин, математик энгийн төсөөлөл, хөгжим дүрслэх урлаг гэсэн хүүхдийн суралцахуйн 6 айг багтаан боловсруулж, хүүхдийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлыг (нийт 7 ерөнхий, 41 тусгай чадвар) гүйцэтгэлийн түвшин бүрд харгалзуулан боловсруулж өгснөөрөө онцлогтой байна. Түүнчлэн хүүхдийг эзэмшсэн чадамжаар үнэлж, сонирхол, эрмэлзэл, хэвшил дадал, чармайлт зэргийг илрүүлэх, хөгжлийн ахицыг үнэлэх нарийвчилсан бүтэцтэй ажиглалт, хувийн хавтас бүрдүүлэлт хийх, чөлөөт ажиглалт хийх гэсэн аргачлал нэвтрүүлсэн зэрэг дэвшилтэт талуудтай байна. Зарим мэргэжилтнүүдийн судалгаагаар энэхүү хөтөлбөр нь (Н.Норжхорлоо, 2019) цэцэрлэгийн менежмент, бие даасан байдал, багш нарын бүтээлч үйлийг дэмжиж, сургалтын хөтөлбөр, орчин, үйл ажиллагааны зохион байгуулалт, байгууллагын соёл, эцэг эх, бусад байгууллага, хүмүүстэй хэрхэн хамтран ажиллахыг өөрсдөө шийдэх эрх, үүргийг цэцэрлэгийн хамт олонд өгсөн юм. Гэвч хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлэх сургалт болон зөвлөн туслах ажил эхний жилийг эс тооцвол улс орон даяар системтэй явагдаагүй, зөнд нь орхисноос зарим судлаачид, орон нутгийн мэргэжилтэн, цэцэрлэгийн удирдлага, багш нарын ойлголтын зөрүү их байна. Багш хуучин хандлагаасаа салахгүй хүүхдэд эзэмшүүлэх хэтэрхий олон мэдлэг, чадварын хойноос хөөцөлдөх, үр дүн багатай бичиг цаасны ажил хийх, ангийнхаа хүүхдүүдийн үнэлгээг буруу нэгтгэх тохиолдлууд байна. Цаашид сургалтын үндэсний хөтөлбөрийг өөрчилж шинэчлэхдээ бага, дунд боловсролын хөтөлбөртэй уялдуулан холбоонд нь авч үзэх, хөтөлбөрийн

хөгжлийн циклийг баримтлах, ялангуяа хэрэгжилт дээр боловсруулалтаас илүү хүч анхаарлаа төвлөрүүлж, багш бүрд хүрч ажиллах шаардлагатай нь харагдаж байна


Боловсролын хүрээлэнгийн үзэж байгаагаар цаашид уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд цэцэрлэг, багш нарт тохиолдож буй бэрхшээлийг үнэлэх, улмаар агуулга, арга зүйн хувьд сайжруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчныг бэхжүүлэх, багш нарын дутагдаж буй ур чадварыг дэмжсэн мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах шаардлагатай байна гэж дүгнэжээ.

Хувилбарт сургалтын үйлчилгээнд хамрагдаж буй зорилтот бүлгийн хүүхдүүдэд зориулсан Явуулын багшийн сургалтын модуль (2005,) Бага насны хүүхдийг хөгжүүлэх хувилбарт сургалтын хөтөлбөр, (2009), Бага насны хүүхдийг хөгжүүлэх хувилбарт сургалтын хөтөлбөр (2010), СӨБ-ын Хувилбарт сургалтын хөтөлбөр (2011), Гэр бүлийн орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөр (2016) зэрэг олон хөтөлбөрүүд боловсруулан нүүдлийн бүлэг, явуулын багшийн сургалтуудад ашигласнаар багш, сургагчдын арга зүйг сайжруулах, сургалтын хөтөлбөрийн хөгжилд их дэмжлэг үзүүлжээ.

**Сургуулийн өмнөх боловсролын багш, мэргэжилтэн**


Хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар (Мянганы сорилын сангийн ТМБ-ын төсөл, 2010) “цэцэрлэгийн багш, сурган хүмүүжүүлэгч” мэргэжил хамгийн эрэлттэй байгаа мэргэжлийн жагсаалтад 23 дугаар байрт жагсаж байжээ. Энэ нь сүүлийн жилүүдэд хот суурин газрын хүн ам, түүний дотор СӨН-ны хүүхдийн тоо нэмэгдсэн, цэцэрлэгийн хүчин чадал, хамран сургалт өссөнөөр цэцэрлэгийн багшийн ажлын байрны хэрэгцээг ихэсгэж байгааг харуулна. Цэцэрлэгийн багшийн тоо 2006 оны үеэс 2 дахин өсөж 2018 оны байдлаар 7845-д хүрээд байна (Зураг 1.1.21).

Зураг 1.1.21. Цэцэрлэгийн багшийн тооны өсөлт (2006-2017)



2018 оны байдлаар СӨБ-ын салбарт нийт 27172 хүн ажиллаж байгаа бөгөөд тэдний 5% нь цэцэрлэгийн эрхлэгч, 2% нь арга зүйч, 28% нь багш, 26% нь туслах багш, 39% нь бусад ажилтнууд тус тус эзэлж байна. Нийт багш нарын 88% нь бүлгийн багш, 9% хөгжмийн багш, 1% хувилбарт сургалтын багш байна (Зураг 1.1.22).


Зураг 1.1.22. Цэцэрлэгт ажиллаж буй багш, мэргэжилтнүүдийн ажлын байр (2018)



Багшийг ажилласан жилээр нь авч үзвэл, 2018 оны байдлаар анхны жилдээ ажиллаж буй багш 18%, 1-5 дахь жилд 48%, 6-10 дахь жилд 15%, 11-15 дахь жилд 8%, 16-20 жилд 4%, 21-24 жилд 2% хувийг тус тус эзэлж байна. Үүнээс үзвэл нийт багшийн дийлэнх буюу 66% нь залуу буюу


эхний 5 жилдээ ажиллаж буй багш нар байна. Нийт багш нарын 77% бакалаврын, 8% дипломын, 7% магистрийн, 2% бүрэн дунд боловсролтой байна. (Зураг 1.1.23.)

Зураг 1.1.23. Цэцэрлэгийн багшийн ажилласан жил (2018)



2018 оны байдлаар улсын хэмжээнд мэргэжлийн зэрэгтэй нийт 1876 багш ажиллаж байгаагаас 82% нь заах аргач, 18% нь тэргүүлэх зэрэгтэй байгаа бол дөнгөж 4 багш зөвлөх зэрэгтэй байна. (Зураг 1.1.22)

Зураг 1.1.24. Мэргэжлийн зэргүүдэд харгалзах зэрэгтэй багш нарын эзлэх хувь (2018)



### Багшийн цалин хөлс, нийгмийн баталгаа

2018 оны байдлаар цэцэрлэгийн багш нар боловсролын салбарт ажиллагчдын нэгэн адил төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээний дагуу цалинжиж, сард 780280 төгрөгийн дундаж цалин хөлс авч байна. Мөн мэргэжлийн зэрэг, улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал, илүү цаг ажилласны зэрэг нэмэгдэн хөлс, нэмэгдлүүдийгсар бүр цалингийн 15-20 хүртэлх хувиар тооцож авч байна. 2008 онд батлагдсан Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу хөдөө орон нутагт ажиллаж байгаа багш 5 жил тутамд харин тэтгэвэрт гарахдаа нэг удаагийн тэтгэмж авдаг.

Доорх дүрэм журмууд нь багшийн хөдөлмөрийн харилцаан зохицуулах, цалин хөлсийг тооцох, нэмэгдэл цалин урамшууллыг тооцоход үндэслэл болгож буй эрх зүйн актуудын талаар энэхүү тайлангийн 2.3 бүлэгт тодорхой тайлбарласан болно.

Монголын цэцэрлэгийн багшийн долоо хоногт ажиллах ажлын дундаж цаг дэлхийн дунджаас бараг 10 орчим цагаар (UNESCO, 2007) илүү байна. Энэ нь манай улсад цэцэрлэгийн асаргаа, сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа бүтэн өдрөөр үргэлжлэн явагддаг, багш нар өдөр тутам ихэнхдээ 1-2 цаг улсаас тогтоосон хөдөлмөрийн цагаас илүү ажилладагтай холбоотой байна. Мөн энэхүү судалгаанаас үзвэл, ихэнх багш нар 35 болон түүнээс дээш тооноос хүүхэдтэй ангид ажиллаж байгаа нь үүнийг нотолж байна. Ихэнх орнуудад цэцэрлэгийн багш ажилд ороход эхлэн авч буй цалинг нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний дундаж хэмжээнээс доогуур тогтоодог ба ажиллах явцдаа ажилласан жил, туршлагаас хамаарч нэмэгддэг тогтолцоотой байна. Манай орны хувьд цэцэрлэгийн багшийн цалингийн хэмжээ төрийн үйлчилгээний байгууллагад ажилласан жилийг харгалзан тогтоодог ба жил ахих тусам цалин өсөх зүй тогтолтой байдаг. Харин цэцэрлэгийн багшийн дундаж цалинг (8.649.360 төг) нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээтэй (8.770.2 төг) жишиж үзвэл адил түвшинд байна. Энэ нь ЗГ-ын 2019

оны 24-р тогтоолоор багшийн цалин, хөлсийг 40 орчим хувиар нэмэгдүүлсэнтэй холбоотой. Хэдийгээр багш нарын цалин, хөлстөрийн бусад албан хаагчдын нэгэн адил аажмаар өсөж байгаа боловч цаашид амьжиргааны өртөг, мөнгөний инфляцын өсөлттэй уялдуулан шат дараатай нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

### Багшийн ажлын ачаалал

Цэцэрлэгийн багшийн ажлын ачааллыг дунд сургуулийн багштай харьцуулахад харьцангуй их бөгөөд энэ нь тэдний ажлын 8 цаг болон түүнээс дээш хугацаагаар ажилладаг, бага насны хүүхдийн аюулгүй байдлыг байнга харж хамгаалах үүрэг хүлээдэг зэргээс хамаардаг.

СӨБ-ын сургалтын талаар баримтлах бодлогод тусгасны дагуу цэцэрлэгийн үндсэн сургалтын нэг хичээлийн жилд үргэлжлэх хугацаа 34 долоо хоног байна. Нэгж хичээлийн үргэлжлэх хугацаа бага бүлэгт 15 минут, дунд бүлэгт 20 минут, ахлах бүлэгт 25 минут, бэлтгэл бүлэгт 30 минут байна. Багшийн заах хичээл болон хөгжүүлэх үйл ажиллагааны долоо хоног, жилийн сургалтын цаг нь доорх байдлаар тодорхойлогдсон байдаг.

Судалгаагаар хот, аймгийн төвийн цэцэрлэгийн багш нар өдөрт дунджаар 10 цаг, сумын төвийн багш 10,3 цаг тус тус ажилладагийг тогтоожээ. Багш нар ихэвчлэн хавар, намар илүү их ачаалалтай ажилладаг. Энэ улирлуудад хүүхэд өөрийгөө авч явах, бие даах хэвшил, дадал суралцахаас гадна хүүхдийн олон уралдаан тэмцээн явагддаг учраас ачаалал маш их болдог. Өвөл ачаалал харьцангуй буурдаг болохыг багш нар дурдаж байжээ. Мөн уг судалгааны дүгнэлтэд цэцэрлэгийн багшийн ажлын ачаалал нь бүлэг дүүргэлт, ажиллах орчин нөхцөл, техник хэрэгслийн хангамж зэргээс шалтгаалан хөдөө, хотод адилхан их байна.

Боловсролын хүрээлэнгээс 2011 онд явуулсан “Цэцэрлэгийн багш, ажилтны ажлын нөхцөл байдлын судалгаа”-ны асуулгад хариулсан багш, ажилтны тооноос харахад сургалтын баримт бичиг боловсруулах, хүүхдийн асаргаа үйлчилгээ, хяналт шалгалтад бэлтгэх хичээлд бэлтгэх заах үйл ажиллагаа эхний эрэмбэд жагссан байна. Харин хүүхэдтэй ганцаарчлан ажиллах, эцэг эхтэй ажиллах, өөрийгөө хөгжүүлэх ажлууд нэлээд доогуур орж байна ( Зураг 1.1.25). Эндээс үзвэл, сүүлийн жилүүдэд боловсролын салбарт хэрэгжсэн агуулга, арга зүйн шинэчлэл, сургалтын хөтөлбөр, бүлэг сэдэв, нэгж хичээлийн боловсруулахад багш нар их цаг зарцуулж байна. Мөн байгууллагын дотоод хяналт шалгалт, орон нутгийн боловсролын удирдах болон мэргэжлийн байгууллагуудын үнэлгээ, шалгалтын ажил ихэссэн, багшийн ажлын байрны чиг үүрэгт хамаарахгүй компани ажлууд орон нутагт их байдгийг харуулж байна. (Цэцэрлэгийн багш, мэргэжилтний нөхцөл байдлын судалгаа, 2011)

Зураг 1.1.25. Багшийн хамгийн их цаг зарцуулдаг ажил (Санал өгсөн багшийн тоогоор)




### Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо

Цэцэрлэгийн багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн болон захиалгат сургалтуудыг БМДИ, МУБИС-ийн СӨБ-ын сургууль, төрөлжсөн сургалтуудыг төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, зарим боловсролын судалгаа арга зүйн байгууллагууд, мэргэшсэн хувь хүн зэрэг олон байгууллага, иргэд зохион байгуулж байна.

Мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг үндэсний болон бүсчилсэн аймаг, орон нутаг, ажлын байран дээр гэсэн түвшинд зохион байгуулдаг. БСШУЯ-наас баталсан Багшийн мэргэжил дээшлүүлэх журамд заасны дагуу эхний 1, 5 болон 10 дахь жилдээ сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын зардлыг улсын төсвөөс гаргаж БМДИ зохион байгуулж байна. Багшийн ажлын байран дээрх болон төрөлжсөн мэргэшүүлэх сургалтуудад

хувийнболон төсөл хөтөлбөр, байгууллагын зардлаар хамрагддаг. 2018 онд 835 багш улс, бүс, орон нутгийн сургалтуудад мэргэжлээ дээшлүүлжээ. (Зураг 1.1.26)

Зураг 1.1.26. Багшийн мэргэжил дээшлүүлсэн байдал (2018)



Монголын цэцэрлэгийн 3 багш тутмын нэг нь жилд 24 цаг буюу нэг кредитээс доошгүй мэргэжил дээшлүүлэх сургалтад (Цэцэрлэгийн багш, мэргэжилтний нөхцөл байдлын судалгаа, 2011) хамрагддаг. Мэргэжил дээшлүүлэх сургалтын үйлчилгээнд хамрагдаж буй багш нарын ихэнх нь хот, төвлөрсөн газрын багш нар байна. Судалгаагаар Мэргэжил дээшлүүлж буй багш нарын 39% стандарт хөтөлбөрийн шинэчлэл, 28% хичээлийн арга зүйг хөгжүүлэх, 19% сургалтын хөтөлбөр боловсруулах, бусад нь идэвхтэй сургалтын арга зүй, үнэлгээ гэх зэрэг сэдэв чиглэлээр БШУЯ, Боловсролын хүрээлэн, МУБИС, орон нутгийн БСГ, бусад мэргэжлийн байгууллагын зохион байгуулсан сургалтуудад хамрагджээ.

БМДИ нь мэдээлэл, бүртгэл, сургалтын 10 гаруй систем ашигладаг бөгөөд эдгээр системд суурилсан МХТ-д суурилан багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааг тогтвортой зохион байгуулах техникийн орчин бүрдүүлсэн байна. Жишээлбэл, Онлайн сургалтаар мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг зохион байгуулж, 10 дахь жилдээ ажиллаж байгаа 37 багш, 5 дахь жилдээ ажиллаж буй 37 багш, эхний жилдээ ажиллаж буй 43 багшийн онлайн сургалтын виртуал анги үүсгэгдсэн байна (БМДИ, 2017).

Цэцэрлэгийн багш нар мэргэжил дээшлүүлэхэд тохиолддог түгээмэл бэрхшээлүүдээс нэрлэнэ үү? гэсэн асуултад өгсөн хариултыг нь хариулт өгсөн оролцогчдын тоогоор эрэмбэлж үзвэл ажлын ачаалал ихтэй, санхүүгийн эх үүсвэр байхгүй, ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэх боломжгүй, мэдээлэл хангалтгүй, орон нутгийн алслагдмал байдал гэж хамгийн олон оролцогч хариулжээ (Зураг 1.1.27).

Зураг 1.1.27. Багш мэргэжлээ дээшлүүлэхэд тохиолддог бэрхшээл (Хариулт өгсөн оролцогчдын тоогоор)



Багш нарын хэрэглэж буй ном, гарын авлагын 55% нь заах арга зүйн, 43% нь хөтөлбөр, зөвлөмжийн, үлдсэн 2% нь боловсрол судлалын чиглэлийн тухай ном байдаг байна. Мөн сургалтын арга зүй, сэтгэл судлал, судалгааны арга зүйн чиглэлийн ном дутагдалтай байдгаа бичсэн байна. Багш нар сургалтын хөтөлбөр, төлөвлөлтийн чиглэлийн гарын авлага номыг түлхүү ашигладаг ба түүнийгээ багш нарт ойлгомжтой, хүүхдэд заах арга барилыг түлхүү тусгасан, олдоц хүртээмжтэй холбоотой гэж тайлбарласан байна.

**Багш бэлтгэх тогтолцоо**

Одоогийн байдлаар төрийн өмчийн 5, төрийн бус өмчийн 17 их дээд сургууль СӨБ-ын багш мэргэжилтнийг бэлтгэж байна (Тогтвортой хөгжил-СӨБ үндэсний зөвлөгөөн, 2018). Манай орны цэцэрлэгийн багш мэргэжилтэн бэлтгэдэг ууган сургууль болох МУБИС-ийн СӨБ-ын сургуульд


өдөр, орой, эчнээ ангийн 1280 оюутан суралцаж байгаа бөгөөд жил тутам төгсөгчийн тоо ихсэж байна.

2006 оноос хойших хугацаанд МУБИС-ийн СӨБ-ын сургуульд суралцах оюутны тоо тогтмол нэмэгдсэн бөгөөд төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь 2009 онд 75% байсан бол өнөөдрийн байдлаар 93 хувьд хүрсэн байна. 2005 оноос хойш цэцэрлэгийн багш бэлтгэх, давтан бэлтгэх ажлыг сайжруулах ажлын хүрээнд УБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын коллеж хичээлийн байр, номын санд 350 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж засварласнаас гадна сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, шинэ хэрэгцээнд нийцүүлэн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдийг шинээр бий болгох, магадлан итгэмжлэх зэрэг олон ажлууд хийгджээ (ЗГ-ын 382 дугаар тогтоол, 2018). Гэвч СӨБ-ын багш мэргэжлээр элсэгчдийн чанар хангалтгүй, багш төгсөгчдийн чадвар харилцан адилгүй, сургалтын хөтөлбөр, суралцахуйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг дурдсан байна. Түүнчлэн цэцэрлэгийн туслах багшийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх шаталсан тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байгаа болохыг тайлангийн хэлэлцүүлгүүдийн үеэр цэцэрлэгийн удирдах ажилтан, мэргэжилтнүүд ярьж байлаа.

**Хувийн секторын оролцоо**

2018 оны байдлаар Монгол Улсад 538 хувийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж, тэдгээрт хамрагдаж байгаа хүүхдүүд СӨБ-ын нийт хамран сургалтын 17.6% эзэлж байна (Зураг 1.1.28). Хувийн цэцэрлэгт нийт 1591 багш, 1536 туслах багш хүүхдэд үйлчилж байна. Хувийн секторыг бэхжүүлэх талаар Мастер төлөвлөгөөнд тавьсан тоон зорилтыг 2 дахин давуулж хангасан бөгөөд улсын төсвөөс жил бүр хувийн цэцэрлэгүүдэд хамрагдаж буй хүүхдийн тоогоор хувьсах зардлыг (нийт хувьсах зардалд зарцуулж буй төсвийн 7.2%) санхүүжүүлж байгаа нь төрөөс туслалцаа үзүүлж буй том дэмжлэг, хувийн цэцэрлэгийн тоо болон хамран сургалт өсөх хүчин зүйл болсон юм.

Зураг 1.1.28. Хувийн өмчийн цэцэрлэг ба хамрагдсан хүүхдийн тоо (2005-2018)



Хувийн цэцэрлэгүүд гол төлөв хувь хүмүүс, аж ахуйн нэгжийн эзэмшилд байдаг. Гэхдээ бас ядуу өрхийн хүүхдүүдэд боловсролын үйлчилгээг хүргэх үүднээс зарим сайн дурын байгууллагууд нэлээд тооны хувийн цэцэрлэгийг санхүүжүүлэн ажиллуулж байна. Мөн Монгол Улсад албан хаагчдынхаа хүүхдүүдэд зориулсан цэцэрлэг ажиллуулдаг хэд хэдэн томоохон төрийн өмчийн аж ахуйн нэгж байдаг. Жишээ нь: “Монголын төмөр зам” корпораци гол төмөр замын өртөөнүүддээ 27 цэцэрлэг ажиллуулж байна. УБ хотын хувийн цэцэрлэгүүд сард дунджаар 80.000-350.000 төгрөгийн төлбөр эцэг эх, асран хамгаалагчдаас авдаг байна.

Хувийн өмчийн цэцэрлэгүүдийн үйлчилгээ чанарын хувьд төрийн өмчийн цэцэрлэгүүдээс багахан зөрүүтэй адил түвшинд байна. Харин эдгээр цэцэрлэгийн бүлэг дүүргэлт бага, хөгжлийг дэмжих сургалтын орчны үзүүлэлт зарим үзүүлэлтээр илүү байжээ (Дэлхийн банк, 2016). Гэхдээ төрийн бус өмчийн зарим цэцэрлэгүүдэд нийслэлийн Боловсролын газраас хийсэн хяналт үнэлгээгээр зарим цэцэрлэгүүд хүүхдийн хоол хүнсний хадгалалт, боловсруулалт, гадаад орчны тохижилт хүрэлцээ, багшийн мэргэжил дээшлүүлэлт, хүүхдийн эрүүл аюулгүй байдал хангалтгүй байгаа нь харагдсан байна (Нийслэлийн боловсролын газар, 2019).



### Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанарын үр дүн

Хүүхдийн цэцэрлэгийн үйлчилгээний нөхцөл байдал, явцын үр дүнд өөрийн бүтцийн байгууллагуудаар дамжуулан хяналт үнэлгээ хийх чиг үүргийг Улсын Мэргэжлийн хяналтын газар гүйцэтгэж байна. Улсын мэргэжлийн Хяналтын газраас үндэсний түвшинд батлагдсан хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг

- “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас”,
- “Цэцэрлэгийн эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг шалгах”,
- “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг шалгах”,
- “Хөдөлмөрийн харилцааг шалгах”,
- “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг шалгах”

хяналтын хуудаснуудаар тус тус шалгаж эрсдэлийг үнэлэн ажиллаж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажилладаг. Хяналт үнэлгээг СӨБ-ын бүх төрлийн байгууллагуудыг хамруулж тоон ба чанарын мэдээлэл цуглуулж эрсдэлийн үнэлгээний тайлан гаргах, цэцэрлэгүүдэд эрсдэлд суурилсан өөрийн үнэлгээг хийлгэх замаар тогтмол чанарын хяналт явуулах замаар хийж гүйцэтгэдэг байна.

БСШУЯ-аас жил тутам СӨБ-ын статистик мэдээллийг тайлангийн хугацаанд цэцэрлэг нэг бүрээс цуглуулж байна. Уг мэдээллийн ихэнх нь цэцэрлэгт хамрагдалт, СӨБ-ын үйлчилгээний төрөл хэлбэр, багш, хүүхэд гэсэн бүлэг үзүүлэлтүүдээр гаргадаг. Эдгээр мэдээлэлд үндэслэн СӨБ-ын төлөв байдлын талаарх мониторинг, үнэлгээг тогтмол явуулдаг. Мөн сүүлийн жилүүдэд Боловсролын салбарын мэдээлэл, удирдлагын систем байгуулж ажиллуулснаар дээрх мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийхэд ихээхэн дэвшил болжээ.

### СӨБ-ын үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн хөгжлийн үзүүлэлт, үр дүн

БСШУСЯ-ны харьяа Боловсролын үнэлгээний төвөөс СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөрөөр эзэмшсэн хүүхдийн мэдлэг, чадвар дадлын түвшинд гүйцэтгэлийн үнэлгээ хийдэг болсон. Тус үнэлгээний төвөөс боловсруулсан тест, аргачлалын дагуу цэцэрлэгийн багш нарын цуглуулсан мэдээлэлд тулгуурлан хүүхдийн хөгжлийн ай тус бүрд хамаарах чанарын мэдээллийг цуглуулж дүн шинжилгээ хийдэг нь цэцэрлэг, орон нутаг, үндэсний түвшинд сургалтын хөтөлбөрийн удирдлагыг боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой юм. Харин энэхүү үнэлгээгээр нэгж цэцэрлэгээс цуглуулж буй мэдээллийн найдвартай байдлыг сайжруулах хэрэгтэй болохыг тайлангийн хэлэлцүүлэгт оролцсон багш, арга зүйчид онцлон тэмдэглэж байлаа.

ЕБС 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжин орохын өмнө 2008 онд 6 настай хүүхдийн, 12 жилийн тогтолцоонд шилжин орсны дараа 2010 онд 5 настай хүүхдийн сургуульд бэлэн байдлыг үнэлэх судалгааг тус тус хийжээ. Энэхүү судалгаагаар хүүхдийн сургуульд бэлэн байдлын түвшин хүүхэд цэцэрлэгт хамрагдсан жил, эцэг эхийн боловсрол, орлого, хот, хөдөөгийн ялгаа зэрэг хүчин зүйлсээс хамааралтай болох нь тогтоогдсон юм (АХБ, 2010).

*Хүснэгт 1.1.10. Хүүхдийн сургуульд бэлэн байдлын үнэлгээний үр дүн (2010)*

Ай	Хүүхдүүдийн тест гүйцэтгэлийн хувь
Бие бялдар	70.1%
Суралцах хандлага	60.1%
Нийгэмшихүйн хөгжил	70.9%
Хэл ярианы хөгжил	64.25%
Танин мэдэхүйн хөгжил	58.8%

Цаашид цэцэрлэгт хамрагдаж буй бүх хүүхдийн сургуульд бэлэн байдлыг үнэлэх системийг үндэсний түвшинд бий болгох шаардлагатай байгаа бөгөөд ялангуяа мэдээллийн технологид тулгуурласан үнэлгээг явуулах, дүн шинжилгээ тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна.

2016 онд Дэлхийн Банкнаас СӨБ-ын чанарын талаар хийсэн судалгаагаар доорх үнэлгээний үр дүн гарсан байна.

Хүснэгт 1.1.11. Монгол Улсын цэцэрлэгүүдийг ЕСЕМI аргачлалаар үнэлсэн чанарын дэд хэмжүүрийн дундаж оноо (2015)

		Гэр		Улсын ердийн		Хувийн	
		Дундаж	СХ	Дундаж	СХ	Дундаж	СХ
Бүтцийн чанар	Орон зай ба тавилга	3.75	1.199	4.259	0.871	4.127	0.938
Явцын чанар	Харилцаа	4.74	0.63	4.548	0.778	4.642	0.669
	Сургалтын зохион байгуулалт	3.71	1.201	4.201	0.959	4.188	0.931
Бүтэц ба явцын чанар	Үйл ажиллагаа	2.798	0.988	4.171	0.871	3.918	0.929
	Бичиг үсэг	3.815	1.057	4.164	0.755	4.052	0.823
	Математик	3.118	1.126	3.633	0.99	3.506	1.008

Төрийн өмчийн цэцэрлэгүүд чанарын индексийн хувьд нэлээд сайн (4.1) гүйцэтгэлтэй гарсан бол харилцааны дэд хэмжүүрээр хамгийн өндөр (4.5) оноо, орон зай ба тавилга/тоноглол (4.3), сургалтын зохион байгуулалтаар (4.2) оноо тус тус авсан байна. Сургалтын үйл ажиллагаагаар 4.17 оноо авсан нь хэл яриа, бичиг үсгийн орчны 4.16 оноотой дөхүү байна. Харин математикийн орчны хэмжигдэхүүн дээр хамгийн бага оноо авчээ (3.63)


Эндээс үзвэл, хөдөө орон нутгийн цэцэрлэгүүд чанарын бүх үзүүлэлтээр хоцорч байна. Нөгөө талаар, СӨН-ны хүүхдийн хөгжлийн ялгаа хот, хөдөөгөөр ялгаатай байна. Хүүхдийн математикийн мэдлэг чадварын түвшин хамгийн доогуур үзүүлэлттэй байна.

### 1.1.3.3. Инклюзив ба үл алагчлах байдал

#### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

2018 оны байдлаар СӨБ-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд нийт хүүхдийн 0,6 хувийг эзэлж байгаа ба хараа, сонсгол, тулгуур эрхтэн, хэл яриа, оюун ухаан, хавсарсан хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байна. Төрийн өмчийн 2 тусгай цэцэрлэг болон нийслэлийн хэмжээнд ажиллаж байна. Ердийн цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамтатган сургах тухай заалтууд 2008 онд батлагдсан СӨБ-ын тухай хууль, 2016 онд уг хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль зэрэг хууль тогтоомжуудад оруулсан юм. Тухайлбал: ердийн цэцэрлэгийн анги бүлэгт 2 хүртэлх хүүхдийг сургах, шаардлагатай багш мэргэжилтнүүдийг нэмэлтээр ажиллуулж болох тухай заалтуудыг (ЗГ, 2008) дурдаж болно. БСШУЯ-ны статистик мэдээллээр одоогоор сургуулийн өмнөх насны 6000 гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байдаг гэсэн мэдээтэй байна. Өнөөдөр тэднээс 1597 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа ба хэл яриа, бие эрхтэн, оюун ухаан, сонсгол зэрэг бэрхшээлтэй хүүхдүүд зонхилж байгаа (Зураг 1.1.30) бөгөөд тэдний нийт тоо 2005 оноос хойших хугацаанд 40 гаруй хувиар өссөн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах зорилгоор БСШУЯ-наас 2003-2007 онд “Тэгш хамруулах боловсрол” хөтөлбөр хэрэгжүүлсэн ба Дэлхийн зөн, ХИС, НҮБ-ын ХС, Шведийн хөгжлийн агентлаг зэрэг олон улсын байгууллагууд олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлж цэцэрлэгийн багш ажилчдыг энэ талаар мэргэшүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, мэдээллээр хангах, эцэг эхийн төрөлжсөн холбоо байгуулах олон талын үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд тэдгээр хүүхдүүдэд хандах боловсролын байгууллага, олон нийтийн хандлага сайжирсан бөгөөд эрх зүйн орчныг нэлээд бэхжүүлсэн юм. Гэхдээ л энэ чиглэлээр гарсан хуулийн заалтуудыг амьдралд хэрэгжүүлэх, шаардлагатай багшийн ур чадвар, тоног төхөөрөмжийн хангалт, эрт илрүүлэлт, нөхөн сэргээх үйлчилгээг тус тус сайжруулах хэрэгцээ байсаар байна.

Зураг 1.1.29. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо (2005-2018) ба тэдний хөгжлийн бэрхшээлийн төрлүүд




Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үйлчилж буй төрийн хувийн хэвшлийн цэцэрлэгүүдэд сургалтын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, сэргээн засах эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, багшийн нэмэгдэл хөлс дутагдалтай талаар дурджээ (ЯХИС, 2018).

**Малчин өрхийн хүүхэд**

Монгол Улсын 341 сумын 80 хувь нь аймгийнхаа төвөөс 100 км-ээс дээш, малчин өрх айлууд сумын төвөөс дунджаар 10-55 км алслагдсан байдаг нь бага насны хүүхдэд үзүүлэх боловсрол, нийгмийн үйлчилгээг үзүүлэхэд өндөр өртөг зардал, уян хатан арга, хэлбэрийг шаарддаг. Нийт хүн амын өрхийн 19,1 хувийг малчин айл өрх (169705) эзэлж байна. Энэхүү хөдөөгийн хүн амын бүлэгт багтаж буй малчин өрхийн хүүхдүүд СӨБ-ын үйлчилгээнд сумын төвийн цэцэрлэг, явуулын болон гэр цэцэрлэг гэх мэт хэлбэрүүдэд зарим нь хамрагдаж байна. Тухайлбал, СӨБ-д хамрагдсан нийт хүүхдийн 11.5 хувийг малчдын хүүхэд (30960) эзэлж байгаа ба хувилбарт сургалтад хамрагдаж байгаа хүүхдийн 69% нь нүүдлийн бүлэг буюу гэр цэцэрлэгт, 12% явуулын багшийн сургалтад тус тус хамрагдаж байна. Эдгээр хүүхдийн 80% нь 3-5 насны хүүхдүүд байна. Малчдын хүүхдийн хамрагдалтыг оноор авч үзвэл 2006-аас 2015 он хүртэлх хугацаанд 44 хувиар өссөн бол 2018 он хүртэлх хугацаанд 9 орчим хувиар буурчээ (Зураг 1.1.30). 2006 оноос хойш хугацаанд ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан сумдад шинээр цэцэрлэг барих, хувилбарт сургалтын гэр цэцэрлэгийн үйлчилгээний хэлбэрийг дэмжих зорилтуудыг хэрэгжүүлсэн нь тус хугацаан дахьдээрх өсөлтийг бий болгожээ. Тус хугацаанд эдгээр зорилтыг хангахад чиглэсэн олон төсөл АХБ, ДБ, НҮБ ХС-аас хэрэгжүүлсэн ба 300 гаруй иж бүрэн гэр цэцэрлэг хөдөөгийн сумдад нийлүүлсэн юм. Мөн ЯХИС-аас 4 аймгийн алслагдсан 30 сумдад малчин өрхийн 8500 хүүхдэд гэр бүлд суурилсан сургуульд бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлснээр эдгээр хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал дээшилсэн мэдээтэй байна.

Зураг 1.1.30. Малчдын хүүхдийн тоо (2005/06-2017/18 оны хичээлийн жил)



Гэхдээ хот, хөдөөгийн цэцэрлэгийн хамрагдалт ялгаатай байгаа ба сум багийн түвшинд СӨН-ны хүүхдийн СӨБ-ын хамрагдалтын хувь хот суурин газрынхаас доогуур үзүүлэлттэй байна. Дэлхийн Банкнаас хийсэн судалгаагаар хөдөөд хүүхдүүдийн дөнгөж 46 хувь (Дэлхийн банк, 2016) нь СӨБ-д хамрагдаж байна гэж үзжээ. Түүнчлэн багийн түвшинд амьдарч байгаа хүүхдүүдэд зуны улиралд гэр цэцэрлэг, явуулын багшийн үйлчилгээг хүргэж байгаа боловч энэ нь хүүхдийг сургуульд бэлтгэхэд хангалттай үйлчилгээ болж чадахгүй байгаа юм. Тухайлбал дээрх судалгаагаар хөдөө орон нутгийн хувилбарт сургалтад хамрагдаж буй хүүхдүүдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, хөгжлийн үр дүн ердийн цэцэрлэгийн хүүхдүүдээс зарим үзүүлэлтээр хоцорч байна гэжээ. Энэ бүгдээс үзэхэд хөдөө орон нутагт амьдарч буй малчин өрхийн хүүхдүүдэд үзүүлэх цэцэрлэг болон хувилбарт сургалтын үйлчилгээг бүх талаар сайжруулах шаардлагатай байна.


**Шилжин суурьшсан өрхийн хүүхдүүд**

Мөн хүн амын шилжилт хөдөлгөөний судалгаануудаас үзвэл, Улаанбаатар, Дархан, Эрдэнэт зэрэг төв суурин газруудад хүн ам олноор шилжин суурьшиж байна. Шилжилт хөдөлгөөнд оролцсон 10 хүн тутмын нэг нь Улаанбаатар хот болон төвийн бүс нутагт шилжин суурьшсан, Улаанбаатарт суурьшсан иргэний 3 хүний нэг нь шилжин ирсэн хүн байна. Тухайлбал, Улаанбаатар хотын хүн ам жилд дунджаар 6 хувиар өссөн нь улсын дундаж өсөлт болох 1.83 хувиас даруй 3.3 дахин өндөр байгаа юм. Нийслэлийн хүн амын өсөлтийн 56 хувийг орон нутгаас шилжин ирсэн хүн амын шилжилт хөдөлгөөн эзэлж, нэг хавтгай дөрвөлжин км газар нутагт ногдох хүн амын нягтрал 286 байгаа нь улсын дунджаас 150 дахин өндөр үзүүлэлт юм. Хотын захын хорооллын хүн амын гуравны нэг нь шинээр суурьшин иргэд байгаа бөгөөд тэдний 40 хувь нь нийгмийн эмзэг бүлэгт

багтдаг тул тусламж дэмжлэг хэрэгтэй хүн амын тоонд орж байна (“Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа”, 2018).


Дээрх шилжин суурьшсан хүн амын өрхийн хувьд хүүхдээ сургууль, цэцэрлэгт хамруулах хэрэгцээ өндөр байдаг. Улаанбаатар хотын хувьд СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин 2006 оны мөн үеэс 29 хувиар ахиж, 78,2 хувьд хүрээд байна (Зураг 1.1.31). Энэ нь сүүлийн 10 жилд хүүхдийн цэцэрлэг шинээр барих, засварлах чиглэлээр хөрөнгө оруулалтийг арга хэмжээний үр дүн юм.

Зураг 1.1.31. УБ хотын СӨБ-ын хамран сургалтын цэвэр жин (2006-2017)



Гэхдээ нийслэлд СӨБ-ын хамран сургалт нэмэгдэж байгаа ч, Улаанбаатар хотын хамран сургалт аймгийн болон сумын төвүүдийн үзүүлэлтээс 10 пунктээр доогуур, сургуулийн өмнөх насны хүүхдийн 21,8 хувь нь цэцэрлэгт хамрагдаагүй байна. Мөн хүн амын шилжилт хөдөлгөөнөөс үүдсэн ачаалал цэцэрлэгүүдэд өндөр байгаа нь тэдний бүлэг дүүргэлт улсын дунджаас 10-20 хүүхдээр илүү, нийслэлд төрийн өмчийн цэцэрлэггүй хороо 26 байгаа мэдээллээс харж болно (Зураг 1.1.32).

Зураг 1.1.32. Цэцэрлэгийн бүлэг дүүргэлт (аймаг, дүүргээр)



Эх сурвалж: СӨБ-Тогтвортой хөгжил чуулганы танилцуулга (2018)

**Үндэсний цөөнхийн хүүхэд**

Казах хүүхдийн тоо 0-14 насны нийт хүүхдийн 5% эзэлж байна. Баян Өлгий аймгийн СӨБ-ын хамран сургалт (60,7%) улсын дунджаас (79.8%) доогуур үзүүлэлттэй байна. Үндэсний цөөнх болох казах өрхүүдийн хүүхдийн СӨБ-д хамрагдах нь бусад аймагаас харьцангуй бага буюу 19 пунктээр доогуур байна.

Баян-Өлгий аймагт нийт казах үндэстний 90% оршин суудаг ба ядуурлын хувь хэмжээ 46% ба энэ нь улсын дунджаас (29%) дээгүүр байна. Тус аймагт сургууль завсардалт улсын дунджаас 3 дахин дээгүүр үзүүлэлттэй ба 3 хүүхдийн 1 нь цэцэрлэгт бүрэн хамрагдаж чадахгүй байна.


Казах хэл дээрх СӨБ-ын хичээл сургалтын ном, материалууд хангалтгүй байдаг ба энэ нь монгол хэл тэдгээр хүүхдүүдэд хоёрдогч хэл болохынхоо хувьд сургуульд элсэн орох хэл яриа, хөгжлийн чадвар монгол хүүхдүүдээс хоцрох шалтгаан болдог байна.

## Ядуу өрхийн хүүхдүүд

Хүн амын ядуурал, амьжиргааны түвшний судалгаанаас үзэхэд ядуурал тогтвортой буурахгүй байгаа ба ялангуяа шилжилт хөдөлгөөнд хамрагдагчид, хот суурин газрын захын хорооллын айл өрх, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хүүхдүүд ядууралд илүү нэрвэгдэж байгаа мэдээтэй байна. Тухайлбал, 2016 оны хүн амын ядуурлын судалгаагаар Улаанбаатар хотод ядуурлын түвшин 24,8% байгаа ба нийт хүн амын 1/3 нь шилжин ирсэн, шилжин ирэгчдийн амьдрал уугуул оршин суугчдынхаас илүү ядуу байгаа нь судалгаагаар тогтоогджээ. Үүнээс үзвэл, цэцэрлэгийн хамрагдалтад сөргөөр нөлөөлж байгаа нэг хүчин зүйл нь ядуурал хэвээрээ байна.

СӨБ олгоход зарцуулж байгаа улсын зардлыг ядуу бус бүлгийн хүн ам ядуу хүн амаас харьцангуй илүү хүртэж байна. Доорх зургаас үзвэл, дундаж буюу дунджаас дээгүүр орлоготой өрхийн хүүхдүүд СӨБ-д илүү хамрагдаж байна.

Зураг 1.1.33. Өрхийн аж байдлын үзүүлэлт ба СӨБ-ын хамран сургалт (2017)



Эх сурвалж: НҮБХС илтгэл 2017

Мөн СӨБ-ын ядуу өрхийн хүүхдүүдэд чиглэсэн хувилбарт сургалтад зарцуулж буй нэг хүүхдэд ноогдох хувьсах зардал цэцэрлэгт явж буй ердийн хүүхдийн зардлаас 50 хувь доогуур байна. Ядуу өрхийн хүүхэд цэцэрлэгт явахад ариун цэвэр, хичээлийн хэрэгсэл, хувцас, унааны зардал нь тэдний боловсрол эзэмшихэд хязгаарлах хүчин зүйлийн нэг болж байна.

### 1.1.4 Дүгнэлт, Зөвлөмж

#### Дүгнэлт

#### Бодлого, эрх зүйн талаар

1990 оноос Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засаг руу шилжих үйл явц эхэлсэн бөгөөд 1991 оноос хойш нэг хүнд ногдох ҮНБ-ийн хэмжээ 1,600 америк доллараас 463 америк доллар болтол буурч, нийт хүн амын дунд эзлэх ядуу хүн амын эзлэх жин 36%-д хүрч, улмаар энэ нь нийгмийн салбарууд болох боловсролын салбарт сөргөөр нөлөөлсөн. 1990-1992 онуудад боловсролд зарцуулах зардал 56% буурчээ. Үүнээс улбаалан СӨБ-ын салбарын тогтолцоонд 1990-ээд оны эхээр тодорхой хүндрэл бэрхшээлүүд учирч эхэлсэн. Тухайлбал, 1990 онтой харьцуулбал, цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоо 37.4% хувиар буурч, 1992 оноос эхлэн хүүхдийн хоолны мөнгөний 50%-ийг эцэг, эхчүүд нь төлж эхэлснээр ядуу хүн амын бүлгийн эцэг эхчүүд хүүхдээ цэцэрлэгт явуулж чадахгүй болсон. Мөн СӨБ-д хуваарилах улсын төсвийн санхүүжилт буурснаар хөдөөгийн цэцэрлэгүүдийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан болно.

Дээрх хүндрэлүүдийг даван туулахын тулд Монгол Улсын УИХ, ЗГ, БСШУЯ-наас тухайн цаг үеийнхээ сорилт, бэрхшээлийг даван туулах зорилготой тодорхой бодлого, зорилтууд дэвшүүлсэн бөгөөд эдгээр бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 1995 оноос эхлэн үндэсний чанартай төсөл хөтөлбөрүүдийг олон улсын байгууллага, хандивлагч орнуудаас санхүүжүүлэн хэрэгжүүлж иржээ.

Өнгөрсөн хориод жилийн хугацаанд СӨБ-ын салбарт хэрэгжсэн бодлого зорилтуудыг дүгнэж үзэхэд үндсэн 3 үе шатыг туулсан байдаг (Хүснэгт 1.1.12). Эхний үе шат буюу 1993-2000 онд шилжилтийн үеийн хүндрэлийг даван туулах зорилгоор СӨБ-ын салбарт тохиолдсон хүндрэлийг арилгах, системийг дэмжих бодлого хэрэгжүүлсэн бол 2000-2008 онд СӨБ-ын хүртээмжийг дээшлүүлэх, тогтворжуулахад чиглэсэн стратеги хэрэгжжээ. Харин 2006-2015 онуудад нэгэнт улс орны төсвийн санхүүжилтийн бололцоо сайжирсан тул СӨБ-ын хүртээмжийн хүрсэн үр дүнг хадгалах, нэмэгдүүлэх улмаар үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн стратегиуд хэрэгжиж байжээ. Тухайн үед дэвшүүлж байсан бодлогыг олон улсын байгууллагууд, хандивлагчид дэмжиж байсан байна.

Хүснэгт 1.1.12. Төрөөс СӨБ-ын талаар авч хэрэгжүүлсэн бодлогын үе шатууд

Он	Үндэсний хөгжлийн баримт бичгүүд	СӨБ-ын салбарт хэрэгжүүлсэн ЗГ-ын хөтөлбөрүүд	Эдгээр хөтөлбөрийг дэмжиж ОУБ, хандивлагч орнуудтай хамтран хэрэгжүүлсэн гол төслүүд
1993-2000	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын ЗГ-ын мөрийн хөтөлбөрүүд</li> <li>Боловсролын тухай хууль (1995)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Сургуулийн өмнөх боловсрол үндэсний хөтөлбөр-1 (1995-2000)</li> <li>Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (1997-2001)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>“СӨБ-ыг бэхжүүлэх нь” үндэсний төсөл (1997-2000), ЯБҮХ,</li> </ul>
2000-2008	<ul style="list-style-type: none"> <li>Эдийн засгийн өсөлтийг дэмжиж ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг (2003)</li> <li>МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (2007)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Сургуулийн өмнөх боловсрол үндэсний хөтөлбөр-2 (2001-2007)</li> <li>Боловсролын салбарыг 2000-2005 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө (1999)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>СӨБҮХ дэмжих хөтөлбөр (Английн Хүүхдийг ивээх сан, 2000-2004)</li> <li>“Суурь боловсрол” төсөл (АХИС, Европын холбоо, 2006-2009)</li> <li>Үр дүнд түргэн хүрэх санаачилга төсөл (2007-2009) Дэлхийн банк</li> </ul>
2006-2015	<ul style="list-style-type: none"> <li>Мянганы хөгжлийн үндэсний зорилтууд, (2006)</li> <li>СӨБ-ын тухай хууль (2008)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө (2006)</li> <li>Боловсролын салбарт хийх чанарын шинэчлэл ЗГ хөтөлбөр (2012)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Үр дүнд түргэн хүрэх санаачилга төсөл, (Дэлхийн Банк, 2009-2011)</li> <li>“Бага насны хүүхдийн хөгжил төсөл, НҮБ-ын ХС</li> <li>Хөдөөгийн нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд СӨБ олгох төсөл (АХБ, 2009-2013 2.8 сая ам.доллар)</li> <li>“Сургуулийн өмнөх боловсрол” төсөл (Дэлхийн Банк 2009-2014)</li> </ul>

Нэгдүгээр үе шатанд СӨБ-ын хүртээмжийг дээшлүүлэх, хүндрэлийг арилгахад чиглэсэн “Сургуулийн өмнөх боловсрол үндэсний хөтөлбөр-1”-ийг БСШУЯ 1995 онд боловсруулж ЗГ-аар батлуулан хэрэгжүүлсэн бөгөөд цэцэрлэгт хамрагдсан хүүхдийн тоог 80% хүртэл өсгөх, үүний тулд СӨБ-ыг дэмжихэд чиглэсэн төрийн өмчийн цэцэрлэг, олон нийтийн үүсгэл санаачлалыг дэмжих зорилготой стратегийг баримталсан байсан (АХИС, 2001). 1997-2001 онд СӨБ-д хамрагдах хүүхдийн тоо 41% хүртэл өссөн нь (АХИС, 2001) энэ үед хэрэгжүүлсэн бодлого эерэг үр дүнгээ өгснийг харуулж байна. Энэ хөтөлбөрийг дэмжих зорилгоор БСШУЯ, ЯБҮХ хамтран НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилтээр 1997-2000 онд 1 сая америк долларын өртөгтэй “Сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх нь” төслийг бүх аймаг, дүүргийг хамруулан хэрэгжүүлжээ. Үүний үр дүнд (СӨБ-ын нөхцөл байдлын үнэлгээний тайлан, 2005) 16,108 хүүхэд шинээр СӨБ үйлчилгээнд хамрагдсан, 356 цэцэрлэг сургалтын хэрэглэгдэхүүнээр хангасан, 24 гэр цэцэрлэг байгуулж, 126 цэцэрлэг мал аж ахуйтай болсон, 139 цэцэрлэгт барилгын их засвар хийгдсэн зэрэг үр дүнд хүрчээ. Энэ үед хэрэгжиж байсан төслүүдийг орон нутаг, яамдын түвшинд Бодлогын зөвлөл байгуулах замаар удирдан зохицуулж нэгдсэн удирдлага үнэлгээний механизм хэрэглэж байсан нь сайнаар нөлөөлж байсан байдаг.

Хоёрдугаар үе шатанд 2001-2007 онуудад “Ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих үндэсний хөтөлбөр” (2001) (УИХ, “Ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих үндэсний хөтөлбөр”, 2001), “Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Мянганы хөгжлийн үндэсний зорилт” (УИХ, 2008) “Сургуулийн өмнөх боловсрол-2” (2001) зэрэг гол бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлсэн. Эдгээр баримт бичгүүдэд СӨН-ны хүүхдийн асуудлыг хүний хөгжил, нийгэм эдийн засгийн болон боловсролын дотоод зорилтуудтай уялдуулахыг чармайж, СӨБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах зорилтуудыг дэвшүүлсэн байдаг. Ялангуяа боловсролын үйлчилгээ хүрч чадахгүй байгаа хүн амын бүлгийн СӨН-ны хүүхдүүдэд хүрч ажиллах түүнд нийцсэн арга хэлбэрийг үүсгэн хөгжүүлэх, цэцэрлэгийн материаллаг орчин, барилгын хүчин чадал хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх асуудлууд тусгагджээ. Энэ үед ядуу эмзэг бүлгийн хүүхдийн цэцэрлэгт хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, хоол тэжээлийн хөтөлбөр, сургалтын таатай орчин бүрдүүлэх, багшийн сургалт зэрэг чиглэлээр Европын Холбооны санхүүжилтээр Английн ХИС-аас хэрэгжүүлсэн “Суурь боловсрол” төсөл 1,3 сая евро, Дэлхийн Зөн ОУБ 3,675,320, Соросын сан 754,582 ам.долларыг тус тус зарцуулсан төслүүд хэрэгжсэн байна (СӨБ-ын нөхцөл байдлын үнэлгээний тайлан, 2005).

*Дараах үе шатанд* 2006-2015 оны хооронд УИХ-аас СӨБ-ын тухай хууль (2008), ЗГ-аас 2006 онд Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг тус тус батлан мөрдүүлсэн. Энэ үе шатанд хэрэгжүүлсэн бодлого нь төрөөс зарцуулах санхүүжилт өсөхийн хэрээр огцом нэмэгдсэн цэцэрлэгийн хамрагдалтын өсөлтийг хангах зорилготой цэцэрлэгийн барилга барих, өргөтгөх, засварлах замаар хүчин чадлыг нэмэгдүүлэх, сургалтын агуулга, арга зүй, багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, хамрагдалтын тэгш бус байдлыг бууруулах, хөдөөд малчдын хүүхдэд зориулсан гэр цэцэрлэгүүдийг байгуулж шаардагдах төсөв хэрэглэгдэхүүнээр хангах, асуудлуудад анхаарсан байна. Тухайлбал, хувилбарт сургалтын үйлчилгээг дэмжихийн тулд (FTI) буюу “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” төсөл (2007-2009) малчдын хүүхдүүдэд зориулсан 311,000 ам.долларын төсөвт өртөгтэй нүүдлийн зуны гэр цэцэрлэгүүдийн гэр, тоног төхөөрөмж, бусад хэрэглэгдэхүүн, АХБ-ны “Хөдөөгийн нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох төсөл”-өөс 136 иж бүрэн гэр цэцэрлэгийг 4 аймаг, 2 дүүрэгт байгуулж түүнд түшиглэсэн сургалт, хоол хүнсний үйлчилгээг ердийн цэцэрлэгийн адил хичээлийн жилийн турш ажиллуулсан зэргийг дурдаж болно. Дээрх бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд СӨБ-ын хамран сургалтыг хязгаарлаж байсан хүчин зүйлийг бууруулж чадсанаар СӨБ-ын хамран сургалт анх удаа 60%-иас давсан юм. Цаашид Монгол Улсын Тогтвортой хөгжлийн хөтөлбөрт СӨБ-ын талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, энэ чиглэлд Боловсролын салбар болон нийгмийн салбаруудын хүчин чармайлтыг нэгтгэсэн бодлого стратегийг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

### **Хэрэгжилт, үр дүнгийн талаар**

#### *Санхүүжилт*

СӨБ-ын төсвийн хүүхдэд шууд үзүүлж буй үйлчилгээний зардал буюу хувьсах зардал, хоолны зардлыг бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалан нэмэгдүүлэх, ялангуяа хичээл, практикийн зардлыг хүүхдийн хөгжлийн үзүүлэлттэй уялдуулан өсгөх зарчимд шилжих хэрэгтэй болжээ. Мөн СӨБ-ын хуульд тусгасан “хүүхдийн хоолны зардлаас эцэг эх, асран хамгаалагчтай хуваалцах” заалтыг (УИХ, 2008) гэр бүлийн орлоготой уялдуулан шат дараатай хэрэгжүүлэх хэрэгтэй.

#### *Хүртээмж*

2005 оноос хойших хугацаанд бий болсон СӨБ-ын хүртээмжийн өсөлт нь чамлахааргүй амжилтыг бий болгожээ. Цаашид ойрын жилүүдэд хамран сургалтын өсөлт жилд 2%-иас илүүгүй байх магадлалтай байна. Харин СӨБ-ын хүртээмжийн өсөлт нь бусад төвлөрсөн суурин газрын төрийн өмчийн цэцэрлэгүүдийн бүлэг дүүргэлтийг (УБ хот 44.3) хэт ихэсгэж, хүүхдийн эрүүл мэнд, асаргаа, хамгаалал, аюулгүй байдалд үүсэх эрсдэлийг нэмэгдүүлсэн, багшийн ажлын ачааллыг ихэсгэсэн зэрэг үйлчилгээний чанарт сөрөг нөлөөллийг дагуулсан. Иймээс хот суурин газрын цэцэрлэгүүдийн бүлэг дүүргэлтийг хүн амын нягтрал, хамран сургалтын доогуур үзүүлэлттэй газруудад цэцэрлэг шинээр барих, хуучин цэцэрлэгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн тооны өсөлт, ачааллыг тэнцүүлж бууруулах (33.4 хүртэл) хэрэгтэй байна.

#### *Чанар, нийц*

Бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг шинэчлэн мөрдүүлэх, түүнд нийцсэн СӨБ-ын чанарынүнэлгээний нэгдмэл хяналт, үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх, төрийн болон хувийн хэвшил, хот, хөдөөний цэцэрлэгүүдээс үзүүлж буй СӨБ-ын үйлчилгээний чанарын ялгааг бууруулах улмаар энэ зорилгод нийцсэн СӨБ-ын хөрөнгө оруулалт, багш, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагатай болжээ.

#### *Тэгш байдал*

СӨБ-ын хамрагдалт доогуур байгаа бүлэгт хөгжлийн бэрхшээлтэй, малчин болон шилжин суурьшсан ядуу өрхийн хүүхдүүд багтаж байна. Хэдийгээр хот суурин газруудад сүүлийн 10 жилд цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах хүчин чадал нэмэгдсэн, СӨБ-д төрөөс үзүүлэх санхүүжилт нэмэгдсэн зэргээс шалтгаалж дээрх бүлгийн хүүхдүүдийн СӨБ-д хамрагдалт нэмэгджээ. Гэвч Улаанбаатар хот болон төвлөрсөн суурин газрын шилжин суурьшсан хүн ам ихтэй захын хорооллуудад цэцэрлэгийн хүүхэд хүлээн авах хүчин чадал хүрэлцээгүй, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэгт хүлээн авах бололцоо хязгаарлагдмал, ядуу өрхийн хүүхдэд цэцэрлэгт явах унаа тээвэр, ариун цэвэр, хичээлийн хэрэглэл, хувцасны зардлууд нэмэлт бэрхшээл учруулдаг зэрэг шалтгаанаар тэдгээр хүүхдүүдийг СӨБ-д хамруулах хэрэгцээ байсаар байна. Мөн цэцэрлэг болон хувилбарт сургалтын үйлчилгээнд хамрагдаж буй малчин өрхийн хүүхдүүдийн

тоо буурч байгаа тул тэдгээр хүүхдүүдэд үзүүлэх СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээний арга хэлбэрийг сайжруулах шаардлагатай байна.

### Өнөөгийн тулгамдсан хэрэгцээ, хэрэгжүүлэх зорилтууд

Бага насны хүүхдийн хөгжил, хамгаалал, боловсролын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, чанарыг дээшлүүлэх талаар сүүлийн 20 жилд Монгол Улсын төрөөс бодлогын зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж чамлахааргүй үр дүнд хүрснийг дээрх үнэлгээний үр дүн харуулж байна. Ялангуяа, энэ чиглэлээр үзүүлсэн төсвийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, бодлого, эрхзүйн дэмжлэг бүс нутгийн орнууд дундаа туршлага болохуйц сургамж үлдээгээд байна. Гэхдээ урт болон дунд хугацаанд СӨБ-ын хүртээмж, чанарыг сайжруулах дараах *тулгамдсан хэрэгцээ, шаардлагууд* байх болно.

1. Хүн амын эрчимтэй өсөлт, хот суурин газрыг чиглэсэн шилжилт хөдөлгөөн, бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн хүүхдээ цэцэрлэгт хамруулах өсөн нэмэгдэж байгаа нийгмийн хэрэгцээ нь одоо байгаа цэцэрлэгийн суудлын тоог ойрын жилүүдэд ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм. Тухайлбал нийт ашиглаж байгаа цэцэрлэгийн хүчин чадлаас 1,6 дахин илүү хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байна. Эдгээр хүүхдийн дийлэнх хэсэг нь төвлөрсөн суурин газар, Улаанбаатар хотод төвлөрч байна.
2. СӨН-ны нийт хүүхдийн (2-5 насны) хамран сургалтыг авч үзвэл, 20,2% нь СӨБ-ын үйлчилгээний ямар нэг хэлбэрт хамрагдаж чадахгүй орхигдож байна. Эдгээр хүүхдүүдэд хөдөөгийн малчин өрхийн хүүхдүүд, суурин газрын захын хорооллын хүүхдүүд, ядуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ихэнх хувийг эзэлж байгаа ба тэдэнд нийцсэн үйлчилгээний хэлбэр арга зүйг боловсронгуй болгох шаардлагатай.
3. 0-2 насны хүүхдийн асаргаа, хамгаалал, эрүүл мэндийн баталгаатай, чанартай үйлчилгээг гэр бүлийн оролцоо, хувийн хэвшлийн оролцоон дээр тулгуурлан нийгэмд бий болгох хэрэгцээ байсаар байна.
4. СӨБ-ын хувилбарт сургалтын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдүүдэд үзүүлдэг үйлчилгээний чанарыг сайжруулах нэн ялангуяа зонхилох хэлбэр болох “гэр цэцэрлэг”-ийн ажиллах хугацааг 6 сар хүртэлх хугацаагаар нэмэгдүүлэх, үүнд шаардагдах төсвийг жил бүрийн төсөвт тусгаж байх шаардлага байна.
5. СӨБ-ын хамран сургалтын өсөлтөөс үүдэн 2020 он хүртэлх бодит хэрэгцээг харгалзаж үзвэл, наад зах нь 556 цэцэрлэгийн багш шаардлагатай байгаа тул багш бэлтгэх сургуулиар мэргэжлийн багшийг төлөвлөгөөтэй бэлтгэх хэрэгтэй.
6. Цэцэрлэгийн багшийн мэргэжил дээшлүүлэх үйл явцад дүн шинжилгээ хийж, дунд хугацаанд багш нарын мэргэжил дээшлүүлэхэд баримтлах стратеги боловсруулж, түүнд нийцсэн бие даасан болон төрөлжсөн сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлэх, үүндээ мэдээлэл харилцааны технологид тулгуурласан сургалтын хэлбэрүүдийг өргөнөөр ашиглах шаардлагатай.
7. Багшийн хөгжлийн тухай хуулийн дагуу цэцэрлэг тус бүрийн төсөвт багшийн мэргэжил дээшлүүлэх зардлыг жил бүр тусгаж байх, түүнчлэн мэргэжил дээшлүүлэх ажилтай холбогдон гарах унаа, томилот, ном гарын авлагын гэх мэт зардлыг тооцож санхүүжүүлж байх. Олон улсын үнэлгээний тайланд (UNESCO, 2016) цэцэрлэгийн багш, ажилтнуудын цалингийн 1% хүртэлх хувьтай тэнцэх зардлыг мэргэжлийн хөгжил, тасралтгүй боловсролд зарцуулж байх тухай зөвлөмжийг авч хэрэгжүүлбэл зохистой байна.
8. Хүүхдийн цэцэрлэгүүдийн хамран сургалт өндөр байгаагаас цэцэрлэгийн эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах ялангуяа, хөдөөгийн болон захын хорооллын цэцэрлэгүүдийг цэвэр бохирын нэгдсэн сүлжээнд холбох, угаалтуур суултуурын тоог нэмэгдүүлэх, цэвэр усны хангамжийг сайжруулах, хүүхдийн хоол бэлтгэх тоног төхөөрөмжөөр цэцэрлэгүүдийг үе шаттай хангах түүнчлэн хүнсний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
9. СӨБ-ын чанарын хэмжүүр болох багш, сургалтын орчны болон эрүүл аюулгүй байдлыг хангах стандарт, дүрэм, журмын хэрэгжилтэд нэгдсэн хяналт, үнэлгээ хийх, дүн шинжилгээ хийсэн мэдээллийг бүх шатны СӨБ-ын төлөвлөлтөд тогтмол ашиглах
10. СӨБ-ын үйлчилгээний чанарыг сайжруулах хэрэгцээтэй холбогдуулан цэцэрлэгийн анги бүлэг, хүүхэд бүрд хүрэлцээтэй тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн, ном, гарын авлагын хангалтыг чанаржуулах, нэмэгдүүлэх шаардлагатай
11. Цэцэрлэгүүдийн үзүүлж буй үйлчилгээ, авч буй санхүүжилтийн үр ашгийн хамаарлыг тооцдог хүүхдийн хөгжлийн ахицад суурилсан үнэлгээний механизмыг бүрдүүлэх шаардлага байна.



**Зөвлөмж**

Сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр 2019 оноос хойш дунд хугацаанд дараах зорилтуудыг хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

1. Боловсролын салбарыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө хэрэгжиж дууссантай холбогдуулан энэ төлөвлөгөөний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах СӨБ-ын дэд салбарын стратеги, үр дүнг нарийвчлан шинээр тодорхойлох хэрэгтэй.
2. СӨБ-ын хүртээмжийг нэмэгдүүлэх бодлогыг цэцэрлэгийн хүүхдийн бүлэг дүүргэлтийн тоог төвлөрсөн суурин газарт бууруулах, цэцэрлэгийн барилгын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг хүн амын өсөлт, орон нутгийн хэрэгцээтэй уялдуулан шинэчлэх зорилтуудтай нягт уялдуулан авч үзэх шаардлагатай. Гэхдээ УБ хот (44.3) бусад төвлөрсөн суурин газрын төрийн өмчийн цэцэрлэгүүдийн бүлэг дүүргэлт, нэг багшид ноогдох хүүхдийн тоо хэт өндөр байгаа нь хүүхдийн эрүүл мэнд, асаргаа, хамгаалал, аюулгүй байдалд үүсэх эрсдэлийг нэмэгдүүлсэн, багшийн ажлын ачааллыг ихэсгэсэн зэрэг үйлчилгээний чанарт сөрөг нөлөөлөл бий болжээ. Ийм учраас хот суурин газрын цэцэрлэгүүдийн бүлэг дүүргэлтийг хүн амын нягтрал, хамран сургалтын доогуур үзүүлэлттэй газруудад цэцэрлэг шинээр барих, хуучин цэцэрлэгүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хүүхдийн тооны өсөлт, ачааллыг тэнцүүлж бууруулах (33.4 хүртэл) хэрэгтэй байна.
3. “Хүүхэд харах үйлчилгээ”-ний чанар, санхүүжилтийн тогтолцоонд хүүхдийг эрүүл, аюулгүй орчинд чанартай үйлчилгээ авах нөхцөлийг хангах чиглэлээр өөрчлөлт хийх.
4. Өнгөрсөн жилүүдэд хувийн хэвшлийн оролцоог дэмжсэн төрийн бодлогыг үргэлжлүүлэхдээ зөвхөн хүүхдэд төрөөс үзүүлж буй санхүүжилтийг зардлыг санхүүжүүлэхээс гадна (хүүхдийн хоол, асаргаа хамгаалал, эрүүл мэнд) цэцэрлэгийн барилга барих, орчин бүрдүүлэх чиглэлээр хөрөнгө оруулах бололцоог үүсгэн байгуулагчдад нээсэн зохистой арга хэлбэрээр төрөөс дэмжлэг үзүүлэх
5. Бага насны хүүхдэд үзүүлж буй боловсрол, нийгмийн үйлчилгээнд оролцож буй төр хувийн хэвшлийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг магадлан итгэмжлэх тогтолцоотой болох, шаардагдах стандарт, эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж мөрдүүлэх
6. Хүүхдийн сурах, хөгжих үйл явцад туслах эцэг эх, гэр бүлийн хандлага, ур чадварыг дээшлүүлэх ажлуудыг хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоо, мэдээлэл харилцааны технологид тулгуурлан мэдээллийн нөөц бий болгох, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр зохион байгуулах
7. Үндэсний болон орон нутаг цэцэрлэгийн түвшинд СӨБ-ын төлөвлөлт, үнэлгээний чадавхыг бий болгох, төрийн өмчийн цэцэрлэгүүдийн менежер, багш нарыг сонгон шалгаруулах, ажлын үр дүнг дүгнэх улс төрөөс ангид, мэргэжлийн тогтвортой тогтолцоог бий болгох
8. Үр дүнд суурилсан СӨБ-ын хяналт шинжилгээ, үнэлгээний тогтолцоо бий болгох тухайлбал, БУМС-д хүүхдийн хөгжлийн ай, сургуульд бэлтгэгдсэн байдлын үзүүлэлт, өгөгдлийг цуглуулах цонх бий болгох, мэдээлэлд дүн шинжилгээ хийж ашиглах

## 1.2. Бага, дунд боловсрол

### 1.2.1. Өмнөтгөл

Энэ дэд бүлэг нь Өмнөтгөл; Бодлого, Эрх зүй; Хэрэгжилт, Үр дүн; Дүгнэлт, Зөвлөмж гэсэн 4 үндсэн хэсэгтэй, Эдгээр хэсгүүд нь Хүснэгт 1.2.1-д үзүүлсэн бүтэц, агуулгатай.

*Хүснэгт 1.2.1. “Бага, дунд боловсрол” дэд бүлгийн агуулгын бүтэц*

1.2.1.	Өмнөтгөл	
1.2.2. Бодлого, Эрх зүй	1.2.2.1 Боловсролын хөгжлийн бодлого	Үндэсний хөгжлийн бодлого Бага, дунд боловсролын хөгжлийн бодлого
	1.2.2.2 Бага, дунд боловсролын чанар, нийцийг хангах бодлогын онол, арга зүйн шийдлүүд	Шинэ зууны боловсролын хөгжлийн чиг хандлага: ТХБ-Цогц чадамж-Боловсролын чанар
		Суралцахуйн онол арга зүйн шийдэл
		<i>Боловсролын стандарт ба сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалууд</i>
		<i>Боловсролын стандартууд</i>
		<i>Сургалтын үндэсний хөтөлбөрүүд</i>
		<i>Сургалтын төлөвлөгөөнүүд</i>
	<i>Сурах бичгийн хангамж</i>	
<i>Бага, дунд боловсролын сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандарт</i>		
<i>Суралцахуйн орчны стандарт</i>		
1.2.3. Хэрэгжилт, Үр дүн	1.2.3.1 Хүртээмж, Оролцоо	Шийдвэр гаргалт ба удирдлага, зохион байгуулалт
		Бага, дунд боловсролын тогтолцоо, сургуулийн бүтэц
		Сургуулийн насны хүн ам
		Элсэлтийн хувь
		Хамран сургалт
		Төгсөлтийн хувь
		Хувийн сургуульд суралцагчдын хувь
	Боловсролын системийн дотоод үр ашиг	
	1.2.3.2. Чанар, нийц	Бага дунд боловсролын стандарт, хөтөлбөрийн хэрэгжилт
		Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгийн талбар дахь түншлэл
		Сургалтын хөтөлбөрүүдийн боловсруулалтыг үнэлсэн судалгаанууд
		Сурах бичгийн нийлүүлэлт
		Сурах бичигтэй холбоотой судалгаанууд
		Бүлэг дүүргэлт
		Багш, сурагчийн харьцаа
		Мэргэжлийн багшийн хангалт
Ээлжийн коэффициент		
1.2.3.3 Инклюзив ба үл алагчлах байдал	ЕБС-ийн суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс	
	Эмэгтэй багшийн эзлэх хувь	
	Ус хангамжийн нөхцөл	
	Ариун цэврийн байгууламжийн нөхцөл	
Дүгнэлт, Зөвлөмж	Бага, дунд боловсролын хүртээмж, оролцооны тухайд	
	Бага, дунд боловсролын чанар, нийцийн тухайд (стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг, сургалтын орчин)	

Энэ дэд бүлэгт үндэсний түвшний хөгжлийн бодлого, эрхзүйн баримт бичгүүд дэх хөгжлийн бодлогууд, стратегийн зорилтууд, хөтөлбөрийн зорилтуудыг тус тус ялган тодорхойлж, тэдгээрийн хэрэгжилтийг холбогдох мэдээллийн эх сурвалжуудыг ашиглан олон улсад хэрэглэгддэг шалгуур индикаторыг хэрэглэн математик статистикийн аргачлалаар боловсролын үйлчилгээний хүртээмж ба оролцоо, чанар ба нийц, инклюзив ба үл алагчлах байдал гэсэн ерөний хүрээнд тус тус тодруулан үнэлэхийг зорьсон болно (Хүснэгт 1.2.2).

Монгол Улсын бага, дунд боловсролын суурь мэдээллийн тайланд тоон өгөгдлүүдийг боловсруулахдаа дараах арга зүйг хэрэглэсэн. Үүнд:

*Бодлого, эрх зүйн шинжилгээнд* баримт бичгийн шинжилгээний аргыг ашиглан Монгол Улсын Их Хурал, Засгийн Газар, БСШУСЯ-аас баталсан бодлого, зохицуулалтын баримт бичгүүд, эрх зүйн

актууд, мөн энэ чиглэлээр сүүлийн үед хийсэн судалгааны тайлангууд, БСШУСЯ-ны 2006-2017 оны тайлангууд болон ҮСХ-ны тайланг тус тус мэдээллийн эх сурвалж болгон ашиглалаа.

**Боловсролын сүүр мэдээллийн** боловсруулалтад арга зүйн дараах онцлогуудыг тооцсон болно. Үүнд:

**Сүүр мэдээлэл цуглуулж, боловсруулахдаа:** Боловсролын салбарын албан ёсны болон захиргааны статистик мэдээлэл, ҮСХ-ны хорооны суурин хүн амын тоо болон ҮСХ-ны томоохон судалгааны үр дүнг ашигласан.

**Суурин хүн амын тоог ашиглахдаа:** Монгол Улсын Хүн ам, орон сууцны 2000, 2010 оны тооллогын дүнг ашиглан 2000-2013 оны хоорондох Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоонд тодотгол хийсэн суурин хүн амын тоог ашигласан. Иймд энд өгөгдөж буй мэдээлэл нь ҮСХ-ны 2013 оноос өмнөх боловсролын шалгуур индикатор болон Мянганы хөгжлийн зорилтын шалгуур индикатораас зөрөөтэй байгааг анхаарах хэрэгтэй.

**Сургуулийн насны хүн амын тоог тогтоохдоо:** Боловсролын тогтолцооны өөрчлөлтөөс үүдэн (ЕБС-ийн 11 жилийн тогтолцоо) 2006, 2007 оны сургуулийн насны хүн амыг бага боловсролд 7-11, дунд ангид 12-15, ахлах ангид 16-17 нас гэж тооцсон бол 2008 оноос хойш (ЕБС-ийн 12 жилийн тогтолцоо) энэ индикаторыг бага боловсролд 6-10, дунд ангид 11-14, ахлах ангид 15-17 нас гэж тус тус тооцсонцлогтой.

**Шалгуур индикаторыг тооцохдоо:** Боловсролын тогтолцооны зураглалыг хийхэд (International Standard Classification of Education, ISCED-2011, UNESCO-UIS, 2012), ҮСХ-ний “Ангиллын кодыг батлах тухай” 2014 оны А/153-р тушаалыг тус тус үндэслэсэн болно.

**Шалгуур, индикаторуудыг сонгохдоо:** (Education Indicators Technical guidelines, UNESCO, 2009), (Боловсролын статистикийн үзүүлэлт тооцох аргачлал, ҮСХ, 2013), (Education sector analysis methodological guidelines, UNESCO, THE WORLD BANK, UNICEF, 2014) зэрэг гарын авлагыг ашигласан.

Тухайн индикаторын жилийн дундаж өөрчлөлтийг 2006-2017 оны хоорондох 12 жилийн хугацааны жилийн дундаж өөрчлөлтөөр буюу  $ЖДӨ = \frac{(N_{2017} - K_{2006})}{(N_{2017} * 12)} * 100$  гэсэн томъёогоор тооцсон болно.


Хүснэгт 1.2.2. Боловсролын үнэлгээний шалгуур, индикаторууд

	Шалгуур, индикатор		Тайлбар
Хүртээмж, Орлоцоо	1.	Элсэлтийн цэвэр ба бохир жин (түвшин бүрээр)	Thematic indicators 4.1.3/SDG4, Монголын боловсролыг 2006-2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө
	2.	Хамран сургалтын цэвэр ба бохир жин (түвшин бүрээр)	
	3.	Дотуур байранд хамрагдалт, малчдын хүүхдийн дотуур байранд хамрагдалт (оноор)	Монголын боловсролыг 2006-2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө, ЗГ-ын хөтөлбөр (2008-2012)
	4.	Төгсөлтийн хувь (түвшин бүрээр)	Thematic indicators 4.1.3/SDG4,
	5.	Хувийн сургуульд суралцагчдын хувь	Монголын боловсролыг 2006-2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө
Дотоод үр ашиг	1	Анги дэвшилтийн хувь	Education Indicators Technical guidelines, Боловсролын статистикийн индикатор тооцох аргачлал
	2	Анги улиралтын хувь	
	3	Сургууль завсардалт	
Чанар, нийц	1.	Бүлэг дүүргэлт (түвшин бүрээр)	
	2.	Сурагч-багшийн харьцаа	Thematic indicators 4.c.2/SDG4
	3.	Мэргэжлийн багшийн эзлэх хувь	Global indicators 4.c.1/SDG4
	4.	Ээлжийн коэффициент	ЗГ-ын хөтөлбөр (2008-2012, 2016-2020)
	5.	3 ээлжээр хичээллэж буй сургууль (оноор)	ЗГ-ын хөтөлбөр (2008-2012)
Инклюзив ба үл алагчлах байдал	1.	Жендэрийн тэнцвэрт байдлын индекс (түвшин бүрээр)	Global indicators 4.5.1/SDG4
	2.	Эмэгтэй багшийн эзлэх хувь (бага, дунд ахлах ангийн багш)	
	3.	ундны ус; хүйсээр ялгасан ариун цэврийн өрөө; гар угаах хэрэгсэл зэргээр хангагдсан сургуулийн тоо	Global indicators 4.a.1/SDG4

### 1.2.2. Бодлого, Эрх зүй

Бүх нийтийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэх замаар ёс зүйтэй, хариуцлагатай, бодит чадвартай, бүтээлч иргэнийг төлөвшүүлэхэд бага, дунд боловсрол чухал үүрэгтэй тул түүнийг боловсролын тогтолцооны хамгийн чухал үе шат гэж үздэг. Иймээс Монгол Улс Үндсэн хуульдаа иргэн бүрд ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй эзэмшүүлж, Боловсролын тухай хуульдаа суурь боловсролыг иргэн бүрийн заавал эзэмших боловсрол болгон тус тус хуульчилсан байдаг. 2017 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 20.1 хувь нь бага, дунд боловсролд хамрагдаж байна (Зураг 1.2.1). Монгол Улсын ЗГ-аас 1995 оноос хойш нийгмийн шинэ тогтолцоондоо нийцүүлэн бага, дунд боловсролын тогтвортой хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, иргэдийн сурч боловсрох эрхийн баталгааг хангах, боловсролынүйлчилгээний хүртээмж, чанарыг, дээшлүүлэхэд чиглэсэн цогц бодлогыг тодорхойлон баталж, тэдгээрийн хэрэгжилтийг хангахын төлөө хүчин чармайлт гаргасаар ирсэн.

Зураг 1.2.1. Монгол Улсын хүн ам ба сургуулийн насны хүн ам (2017)



Монгол Улсын хөгжлийн үндэсний түвшний бодлогын дийлэнх баримт бичгүүдэд бага, дунд боловсролыг хүний хөгжил, нийгэм эдийн засгийн болон боловсролын бүх түвшний зорилтуудтай уялдуулан авч үзэж, бага, дунд боловсролын хүртээмж ба оролцоо, чанар ба нийц, инклюзив ба үл алагчлах байдалтай холбоотой тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхээр шууд ба шууд бус утгаар тусган дэвшүүлсэн байдаг.

#### 1.2.2.1. Боловсролын хөгжлийн бодлого

##### Үндэсний хөгжлийн бодлого

УИХ-ын түвшинд баталсан “Мянганы хөгжлийн үндэсний зорилт” (2005, 2008) (УИХ-ын 25-р тогтоол, 2005), “Үндэсний хөгжлийн цогц бодлого 2007-2021” (2008), “Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилт 2030” (2016) гэсэн бодлогын баримт бичгүүдэд бага, дунд боловсролын хөгжлийн талаартусгагдсан төвлөсөн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүнг тоймлон авч үзлээ.

- УИХ-аас баталсан Мянганы хөгжлийн үндэсний зорилтын “2015 он гэхэд Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших”, “Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх” гэсэн гол зорилгыг хүрээнд 2015 онд гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох, 2009 он гэхэд бага ба дунд боловсрол эзэмшигчдийн дунд улмаар 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах гэсэн зорилтуудыг дэвшүүлжээ. Энэхүү Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн талаар 2013 онд хийсэн дунд хугацааны үнэлгээний тайланд (Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний тав дахь илтгэл-2013, 14 хуудас, 2013) дээрх зорилтуудыг “нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой” гэж дүгнэсэн байна. Дээрх зорилтын биелэлтийг 2015 оны байдлаар эцэслэн үнэлэхэд бага, боловсролын хамран сургалтын цэвэр жин 96.3 хувь, нэгдүгээр ангид элсэн ороод 5-р ангиа төгсгөл суралцсан суралцагчдын хувь 94.0, бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 0.96, ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа 1.07 гэсэн биелэлттэй гарсан байна (Хавсралт 1.2.1).

- “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Монгол Улсын үндэсний хөгжлийн цогц бодлого”-д боловсролын чиглэлээр монгол хүний хөгжил, түүний дотор боловсрол, эрүүл мэнд, түүнчлэн шинжлэх ухаан, технологи, байгаль орчны тогтвортой хөгжлийг тэргүүлэх чиглэл болгоно гэж тусгасан байна. Түүнчлэн урт хугацааны хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх стратеги, хүрэх үр дүнг дараах 2 үе шаттайгаар тодорхойлжээ.

- 2007-2015 онд эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх
- 2016-2021 онд мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих

Тухайлбал, нэгдүгээр үе шат (2007-2015)-нд “Суралцагчдад хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлнэ” *гэсэн Зорилт 1*-ийн хүрээнд бага, дунд боловсролын чиглэлээр дараах зорилтыг дэвшүүлсэн байна:

- 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулах
  - ЕБС-ийн дотуур байрны тохилог орчинг бүрдүүлж, дотуур байранд суух хүүхдийн тоог 2.1 дахин нэмэгдүүлэх
  - Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх
- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-ын “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилгын хүрээнд дараах зорилтыг хэмжих индикаторуудын хамт дэвшүүлжээ (Хүснэгт 1.2.3).

*Хүснэгт 1.2.3. “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн” зорилгыг хэрэгжүүлэх үе шатууд, зорилтууд*

	I үе шат (2016-2020)	II үе шат (2021-2025)	III үе шат (2026-2030)
Монгол иргэнийг төлөвшүүлэх ерөнхий боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд (PISA) хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх.	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд хамрагдах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ерөнхий боловсролын сургуулийн тоог 30 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 25-аас илүүгүй байлгах.	Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд эзлэх байрыг 5-аар урагшлуулж, сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх сургуулийг 100 хувь хангах, хоёр ээлжээр хичээллэж байгаа ЕБС-ийн тоог 50 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дунджийг 20-оос илүүгүй байлгах.

### Бага, дунд боловсролын хөгжлийн бодлого

Боловсролын яамнаас 1991 онд “БНМАУ-д боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлал” (Боловсролын сайдын 284-р тушаал, 1991), “Ерөнхий боловсролын сургуулийн бүтэц агуулгыг шинэчлэх чиглэл” зэрэг баримт бичгийг гаргажээ. Боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлалд *“Боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан нийгмийн тасралтгүй хөгжил, хүн төрөлхтний болон үндэсний соёл, иргэнийн үнэт зүйлс өв уламжлал, шинжлэх ухаанд үндэслэх” гэсэн зарчмуудыг баримтлах төдийгүй, “... хүүхэд залуучуудад үндэсний соёлын өвийг, хүн төрөлхтний соёл иргэнийн ололттой хослуулан эзэмшүүлж, шинжлэх ухааны үндэстэй эрдэм боловсрол олгох...”* гэж заасан байна. Энэ нь бага, дунд боловсролын агуулга үндэсний уламжлалт соёлоос хөндийрсөн үед чухал чиглэл болсон байна. (Боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого, шинэчлэл 1999-2014 он, 2014).

Дэлхий нийт дэх боловсролын хөгжлийн болон Монгол Улсын 1990 оноос хойших нийгэм, эдийн засаг хийгээд боловсролын секторын хөгжлийн замнал, өрнөлийг үечлэн авч үзсэн судалгаандүндэслэн бага, дунд боловсролын хөгжлийн үйл явцыг дараах үе шаттайгаар явагдаж байна гэж үзжээ (БСШУЯ, БМДИ, ШХА, 2018) Үүнд:

#### 4. Хөгжлийн бодлого, стратегиуд тодорхойлогдон эрх зүйн шинэ орчин бүрэлдэж, БНБ-ын хүрээнд бага, дунд боловсролын шинэ тогтолцоо үүсэн бүрэлдэх үе шат (1995-2004)

Монгол Улс хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн шинэ харилцаанд шилжиж байгаатай холбогдуулан иргэдийн боловсролын шинэ эрэлт хэрэгцээ, боловсролын дэлхий нийтийн

хөгжлийн чиг хандлагатай уялдуулан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг 1995 онд баталсан (Боловсролын бодлогын баримт бичгийн хураангуй 2 дахь хэвлэл, 2013).

Энэ хугацаанд шинэ нийгмийг цогцлоон хөгжүүлэх хөгжлийн бодлого, стратегиуд тодорхойлогдон эрх зүйн цоо шинэ орчин бүрэлдэж, боловсролын зорилго, агуулга, арга зүй, үнэлгээг суралцахуйд төвлөрүүлэн цогц чадамжуулж, тэдгээрийг шинэчлэх онол, арга зүйн дидактик шийдлүүд хийгдэж, боловсролын төлөвлөлтийг оролтод бус гаралтад төвлөрдөг болгон өөрчилж, боловсролын үйлчилгээний нээлттэй орчинд чанарын баталгааг хангахын тулд стандартад суурилсан боловсролын шинэчлэлийг эхлүүлж, боловсролын хүртээмж, чанар, нийц, тэгш боломжийг эрхэмлэсэн Бүх нийтийн боловсрол (БНБ)-ын шинэ тогтолцоо бүрэлджээ.

**5. *ТХБ-ын үнэт зүйлсийг чухалчлан тэдгээрийг сургалтын хөтөлбөр, сургалтын арга зүйдээ интеграцчилж, хүүхэд бүрийн хөгжлийг эрхэмлэн “ТХБ-10 жил”-ийн хүрээнд БНБ-ын тогтолцоог бэхжүүлэх үе шат (2005-2015)***

Боловсролд стратегийн төлөвлөлт, БНБ-ын индикаторуудыг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний олон улсын зарчим, арга зүй нэвтэрч, хэрэгжилтийн үйл явцыг хөтөлбөржүүлдэг болсон төдийгүй, суралцах хугацааг олон улсын жишигт нийцүүлэх шилжилтийг бүрэн хэрэгжүүлж, цогц чадамжид суурилсан шинэ стандартууд, 12 жилийн сургалтын хөтөлбөрүүд боловсрогдож, тэдгээрийг хэрэгжүүлэх сурах бичгээр хангагдан багш нарын мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа институтчилагдан ТХБ-ын үзэл санаа, агуулгыг сургалт ба сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилж, ТХБ-ын үнэт зүйлсийг чухалчлан хүүхэд бүрийн хөгжлийг эрхэмлэсэн байна. Энэ хүрээнд бага, дунд боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах баримт бичгүүдэд тодорхой тусгажээ. Үүнд: “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” (2015), “Боловсролын тухай хууль” (2006, 2012, 2015, 2016 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан), Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” (2006), “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010), “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр II” (2008), “Англи хэлний боловсролын үндэсний хөтөлбөр” (2008), “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” (2008), “Зөв Монгол хүүхэд” (2013), “Нэг Монгол” үндэсний хөтөлбөр (2014).

**6. *Дэлхий нийтийн “ТХЗ-2030 ба ТХЗ 4-Боловсрол 2030 үйлийн хүрээ” болон Монгол Улсын боловсролын хөгжлийн шинэ стратегийн төлөвлөлтийн хүрээнд бага, дунд боловсролыг бүхэлд нь ТХЗ-ын төлөөх боловсрол болгон хувирган өөрчлөх эхлэлийн үе шат (2016-аас хойш)***

Дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч баталсан “ТХЗ 4-Боловсрол 2030 үйлийн хүрээ”-нд тодорхойлогдсон ТХБ-ын шинэ алсын хараа, үзэл баримтлалд баримжаалан өөрийн орны хам нөхцөл, онцлогт нийцүүлэн “ТХБ үндэсний хөтөлбөр (2018-2022)”-ийг боловсруулан баталж, ТХ-ийг боловсролд, боловсролыг ТХ-д бүрэн гүйцэт, зөв оновчтой интеграцчилж, боловсролыг бүхэлд нь ТХЗ-ын төлөөх боловсрол болгон хувирган өөрчлөх үе эхэлж байна. Өнөөдөр Монголчууд өнгөрсөн 30-аад жилд улс үндэстэн бүхэлдээ болон нийгмийн салбар бүрийнхээ ололт амжилт, алдаа дутагдал, сургамжаа тус тус ялган тодорхойлж, үндэсний түвшний болон боловсролын салбарын хөгжлийн бодлого, стратеги, урт, дунд хугацааны төлөвлөлтүүдээ нарийвчлан хэлэлцэж байна.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)-д “Боловсрол нь иргэн бүрийн насан туршийн амьдралын чанарыг дэмжин баталгаажуулах, улс орны нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн түлхүүр хүчин зүйл, үндэсний тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгаа хэмээн үзэж, Монгол Улсын төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ” гэсэн зорилгыг дэвшүүлжээ. Мөн ЗГ-ын 2018 оны 209 дүгээр тогтоолоор “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”-ийг (ЗГ, 2018) баталж, хэрэгжилтийг үнэлэх шалгуур индикаторыг тодорхойлсон байна. Тухайлбал, үндэсний хөтөлбөрт 4 зорилт дэвшүүлсэн ба тэдгээрээс Зорилт I нь БСШУЯ-нд шууд хамаарч, дараах байдлаар томъёологджээ.

**Зорилт 1.** Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсрол, мэргэжлийн болон дээд боловсролын бодлого, сургалтын хөтөлбөрийн агуулгыг байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээний соёл, эрүүл, аюулгүй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр баяжуулж, шаардагдах хүний нөөцийн болон материаллаг баазыг бэхжүүлэх. Энэ зорилтын хэрэгжилтийг дараах шалгуур, индикатораар хэмжигдсэн үнэлэхээр тусгажээ (Хүснэгт 1.2.4)

## Хүснэгт 1.2.4. “ТХБ үндэсний хөтөлбөр”-ийн Зорилт 1-ийг үнэлэх шалгуурууд

Шалгуур индикатор	Суурь түвшин		Хүрэх түвшин		Хариуцах байгууллага
	2017	2020	2022		
Тогтвортой хөгжлийн боловсролын агуулга, арга зүй тусгагдах сургалтын хөтөлбөрийн тоо	143	148	155		БСШУСЯ
Боловсролын салбарын хүний нөөцийн тогтвортой хөгжлийн боловсролын төрөлжсөн сургалтад хамрагдсан хувь	50	70	100		БСШУСЯ, БМДИ
Олон улсын Эко сургууль хөтөлбөрт хамрагдах сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын байгууллагын тоо	255	350	450		БСШУСЯ, БОАЖЯ
Олон улсын “Ногоон” санаачилга үйл ажиллагааг нэвтрүүлэх дээд, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тоо	-	5	10		БСШУСЯ, БОАЖЯ
“Эко”, “Ногоон” гэрчилгээ авах сургалтын байгууллагын тоо	45	60	80		БСШУСЯ, БОАЖЯ
Ногоон паспорттой сурагчдын эзлэх хувь	-	20	30		БСШУСЯ, БОАЖЯ

Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг дээрх бодлого, стратеги, хөтөлбөрүүдтэй уялдуулан хэрэгжүүлж байна.

### 1.2.2.2. Бага, дунд боловсролын чанар ба нийцийг хангах бодлогын онол, арга зүйн шийдлүүд

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай багц хууль, боловсролын хөгжлийн бодлого, стратегийн зорилтууд болон бусад эрх зүйн баримт бичигт тулгуурлан 1920-иод оноос өнөөг хүртэл бага, дунд боловсролын агуулгыг боловсруулахдаа түүнийг тухайн түүхэн цаг үеийн нөхцөл байдал, хувь хүн, нийгмийн хэрэгцээ шаардлага, олон улсын чиг хандлагатай уялдуулан байнга баяжуулан хөгжүүлж иржээ.

“Боловсролын чанар” гэдэг нь боловсролын зорилтуудаас эхлэн гаралтын дам үр дүнгүүд хүртэлх маш өргөн хүрээний асуудлыг хамарсан интерактив шинжтэй, өндөр эрэмбийн ерөнхий шалгуур юм. Харин “боловсролын бодит нийц” гэдэг нь хувь хүний болон боловсролын секторын хөгжлийн хэрэгцээг хэрхэн хангаж байгааг илэрхийлэх боловсролын чанарыг өөртөө агуулсан илүү ерөнхий шалгуур байдаг.

Монгол Улсын бага, дунд боловсролд боловсролын чанар, нийцийн талаар баримталж ирсэн суралцахуйн түвшний бодлого нь нэг талаас, өөрийн орны олон мянган жилээр шалгарч ирсэн өв уламжлалууд, боловсролын салбарт хүрсэн ололт амжилтын түвшин нөгөө талаас, хүн төрөлхтний шинэ зууны боловсролын хөгжлийн чиг хандлагатай тухайлбал, суралцахуйн конструктив онолуудын зарчмууд, цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, кирриколикийн онол арга зүй, тэдгээрт ТХБ-ыг интеграцчилах стратегитай нягт холбоотойгоор тус тус тодорхойлогдож ирсэн түүхтэй.

Монгол Улс социалист нийгмийн тогтолцоотой байх үед хүн ам нь бүх нийтээрээ бичиг үсэгт тайлагдсан амжилтыг ЮНЕСКО-оос үнэлж, бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгахад онцгой гавьяа байгуулсан байгууллага, хүмүүст олгодог Н.Крупскаягийн нэрэмжит шагналыг 1970 онд Монгол улсад олгосон. Энэ хугацаанд Монгол Улсад орчин цагийн боловсрол, шинжлэх ухаан, техник технологи, үндэсний, сонгодог, орчин үеийн соёл, урлаг үүсэн хөгжиж, монголчуудын нийгмийн хөгжил, дэвшлийн төлөөх үйл хэрэг тасралтгүй үргэлжилсээр ирсэн.

#### Шинэ зууны боловсролын хөгжлийн чиг хандлага: ТХБ-Цогц чадамж-Боловсролын чанар

Аливаа систем дэх өөрчлөлтийг судлах, хөгжлийн чиг хандлагыг тогтоох зорилгоор 1970 оноос макро-эдийн засагт “индикатор” хэмээх хэрэгслийг хэрэглэж эхэлсэн бөгөөд улмаар өнөөдөр нийгмийн салбарт ч түүнийг өргөн хэрэглэх болсон. Тухайлбал, НҮБ-д “Хүний хөгжлийн индекс”, “Мянганы хөгжлийн зорилтууд”-ыг хэмжих тусгай индикаторуудыг хэрэглэдэг. Мөн боловсролын системд ч “БНБ-ын индикаторууд”, “ТХБ-ын индикаторууд” хэрэглэгдэж байна.

Энэ цаг үеэс боловсролын системийн чанарыг суралцахуйн гаралтад баримжаалан үнэлэх чиглэлээр боловсролын онолын болон эмпирик судалгаанд боловсролын чанарыг үнэлэхэд хэрэглэх ухагдахууны талаар олон улсын судлаачдын дунд өргөн хэлэлцүүлэг эхэлсэн билээ.

Хоёр зууны зааг дээр 21-р зуунд амьдрах иргэний дүр төрхийг тодорхойлох шинэ шаардлагууд тодорхойлогдож, боловсролын чанарын асуудал дэвшигдэх болсноор боловсролын чанарын баталгааг хангах үндсэн арга хэрэгсэл болох боловсролын стандартыг шинэчлэх ажил эхэлсэн. Стандартын шинэчлэл нь боловсролын үйл явцын гаралтад хүлээгдэж буй үр дүнг ирээдүйн иргэний дүр төрхийн тусгал болох цогц чадамж хэлбэрээр тодорхойлох болсон. Иймээс өнгөрсөн зууны 70-аад оноос эхлэн ЮНЕСКО болон олон улсын бусад байгууллагууд, түүнчлэн улс орнууд дангаараа болон бүс нутгаараа нэгдэн шинэ зууны иргэдийн эзэмшвэл зохих цогц чадамжуудын талаар өргөн цар хүрээтэй судалгаанууд хийж, 21-р зууны цогц чадамжийн олон хувилбарууд боловсрогдож, дэлхийн төдийгүй улс орон бүрийн боловсролын шинэчлэлийн үндсэн стратеги болсоор байна.

Монгол Улс ч дэлхий нийтийн боловсролд гарсан эргэлтийн шинжтэй энэ том өөрчлөлтийн үзэл санаа, зарчим, үйл хэргээс хараа салгаж, хөл алдалгүй явж байна.

Хувь хүний эзэмшсэн боловсрол чанартай байна гэдэг нь суралцах болон ажил амьдралдаа тулгарсан асуудлыг бүтээлчээр, хариуцлагатайгаар өөрөөр хэлбэл, тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааны дагуу шийдвэрлэх сэтгэлгээний шинэ барил, шийдвэр гаргах шинэ ёс зүй, үйл ажиллагааны менежментийн шинэ арга ухаан эзэмшсэн, идэвхтэй, бүтээлч оролцоотой үйлийн эзэн байна гэсэн үг юм.

### Суралцахуйн онол арга зүйн шийдэл

Бага, дунд боловсролын чанарын баталгааг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэхийн тулд төрөөс суралцахуйн түвшинд баримтлах бодлогын дараах үндсэн баримт бичгүүдэд тусгасан онол, арга зүйн шийдлийг товч танилцуулж байна. Үүнд:

- Бага, дунд боловсролын стандарт ба киррикулимийг шинэчлэх үзэл баримтлал (2002)
- Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал (2013)
- Бага, дунд боловсролын стандартууд (2004)
- 12 жилийн сургалттай ЕБС-ийн сургалтын үндэсний хөтөлбөрүүд (2008-2012)
- Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрүүд (2014-2018)
- Сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандарт (2004-2008)
- Багшийн ажлын байрны тодорхойлолт ба түүнтэй шууд холбогдох журмууд (2007-2012).

Хүн судлалын шинжлэх ухаануудын парадигмийн өөрчлөлтийн огтлолцол дээр 1980-аад оны үеэс дидактикт боловсролын нийц ба чанарыг дээшлүүлэх олон шинэ шийдлүүд хийх боломж бүрдсэн. Иймээс тэдгээрийг харьцуулан судалж, Монгол Улсын бага, дунд боловсролын агуулга, сургалтын технологийг шинэчлэх *үндсэн стратеги* (БСШУЯ, 1999), *дидактик түвшний стратеги шийдлүүд* (Гэгээрлийн яам, 1998), *хүлээгдэж буй үр дүнгийн талаарх таамаглалыг* (Гэгээрлийн яам, 1999, хууд. 16) тус тус дэвшүүлсэн байна (Зураг 1.2.2.).

Зураг 1.2.2. Бага, дунд боловсролын түвшинд хийгдсэн суралцахуйн дидактик шийдлүүд

Агуулга, аргазүйг шинэчлэх гол стратеги	Гол стратеги хэрэгжүүлэх дидактик шийдлүүд	Хүлээгдэж буй үр дүнд хүрэх таамаглал
<p>“Боловсролын академик талыг бууруулахгүйгээр прагматик талыг хөгжүүлэх замаар агуулгаа <u>цогц чадамжуулж</u>, агуулга, арга зүйн түвшинг бүхэлд нь эрэмбэ ахиулах”</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын агуулгыг ур чадварын тогтолцоо буюу <u>цогц чадамжууд болгох</u></li> <li>• Боловсролын стандарт, киррикулим боловсруулахдаа шинжлэх ухааны ерөнхий арга судлал (<u>системийн шинжилгээний арга судлал</u>)-ын зарчимд тулгуурлах</li> <li>• Агуулга, арга зүйн <u>дидактик нэгжийг томсгох</u></li> <li>• Агуулга, арга зүйг <u>элементарчлах</u></li> <li>• ТХБ-ын үзэл санаа, агуулгыг албан сургалтад оршоон интеграцчилах</li> <li>• Монгол ардын <u>өв уламжлалтай нягт холбох</u></li> <li>• Сургалтын менежментийг <u>нээлтэй киррикулим</u> тогтолцоонд шилжүүлэх</li> </ul>	<p>“Хэрвээ бид шинжлэх ухааны орчин үеийн ерөнхий арга судлал болон тодорхой шинжлэх ухааны арга судлалын амьд холбоонд тулгуурлан сургалтын агуулгын судлагдахууны болон ур ухааны харилцан эсрэг гэхээр парадокс талуудын нэгдлийг буюу хөгжлийг оновчтой тодорхойлж, агуулгын дидактик нэгжийг томсгож чадвал сургалтын агуулгын онол (академик)-ын түвшнийг бууруулахгүйгээр сургалтын прагматик шинжийг түлхүү хөгжүүлж, суралцагчдад агуулгын инвариант элементар болох "тогтолцоон" баримжаа эзэмшүүлж, хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа орчинд асуудлаа шийдвэрлэх бодит чадвартай, бүтээлч, хариуцлагатай иргэн төлөвших гол нөхцөл хангагдана”</p>




Дидактик түвшний дээрх шийдлүүдээс харахад Монгол Улсын бага, дунд боловсролыг шинэчлэх стратегид “ТХБ-ын үзэл санаа, агуулгыг албан сургалтад оршоон интеграцчилах” гэсэн бие даасан дидактик шийдлийг томъёолсон байхын зэрэгцээ түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар үнэ цэнэтэй тусгай шийдлүүд хийгдсэн байна. Тухайлбал, дээрх стратеги, дидактик шийдэл, таамаглалд ТХБ-ын агуулга, арга зүйг цогц чадамжуулах, хэрэгцээтэй арга ухааныг айжуулах, системийн шинжилгээний аргаар агуулгын дидактик нэгжийг томсгон хам нөхцөлд буулгах (контекстжүүлэх), суралцагчдад юмс, үзэгдлийг танин мэдэх элементар болох “тогтолцоон баримжаа”-г тодотгож төлөвшүүлэн мэдлэг, чадвараа хэрэглэх бодит боломжийг бүрдүүлэх зэрэг шаардлагыг цогцоор нь албан боловсролдоо оршоон интеграцчилах онол, арга зүйн өндөр түвшний шийдэл хийгджээ гэж үзэж болохоор байна. Хэрвээ дидактик түвшний дээр дурдсан стратеги шийдлүүдийг бодитоор хэрэгжүүлж чадваас боловсролын шинэчлэлийн дүнд хүрэх дам болон нөлөөт үр дүнгийн талаар дэвшүүлсэн таамаглал батлагдах боломжтой гэж үзжээ.

### Боловсролын стандарт ба сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалууд

Монгол улсад 1990-ээд оноос эхэлсэн боловсролын өөрчлөлт шинэчлэл нь эрин үеийн бодит нийгэм-түүхэн нөхцөлийн хэрэгцээ шаардлагаар үндэслэгдсэн, боловсролын бүх төвшин, бүрэлдэхүүн хэсгийг хамарсан, цогц шинжтэй, бүхэл бүтэн тогтолцооны шинэчлэл байсан бөгөөд өнөөдөр ч энэ үйл явц үргэлжилсээр байна. Боловсролын хөгжлийг хангах гарааны суурь шийдлүүд нь бүх төвшний боловсролын үндэсний стандарт ба киррикулимийг хөгжүүлэх үзэл баримтлалуудад тусгалаа олсон байдаг. Дэлхий нийтийн боловсролын хөгжлийн чиг хандлага болон боловсролын философи, арга судлал, мэдлэгийн онол, боловсролын психологи, социологи, антропологи, менежментийн шинжлэх ухааны тасралтгүй хөгжиж байгаа үзэл санаа, зарчим, арга зүйд тус тус тулгуурлан боловсруулж баталсан Монгол Улсын “Бага, дунд боловсролын киррикулим, стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал”-д (БСШУЯ, 2002) боловсролыг шинэчлэх дараах шийдлүүд хийгджээ.

- Боловсролыг нийгмийн хэрэгцээ, захиалга талаасаа бол, “улс орны тусгаар тогтнол, нийгмийн тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварын үндэс”, харин хувь хүний хэрэгцээ, эрэлт талаасаа бол, “чанартай амьдралын арга ухаанд тасралтгүй суралцах, дадлагажин мэргэших, төлөвших үйл явц, соёлын үнэт зүйлс болон үр чадвар эзэмшин нийгэмших–иргэнших үйл ажиллагаа” гэж үзнэ.
- Боловсролын зорилго нь “... иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, амьдрах, ажиллах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”.
- Нийгмийн тасралтгүй, хурдацтай хөгжлийн шаардлага нь боловсролтой иргэний дүр, шинж чанараар илрэх боловсролын эрэлт хэрэгцээг тодорхойлж, энэ эрэлт хэрэгцээг хангах нийлүүлэлт нь үндэсний болон орон нутаг, сургуулийн бүх төвшний киррикулимийн хөгжлөөр тодорхойлогдоно. Энэхүү боловсролын эрэлт нийлүүлэлтийн чанарыг боловсролын стандартаар хэмжиж үнэлнэ.
- Боловсролын стандарт бүхэлдээ боловсролын хуулиар тодорхойлсон зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд хэрэгжилтийн явцдаа боловсролын зорилгыг нарийвчлах, киррикулимаа боловсронгуй болгох үндэслэлийг тодотгож байх давхар үүрэгтэй. Боловсролын стандарт нь боловсролын зорилго, агуулга, арга зүй, орчин, үнэлгээг тодорхойлон бүх нийтээрээ мөрдөхөөр хуульчилсан, боловсролын үйл ажиллагааг үнэлэн боловсронгуй болгож байхад баримтлах норматив баримт бичиг мөн.
- Стандарт нь Монголын бага, дунд боловсролын бүх шатлал, төрөл, бүрэлдэхүүн хэсгийг хамарсан өргөн хүрээтэй, тэдгээрийн өвөрмөц хэрэгцээ, онцлогийг тусгасан олон төрөл хувилбартай байна.
- Боловсролын бүх төвшний киррикулим нь стандартыг хэрэгжүүлэхийн тулд Монголын нийгмийн соёлын үнэт зүйлсээс сургууль боловсролын байгууллагаар дамжуулан иргэддээ эзэмшүүлэхээр сонгосон тодорхой зорилго, агуулга, арга зүй, орчин, үнэлгээ бүхий сургалтын тогтолцоо мөн. Киррикулимийн хөгжил нь боловсролын стандартаа боловсронгуй болгож сайжруулах үндэслэл болно.
- Боловсролтой иргэн нь хүн төрөлхтний даяаршил болон нийгмийн хөгжлийн шалгуурыг ханган ажиллаж, амьдрах бодит чадвартай, хариуцлагатай бүтээлч шинж бүхий Монгол иргэний дүр төрхөөр тодорхойлогдоно. Түүний дүр төрх, төлөвшил нь боловсролын агуулгыг тодорхойлж, боловсролын стандартын үүрэг, зориулалтын биелэлтийн шалгуур болно. Боловсролтой иргэний шинж чанар, төлөвшил нь цогц чадамжуудаар, цогц чадамж нь сургалтаар эзэмших үр чадваруудаар тус тус тодорхойлогдоно. Суралцагчдад төлөвшсөн цогц чадамжийг танин мэдэхүйн төвшний шалгуур (бенчмарк)-аар үнэлнэ.
- Цогц чадамжууд нь олон төрөл, ангилал, төвшинтэй байх бөгөөд тэдгээр нь хөгжлийн явцад харьцангуй үл өөрчлөгдөн хадгалагдах суралцахуйн зорилгын дараах тулгуур айн аль нэгт багтана:
  - Мэдэхийн төлөө суралцахуй
  - Хийж гүйцэтгэхийн төлөө суралцахуй
  - Оршин байхын төлөө суралцахуй
  - Хамтдаа нийгэмшин амьдрахын төлөө суралцахуй

Зураг 1.2.3. Бага, дунд боловсролын стандарт дахь олон эрэмбэт шүтэлцээ



Эх сурвалж: (БОНХАЖЯ, ШХА, 2015, хууд. 250) .

Ж.Делорсын хэмээн нэрлэдэг “Learning: the treasure within” (Delors J. , 1996) буюу “Суралцахуйд эрхэмлэх үнэт эрдэм” сэдэвт ЮНЕСКО-гийн (1996) илтгэлд суралцахуйн зорилгыг “Мэдэхийн төлөө суралцахуй”, “Хийж бүтээхийн төлөө суралцахуй”, “Бие даан оршихуйн төлөө суралцахуй”, “Хамтдаа нийгэмшихуйн төлөө суралцахуй” гэсэн суралцахуйн 4 айгаар тодорхойлсон байдаг.

OECD байгууллагаас 2002 гаргасан “Definition and selection of competencies (DeSeCo): Theoretical and conceptual foundations” (OECD, 2002) буюу “Компетенцийн тодорхойлолт ба сонголт: Онол, үзэл баримтлалын үндэслэл” сэдэвт төслийн тайланд ТХБ-ын цогц чадамжуудыг тодорхойлсон байдаг. Дээрх судалгаануудын үр дүнгүүд болох ТХБ-ын цогц чадамжуудыг (Inka Borgman, 2008) шалгуур болгон Стандарт, киррикулимийн үзэл баримтлалд ТХБ-ын цогц чадамжууд хэрхэн тусгагдсан байдлыг үнэлсэн судалгаа (Хавсралт 1.2.2)-наас дараах дүгнэлтийг хийжээ (Н.Нэргүй, 2015) (БОНХАЖЯ, ШХА, 2015). Үүнд:

1. Монгол Улс бага, дунд боловсролын стандартыг хөгжүүлэх үзэл баримтлалдаа ЮНЕСКО-оос санал болгосон “Суралцахуйн 4 тулгуур багана”-ыг суралцахуйн зорилго буюу цогц чадамжийн хүлээгдэж буй үр дүнгийн 4 ай болгон сонгосон байна. Үзэл баримтлал, бодлогын түвшин дэх цогц чадамжийн сонголттой холбоотой энэхүү шийдэл нь ТХ болон ТХБ-ыг үнэлэх гүн ухааны гол зарчмын нэг болох “арга билгийн шүтэн барилдах” ёсны шалгуурыг түвшин бүрдээ хос хосоороо бүрэн хангаж байгаа нь (Зураг 1.2.3) стандартын шинэчлэл нь онол, арга зүйн гүн гүнзгий үндэслэлтэй байх зарчимд нийцсэн гэж үзэх боломж олгож байна.
2. Уг үзэл баримтлалд цогц чадамжийн энэхүү 4 ай бүрээр стандарт, киррикулимийг шинэчлэн хөгжүүлэх бодлогын шийдлүүд хийгдэж, тус бүрд нь харгалзах үндсэн мэдлэг, чадваруудаас тодорхой жишээ татан дурдсан байна.
3. Үзэл баримтлал дахь стандарт, киррикулимийг шинэчлэн хөгжүүлэх бодлогын шийдлүүд (17шийдэл) ба цогц чадамжийн айнууд (4 ай), тэдгээрт харгалзах мэдлэг, чадварууд (43 чадвар) нь бүхэлдээ ТХБ-ын дээр дурдсан цогц чадамжуудад бүрэн харгалзаж байна (Хавсралт 1.2.2).
4. ТХБ-ын цөм агуулгыг илэрхийлдэг юмс, үзэгдлийг танин мэдэх систем сэтгэлгээ (А), шийдвэр гаргах ойлголцол, зөвшилцлийн ёс зүй (В), үйл ажиллагаа явуулах нэвт шувт менежмент (С)-ийн арга ухаан нь олон улсын ТХБ-ын цогц чадамжид ч, Монгол Улсын стандарт, киррикулимийг хөгжүүлэх үзэл баримтлалд ч хангалттай түвшинд тусгалаа олж чадсан байна гэжээ.

“Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал (2013)” (БШУ-ны Сайдын А/155 дугаар тушаал, 2013) нь нийтлэг үндэслэл, бодлогын үндсэн чиглэл, баримтлах зарчим, үйл ажиллагааны чиглэлүүд гэсэн 4 бүлэгтэй. Баримт бичгийн бүтцээс харахад боловсролын чанарт анхаарах шаардлага байгааг үндэслээд стандарт, хөтөлбөр, арга зүй, чанарын үнэлгээ, багш, сурах бичиг, байгууллагын хөгжлийг цогцоор нь авч үзэж, шинэчлэхээр тодорхойлжээ.

Энэ үзэл баримтлалын шинжилгээнээс харахад чанарын шинэчлэлийн чиглэлээр нийт 52 заалттай бөгөөд тэдгээрийн 13 нь бодлого, зарчмын түвшний, үлдсэн 39 буюу 75%-г үйл ажиллагааны түвшинд хамааруулан тодорхойлсон байна. Уг баримт бичгийн шинжилгээнээс харахад энэ

баримт бичиг нь “хөгжлийн үзэл баримтлал” гэхээсээ илүүтэйгээр бүхэлдээ дунд хугацааны стратегийн төлөвлөгөөний түвшний баримт бичиг болжээ хэмээн дүгнэж болохоор байна. Гэвч уг баримт бичиг нь багш бэлтгэхтэй холбоотой шинэ зорилт, үйл ажиллагаа бүхий цогц арга хэмжээ, чанарын үнэлгээний тогтолцоо, түүний зайлшгүй нөхцөлийн нэг болох бүртгэл мэдээллийн удирдлагын тогтолцоог бий болгох, сургалтын технологийн менежментийг шинэчлэх зэрэг хойшлуулшгүй зорилтуудыг дэвшүүлснээрээ чухал ач холбогдолтой юм.

Ийнхүү 2002 онд батлагдсан “Бага, дунд боловсролын стандарт ба киррикулимийг шинэчлэх хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг 2013 оны “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал” гэсэн 2 үзэл баримтлал хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

### **Боловсролын стандартууд**

Монгол Улсад 1998 оноос өмнө ерөнхий боловсролын сургуульд мөрддөг сургалтын үндсэн баримт бичиг нь “Хичээлийн программ”-ууд байсан бөгөөд эдгээр программ нь бүхэлдээ тухайн шинжлэх ухааны хөгжлийн үе шатуудад баримжаалсан судлагдахууны системчилсэн жагсаалт байсан. УИХ-аас 1995 онд баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д “Бага, дунд, дээд боловсролын стандартыг төрөөс тогтоож, түүнийг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагад нэгэн адил мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх механизмыг бий болгох” гэсэн заалтын дагуу бэлтгэл ажлыг ханган ажилласнаар Стандартчилал хэмжил зүйн үндэсний төвийн зөвлөлийн 1998 оны 13-р тогтоолоор Монгол Улсын анхны “Бага, дунд боловсролын агуулгын стандарт”-ыг батлуулан, 6-р сарын 1-ээс эхлэн мөрдсөн байна.

Энэ стандарт нь зөвхөн боловсролын агуулгын стандарт байсан бөгөөд өмнө нь бүх нийтээр хөдөлшгүй баримталдаг байсан “хичээлийн программ”-ыг сургууль, багш нар өөрсдийн хэрэгцээ болон хам нөхцөлдөө нийцүүлэн өөрчилж болох “цөм хөтөлбөр” хэлбэртэй болгон өөрчилж, боловсролын түвшин бүрийн болон хичээл бүрийн зорилтыг стандартчилсан. Өөрөөр хэлбэл, хуучин ба шинэ хандлагын аль алийг илэрхийлэхийн зэрэгцээ стандарт ба киррикулим хоёрын зөвхөн агуулгын хэсгийг хамарсан, түүнийг нээлттэй болгосон анхны баримт бичиг байв.

Бага, дунд боловсролын агуулгын стандартыг 2004 онд цогц чадамжид суурилсан боловсролын стандарт болгон шинэчлэн баталсан бөгөөд 2018 он хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байсан байна. Боловсролын тухай хуульд 2017 оны 12 сарын 21-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тус хуулийн “стандартыг асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулан, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 6.5-д заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгүүлнэ” гэсэн 11.3 дахь заалтыг хүчингүй болгож, 11.2-т “Боловсролын стандарт нь багшийн мэргэжлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно” хэмээн зааж, Монгол Улсын боловсролын стандартыг боловсролын *түвшин бүрийн* агуулгад тавигдах шаардлагагүй буюу стандартгүй болгосон байна. Хуульд оруулсан энэ өөрчлөлт нь “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024” (2015)-ын 4.3 ба 4.8 дахь заалтыг зөрчсөн төдийгүй Боловсролын тухай багц хуульд боловсролын стандарттай холбоотой ойлгомжгүй, зөрчилтэй олон заалтууд хүчин төгөлдөр байхаар үлдээсэн байна (Хавсралт 1.2.3). Энэ асуудлыг 2018 онд эхэлсэн Боловсролын тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хүрээнд зайлшгүй хянан үзэж шийдвэрлэх шаардлагатай.

### Шинэ стандартыг бүтээсэн үндсэн шийдэл (БСШУЯ, БСХХ, ЖАЙКА, 2003)

Боловсролын удирдлагын төвлөрлийг сааруулах, нээлттэй киррикулимийн хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд шинээр төлөвшиж буй тогтолцооныхоо мөн чанарт нийцүүлэн агуулгын стандартаа боловсролын стандарт<sup>6</sup> болгон шинэчлэн хөгжүүлэхдээ дараах цогц шийдлийг хийсэн байна. Үүнд:

- Боловсролын үйл ажиллагаа нь боловсролын хэрэгцээ, зорилго, агуулга, арга зүй, үнэлгээ, бүхий тогтолцоо байна.
- Боловсролын чанар нь цогц чадамжаар үнэлэгдэнэ.
- Боловсролын хэрэгцээ нь хувь хүн, нийгмийн эрэлт хэрэгцээнд үндэслэгдэнэ.
- Боловсролын зорилго нь суралцагчдад цогц чадамж төлөвшүүлэхэд оршино.
- Боловсролын агуулга нь цогц чадамжийг төлөвшүүлэхээр сонгогдож, бүтэцлэгдэнэ.
- Боловсролын стандартчилал нь танин мэдэхүйн түвшингээр тогтоогдоно.

<sup>6</sup> Энд “Боловсролын стандарт” гэдгийн доор суралцахуйн зорилт, агуулга, арга зүй, орчин, үнэлгээг бүхэлд нь хамарсан, тэдгээрийн тус бүрд тавигдах шаардлагыг ойлгоно.

- Боловсролын арга зүйн үндэс нь суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэх конструктив дидактик зарчмуудад үндэслэгдэнэ.
- Цогц чадамжийн төлөвшил нь танин мэдэхүйн түвшний ерөнхий шалгуурт суурилна.
- Боловсролыг хүний мэдлэг, чадвар, хандлага, төлөвшил чанарын хувиргалт хийгддэг тасралтгүй үйл явц гэж үзнэ.

Боловсролын стандартын шинэчлэлийг дараах байдлаар ерөнхийлөн дүгнэжээ.

“Шинэ стандартад боловсролын хэрэгцээг хувь хүн, нийгмийн эрэлт хэрэгцээнээс ургуулж, зорилго, зорилтыг цогц чадамжуудаар хэмжээсжүүлэн томьёолж, агуулгын нэгжийг томсгон айд багцалж, арга зүйг орчин цагийн шинжлэх ухааны үндэстэй дидактик шийдлийн зарчимд үндэслэж, цогц чадамжийг танин мэдэхүйн хөгжлийн үе шатуудад харгалзуулан үнэлэхээр үнэлгээний шалгуур индикаторыг түвшинчлэн тус тус тодорхойлсон болно” (БСШУЯ, БСХХ, ЖАЙКА, 2003)

Стандартыг агуулга хоорондын хөндлөн холбоог илэрхийлсэн сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дүнд гэсэн боловсролын 4 дэд түвшин, түүнчлэн агуулга хоорондын босоо холбоог илэрхийлсэн хүмүүнлэг, математик, байгалийн ухаан, нийгмийн ухаан, технологи гэсэн агуулгын 5 айн 16 чиглэлээр боловсруулжээ.

Боловсролын түвшний болон агуулгын чиглэлийн бүх стандарт нь удиртгал, үзэл баримтлал, агуулгын стандарт, үнэлгээний стандарт, арга зүйн үндэс гэсэн 5 хэсэгтэй ба эхний хоёр хэсэгт тухайн стандартын бүтэц, дизайн болон түүний хэл болох код, түлхүүр нэр томьёог танилцуулсан байна.

*Шигтгээ 1.2.1. Бага, дунд боловсролын стандартын тухай зүйр үлгэр*

Эртээ урьдын цагт биш энэ цаг дор эртний түүхт Монгол улсад энхрий олон шавьтай эрдэмтэн багш нар амьдарч байлаа. Эзэлж буй эрин цагт нь эртэй их өөрчлөлтүүд болж, ээж аав, элгэн садан, ер нь бүх хүмүүс ачийж тачийн, арвайж сарвайн ажиллаж, амьдрах болжээ. Зарим нь эрдэм номоо ч, энхрий үрсээ ч умартах болж гэнэ. Энэ их үймээн самуун, өрсөлдөөн тэмцэл дунд энхрий шавь нараа эрсдэхээргүй эрдэмтэй, эгнэхээргүй боловсролтой болгох эрхэм хүндэт үүрэг эрдэмтэн багш нарт оногджээ. Тэд шавь нараа эрсдэхээргүй эрдэмтэй, эгнэхээргүй боловсролтой болгоно гэж ид шидтэй эрдэнэс ундраадаг багаж бүтээжээ. Ид шидтэй эрдэнэсийг нь цогц чадамж, эрдэнэс ундраадаг багажыг нь стандарт гэж нэрлэдэг гэнэ. Энэ багаж нь код гэсэн цоожтой, нэр томьёо гэсэн түлүүртэй юмсанж. Ид шидийг бүтээгч эрдэнэсийг энхрий шавь нартаа атгуулахын тулд эрдэмтэн багш нар нь түлхүүр цоожоо тааруулан багажаа ажлуултал эрдэнэс нь харагдах хэрнээ баригддаггүй гэнэ. Тэд хэлэлцэж байгаад эрдэнэсээ барьдаг нэг арга олжээ. Тэр аргаа киррикулим гэж нэрлэв. Багш нар хамтарч бүтээсэн аргынхаа хүчээр эрсдэхээргүй эрдэмтэй, эгнэхээргүй боловсролтой болгодог ид шидийн эрдэнэсийг энхрий шавь нартаа атгуулж чадав. Тэд бас багажаа ч, аргаа ч улам бүр сайжруулсаар байжээ. Үүний дүнд цаг үе нь төвшин амгалан, зон олон нь баяр цэнгэлтэй болсоор Монгол улс цэцэглэн мандаж, бултаараааар сайхандаа жаргажээ.

*Н.Нэргүй, БСШУЯ, 2003. Бага, дунд боловсролын стандартын ерөнхий зөвлөмж. хууд.10 ба 49.*

### Стандарт ба киррикулим хоорондын шүтэлцээ

Дээрх шийдлийн тогтолцоонд тулгуурлан стандарт ба киррикулимийн хоорондох харилцан хамаарал, шүтэлцээг дараах байдлаар тодорхойлсон байна.

Боловсролын стандарт нь нийгмийн хөгжлийн захиалга, хувь хүний хэрэгцээг хангахуйц боловсролын үйлчилгээний чанарын түвшинг тогтоохын тулд боловсролын тухайн түвшин ба шатлал, боловсролын агуулгын тухайн чиглэл бүрийн зорилго, агуулга, арга зүйн үндэс, орчин нөхцөл, үнэлгээнд бүхэлд нь зайлшгүй тавигдах наад захын шаардлагын тогтолцоо болон түүнийг хөгжих үйл явцын үндсийг хэмжээсжүүлэн тодорхойлсон норматив баримт бичиг; боловсролын киррикулимнь боловсролын стандартад нийцүүлэн өөрийн улс болон хүн төрөлхтний соёлын дэвшилтэт үнэт зүйлсийг иргэддээ эзэмшүүлэхээр тусгай зөвлөмжийн дагуу сургууль, багш нараас сонгосон тодорхой зорилго, агуулга, арга зүй, орчин, үнэлгээ бүхий сургалтын үйл ажиллагааны тогтолцооны удирдамж баримт бичиг мөн. “Боловсролын стандарт нь боловсролын аливаа киррикулимийн чанарыг үнэлэн түүнийг хөгжилд хөтөлж чадахуйцаар бүтээгдэж, харин боловсролын киррикулим нь стандартаар чанараа үнэлүүлэн хөгжсөөр байхаар боловсрогдож байна.” (БСШУЯ, 2003, хууд. 14)

Өөрөөр хэлбэл, боловсролтой иргэний төлөвшлийн захиалга (загвар) нь стандарт ба сургалтын хөтөлбөрийн хөгжлөөр тодорхойлогдох бөгөөд харин стандарт, сургалтын хөтөлбөрийн хоорондох шүтэлцээ нь боловсролын хөгжлийн дотоод механизмыг тодорхойлно. Өөрөөр хэлбэл,

стандарт нь боловсролын эрэлтийг, сургалтын хөтөлбөр нь түүний нийлүүлэлтийг тус тус илэрхийлж (БСШУЯ, 2002), энэхүү эрэлт нийлүүлэлтийн харилцаа нь тэдгээрийн харилцан үнэлэх, үнэлэгдэх зарчмаар тодорхойлогдоно (БСШУЯ, 2003). Энэ нь хэдий чинээ эрэлт нэмэгдэнэ, төдийчинээ боловсролын чанар дээшилж, нийлүүлэлтийн үнэ цэнэ нэмэгдэнэ гэж үзсэн байна.

Зураг 1.2.4. Стандарт, киррикулум хоорондын шүтэлцээ



Эх сурвалж: Агуулгын стандартыг боловсролын стандарт болгоход хийгдсэн өөрчлөлтүүд (БСШУЯ, 2003)

Цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг бүтээсэн цогц шийдлээс түүний шинж чанар, онцлог талууд урган гарах бөгөөд түүний хамгийн ерөнхий бүхлийн шинж нь дараах 3 өөрчлөлтөөр тодорхойлогдоно.

- Зөвхөн агуулгыг тодорхойлсон стандартаас боловсролын зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ зэрэг киррикулум тогтолцооны бүх элементийг хамарсан боловсролын стандарт болж, бүрэлдэхүүнийхээ хувьд өргөжиж томорсон.
- Судлагдахуунд суурилсан (subject based) стандартаас цогц чадамжид суурилсан (competence based) стандарт болж, бага дунд боловсролын дэд түвшин бүрийн хүлээгдэж буй үр дүн, зорилго, агуулгынхаа хувьд интеграцилагдан тус бүрийнх нь дидактик нэгж нь томорч эрэмбэ ахисан.
- Суралцагчид бүтээлч үйлээрээ шинэ мэдлэг бүтээх суралцахуйн конструктив онолын зарчмуудад суурилсан багшлахуйн арга зүйд дидактик (боловсролын философи, суралцахуйн сэтгэл судлал, эпистомологи, социологи, антропологи, менежментийн ухааны интеграц)-ийн болон боловсролын чанар, нийц, тэгш боломж, үл алагчлах шударга байдал зэрэг зарчмуудыг чухалчилсан.

Ийнхүү боловсролын шинэ стандартад бага, дунд боловсролын түвшинд судлах агуулгын бүх чиглэл буюу бүх хичээл нь зорилго, зорилтынхоо түвшинд амин холбоотой болсноор хичээл хоорондын холбоог хангах чиглэлээр явуулсан олон жилийн үйл ажиллагаа бодитоор хэрэгжих үндсэн нөхцөлийн нэг хангагдсан байна.

Агуулгын стандартыг боловсролын стандарт болгон шинэчлэхэд хийгдсэн өөрчлөлтийн харьцуулалтыг дээр дурдсан эх сурвалжаас дэлгэрүүлэн үзэх боломжтой.

Стандартчилал Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн 2004 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Сургуулийн өмнөх, бага, суурь, дунд боловсролын стандарт”-ыг 2005 оны 1 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн байна. Холбогдох хуулийн дагуу энэхүү стандартад 2009 онд анхны үнэлгээ хийгдэж, боловсролын стандарт, түүний хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгч, дүгнэлт гарган, цаашид сайжруулахтай холбогдсон санал, зөвлөмж гаргажээ (БСШУЯ, 2009).

Тус үнэлгээний нэгдсэн тайланд бичсэн стандартын боловсруулалт ба түүний хэрэгжилттэй холбоотой нийт 12 дүгнэлтийн 1/3 хэсэг нь стандартын боловсруулалттай, үлдсэн хэсэг нь түүнийг хэрэгжүүлэх менежменттэй холбоотой дүгнэлт эзэлж байна. Мөн тэдгээр дүгнэлтэд үндэслэн стандартыг хэрэгжилтийн зохицуулах ба стандартын боловсруулалтыг сайжруулах гэсэн хоёр чиглэлээр тус бүр 5 зүйлийг зөвлөмжилжээ.

Монгол Улсын ЗГ-ын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний “Эрдэм боловсролтой Монгол хүн” гэсэн 3 дахь бүлэгт “Ерөнхий боловсролын сургалтад хүүхэд бүрийг хөгжүүлэх бодлого баримтлан, үндэсний шинэ стандарт нэвтрүүлэх,” гэсэн шинэчлэлийн хүрээнд “Эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн “Зөв монгол хүүхэд” хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг, сургуулийн насны хүүхдүүдийг монгол бахархалтай, үндэсний соёл уламжлалыг дээдэлсэн иргэн болгон хүмүүжих нөхцөлийг агуулсан сургалтын стандарттай болох” (ЗГ, 2012) гэсэн үйл ажиллагааг тусгасан байна. Энд дурдагдсан “үндэсний шинэ стандарт” ба “сургалтын стандарт” одоогоор боловсрогдоогүй байна.

### Сургалтын хөтөлбөрүүд

Монгол Улсын хэмжээнд 2004 оноос мөрдөж эхэлсэн цогц чадамжид суурилсан боловсролын стандартад боловсролын хэрэгцээ, агуулга, үнэлгээний хүлээгдэж буй үр дүнгүүдийн зэрэгцээ багшлахуй, суралцахуйн арга зүйн зарчмууд тодорхойлогдож, сургууль багш нар түүнд нийцсэн кирриклиомууд боловсруулах ажил өрнөжээ. Сургууль, багш нарын кирриклиом боловсруулах үйл ажиллагаа нь бэрхшээлтэй, хүнд хэцүү ажил байсан боловч Монгол Улсад багшлах арга зүйг шинэчлэхэд тойрч болохгүй зайлшгүй туулж гарах ёстой үүрэг хариуцлагын том сорилт болсон байна. Энэ ажлыг гүйцэтгэхэд үндэсний болон орон нутаг, сургуулийн түвшинд захиргааны менежментээр хангагдаж байсан боловч, сургалтын технологийн болон мэргэжил, арга зүйн менежмент аль ч түвшиндээ дутагдалтай байсан явдал нь багшлах арга зүйн шинэчлэлийн хүлээгдэж буй үр дүнд буюу суралцахуйн арга зүйн хөгжилд бүрэн дүүрэн хүргэж чадаагүй байгаа бөгөөд энэ байдал одоо ч үргэлжилсээр байна.

Үүнийг БСШУЯ-аас 2009 онд хийсэн Бага, дунд боловсролын стандартын үнэлгээний тайланд дурдсан "... үндэсний хэмжээнд батлан мөрдөж байгаа стандарт болон түүнийг хэрэгжүүлэхээр сургуулиудад хэрэгжүүлж буй хөтөлбөрийн агуулгууд хоорондоо тохирохгүй байна" гэсэн дүгнэлтээс харж болно.


### Сургалтын үндэсний хөтөлбөрүүд

Боловсролын эрэлт болох стандарт ба боловсролын нийлүүлэлт болох кирриклиом хоорондын тохирцын дээрх зөрөөг багасгах, арилгах түүнчлэн сургууль, багш нарт ногдоод байсан чадавхаас нь хэтэрсэн ачааллыг бууруулахын тулд боловсролын түвшингээр тодорхойлсон шаардлагуудыг анги, хичээл бүрээр тусгайлан тодорхойлсон сургалтын үндэсний хөтөлбөр<sup>7</sup> (кирриклиом) боловсруулах шийдвэрийг БСШУЯ-аас 2007 онд гаргасан байна. Энэ шийдвэрээр ЕБС-ийн сургалтыг 12 жилд шилжүүлэх графикайн дагуу сургалтын үндэсний хөтөлбөр боловсруулж, сургалтад нийлүүлэх ажлын хэсгийг нийт 13 баг, 237 (давхардсан тоогоор) хүний бүрэлдэхүүнтэйгээр баталжээ. Ийнхүү 2014-2015 оны хичээлийн жилд багтаан ЕБС-ийн сургалтыг 12 жилд шилжих шилжилтийг дуусгаж, бүх анги, хичээл бүрээр сургалтын үндэсний хөтөлбөртэй болгож, тэдгээрт нийцсэн сурах бичгээр хичээллэдэг болох зорилт дэвшигдсэн байна.

Шинэ стандартыг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүрээр боловсруулсан бол үндэсний хөтөлбөрүүдийг анги болон бүлэг сэдвүүдээр хүлээгдэж буй үр дүн, эзэмших агуулга, суралцах үйл ажиллагааны үндсэн төрөл ба хэлбэр, сургалтын арга зүй, бүлэг бүрийн хүлээгдэж буй үр дүнг үнэлэх үнэлгээний индикаторууд гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэйгээр суралцагчийн нас ба сэтгэцийн онцлог, боловсролын түвшин ба анги хоорондын залгамж холбоотойгоор боловсруулжээ.

Бага, дунд боловсролын сургалтын үндэсний хөтөлбөр нь бүх анги, бүх хичээлийн хувьд дараах ерөнхий бүтэцтэй байна гэж үзжээ (БОНХАЖЯ, ШХА, 2015).

Зураг 1.2.5. Сургалтын үндэсний хөтөлбөрүүдийн инвариант бүтэц (2008-2012)



<sup>7</sup>Боловсролын “стандарт”-ад суурилсан шинэчлэлийг хийхдээ олон улс дахь “curriculum” гэсэн ойлголт ухагдахууны агуулга нь хичээлийн “программ” гэдэг өмнөх ойлголт, ухагдахууны агуулгаас ялгаатай болохыг салбарын хэмжээнд шинээр таниулахын тулд боловсролын бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдэд “кирриклиом” хэмээн галигдан хэрэглэж байгаад 2007 оноос “сургалтын хөтөлбөр” гэсэн нэр томъёог хэрэглэх болсон.

## Сургалтын цөм хөтөлбөрүүд

Дээр дурдсан сургалтын үндэсний хөтөлбөрүүдийг “сургалтын цөм хөтөлбөр” нэрээр дахин шинэчилж, бага боловсролын цөм хөтөлбөрийг 2014-2015 оны, суурь боловсролын цөм хөтөлбөрийг 2015-2016 оны, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг 2016-2018 оны хичээлийн жилээс эхлэн үндэсний хэмжээнд тус тус хэрэгжүүлж эхэлсэн байна.

ЮНЕСКО-оос 2013 онд гаргасан хүүхэд бүрд ямар суралцахуй хэрэгтэйг боловсролын шатлалаар тоймлон гарсан судалгаа (Toward Universal Learning: What Every Child Should Learn)-ны тайлангийн үр дүн болон “цөм хөтөлбөр”-ийн талаар судлаачдын тодорхойлолтод тус тус үндэслэн “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр нь өсвөр үеийнхнийг өөртөө итгэлтэй, шийдвэр гаргах, хамтран ажиллаж амьдрах, насан туршдаа суралцах чадвартай, бие бялдар, оюун сэтгэхүй, ёс суртахууны төлөвшилтэй үндэсний хэл, соёл, ёс уламжлалаа эрхэмлэдэг иргэн болж хөгжихөд эцэг эх, төрийн үүрэг, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг тодорхойлж, “Нийт хүүхэд” гэсэн ойлголтоос “Хүүхэд бүрийн хөгжил” гэсэн зорилгыг дэвшүүлсэн.

2013 оноос эхэлсэн “Хүүхэд бүрийг хөгжүүлэх” боловсролын шинэчлэлийн бодлогын хүрээнд бага, дунд боловсролын шинэчлэлийн менежментийг хэрэгжүүлэхээр БШУ-ны Сайдын 2013 оны 155 тоот тушаалаар дараах асуудлуудыг шийдвэрлэжээ. Үүнд:

- Бага, дунд боловсролын шинэчлэлийн ерөнхий зураглалыг батлах
- Бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалыг батлах
- Бага, дунд боловсролын үндэсний стандарт, хөтөлбөр шинэчлэх, Боловсролын үнэлгээ, Багшийн мэргэжил дээшлүүлэх, Сурах бичиг, сургалтын орчин, Боловсролын байгууллагын чадавхыг дээшлүүлэх асуудлаар үзэл баримтлал, бодлого чиглэл боловсруулах багийн бүрэлдэхүүн (147 хүнтэй, 19 баг)-ийг батлах
- Багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөр шинэчлэх багийн ахлагчдын бүрэлдэхүүнийг батлах

Гэвч энэ шинэчлэл нь батлагдсан графикайн дагуу явагдаагүй бөгөөд үндэсний стандарт, хөтөлбөр, сурах бичиг, багшийн мэргэжил дээшлүүлэх, байгууллагын чадавхыг дээшлүүлэх талаар баримтлах, бодлого, чиглэлийг боловсруулан баталсан албан ёсны эх сурвалжууд олдохгүй байна. Түүнчлэн өмнө бүх ангийн бүх хичээлээр боловсруулан баталж, сургалтад мөрдөж байсан үндэсний хөтөлбөрүүд, тэдгээрийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт гаргах гаргах судалгаа хийгдсэн эсэх нь тодорхойгүй, хийгдсэн бол судалгааны тайлан, холбогдох мэдээлэл, албан эх сурвалжаас олдохгүй байна. Иймд өмнөх хөтөлбөрүүдийг шинэчлэх үндэслэл болон үзэл баримтлал, онол, арга зүйн шийдлийг тодорхойлон томъёолсон баримт бичиг боловсрогдон батлагдаагүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Иймд энэхүү судалгааны хүрээнд 2013 оноос эхэлсэн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн онол, арга зүйн шийдлийн талаар харьцуулсан дүгнэлт өгөх боломжгүй байлаа.

Бага, ба суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг тухайн түвшинд хамаарах ерөнхий хэсэг болон анги бүрээр тодорхойлсон хичээлүүдийн цөм агуулга гэсэн үндсэн 2 хэсэгтэй гэж үзэж болно. Эхний ерөнхий хэсэг нь нийтлэг үндэслэл, хөтөлбөрийн зарчим, зорилго, зорилт, хөтөлбөр хэрэгжүүлэх зохион байгуулалт, хэрэгжилтийн үнэлгээ гэсэн бүтэцтэй бол цөм агуулгын хэсэг нь сургалт ба сургалтыг дэмжих үйл ажиллагаа гэсэн хоёр дэд хэсэгтэй байна.

Зураг 1.2.6. Бага ба суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн ерөнхий бүтэц (2014-2016)



Бага ба суурь боловсролын цөм хөтөлбөрийн “Сургалт” ба “Сургалтыг дэмжих үйл ажиллагаа” нь дараах дэд бүтцүүдтэй.

Зураг 1.2.7. Сургалтын цөм хөтөлбөрийн агуулгын бүтэц



Эх сурвалж: (БОНХАЖЯ, ШХА, ТТУ, 2015)

Бага боловсролын цөм хөтөлбөрийг боловсруулах, экспертиз хийх, захиалагч тал хүлээн авахад тавигдах шалгуур үзүүлэлт батлагдан гараагүй бөгөөд суурь боловсролын цөм хөтөлбөрийг боловсруулах, магадлан шинжлэхэд тавигдах шаардлагыг яамнаас батлан гаргажээ.

Харин бүрэн дунд боловсролын хөтөлбөрийг боловсруулахад баримтлах бодлого боловсруулах судалгаа 2013 оноос хийгдэж эхэлсэн бөгөөд БСШУ-ны Сайдын 2016 оны А/275 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар “Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын талаар баримтлах бодлого”-ыг баталсан байна (БСШУЯ, 2016). Уг бодлогод “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)”-д Бүрэн дунд боловсролын **зорилго**: Сонголттой, уян хатан хөтөлбөрөөр мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах чадвар бүхий ирээдүйд эзэмших, мэргэжлийн суурь баримжаа олгох үе”; Боловсролын тухай хуульд “оюун ухаан, ёс суртхуунбие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэх; Бага, дунд боловсролын тухай хуульд “мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадвартай иргэн төлөвшүүлэх” гэж тодорхойлсон заалтуудыг тус тус үндэслэл болгож, ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөрүүдийг товлосон тодорхой **зорилготой** дараах 3 төрлийн **агуулга** бүхий ерөнхий **бүтэцтэй** байхаар тогтоожээ. Үүнд:

- **Заавал судлах цөм хөтөлбөрийн** зорилго нь сурагчид шинжлэх ухааны үндэс, судалгааны аргыг эзэмшүүлэх, иргэний болон нийгмийн үнэт зүйл, бие даан суралцах, бүтээлчээр насан туршдаа суралцах хандлага, чадвартай болгох (8 хичээл, судлах нийт цагийн 48%)
- **Заавал сонгон судлах хөтөлбөрийн** зорилго нь тухайн суралцагчийг цаашид ямар ч төрөл салбараар мэргэшиж суралцахаас үл хамааран хувь хүний хөгжил, иргэн болж төлөвшихөд шаардлагатай ур чадварыг эзэмшүүлэх болгох (5/6 хичээл, судлах нийт цагийн 25%)
- **Сонгон гүнзгийрүүлж судлах цөм хөтөлбөрийн** зорилго нь сурагчид шинжлэх ухааныг гүнзгийрүүлэн судалж суралцах, ажил мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлж суралцах, өөрийн сонирхсон, сонгосон чиглэлээр авьяас, давуу тал, чадварыг хөгжүүлэх болгох (15 хичээл, судлах нийт цагийн 27%)

Дээрх гурван төрлийн хөтөлбөр бүрийг зорилго, зорилт, агуулга, арга зүй, үнэлгээ гэсэн ижил бүтэцтэйгээр боловсруулсан байна. Мөн бүрэн дунд ба дээд боловсролын залгамж холбоог хангахыг зорьж сонгон гүнзгийрүүлж судлах цөм хөтөлбөрийг кредитийн тогтолцоонд шилжүүлэхээр шийдвэрлэжээ.

Монгол Улсын газар нутагт сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа Монгол иргэдийн хүүхдүүд суралцдаг ерөнхий боловсролын бүх сургуулиуд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр сургалтын цөм



хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй бөгөөд бүх суралцагч нь анги дэвших, сургууль төгсөх улсын шалгалтууд өгдөг журамтай. Эдгээр сургуулиуд цөм хөтөлбөрийн зэрэгцээ олон улсын сургалтын хөтөлбөрүүдийг гадаад хэл дээр хэрэгжүүлдэг бөгөөд сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллагаасаа олон улсын хөтөлбөртөө зөвшөөрөл авдаг. Энэ нь хэдийгээр хүүхдийн боловсрол эзэмших, сонгох эрхийг хангаж байгаа боловч нөгөө талдаа “дотоодод суралцаж буй Монгол гадаад суралцагчид”-д тохиолдох эх хэл, өв соёлоо эзэмших боломжоор алагчилагдах, эх орондоо суралцаж, ажиллаж, амьдрах боломжоор тодорхой хэмжээнд хязгаарлагдах эрсдэлийг дагуулах болсон.

### Сургалтын төлөвлөгөөнүүд

Бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрүүдэд туссан үзэл санаа, бодлого болон агуулга, арга зүйг анги танхимын түвшинд хэрэгжүүлэх гол арга хэрэгсэл нь сургалтын төлөвлөгөө байдаг. Сургалтын төлөвлөгөө нь хэдийгээр 1-3 нүүр төдий баримт бичиг боловч сургалтад шаардлагатай хүний нөөцийн, санхүүгийн, цаг хугацааны, материаллаг бүхий л нөөцийг оновчтой зөв хуваарилан төлөвлөх, нөөцийн ашиглалтыг хянах, сургалтыг эзэмшихүйн зүй тогтолд нийцүүлэн явуулах зэрэг сургалтын менежментийн эрх зүйн гол үндэслэл болж, “боловсролын үйлдвэрлэлийн процесс эхлэхийг зөвшөөрсөн тамга”-ын зориулалттай баримт бичиг юм.

Энэхүү тайланд сургалтын төлөвлөгөөний зөвхөн агуулгын бүтцийг тоймлон авч үзсэн болно.

1992 оноос эхлэн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай багц хуульд тодорхойлсон зорилгын дагуу сургалтын төлөвлөгөөний агуулгыг тогтвортой буюу нийтээрээ заавал судлах болон хувьсах буюу сургууль, сурагчид сонгон судлах гэсэн үндсэн 2 хэсэгтэй болгох шаардлага гарчээ.

Энэ шаардлагын дагуу Гэгээрлийн сайдын 1998 оны 100 дугаар тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөнөөс эхлэн өнөөг хүртэл сургалтын төлөвлөгөөнд нийт 21 удаа өөрчлөлт орсон боловч сургалтын төлөвлөгөөний энэ үндсэн 2 хэсэг тухайн цаг үеийнхээ онцлогийг тусган өөр өөр нэртэйгээр хадгалагдаж ирсэн байна (Хавсралт 1.2.4).

1998 оноос хойших хугацаанд сургалтын хөтөлбөрт 3 үе шаттайгаар өөрчлөлт хийгдсэн бөгөөд тэдгээр өөрчлөлт бүр дэх шинэчлэлийн бодлогыг тусгасан нийтлэг онцлогууд байсан байна. (Хүснэгт 1.2.5)

Хүснэгт 1.2.5. Сургалтын төлөвлөгөөний хөгжлийн үе шатууд, тэдгээрийн онцлог (1998-2018)

1998 - 2007	<p><b>БДБ-ын агуулгын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө</b> (Сайдын 1998 оны 100-р тушаалын 1 ба 2 дугаар Хавсралтууд)</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын агуулгыг анх удаа нээлттэй, сонголттой болгосон.</li> <li>• Иргэний, ардчилсан, хүмүүнлэг нийгмийн үнэт зүйлс, зах зээлийн эдийн засаг, хүрээлэн буй орчны асуудлыг сургалтын агуулгад даруй тусгах шаардлагын дагуу төслүүдийн хүрээнд тусгай модулууд боловсруулан заавал сонгон судлах хичээл хэлбэрээр оруулж эхэлсэн.</li> <li>• Сургалтын энэ төлөвлөгөө хамгийн удаан буюу 9 жилийн турш тогтвортой мөрдөгдсөн онцлогтой.</li> </ul>
2008 - 2014	<p><b>Цогц чадамжид суурилсан Үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнүүд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• 6 ба 7 настай хүүхдийг сургуульд элсүүлж, ЕБС-ийн сургалтыг 11 ба 12 жилийн сургалтад шилжүүлэх графикийн дагуу жилд 2 ангийг шинэ тогтолцоонд шилжүүлсэн.</li> <li>• Сургалтын төлөвлөгөөнүүд нь дээрх графикийн дагуу боловсруулсан сургалтын үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн.</li> <li>• Энэ хугацаанд сургуульд суралцах хугацаа 11 ба 12 жилд шилжих шилжилт явагдаж байсан.</li> <li>• Мөн сургуулийн бүтэц 5-4-2 гэсэн бүтцээс 5-4-3 гэсэн бүтцээр өөрчлөгдөж байсан</li> <li>• Сургалтын төлөвлөгөөнүүд хувилбартай гарч байсан нь сайн муу 2 талтай байв,</li> </ul>
2014 - 2018	<p><b>Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнүүд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хүүхэд бүрийг хөгжүүлэх шинэчлэлийн бодлогын хүрээнд үндэсний хөтөлбөрүүдийг цөм хөтөлбөр болгон шинэчилж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд бага, суурь, бүрэн дунд гэсэн 3 үе шатны онцлогтой сургалтын төлөвлөгөөнүүд боловсруулж, хэд хэдэн удаа тэдгээрийг өөрчилсөн</li> <li>• Хөдөөгийн цөөхөн сурагчидтай сургуулиудын ахлах ангид бүлэг дүүргэлт хүрэхгүйн улмаас сонгох хичээлүүд заагдах боломжгүй болсон тул олон суралцагчидтай (хот суурингийн) болон цөөн суралцагчидтай (хөдөөгийн) сургуулиудад зориулсан сургалтын</li> </ul>

	<p>төлөвлөгөөний 2 хувилбар зэрэгцэн мөрдөгдөж байгаад 2018 оны А/453 дугаар тушаалаар нэг хувилбарт болсон байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Өмнө нь сургалтын хөтөлбөр, хичээлээс гадуурх үйл ажиллагааны хөтөлбөр гэж 2 тусдаа байсан хөтөлбөрийг нэгтгэж, сургуулиас зохицуулах агуулгыг өргөжүүлсэн.</li> <li>• Үндэсний цөөнх, тусгай хэрэгцээт боловсрол эзэмшүүлэх сургалтын төлөвлөгөөг нэг тушаалаар баталсан нь тэдгээрийг харьцуулах боломж олгосон.</li> <li>• Эрүүл мэндийн хичээл анх 1998 онд сургалтын төлөвлөгөөнд сонгох агуулгаар эхэлж ороод 2004 оноос тогтвортой агуулгад шилжсэн байсныг 2015 онд сургалтын төлөвлөгөөнөөс хасаж, дараа нь 2018 оноос амьдрах чадварын хичээлийн цагийг ашиглан бие даасан хичээл хэлбэрээр заахаар дахин нэмж оруулжээ.</li> </ul>
<p>2004-2018 оны хооронд сургалтын төлөвлөгөө нийт 21 удаагийн шийдвэрээр өөрчлөгдсөн</p>	

Сургалтын төлөвлөгөөнүүдийн агуулгын бүтцийн харьцуулалт, тэдгээрийн шинэчлэлийн үе шат бүрийн онцлогоос харахад ТХБ-ыг эхлээд заавал сонгон судлах экологи, эрүүл мэнд, эдийн засаг, эрх зүйн хичээлийн агуулга, арга зүйгээр дамжуулан оруулж, цаашдаа тогтвортой агуулгын хичээлүүдэд ТХБ-ын цогц чадамжуудыг интеграцилах, сургуулиас зохицуулах агуулгын хүрээнд эзэмшсэн мэдлэг чадвараа тухайн орон нутгийн байгаль цаг уур, эрхлэх аж ахуй эдийн засаг, нийгэм, соёлын хам нөхцөлтэй холбоотой болон сургуулийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хэрэглэх боломжийг суралцагчдад олгож, ТХ-ийн үйл хэрэгт тэдний оролцоог хангах бодлого зохих ёсоор тусгалаа олж иржээ гэж үзэхээр байна.

Сургуулиас зохицуулах боломжтой, сонгох агуулгын хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны агуулга, арга зүйг боловсруулахад Монгол Улсад өнгөрсөн хугацаанд байгаль орчин, эрүүл мэндийн шинэ хичээлүүдийг бий болгох, багшлахуйн арга зүйг дэмжих олон тооны хөтөлбөр төслүүд үнэтэй хувь нэмэр оруулсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Энэ талаар БОНХАЖЯ-аас 2015 хийлгэсэн суурь судалгааны тайлангийн 4.3 бүлгийн “Хамтын ажиллагаа ба түншлэл” (БОНХАЖЯ, ШХА, 2015) хэсэгт тодорхой өгүүлсэн байна.

### Сурах бичгийн хангамжийн бодлого

Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн талаарх бодлого/чиглэл, авч хэрэгжүүлэх арга хэмжээг дараах баримт бичгүүдэд тусгасан байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль (2002 оны, түүнд 2006, 2012, 2015 онд нэмэлт өөрчлөлт оруулсан)-д *“цэцэрлэг, бүх шатны сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, мэргэжил, арга зүйн байгууллагыг зориулалтын ... хичээлийн хэрэглэгдэхүүн, ном, сурах бичгээр хангах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах (28.1.7)”* гэж боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд заасан бол Бага, дунд боловсролын тухай хууль (2002)-д *“... сурах бичиг нь боловсролын стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна (8.1)”*, *“...сурах бичиг зохиох, хэвлүүлэх, түгээх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу зохион байгуулна (8.2)”* гэж тус тус заажээ.
- “Бага, дунд боловсролын сурах бичгийн талаар баримтлах чиглэл (1998)”-д сурах бичиг хангамжийн (бэлтгэх, хэвлэх, хадгалах, сурталчлах, борлуулах, хуваарилах, түгээх) шинэ тогтолцоо бий болгоход баримтлах чиглэлийг тодорхойлсон байна.
- “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого (2006)”-д *“... сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, арга зүйг нээлттэй, хувилбартай, сонголттой болгох зарчмыг баримтлан шинэчлэн хөгжүүлнэ”* гэсэн бодлогыг тодорхойлогджээ.
- “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021)-т *“үндэсний хэмжээнд бага, дунд сургуулийн сурах бичгийн чанарын судалгаа хийж, суралцагчдыг стандартын шаардлага хангасан сурах бичгээр хангана”* гэсэн зорилт дэвшүүлжээ.
- Монгол Улсын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ” (3.2.10.) гэсэн зорилгыг дэвшүүлсэн байна.
- Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд заасан ЕБС-д сурч буй эмзэг бүлгийн сурагчдад хичээлийн сурах бичгийг үнэ төлбөргүйгээр хэрэглүүлнэ гэсэн зорилт дэвшүүлсэн. Энэ зорилтын хүрээнд ЗГ-ын шийдвэрээр 2009 оноос эхлэн ЕБС-ийн бага ангийн бүх сурагчдад, дунд ахлах ангийн сурагчдын 40 хувьд сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан үнэ төлбөргүй хэрэглүүлэх ажлыг зохион байгуулж (Монгол улсын Засгийн газрын 28 дугаар тэмдэглэл, 2009), бага ангид хүүхэд бүрийн сурах бичгийг төрөөс хариуцаж, дунд, ахлах ангийн бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, амьжиргааны

баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн болон ЕБС-д 3 буюу түүнээс дээш хүүхэд нь суралцдаг өрхийн хүүхдийн сурах бичгийг үнэ төлбөргүйгээр хангаж байна.

ЕБС-ийн сургалтад улсын хэмжээнд нэг ижил (үндсэн) сурах бичгийг хэрэглэх, сурагч бүр судлах хичээл тус бүрээр сурах бичигтэй байх, үндэсний цөөнх (казах иргэдийн хүүхэд)-ийг эх хэл дээр нь хэвлэсэн бага ангийн сурах бичгээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт нийцсэн сурах бичгээр хангах, сурах бичгийг зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, зорилтот бүлэгт зориулан хэвлэн нийлүүлэхтэй холбоотой бүхий л зардлыг төр хариуцах, сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэлбэрийг нэвтрүүлэх бодлогыг тус тус баримталж байна.

### **Бага, дунд боловсролын сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандарт**

Улсын хэмжээнд 1990-ээд оноос номын болон сурах бичиг хангамжийн төвлөрсөн сүлжээ задарч, зах зээлийн харилцаанд нийцсэн шинэ тогтолцоо үүсэх үйл явц эхэлсэн ч өнөөг хүртэл энэ үйл явц үргэлжилсээр байна. Өнгөрсөн хугацаанд сурах бичиг хангамжийн талаар баримтлах чиглэлийг 1998, 2000, 2009 онд 3 удаа боловсруулан баталжээ. Эдгээр баримт бичигт сурах бичгийг хувилбартай болгон сургууль багш нарт сонгох боломж бүрдүүлэх, хэвлэн нийтлэлийн газрыг бий болгох, сурах бичиг хэвлэх ажиллагааг нээлттэй болгон өрсөлдүүлэх, сурах бичгийн агуулга арга зүйг боловсронгуй болгох талаар тодорхойлсон бодлогыг хэрэгжүүлэх зориулалттай журмууд нь эдгээр бодлого бүрэн хэрэгжих боломж олгоогүйг 2004 онд БСШУЯ-аас сурах бичгийн хангамжийн талаар явуулсан судалгаанд дурдсан байна (БСШУЯ, БХХ, 2004).

Иймд нэг талаас, дээрх судалгааны үр дүн, дүгнэлт нөгөө талаас, цогц чадамжид суурилсан боловсролын стандартад нийцсэн сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн арга зүй, үнэлгээг бүхэлд нь тогтолцоогоор нь өөрчлөх хэрэгцээг тус тус үндэслэн БСШУЯ-аас “Сурах бичгийн арга зүй, менежментийг боловсронгуй болгох” чиглэлээр захиалгат ажил (БСШУ-ны Сайдын 280 дугаар тушаал, 2004) гүйцэтгүүлж, уг ажлыг АХБ-ны “Боловсролын хөгжлийн хөтөлбөр-2”-оос санхүүжүүлсэн байна. Энэхүү захиалгат ажлын хүрээнд 5 төрлийн судалгаа хийгдэж, тэдгээрийн үр дүнд дараах багц бүтээгдэхүүн нийлүүлэгджээ. Үүнд:

- Сурах бичгийн хөгжлийн үзэл баримтлалын төсөл
- Бага, дунд боловсролын сурах бичиг хангамжийн бодлогын төсөл
- Бага, дунд боловсролын сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандарт
- Сурах бичгийн шинэ стандартын дагуу зохиосон туршилтын 3 сурах бичиг
- Сурах бичгийн хэвлэн нийтлэл, үнэлгээ, сурах бичгийн Зөвлөлийн журмын төслүүд

Цогц чадамжид суурилсан боловсролын стандарт болон нээлттэй киррикулимийн үзэл санааг хэрэгжүүлэхийн тулд төрийн оролцоо давамгайлсан сурах бичиг хангамжийн тогтолцоог шинэчлэх шаардлага бий болсон байна. Энэ шаардлагын дагуу БСШУЯ-аас 2005 онд бага, дунд боловсролын сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандарт болон сурах бичиг зохиох, хэвлэх, сонгох, түгээх журмыг боловсруулан баталжээ. Сурах бичгийн эрх зүйн орчинг шинэчлэхдээ сурах бичгийн хөгжил нь нэг талаас, цогц чадамж төвтэй боловсролын стандартад суурилсан нээлттэй киррикулимийн хөгжлөөр илэрхийлэгдэх эрэлт хэрэгцээ нөгөө талаас, стандартад суурилсан, хэвлэн нийтлэл төвтэй, сурах бичиг хангамжийн тогтвортой, хүртээмжтэй, сонголттой, нээлттэй тогтолцоогоор хангагдах нийлүүдэлт хоёрын харилцан шүтэлцлээр тодорхойлогдоно гэдгийг өөрчлөлт шинэчлэлийн гол бодлого болгон тодорхойлсон байна.

Бага, дунд боловсролын шинэ стандартыг хэрэгжүүлэхэд хэрэглэх сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандартыг (Стандарт, хэмжил зүйн газар, 2008) Стандартчилал, хэмжилзүйн төвөөр баталгаажуулж, 2005 оноос мөрдөж эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл энэ стандарт зарчмын өөрчлөлтгүйгээр мөрдөгдсөөр байна. Сурах бичгийн энэхүү стандарт нь бага, дунд боловсролыг албан болон албан бус арга замаар эзэмшигчдэд хэрэглэх сурагчийн хэвлэмэл сурах бичгийг зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, хэвлэлийн эхэд болон бэлэн болсон сурах бичигт үнэлгээ өгөх үйл ажиллагааг явуулахад баримтлах нийтлэг болон тусгай шаардлагуудыг тогтоож өгсөн норматив баримт бичиг юм. Уг стандартад “Сурах бичиг нь боловсролын стандарт ба киррикулимийг хэрэгжүүлэхийн тулд суралцахуй ба багшлахуйн нэгдлийг хангахад шаардлагатай онол, арга зүйн үндэс бүхий дидактик шийдлийг цогцоор хэлбэржүүлсэн сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн мөн” гэж түүний зориулалтыг тодорхойлон зааж өгчээ.

Бага, дунд боловсролын стандарт ба сурагчийн сурах бичгийн стандарт (сурах бичгийн агуулга, арга зүйд тавигдах шаардлага) хоорондын харьцуулалтаас тэдгээрийн агуулгын тохирц нь хангалттай түвшинд байна хэмээн үзэж болно (Хавсралт 1.2.5).

Сурах бичиг хангамжийн талаар баримтлах бодлого 1998, 2000, 2009 онд 3 удаа, эдгээр бодлогыг хэрэгжүүлж, сурах бичиг зохиох, магадлан шинжлэх, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, түгээх, ашиглах харилцааг зохицуулсан журам 1998 оноос хойш 12 удаа өөрчлөгдсөн байна (Хавсралт 1.2.6).

Өөрөөр хэлбэл, сурах бичиг хангамжийн тогтвортой, оновчтой тогтолцоо өнөө хэр төлөвшиж чадаагүй байна.

Тухайлбал, Сайдын 2008 оны 22 дугаар тушаалаар сурах бичгийг хувилбаргүй буюу сонголтгүй болгосон бол Сайдын 2009 оны 62 дугаар тушаалаар хэвлэн нийтлэл төвтэй сурах бичиг хангамжийг тогтолцоог төрийн оролцоо давамгайлсан тогтолцоо болгон өөрчилжээ.

2013 оноос эхлэн сурах бичгийн чанарыг дээшлүүлэхийн тулд багш, судлаач, иргэн, эцэг эх, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий экспертийн багуудыг БСШУЯ-аас томилон ажиллуулж байгаа нь ТХБ-ын үзэл санааны дагуу боловсролын үйл хэрэгт сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах нэг чухал алхам болсон байна.

### Суралцахуйн орчны стандарт

Цэцэрлэг, ЕБС, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны А/253/251/173 дугаар “Норм, шаардлага батлах тухай” тушаалаар баталсан байна. Тус баримт бичигт дараах чиглэлийн шаардлагууд тодорхойлогджээ. Үүнд:

- Унд, ахуйн усны хангамжид тавигдах шаардлага
- Ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага
- Гар угаагуур болон шүршүүрт тавигдах шаардлага
- Ус, ариун цэвэр, эрүү ахуйн байгууламжийн засвар үйлчилгээнд тавигдах шаардлага
- Эрүүл ахуйн боловсрол, зан үйлийн өөрчлөлтөд тавигдах шаардлага
- Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлага
- Хатуу хог хаягдал, бохир усыг зайлуулах менежментэд тавигдах шаардлагыг нормчилж, стандартчилж өгсөн байна.

### 1.2.3. Хэрэгжилт, Үр дүн

#### 1.2.3.1. Хүртээмж, Оролцоо

##### Шийдвэр гаргалт ба удирдлага, зохион байгуулалт

Бага, дунд боловсролын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх бүтцийг авч үзвэл:

УИХ-ын түвшинд Монгол Улсын Их Хурал нь хууль тогтоох эрх мэдэл бүхий төрийн дээд байгууллага бөгөөд Нийгмийн Бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд бага, дунд боловсролын асуудал хамаарагдана.

Засгийн газрын түвшинд Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нь бага, дунд боловсролын асуудлыг хариуцаж байдаг.

Орон нутгийн түвшинд Аймаг, нийслэлийн Засаг дарга нар бага, дунд боловсролын үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах үүргийг Боловсролын тухай хуулийн дагуу хүлээж, харьяалах Засгийн газрын гишүүнтэй үр дүнгийн гэрээ байгуулан ажилладаг. Мөн аймаг, нийслэлийн түвшинд Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл урлагийн газар бага, дунд боловсролын талаарх төрөөс баримтлах бодлого эрх зүйн актыг хэрэгжүүлж, сургууль, цэцэрлэгийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг хүлээнэ.

Сум, дүүргийн түвшинд Засаг дарга нар төрөөс үзүүлэх боловсролын үйлчилгээг хүргэх үр дүнгийн гэрээг аймаг, нийслэлийн Засаг даргатай хийх бөгөөд түүнийг хэрэгжүүлэхдээ тухайн сум, дүүргийн цэцэрлэг, сургууль болон тухайн төрлийн үйлчилгээ явуулах эрх бүхий байгууллагын удирдлагатай үр дүнгийн гэрээ байгуулах замаар гүйцэтгүүлнэ. Нийслэлийн дүүргийн Засаг дарга нар өөрийн бүтцэд хамаарах Боловсролын хэлтсээр дамжуулан орон

нутгийн төрийн ба хувийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг өдөр тутмын удирдлагаар хангах үүргийг хүлээнэ.


“Боловсролын тухай” болон “Бага, дунд боловсролын тухай” хуульд зааснаар баг, хорооны Засаг дарга нь сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа өрх, хамран сургах тойргийн хүүхдийг хамруулах үүргийг хүлээнэ.

### Бага, дунд боловсролын тогтолцоо, сургуулийн бүтэц

Боловсролын тухай хуульд заасны дагуу бага, дунд боловсрол нь бага, суурь, бүрэн дунд гэсэн 3 шатлалтай. Эдгээр шатлалын боловсролыг бүхэлд нь эсвэл аль нэг болон хэд хэдэн шатлалын боловсрол эзэмшүүлдэг бүтэц, хэв шинжээрээ ялгаатай хэд хэдэн хувилбарын ЕБС-ууд байдаг.

Бага, дунд боловсролын тогтолцооны бүтэц нь ЕБС-д суралцах хугацаагаар тодорхойлогддог. ЕБС-ийн бүтэц нь дараах байдлаар (Зураг 1.2.8) өөрчлөгдөж ирсэн байна (ҮСХ, 2010) Тухайлбал,

Зураг 1.2.8. ЕБС-ийн суралцах хугацаа болон бүтцийн өөрчлөлт (1975-2015)



Бага, дунд боловсролын тухай хуульд хэд хэдэн удаа өөрчлөлт орж, сургуулийн бүтэц 5 удаа өөрчлөгдсөн ажээ (Хүснэгт 1.2.6).

#### Ерөнхий боловсролын сургууль (2004-2007)

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг 2004-2005 онд 11 (5+4+2) жилийн тогтолцоонд шилжүүлж эхэлсэн бөгөөд сургуульд элсэх насыг 7 болгож өөрчилж, бага, дунд боловсрол эзэмших хугацааг дэлхийн улс орнуудын жишигт дөхүүлэх чухал алхмыг эхлүүлсэн. Мөн хуульд оруулсан энэ удаагийн өөрчлөлтөөр ЕБС-д мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт явуулах, сургалтын байгууллагын ангилал, хэв шинж, тогтолцоог тодотгох, сургуулийн Удирдах зөвлөлийг Сургуулийн Зөвлөл болгон өөрчлөх, зарим албан тушаалтан, суралцагчийн нийгмийн баталгааг хангах заалтууд тусгагджээ.

#### Ерөнхий боловсролын сургууль (2008-2014)

УИХ-ын “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2006 оны 89-р тогтоол батлагдсанаар ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажил эхэлсэн. БСШУ-ны Сайдын “График батлах тухай” 2007 оны 405-р тушаалаар ЕБС-ийг 5 жилд багтаан 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Улмаар 2004-2005 оны хичээлийн жилд 11 жилийн сургуулийн 7 настай элссэн суралцагчид буюу 2008-2009 оны хичээлийн жилд V анги төгсөгчдийг 12 жилийн сургуулийн VII ангид дэвшүүлж, шилжилтийн хөтөлбөрөөр хичээллүүлэх замаар ЕБС-ийн сургалт хөтөлбөрийн хувьд 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлснээр эдгээр сурагчид 2014-2015 онд XII ангийг төгссөн байна.

(Суралцсан хугацаа 11 жил боловч V-VII анги руу шилжихдээ шилжилтийн хөтөлбөрөөр хичээллэж, XII ангийг төгссөн болно). Харин 2008-2009 оны хичээлийн жилд VI буюу түүнээс дээш ангийн сурагчид шилжилтэд хамрагдалгүйгээр 11 жилийн тогтолцоогоор XI анги төгссөн. Нөгөө талаар 2018-2019 оны хичээлийн жилд бүтэн 12 жил суралцсан анхны төгсөгчид төгсөлтөө хийж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Хүснэгт 1.2.6. Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлсэн график

Хичээлийн жил	Анги												Нийт суралцагч	Төлөв		
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII				
2002-2003 он	85156	54912	57235	60458	61629	58120	54394	50401	35746	29823	57		527931			
2003-2004 он	62047	60978	53707	55645	59901	61022	57698	53358	37274	35698	70		537398			
2004-2005 он	66863	58665	59502	52157	55208	58855	60169	56672	40734	37906	113		546844	10 жил		
2005-2006 он	10502			11 жилийн анхны элсэлт цэцэрлэгийн бүлэг									10502	11 жил	7 нас	
2005-2006 он	56190	27524	49120	57917	58871	51717	54756	58136	59159	43322	40078	86	550870	11 жил		
2006-2007 он	56806	53171	25859	46677	56749	56742	50265	53167	56731	43923	42359	56	542505	11 жил		
2007-2008 он	60331	54631	52290	25961	46450	55053	55836	48993	52361	42192	43383	65	537546	11 жил		
2008-2009 он	39946												129	40075	12 жил	6 нас
2008-2009 он	23742	57795	53596	51674	25851	45302	54247	54988	48320	35771	40697		491983	11 жил	7 нас	
2008-2009 он	50747	41423					25677						139	117986	12 жил	
2009-2010 он		21327	56614	52018	50937		44917	53624	54453	34485	34805		404080	11 жил		
2009-2010 он	46785	48941	40510				50388	25363					156	212143	12 жил	
2010-2011 он			21276	55978	52149			44183	52913	39981	33590		300070	11 жил		
2010-2011 он	46840	45397	48075	39228			51562	49523	24709				131	305465	12 жил	
2011-2012 он				21581	55463			43481	40235	39184			199944	11 жил		
2011-2012 он	48092	45410	44688	47524	38550		55398	50983	48937	20781			167	400530	12 жил	
2012-2013 он					21123					34970	39500		95693	11 жил		
2012-2013 он	55972	47092	44835	44261	47129	36813	22667	54671	50480	39200	19472	190	462784	12 жил		
2013-2014 он													34238	11 жил		
2014-2015 он	62367	54741	46279	44171	43646	46224	36283	22266	53861	39559	37126	19293	505816	12 жил		
2015-2016 он	66048	61233	54426	46055	43925	43070	45884	35953	22124	42197	37933	36207	535055	12 жил		
2016-2017 он	62245	65169	60928	54166	45837	43501	42750	45423	35690	17253	41410	37581	551953	12 жил		
2017-2018 он	68238	61683	64899	60565	53970	45695	43153	42349	45013	29575	16771	40841	572752	12 жил		
2018-2019 он	72520	68002	61417	64640	60431	53038	45103	42853	42123	36634	28870	16601	503150	12 жил		
2019-2020 он													28590	12 жил	Төлөв	


Хүснэгт 1.2.6 нь цаашид боловсролын тогтолцооны шилжилт болон бусад индикаторын тооцоолол, шалтгаан, үр дагаврыг тайлбарлахад чухал үндэслэл болох ач холбогдолтой.

Ерөнхий боловсролын сургууль (2014-өнөөг хүртэл)

Сургуульд 6 настай хүүхдийг элсүүлж, 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийн сургалт 12 жил (5+4+3)-д бүрэн шилжсэн явдал нь Монгол Улсын бага, дунд боловсролын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэхэд гаргасан чухал амжилтын нэг болсон байна.

2017-2018 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын нийт 798 (төрийн өмчийн 652, хувийн өмчийн 146) сургууль сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. (Хавсралт 1.2.7)


Зураг 1.2.9. Ерөнхий боловсролын бага, дунд, ахлах сургуулийн тоо (2006/07-2017/18 оны хичээлийн жил)



Сүүлийн 12 жилийн байдлаар сургуулийн тооны өөрчлөлтийг өмчийн хэлбэр, байршил, ангиллаар авч үзвэл, өмчийн хэлбэрийн хувьд төрийн өмчийн сургуулийн жилийн дундаж өсөлт 0.8, хувийн өмчийн сургуулийн жилийн дундаж бууралт-0.3, сургуулийн ангиллын хувьд бага сургуулийн

жилийн дундаж бууралт -1.2, дунд сургуулийн жилийн дундаж бууралт-3.5, ахлах сургуулийн жилийн дундаж өсөлт 1.2 байна (Зураг 1.2.9). Зургаас харахад бага ба дунд сургуулийн тоо буурч, дунд, ахлах сургуулийн ангилал нэмэгдсэн ерөнхий дүр зураг ажиглагдаж байна.


Зураг 1.2.10. ЕБС-ийн тоо: Байршлаар (2009, 2016-2018)



ЕБС-ийн ангиллыг байршлаар нь авч үзэж, сүүлийн 3 жилийг 2009 онтой харьцуулахад ахлах сургуулийн тоо баг, сум, аймгийн аль ч байршилд өссөн байна (Зураг 1.2.10). Харин багийн дунд сургуулийн тоо өсөж, сум, аймгийн дунд сургуулийн тоо буурсан бол сумын бага сургуулийн тоо буурч, баг ба аймгийн бага сургуулийн тоо нэмэгджээ. Ийнхүү хөдөөгийн аймаг, сум, багт ахлах сургуулийг олноор нэмж байгуулсан нь бүлэг дүүргэлт буурах, мэргэжлийн багшийн далд хомсдол үүсэх, улмаар багшийн хөгжил болон сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг болж байна.

Аймаг, нийслэлээр үзүүлсэн ЕБС-ийн байршлын тархалтыг Зураг 1.2.11-т үзүүлэв

Зураг 1.2.11. ЕБС-ийн байршлын тархалт: Аймаг, нийслэлээр




### Сургуулийн насны хүн ам

Монгол Улсын бага, дунд боловсрол нь 12 (5+4+3) жилийн тогтолцоотой бөгөөд сургуульд элсэх нас 6 байдаг.

“Боловсролын тухай” хуулийн 3.1.1-д “бүх нийтийн ерөнхий боловсрол” гэж 12 жилийн сургалтын агуулгын түвшинг хэлнэ гэж заасан тул ерөнхий боловсролын хүн амыг 6-17 насаар тооцдоо. 2006-2007 онд ерөнхий боловсролын сургуулийн тогтолцоо 11 (5+4+2), сургуульд элсэх нас 7 байсан тул 2006-2007 оны хүн амыг 7-17 насаар тооцсон болно.

Зураг 1.2.12. Монгол Улсын сургуулийн насны хүн ам ба ЕБС-д хамрагдаж буй суралцагчдын тооны динамик өөрчлөлт (2006-2017)




Монгол Улсын хүн амын тооны 2006-2017 оны хоорондох динамик өөрчлөлтөөс харахад 2006-2012 онд бууралттай байж байгаад 2013 оноос өсөлт гарсан байна (Зураг 1.2.12). 2010-2014 онд хүн амын тооны өөрчлөлт ерөнхийдөө тогтмол байсан хэдий ч 2015 оноос эхлэн өсөлттэй болсон байна. Энэ нь хүн амын төрөлтийн түвшингээр тайлбарлагдах юм.

**Элсэлтийн хувь**

ЕБС-ийн элсэлтийн цэвэр ба бохир жингийн сүүлийн 12 жилийн өөрчлөлт (Зураг 1.2.13)-өөс харахад 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар I ангийн элсэлтийн бохир жин 97.9, дунд ангийн VI ангийн элсэлтийн бохир жин 98.0, ахлах ангийн элсэлтийн бохир жин 68.5 хувьтай байна.

Зураг 1.2.13. Бага, дунд боловсролын шатлал бүр дэх элсэлтийн бохир ба цэвэр жин (2006/07-2017/18 оны хичээлийн жил)



Бага ангийн элсэлтийн хувьд: 2008-2009 онд I ангийн элсэлтийн бохир жин 137.2 хувь өндөр хэмжээнд хүрсэн нь 12 жилийн сургалттай сургуулийн анхны 6 настай I анги, 11 жилийн сургалттай сургуулийн 7 настай I ангийн элсэлт нөлөөлсөн байна. Цэвэр жингийн хувьд 2007-2008 онд хамгийн бага буюу 71.3 хувьтай байгаа нь 7 настны хамгийн сүүлийн элсэлт байсантай холбоотой.

Дунд ангийн элсэлтийн хувьд: 2009-2010 оны хичээлийн жилд дунд ангид элсэлтийн бохир жин 53.5, цэвэр жин 18.9 хувьд хүрч нугарлын цэг гарсан нь ЕБС-ийн 12 жилийн тогтолцооны V ангиас VII анги руу шилжсэн суралцагчид болох 25,677 хүүхэд элссэн нь (11 жилийн анхны элсэлт) нөлөөлсөн байна. 2010-2011 оны хичээлийн жилд дунд ангийн элсэлтийн бохир жин 106.1, цэвэр жин 97.9 хувьд хүрсэн нь 11 жилийн 2 дахь элсэлтийн суралцагчид дунд ангид шилжин орсонтой холбоотой.




*Ахлах ангийн элсэлтийн хувьд:* Ахлах ангид элсэгчдийн бохир жин 2006-2013 онд дунджаар 70.7 хувьтай байгаа нь 2005 оны БСШУ-ны сайдын 486 дугаар тушаалаар ахлах ангийн элсэлтийн хувийг 80.0 болгосонтой холбоотой болно. 2012-2013 оны хичээлийн жилд ахлах ангийн элсэлтийн бохир жин огцом 44.0, цэвэр жин 26.1 хувьд хүрч буурсан нь 11 жилийн анхны элсэлтийн суралцагчид ахлах ангид элсэн орсон бөгөөд 2016-2017 ахлах ангийн бохир жин дахин 38.3, цэвэр жин 29.9 хувь болтлоо буурсан нь 12 жилийн сүүлийн элсэлтийн суралцагчид элсэж орсон нь нөлөөлсөн байна.

### Хамран сургалт

*Бага, дунд ангийн хамран сургалт:* Бага боловсролын хамран сургалтын бохир жин 2017 оны байдлаар 97.6, цэвэр жин 96.2 хувьтай байгаа бол дунд ангийн хамран сургалтын бохир жин 100.3, цэвэр жин 92.1 хувьтай байна. Сүүлийн 12 жилийн байдлаар бага боловсролын бохир жингийн жилийн дундаж өсөлт 0.16 пункт, цэвэр жингийн жилийн дундаж өсөлт 1.09 пункт байна (Зураг 1.2.14).

Зураг 1.2.14. Бага, дунд ангийн хамран сургалтын бохир ба цэвэр жин (2006/07-2017/18 хичээлийн жил)



2008-2013 онуудад хамран сургалтын бохир болон цэвэр жингийн зөрүү их байгаа нь ЕБС-ийг 11 жилийн тогтолцооноос 12 жилийн тогтолцоонд шилжих шилжилтийн үетэй холбоотой болно.


2007 онд бага боловсролын хамран сургалтын бохир жин 2006 оноос 1.1 пунктээр өссөн нь 2006 онд ЗГ-ын 2006 оны 194-р тогтоолоор “Үдийн цай” хөтөлбөр-ийг батлуулан, ЕБС-ийн I-II ангийн 110.0 мянган хүүхдийг хамруулсан зэрэг олон хүчин зүйлүүд нөлөөлсөн төдийгүй 2008-2009 онд бага ангийн цэвэр болон бохир жин жигд өссөн нь ЗГ-аас 12 жилийн шилжих шилжилттэй холбогдуулан ихээхэн ажлыг хийж өрнүүлж байсны үр нөлөө юм. Тухайлбал, 6 настныг элсүүлэхэд тусгайлан анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн, багшийг бэлтгэсэн төдийгүй, дотуур байранд амьдрах 6 настны өрөө танхим, багшийг тусгайлан бэлтгэн хэрэгжилтийг хангасантай холбоотой гэж үзэж болох юм.

Бага боловсролын хамран сургалтын бохир жин 2015-2016 оны байдлаар 98.4 хувь, эмэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жин 98.6 хувь, эрэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жин 98.3 хувьтай байгаа нь “Монголын боловсролыг 2006-2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний бага боловсролын хамран сургалтын 97.8 хувьд, эрэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жинг 96.1 хувьд хүргэнэ гэсэн зорилтыг хангасан бол, эмэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жинг 99.6 хувьд хүргэнэ гэсэн зорилтод хүрээгүй байна.

*Суурь боловсролын хамран сургалт:* 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар улсын хэмжээнд ерөнхий боловсролын 798 сургуульд нийт 581,160 хүүхэд, үүнээс өдрөөр 572,752 хүүхэд сурч байна. Суурь боловсролын хамран сургалтын бохир жин 98.5, цэвэр жин 94.7 хувьд хүрсэн байна (Хавсралт 1.2.8).

ЗГ-аас боловсролын салбарт бодлогын тэргүүлэх ач холбогдол өгч, суралцагчдын суралцах эрхийн баталгааг хангах, сургалтын орчин нөхцөлийг сайжруулахад бүх талын дэмжлэг үзүүлж байгаагийн үр дүнд боловсролын хүртээмж, чанар жилээс жилд дээшилж байна.

Зураг 1.2.15. Суурь боловсролын хамран сургалтын бохир ба цэвэр жин (2006/07-2017/18 оны хичээлийн жил)




Сүүлийн 12 жилийн байдлаар суурь боловсролын хамран сургалтын бохир жингийн жилийн дундаж өсөлт 0.23 пункт, цэвэр жингийн жилийн дундаж өсөлт 1.19 пункт байна (Зураг 1.2.15).

2008-2013 онуудад хамран сургалтын бохир болон цэвэр жингийн зөрүү их байгаа нь ЕБС-ийг 11 жилийн тогтолцооноос 12 жилийн тогтолцоонд шилжих шилжилтийн үетэй холбоотой болно.

**Бүрэн дунд боловсролын хамран сургалт:** Ахлах ангийн хамран сургалтын бохир жин 2017 оны байдлаар 100.3 хувь, цэвэр жин 95.2 хувьтай байна. (Зураг 1.2.16).

Зураг 1.2.16. Бүрэн дунд боловсролын хамран сургалтын бохир ба цэвэр жин (2006/07-2017/18 оны хичээлийн жил)




Сүүлийн жилүүдэд бүрэн дунд боловсролын хамран сургалтын цэвэр болон бохир жин өсөж байгаа нь нэг талаас, нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хүүхдэдээ гурав дахь шатны боловсрол эзэмшүүлж, ажлын байранд бэлтгэх эцэг эхчүүдийн хүсэл эрмэлзэл нэмэгдэж буйтай нөгөө талаас, гэрт нь ойр байрлах ахлах сургуулиуд олширсонтой холбоотой байж болох юм.

**Дотуур байранд хамрагдалт**

2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар ЕБС-д суралцаж буй нийт хүүхдийн 19.1 хувь буюу 109618 малчдын хүүхэд сургуульд суралцаж байна.


Зураг 1.2.17. Малчин өрх болон ЕБС-д суралцаж буй малчдын хүүхдийн тоо (2008/09-2017/18 оны хичээлийн жил)



Дээрх үзүүлэлтээс харахад улсын хэмжээнд дунджаар малчин 2 өрх тутмаас нэг хүүхэд сургуульд суралцаж байна. Эндээс малчин өрхийн дунд хүүхэдгүй тухайлбал, ахмадууд дийлэнх нь байна уу? Эсвэл цөөн өрх олон хүүхэдтэй байна уу? 6 ба 7 настнууд сургуульд элсэхгүй байна уу? гэсэн олон асуулт гарч байна. Иймд малчдын хүүхдийн сургуульд хамрагдалтын асуудлыг нарийвчлан судлах шаардлага байна.


Малчдын хүүхдийн сургуульд хамрагдалтад нөлөөлөх хүчин зүйлийн нэг нь дотуур байрны хүчин чадал юм. 2017-2018 оны хичээлийн жилд дотуур байранд 38,444 хүүхэд хүсэлт гаргаснаас 35,196 хүүхэд, малчны 27,945 хүүхэд хүсэлт гаргаснаас 25,705 хүүхэд дотуур байранд амьдарч байна. Дотуур байрны хамрагдалт 91.6 хувь, малчдын хүүхдийн дотуур байранд хамрагдалт 92.0 хувьтай байна (Хавсралт 1.2.9)

Зураг 1.2.18. ЕБС-ийн дотуур байранд амьдардаг нийт болон малчдын хүүхдийн хамрагдалт (2006-2017)



ЗГ-ын 2000 оны 186-р тогтоолоор ЕБС-ийн дотуур байрын хүүхдийн хоолны зардлын нормативыг шинэчлэн батлуулж, дотуур байрын зардлыг төрөөс бүрэн хариуцах болсноор дотуур байранд амьдрах хүсэлтэй хүүхдийн тоо нэмэгдсэн байна (Зураг 1.2.18). Хүүхдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан төрөөс дотуур байрны хангалтад анхааран 2008-2017 онд нийт 79 дотуур байрыг ашиглалтад оруулж хүчин чадлыг 8684 ороор нэмэгдүүлжээ. (Зураг 1.2.19).

Зураг 1.2.19. Шинээр ашиглалтад оруулсан дотуур байрны барилга болон хүчин чадал (2008-2017)




2015-2016 оны хичээлийн жилд малчдын хүүхдийн дотуур байранд хамрагдалт 98.1 хувьд хүрсэн нь Боловсролыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө (2006-2015)-нд дэвшүүлсэн дотуур байранд хамрагдах малчдын хүүхдийн хамран сургалтыг 40.5 хувиар нэмэгдүүлж, 75.0 хувьд хүргэнэ гэсэн зорилт хангагдсан байна.

**Төгсөлтийн хувь**

2017-2018 оны хичээлийн жилд бага боловсрол эзэмшин төгсөгчдийн тоо 53,048 буюу төгсөлтийн хувь 114.3, суурь боловсрол эзэмшин төгсөгчдийн тоо 44,573 буюу төгсөлтийн хувь 103.2, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн тоо 40,537 буюу төгсөлтийн хувь 84.9 байна (Хавсралт 1.2.10).

Зураг 1.2.20. Бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн төгсөлтийн хувь (2006/07-2017/18 оны хичээлийн жил)



Бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн төгсөлтийг боловсролын түвшингээр авч үзвэл (Зураг 1.2.19)

Бага боловсрол эзэмшин төгсөгчид 2008-2009 онд 51.6 хувьд хүрсэн нь 2004-2005 онд 11 жилийн тогтолцооны анхны элсэлтийн 25,159 төгсөгчид юм.

Суурь боловсролын хувьд 2015-2016 оны хичээлийн жилд төгсөлтийн бохир жин 44.2 хувь болж огцом буурсан нь 2008-2009 онд 11 жилийн системээр элссэн сүүлийн элсэгч болох 21,149 төгсөгчидтэй холбоотой.

Бүрэн дунд боловсролын хувьд 2014-2015 оны хичээлийн жилд төгсөлтийн бохир жин 40.3 хувь болтлоо буурсан нь анхны ерөнхий боловсролын 12 жилийн сургалтаар хичээллэсэн төгсөгчид болно.

### Хувийн сургуульд суралцагчдын хувь

ЕБС-д 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар нийт суралцагчдын 6.1 хувь буюу 35,012 суралцагч хувийн өмчийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж байна.

Зураг 1.2.21. Төрийн болон хувийн өмчийн сургуульд суралцагчдын тоо (2006/07-2017/18 оны хичээлийн жил)



Сүүлийн 12 жилийн байдлаар хувийн өмчийн сургуульд суралцагчдын хувь жилд дунджаар 1.1 пунктээр өссөн байна (Зураг 1.2.21). 2006 онд хувийн өмчийн сургуульд суралцагчдын хувь 5.3, 2015 оны байдлаар 5.8 (бага боловсролд 5.6, дунд ангид 5.0, ахлах ангид 7.2) байгаа нь Монголын боловсролыг 2006-2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөөний суралцагчдын 10.0 хүртэлх хувийг хувийн сургуульд хамруулна гэсэн зорилтод хүрээгүй байна.

### Боловсролын системийн дотоод үр ашиг

Боловсролын системийн дотоод үр ашгийн коэффициент нь суралцагчийг элсэлтээс эхлээд төгсөх хүртэлх боловсролын бүхий л үйл ажиллагааны үр ашигт сургууль завсардсан болон улирсан суралцагчид хэрхэн нөлөөлдгийг тодорхойлдог.

Хүснэгт 1.2.7. Анги дэвшилтийн хувь (2016)

2016 он	I анги	II анги	III анги	IV анги	V анги
Анги дэвшилт	99.0%	99.5%	99.3%	99.5%	97.3%
Анги улиралт	0.6%	0.1%	0.0%	0.0%	0.1%
Сургууль завсардалт	0.5%	0.4%	0.6%	0.5%	2.7%

Анги дэвшилтийн хувь 100%-иас доогуур байх нь төсвийн үр ашиггүй зарцуулалт, багшийн мэргэжил, ур чадвар дутмаг байдал, анги, танхимын хүрэлцээгүй байдал гэх мэт индикаторуудтай холбоотой байдаг. Дотоод үр ашгийн коэффициентийг авч үзэхэд 2016 онд 0.96, 2015 онд 0.94 байна (Хүснэгт 1.2.7). Үүнээс өмнөх онуудыг тооцоход 11 жилээс 12 жилийн шилжилтийн үе таарч буй учир тооцох боломжгүй байна. Цаашид боловсролын секторын орчлын нэгдсэн үнэлгээг хийснээр дотоод үр ашигт нөлөөлж буй хүчин зүйлийг илрүүлж, илүү нарийвчлан судлах шаардлага бий болж байна.

### 1.2.3.2. Чанар, нийц

Бага, дунд боловсролын хувьд сүүлийн 15 орчим жил нь цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг хангах, хоёр удаагийн шинэчлэл бүхий нээлттэй киррикулимүүдийг хэрэгжүүлэн ТХБ-ыг хөтөлбөрт интеграцилан хэрэгжүүлэх, ЕБС-ийн сургалтыг 12 жилд шилжүүлэх зэрэг зэрэгцсэн олон өөрчлөлт шинэчлэлийг сургууль, багш, суралцагчид маань даван туулсан, маш их ачаалалтай, бас хариуцлагатай он жилүүд байжээ.

Энэ цаг үе нь Дэлхий нийтээрээ хэрэгжүүлсэн “ТХБ-ын 10 жил” санаачилгын хүрээнд боловсролын стратегийн төлөвлөлт болон БНБ-ын индикаторуудын хэмжилт, хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим, арга зүй нэвтэрсэн, хэрэгжилтийн үйл ажиллагааг хөтөлбөржүүлдэг болсон, ТХБ-ын үнэт зүйлсийг чухалчлан хүүхэд бүрийн хөгжлийг эрхэмлэх болсон зэрэг Монгол Улсад БНБ-ын тогтолцоог бэхжүүлсэн хөгжлийн чухал үе шат байв.

**ЕБС-ийн сургалтыг 10 жилээс 12 жилийн тогтолцоонд шилжүүлсэн шилжилт**

ЕБС-ийн сургалтын тогтолцоог 11 ба 12 жилд шилжүүлэх болон цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэгцсэн томоохон шинэчлэлийн хүрээнд БСШУЯ-аас дараах цогц менежментийг амжилттай хэрэгжүүлсэн байна. (БСШУЯ, АХБ, 2008). Тухайлбал,


1. ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах яамны дэд сайд, бүх газрын дарга нар, багш бэлтгэдэг бүх их, дээд сургуулийн захирлууд, бүх аймгийн Боловсрол, соёлын газрын дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулан ажиллуулжээ (*БСШУ-ны Сайдын 2007 оны 436 тоот тушаал*).
2. ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн 2014-2015 онд багтаан шилжүүлэх графикийг батлан мөрдүүлсэн (*БСШУ-ны Сайдын 2007 оны 405 тоот тушаал*).
3. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого, сургалтын төлөвлөгөөг шинэчлэн баталж мөрдсөн байна. (*БСШУ-ны Сайдын 2007 оны 20 тоот тушаал*).
4. ЕБС-ийн сургалтын талаар баримтлах бодлогууд, холбогдох сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн батлаад, тэдгээрт зарим өөрчлөлтүүд оруулан мөрдсөн байна (*БСШУ-ны Сайдын 2007 оны 236, 298, 2008 оны 71, 72 тоот тушаал*).
5. 72-83 сартай хүүхдийг 6 настайд тооцож, ЕБС-д сургуульд элсүүлэх шийдвэрийг гаргаж, тусгайлсан заавар боловсруулан хэрэгжүүлсэн ажээ (*БСШУ-ны Сайдын 2007 оны 162 тоот тушаал*).
6. Бэлтгэл хангах ажлын хүрээнд 2007-2008 оны хичээлийн жилээс янз бүрийн бүтэц, хэмжээ, хэв шинж бүхий аймаг, сум, дүүргийн 8 сургуулийг сонгож, 6 настай хүүхдийн судлах хичээлүүдийн агуулга, багшийн арга зүй, сургалтын орчны тохирцыг тусгай төлөвлөгөөний дагуу үндэсний менежмент багийн удирдлагын доор туршиж, үр дүнг хэлэлцэн холбогдох арга хэмжээнүүдийн авсан байна (*БСШУ-ны Сайдын 2007 оны 297 тоот тушаал*).
7. ЕБС-ийн 12 жилийн сургалтын үндэсний хөтөлбөр боловсруулах 237 (давхардсан тоогоор) хүний бүрэлдэхүүнтэй 13 үндэсний багийг байгуулж, батлагдсан графикийн дагуу анги бүрийн, хичээл бүрийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж, шинэчлэлт хийгдэж буй ангиудад хичээл заах багш нарт зориулсан нийт 10 төрлийн 406 сургалтыг төлөвлөн тэдгээрийг амжилттай зохион байгуулсан байна. Эдгээр сургалтын зардлыг АХБ-ны Боловсролын хөгжлийн хөтөлбөр болон улсын төсвөөс санхүүжүүлжээ. (*БСШУ-ны Сайдын 2007 оны 434 тоот тушаал*)
8. 2008-2009 оны хичээлийн жилээс 6 настай нийт хүүхдийг сургуульд элсүүлж, 12 жилийн сургалтад шаардагдах бага ангийн багшийн хэрэгцээг ажиллаж байгаа багшийн тоо, хүн амын өсөлтийн прогнозын үзүүлэлтийг 20 орчим хувиар өсгөж тооцсон тооцоонд үндэслэн хангах графикийг баталж, энэ хэрэгцээг хангах арга замын хувилбаруудыг танилцуулан тайлбарлах; 6 ба 7 настай хүүхдүүд сургалтын 2 өөр хөтөлбөр, төлөвлөгөөгөөр хичээллэх гэж байгаатай холбогдуулан 12 жилийн сургалтад бүрэн шилжтэл жил бүрийн I ангид хичээл заах багш нарт зориулсан сургалтыг тусгайлан боловсруулсан хөтөлбөрөөр чанартай зохион байгуулах; 12 жилийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг чанартай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрэн хангасан байхаар багшийн мэргэжил дээшлүүлэх журмыг 2008 оны эхний хагаст багтаан боловсруулж мөрдүүлэх (анх удаа мэргэжил дээшлүүлэх харилцааг зохицуулсан журамтай болсон); мөн бага ангийн багш бэлтгэх сургалтын агуулга, арга зүйг шинэчлэн боловсруулж, элсэлт, төгсөлтийн төлөвлөлтийг оновчтой болгох шийдвэрүүдийг тус тус гаргаж хэрэгжүүлсэн байна (*БСШУ-ны Сайдын 2007 оны 04 тоот тушаал*)
9. Сургалтын үндэсний хөтөлбөрүүд ба төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай анги бүрд судлах нийт 105 сурах бичгийг хичээл бүрээр шинэчлэн бэлтгэх графикийг батлан хэрэгжүүлжээ (*БСШУ-ны Сайдын 2007 оны 461 тоот тушаал*).
10. ЕБС-д 6 настан элсэн суралцахад шаардлагатай ширээ, сандал (37916), дотуур байрны өрөө (1312), ор (6504) болон сургууль ба дотуур байрны ариун цэврийн өрөөний суултуур (3339), гар угаах тосгуур (3517)-ын тоог тооцож, тэдгээрийг тус тус бэлтгэн нийлүүлэх хуваарийг нийслэл, аймаг бүрээр гаргаж, шаардлагатай зардлын эх үүсвэрүүдийг шийдвэрлэн хэрэгжүүлжээ (*БСШУ-ны Сайдын 2008 оны 08 тоот тушаал*).
11. ЕБС-д 6 настанг сургахад бэлтгэж, 6 настан хичээллэх загвар анги танхимын орчин, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг баталж, 2007-2008 оны хичээлийн жилд аймаг, нийслэлийн дүүрэг бүрийн 2-оос доошгүй сургуульд байгуулж туршсан байна (*БСШУ-ны Сайдын 2007 оны 243 тоот тушаал*).

12. ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж байгаатай холбогдуулан нийгмийн сэтгэл зүйг бэлтгэх ажлын графикайг баталж, энэ шилжилтийн зорилго, ач холбогдол, бэлтгэл ажлын талаар 10-аад чиглэлийн агуулгын хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт иргэдэд ойлгуулан таниулах ажлыг зохион байгуулжээ (*БСШУ-ны Сайдын 2007 оны 470 тоот тушаал*).

**Бага дунд боловсролын стандарт, хөтөлбөрийн хэрэгжилт**

Бага, дунд боловсролын стандарт, кирриколимийг хөгжүүлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 2002 оноос хойш чамлалтгүй үр дүнд хүрсэн бөгөөд энэ зорилтын хүрээнд дараах шууд үр дүнгүүдэд хүрсэн байна (Зураг 1.2.22).

*Зураг 1.2.22. Онол, арга зүйн шийдлийн хүрээнд боловсруулсан үзэл баримтлал, стандарт, хөтөлбөр, сурах бичгийн тоо (2002-2018)*



Энд үзүүлсэн сургалтын хөтөлбөр ба сурах бичгүүд, багшийн удирдамжуудын эхний тоо нь Үндэсний хөтөлбөр (2008-2013) дараагийн тоо нь Цөм хөтөлбөр (2014-2018)-г тус тус хамаарна.

Боловсролын тухай холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж, ЕБС-ийн сургалтын үргэлжлэх хугацаа болон сургуулийн бүтэцэд 1991 оноос хойш 5 удаа өөрчлөлт оруулсан байна (Хүснэгт 1.2.8).

*Хүснэгт 1.2.8. ЕБС-ийн бүтэц ба суралцах хугацааны өөрчлөлт (1991-2012)*

Он	Бага	Суурь	Бүрэн дунд	Суралцах хугацаа	Хуулиуд
1991	3	5	2	10	БНМАУ-ын боловсролын хууль
1995	4	4	2	10	Монгол Улсын Боловсролын тухай хууль
2002	5	4	2	11	Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуулиуд
2012	5	4	3	12	Бага, дунд боловсролын тухай хууль

Сургуульд элсэх насыг урагшлуулж, суралцах хугацааг уртасгаж, сургуулийн бүтэц хэдэнтэй өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 1991 оноос хойш бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнүүд тодорхой үе шаттайгаар өөрчлөгдөж иржээ: Тухайлбал,

**1990-2001 онд**

- 1998 оноос өмнө ЕБС-д мөрддөг сургалтын үндсэн баримт бичиг нь хичээл бүрээр тухайн шинжлэх ухааны судлагдахуунд суурилсан “хичээлийн программ”-ууд байсан.
- 1998 онд “Бага дунд боловсролын агуулгын стандарт” анх батлагдсан.
- 1998 онд Бага, дунд боловсролын агуулгын талаар баримтлах бодлогын батлагдсан.
- 1998 онд “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө” батлагдаж, 9 хичээлийн жилийн туршид тогтвортой мөрдөгдсөн.

**2002-2012 онд**

- 2002 онд бага, дунд боловсролын стандарт, кирриколимийг шинэчлэх үзэл баримтлал батлагдсан.
- 2004 онд цогц чадамжид суурилсан СӨБ болон бага, дунд боловсролын стандартууд батлагдаж мөрдөгдсөн.

- 2006 оноос боловсролын стандартыг хэрэгжүүлэх 11 жилийн сургуульд мөрдөх агуулгын үлгэрчилсэн хүрээг баталж мөрдсөн.
  - Ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө. Хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ, БСШУЯ, БХ, УБ., 2004;
  - Ерөнхий боловсролын шилжилтийн агуулгын хүрээ (2005-2006 оны хичээлийн жилд мөрдөнө), БСШУЯ, БХ, БХХ-3, УБ, 2005;
  - Ерөнхий боловсролын 11 жилийн сургуульд 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ (бага, дунд, ахлах ангиар), БХ, УБ., 2006;

#### 2008-2014 онд

- 12 жилийн сургалтын үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлсэн. Үүнд:
  - 2008-2009 хичээлийн жилээс I ангийн сургалтын хөтөлбөр
  - 2009-2010 хичээлийн жилээс II ба шилжилтийн VII ангийн сургалтын хөтөлбөр
  - 2010-2011 хичээлийн жилээс III ба VIII ангийн сургалтын хөтөлбөр
  - 2011-2012 хичээлийн жилээс IV ба IX ангийн сургалтын хөтөлбөр
  - 2012-2013 хичээлийн жилээс V ба X ангийн сургалтын хөтөлбөр
  - 2013-2014 хичээлийн жилээс VI ба IX-р ангийн сургалтын хөтөлбөр
  - 2014-2015 хичээлийн жилээс VII ба XII ангийн сургалтын хөтөлбөр

#### 2013 оноос өнөөг хүртэлх

- 2012 онд “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал” батлагдсан.
- 2013 онд Монгол Улсын ерөнхий боловсролын сургалтад хүүхэд бүрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд “Зөв монгол хүүхэд” үндэсний хөтөлбөр батлагдсан.
- 2014-2015 оны хичээлийн жилд 12 жилийн сургалтаар 11 жил суралцсан анхны төгсөлт болж ЕБС 12 жилийн сургалтын тогтолцоонд бүрэн шилжиж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шатлал, бүтэц бүхий ерөнхий боловсролын сургалтын системтэй болсон.
- 2012-2018 онд сургалтын цөм хөтөлбөрүүдийг боловсруулж, үе шаттайгаар үндэсний түвшинд бүх нийтээрээ мөрдөн хэрэгжүүлж байна. Тухайлбал,
  - 2014-2015 оны хичээлийн жилээс бага боловсролын сургалтын хөтөлбөр
  - 2015-2016 оны хичээлийн жилээс суурь боловсролын сургалтын хөтөлбөр
  - 2016-2017 оны хичээлийн жилээс бүрэн дундын X ангийн сургалтын хөтөлбөр
  - 2017-2018 оны хичээлийн жилээс бүрэн дундын XI ангийн сургалтын хөтөлбөр
  - 2018-2019 оны хичээлийн жилээс бүрэн дундын XII ангийн сургалтын хөтөлбөр

Ерөнхий боловсролын 12 жилийн сургалттай сургуулийн сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулах менежмент нь дараах онцлогтой байсан байна. Тухайлбал,

- Бүх ангийн бүх хичээлийн сургалтын үндэсний хөтөлбөрүүдийг 2007-2008-аас 2014-2015 оны хичээлийн жилд багтаан жил бүр 2 ангийг шинэ тогтолцоонд шилжүүлэх нэгдсэн график (2007 оны 405 дугаар тушаал)-ийг мөрдөн ажилласан байна.
- Шинээр боловсруулах сургалтын үндэсний хөтөлбөрийн бүтэц дизайн, үйлийн хүрээг боловсролын стандарттай нийцүүлэх зорилготой бие даасан төслийг 2008 онд АХБ-ны III хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын зөвлөхийн 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг гүйцэтгэжээ. Энэ төслийн үр дүнд сургалтын бүх хөтөлбөрүүд ижил бүтэц, дизайнаар боловсрогдсон байдал нь сурах бичиг зохиох, тэдгээрт экспертиз хийх, сургууль багш нар хөтөлбөрөө боловсруулах, үнэлэхэд нь ойлгомжтой, хэрэглэхэд хялбар дөхөм байх нөхцөлийг бүрдүүлжээ. (MECS, ADB-LOAN-2238-MON, 2008)
- Сургалтын хөтөлбөр боловсруулах бүх багуудад ТХБ-ыг хөтөлбөрт интеграцлахад нь мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх бие даасан багийг байгуулж ажиллуулсан байна (БСШУ-ны Сайдын 2007 оны 434 дүгээр тушаал). Тус багийн үйл ажиллагааг дэмжих зорилготой ШХА-ын санхүүгийн дэмжлэгтэй бие даасан жижиг төсөл хэрэгжсэн бөгөөд хөтөлбөрт ТХБ-ын үзэл санаа, агуулгыг интеграцчилах чиглэлээр бусад багийн ахлагч болон гишүүдэд зориулсан цуврал сургалт, семинарыг зохион байгуулах, шаардлагатай мэдээллийг боловсруулж өгөх, стандартад тусгагдсан цогц чадамжийг ТХБ-ын цогц чадамжийн утга санаатай хэрхэн уялдуулах талаар арга зүйн зөвлөмж өгч ажилласан ба үйл ажиллагааныхаа үр дүнгээр тусгай ном (БСШУЯ, ШХА, 2011) бэлтгэн хэвлүүлжээ.
- Сургалтын үндэсний хөтөлбөрүүд боловсруулах, экспертиз хийх, захиалагч тал хүлээн авах үндэслэл болгож, “Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт

гаргах ерөнхий шалгуур” (БСШУ-ны Сайдын 2008 оны 393 дугаар тушаал)-ыг баталж мөрдсөн нь боловсруулалтын чанарын баталгааг хангах чухал хөшүүрэг болжээ.

БСШУ-ны Сайдын 2007 оны 405 дугаар тушаалаар баталсан “ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх график”-ийн дагуу БСШУ-ы Сайдын 2007-2011 оны 8 удаагийн тушаалаар I-XII ангийн бүх хичээлийн сургалтын үндэсний нийт 155 хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 1.2.9. ЕБС-ийн сургалтыг 12 жилд шилжүүлэх графикийн дагуу бэлтгэсэн сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн номын тоо (2008/09-2018/19 оны хичээлийн жил)*

Хичээлийн жил	12 жилийн сургалтад шилжсэн анги	Сургалтын үндэсний хөтөлбөрийн тоо	Сурагчийн сурах бичгийн тоо	Багшийн номын тоо
2008-2009	1	6	10	1
2009-2010	2 ба шилжилтийн 7	23	9	0
2010-2011	3 ба 8	24	26	2
2011-2012	4 ба 9	24	29	1
2012-2013	5 ба 10	24	26	1
2013-2014	6 ба 11	28	26	27
2014-2015	7 ба 12	26	30	29
<i>Нийт</i>	<i>12</i>	<i>155</i>	<i>156</i>	<i>61</i>
2014-2015	бага боловсрол (I-V)	11	33	29
2015-2016	дунд боловсрол (VI-IX)	12	31	48
2016-2017	ахлах анги: X	23	0	0
2017-2018	ахлах анги: XI	31	51	1
2018-2019	ахлах анги: XII	20	23	15
<i>Нийт</i>		<i>97</i>	<i>138</i>	<i>93</i>
<b>БҮГД</b>		<b>252</b>	<b>294</b>	<b>154</b>

Ерөнхий боловсролын 12 жилийн сургалттай сургуульд мөрдөх цөм хөтөлбөрийг боловсруулах менежмент зарим онцлогтойгоор хийгджээ. Тухайлбал, БШУЯ-аас 2014 онд I-VI ангийн бүх хичээлийн ”Бага боловсролын цөм хөтөлбөрүүд” (БШУ-ны Сайдын 2014 оны А/240 тоот тушаал), 2015 онд VII-IX ангийн бүх хичээлийн ”Суурь боловсролын цөм хөтөлбөрүүд” (БШУ-ны Сайдын А/220-р тушаал, 2015), 2016 онд X, XI, XII ангийн заавал судлах, сонгон гүнзгийрүүлэн судлах 9 хичээлийн, заавал сонгон судлах 5 хичээлийн сургалтын хөтөлбөрүүд болон сургуулийн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага (БСШУ-ны Сайдын 2016 оны А/277 тушаал)-ыг тус тус баталж, сургалтад мөрдөж байна

2014 оноос эхлэн мөрдөж буй бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт шинжлэх ухааны мэдлэг, чадвараас гадна өөрийн хүч нөөцийг мэдрэх, бусадтай хамтрах, мэдлэгийг хайн олж судлах арга барилтай болох, байнга тасралтгүй хөгжих, хүрээлэн буй орчныг зөв ухаарч тэнд өөрийгөө зөв авч явах, зорилго чиглэлтэй амьдарч хөдөлмөрлөх зэрэг хувь хүний хөгжилд хандсан ТХБ-ын үзэл санаа, агуулгыг тодорхой тусгасан байна. Сургалтын цөм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд баримтлах тодорхой зарчмуудыг чухалчилж, хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй нь сурагчдын аливаа юмс, үзэгдлийг өөрөө сонирхон шинжлэн судлах, асуудал шийдвэрлэх, бусадтай харилцаа холбоо тогтоох, хамтран ажиллах үр дүнгээ танилцуулах зэрэг бүтээлч үйл ажиллагаанд сууриллахаар тодорхойлжээ.

Харин бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, төлөвлөгөөг ахлах ангийн сурагчдад өөрсдийн авьяас, сонирхол, ирээдүйн мэргэжлийн чиг баримжаандаа тулгуурлан хичээлээ сонгож судлах өргөн боломж олгох, ахлах сургуулийг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого баримталсан талаар тайлангийн 1.2.2 дахь дэд бүлэгт дурдсан билээ. Энэ бодлогын хүрээнд бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ахлах сургуульд дараах нэмэлт үйл ажиллагаанууд хэрэгжиж, тэдгээрт харгалзах шинэ менежмент шаардагдаж, сургуулийн захирал, сургалтын менежер, ангийн болон хичээл заадаг багш нар, нийгмийн ажилтан, сурагчид, эцэг эхчүүд шинэ үүрэг хариуцлага хүлээхээр төлөвлөсөн байжээ. Тухайлбал,

- Сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөрт нийцүүлэн ахлах ангийн сурагчид хичээлээ сонгож судлах
- Сурагчдаар сонголт хийлгэх, сонголтын бүлгийг зохион байгуулах ажил ЕБС-д шинээр хийгдэх



- Сурагчийн сонголтоо хийхэд нь туслах зорилгоор сургалтын хөтөлбөрийг танилцуулах, бие даалтын ажлыг чиглүүлэх зэрэг зөвлөн туслах ажлыг шинээр зохион байгуулах
- Заавал сонгон судлах хичээлийн хүрээнд орон нутгийн болон сургуулийн онцлог, багшийн нөөц, ур чадварт үндэслэн сургуулийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх зэрэг болно.

Гэвч дээрх шийдвэр гаргахдаа Монгол Улс дахь ЕБС-ийн бүтэц, байршил, хэмжээ, хэв шинжийн онцлогийг гүйцэд тооцоогүй, зохих бэлтгэлийг бүрэн хангаагүйн улмаас хөдөөгийн цөөн сурагчидтай сургуульд сонгон суралцах боломжууд хязгаарлагдаж, тус бодлогын хэрэгжилтэд бэрхшээлүүд гарч, батлагдсан сургалтын төлөвлөгөөнүүд өөрчлөгдөхөд хүргэсэн байна. Улмаар дараагийн шатны сургуульд үргэлжлүүлэн суралцах залгамж холбоог хангах, бүрэн дунд боловсролын агуулгыг кредитийн тогтолцоонд шилжүүлэх, суралцагчдад сонгох боломжийг өргөжүүлэх, ахлах сургуулийг хөгжүүлэх бодлогыг үргэлжлүүлэн бүрэн утгаар нь хэрэгжүүлж чадаагүй байна. Энэ нь БСШУС-ын сайдын 2016 оны А/103 дугаар тушаалаар БСШУ-ны сайдын А/275 тоот тушаалыг хүчингүй болгосонтой холбоотой ажээ.

Өнгөрсөн хугацаанд БСШУЯ-аас багш нарт зориулан ЕБС-ийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх анги бүрийн Багшлахуйн удирдамж (2008-2012)-ууд, мөн цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх бага, суурь, бүрэн дунд боловсролын анги бүрийн Суралцахуйн удирдамж (2014-2018)-уудыг тус тус боловсруулан сургууль, багш нарт түгээн хэрэглүүлжээ.

Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд ашиглах “Суралцахуйн удирдамж”-ыг боловсруулах, батлах, түгээх үүргийг Сайдын 2016 оны тушаалын 277-р тушаалын 3 заалтаар Боловсролын хүрээлэнд даалгасан боловч энэ ажил хөрөнгө санхүүгийн хүрэлцээгүй байдал, сургалтын төлөвлөгөөний олон удаагийн өөрчлөлт зэргээс хамаарч анги бүрийн хувьд ялгаатай, хичээл бүрийн хувьд жигд бус явагдаж байна. Тухайлбал, Х ангийн математик, физик, хими, биологийн Суралцахуйн удирдамжийг АХБ-ны санхүүжилтээр хэвлэсэн бол XI ба XII ангийн Суралцахуйн удирдамжийг Боловсролын хүрээлэнгийн Эрдмийн Зөвлөлөөр хэлэлцэн дэмжиж, Хүрээлэнгийн сайтад байршуулан багш нарт хүргэсэн байна. Гэвч зарим Суралцахуйн зөвлөмжүүд өнөөг хүртэл боловсрогдоогүй байгаа ажээ.

АХБ-ны дэмжлэгтэйгээр 2016-2018 онд бүрэн дунд боловсролын X-XII ангийн математик, физик, химийн цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эдгээр хөтөлбөрүүдийг хэвлэх, шинэ хөтөлбөрөөр хичээллэх багш нарт зориулсан зуны сургалтуудыг зохион байгуулжээ. Бусад хичээлийн цөм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд бэлтгэх багш нарын сургалтыг БМДИ хариуцан зохион байгуулсан байна.

#### ***Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн тохирцын үнэлгээ***

Эцэг эхчүүдээс ЕБС-ийн бага ангийн сурагчдын ачаалал хэт их байгаа талаар яаманд гаргасан санал гомдолд БСШУЯ онцгой анхаарал хандуулж, ЕБС-ийн бүх ангийн цөм хөтөлбөрийн агуулгад нарийвчилсан судалгаа хийж, ачааллыг багасгах боломжийг тогтоох чиглэлээр БСШУЯ, БХ-ээс “Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрт дүн шинжилгээ хийх” хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэгийг 2019 ны 3 сараас эхлэн зохион байгуулсан байна. Эхний 5 хоногийн хэлэлцүүлэгт ЕБС-ийн багш, сургалтын менежер, захирал, БСУГ-ын мэргэжилтний төлөөлөл бүхий 90 хүн оролцож, цөм хөтөлбөрийн агуулгын залгамж холбоо, давхардал, хүндрэл, багш, сурагчийн хэт ачаалал зэрэг даруй шийдвэрлэх шаардлагатай дараах асуудлуудыг илрүүлсэн байна (Ё.Баатарбилэг, 2019). Тухайлбал,

#### ***Сургалтын хөтөлбөрийн талаар:***

- ЕБС-д судалж байгаа хичээлийн тоо олон, зарим хичээлийн агуулга давхцаж байна (Бага ангийн хүн ба орчин, хүн ба байгаль, хүн ба нийгэм, иргэний боловсрол, эрүүл мэнд).
- Зарим хичээлийн агуулга цагтаа багтдаггүй (Бага боловсролын математик, монгол хэл, байгалийн ухаан, дүрслэх урлаг, технологи, 7-9-р ангийн газар зүй, 9-р ангийн хими, физик, 8-р ангийн математик, 8, 9-р ангийн дүрслэх урлаг, дизайн технологи, 10-12-р ангийн математик, монгол хэл бичиг, уран зохиол, физик, газарзүй, мэдээллийн технологи, хими).
- Зарим хичээлийн агуулга хүндэдсэн (3-р ангийн математикийн энгийн бутархай, сөрөг тоо, монгол хэлний жорын дагуу унших, зохиох, захидал бичих, ёгт үлгэр зохиох, 5-р ангийн “Хүн ба байгаль” хичээлийн туршилт хийдэг “Хөшүүрэг”, “Энерги”).
- Зарим хичээлийн агуулга ангиудад жигд хуваарилагдаагүй (9-р ангийн хими, физикийн агуулга их, 10-12-р ангийн агуулгад танин мэдэхүйн үйлийн доод түвшний суралцахуйн зорилт 54-77%, дээд түвшний зорилт 22-46% байна гэж шинжилгээний үр дүнгээс танилцуулсан байна).

- Зарим хөтөлбөрийн агуулга буюу суралцахуйн зорилтын томъёолол ерөнхий, ойлгомжгүй, багтаамж нь харилцан адилгүй байна гэж тус тус үзсэн байна.

Багшийн ажлын ачаалалын талаар

- Багш нарын мэдлэг чадвар харилцан адилгүй, мэргэжлийн багш дутагдалтай.
- Багшийн ажлын байрны тодорхойлолтын дагуу сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, үнэлэх, дүгнэхээс гадна тайлан бичих, судалгаа бөглөх, журнал, бичиг баримт хөтлөх гээд бичиг цаасны ажилд хамгийн их цаг зарцуулдаг.
- Ангийн ажил, цаг үеийн ажилд дайчлагддаг (*Багш сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын ажилд нийт цагийн 37,3%, бусад нэмэлт ажилд нийт цагийнхаа 62,7%-ийг зарцуулж байна гэсэн үр дүнг танилцуулсан*).
- Багш нар долоо хоногт ижилхэн 19 цагийн хичээл заах онцлогтой ч зарим багш нар мэргэжлийн онцлогоосоо хамаарч илүү ачаалалтай ажилладаг. Жишээ нь, хөгжим, дизайн технологи, мэдээллийн технологийн багш нар үндсэн ажлаас гадна хичээлээс гадуурх олон төрлийн үйл ажиллагаанд их цаг зарцуулдаг. Бага ангийн багш нар олон чимхлүүр ажил хийдэг
- Боловсролын мэдээллийн системд мэдээлэл оруулах, цахим журнал хөтлөх орчин бүрдээгүй, нэг мэдээллийг дахин дахин оруулах шаардлага гардаг. Энэ нь интернэтийн хурд удаан, сүлжээ тасардаг гэх мэт шалтгаантай зохиомол ачааллыг үүсгэдэг.

Сурагчийн ачааллын талаар

- Хичээлийн цагт багтаагүй агуулгыг гэрийн даалгаварт өгдөг нь цөөнгүй.
- Бага ангийн сурагчдын гэрийн **даалгаврын хэмжээ их**, зарим хичээлийн гэрийн даалгавар **сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохирдоггүй** (*Багш нар даалгавар өгөхдөө өөрсдөө хийж шалгаж төлөвлөдөггүй, гүйцэтгэх үйлийн алхмуудыг тооцоолохгүй даалгавар өгч байна*).
- Сурагчид сургалтын төлөвлөгөөнд заасан үндсэн хичээлээс гадна хичээлийн цагтай тэнцэхүйц хэмжээний цагт орон нутаг, сургуулийн нэмэлт үйл ажиллагаа, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд хамрагдаж байна (*Суурь боловсролд сурагчид сургалтын цагаас гадна 4.4-5.4 цагийн нэмэлт үйл ажиллагаа, сургалтад хамрагдаж байгааг багш нар хэлж байна*).

Улмаар хэлэлцүүлэгт оролцсон багш нар бодлого боловсруулагчид, сургалтын хөтөлбөр боловсруулагчид болон багш нарт хандаж дараах саналыг хүргүүлсэн байна. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг нийгэм, эдийн засаг, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан, хот, хөдөөгийн сургуулийн бодит нөхцөл байдлыг тооцох
- Багш нарт сургалтын хөтөлбөрийн үзэл санаа, агуулга, арга зүйг бүрэн ойлгуулсны дараа үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх
- Багш нар өөрсдөө сургалтын хөтөлбөр, зөвлөмжийг бүрэн судлаагүй, агуулгын залгамж холбоо, өргөсөл, гүнзгийрлийг ойлгоогүй болон сургалтын хөтөлбөрт шинээр нэмэгдсэн, хүндэвтэр агуулгыг заахад тэдний мэдлэг, чадвар дутагдаж байгааг тэмдэглэж байлаа.

Дээрх хэлэлцүүлгийн дараа сургалтын цөм хөтөлбөрт нарийвчилсан шинжилгээ хийж, асуудлуудыг шийдэх гарц, арга замыг тодорхойлох, агуулгын залгамж холбоог сайжруулах чиглэлээр БХ-ийн дэргэд эрдэмтэн, судлаачид, багш нарын төлөөлөлтэй ажлын хэсэг 2 сар гаруй хугацаанд ажиллаж, сургалтын цөм хөтөлбөрийн тохирцыг сайжруулсан хувилбарыг боловсруулаад байна. Энэ хувилбарын хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэгийг үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулж, эцсийн хувилбарыг баталгаажуулан зохих бэлтгэлийг хангах үндсэн дээр 2019-2020 оны хичээлийн жилээс ЕБС-ийн сургалтад мөрдөхөөр ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар 2008-2018 оны хооронд үндэсний түвшний нийт 252 сургалтын хөтөлбөр боловсруулж мөрдсөн боловч сүүлийн жилүүдэд боловсрогдсон нийт хөтөлбөрийн 70 гаруй хувь нь хүчингүй болсон байна

**Сургалтын онцлох хөтөлбөрүүд:** ЕБС-ийг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх шилжилтийн 5 жилийн хугацаанд 2009-2010 оны хичээлийн жилээс эхлэн VII ангийн шилжилтийн сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөө батлан хэрэгжүүлсэн байна. Энэхүү төлөвлөгөө, хөтөлбөрөөр 903 бүлгийн 25854 сурагч хичээллэж, сургалтыг 1422 багш зохион байгуулжээ. VII ангийн шилжилтийн төлөвлөгөөг 11 жилийн сургуулийн VI, VII ангийн сурагчдын судалж буй 17 хичээлтэй адил төрлийн хичээлийг судлахаас гадна 1 долоо хоногт судлах цагаас 3 цаг буюу 120 минутаар илүү хичээллэхээр боловсруулсан бол агуулгыг 11 жилийн сургуулийн VI ба VII болон 12 жилийн сургуулийн VII ангийн харгалзах хичээлийн агуулгын давхардал, ялгааг нягтлан тогтоож, 12 жилийн сургуулийн VIII ангийн харгалзах хичээлийн залгамж холбоог тодорхойлсны үндсэн дээр боловсруулсан онцлогтой. БСШУЯ-наас

багш нарыг 2 үе шаттайгаар сургах, шилжилтийн төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмжийг сургуулиудад хүртээмжтэй хэвлэн түгээх зэрэг тусгай арга хэмжээнүүдийг авснаар энэхүү хөтөлбөр амжилттай хэрэгжсэн байна.

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн шинээр боловсруулан мөрдөж байсан сургалтын үндэсний хөтөлбөрүүдийг Кембрижийн ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөртэй уялдуулан шинэчилж эхлэх шийдвэрийг ЗГ-аас 2010 онд гаргажээ. Монгол Улсын бага, дунд боловсролын стандарт, сургалтын үндэсний хөтөлбөрийг Кембрижийн олон улсын стандарт, хөтөлбөртэй адил түвшинд хүргэх, монгол, англи хос хэлний сургалтын системийг хөгжүүлэх үндэс суурийг тавих, 2011-2013 онд Монгол улсаас Кембрижийн их сургуульд оюутан суралцуулах чиглэлээр 2010 оны 12-р сард харилцан тохиролцсон байна.

Монгол Улсын ЗГ нь Кембрижийн их сургуулийн Олон улсын шалгалтын төвтэй “Бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг”-т 2011 онд гарын үсэг зуржээ. Дээрх санамж бичгийн хүрээнд Боловсролын яамны харьяанд 2011 онд олон улсын Кембрижийн сургалтын хөтөлбөрөөр хос хэл дээр хичээллэдэг “Шинэ эрин”, “Шинэ эхлэл”, “Монгол тэмүүлэл” гэсэн 3 лаборатор сургуулийг анх байгуулсан байна. Өнөөдөр эдгээр сургууль нь шинэ төрлийн сургалтыг Монголд амжилттай нутагшуулан сургалтын хөтөлбөр, сургалтын технологи, сургуулийн менежментийн шинэ хувилбаруудыг бүтээж, Монголын төрийн өмчийн ЕБС төгсөгчид олон улсын нэр хүндтэй сургуулиудад шууд элсэн суралцаж, чадвартай мэргэжилтнүүд бэлтгэгдэх боломжийг нээж өгч байна.

Улмаар бага, дунд боловсролын математик, физик, хими, биологи, англи хэл, байгалийн шинжлэлийн хичээлийн үндэсний хөтөлбөрүүдийг Кембрижийн хөтөлбөртэй уялдуулан шинэчилж эхэлсэн бөгөөд 2011-2016 онд эдгээр хичээлийн шинэчлэгдсэн үндэсний хөтөлбөрүүд туршигдаж байжээ. Туршилтад аймаг бүрийн төвд тус бүр 1, Улаанбаатарт 10 нийт 31 сургуульд 2529 багш, 55978 сурагч хамрагдсан байна (БСШУЯ, 2012.04.21).

Монгол иргэдийн хүүхдүүд суралцаж байгаа төрийн бус өмчийн бүх сургууль Бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн шаардлагыг бүрэн хангах үүрэгтэй бөгөөд нэмэлтээр өөрийн сургуулийн онцлогийг тусгасан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжтой байдаг. Төрийн бус өмчийн сургуулиуд сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааныхаа хүрээнд аймаг, нийслэлийн Боловсролын газраар сургалтын хөтөлбөртөө магадлан шинжилгээ хийлгүүлж, зөвшөөрөл авдаг журамтай. Иймээс нэг хүүхдэд ногдох урсгал зардлыг төрөөс эдгээр сургуулиудад олгодог. Монголд 2017-2018 оны хичээлийн жилд 146 хувийн өмчийн сургуулиуд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ нь нийт сургуулийн 18.3 хувийг эзэлж байна. Эдгээр сургуульд хөрөнгө мөнгөтэй өрхийн хүүхдүүд ихэвчлэн суралцдаг бөгөөд зарим сургуулийн сургалтын жилийн төлбөр хэт өндөр байдаг (Хүснэгт 1.2.10).

*Хүснэгт 1.2.10. Хувийн сургуулиудын төлбөрийн мэдээлэл (Мэдээлэл ирүүлсэн сургуулийн хувьд авч үзлээ.)*

Он	Төлбөргүй	1.5 сая ₮ хүртэл	3.0 сая ₮ хүртэл	5 сая ₮ хүртэл	10 сая ₮ хүртэл	10 сая ₮-өөс дээш	Нийт
2015-2016	8	88	25	2	3	2	128
2018-2019		14	31	26	9	4	84

Жич: 2015-2016 оны хичээлийн жилд хувийн өмчийн 132 сургууль үйл ажиллагаа явуулж байснаас судалгаанд 128 сургууль, 2018-2019 оны хичээлийн жилд хувийн өмчийн 147 сургуулиас 84 сургуулийн мэдээлэлд үндэслэн судалгааг гаргав.

Бага, дунд боловсролын салбар дахь хувийн сургуулиудийн хөгжлийн шалгарал хэдийнээ явагдаж эхэлсэн байна. Хувийн болон олон улсын хамтарсан сургуулиудад боловсролын чанар, өрсөлдөх чадварын төлөө сургалтын онцлог хөтөлбөрүүд, дэвшилтэд технологи, сургалтын байгууллагын өвөрмөц менежментүүд туршигдан боловсорч, Монголын ЕБС-ийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж, бага, дунд боловсролыг шинэ өнгө төрхөөр “солонгоруулж” байна. Гэвч үүний зэрэгцээ энэ төрлийн сургуулиуд чанарт бус ашиг орлогод түлхүү анхаарах, сургалтын төлбөрийн хэмжээг хөөрөгдөх, нийгмийн бүлгүүдийг үл алагчилах байдалд сөрөгөөр нөлөөлөх зэргээр алсдаа нийгмийн давхраажилтын ялгарлыг эрс нэмэгдүүлж, нийгмийн тогтвортой байдлыг алдагдуулах зэрэг гарч болзошгүй эрсдэлүүд байна. Иймд цаашид боловсрол болон нийгмийг эдгээр эрсдэлээс хамгаалсан, мөн тэднийг бага, дунд боловсролын хөгжлийг дэмжих нэг чухал эх булаг болохыг хүлээн зөвшөөрч дэмжсэн ухаалаг бодлогыг төрөөс баримталж, хэрэгжүүлэх шаардлагатай.

**Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичгийн талбар дахь түншлэл**

Шинжлэх ухаан, технологийн хөгжил давамгайлсан цаг үед боловсрол нь эдийн засгийн тогтолцооны нэг гол хүчин зүйл төдийгүй нийгмийн салбарын нэг бүрэлдэхүүн хэсэг болж улмаар түүний чанар нь эргээд нийгэмдээ бүхэлд нь нөлөөлдөг. Боловсролыг энэ өргөн утгаар нь ойлгож, Монголын төрөөс боловсрол бол нийгмийн тэргүүлэх салбар гэж хуульчлан тогтоосон. Хуулиар тэргүүлэх салбар гэж тунхаглах нэг хэрэг бөгөөд харин төр, сонирхлын бүлэг, иргэд бүх түвшиндээ түүний ач холбогдлыг тэргүүн зэрэгт үзэж хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх механизмаа сонгож, түншлэлийг хөгжүүлэх нь өөр хэрэг юм.

Иймд өнгөрсөн хугацаанд боловсролын шинэ тогтолцоог үүсгэн хөгжүүлэхэд Монгол Улсын ЗГ, БСШУЯ-аас салбар хоорондын болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, Дэлхийн болон бүсийн банк санхүүгийн байгууллагууд, гадаад улс орны ЗГ-ууд, бусад хандивлагчид хоорондын түншлэлийг бүтээлчээр ашиглаж ирсэн байна. Энэхүү түншлэлийн нэг тод илрэл нь БСШУЯ-аас бусад яам, олон улсын байгууллагуудтай хамтран бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багшийн хөгжлийн талбарт “Эрүүл мэнд”, “Иргэний боловсрол”, “Англи хэл” гэсэн хичээлүүдийг цоо шинээр бий болгож, ТХБ-ыг бүх судлагдахуун болон сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах зорилтууд амжилттай хэрэгжсэн явдал юм. Урт удаан хугацааны түншлэлийн үр дүнд багагүй бэрхшээлийг даван туулж хүрсэн эдгээр амжилтыг “Эрүүл мэнд”-ийн хичээлийн жишээн дээр товч танилцуулж байна. Эрүүл мэндийн болон боловсролын салбар хоорондын зохицуулалт, түншлэл нь дараах үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжжээ. Үүнд:

- "Сурагч, өсвөр үеийнхний эрүүл мэнд (1997-2005)", ЗГ-ын 1997/30, ЭМНХЯ, ГЯ
- “Хүн амын эрүүл мэндийн боловсрол (1998-2005)”, ЗГ/1998/05, ЭМНХЯ, ГЯ, ДЭМБ, ХАС, МННХ, бусад
- “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр-I, (1997-2001)”, ЗГ1997/126: *ӨҮНҮЭМ хөтөлбөр 1*, (MON/01/PO6/ARH); ЭМНХЯ, ГЯ, ХАС
- “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр-II (2002-2006)”, ЗГ 2001/288, *ӨҮНҮЭМ хөтөлбөр -2*, (MON/02/PO6(PO20)/ARH); БСШУЯ, ЭМЯ, ХАС
- БЗХӨ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх хөтөлбөр: *Сургуулийн боловсрол (2003-2006)*”, MON/202/G02/H/00NIV/AID; Global fund, БСШУЯ
- “Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр-III (2007-2011), ЗГ 2007/288, *ӨҮНҮЭМ хөтөлбөр -3*, (MON/02/PO6 (PO20)/ARH); БСШУЯ, ЭМЯ, ХАС,
- “Эрүүл мэнд” Үндэсний хөтөлбөр (2010-2021), ЗГ 2010/268, ЭМЯ, БСШУЯ, бусад
- "Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр-IV" (2012-2016)”, ЗГ 2012/61, ЭМЯ, БСШУЯ, ХАС

1995 онд батлагдсан Боловсролын тухай багц хуулийн нийт 20-иод заалтад суралцагчдын эрүүл мэндийн асуудал тусгагдсан явдал хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндэд манай улс онцгой анхаардгийн нэг илрэл юм. Дээр дурдсан хүн ам, өсвөр үеийнхний эрүүл мэндийн боловсролын үндэсний хөтөлбөрүүд хэрэгжсэнээр иргэдэд эрүүл мэндээ хамгаалж бэхжүүлэх, эрүүл аж төрөх талаар цэгцтэй мэдлэг, зөв хандлага, дадал төлөвших “эрүүл мэндийг дэмжигч” таатай орчин бүрдүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын бүх төвшин болон үйл ажиллагааны бүхий л хэлбэрийг хамарсан боловсролын салбар дахь олон талт түншлэлд томоохон үүрэг гүйцэтгэжээ.

Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ЗГ-аас батлагдан гарсан 20 орчим Үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн 140 гаруй зорилтод анализ хийх үндсэн дээр эрүүл мэндийн боловсролын чиглэлээр хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслүүдийн менежментийг боловсронгуй болгох, тэдгээрийн санхүүгийн болон хүний нөөцийг ашиглалт, зохицуулалтыг сайжруулах замаар энэ чиглэлд явуулж буй үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх шаардлага байгааг илрүүлжээ. Энэ шаардлагыг хангах хүрээнд БСШУ-ны болон Эрүүл мэндийн Сайдын 2003 оны 188/143 тоот хамтарсан тушаалаар эрүүл мэндийн боловсролын чиглэлээр 2003-2006 онд баримтлах стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг; мөн БСШУ-ны болон Эрүүл мэндийн сайдын 2010 оны 286/216 тоот хамтарсан тушаалаар Эрүүл мэндийн боловсролын талаар 2010-2015 онд баримтлах стратеги төлөвлөгөөг тус тус батлан хэрэгжүүлсэн байна.

Ийнхүү эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслийн менежментийг сайжруулснаар сурагч, өсвөр үеийнхний эрүүл мэндийн боловсролыг дэмжсэн цогц бодлого, хэрэгжилтийн зохицуулалт бий болж, улмаар энэ үйл хэрэгт хувь нэмрээ оруулсан холбогдох

байгууллага, баг хамт олон, хувь хүмүүсийн бүтээлч хүчин чармайлтын үр дүнд дараах асуудлууд шийдвэрлэгдэж, ЕБС-ийн сургалтад эрүүл мэндийн хичээл бүрэн институтчилагджээ. Тухайлбал,

- Бага, суурь, бүрэн дунд боловсролын Эрүүл мэндийн боловсролын стандарт (2004)-ууд боловсрогдон батлагдаж, мөрдөгдсөн.
- ЕБС-ийн IV-X(XII) ангийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрүүд (1998, 2007-2012) тус тус боловсруулагдан батлагдаж, мөрдөгдсөн.
- Сургалтын төлөвлөгөөнд долоо хоногт нэг удаа ордог бие даасан хичээл (2005) болон тусгагдаж чадсан.
- Анги бүрийн сурах бичиг, багшийн ном (2003-2014), сургалтын бусад хэрэглэгдэхүүнээр хангагдсан.
- Эрүүл мэндийн хичээл заах багш нарыг бэлтгэх (1998, 2007-2011), тэдний мэргэжил дээшлүүлэх тогтолцоо институтчилэгдсэн. (2008-2009 оны хичээлийн жилээс БЭМ, БТЭМ-ийн багш бэлтгэж эхэлсэн)
- Мэдээлэл сургалт сурталчилгааны болон өсвөр үеийнхний бүтээлч, бодит оролцоонд тулгуурлах үр өгөөжтэй шинэ аргазүй сургалтад нэвтэрсэн.
- Эрүүл мэндийн боловсролын хэрэглээг дэмжих орчин сайжирч, эрүүл мэндийг дэмжигч сургууль, цэцэрлэг, хамт олны тоо нэмэгдсэн байна.

Энэ түншлэлийн хүчин чармайлтын үр дүнд 1996-1997 оны хичээлийн жилээс Монгол Улсад “Эрүүл мэндийг дэмжигч сургууль”-ийн хөдөлгөөн үүсэж, 1997-1998 оны хичээлийн жилээс ЕБС-ийн I-X ангид бүтэн нэг улирлын туршид 9 цаг буюу долоо хоногт нэг цагаар, эрүүл мэндийн хичээлийг нийт сургуульд судалж эхэлсэн түүхтэй ажээ. Харин 2004 онд Эрүүл мэндийн боловсролын стандартыг анх удаа боловсруулан баталснаар энэ цаг үеэс эхлэн эрүүл мэндийн хичээлийг IV-XII дугаар ангид (1-3 дугаар ангид Хүн-Орчин интеграц хичээлээр) заавал судлах хичээлийн хэлбэрээр бүтэн жилийн турш долоо хоног нэг цаг буюу нийт 34-35 цаг судалдаг болжээ. Эрүүл мэндийн хичээл нь хүүхэд өсвөр насныханд эрүүл аж төрөхөд шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэх зорилготой, амьдралын хэрэгцээнд нь тулгуурласан хичээл юм.

Ийнхүү Монгол Улсын ЗГ-аас НҮБ-ын ХАС-тай хамтран 1996-2006 онд хэрэгжүүлсэн “Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд I ба II” хөтөлбөрийн “Өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэнд I ба 2” дэд хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн сургалтад эрүүл мэндийн хичээл нь анх удаа бие даасан хичээл болгон институтчилагдсан байна. Энэ ч утгаараа сургалтын хөтөлбөрт нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын асуудлууд нь эрүүл ахуй, амны хөндий, хоол хүнс, бие бялдрын хөгжил соёл, хорт зуршил, сэтгэцийн эрүүл мэнд зэрэг агуулгын бусад 8 айнаас илүү нарийвчлагдан тусгагдсан онцлогтой. Бүх ангийн хичээлд нөхөн үржихүйн эрүүл мэндийн агуулга тусгагдсан боловч суурь боловсролын сүүлчийн ангид “Бэлгийн боловсрол” гүнзгийрүүлсэн агуулгыг заавал сонгон хичээлээр судлах боломжийг бүрдүүлсэн байна.

Гэвч 2015-2016 оны хичээлийн жилээс эрүүл мэндийн хичээл сургалтын төлөвлөгөөнөөс хасагдаж, (БСШУ-ны Сайдын 2014 оны А/240 ба А/335 тоот тушаал) уг хичээлийг сургуульд бие даасан хичээл байдлаар судлахгүй, бусад хичээлийн агуулгад интеграцчилан судлах шийдвэр гарчээ. Энэ шийдвэр нь эрүүл мэнд ба боловсролын салбаруудын мэргэжлийн байгууллагууд, мэргэжилтнүүд болон олон нийт, суралцагчдын зүгээс нэлээд эсэргүүцэлтэй тулгарсан байна.

*Шигтгээ 1.2.2. БСШУ-ны Сайдад эрүүл мэндийн хичээлийн талаар шаардлага хүргүүлсэн тухай*

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Сурагч өсвөр үеийнхний эрүүл мэнд”, “Хүн амын эрүүл мэндийн боловсрол” хөтөлбөрүүд нь сурагч, өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих тогтолцоог боловсронгуй болгоход төр, олон нийт, аж ахуй нэгж байгууллага, эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн анхаарлыг чиглүүлж, эрүүл мэндийн зохих боловсролтой, эрүүл чийрэг иргэд болон төлөвших орчныг бүрдүүлэх” зорилго тавьсны дагуу олон улсын хандивлагч байгууллагууд, дотоод, гадаадын мэргэжилтнүүд асар их хүч хөдөлмөр, хөрөнгө нөөц зарцуулж ирсэн билээ. ... ардчиллын үндсэн зарчмын нэг болох оролцогч талуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, санал авалгүйгээр гаргасан таны энэ шийдвэр нь сүүлийн 20 гаруй жилд олсон ололтоосоо ухарсан, магадгүй, хэдэн жилийн дараа харамсаад ч барахгүй үр дагавар авчирч мэдэхээр байна. ... Эрүүл мэндийн хичээлийг бусад хичээлтэй интеграцилж буй үр дүн муутай энэхүү ажлаа зогсоож, ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд Эрүүл мэндийн хичээлийг бие даасан хичээл хэвээр үлдээн, гаргасан шийдвэрээ эргэж харахыг Олон талт оролцооны байгууллагууд албан ёсоор шаардаж байна.

*108 ТББ-ыг төлөөсөн 7 байгууллагын гарын үсэг, тамга бүхий шаардлага.  
<http://lag.mn/news/article61854>*

Иймээс эрүүл мэндийн салбар болон холбогдох төрийн болон ТББ, мэргэжилтнүүдийн шаардлагаар 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийн IV-XII ангид уг хичээлийг дахин бие даасан хичээл хэлбэрээр судлах шийдвэр (БСШУС-ын Сайдын 2018 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн А/453 тоот тушаал) гараад хэрэгжиж байна.

Салбар дамнасан түншлэлийн өөр нэг жишээ бол хүрээлэл орчны болон тогтвортой хөгжлийн боловсролын чиглэлээр БОАЖЯ ба БСШУЯ болон ШХА, ГХАН, ДБХС-ын хамтын ажиллагаа юм. Өнгөрсөн хугацаанд ЗГ-аас нийт иргэдийн хүрээлэл орчин болон тогтвортой хөгжлийн боловсролд анхаарал хандуулж, дараах үндэсний хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлсэн. Үүнд:

- “Бүх нийтийн экологийн боловсрол (1998-2005)”, ЗГ 1997/255, ГЯ, БОЯ, ШХА, ГХАН, ДБХС
- “Тогтвортой хөгжлийн боловсрол (2018-2022)”, ЗГ 2018/209, БСШУСЯ, БОЯ, бусад

Эдгээр үндэсний хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн сургалтын хөтөлбөр, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд экологийн боловсрол, ТХБ-ыг интеграцилах зорилт амжилттай хэрэгжиж байна. Тухайлбал, сургалтын хөтөлбөрболон сургалтын төлөвлөгөөний сургуулиас зохицуулах, сонгох агуулгыг хэрэгжүүлэхэд зориулан Монгол Улсад хүрээлэн буй орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа гадаадын улс орнууд болон төрөлжсөн байгууллагуудын төсөл хөтөлбөрийн хүрээнд 2007-2010 онд зөвхөн багш нарт зориулан ТХБ-той холбогдох мэдээлэл, онол, арга зүйн чиглэлийн 7 ном, ТХБ-агуулга, арга зүйтэй холбоотой сургалтын хөтөлбөрийн 14 гарын авлагыг боловсруулан тэдгээрийг нэг багц болгож, ГТХАН-ийн “Байгаль орчны мэдээлэл, сурталчилгаа ба байгаль орчны боловсрол” төслийн хүрээнд сургуулиудад түгээсэн ажээ.

Эдгээр хэвлэмэл материалыг боловсруулахад яам, агентлагийн ажилтнууд, их дээд сургуулийн профессор багш нар, аймаг, нийслэлийн Боловсролын газрын арга зүйчид, сургуулийн багш нийт 375 хүн оролцож, ТХБ-ын асуудлаар багш нар шууд хэрэглэж болохуйц сургуулийн түвшний 142 сургалтын хөтөлбөр, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хэрэглэж болох 13 модуль боловсруулсан байна. Эдгээр материалыг боловсруулахад оролцогчдын дийлэнх хувийг Байгаль орчин, ТХБ-ын чиглэлээр хэрэгжүүлсэн төсөлд хамрагдсан сургуулийн багш нар эзэлж байжээ. (БОНХАЖЯ, 2015).

Түүнчлэн ISO14001 стандартад суурилсан Олон Улсын “Эко сургууль” хөтөлбөрийг Дэлхийн байгаль орчны боловсролын сан (ДБОБС)-аас нийт 64 орны 49,000 гаруй сургуулиудад өөрийн үндэсний гишүүн байгууллагуудаараа дамжуулан хэрэгжүүлж байгаа билээ. Байгаль орчны мэдээлэл сургалтын төв ТББ нь 2011 оноос эхлэн тус хөтөлбөрийг Монголд албан ёсны эрхтэйгээр хэрэгжүүлж байгаа үндэсний оператор байгууллага юм. Үндэсний хэмжээний энэ хөтөлбөрт 2018 оны байдлаар 288 ерөнхий боловсролын сургууль, 4 цэцэрлэг бүртгэлтэй байгаагаас үйл ажиллагаагаа тогтмол явуулж амжилт гаргасан 70 сургууль “Хүрэл гэрэгэ” өргөмжлөл, 30 сургууль “Мөнгөн гэрэгэ” өргөмжлөл, 9 сургууль “Ногоон туг” өргөмжлөл (ОУ-ын шагнал) гардан аваад байна (БОМСТ/ТББ, 2018).

Монгол Улсын ЗГ болон ШХА, холбогдох бусад гадны байгууллагуудтай хамтран 2015-2018 онд “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийг амжилттай хэрэгжүүлж дууссан байна. Энэ төслийн хүрээнд боловсролын үндэсний хэмжээний мэргэжлийн байгууллагууд ТХ/ТХБ-ын чиглэлээр томоохон судалгаанууд хийгдсэн талаар доор тодорхой өгүүлэх болно.

### **Сургалтын хөтөлбөрүүдийн боловсруулалтыг үнэлсэн судалгаанууд**

Стратегийн төлөвлөлтөд “backcasting” хийхгүйгээр “forecasting” хийх буюу алсын хараагаа тодорхойлох боломжгүй гэж үздэг. Иймээс боловсролын амин сүнс нь болсон боловсролын стандарт, киррикулимийг цаашид сайжруулах, ялангуяа хөгжлийн өнөөгийн шатанд боловсролыг бүхэлд нь хувирган өөрчлөх (transforming)-өд өмнөх үеийн бүх бодлого, шийдэл, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлж цэгнэхгүйгээр цаашдын алсын хараа, стратегиа тодорхойлох боломжгүй юм. Энэ чиглэлээр бага, дунд боловсролын стандарт, киррикулимийн талаар өнөөгийн байдлаар боломжийн түвшинд чанартай судалгаанууд хийгдээд байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тэдгээрийн гол үр дүнгээс товч танилцуулж байна. Үүнд:

*1. Монгол Улсын ТХБ, ТХ, НХ-ийн бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа* (БОНХАЖЯ, ШХА, 2015)

Энэ судалгаанд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр сургалтын төлөвлөгөө, сурах бичгийн болон багшлахуйн эрх зүйн шинэчлэлийн бодлого, хэрэгжилтийн талаар түүхэн цаг үеийн

дарааллаар иж бүрэн мэдээлэл цуглуулан, тэдгээрт шинжилгээ хийж, холбогдох дүгнэлт, зөвлөмжийг гаргасан байна.

Бага ба суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрүүдийн бүтэц бүрэлдэхүүн, онцлог болон “шинэ” ба “хуучин” хөтөлбөрүүдийн харьцуулалтаас илрүүлсэн тэдгээрийн давуу сул талууд, цаашид анхаарах, сайжруулах чиглэлийн талаар дээрх суурь судалгааны тайланд тодорхой өгүүлжээ. (БОНХАЖЯ, ШХА, 2015).

2. Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс судалгаа (2017):

Монголд 2014 оноос хойш эдийн засгийн өсөлт огцом буурч, ЗГ-ын санхүүжилт багассан явдал нь боловсролын салбарт нэлээд цохилт болсон байна. Энэ үед БСШУЯ-аас сургалтын чанар, тэгш хүртээмж, суралцагчдын ялгаатай байдалд нийцсэн байдал, боловсролын засаглалд эцэг эх, орон нутаг, иргэний нийгмийн оролцоог сайжруулах зэрэг хэд хэдэн шинэчлэлийг хийх замаар тулгарсан дээрх эдийн засгийн өөрчлөлтийн нөлөөллийг багасгахыг зорьж, 2015 онд Боловсролын салбарын шинэчлэлийн менежмент, хэрэгжилтэд шинжилгээ хийх, зөвлөмж гаргах техникийн туслалцааг АХБ-аас хүссэн байна. Энэхүү техник туслалцааны төслийн (АХБ, Maxwell Stamp LTD (Bangladesh), & МЭК ХХК (Монгол), “Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” сэдэвт судалгааны тайлан, 2017) нь дараах 2 зорилготой байжээ. Үүнд:

1. Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын үнэлгээний төв зэрэг боловсролын мэргэжлийн байгууллагуудын чадавхыг дээшлүүлэх
2. Зорилтот сургуулиудад судалгаа хийж, Монголын боловсролын шинэчлэлийн боловсролын чанар, хүртээмжид үзүүлж буй нөлөөг тодорхойлох

Судалгааны багийнхны дийлэнх нь Монголын боловсролыг олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэхэд үндэсний 31 лаборатори сургуульд зөвлөн тусалж, лаборатори сургуулиудад цөм хөтөлбөрийг турших, сургалтын шинэ арга зүйг хэрэгжүүлэх, сургуулийн уян хатан менежментийг нэвтрүүлэх, лаборатори болон лаборатори бус сургуулийн багш нартай мэдлэг, туршлагаа хуваалцах үүрэгтэйгээр ажиллажээ. Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихийн тулд лаборатори сургуулиудад нэмэлт нөөц, хэрэглэгдэхүүн олгосон бол харинлаборатори бус сургуулиудад тэдгээрийг олгоогүй байна.

Энэхүү техник туслалцааны хүрээнд бодлогын түвшний дараах 6 чиглэлээр зөвлөмж гаргажээ. Үүнд:

1. Сургалтын хөтөлбөрийн стандарт<sup>8</sup>
2. Сурагчийн үнэлгээ
3. Сургууль, захирал, багшийн үнэлгээний тогтолцоо
4. Сургалтын материал
5. Захирал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил
6. Боловсролын салбарын мэдээллийн системийг ашиглан боловсролын төлөвлөлтийг үр ашигтай болгох

Тухайлбал, *Бодлогын Зөвлөмж 1*: “Сургалтын хөтөлбөрийн стандарт”-ын хүрээнд судалгааны гол үр дүнгүүд, сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүд ялангуяа, суралцахуйн зорилтуудын томъёолол, залгамж холбоог хэрхэн сайжруулах, боловсролын шатлал бүрийн төгсгөлд хүлээгдэх үр дүнг хэрхэн товлох, ажиглагдаж, хэмжигдэж болохоор үйлийг нэрлэх (үйл үг), түүнчлэн суралцахуйн зорилтыг томъёолон бичихэд тооцох хүчин зүйлсийг ялгаж, судалгааны үр дүн болон бодлогын зөвлөмжийг дараах байдлаар өгчээ. Үүнд:

Судалгааны гол үр дүнгээс	Зөвлөмж
1. Багш нар сургалтын хөтөлбөрт тусгасан хичээл тус бүрээр тодорхой заасан зарчим, зорилго, зорилт зэргийг ерөнхийдөө ойлгож байгаа ч багш, тэдний сургагч багш нар энэхүү хөтөлбөрийг сурагчийн тодорхой чадамжуудад буулгах нь хүндрэлтэй гэжээ.	1. Багш, сургагч багш нар сургалтын хөтөлбөрийн стандартуудыг ойлгоход төвөгтэй гэж үзэж байгаа тул хялбаршуулах хэрэгтэй. 2. Одоо мөрдөж буй сургалтын хөтөлбөрийн бүтцийг хадгалж, суралцахуйн зорилтын тодорхойлолтыг бодит, ажиглагдахуйц

<sup>8</sup> Энэ тайланд хэрэглэсэн “сургалтын хөтөлбөрийн стандарт” гэдгийн доор сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүд, ялангуяа суралцахуйн зорилтууд, хүлээгдэж буй үр дүнг тодорхойлж, томъёолон бичихэд тавигдах шаардлага-стандарт гэсэн утгаар хэрэглэжээ гэж тайланг унших үед ойлгогдсон болно.

<p>2. Багш нарт агуулгад заасан сэдвүүдийг аль хэр хэмжээнд хэрхэн сурагчдад хүргэх зааварчилгаатай, мөн хүрэх түвшингийн амжилтын үзүүлэлтийг маш тодорхой тусгасан цогц агуулгын жагсаалт хэрэгтэй.</p> <p>3. Амжилттай суралцах үр дүнгийн тодорхойлолтыг маш тодорхой зааж өгч, түвшин болон хичээлд тохирсон, хэмжигдэхүйц, ажиглаж болохуйц, тайлагнаж болохуйц, тодорхой нэг үйл юмуу, ур чадвараар тодорхойлох</p> <p>4. Сургалтын хөтөлбөрт заасан тодорхой үр дүнд хүрэхийн тулд багш нарт төрөл бүрийн арга зүйн шийдлийг агуулсан зөвлөмж хэрэгтэй. Ингэснээр тэд өөрсдийн сургалтын арга зүйн сонголттой болох боломжтой.</p>	<p>хэмжүүртэй, олон улсын стандартын шалгуур индикаторын дагуу дахин шинэчлэн бичих</p> <p>3. Суралцахуйн зорилтын тодорхойлолтыг тодорхой үйл, ур чадварыг ажиглаж болохуйц, хэмжиж болохуйц, тайлагнах боломжтой, анги, хичээлүүдэд зохицсон, сурагчийн чадамжийн хүрээнд байхаар тодорхойлох</p> <p>4. Боловсролын хүрээлэнд суралцахуйн зорилтын тодорхойлолтыг багш, суралцагчдад ойлгомжтой болгох үүднээс сургалтын хөтөлбөрийн ажлын хэсэг (хичээлээр нь)-үүдийг байгуулж, дахин боловсруулж бичих</p>
--	--

3. ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцилах арга зүй (БСШУЯ, БМДИ, ШХА, 2018)

БСШУЯ, БМДИ-ээс “ТХБ төслийн хүрээнд” ШХА-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр 2018 онд “ТХЗ 4-Боловсрол 2030 Үйлийн хүрээ”-нд дэвшүүлсэн зорилт, стратегиудын хэрэгжилтийг дэмжих зорилгоор энэхүү томоохон судалгааг хийж, багш нарт зориулсан гарын авлага боловсруулан хэвлэж, сургуулиудад тараасан байна. Мөн уг гарын авлагыг БМДИ-ийн сайтад тавьж, багш бүр ашиглах боломжоор хангажээ.

Уг судалгаагаар НҮБ-аас 1972-2017 оны хооронд батлан гаргасан гол баримт бичгүүд болон бусад эх сурвалжуудын судалгаанд үндэслэн дэлхий нийтийн хэмжээнд ТХ, ТХБ-ын үзэл баримтлал, үйл хэргийн хөгжлийн замнал, өрнөлийн тоймыг түүхчлэн өгүүлж, холбогдох дүгнэлтүүдийг хийж, ТХ-ийн тодорхой үе шатуудад харгалзсан 4 удаагийн цикл бүхий ТХБ-ын хөгжлийн үйл явцын бүдүүвчийг боловсруулан танилцуулжээ.

Мөн Монголын УИХ ба ЗГ-ын шийдвэрээр батлагдсан Монгол Улсын хөгжлийн стратегийн баримт бичгүүдийн судалгаанд үндэслэн Монгол Улс дахь ТХ ба ТХБ-ын хөгжлийн бодлого, стратегийн замнал өрнөлийг тоймлож, холбогдох зарим дүгнэлтүүд гаргасан бөгөөд тухайлбал, ТХ ба ТХБ-ын хөгжлийн бодлого, стратегийн замналыг 3 үе шатанд ялгаж, тодорхойлсон байна. Түүнчлэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлагдсан бага, дунд боловсролын стандарт ба киррикулимийг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал, боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрүүдийн хүрээнд ТХБ-ыг бага, дунд боловсролд интеграцчилсан бодлогын болон онол, арга зүйн шийдлүүдийг товч танилцуулж, холбогдох дүгнэлтүүд хийжээ. Энэхүү гарын авлагын 2-р бүлэг нь дэлхий нийтийн болон Монгол Улсын ТХ ба ТХБ-ын хөгжлийн замнал, өрнөлийг тоймлон уялдаа холбоонд нь илүү цэгцтэйгээр нэгтгэн дүгнэсэн, сонирхсон хүмүүст гүнзгийрүүлэн судлах эх үүсвэрүүдийг зааж өгсөн боловсролын салбар дахь харьцангуй түгээмэл хэрэглээтэй бүтээл болсон байна. Энэ бүлэгт өгөгдсөн мэдээлэл нь хэрэглэгчдэд ТХ, ТХБ-ын хөгжлийн дэлхий нийтийн түвшинд бараг хагас зууны, үндэсний түвшинд 30-аад жилийн замнал, өрнөлийг бүдүүвчлэн тоймлож, нэг хавтгай дээр тавьж харах боломж олгосон, хөгжлийн дунд ба урт хугацааны стратегийн төлөвлөлт хийхэд тус болох ач холбогдолтой юм.

Багш нарт зориулсан гарын авлага нь дараах зориулалтаар бүтээгджээ. Үүнд:

- Боловсролын алсын хараа шинэчлэгдсэн эргэлтийн шинжтэй энэ цаг үед дээрх судалгааны үр дүнгүүд нь багш нарт боловсролыг хувирган өөрчлөхөд шаардлагатай дэлхий нийтийн, үндэсний, салбарын түвшний цэгцтэй мэдээлэл өгч, зайлшгүй судлах тодорхой эх үүсвэрүүдээр хангах;
- ТХБ, ТХЗ-ын үзэл баримтлалын мөн чанар, ТХЗ-д хүрэх суралцахуйн зорилго, ТХ-ийн гол агуулга (сэдвүүд), арга зүйн хандлагуудыг, багш нарт цэгцтэйгээр ойлгуулах;
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, сурах бичгүүдийг дээрх үзэл баримтлалын үүднээс нягтлан судлуулж, тэдгээрт тусгагдсан ТХБ-ын агуулга, тогтвортой байдал (ТБ)-ын цогц чадамжийг ТХЗ-д хүрэх агуулга, арга зүй болгон хувиргаж, сургалт ба сургалтыг дэмжих үйл ажиллагаандаа *интеграцчилж* болохыг харуулах;
- Дидактик нэгжээ томсгон хичээлээ төлөвлөж, турших замаар тэдэнд ТХ, ТХБ, ТХЗ-ын хэл (SD/ESD/SDG literacy)-д тайлагдах сэдэл төрүүлж, боловсролын хөгжлийн шинэ алсын




хараанд чиглүүлэн өөрсдийн үйлээ тохируулан өөрчилж, ТХЗ-ын бодит хэрэгжилтийг дэмжих итгэл үнэмшил төрүүлэх;

- ТХБ, ТБ-ын цогц чадамжийг өөрсдөө эзэмшиж, суралцагчиддаа эзэмшүүлэх замаар олон салбарын олон төрөл, хэлбэрийн үйл ажиллагаанд тодорхой, мэдлэг мэдээлэлтэйгээр бүтээлчээр оролцох, улмаар ТХЗ-ыг хангахад хүлээх өөрсдийн ухамсар, хариуцлагаа нэмэгдүүлэхэд тус тус дэмжлэг үзүүлэх зэрэг болно.

Дээрх судалгаанд сүүлийн 50-иад жилийн боловсролын хөгжлийн төлөөх дэлхий нийтийн хүчин чармайлтыг нэгтгэж, ЮНЕСКО-оос 2017 онд гаргасан “Тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол” буюу “Education for Sustainable Development Goals” (ЮНЕСКО, 2017) гэсэн баримт бичигт тодорхойлогдсон ТХЗ-д хүргэх суралцахуйн зорилт, агуулгын сэдвийн хүрээ, арга зүйн хандлага, арга техникийг тус тус шалгуур индикатор болгон сонгосон байна. Тодруулбал, судалгаандаа ТХ-ийн 17 зорилгын хүрээнд нийт ТБ-ийн 8 цогц чадамжийн төлөвшилд хувь нэмэр оруулах боломжтой 255 суралцахуйн зорилт, 171 сэдэв, 119 арга зүйн хандлага, арга, техник тус тус сонгож, нийт 553 индикатораар бүх ангийн бүх хичээлийн бүх цөм хөтөлбөрт<sup>9</sup> үнэлгээ хийх хүчин чадалтай хоёр багаж (матриц)-ийг бүтээж, тэдгээрийг хэрэглэн шинжилгээ хийсэн байна. Зарим ерөнхий үр дүнгээс нь дурдвал;

- ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрөөс давхардсан тоогоор нийт 567 суралцахуйн зорилт ТХЗ-д хамаарахаар тодорхойлогджээ. Тэдгээр нь ТХЗ-ын суралцахуйн зорилтуудад дараах тархалттайгаар харгалзаж байна (Зураг 1.2.23). Цөм хөтөлбөрийн хамгийн олон буюу 108 (18.8%) суралцахуйн зорилт “ТХ303. Сайн эрүүл мэнд ба сайн сайхан байдал”-д, хамгийн цөөн буюу 4 (0.7%) суралцахуйн зорилт “ТХ314. Усан доорх амьдрал”-д тус тус хамаарч байна.

Зураг 1.2.23. ТХЗ-ын суралцахуйн зорилтод харгалзах цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтын тархалт: Хувиар



- Сургалтын цөм хөтөлбөрийн суралцахуйн зорилтыг боловсролын түвшингээр авч үзвэл бага боловсрол (ББ)-ын 142 (25.0%), суурь боловсрол (СБ)-ын 217 (38.3%), бүрэн дунд боловсрол (БДБ)-ын 208 (36.7%) суралцахуйн зорилт тус бүр ТХЗ-д хамаарч байна (Хүснэгт 1.2.11).

Ерөнхий дүнгээр боловсролын түвшингээс үл хамааран цөм хөтөлбөрт ТХБ-ын интеграцчилал жигд боловч ТХЗ тус бүрийн онцлогоос хамаарч боловсролын түвшингүүдэд харилцан адилгүй интеграцчилагдсан байна.

Хүснэгт 1.2.11. Сургалтын цөм хөтөлбөр дэх ТХЗ-д хамаарах суралцахуйн зорилт: Боловсролын түвшингээр

БТ	Тогтвортой хөгжлийн зорилго																	Нийт	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	тоо	%
ББ	4	4	27	12	6	7	5	2	1	2	31	9	10	1	11	6	4	142	25.0
СБ	3	10	43	32	5	19	12	11	6	5	7	11	10	0	34	4	5	217	38.3
БДБ	9	10	38	8	3	19	16	15	10	5	8	16	18	3	19	6	5	208	36.7
<b>Нийт</b>	<b>16</b>	<b>24</b>	<b>108</b>	<b>52</b>	<b>14</b>	<b>45</b>	<b>33</b>	<b>28</b>	<b>17</b>	<b>12</b>	<b>46</b>	<b>36</b>	<b>38</b>	<b>4</b>	<b>64</b>	<b>16</b>	<b>14</b>	<b>567</b>	<b>100</b>
%	2.8	4.2	19.0	9.2	2.5	7.9	5.8	4.9	3.0	2.1	8.1	6.3	6.7	0.7	11.3	2.8	2.5	<b>100</b>	

- Агуулгын интеграцын судалгаагаар тодорхойлогдсон 567 суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд ТХЗ-ын арга зүйн хандлагын 4 төрөлд харгалзах давхардсан тоогоор 895 арга, техникийг хэрэглэж болохоор суралцахуйн удирдамжуудад тусгагдсан байна.

<sup>9</sup>Судалгааны объект болгож ЕБС-ийн бүх ангийн бүх хичээлийн сургалтын цөм хөтөлбөр, шаардлагатай тохиолдолд суралцахуйн удирдамж, сурах бичгүүдийг нэмж, нийт 230 гаруй сургалтын үндсэн баримт бичгийг ашигласан байна. Судалгааны объект болгосон сургалтын эдгээр баримт бичгүүдийг энэхүү гарын авлагад цаашид “цөм хөтөлбөр” гэсэн ерөнхий нэг нэр томъёогоор хэрэглэжээ.

- Цөм хөтөлбөрөөс тодорхойлогдсон 567 суралцахуйн зорилтыг 895 арга, техник хэрэглэн хэрэгжүүлснээр ТБ-ын 8 цогц чадамжийн төлөвшилт хувь нэмэр оруулах 957 боломж байгааг илрүүлжээ.
- ТХЗ-ын төлөөх боловсролын суралцахуйн зорилт, түүнд хамаарах сэдэв, арга хандлага нь цөм хөтөлбөрийн боловсролын түвшингүүд, судлагдахуун агуулгын чиглэл, судлагдахуун бүрээр ялгаатай, өөрийн өөрийн онцлогтойгоор тусгагдсан байна.

Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ зорилго, агуулгын хувьд харьцангуй сайн интеграцчилагдсан байна. Гэхдээ боловсролын түвшин бүрийн сургалтын цөм хөтөлбөрийн бүтэц, дизайны ялгаатай байдал, судлагдахууны агуулгын чиглэлүүдийн онцлогууд, хөтөлбөрүүдийн боловсруулалтын түвшний жигд бус байдал зэргээс хамаарч цөм хөтөлбөрт ТХБ-ийн интеграцчилагдсан байдлыг илрүүлэх ажиллагаа нь судалгаанд сонгогдсон эх материал бүрийн хувьд ялгаатай аргачлалаар явагдахад хүргэсэн талаар уг судалгаанд тэмдэглэжээ.

4. ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулга, арга зүй тусгагдсан байдлын судалгаа (БСШУЯ, МУБИС, 2018)


Судалгааны тайланд ЕБС-ийн бүх ангийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан судлагдахуун ба үйл ажиллагааг “Математик, байгалийн ухаан”, “Хэл хүмүүнлэг”, “Түүх, нийгмийн ухаан”, “Сургалтын дэмжих үйл ажиллагаа” гэсэн 4 төрөлд багцлан сургалтын хөтөлбөрийн үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг “Хөтөлбөрийн зорилго ба үнэлгээ”, “Хөтөлбөрийн агуулга”, “Арга зүй ба орчин хэрэглэгдэхүүн” гэж 3 хэсэгт ангилан судалгаанд зориулан бүтээсэн тусгай арга хэрэгслийн тусламжтайгаар ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөр ба Матриц 2 (БСШУЯ, БМДИ, ШХА, 2018) болон суралцахуйн удирдамжид ТХЗ-ын төлөөх боловсрол (ТХЗБ) хэрхэн туссан байдлыг шинжилсэн судалгааны үр дүнг дараах бүтэцтэйгээр танилцуулсан байна. Үүнд:

1. Цөм хөтөлбөрийн шинжилгээний ерөнхий дүн
2. Цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний шинжилгээний дүн
3. Цөм хөтөлбөрийн агуулгын шинжилгээний дүн
4. Цөм хөтөлбөрийн арга ба хэрэглэгдэхүүний шинжилгээний дүн

Энэ судалгаанд 3 төрлийн зориулалттай нийт 16 шалгуур, 75 индикаторыг сонгож цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжид үнэлгээ хийжээ. Тухайлбал, бага, дунд боловсролын цөм хөтөлбөрийн зорилго ба үнэлгээний хэсгийг үнэлэхдээ ТБ-ын цогц чадамжийн 8 айг; агуулгыг үнэлэхдээ ЮНЕСКО-оос боловсролын Дэлхий нийтийн Хяналт-шинжилгээний Тайлан (Global Monitoring Report)-д ашиглаж байгаа агуулгын 4 айг; аргыг үнэлэхдээ ТХЗ-ын төлөөх боловсролын арга зүйд санал болгосон арга техникийн 4 айг; харин сургалтын орчин ба хэрэглэгдэхүүнийг үнэлэхдээ сонгогдсон арга техникийг хэрэглэхэд шаардагдах байдлыг тус тус шалгуур болгон сонгосон байна. Шалгуур тус бүрийг тодорхой тооны индикаторуудын тусламжтайгаар үнэлжээ.

Судалгаанд өгөгдлийн бүртгэл ба үр дүнгийн боловсруулалт нь автоматчилагдсан EXCEL TEMPLATE-ийг хэрэглэсэн бөгөөд давхардсан тоогоор нийт 5653 өгөгдөл бүртгэгдсэн ба тэдгээрийн сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрд харгалзах тоог Зураг 1.2.24-д үзүүлэв.

Зураг 1.2.24. ЕБС-ийн цөм хөтөлбөрт ТХЗБ-ын тусгагдсан ерөнхий байдал: Давхардсан нийлбэр тоогоор



Зураг 1.2.24-оос харахад “Цөм хөтөлбөр”-өөс бүртгэгдсэн нийт өгөгдлийн 22,3% хөтөлбөрийн зорилго, зорилтод, 7,4% үнэлгээнд, 12,8% агуулгад, 33,1% аргад, 24,4% орчин ба хэрэглэгдэхүүнд тус тус ногдож байна. “Цөм хөтөлбөр”-т үнэлгээний зорилт нь суралцахуйн зорилтоосоо 3 дахин цөөн байна. Зүй ёсоороо бол үнэлгээний зорилт (шалгуур, индикаторууд) нь хөтөлбөрийн зорилтоосоо дутуугүй, харин ч илүү нарийвчлагдсан байвал зохилтой гэж үзжээ.

Мөн сургалтын арга зүй буюу арга ба хэрэглэгдэхүүнд хамаарах өгөгдлүүд нийт өгөгдлийн 57,5% эзэлж байгаа бөгөөд арга нь хэрэглэгдэхүүнээсээ 1,4 дахин олон байна. Энэхүү судалгаагаар “Цөм хөтөлбөр”-ийн арга зүйн хэсэг нь өндөр үзүүлэлттэй гарч байгаа нь Үндэсний сургалтын цөм хөтөлбөрт арга зүйн хэсэг нь маш ерөнхий тусгагдсан байсан тул энэ нь судалгааны Суралцахуйн удирдамжуудыг нэмж хамруулан үзсэнтэй холбоотой бөгөөд Суралцахуйн удирдамжид арга зүйг нарийвчлан тайлбарласан байдаг нь нөлөөлсөн гэж үзжээ.

ТХБ-ын индикатор ба цогц чадамжийн чиглэлээр судалгаа явуулдаг эрдэмтэд индикатор ба цогц чадамж нь ТХБ-ын “чанар”-ын асуудлыг нарийвчлах чармайлтыг илэрхийлдгээрээ нэг зоосны хоёр тал гэж үздэг. Шалгуур ба индикаторын иж бүрдэл нь боловсролын систем ба процессын чанарт төвлөрдөг бол компетенцийн загвар хувь хүний мэдлэг, чадварын чанарт өөрөөр хэлбэл, сургалтын амжилтын хүлээгдэж буй үр дүнд төвлөрдөг онцлогтой.

#### 5. “21 дүгээр зууны Монгол суралцагчийн компетенцийн загвар” (БХ, 2018)

Энэ судалгаанд 21 дүгээр зууны боловсролын зорилго, зорилтууд компетенцид суурилдаг болж, дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн боловсролын судалгааны байгууллагууд, судлаачдаас XXI зууны суралцагчдын эзэмшвэл зохих цогц чадамжийн талаар явуулсан судалгааны хэвлэлийн ерөнхий тойм, зарим загварууд, тэдгээрийг хэрэгжүүлж буй зарим улс орны туршлага, түүний дотор Монголын бага, дунд боловсролын стандарт, сургалтын цөм хөтөлбөрүүдэд цогц чадамжуудыг тусгасан байдлыг тус тус танилцуулж, XXI зууны Монгол суралцагчийн компетенцийн нэгэн загварыг дэвшүүлсэн байна.

#### 6. Монголын 6-21 насны хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлог судалгааны тайлан:

Боловсролын хүрээлэнгээс 2018 онд Монголын хүүхэд залуусын хөгжлийн судалгаанд тулгуурласан хөгжлийн шалгуур индикаторыг боловсролын түвшин тус бүрээр боловсруулах зорилгоор “Монголын 6-21 насны хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлог” сэдэвт судалгаа хийжээ. Уг судалгаанд нийслэл, орон нутгийн 6-21 насны 4200 хүүхэд, залуучууд хамрагдсан байна. (Боловсролын хүрээлэн, 2018)

Уг судалгаагаар хүүхэд, залуучуудын бие бялдрын ерөнхий хөгжлийн онцлог, танин мэдэхүйн хөгжлийн онцлог, нийгэмшлийн онцлогийг 6-21 насанд бүхэлд нь болон тэдгээрийг 6-10, 11-14, 15-17, 18-21 гэсэн насны бүлгээр ангилан судалжээ. Хүүхэд залуучуудын хөгжлийн дээрх 3 айн хүрээнд дараах индикаторуудыг сонгон хэрэглэсэн байна. Үүнд:

- Бие бялдрын хүчин зүйлийн шинжилгээнд: Нас, хүйс, сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан эсэх, амьдарч буй нөхцөл, унтдаг цаг, гэр бүлийн харилцаа, эцэг, эхийн боловсролын түвшин, газар зүйн байршил, сургуульд хамрагдалтын хамаарал
- Бие бялдрын хөгжил, бэлтгэлжилтийг тооцохдоо биеийн өсөлт, биеийн өндөр, жин, гарын атгах хүч, цээжний тойрог, уян хатан чанар, биеийн өсөлт, хөгжил, хурд, тэсвэр, авхаалж самбаа, уушгины амьсгал гаргах хурд, тэсвэр
- Танин мэдэхүйн чадварыг судалгаанд: Хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг харгалзан ажигч чанар, анхаарлын тогтворжилт, шилжилт, ажиллах чадвар, богино хугацааны хараа, сонорын ой, утгын ой тогтоолт, сэтгэхүй, сэтгэхүйн харьцуулах үйлдэл, хэл ярианы хөгжлийг судлахдаа үгсийг утгаар нь бүлэглэх, үг тайлбарлах, зураг хараад ярих чадвар
- Нийгэмшлийн хөгжлийн чадварын судалгаанд: Нийгмийн харилцааны чадвар, нийгмийн дасан зохицол, үнэт зүйл ба хэм хэмжээ, бие хүний зан төлөв, өөрийн ухамсар, сэтгэлийн хөдөлгөөний чадвар, ээнэгшилт.
- Харин танин мэдэхүй, нийгэмшлийн нөлөөллийн шинжилгээнд: Хүйс, нас, ам бүлийн тоо, эцэг, эхийн боловсрол, ажил эрхлэлт, байршил

Энэ судалгааны үр дүнг ЕБС-ийн цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үнэлэх арга зүйг боловсруулах болон сонгоход харгалзаж үзэх нь чухал ач холбогдолтой юм (Хүснэгт 1.2.12).

Хүснэгт 1.2.12. Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны зарим үр дүн (2019)

<p><b>Хичээлийн төлөвлөлт</b> Багш нарын хичээлийн төлөвлөлтийг сургалтын цөм хөтөлбөртэй уялдуулан хийсэн шинжилгээ:</p>	<p><b>Хөтөлбөрийн хэрэгжилт</b> Сурагчдын мэдлэг, ойлголтыг боловсролын түвшин бүрд хичээл тус бүрээр авч үзсэн шинжилгээ:</p>
<p><u>Үр дүн</u></p> <ul style="list-style-type: none"> <li>○ Бага боловсролд 3.2%-57.7%</li> <li>○ Суурь боловсролд 57.5%</li> <li>○ Бүрэн дунд боловсролд 20.6-31%</li> </ul> <p><u>Дүгнэлт</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Багш нар хичээлийн бэлтгэлээ хангалттай түвшинд хийхгүй байна.</li> <li>• Багш нар сурагчдын ялгаатай байдалд тохируулан хичээл төлөвлөж тэр бүр чадахгүй байна. Ялангуяа, анги ахих тутам сурагчдын ялгаатай байдлыг төлөвлөлтөд тусгахад бэрхшээлтэй байна.</li> <li>• Сургалтын хэрэглэгдэхүүнд зардал, мөнгө гаргах шаардлагатай болдог тул төлөвлөлтөд тэдгээрийг ашиглах талаар тодорхой тусгаж чадахгүй байна.</li> </ul>	<p><u>Үр дүн</u></p> <p><i>Эзэмшилтийн хувь:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бага ангид 56.0%</li> <li>• Дунд ангид 46.0%</li> <li>• Ахлах ангид 37.0%</li> </ul> <p><i>Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бага ангид 37.0%</li> <li>• Дунд ангид 43.0%</li> <li>• Ахлах ангид 36.0%</li> </ul> <p><i>Шинжлэх ухаанч арга барил эзэмисэн байдал:</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Дунд ангид 28.0%</li> <li>• Ахлах ангид 32.0%</li> </ul> <p><u>Дүгнэлт</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Дунд ангийн сурагчдын мэдээлэлтэй ажиллах, асуудлыг шийдвэрлэх бүтээлч чадвар, сурах арга барилын эзэмшилт, сэтгэхүйн задлан шинжлэх, харьцуулах, нэгтгэн дүгнэх, таамаглал дэвшүүлэх чадвар сул байна.</li> <li>• Ахлах ангийн сурагчдын мэдээлэлтэй ажиллаж асуудал шийдвэрлэх, бие даан бүтээлч үйл гүйцэтгэх чадвар сул байна.</li> <li>• Сурагчдын мэдлэгээ хэрэглэх чадвар ерөнхийдөө сул, хичээлүүдээр ялгаатай байна.</li> </ul>

Судалгааныхаа дээрх үр дүн, тусгайлсан тусгай дүгнэлтүүдэд тулгуурлан дараах ерөнхий дүгнэлтүүдийг хийжээ: Үүнд:

1. Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд хөтөлбөрийн хэрэгжилт сул, жигд бус буюу сурагчдын эзэмшиж буй мэдлэг, чадвар өнгөц байгаа нь хөтөлбөрөөр эзэмшиж буй боловсролын чанар, үр дүнд анхаарах цаг болсныг харууллаа.
2. Даалгаврын хүнд хөнгөнийг авч үзэхэд, бага ангид 49, дунд болон ахлах ангид 37 хувь нь тохиромжтой, харин хүнд, хэт хүнд даалгавар нь багад 38, дундад 58, ахлах ангид 57 хувьтай; хөнгөн буюу хэт хөнгөн даалгавар нь багад 8, дундад 5, ахлах ангид 5 хувьтай тус тус байна.
3. Анги ахих буюу түвшин нэмэгдэх тусам багшийн мэргэжлийн зэрэг ахиж байна.
4. Судалгаанд хамрагдсан бага, дунд, ахлах ангид хичээл заадаг багш нарын тест, даалгаврын санг хичээл төлөвлөхдөө ашиглах чадвар нь анги ахих тусам бага зэрэг өссөн үзүүлэлттэй ч ерөнхийдөө сул байна.
5. Сурагчийн сурлагын ахиц, амжилт болон хүүхдийн онцлог, ялгаатай байдлыг талаар улиралд нэг удаа эцэг эх, асран хамгаалагчдад мэдээлж, хамтран ажиллах байдал дунд, ахлах ангиудад хичээл заадаг багш нарын хувьд бага зэрэг нэмэгдэж байгаа дүр зурагтай байна.
6. Сурагчийн сурлагын амжилтыг ахиулахад эцэг эхчүүд сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх, хангахад туслах явдал дунд болон ахлах ангид багасаж, байгаагийн зэрэгцээ хүүхдийнхээ хүмүүжил, төлөвшилтийн талаар асуух нь цөөрдөг дүр зураг ажиглагджээ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд сурагчдын эцэг эхийн боловсролын түвшин, эцэг эхийн ажил эрхлэлт, өрхийн сарын дундаж орлого, сургуулийн өмчийн хэлбэр, сургуулийн байршил (нийслэл, аймаг, сум), бага ангийнхны хичээл таслалт, дунд ахлах ангийнхны гэрийн даалгавар хийхдээ ашигладаг нэмэлт хэрэглэгдэхүүний хүртээмж, оройтож унтдаг явдал зэрэг *хүчин зүйлс* нөлөөлж байгааг тогтоожээ. Мөн сурагчийн сурах бичиг багшийн номын хангалт, хүртээмж, ашиглалт болон сургалтын гадаад, дотоод орчин, дотуур байрны нөхцөлийг тусгайлан судалжээ.

Энэхүү судалгааны үнэлгээ, дүгнэлтдээ үндэслэн Боловсролын үндэсний түвшний бодлого тодорхойлдог болон мэргэжлийн ба орон нутгийн боловсролын байгууллагууд, сургуулийн түвшинд анхаарч хэрэгжүүлэх зөвлөмжүүдийг гаргасан байна.

7. Монгол Улсын ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцын тайлан (БСШУСЯ, ЖАЙКА, 2018)

Монгол Улсад 1995 оноос хойш бага, дунд боловсролын цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, нээлттэй киррикулимийн тогтолцоог бүрдүүлэх, түүнд ТХБ-ыг интеграцилах, ЕБС-ийг сургалтыг 10-аас 12 жилд шилжүүлэх зэрэг бүтэц, тогтолцооны томоохон өөрчлөлтүүд эрчимтэй хийгдэж ирсэн. Хөгжилд баримжаалсан бодлогын түвшний эдгээр зэрэгцсэн цогц өөрчлөлт нь харьцангуй богино хугацаанд хийгдсэн тул анги танхим дахь суралцахуй ба багшлахуйн тогтвортой байдал хөндөгдөж, тодорхой асуудлууд тулгамдах болсон. Иймээс цаашид сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулах үйлийн төлөвлөлт, туршилт, хэрэгжилт, үнэлгээг оновчтой, үр өгөөжтэйгөөр тасралтгүй үргэлжилж байх “Сургалтын хөтөлбөрийн менежментийн цикл”-ийг нарийвчлан боловсруулж мөрдөх хэрэгцээ үүссэн байна. Энэ хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор БСШУЯ, ЖАЙКА байгууллагатай хамтран 2016-2018 онд дээрх судалгааг явуулж, үр дүнгээ Сайдын 2018 оны А/549 тушаалаар баталгаажуулан мөрдөж эхлээд байна. Өөрөөр хэлбэл, Менежментийн энэ цикл нь хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт, үнэлгээ, эргэх холбоог PDCA (Plan, Do, Check, Action) тодорхой хугацаанд үе шаттайгаар зохион байгуулж сайжруулах үйл явц юм. Хөтөлбөрийн менежментийн нэг цикл нь нөгөө циклд шилжих замаар тасралтгүй үелэн давтагдаж үргэлжлэх онцлогтой.

### Сурах бичгийн нийлүүлэлт

Сурах бичиг хангамжийн талаар баримтлах бодлого 1998, 2000, 2009 онд 3 удаа эдгээр бодлогыг хэрэгжүүлж, сурах бичиг зохиох, магадлан шинжлэх, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, түгээх, ашиглах харилцааг зохицуулсан журам 1998 оноос хойш 12 удаа тус тус өөрчлөгдсөн талаар өмнө нь дурдсан (Хавсралт 1.2.6). Тухайлбал, Сайдын 2008 оны 22 дугаар тушаалаар сурах бичгийг хувилбаргүй буюу сонголтгүй болгосон бол Сайдын 2009 оны 62 дугаар тушаалаар хэвлэн нийтлэл төвтэй сурах бичиг хангамжийг тогтолцоог төрийн оролцоо давамгайлсан тогтолцоо болгон өөрчилжээ.

2013 оноос эхлэн сурах бичгийн чанарыг дээшлүүлэхийн тулд багш, судлаач, иргэн, эцэг эх, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий экспертийн багуудыг БШУЯ-аас томилон ажиллуулж байгаа нь ТХБ-ын үзэл санааны дагуу боловсролын үйл хэрэгт сонирхлын бүлгүүдийн оролцоог хангах нэг чухал алхам болсон байна.

Цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, Сурагчдын хэвлэмэл сурах бичгийн стандартыг хэрэгжүүлэх агуулга, арга зүй, үнэлгээний шаардлагыг хангасан дидактик шийдэл бүхий шинэ загварын сурах бичгүүд зохиох арга зүй, менежментийг турших зорилгоор “Хими-10”, “Математик-6”, “Монголын түүх-8” гэсэн 3 сурах бичгийг сурагчийн болон багшийн номын хамт зохиож, хэвлэн сургалтад хэрэглэжээ. Эдгээр сурах бичиг нь шинэ үеийн сурах бичгийн загвар болсон төдийгүй, 11 ба 12 жилийн сургалттай сургуулийн сурах бичгүүдийг зохиох хөтөч болсон бөгөөд сурах бичгийг зохиох, хянан тохиолдуулах, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх энэхүү туршилт (БОНХАЖЯ, ШХА, 2015) нь сурах бичиг бэлтгэх өнөөгийн менежментийн суурийг тавьсан хэмээн 2015 онд БОНХАЖЯ-аас хийсэн суурь судалгаанд дүгнэсэн байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэл, жил бүрийн улсын төсөвт ерөнхий боловсролын сургуулийг сурах бичгээр хангах зардлыг тусгаж, батлагдсан төсвийн хүрээнд сурах бичгийг шинэчлэх, нөхөн хангах ажлыг зохион байгуулж байна.

*Хүснэгт 1.2.13. Шинээр зохиосон болон нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлсэн сурах бичиг (2014-2018)*

	2014	2015	2016	2017	2018
Сурах бичгийн нэр төрлийн тоо	96	68	105	89	112
Хэвлэн нийлүүлсэн сурах бичиг	2111247	1032902	1065953	1338737	1889573
ЕБС-ийн сурах бичигт зарцуулсан хөрөнгө	3724887370	1844781362	1632150024	3394724676	3858611428

*Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын хүрээнд өнөөдөр* “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага MNS 2054:2008” стандарт (2008), “Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-ыг (2009) мөрдөж байна.

“Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага”-д нийт шаардлагыг дараах байдлаар бүлэглэн стандарт болгосон байна.

- Ерөнхий шаардлага
- СБ-ийн эх зохиоход тавих шаардлага (агуулга, арга зүй, үнэлгээ, хэл найруулга, дизайн тавих шаардлага)
- Хэвлэлийн эх бэлтгэлд тавих шаардлага
- Хэвлэлтэд тавих шаардлага
- Сурах бичгийг хэвлэлтээс хүлээн авахад тавигдах шаардлага

“ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-аар сурах бичгийн эх зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, дахин хэвлэх, түгээх, ашиглах, нөхөн хангах болон бусад асуудлыг зохицуулж байна.

Өнөөгийн байдлаар ЕБС-ийн I-V ангид 6-8 хичээлийн 34 нэрийн, VI-IX ангид 12-17 хичээлийн 59 нэрийн, X-XI ангид 8-14 хичээлийн 35 нэрийн нийт 128<sup>10</sup> нэрийн сурах бичиг хэрэглэж байна. Мөн түүнчлэн казах хэл дээр хөрвүүлсэн I-V ангийн 23 нэрийн, казах хэл, уран зохиолын I-IX ангийн 9 нэрийн, тува хэл дээр хөрвүүлсэн I ангийн 4 нэрийн, тува хэлний I-IV ангийн 4 нэрийн, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан I-V ангийн 16 нэрийн сурах бичгийг сургалтад ашиглаж байна.

Хүснэгт 1.2.14. Сурах бичгийн нас

	Сурах бичгийн ашиглагдаж буй жил (тоо, хувиар)							
	1 дэх жил		2 дахь жил		3 дахь жил		4 дэх жил	
Бага анги	1493490	71%	195500	9%	240350	12%	160189	8%
Дунд анги	41335	4%	383700	41%	250900	27%	257643	28%
Ахлах анги	280870	55%	227000	45%				
Нийт	1815695	51%	806200	23%	491250	14%	417832	12%

Гадаадад суугаа монгол иргэдийн хүүхдүүдэд зориулсан монгол хэл, соёлын цахим сурах бичиг, багшийн гарын авлагыг боловсруулж [www.tsakhim.reader.mn](http://www.tsakhim.reader.mn) цахим хуудсанд байршуулжээ. Тус цахим сурах бичгийг бага ангийн сургалтын хөтөлбөрийг үндэслэн 3 түвшинтэй хийсэн байна.

Сурах бичиг ашиглалтын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор ЕБС-ийн бүх сурах бичгийг БСШУСЯ-ны [www.econtent.edu.mn](http://www.econtent.edu.mn) цахим хуудсанд байршуулсны зэрэгцээ гар утсаар сурах бичгийг ашиглах аппликейшнууд хөгжүүлж байна.

Бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг дагалдуулан сурах бичгийн шинэчлэлийг хэрэгжүүлж байна.

Ерөнхий боловсролын сургалтад хэрэглэж буй нийт 184 сурах бичгийн 165 нь БШУ-ны Сайдын 2013 оны А/155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Бага дунд боловсролын шинэчлэлийн ерөнхий зураглал”-ын дагуу 2014 оноос эхлэн сургалтын цөм хөтөлбөрийн үзэл санаа, агуулга, арга зүй, үнэлгээг хэрэгжүүлэх хүрээнд шинэчлэгдсэн байна.

Хүснэгт 1.2.15. ЕБС-д төрөлх хэл дээрээ хэрэглэж буй сурах бичгийн нэр төрлийн тоо (2009-2018)

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	Бүгд
ЕБС-ийн үндсэн сурах бичиг			3	2	4	28	29		42	20	128
ХБХ-ийн сурах бичиг					3	2	5		4	2	16
Казах хэлний сурах бичиг	2	1	1	1	1	1			1	1	9
Казах хэл дээр хөрвүүлсэн сурах бичиг						23					23
Тува хэлний сурах бичиг					1	1		1	1		4
Тува хэл дээр хөрвүүлсэн сурах бичиг								4			4
Нийт	2	1	4	3	9	55	34	1	48	23	184

<sup>10</sup> 4 нэрийн сурах бичиг /Дүрслэх урлаг VI-VII, Хөгжим VI-VII, Хөгжим VIII-IX, Үндэсний бичиг X-XI/ 2 анги дамжин хэрэглэгдэж байгааг давхардуулалгүй авсан болно.

Дунд, ахлах ангийн сурагчдын 60 хувь нь сурах бичгээр хангагдах боломж бүрдээгүйг үндэслэн сурагчид хичээлийн жилийн эхэнд шаардлагатай багц сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан түрээсээр авч ашиглаад, хичээлийн жилийн төгсгөлд буцаан хүлээлгэж өгөх “Сурах бичгийн эргэлтийн сан-түрээсийн тогтолцоо”-г нэвтрүүлэх туршилтыг АХБ-ны буцалтгүй тусламжийн хүрээнд 2010-2011 оны хичээлийн жилээс 2013-2014 оны хичээлийн жилийг дуустал 21 аймгийн 406, Улаанбаатар хотын захын дүүргийн 84 сургууль буюу нийт төрийн өмчийн сургуулийн 80 хувийг хамруулан хэрэгжүүлсэн (Азийн хөгжлийн банк, 2014) нь сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байсан байна. Сурах бичгийн хангалт, хүртээмжийг энэхүү туршилтын хугацааны дунджаар авч үзэхэд 45 хүртэлх хувиар нэмэгдүүлсэн тухайлбал, 2014 онд дунд, ахлах ангийн сурагчдын 85 хувь сурах бичгээр хангагдаж байсан байна. Туршилтын үр дүнд “сурагчид сурах бичиггүйгээс хичээлд оролцдоггүй, гэрийн даалгавар хийдэггүй байдал багасгаж, сургалтын үр дүнд ахиц гарсан” гэж багш нар үзсэн”(Боловсролын хүрээлэнгийн СБСОСС, 2013) бөгөөд эцэг, эхэд ч сурах бичгийг нэг дороос түрээслэн авах нь санхүүгийн хувьд хөнгөлөлт, дэмжлэг болж байсан байна.

“Сурах бичгийн эргэлтийн сан-түрээсийн тогтолцоо”-г нэвтрүүлэх туршилтын үр дүнд төрийн сангийн дансанд 3.9 тэрбум төгрөг хуримтлагдсан ч зарцуулах эрх нь нээгдээгүй байна. Энэхүү хөрөнгийг эрсдэлгүй нөхцөл хангасан арилжааны банканд байршуулж, хүүгээр өсгөх боломж бүрдүүлээгүй байна.

2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын цөм хөтөлбөрийн дагуу сурах бичгүүд шинэчлэгдсэн, мөн түрээсээр ашиглаж байсан сурах бичгүүдийн эдэлгээний хугацаа дууссан бөгөөд түрээсээр ашиглуулах сурах бичиг дахин хэвлээгүй байна. Иймээс 2018 он гэхэд сурах бичиг түрээсээр ашиглуулах үйл ажиллагаа зогсож, дунд, ахлах ангийн сурах бичгийн хангалт эрс буурахад хүргэсэн ба энэ хичээлийн жилд нийт сурах бичгийн сурах бичгээ худалдан авбал зохих нийт сурах бичгийн дөнгөж 16% худалдаалагдсан байна (Хүснэгт 1.2.16).

Дунд, ахлах ангийн сурагчдын 60 хувь нь номын худалдаанаас сурах бичгээ худалдан авахаар зохицуулагдсан боловч хэрэглэгч бүрд хүрч чадахуйц номын худалдааны тогтолцоо бүрдээгүй, сурах бичгийн борлуулалт болон худалдан авалт хангалттай төвшинд хүрээгүй байна. Энэхүү зохицуулалтад 2018-2019 оны хичээлийн жилд 159,679 сурагч хамрагдахаар тооцжээ.

Хүснэгт 1.2.16. Дунд, ахлах ангийн сурах бичгийн хангалт (2018/19 оны хичээлийн жил)

Анги	Шаардлагатай сурах бичгийн тоо	Төрөөс нийлүүлсэн сурах бичгийн тоо	Төрөөс хангасан хувь	Худалдаж авбал зохих сурах бичгийн тоо	Сурагч худалдаж авсан сурах бичгийн тоо	Худалдаж авсан хувь
6	647256	257468	40	389788	48215	12
7	766751	293390	38	473361	50470	11
8	728501	295910	41	432591	73204	17
9	673968	245503	36	428465	68063	16
10	512876	242670	47	270206	63160	23
11	404306	211170	52	193136	50023	26
12	132808	59040	44	73768		0
Нийт	3866466	1605151	43	2261315	353135	15

Сурах бичгийн чанартай холбоотой олон нийтийн шүүмжлэлд үндэслэн БСШУС-ын Сайдын тушаалаар ажлын хэсэг томилогдож, 2014, 2015 онд шинэчилсэн 61 сурах бичгээс 30 сурах бичигт дараах шалгуураар үнэлгээ хийсэн байна. Үүнд:

- Үндэсний уламжлал, ёс заншил, соёлыг сурагчдад өвлүүлэн хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага хангаж буй эсэх
- Хэл найруулга, зөв бичих дүрмийн шаардлагыг хангаж буй эсэх
- Түүхийн үнэн бодит байдлыг хангаж буй эсэх

Хөндлөнгийн Энэ үнэлгээгээр үндэсний уламжлал, ёс заншил, соёлыг сурагчдад өвлүүлэн хөгжүүлэх агуулга дутагдалтай, хэл найруулга, зөв бичих дүрмийн алдаатай, түүхийн үнэн бодит байдлыг хангаж байгаа гэсэн ерөнхий дүгнэлт гарсан байна (БСШУС-ын сайдын А/133 дугаар тушаал, 2016).

2017-2018 оны хичээлийн жилд I-XI ангийн сургалтад хэрэглэж буй 118 нэрийн сурах бичгийг [www.mier.mn](http://www.mier.mn) цахим хуудсанд байршуулж, багш нараас санал авах ажлыг зохион байгуулж, хот, хөдөөгийн 350 гаруй ЕБС-ийн нийт 4060 багшаас давхардсан тоогоор 12000 гаруй санал ирүүлснийг Боловсролын хүрээлэн нэгтгэж, дүн шинжилгээ хийжээ. Энэ үнэлгээнд үндэслэн

нөхөн хангалтаар хэвлэн нийлүүлэх 97 нэрийн сурах бичгийн эхэд монгол хэлний журамласан үгийн толийн дагуу зөв бичих дүрмийн засвар хийж, хэвлүүлсэн байна.

ЕБС-ийн I-V ангийн “Иргэний боловсрол (ёс суртахууны унших эх)” сурах бичгүүдийг ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журмын дагуу, бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах MNS5418:2008 стандарт шаардлагад нийцүүлэн дахин зохиож, хэрэглээнд нэвтрүүлэхийг БСШУСЯ-нд даалгасан шүүхийн шийдвэр (ЗХАШШүүх, 2016, хууд. № 739) гарсан байгаа нь сурах бичгийн зохиогч, редактор, экспертүүдийг сургаж бэлтгэх, туршилт, судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй, чанартай зохион байгуулах, сурах бичгийг бүтээх үйл ажиллагааны үе шат бүрд оролцогч талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох шаардлагатайг нотолж байна.

### Сурах бичигтэй холбоотой судалгаанууд

1. *Стандарт, сургалтын хөтөлбөр, сурах бичгийн “Олон талт суурь судалгаа* (БШУЯ, ШХА, 2014)

БШУЯ-аас 2014 онд ТХБ-ын үзэл санаа агуулга нь бага, дунд боловсролын стандарт, ЕБС-ийн I-XII ангийн сургалтын үндэсний хөтөлбөр болон сурах бичигт хэрхэн туссан болон тэдгээрийн хэрэгжилтийн өнөөгийн байдлыг үнэлж, цаашид сургалтын эдгээр баримт бичгүүдэд ТХБ-ын үзэл санааг хэрхэн тусгах талаар зөвлөмж гаргах зорилготойгоор захиалгат судалгаа хийлгүүлжээ. Уг судалгааг ШХА-ийн Хамтын Ажиллагааны Монгол дахь Суурин Төлөөлөгчийн Газар санхүүжүүлж, МУБИС-ийн эрдэмтэн багш нарын баг гадаадын зөвлөхүүдийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэжээ.

Уг судалгаанд ТХБ-ын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн судалгаа хийхэд олон улсад хэрэглэж буй аргуудыг хэрэглэхдээ Монголын онцлогийг тодорхой хэмжээгээр тооцсон байна. Судалгааны тайлангаас үзэхэд тус үнэлгээ нь судалж буй асуудалтай холбоотой бодлогын болон боловсролын албан ёсны баримт бичгийн шинжилгээ, сургууль, анги танхимын түвшин дэх тэдгээрийн хэрэгжилт гэсэн 3 түвшний шинжилгээ хийж, тэдгээрийн хоорондох хамаарлыг тогтоох зорилт тавиад боловсролын албан ёсны баримт бичгүүдэд ТХБ-ын үзэл санаа “...төдийлөн хангалттай тусгагдаагүйн зэрэгцээ сургууль, анги танхимын үйл явцад ч мөн төдийлөн хангалттай хэрэгжихгүй байна” гэсэн ерөнхий дүгнэлт гаргажээ.

Судалгаанд сонгосон арга зүйнхээ дагуу боловсролын албан ёсны баримт бичгүүдэд ТХБ-ын үзэл санаа хэрхэн туссаныг үнэлэхдээ тухайн хичээлийн стандарт, сургалтын хөтөлбөр, сурах бичигт нийгэм соёл, байгаль орчин, эдийн засгийн хүрээний асуудлыг хэрхэн туссаныг мөн ТХБ-д холбогдох 10 зан үйл, 22 чадварыг тус тус индикатор болгон сонгосон байна. Энэ үнэлгээгээр дээрх 3 төрлийн боловсролын баримт бичгийн “... аль алинд нь мэдлэг олгох, үнэт зүйлс төлөвшүүлэхээс илүүтэйгээр чадвар, чадамжийг хөгжүүлэхийг чухалчилсан байна” хэмээн дүгнээд ирээдүйгээ төсөөлөх, оролцогч талуудын эрх ашгийг ялган таних, хэлэлцэх болон зөвшилцөх чадварууд стандартад 69, сургалтын хөтөлбөрт 47 хувь, сурах бичигт 56 хувь байгаа нь харьцангуй доогуур үзүүлэлт гэж дүгнэжээ.

Мөн “сурах бичгүүдэд ТХ-ийн талаарх дэлхий нийтийн үйл ажиллагаа, хүчин чармайлт, эрч хүчний талаар тусгасан байдал учир дутагдалтай байна хэмээн дурдсан байна.

ТХБ-ын үзэл санааг сурах бичигт хэрхэн тусгасан талаар уг судалгаанд дурдахаа биологи, газар зүй, англи хэл, нийгмийн ухааны хичээлийн сурах бичигт энэ үзүүлэлт харьцангуй гайгүй, харин бусад хичээлд тун хангалтгүй тусгагдсан байна гэж үзээд шалтгаан нь эдгээр мэргэжлийн багш нар бусдаасаа илүү ТХБ-ын талаарх сургалтад хамрагддаг, гадаадын зөвлөхүүдтэй ажилладагтай холбоотой байж болох талаар өгүүлсэн байна.

2. *Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа* (БОНХАЖЯ, ШХА, 2015)

БОНХАЖЯ-аас 2015 онд хийсэн дээрх суурь судалгаанд ТХБ-ын үзэл санааг сурах бичигт хэрхэн тусгах нь тэдгээрийг зохиогчид, экспертүүд, редакторуудын чадавхаас хамаарна гэсэн “Олон талт суурь судалгаа”-ны дүгнэлттэй санал нийлж байгаа ч энэ дүгнэлтэд эргэлзэж байгаагаа судлаачид тэмдэглэсэн байна. Тухайлбал, химийн суурь болон бүрэн дунд боловсролын сурах бичгүүдэд ТХБ-ын үзэл санаа агуулга, арга зүй, хэлбэршүүлэлт буюу дизайнчлалын хувьд хангалттай түвшинд туссаныг жишээ болгон харуулсан байна. Доор шигтгээ болгосон баримт нь Химийн сурах бичигт өгөгдсөн “тун хангалтгүй” гэсэн ангилалд орох үндэслэлгүй байгаа талаар дурджээ.



*Шигтгээ 1.2.3. Химийн сурах бичгүүдэд ТХБ-ын үзэл санаа, агуулгыг тусгасан байдал*

**IX ангийн “ХИМИИ-II” сурах бичиг, 2011 он**

- Хүхрийн хүчлийн үйлдвэрлэл (хх.99)
- Зэс олборлолтын эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, учруулах үр дагаврыг хэлэлцэх даалгаврууд (хх.104), түүний олборлолт, үйлдвэрлэлтэй холбоотой хог хаягдлын асуудлууд (хх.107)
- Алт олборлолттой холбоотой тулгамдсан асуудлын тодорхой кейсүүд хх. (108-110), алт олборлолтын жишээн дээр асуудал шийдвэрлэх арга зүйг алхамчлан эзэмшүүлэх даалгаврууд (хх.110-115)
- Түлш шатахуун, полимер болон хүнс тэжээлийн хэрэглээтэй холбоотой тулгамдсан асуудлууд, тэдгээрийн сөрөг үр дагавар, шийдвэрлэх арга замуудтай холбоотой даалгаврууд туссан байна. Тухайлбал, түлш шатахууны байгалийн эх үүсвэрийн хомсдол экологийн сөрөг нөлөөлөл (хх. 136), полимерийн хог хаягдал (145-147), хүнсний бохирдолт, аюулгүй байдал(159-160)

**XII ангийн “ХИМИИ-V” сурах бичиг 2014 он**

- Бүлэг 3.1. Химийн үйлдвэр ба ногоон хими (хууд.80-86). Энэ бүлэгт ТХ, ТХБ ногоон технологийн товч агуулга, хөгжлийн түүх, тэдгээрийн хоорондох хамаарал үнэлэх тодорхой аргуудын талаар танилцуулжээ.
- Бүлэг 3.2, 3.3,3.4, 3.5, 3.6, 3.7 -т Зэс (хх. 94), аммиак (хх. 101), азотын хүчил (хх. 108), хуванцар (хх. 114), резин (хх. 124) мяндас (хх. 133) үйлдвэрлэх технологийг тус тус ногоон химийн 12 зарчмаар үнэлэх даалгавруудыг сурагчдаар гүйцэтгэтгүүлэхээр тус тус тусгасан байна.

Дээрх судалгааны хүрээнд БШУЯ-аас гаргасан Ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх зорилтын хүрээнд Бага, дунд боловсролын сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандартад нийцүүлэн 2009-2013 оны хооронд ЕБС-ийн бүх ангийн 156 нэр төрлийн сурагчийн сурах бичиг, 59 нэр төрлийн багшийн ном тус тус бэлтгэн сургалтад хэрэглэсэн тухай дурдсан байна.


*Хүснэгт 1.2.17. Боловсролын инклюзив ба үл алагчилагдах нөхцөлийг хангахаар бэлтгэж, сургалтад хэрэглэж буй сурагчийн сурах бичиг ба багшийн номын нэр төрлийн тоо (2009-2013)*

Анги	Сурагчийн сурах бичиг					Багшийн ном	
	Зориулалт (нэр төрлөөр)			Нийт тоо (нэр төрлөөр)			
	Бүх сурагчид	Үндэстний цөөнх	Хөгжлийн бэрхшээлтэй сурагчид	Тоо (ангиар)	Тоо (түвшингээр)		
I	7	2	1	10	50	1	
II	6	1	2	9		0	
III	6	1	1	8		0	
IV	9	1	1	11		1	
V	11	1	0	12		0	
VI	12	1	0	13	67	12	
VII	17	1	0	18		18	
VIII	18	0	0	18		1	
IX	18	0	0	18		1	
X	14	0	0	14	39	2	
XI	13	0	0	13		12	
XII	12	0	0	12		11	
Нийт	Тоо	143	8	5	156	156	59
	Хувь	91.7	5.1	3.2	100		

Дээрх хүснэгтээс суралцагчдын нийгэм соёлын ялгаа болон инклюзив хэрэгцээг тодорхой хэмжээгээр тооцож, тэдэнд зориулсан сурах бичгийг бэлтгэж эхэлсэн байгааг харж болно. Гэвч тэдгээр нь бүх ангийн хувьд ч нэр төрлийн хувьд ч хангалттай түвшинд хүрээгүй байна. Үүнийг нийт сурах бичигт эзлэх үндэстний цөөнхийн хүүхдүүдэд зориулсан сурах бичгийн нэр төрөл 5.1 хувь (I-VII ангийн казак хэл ба I ангийн тува цагаан толгой), хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан сурах бичгийн нэр төрөл 3.2 хувь (зөвхөн математик, монгол хэл) байгаа явдал илтгэнэ. Энэ байдал нь ТХБ-ын гол зарчмын нэг болох суралцагчдыг чанартай боловсрол эзэмшихэд нь “үл алагчлах байдал” бүрэн хангагдаагүй байгааг харуулж байна.


Түүнчлэн 2015 онд хийгдсэн судалгаанд (БОНХАЖЯ, ШХА, 2015)ЕБС-ийн I-VII ангид үндэстний хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдсэн сурах бичгүүдийн боловсролын түвшин болон ангид ногдох хувьба хазайлт (Зураг 1.2.25 ба 1.2.26)-аас харахад ЕБС-ийн анги бүрд ногдох сурах бичгийн нэр төрлийн тооны дундаж хувь нь 8.3 байна. Энэ дундажтай анги бүрийг болон боловсролын түвшин бүрийг харьцуулахад бага боловсролын түвшний I-III анги сөрөг хазайлт ихтэй, суурь боловсролын VII-IX анги тэнцүү хэмжээний эерэг хазайлт ихтэй харин бүрэн дунд боловсролын X-XII анги хазайлт багатай байгаа нь тус тус харагдаж байна.

Зураг 1.2.25. ЕБС-ийн I-VII ангид үндэсний хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдсэн сурах бичгүүдийн боловсролын түвшин болон ангид ногдох хувь (2009-2015)



Мөн бага болон суурь боловсролын ангиудын хазайлт дундаж хувийн 24-36 хувийг ойролцоогоор эзэлж байна. Судалгаанд хэрвээ хичээл бүр сурах бичигтэй байна гэж тооцвол бага ангийн сурагчдын судлах хичээлийн тоо буюу эзэмших агуулга дээрх дунджаас бага, улмаар сурагчдын ачаалал нь харьцангуй бага, түвшин дотроо жигд бус байгаа бол суурь боловсролд сурагчдын судлах хичээл, эзэмших агуулга нь тэр дунджаас харьцангуй их, сурагчдад ирэх ачаалал дийлэнх ангидаа адилхан хэт их байгааг харж болно. Мөн VI ангийн хичээлийн хазайлт түвшин дотроо эрс ялгаатай байгаа нь сургуулийн бүтцийг өөрчлөхөд энэ анги бага боловсролоос суурь боловсролд хамаарах болж өөрчлөгдсөнтэй холбоотой байх талтай хэмээн үзжээ.

Зураг 1.2.26. Анги бүрийн сурах бичгийн нэр төрлийн дунджаас тооцсон хазайлт (2009-2015)




Түүнчлэн энэ хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан монгол хэл, математикийн 16 сурах бичиг, багшийн 1 номыг шинээр зохиожээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах бичгийг төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтээр бэлтгэдэг байгаад 2014 оноос эхлэн улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэн нийлүүлдэг болсон байна. Мөн үндэсний цөөнхөд зориулсан хос хэлний сургалтын бодлого, агуулга, хөтөлбөр, сурах бичгийг 2015-2016 оны хичээлийн жилд багтаан боловсруулж, бэлтгэн хангах шийдвэрийг БСПУ-ны Сайдын 2015 оны А/220 дүгээр тушаалаар гаргажээ.

### Бүлэг дүүргэлт

2017-2018 оны хичээлийн жилд бүлэг дүүргэлт улсын хэмжээнд 28.3, төрийн өмчийн сургуульд 29.5, хувийн өмчийн сургуульд 17.8 байна (Зураг 1.2.27 ба 1.2.28).

Зураг 1.2.27. Бүлэг дүүргэлт: Байршил, бүс нутгаар, (2017/18 оны хичээлийн жил)




Бүлэг дүүргэлтийг боловсролын түвшингээр авч үзвэл, улсын хэмжээнд дунджаар бага ангид 30.3, дунд ангид 26.9, ахлах ангид 30.3 тус тус байна. Бүлэг дүүргэлтийн улсын дунджийг сургуулийн байршлаар авч үзвэл, хотод 31.5, хөдөөд 26.1 байна. Тухайлбал, аймгийн төвийн сургуульд 30.7,

сумын сургуульд 24.5, баг, хороо, тосгоны сургуульд 18.2 тус тус байна. Хөдөөгийн сум, баг, хороо, тосгонд үйл ажиллагаа явуулж буй ихэнх сургуулиудын хувьд бүлэг дүүргэлт тогтоосон нормативт хэмжээнээс доогуур байна. Бүлэг дүүргэлтийг бүсчилж авч үзэхэд Хангайн бүсийн багийн төвд хамгийн бага бүлэг дүүргэлттэй бол Улаанбаатарт хамгийн их бүлэг дүүргэлттэй байна.

Улсын хэмжээнд бүлэг дүүргэлтийг ангийн түвшингээр авч үзэхэд 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар I-XII ангид 22.2-32.1-д байгаа нь норматив түвшинд байна Гэвч сургуулийн байршил, хэв шинж, өмчийн хэлбэр, ангийн түвшинд нарийвчлан авч үзэхэд бүлэгт дүүргэлт хэт өндөр сургуулиуд байгаа нь хэдий санхүүгийн хувьд үр ашигтай ч боловсролын чанарт сөргөөр, хэт доогуур байгаа нь боловсролын чанарт бас сөргөөр нөлөөлж, санхүүгийн хувьд үр ашиггүй байна.


Хот суурин, төвлөрсөн газар, томоохон суманд суурьших иргэдийн шилжилт хөдөлгөөний улмаас сум, багийн сургуулийн хүүхдийн тоо цөөрч, сургууль хүчин чадлаараа бүрэн ажиллаж чадахгүйд хүрч байна. Иймд суурь боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургууль завсардалтыг бууруулах, хамран сургалт бага хувьтай байгаа аймаг, (сум)-ын сургуулийн ачааллыг харгалзан сургуулиудын бүтэц, хэв шинжийг оновчтой болгох, ЕБС-ийн зураглалыг шинэчлэх, засаг захиргааны нэгжийг томсгох шаардлага зайлшгүй гарч байна.

Зураг 1.2.28. Хот, хөдөөгийн сургуулийн бүлэг дүүргэлт: Өмчийн хэлбэрээр (2017/2018 оны хичээлийн жил)



Бүлэг дүүргэлтийг өмчийн хэлбэр, хот, хөдөө гэсэн байршлаар авч үзэхэд хотод бүлэг дүүргэлт нь норматив хэмжээнээс хэтэрсэн төрийн өмчийн 46 сургууль, хөдөөд 12 сургууль байна. Хотод норматив хэмжээнээс доогуур бүлэг дүүргэлттэй хувийн өмчийн 110 сургууль, төрийн өмчийн 21 сургууль байгаа бол хөдөөд норматив хэмжээнээс доогуур бүлэг дүүргэлттэй хувийн өмчийн 21 сургууль, төрийн өмчийн харьцангуй хэт олон буюу 286 байна.

Зураг 1.2.29. Бүлэг дүүргэлтийн улсын дундаж: Сургууль ба боловсролын шатлалаар (2006/07-2017/18 оны хичээлийн жил)




Бүлэг дүүргэлтийн улсын дунджийг боловсролын шатлалаар авч үзвэл, сүүлийн 12 жилийн хугацаанд харилцан адилгүй өөрчлөлттэй байна. Тухайлбал, 2006-2008 онд ахлах ангийн, 2012-2015 онд дунд ангийн, 2015-2018 онд бага ангийн бүлэг дүүргэлт улсын дунджаас дээгүүр байна (Зураг 1.2.29). Төрийн өмчийн сургуульд бүлэг дүүргэлт нормативт хэмжээнээс хэтэрснээс багш нарын ажлын ачаалал ихсэж, нэг багшид ногдох хүүхдийн тоо эрс нэмэгдэж, хүүхэд бүрдтэй тулж ажиллах боломж хязгаарлагдан, боловсролын чанар, суралцагчдыг бодитой үнэлэхэд сөргөөр нөлөөлж, сурлагын хоцрогдол үүсэх нөхцөлийг бүрдүүлж буй нэг шалтгаан болж байна. Түүнчлэн

бүлэг дүүргэлт нормативоос хэтэрсэн нь танхимын болон ширээ, сандал, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмж багасаж, нэг ширээнд гурваараа суух тохиолдол ч гарч байна.

### Багш, сурагчийн харьцаа

ЕБС-ийн нэг багшид ногдох хүүхдийн дундаж тоо улсын хэмжээнд дунджаар 2017 онд 19.6 байгаа ба үүнээс бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо 32.3, дунд, ахлах ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо адилхан 13.4 байна (Зураг 1.2.30).

Зураг 1.2.30. Багш, сурагчийн харьцаа: Сургууль ба боловсролын шатлалаар (2006/07-2017/18 оны хичээлийн жил)




Бага ангийн бүлэг дүүргэлт, бага ангийн багш сурагчийн харьцааны үзүүлэлтүүдээс харахадсум, багийн сургуульд бүлэг дүүргэлт хэт бага, багш, сурагчийн харьцаа ч бага байна. Улмаар энэ нь бүлгийн тоо цөөрөхөд хүргэж, багшийн норматив цаг гүйцэхгүй болсноор багш олон ангид олон төрлийн хичээл заах шаардлагатай болдог. Энэ нь мэргэжлийн багшийн далд хомсдолыг бий болгож, сургалтын чанарт сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ багшийн ажлын байрны үл алагчилсан шударга байдал алдагдахад хүргэж байна.

### Мэргэжлийн багшийн хангалт

ЕБС-ийн нийт ажиллагчид болон мэргэжлийн багшийн тоо сүүлийн 12 жилийн туршид тасралтгүй өссөн байна (Зураг 1.2.31). Энэ дүр зургийг нь сургуулийн насны хүүхдийн тооны өөрчлөлтийн чиг хандлага (Зураг 1.2.12), элсэлтийн жин (Зураг 1.2.13), бага, дунд боловсролын шатлал бүрийн хамран сургалт (Зураг 1.2.14-16), төгсөлтийн хувь (Зураг 1.2.20), нийт суралцагчдын тоо (Зураг 1.2.21)-той тус тус харьцуулахад нэгэн утгат хамаарал ажиглагдахгүй байна.


2017-2018 оны хичээлийн жилд ЕБС-д нийт 47,991 (төрийн өмчийн сургуульд 43,754, хувийн өмчийн сургуульд 4,237) албан хаагчид ажиллаж байна. Үүнээс 29,242 үндсэн багш байгаагийн 10,238 бага ангийн, 19,004 дунд, ахлах ангийн багш тус тус байна (Зураг 1.2.30).

Зураг 1.2.31. ЕБС-ийн ажиллагчид, үндсэн багшийн тоо (2006/07-2017/18 оны хичээлийн жил)



ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт 2017 оны байдлаар улсын дундаж 97.0 хувь, бага ангийн мэргэжлийн багшийн хангалт 97.0, дунд, ахлах ангийн мэргэжлийн багшийн хангалт 97.1 хувьтай байна (Зураг 1.2.31). Энэ нь 2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн 6 настай хүүхдийг сургуульд шинээр элсүүлсэнтэй холбоотой.

Зураг 1.2.32. ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалт: Сургууль ба боловсролын шатлалаар (2006-2018)



ЗГ-ын 2008 оны 316 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан хэрэгжүүлсэн байна.


ЕБС-ийн бүтцийн өөрчлөлт, цогц чадамжид суурилсан боловсролын стандарт болон сургалтын нээлттэй хөтөлбөрийг суралцагчдын эрэлт хэрэгцээнд тохируулан хэрэгжүүлэх чадвартай багш бэлтгэх, багшийн мэргэшил, арга зүйг тасралтгүй дээшлүүлэх, цаашид тогтвортой хөгжих нөхцөлийг хангах зорилтын хүрээнд “Багшийн ажлын байрны тодорхойлолт, “Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам” (БСШУ-ын сайдын 73-р тушаал, 2008), “Багшлах эрх олгох, хасах журам” (БСШУ-ы сайдын 74-р тушаал, 2008), “Мэргэжил дээшлүүлэх журам” (БСШУ-ы Сайдын 72-р тушаал, 2008) зэрэг эрх зүйн 20-иод баримт бичгийг харилцан уялдаа холбоотойгоор боловсруулан баталж, багшлах эрх зүйн шинэ орчныг бүрдүүлсэн байна. Түүнчлэн 2012 онд Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийг сэргээн байгуулснаар багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо институтчилагдаж, мэргэжлийн багшийн хангалад эерэгээр нөлөөлсөн.

2017 оны байдлаар 590 бага ангийн багш, 1142 дунд, ахлах ангийн багш шинээр ажилд оржээ. Энэхүү үзүүлэлтийг сүүлийн 12 жилийн дунджаар авч үзэхэд жилд дунджаар 360 гаруй бага ангийн багш, 900 гаруй дунд, ахлах ангийн багш шинээр ажилд орж байгаа нь жилээс жилд багшийн тоо өсөж байгааг харуулж байна.

**Ээлжийн коэффициент**

ЕБС-ийн ээлжийн коэффициентийн улсын дунджийн сүүлийн 10 жилийн хугацааны өөрчлөлтийг нийт сургуулиар болон төрийн ба хувийн өмчийн сургуулиар ангилан тооцов (Зураг 1.2.30). Тухайлбал, 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар ЕБС-ийн ээлжийн коэффициент 1.3, үүнээс төрийн өмчийн сургуульд 1.4, хувийн өмчийн сургуульд 0.4 байна (Зураг 1.2.32).

Зураг 1.2.33. ЕБС-ийн ээлжийн коэффициент: Өмчийн хэлбэрээр (2007/08-2017/18 оны хичээлийн жил)



Хэдийгээр улсын хэмжээнд ээлжийн коэффициент хэвийн хэмжээнд байгаа ч зарим сургуулиуд 3 ээлжээр хичээллэсээр байна. Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирж буй иргэдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага түүний дотор ЕБС-ийн суудлын тоо, хүчин чадал хүн амын өсөлтийггүйцэж, шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийг бүрэн дааж чадахгүй байна.

Сүүлийн жилүүдэд 3 ээлжээр хичээллэж буй сургуулиудыг цөөлөх талаар эрчимтэй арга хэмжээ авч, шинээр сургууль барих, өргөтгөлийг нэмж барьж байгаа боловч 3 ээлжээр хичээллэж буй сургуулийн тоо төдийлөн буурахгүй байна (Хүснэгт 1.2.18).

Хүснэгт 1.2.18. Гурван ээлжээр хичээллэж буй сургууль, бүлэг, суралцагчийн тоо (2006-2017)

он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Сургуулийн тоо	10	16	31	35	34	25	20	23	22	24	32	25
Бүлэг	58	94	146	158	179	131	136	141	157	175	224	186
Суралцагч	2377	3506	5114	5483	6150	4454	4723	4729	5469	6311	8755	7335

Гэвч 2013 онд 5 (Дорноговь аймагт Замын-Үүд сумын сургууль, УБ хотод 85, 106, Голомт цогцолбор, 109-р сургууль), 2014 онд 5 (Хэнтий аймагт Баян-адарга сургууль, УБ хотод 53, 79, 92, 3-р сургууль), 2015 онд 5 (Орхон аймагт Эрдэнэт цогцолбор, УБ хотод 51, 58, 114, Цэцээ гүн цогцолбор), 2016 онд 5 (Хөвсгөл аймагт Гурван-эрдэнэ, УБ хотод 33, 67, 61, 73-р сургууль), 2017 онд 7 (УБ хотод 13, 14, 84, 97, 102, Шавь цогцолбор, 115-р сургууль) сургуулийг шинээр барих, өргөтгөл барих зэргээр жилд дунджаар 4-5 сургуулийг 3 ээлжээс гаргаж байна.

Боловсролын салбарт 2007-2017 онд улсын төсвийн хөрөнгөөр 81.2 мянган суудалтай 184 сургуулийн хичээлийн байрыг шинээр барьж ашиглалтад оруулсан байна (Зураг 1.2.33).

Зураг 1.2.34. Шинээр ашиглалтад оруулсан сургуулийн тоо, хүчин чадал (2006-2017)



ЕБС-ийн хүчин чадал нэмэгдэж буй ч дараах шалтгаанаар сургуулийн хүчин чадал хүрэлцэхгүй хомсдох асуудал үргэлжилсээр байна.

- Хүн амын өсөлт
- Боловсролын хөгжлийн шаардлагаар шинээр үүсэж буй хэрэгцээ
- Одоо ашиглаж буй барилгын насжилт өндөр, ашиглалтын хугацаа дууссан, зориулалтын бус барилгад сургалт явуулж байгаа явдал

Боловсролын салбарын статистик мэдээгээр одоо ашиглаж буй ЕБС-ийн 934 хичээлийн байрны 25 хувь, 1970 оноос өмнө баригдсан барилгууд тул эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл шаардлагыг хангахгүй болсон, мөн 1970 оноос хойш баригдсан ч газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар буурсан байна (БСШУЯ-ны 2010-2011 оны хичээлийн жилийн статистик мэдээ, 2011).

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газраас 2012 онд сургууль, дотуур байр, спорт заалны нийт 224 барилгыг нэн тэргүүнд шинээр барих шаардлагатайгэсэн дүгнэлт гарсанжээ. Үүний 198 нь сургуулийн, 23 нь дотуур байрны, 3 нь спорт заалын барилга байна. Түүнчлэн Улаанбаатар хотод сургуулийн 27 барилга газар хөдлөлтийн нормын тооцоолол хийлгүй барьсан бөгөөд Улаанбаатар хот нь газар хөдлөлийн 7-8 баллын бүсэд оршдог газар болохыг онцолсон байна.


Иймд нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд суурилсан сургуулийн зураглалыг шинэчлэн баталж хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

### Инклюзив ба үл алагчлах байдал

#### ЕБС-ийн суралцагчдын жендэрийн тэнцвэрт байдлын индекс

ЕБС-д суралцаж байгаа нийт суралцагчдын хүйсийн харьцааны индекс 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар 1.00 байгаа бөгөөд хүйсийн харьцааг түвшингээр авч үзвэл бага ангид 0.96, дунд ангид 0.98, ахлах ангид 1.19 байна. Өөрөөр хэлбэл, 100 эрэгтэй суралцагчид 100 эмэгтэй, бага ангийн 100 эрэгтэй сурагчид 96 эмэгтэй, дунд ангийн 100 эрэгтэйд 98 эмэгтэй, ахлах ангийн 100 эрэгтэйд 119 эмэгтэй тус тус ногдож байна гэсэн үг юм (Зураг 1.2.35).

Зураг 1.2.35. Хүйсийн харьцаа: Боловсролын шатлалаар (2006/07-2017/18 оны хичээлийн жил)




Бага, дунд ангид хүйсийн харьцаа жигд байсан бол ахлах ангид хөвгүүдийн тоо буурсан байна.

### Эмэгтэй багшийн эзлэх хувь

2017-2018 оны хичээлийн жилд ЕБС-д нийт 29,242 багш ажиллаж байгаагийн 23,876 буюу 81.6 хувийг эмэгтэй багш эзэлж байна. Бага ангийн багшийн хувьд нийт 10,238 багшийн 9,724 буюу 95.0 хувийг, дунд, ахлах ангийн 19,004 багшийн 14,152 буюу 74.5 хувийг тус тус эмэгтэй багш тус тус эзэлж байна (Зураг 1.2.36).

Зураг 1.2.36. Эмэгтэй багшийн эзлэх хувь: Боловсролын түвшингээр (2006/07-2017/18 оны хичээлийн жил)



Сүүлийн 12 жилийн байдлаар авч үзэхэд бага ангийн багшийн хувьд эмэгтэй багшийн эзлэх хувь 90-ээс дээш, дунд, ахлах ангийн багшийн хувьд эмэгтэй багшийн эзлэх хувь 74.0 хувь буюу жигд үзүүлэлттэй, эрс өөрчлөлтгүй байна.


### Ус хангамжийн нөхцөл

Монгол Улс ус хангамжийн төвлөрсөн болон төвлөрсөн бус үндсэн 2 төрөлтэй. Нийт сургуулиудын 54% нь (413 сургууль) төвлөрсөн ус хангамжтай бөгөөд эдгээр сургуулиуд нь ихэвчлэн Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотууд, аймгийн төвүүдэд байрлаж байна. Төвлөрсөн ус хангамжийн сүлжээнээс усаа авдаг сургуулийн тоогоор Орхон (100%), Говьсүмбэр (100%), Дархан-Уул (92%), Улаанбаатар (85%), Сэлэнгэ (65%), Өмнөговь (62%), Дорноговь (62%) аймгууд тэргүүлж байна. Нийт сургуулиудын 46% нь (357 сургууль) төвлөрсөн бус эх үүсвэрээс усаа хангаж байгаа ба эдгээр нь ихэвчлэн сумдын сургуулиуд юм ("Цэцэрлэг, ЕБС, Дотуур байрын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал" судалгааны тайлан, 2017).

### Ариун цэврийн байгууламжийн нөхцөл

Ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг тодорхойлохдоо 2015 онд батлагдсан "Цэцэрлэг, сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйн норм шаардлага"-ын 2.1.1 дэх "Нэг ээлжид хичээллэж буй 1 хичээлийн байранд 30 эмэгтэй хүүхдэд 1 суултуур, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур+1 шээлтүүр ногдохоор тооцож байгуулах" гэсэн заалтыг үндэслэн нэг ээлжид хичээллэх эрэгтэй, эмэгтэй сурагчдын тоог ариун цэврийн өрөөний суултуурын тоонд харьцуулан гаргасан (Зураг 1.2.37).

Зураг 1.2.37. Нэг суултуурт ногдох охид, хөвгүүдийн тоо (2017)



Судалгаанаас харахад сургуулиудын 60% нь норм шаардлагыг хангаж байгаа буюу нэг суултуурыг нэг ээлжид хичээллэж буй 30 хүртэлх эмэгтэй хүүхэд хэрэглэж байна. Харин сургуулиудын 40% нь норматив шаардлагын үзүүлэлтэд хүрэхгүй байна. Үүнээс 23% нь 30-50 охид 1 суултуурыг хэрэглэж байгаа буюу суултуурын тоог 1 ширхгээр нэмэгдүүлэхэд л норматив шаардлагыг хангаж болохоор үзүүлэлттэй байна. Энэ үзүүлэлт нийслэл болон орон нутагт сурагчийн тооноос хамааран нэлээд ялгаатай байдал ажиглагдаж байна. Харин хөвгүүдийн хувьд нийт сургуулиудын 39% нь л норматив шаардлагыг хангасан буюу нэг суултуурыг нэг ээлжид хичээллэж буй 40 хүртэлх эрэгтэй сурагчид хэрэглэж байна.

Сургуулийн байгууламжийг үнэлэх нэг гол индикатор бол нэг гар угаалгуурт ногдох суралцагчийн тоо бөгөөд ЕБС-ын хувьд энэхүү индикаторын үзүүлэлт сайн буюу бүгд гар угаагуураар хангагджээ. Улсын хэмжээнд нийт сургуулиудын 37% буюу 282 сургууль усаа зөөж дүүргэдэг энгийн угаагуур, 61% буюу 470 сургууль нэгдсэн шугамд холбогдсон байнгын устай крант бүхий гар угаагуур ашигладаг. Сургуулийн ариун цэврийн байгууламж нь хүүхдэд ээлгүй (гар угаах саван байхгүй, бага насны хүүхэд өвлийн хүйтэнд гадаа гарч бие засах, гаднах нүхэн жорлон нь хүүхэд халтирах, нүхэнд унах эрсдэлтэй г.м) байгаа нь тэднийг эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг эзэмшихэд хүндрэл учруулж байна. ("Цэцэрлэг, ЕБС, Дотуур байрын ус хангамж, ариун цэврийн байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал" судалгааны тайлан, 2017)

#### 1.2.4. Дүгнэлт, Зөвлөмж

Энэхүү дэд бүлгийн судалгаанд ашигласан боловсролын хүртээмж, оролцоо; чанар, нийцийн талаар баримталж ирсэн бодлого, эрх зүйн хувьд баталгаажсан сургалтын үндсэн баримт бичгүүд болох боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг, орчны стандартууд болон эдгээр баримт бичгийн боловсруулалт ба хэрэгжилтийн чиглэлээр сүүлийн жилүүдэд хийгдсэн зарим томоохон судалгаануудын үр дүнд тулгуурлан дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна. Тус тайлангийн 2.1 дэд бүлэгт Бага, дунд боловсролын инклюзив ба үл алагчилах байдлын талаар дэлгэрэнгүй өгүүлсэн тул энэ дэд бүлэгт тус шалгуураар тусгайлсан дүгнэлт зөвлөмжийг оруулаагүй болно.

#### Дүгнэлт: БДБ-ын хүртээмж, оролцооны тухайд

##### Ололт амжилт

1. Монгол Улс боловсролын хүртээмж, оролцооны талаар дэвшүүлсэн Мянганы хөгжлийн зорилтдоо 6 настай хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, бага боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх замаар олон арван жил мөрдөж ирсэн сургуулийн сургалтын тогтолцоогоо 2 жилээр уртасгаж, 12 жилийн тогтолцоонд шилжүүлэн олон улсын жишигт нийцүүлэх онцгой зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүнд, хариуцлагатай зорилтоо хүрэхийн тулд төрөөс цогц бодлого хэрэгжүүлж, хүртээмжийг жил бүр тооцон дүгнэж, сургуулиудад зохих орчин нөхцөлийг бүрдүүлж, тэднийг дэмжин ажилласнаар бага, дунд боловсролын хүртээмж ба оролцоог тогтвортой нэмэгдүүлж, товлосон зорилтоо хүрч чадсан нь бага, дунд боловсролын түвшинд олсон томоохон амжилтын нэг юм. Үүнийг сургуульд элсэх насыг доошлуулсан ч гэсэн бага боловсролын элсэлтийн хувь буураагүй өндөр хэвээр байгаа үзүүлэлт нотолно.
2. Бага боловсролын хамрагдалтын бохир жин 2015-2016 оны байдлаар 98.4 хувь, эрэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жин 98.3 хувьтай байгаа нь “Монголын боловсролыг 2006-2015 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний бага боловсролын хамран сургалтын 97.8



хувьд, эрэгтэй хүүхдийн хамран сургалтын бохир жинг 96.1 хувьд хүргэнэ гэсэн зорилтыг хангасан байна.

3. Дээрх ололт амжилт нь төрөөс боловсролын үйлчилгээндээ инклюзив ба үл алагчилах байдлыг хангах талаар оновчтой бодлого баримталж, цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, бүх талын бүх түвшний түншлэлийг ханган ажилласны үр дүн юм. Тухайлбал, 6 настай болон малчдын хүүхдийн сургуульд хамруулах талаар тодорхой зорилтууд дэвшүүлж, 6 настны багш, анги танхим, сурах бичиг, хэрэглэгдэхүүн, ариун цэвэр эрүүл ахуйн орчныг тусгайлан бэлтгэх, дотуур байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулж, гэрийн нөхцөлд дөхүүлэх, дотуур байрны багшийг давтан бэлтгэх, хүүхдийн хөгжил, хүмүүжлийн олон талт үйл ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлснээр малчдын болон 6 настай хүүхдийн хамралт тогтмол нэмэгдэж, сургуульд хамрагдаж буй хүүхдийн тоо жилээс жилд өсөж байна.

#### Алдаа, дутагдал

1. Сургуулийн насны хүүхдийн тооны бодит өсөлтийн прогноз, бүс нутгийн хөгжлийн хэтийн бодлогод үндэслэгдсэн сургуулийн зураглал (school mapping)-ын тооцоолол хийгдэхгүй болж, улс төрийн бодлогогүй шийдвэрүүд, хууль тогтоомжоор олгогдсон орон нутгийн болон сургалтын байгууллагуудын удирдлагуудын шийдвэр гаргах эрх мэдлийн бодлогогүй хэрэглээ зэргээс хамаарч сургуулийн бүтэц, хэмжээ, хэв шинж, байршил оновчгүй болж, бага, дунд боловсролд олон сорилт бэрхшээлийг үүсгэх гол шалтгаан болсон байна. Тухайлбал, сургуулийн зураглалын оновчгүй байдал нь хөдөөд цөөн хүүхэдтэй хэрнээ мэргэжлийн багшийн далд хомсдол үүсгэснээс, нийслэлд бүлэг дүүргэлт хэтрэлтээс тус тус улбаатайгаар сурлагын амжилтын үзүүлэлт буурах үндсэн шалтгааны нэг болж байна.
2. Бага, дунд боловсролын улсын төсөв, зээл болон гадаад дотоодын донор, хандивлагчдын санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээ хэдийгээр нэмэгдэж, сургууль ба дотуур байрны олон барилга шинээр барьж, хүчин чадлыг байнга нэмэгдүүлж ирсэн ч тэдгээр нь дээр дурдсан алдаатай бодлогын дүнд бий болсон сөрөг үр дагавруудыг багасгахад илүүтэй зориулагдан үр ашиг муутай зарцуулагдаж байна. Дээр дурдсанаар эдийн засгийн үр өгөөж ч сул байна.

#### Сорилт, бэрхшээл

1. Хөдөө орон нутгаас нийслэлд шилжин ирж буй иргэдийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага түүний дотор ЕБС-ийн суудлын тоо, хүчин чадал хүн амын өсөлтийг гүйцэж, шилжилт хөдөлгөөний өөрчлөлтийг бүрэн дааж чадахгүй байгаагаас бүлэг дүүргэлт улсын хэмжээнд хэвийн байгаа ч бүс нутаг, байршлаас хамаарч харилцан адилгүй жигд бус тархалттай болсон байна. Хамгийн их бүлэг дүүргэлттэй сургуулиуд нийслэлд, хамгийн бага бүлэг дүүргэлттэй сургуулиуд сумын багт байна. Тухайлбал, хөдөөд төрийн өмчийн 119 сургууль 20 хүртэлх хүүхдийн бүлэг дүүргэлттэй, нийслэлд төрийн өмчийн 17 сургууль 40-өөс дээш хүүхдийн бүлэг дүүргэлттэй байна. Түүнчлэн 2007-2017 онд 184 сургуулийг шинээр барьж, суудлын тоог 81,2 мянгаар нэмэгдүүлсэн ч 3 ээлжээр хичээллэж буй сургуулийн тоо буурахгүй байна.
2. ЕБС-ийн ангилал, хэмжээ, хэв шинж, байршил буюу сургуулийн зураглал оновчгүй болж хөдөөд цөөн суралцагчтай 12 жилийн сургуулийн тоо олширсноос сургалтын төлөвлөгөөгөөр олгогдсон сонгон суралцах боломжууд хангагдахгүй байх, мэргэжлийн багшийн далд хомсдолыг үүсгэх, улмаар суралцагчдын сургалтын амжилтад сөргөөр нөлөөлж байна
3. Нэг ээлжид хичээллэж буй 30 хүртэлх эмэгтэй хүүхэд нэг суултуурыг хэрэглэж байгаа буюу норматив шаардлагыг хангасан ЕБС нийт ЕБС-ийн 60 хувийг эзэлж байна. Энэ үзүүлэлт нийслэл болон орон нутагт сурагчийн тооноос хамааран ялгаатай байна. Улсын хэмжээнд 282 сургууль усаа зөөж дүүргэдэг энгийн угаагуур ашигладаг. Сургуулийн ариун цэврийн байгууламж нь хүүхдэд ээлгүй (гар угаах саван байхгүй, бага насны хүүхэд өвлийн хүйтэнд гадаа гарч бие засах, гаднах нүхэн жорлон нь хүүхэд халтирах, нүхэнд унах эрсдэлтэй г.м) байгаа нь тэднийг эрүүл ахуйн зөв дадал хэвшлийг эзэмшихэд хүндрэл учруулж байна.

#### **Зөвлөмж: БДБ-ын хүртээмж, оролцооны тухайд**

1. Шилжилт хөдөлгөөн ихсэж, бүлэг дүүргэлт хот, хөдөөд эрс ялгаатай болж, үндэсний хэмжээн дэх сургуулийн зураглалын төлөвлөлт, тооцоолол алдагдаж, бага, дунд боловсролд оруулсан санхүүжилт, хөрөнгө оруулалтын үр ашиг, үр өгөөж бага байгаа нь зөвхөн боловсролын салбарын төдийгүй нийгэм, эдийн засгийн шинжтэй томоохон асуудал болохыг харгалзан ЕБС-ийн бүтэц, хэв шинж, байршлыг бүсчилсэн хөгжлийн

үзэл баримтлалд нийцүүлэн оновчтой болгох, сургуулийн зураглалыг шинээр боловсруулж, баталгаажуулан хэлбэрэлтгүй мөрдөх шаардлагатай байна.

2. Үндэсний хэмжээнд сургуулийн зураглал нь боловсролын үйлчилгээний инклюзив ба үл алагчилах байдлыг хангасан, эдийн засгийн хувьд үр ашигтай, чанар, нийцийн хувьд үр өгөөжтэй, ажиллагааны хувьд тогтвортой байх нөхцөлийг хангасан байхаар сургууль байгуулж, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эрх мэдлийн хуваарилалтыг нягтлан судалж, оновчлох нь сургуулийн шинэ зураглалыг мөрдөх гол хөшүүрэг болно.
3. Сургуулийн хичээлийн болон дотуур байрны барилгыг засварлах, өргөтгөх, шинээр барихдаа эрүүл ахуй, ариун цэврийн тусгай шаардлагууд, норм нормативыг бүрэн хангасан байхаар төлөвлөж, төсөвлөж, хүлээн авах хариуцлагын хяналтыг сайжруулах, удирдлагын бүх түвшний шийдвэр гаргагчид нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд суралцах, амьдрах боломж нөхцөлийг бүрдүүлэх, аюул осол, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангахад онцгой анхаарч, энэ чиглэлээр байгууллага, хамт олонд шинэ соёлыг төлөвшүүлэх хэрэгтэй байна.

**Дүгнэлт: БДБ-ын чанар, нийцийн тухайд (а).стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө)**

Ололт амжилт

1. Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд заагдсан “2008-2014 онд багтаан батлагдсан графикайн дагуу бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөө ба хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэх замаар ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд бүрэн шилжүүлэх, 6 ба 7 настай хүүхдийг сургах агуулга, арга зүй, сургалтын орчныг бүрдүүлэх” зорилтууд амжилттай хэрэгжсэн байна.
2. Бага, дунд боловсролын стандарт ба киррикулимийг шинэчлэх үзэл баримтлал, Бага, дунд боловсролын стандарт, 12 жилийн сургалттай ЕБС-ийн сургалтын үндэсний болон цөм хөтөлбөр, сурах бичгийн стандартад суралцахуйн зорилго, үр дүнг цогц чадамжуулж, агуулгыг нээлттэй, сонголттой болгож, арга зүйг бэлэн мэдээлэл дамжуулахаас, шинэ мэдлэг бүтээлгэх чиглэлээр өөрчилж, үнэлгээг эзэмшихүйн зүй тогтоолын үе шатуудад харгалзуулан оновчлох онол, арга зүйн тодорхой шийдлүүдийг хийж, ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүйг ЕБС-ийн сургалтад зохих түвшинд интеграцчилагдаж чадсан байна.
3. 2002 онд батлагдан өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Бага, дунд боловсролын стандарт ба киррикулимийг шинэчлэх үзэл баримтлалд нийцүүлэн боловсролын 20 стандарт, сургалтын үндэсний түвшний 178 хөтөлбөр, сурагчийн 294 сурах бичиг, багш боловсролын 6 стандарт, багшийн 154 номыг тус тус боловсруулан сургалтад мөрджээ.
4. 2008-2015 онд боловсруулж хэрэгжүүлсэн Бага, дунд боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрүүд нь цогц чадамжид суурилсан боловсролын стандартын онол, арга зүйн шийдлийг бодит үйл хэрэг болгон хувиргах технологийн шийдэл болон хэлбэржиж, багшид үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, бүх ангийн бүх хичээлийн сурах бичиг зохиох болон багш нарын мэргэжил дээшлүүлэх үйлийн хөтөч болсон төдийгүй ЕБС-ийн сургалтыг 12 жилд шилжүүлэх шилжилтийг амжилттай дуусгахад чухал үүрэг гүйцэтгэсэн түүхэн ач холбогдолтой сургалтын баримт бичгүүд болсон байна.
5. Бага, суурь боловсролын цөм хөтөлбөрт сургалтыг дэмжих үйл ажиллагаатай холбоотой бүрэлдэхүүн хэсгийн агуулга, арга зүйг сургалтын төлөвлөгөөнд интеграцчилж албажуулсан нь сургуулийн түвшинд ТХБ-ыг дэмжих олон арга хэлбэрийг ашиглан суралцагчдын хандлага, зан үйлийн түвшинд бодит ахиц, дэвшил гаргах боломжийг бүрдүүлж, мөн боловсролын түвшин хоорондын залгамж холбоог хангах зорилгоор бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, цөм хөтөлбөрт сонголтын төрөл, хувилбаруудыг нэмэгдүүлж, ахлах сургуулийг хөгжүүлэх бодлогын шийдлийг, хийж чадсан байна
6. Монгол Улсын ЗГ,НУБ-ын төрөлжсөн байгууллагууд, гадаад улсын ЗГ-ууд олон улсын санхүүгийн болон мэргэжлийн байгууллага хоорондын түншлэл нь бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, суралцахуй болон багшлахуйн арга зүйн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсаар ирсэн байна. Тухайлбал,
  - a. Бага, дунд боловсролын сургалтын үндэсний болон цөм хөтөлбөрүүдэд ТХБ-ыг интеграчилахболон интеграцлагдсан байдлыг үнэлэх судалгаанууд (ШХА болон энэ байгууллагаас хэрэгжүүлсэн төслүүд 2008 -2018)
  - b. Хичээлийн судалгааны арга зүйг багш нарт эзэмшүүлэх болон түгээн дэлгэрүүлэх 2 шаттай 6 жилийн төсөл (ЖАЙКА, 2008 -2013); Сургалтын хөтөлбөрийн менежментийн цикл (ЖАЙКА, 2014 -2018);

- с. ЕБС-д заавал судлах хичээлүүд болон хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан суралцагчдад ТХБ-ыг эзэмшүүлэхэд ашиглах боломжтой сургалтын нэмэлт хөтөлбөрүүд, шинэлэг арга зүй бүхий гарын авлагаар сургууль багш нарыг боломжийн түвшинд хангагдсан бөгөөд энэ үйл хэрэгт АХБ, ГХАН, ДБХС зэрэг олон байгууллагууд олон жилийн туршид томоохон хувь нэмэр оруулжээ.
7. Өнөөдрийн байдлаар сургалтын цөм хөтөлбөрийн боловсруулалт ба хэрэгжилтэд энэхүү тайланд дурдагдсан иж бүрэн судалгаанууд хийгдэж, тэдгээрийг цаашил сайжруулах дүгнэлт, зөвлөмжүүд гараад байна.

#### Алдаа дутагдал

1. Боловсролын талаар баримтлах төрийн бодлого, шийдвэр нь улс төрөөс хүчтэй хараат, тогтворгүй байгаа байдал; богино хугацаанд дорвитой судалгаа, шинжилгээний үндэслэлгүйгээр эдийн засгийн тооцоололгүйгээр, зохих бэлтгэлийг бүрэн хангахгүйгээр сүүлийн 10 жилийн дотор 2 удаагийн хөтөлбөр ба сурах бичгийн шинэчлэл хийгдсэн явдал; мөн мэргэжлийн боловсон хүчний тогтвор суурьшилгүй ажиллаж буй байдал зэрэг нь боловсролын салбарын тухайлбал, анги танхимын түвшин дэх суралцахуй, багшлахуйн хөгжилд сөргөөр нөлөөлж, суралцагч, багш, сургуулийн хэвийн ажиллагаа доголдох, суралцагчдын суралцахуйн үр дүнгүүдэд дорвитой ахиц гарахгүй байхад тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.
2. 2007-2013 оны хооронд боловсруулан мөрдсөн бага, дунд боловсролын нийт 252 үндэсний болон цөм хөтөлбөрийн 70 гаруй хувийг мөнхийт бэлтгэсэн нийлүүлсэн 294 сурах бичгийн Х, XI, XII (үндэсний хөтөлбөрийн хүрээнд) сурах бичгийг сүүлийн жилүүдэд тус тус хүчингүй болгосон байна. Энэ байдал нь онол, арга зүйн хувьд ч үндэслэл нь бүрхэг, эдийн засгийн үр ашгийн хувьд ч үрэлгэн хандсан байдлыг харуулна. Түүнчлэн зохиогчдын оюуны өмч, хэвлэлийн компаний эрх ашгийг хөндсөн асуудлууд үүсгэсэн бөгөөд хүний нөөцийн хязгаарлагдмал нөхцөлд цөм хөтөлбөр, боловсруулах, сурах бичиг зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх үе шатуудад ногдох хугацаа хэтэрхий давчуу, хүмүүст нухацтай ажиллах цаг хугацаа хэт хомс олгосон нь сургалтын хөтөлбөр, сурах бичгийн чанарын асуудалд сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг болжээ.
3. Сүүлийн жилүүдэд үндэсний түвшинд хийгдсэн үнэлгээгээр сурагчдын сурлагын амжилт нь боловсролын шатлал бүрд 60 хүрэхгүй хувийн үзүүлэлттэй байгаа бөгөөд ялангуяа, дунд ахлах ангийн үзүүлэлтүүд бага боловсролынхоос доогуур байна. Энэ байдал нь олон хүчин зүйлсээс хамаарах боловч юуны өмнө улс төрөөс хамаарсан бодлогын тогтворгүй байдал, шинэчлэлийн оновчгүй менежментийн алдаа, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг сайжруулах онол, арга зүйн суурь шийдлүүдийг хэрэгжүүлэх боловсруулалтын дутуу дулимаг байдал зэрэг нь голлон нөлөөлжээ гэж үзэж болно.
4. Монгол Улсын ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт ТХБ зорилго, агуулгын хувьд харьцангуй сайн интеграцчилагдаж чадсан ч боловсролын түвшин бүрийн сургалтын цөм хөтөлбөрийн бүтэц, дизайны ялгаатай байдал, судлагдахууны агуулгын чиглэлүүдийн онцлогууд, хөтөлбөрүүдийн боловсруулалтын жигд бус байдал зэрэг нь хэрэглэгчдэд ойлгомжгүй, төвөгтэй байдлыг бий болгож байгааг тэмдэглэх шаардлагатай. Цаашид энэ асуудлыг эс анхаарвал сурах бичиг зохиох, багш нар хичээлийн хөтөлбөрөө боловсруулах, хөтөлбөрийн боловсруулалтын болон хэрэгжилтийг үнэлэхэд цөм хөтөлбөр нь хөтөч болох зориулалтаа бүрэн хангаж чадахгүйд хүрэх эрсдэлтэй.
5. Цөм хөтөлбөрийг цаашид боловсронгуй болгоход онол, арга зүйн түвшинд зайлшгүй анхаарч үзэх ёстой болон сургалтын хөтөлбөрүүдийн хүрээнд олсон амжилтуудаа бататгах шаардлагатай дараах асуудлууд байгааг зарим судалгааны тайлангуудад онцлон тэмдэглэсэн байна (БОНХАЖЯ, ШХА, 2015), ба (АХБ; Maxwell Stamp LTD (Bangladesh); МЭК ХХК (Монгол), 2017) Тухайлбал:
  - а. Компетенц буюу цогц чадамжийн төрөл, эрэмбэт чанарыг алдагдуулсан байна. Тухайлбал, хөтөлбөрт дурдагдсан “чадвар”-ууд дотор цогц чадамжууд ялангуяа ТХБ-ын цогц чадамжид хамаарах чадварууд хангалттай хэмжээнд багтсан хэрнээ тэдгээрийг эрэмбэлж аль нь зорилт буюу хүлээгдэж буй үр дүнд, аль нь агуулгад, аль нь шалгуур индикаторд, аль нь үйл ажиллагаанд хамаарахыг оновчтой, зөв тодорхойлон томъёолоогүй байна. Энэ нь дээр дурдсан цөм хөтөлбөр “ойлгомжгүй” ба “төвөгтэй”, “ажиглагдаж, хэмжигдэхүйц бус” байгаагийн үндсэн шалтгааны нэг юм.
  - б. Түүнчлэн таксономын мэдлэг ба когнитив үйлүүдийн эрэмбэт чанар болон боловсролын түвшин, шатлал хоорондын харьцааг оновчтой тогтоож, ойлгомжтой тодорхойлоход учир

- дутагдалтай хандсан байна. Энэ нь “ажиглагдаж, хэмжигдэхүйц бус” байгаагийн бас нэг шалтгаан юм.
- с. Цогц чадамжийн танин мэдэхүйн, сэтгэл хөдлөлийн, нийгэмшихүйн айн мэдлэг, чадварын төлөвшлийн үнэлгээний шалгуур, индикаторуудыг ялгаж нарийвчлаагүйгээс үнэлгээний асуудал хэт ерөнхий, барьцгүй болж улмаар энэ нь суралцахуйн явцын болон үе шатны үнэлгээ болон сурагчийн сурлагын амжилтын үнэлгээнд нөлөөлж байна.
6. 1998-2014 онд сургуулийн бүтцэд 4 удаа, 1998-2019 оны хооронд сургалтын хөтөлбөрт 3 үе шаттай өөрчлөлт хийгдсэн бөгөөд тэдгээр өөрчлөлт бүр дэх шинэчлэлийн бодлогыг тусгасан сургалтын төлөвлөгөөнүүд боловсрогдон хэрэгжиж иржээ. Энэ 20 жилийн хугацаанд сургалтын төлөвлөгөөг өөрчилсөн нийт 21 удаагийн шийдвэр гарсан байна. Энэ өөрчлөлтүүд нь ЕБС-ийн сургалтын хугацааг 10 жилээс 11 жилд, улмаар 12 жилд шилжүүлэн сургуулийн бүтцийг өөрчлөх, мөн цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэсэн шинэчлэлийн зэрэгцсэн 2 чухал стратегийн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой юм. Энэхүү боловсролын үйл хэргийн цөм болсон хоорондоо амин холбоотой, нарийн нийлмэл үйл явцын үр дүнд Монгол Улсын бага, дунд боловсролын стандарт, киррикулимийн хөгжил үндсэндээ дэлхийн боловсролын хөгжилд баримжаалсан хөгжлийнхөө зам дээр (on the way) гарч чадсан гэж үзэх боломжтой. Гэхдээ бодлогын тогтворгүй байдал, мөн менежментийн зарим доголдол зэргээс хамаарч багагүй алдаа дутагдал, сорилт, бэрхшээлийг дагалдсаар байна.

#### Сорилт, бэрхшээл

1. Хүн төрөлхтний ГХ, түүнд хүрэх арга хэрэгсэл болсон ГХБ-ын талаар Дэлхий нийтийн үйлийн замнал, өрнөлийн шинэ үе шат эхэлж, танин мэдэхүйн болон практик үйлийн түвшинд гарч буй өөрчлөлтийг анхаарах мэдрэмж үндэсний хэмжээнд нийгмийн зохион байгуулалтын бүх түвшинд сул байгаагаас энэ талаарх ойлголт хангалтгүй байгаагаас үйл ажиллагаа, хүчин чармайлтын үр өгөөж, үр нөлөө харьцангуй сулхан байна.
2. Боловсрол судлалын шинжлэх ухааны байгууллагын бие даасан байдал бүрэн хангагдаагүй, бүтэц нь хангалттай түвшинд бэхжээгүйн улмаас боловсролын салбарт боловсрол, хүний хөгжлийн чиглэлээр баримтлах төрийн бодлогын үндэс, суурь болчихоор чанартай суурь судалгаанууд эхлэл төдий хийгдэж байна.
3. Суралцагчдад боловсрол эзэмшүүлэх нийгмийн хэрэглүүр болох сургалтад мөрдөх сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг үнэлгээний журам зэрэг нь ойр ойрхон өөрчлөгдөж байгаа нь сургууль, багш нарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэж байна.
4. Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр хэрэгжилтийг хангах, тэдгээрийн сайжруулахад чиглэсэн шинжлэх ухааны үндэслэл бүхий үндэсний хэмжээний иж бүрэн судалгаанууд хийгдэж эхэлсэн ч тэдгээрийг тогтвортой явуулахад улс төр, эрх зүйн, эдийн засгийн хүчин зүйлсийн сөрөг нөлөөлөл саараагүй байна.

#### **Зөвлөмж:БДБ-ын чанар, нийцийн тухайд (а).стандарт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө)**

1. ГХБ-ын индикатор ба цогц чадамжийн чиглэлээр олон улсад хийгдэж буй судалгааны үр дүнгүүд болон Монгол хүний сурч, ажиллаж, амьдрах арга ухааны өвөрмөц онцлогийг нарийвчлах суурь судалгааг тасралтгүй явуулж байхыг холбогдох байгууллагын үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа улмаар судалгааны үр дүнд суурилсан шинэчлэлийн бодлого, стратегийг дэвшүүлэн хэрэгжүүлж байхыг шийдвэр гаргалтын суурь зарчим, гол хариуцлага тус тус болгож байх
2. Төрөөс стандарт ба киррикулим, сурах бичиг, хүний нөөц судлалын талбар дахь боловсролын суурь судалгаа тасралтгүй явагдах боломж нөхцөлөөр бүрэн дүүрэн хангаж, дотоод, гадаадад зохиогддог мэдлэг, туршлагаа хуваалцах арга хэмжээнүүдэд оролцон судалгааны үр дүнгүүдээс танилцуулах замаар ГХБ-ын хөгжилд гарч буй мэргэжлийн болон төрийн захиргааны түвшин дэх хөгжлийн онол, арга зүйн ахиц, ололтоос суралцаж, өөрсдийн үнэт зүйлс, өв соёлоо уламжлан хөгжүүлж, инновацийг үйл хэрэг, бодит үр дүн болгож байх менежментийг хэрэгжүүлж, Дэлхий нийтийн ГХБ-ын үйл явцтай хөл нийлүүлэн урагшлах
3. “ГХЗ 4 Боловсрол 2030 Үйлийн хүрээ”-нд баримжаалан суралцахуйн үзэл баримтлал, боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг ба сургалтын бусад материал, хэрэглэгдэхүүн, багшийн хөгжил болон тэдгээрийн зориулалт, зорилго, агуулга, арга зүй, үр дүн хоорондын инвариант (үл хувиран хадгалагдах) чанар ба

тус бүрийнх нь иерархи (шатлан эрэмбэлэгдэх), чанарын шүтэлцээ хийгээд гадаад, дотоод хүчин зүйлийн холбоо хамаарал, бүхэл бүтэн, дотоод саланги чанарынх нь нэгдэл зэргийг тус тус хангаж чадахуйц нэгдсэн онол, арга зүйн шийдэлтэй байхаар сургалтын баримт бичгүүдийг боловсруулах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, сургалтын үндсэн баримт бичгүүдийг систем сэтгэлгээний арга барилын дагуу боловсруулж үйлдвэл илүү тустай байна. Ингэж чадвал боловсролд ТХБ-ыг амжилттай интеграцчилах суурь нөхцөл хангагдана.

4. Цаашид сургалтын үндсэн баримт бичгүүдийг уялдаа холбоотойгоор сайжруулан боловсруулахдаа эхлээд тэдгээрийг бүтээх онол, арга зүйн шийдлийг тодорхой болгон баталгаажуулж, дараа нь боловсролын чанар нь боловсролын стандартаар, стандарт нь цогц чадамжаар, цогц чадамж нь ТХБ-ын хүрээний цогц чадамжуудаар, эдгээр цогц чадамжууд нь ТХЗ-ыг хангах агуулга, арга зүйгээр эрэмбэлэгдэх ерөнхий зүй тогтолд баримжаалан үйлдэх нь зохилтой. Өөрөөр хэлбэл, “Эх нь булингартай бол адаг нь булингартай” гэдэг зүйрлэлийг санаж байхад илүүдэхгүй.
5. Шинжлэх ухааны үндэслэл бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх замаар бүх шатны, бүх хэлбэрийн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, багш боловсролын стандарт, хөтөлбөр, бүх төрлийн үнэлгээний тогтолцоон дахь ТХБ-ын шалгуур, индикаторууд болон цогц чадамжуудын интерацчилалыг улам бүр гүнзгийрүүлж байх бодлогыг тууштай баримталж байх нь зүйтэй.
6. Боловсролын бүх төрлийн стандартуудыг холбогдох хуульд заасан хугацаанд үзлэг, үнэлгээнд хамруулж, тэдгээрийг үе шаттайгаар сайжруулж байх хуулийн механизмыг бүрэн дүүрэн ашиглах шаардлагатай.
7. Боловсролын салбарын ТХ-ийг хангахад онцгой анхаарч, шинжлэх ухааны үндэслэл бүхий хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх үндсэн дээр тодорхойлсон бодлогоо тууштай баримталж, ойр ойрхон “шинэчлэх” биш, тасралтгүй “сайжруулах” стратеги баримтлах нь ТХБ-ийн хөгжилд бодит ахиц гаргах, сургууль, багш нарын тогтвортой хөгжлийг хангахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, олон жилийн туршид дээдх нь суудлаа ололгүй “шинэчилсээр” байтал доодох нь гүйдлээ олохгүй “бужигнасаар” байгааг анхаарах ёстой.
8. Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтийн талаар хийгдсэн дээрх судалгаануудын тайланд өгөгдсөн онол арга зүйн, бодлого стратегийн, хэрэгжилтийн менежментийн чиглэлээр тус тус өгөгдсөн маш үнэ цэнэтэй сургаж, дүгнэлт, санал зөвлөмжийг цаашдын үйл ажиллагаандаа заавал судлан тусгах шаардлагатай

#### **Дүгнэлт: БДБ-ын чанар, нийцийн тухайд ( б).сурах бичиг, сургалтын орчин)**

##### Ололт, амжилт

1. Бүх хичээлийн хөтөлбөрийг багшийн зөвлөмжтэй хамт, сурагчийн сурах бичгийг багшийн номтой хамт бэлтгэх ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимжсэн нь багш нар сургалтын хөтөлбөр, сурах бичгийг бүтээлчээр хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлсэн байна.
2. Сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандартууд дахь агуулга, арга зүй, үнэлгээний шаардлагууд харьцангуй тогтвортой мөрдөгдөж байгаа нь богино хугацаанд хийгдсэн сургалтын хөтөлбөрийн 3 удаагийн шинэчлэлийн шаардлагыг хангасан сурах бичгүүд бүтээхэд эергээр нөлөөлөх хүчин зүйлсийн нэг болсон байна.

##### Алдаа, дутагдал

1. 1998-2009 оны хооронд бага, дунд боловсролын сурах бичиг хангамжийн талаар баримтлах бодлого (3), эрх зүйн зохицуулалт нь олон (12) удаа өөрчлөгдсөний улмаас өнөөг хүртэл сурах бичиг хангамжийн найдвартай, тогтвортой тогтолцоо төлөвшиж чадаагүй байна.
2. Сурах бичгийн хангамжийн оновчтой, тогтвортой тогтолцоо бүрэлдэж төлөвшөөгүйтэй холбоотойгоор сурах бичгийн хөгжил бүрэн хангагдаагүй байгаа бөгөөд сурах бичгийн чанар тасралтгүй сайжирч байх, хөрөнгө оруулалт үр ашигтай байх зарчмууд алдагдах хандлагатай байна.
3. 2009-2018 оны хооронд нийт 217 сурах бичиг шинээр бэлтгэснээс өнөөдрийн байдлаар 106 сурах бичгийг сургалтад хэрэглэж байгаа бөгөөд бэлтгэсэн нийт сурах бичгийн 48,8 хувь буюу 111 сурах бичгийг сургалтад албан ёсоор хэрэглэхгүй болжээ. Ялангуяа 2013 оноос хойш хэвлэгдсэн V, VI, VII, X, XI, XII дугаар ангийн 80 орчим сурах бичиг 3-2 жил хэрэглэгдээд хүчингүй болсон (дунд анги) бөгөөд хүчингүй болохоор (ахлах анги) байна.

4. Сурах бичгүүдийн тухайн боловсролын түвшин болонтухайн ангид ногдох хувь болон анги бүрийн сурах бичгийн нэр төрлийн дунджаас тооцсон хазайлтын шинжилгээ нь ЕБС-д судлах хичээлийн тоо, агуулгын багтаамж нь суралцагчдын хэрэгцээ, бодит боломж, суралцахуйн зарчим, ТХБ-ын арга зүйн зарчимд тус тус нийцсэн тодорхой зүй тогтоолоор төлөвлөгдөж, дизайнчлагдаагүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.
5. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын сурах бичиг ангийн хувьд ч нэр төрлийн хувьд ч хангалттай түвшинд хүрээгүй байна. Үүнийг нийт сурах бичигт эзлэх үндэсний цөөнхийн хүүхдүүдэд зориулсан сурах бичгийн нэр төрөл 5,1 хувь (I-VII ангийн казак хэл ба I ангийн тува цагаан толгой), хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан сурах бичгийн нэр төрөл 3,2 хувь (зөвхөн математик, монгол хэл) байгаа явдал илтгэнэ.
6. Судалгааны үнэлгээ, дүгнэлтгүйгээр сурах бичгүүдийг ойр ойрхон шинэчлэх явцад хүний нөөцийн чадавх дутагдах, сурах бичиг зохиох менежментийн төлөвлөлтийн зарим сул талаас үүдэлтэй түүнийг зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх үе шатуудад ногдох хугацаа хэтэрхий давчуу, хүмүүст нухацтай ажиллах цаг хугацаа хэт хомсдолтой байх зэрэг бэрхшээл нь сурах бичгийн чанарт муугаар нөлөөлөхөөр байжээ.

#### Сорилт, бэрхшээл

1. Сурах бичгийн эхийг богино хугацаанд зохиож байгаа нь чанарт муугаар нөлөөлж байна
2. Сурах бичиг зохиох, хэвлэлийн эх бэлтгэх хүний нөөц хангалтгүй байна.
3. Сурах бичиг судлал хангалттай түвшинд хөгжөөгүй байна.
4. Сурах бичгээр мэргэшсэн шинжээчид байхгүй байна.
5. Сурах бичигтэй холбоотой сонгон шалгаруулалт зохион байгуулахад бэрхшээл учирдаг
6. Худалдаа борлуулалтын нэгдсэн сүлжээ байхгүй байна.

#### **Зөвлөмж: БДБ-ын чанар, нийцийн тухайд ( б).сурах бичиг, сургалтын орчин)**

1. Сурах бичиг хангамжийн талаар өнгөрсөн хугацаанд хуримтлуулсан туршлага, сургамжаа нэгтгэн дүгнэж, сурах бичиг хангамжийн хэлхээн дэх төрийн оролцооны хэсгийг маш оновчтой тогтоох замаар олон улсын жишигт нийцсэн төрийн зохих оролцоо бүхий сурах бичиг хангамжийн хэвлэн нийтлэл газрууд төвтэй тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх нь зүйтэй юм.
2. Төрийн оролцоо зайлшгүй шаардагдах сурах бичгийн стандарт, шинжээчдийн чадавх, ёс зүй, эрх зүйн хариуцлагын зохицуулалт, сурах бичгийн сонголт зэрэг хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой асуудлаар гаргах шийдлийн хувилбарууд боловсруулж, цаашид сурах бичиг хангамжийн тогтвортой хөгжлийг хангах нь чухал юм.
3. Төрөөс сурах бичиг судлалыг хөгжүүлэхээр тунхаглах төдий бус чанартай үр дүн гаргахуйц бодит дэмжлэг үзүүлдэг болж, эхний ээлжид 2004 оноос хойш бүтээгдсэн бүх сурах бичгүүдэд үнэлгээ хийж, дүгнэлт гарган сурах бичгийн талаар олсон ололт, гаргасан алдаа дутагдлаа илрүүлэн түүний хөгжлийн түвшинг тогтоож, цаашид тэдгээрийг сайжруулах үнэ цэнэтэй зөвлөмж гаргуулах хэрэгтэй байна.
4. Хуульд заасан хугацаанд сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандартад үзлэг хийж, сайжруулж байх хэрэгтэй.
5. Юуны өмнө өнөөгийн сурах бичгийн хангамжийн хэрэгжилтийн менежментэд өргөн хүрээний иж бүрэн суурь судалгаа хийж, сурах бичгийн агуулга, арга зүй, хэвлэн нийтлэл, түгээлт, ашиглалтын талаар үнэлгээ, дүгнэлт гаргах, сургамж ялгах шаардлагатай.
6. Сурах бичиг хангамжийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой бодлогыг үнэлэх, сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох
7. Дунд, ахлах ангийн сурагчдын сурах бичиг хангамжийг нэмэгдүүлэх нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Тухайлбал, “Сурах бичгийн эргэлтийн сан-түрээсийн тогтолцоо”-г нэвтрүүлэх боломжтой юм.
8. Сурах бичиг судлалыг хөгжүүлэх
9. Сурах бичиг зохиох, хянах, эх бэлтгэх, судлах, турших хүний нөөцийг бэлтгэх, сургаж дадлагажуулах

## 1.3. Мэргэжлийн боловсрол, сургалт

### 1.3.1. Өмнөтгөл

Дэлхийн орнууд ТМБС гэсэн нэр томъёог өөр өөрийнхөөрөө тодорхойлж хэрэглэсэн байдаг. Мэргэжлийн боловсрол, сургалт (МБС) гэсэн нэр томъёог англи хэлтэй орнууд өргөн ашигладаг. “Техникийн боловсрол”, “мэргэжлийн боловсрол” болон “сургалт” зэрэг нь өөр хоорондоо ялгаатай ойлголтууд боловч ТМБС-ын агуулгын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд юм. Энэхүү бүрдэл хэсэг бүр иргэний мэргэжил эзэмших тодорхой хэрэгцээ, хэм хэмжээг илэрхийлэх бөгөөд мэргэшлийн түвшний үндэсний тогтолцооны тодорхой түвшнүүдэд хамаарна.

МБС нь иргэнийг амьдрал, хөдөлмөрт бэлтгэхэд илүүтэй чиглэсэн гэж ойлгож болно. Иргэн бага наснаасаа гэр бүлийн амьдрал, сургууль, нийгмийн орчинд ажил хөдөлмөрийн тухай ойлголттой болж, мэргэжлээ сонгох, мэргэжил эзэмших замаар ажил эрхэлж, цалин орлого олж, амьдралаа авч явах, улмаар илүү мэргэших, ахисан түвшинд суралцах суурь боломжийг нээж өгдөг тул МБС нь иргэн хүн амьдралд хөл тавих чухал үе шат болдог.

МБС-ын тухай Монгол Улсын хуульд (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2009) “Мэргэжлийн сургалт”, “Мэргэжлийн боловсрол”, “Техникийн боловсрол” гэдэг ойлголтуудыг сургалтын агуулгаар нь зааглан тодорхойлсон байна.

Монгол Улсад мэргэжилтэй ажилтан бэлтгэж эхэлсэн замналыг харвал, энэ салбар нь 90 гаруй жилийн түүхтэй боловсролын ууган салбаруудын нэг юм. Монгол Улсад аж үйлдвэр, үйлчилгээний салбарууд үүсэн хөгжихтэй зэрэгцэн анхны мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэж эхэлжээ. 1921 онд Телефон цахилгаан мэдээний албан хаагч, ноос угаах цехийн ажилтан бэлтгэх курс, мал адгуусыг эмчлэн сувилах сургууль зэрэг байгуулагдаж, мэргэжлийн энгийн төвөгтэй бус мэргэжил, чадваруудыг эзэмшүүлж байв. Улмаар 1960-1990 онд нийт МБС-ын тогтолцоо бүрдэн хөгжиж, сургалтын байгууллагын тоо 46 болтлоо өсөж, улсын үйлдвэрлэл, үйлчилгээний хэрэгцээт ажилтны 60 гаруй хувийг бэлтгэж (МАХН-ын Төв Хороо, СнЗ-ийн, ТМС-иар мэргэжилтэй ажилтан бэлтгэж эхэлсний 20 жилийн ойд ирүүлсэн “Баярын бичиг”, 1984), эх орныхоо хөгжилд бодитой хувь нэмэр оруулж ирсэн. Харин 1990 оноос хойш энэ салбар нийгмийн өөрчлөлт, зах зээлийн шилжилтийн хүнд үеийг туулж, тодорхой хэмжээгээр ухралтад орсон байна.

2002 онд “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” анхны бие даасан хууль гарч, төрөөсөнэ салбарын хөгжилд онцгой анхаарал хандуулах болсноор 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар (ХНХЯ, 2019) нийт 86 МБС-ын байгууллага (төрийн өмчийн 51, хувийн 35), 4520 багш, ажилчидтай, 193 мэргэжлээр жилд дунджаар 20 орчим мянган мэргэжилтэй ажилтныг бэлтгэдэг салбар болж өргөжин хөгжиж байна.

Монгол улс дахь МБС-ын суурь мэдээллийн тайлан доор дурдсан арга зүйн дагуу боловсруулсан. Тухайлбал, Монгол Улсын МБС-ын салбарын хөгжлийн түүхэн замнал болон хөгжлийн бодлого стратеги, бүтэц, тогтолцоо, удирдлага, зохион байгуулалт, хэрэгжилтийн үр дүнг “ТХЗ 4 Боловсрол-2030 үйлийн хүрээ”-ний өнцгөөс харж, тулгарч буй зорилтууд, шийдвэрлэх асуудлыг нотолгоонд суурилан ялган тодорхойлохыг зорьсон.

Монгол Улсын МБС-ын дэд салбарын суурь мэдээллийн тайланг боловсруулж, хөгжлийн тойм шинжилгээг хийхдээ ЮНЕСКО, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага, Европын сургалтын сан зэрэг олон улсын байгууллагуудын санал болгож байгаа ТМБС-ын салбарын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг ашигласан болно. Энэ шалгуур үзүүлэлтийг өөрийн орны МБС-ын салбарын өвөрмөц онцлог, бүтэц, хэв шинж, боловсролын салбарын онцлог зэргийг харгалзан тохируулга хийж, судалгааны тайланг боловсрууллаа.

Тайланд МУ-ын МБС-ын бодлого, эрхзүйн актууд, олон улсын байгууллага, мэргэжлийн судалгааны байгууллагуудаас хийсэн судалгааны тайлангууд, ҮСХ, ЗГ-ын холбогдох байгууллагуудын статистик мэдээлэл, тайлан болон зарим тохиолдолд салбарын мэргэшсэн олон улсын зөвлөх (Меянатан, 2013)-ийн судалгааны тайлан зэргийг мэдээллийн эх сурвалж болгон ашигласан. Мөн БСШУСЯ, ХНХЯ, Сангийн яам болон МБСҮТ, БМИҮЗ зэрэг ЗГ-ын болон түүний харьяа байгууллагуудын төлөөлөл, Мэргэжлийн сургуулиудын ассоциац, Техник мэргэжлийн боловсрол, сургалтын ассоциац, Техник мэргэжлийн сургуулиудын холбоо зэрэг мэргэжлийн байгууллагуудын мэдээлэл, ярилцлагын үр дүнг боловсруулан ашигласан болно.

Баримт бичгийн судалгаанд анхдагч эх үүсвэрүүдээс мэдээллийг цуглуулж, шаардлагатай тохиолдолд хоёрдогч эх үүсвэрийг ашиглан, энэ салбарын бусад салбараас ялгагдах гол онцлог, нийтлэг талуудыг хамруулан системийн арга хандлагаар шинжилгээ хийхийг зорьсон.

### 1.3.2. Бодлого, Эрх зүй

Мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшлийн ур чадварыг өндөржүүлэх замаар ажил эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах нь Монгол Улсын төр, засгийн бодлогын тэргүүлэх чиглэл байсаар ирсэн.

#### Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар баримтлах төрийн бодлого

МБС-ын талаар төрөөс баримтлах бодлого нь дараах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байна. Үүнд:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030
- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он)
- Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого
- Боловсрол” Үндэсний хөтөлбөр (2010-2021 он)
- “Техникийн болон мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр (2016-2022)
- “Ажилтай, орлоготой Монгол хүн” үндэсний хөтөлбөр
- “МБС-ын багшийн хөгжил” хөтөлбөр

Өнөө цагийн Монгол Улсын хөгжлийн бодлогын суурь баримт бичиг болох “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал-2030”-д МБС-ын хөгжлийн талаар тодорхой зорилтууд дэвшүүлжээ. Тухайлбал, “Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлэх” зорилгын хүрээнд:

- 2020 он гэхэд Ядуурлыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлж, иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулан, хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлж, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах.
- Нийгмийн түншлэл дээр үндэслэн мэргэжлийн боловсрол, сургалтын багшлах боловсон хүчнийг чадваржуулж, дадлагын баазыг өргөжүүлж, суралцагчдын тоог 60.0 мянгад хүргэх,
- 2030 он гэхэд үндэсний ажиллах хүчний хэрэгцээг мэргэжлийн өндөр ур чадвартай ажиллах хүчнээр бүрэн хангах зорилтуудыг тус тус дэвшүүлсэн байна.

Бодлогын дээрх баримт бичгүүдийн зорилго, агуулга нь дараах асуудлуудад илүүтэй чиглэсэн байна:

- Нийгмийн түншлэлд суурилсан, эрэлтэд нийцсэн МБС-ын тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх, хувийн хэвшлийн оролцоог өргөжүүлэх
- МБС-ыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хөгжлийн зорилтод нийцүүлэх
- Чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоонд шилжих, ажил мэргэшлийн лавлах, сургалтын стандарт, хөтөлбөрийг ажил олгогчийн эрэлт, шаардлагатай уялдуулж шинэчлэх, багшийг чадваржуулах замаар МБСҮТ, Политехник коллеж төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг өндөржүүлж, ажлын байртай холбох
- Үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг чанаржуулах, бааз, лабораторийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх
- МБС-ын санхүүжилтийн олон эх үүсвэр бүхий тогтолцоонд шилжих.

Үе үеийн ЗГ-ийн үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд МБС-ийн талаар дараах зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлж иржээ (Хүснэгт 1.3.1).



Хүснэгт 1.3.1. ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд МБС-ийн талаар дэвшүүлсэн зорилтууд (1992-2016)

1992-1996 (1992, №27)	<ul style="list-style-type: none"> <li>ТМС<sup>11</sup>-ийн сургалтын залгамж холбоог нягтруулах, удирдлага, зохион байгуулалтын систем, бүтцийг боловсронгуй болгох; боловсрол, шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн интеграцыг хангах; бэлтгэх мэргэжлүүдийн хүрээг өргөтгөх; Сургалтын байгууллагуудын элсэлт, төгсөлтийг гэрээ, захиалгаар зохицуулах, төгсөгч хөдөлмөрийн зах зээлд өрсөлдөх боломжийг нээх.</li> </ul>
1996-2000 (1996, №61)	<ul style="list-style-type: none"> <li>ТМС-ийн мэргэжлийн чиглэлийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулах, суралцагчдын тоог нэмэгдүүлэх сургалтын чанарыг дээшлүүлэх; Мэргэжлийн анхан ба дунд шатны сургуульд суралцагчдыг сургалтын төлбөрөөс чөлөөлөх</li> </ul>
2000-2004 (2000, №33)	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн боловсролын байгууллагын магадлан итгэмжлэлийн журамсургалтын чанарыг сайжруулах;Тусгай мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх; МСҮТ-ийн сургалтын чиглэл, үйл ажиллагааг боловсронгуй болгох</li> </ul>
2004-2008 (2004, №24)	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн боловсролын агуулга, стандартыг шинэчлэх, сургалтын орчныг бэхжүүлэх; ЕБС МСҮТ-ийг компьютержуулж, сүлжээнд холбох; Оюутнуудад зориулсан оюутны байр, хотхон байгуулах санаачилгыг болон хотхоны хэлбэрээр цогц үйл ажиллагаа явуулах их, дээд сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг дэмжих</li> </ul>
2008-2012 (2008, №3)	<ul style="list-style-type: none"> <li>МБС-ын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх; МСҮТ-ийг орчин үеийн сургалтын бааз, лабораториор хангах; Хөдөлмөрийн зах зээлийн тогтолцоог иж бүрнээр хөгжүүлж, ажилтан, ажилчдыг зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн сургаж бэлтгэх, ур чадварыг нэмэгдүүлэх, дадлагажуулах тогтолцоо бий болгох; МСҮТ-эд суралцагчдын тоог 3 дахин нэмэгдүүлэх; ААН, үйлдвэрийн газрыг түшиглэсэн мэргэжил олгох тогтолцоог дэмжих</li> </ul>
2012-2016 (2012, №37)	<ul style="list-style-type: none"> <li>МСҮТ-ийг ажлын байртай шууд холбодог тогтолцообүрдүүлэх; МБСБ-ын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулах; элсэгчдийг ажил олгогчийн гэрээ, захиалга дээр тулгуурлан элсүүлж, төгсөгчдийг ажлын байраар хангах нөхцөлийг бүрдүүлэх.; МСҮТ-д суралцаж байгаа сурагчдын тэтгэлгийг бууруулахгүйгээр суралцах сонирхлыг дэмжиж ажиллах.</li> </ul>
2006-2020 (2016, №45)	<ul style="list-style-type: none"> <li>Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж, үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх боломжтой болгоно. Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ. Суралцагчдадүндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг олгоно. Хөдөлмөрийн эрэлт, ур чадвар, мэргэшлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлнэ. МБСБ-ыг хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. МБС-ын салбарын удирдах ажилтан багш, сурган хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэшил дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулах "Мэргэжилтэй ажилтан" бодлогын хүрээнд жилд 20 000-аас доошгүй залуучуудыг МСҮТ-д сургаж, мэргэжил, ур чадвар эзэмшүүлнэ. Их, дээд сургууль, МСҮТ-ийн төгсөгчдийг тоног төхөөрөмжийн лизинг, жижиг зээлд хамруулах арга хэмжээ авна.</li> </ul>

### Мэргэжлийн боловсрол, сургалтын эрх зүйн орчин

МБС-ын эрх зүйн харилцаа 2002 оныг хүртэл Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуулийн хүрээнд зохицуулагдаж иржээ. 2002 онд "Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай" анхны бие даасан хууль гарч, түүнд 2009 онд шинэчилсэн найруулгын нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөж ирсэн.

МБС-ын эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа гол **хуулиуд**:

- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор салбарын харилцаа бүхэлдээ зохицуулагдаж байна.

<sup>11</sup> ТМС-гэдэг техник мэргэжлийн сургууль гэсэн үгийн товчлол юм. Социалист нийгмийн үеийн боловсролын тогтолцооны нэг бүрэлдэхүүн хэсэг болсон техник, мэргэжлийн боловсролоор мэргэжлийн ажилчдыг дотоод, гадаадад олноор бэлтгэж байсан.

МБС-ын талаар гарсан ЗГ-ын **тогтоол**, батлагдсан **дүрэм, журам**:

- ЗГ-ын 2009 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 257 дугаар тогтоол: “Агентлаг байгуулах тухай” (ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг болох Мэргэжлийн боловсрол, сургалтын газар байгуулагдсан)
- ЗГ-ын 2011 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 117 дугаар тогтоол: “Журам батлах тухай” “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих тухай журам”
- ЗГ-ын 2011 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 326 дугаар тогтоол: “Мэргэжлийн боловсрол, сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” (Дэд салбарын хөгжлийн стратегийг тодорхойлох, багш, бэлтгэх, мэргэшүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хариуцлагыг өндөржүүлэх, төсвийн тогтолцоог шинэчлэх)
- ЗГ-ын 2012 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 94 дүгээр тогтоол: “Зардлын дундаж норматив батлах тухай” (МБСБ-ын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив. 4 дүгээр хавсралт)
- ЗГ-ын 2013 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 29 дүгээр тогтоол: “Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь тогтоох тухай”
- ЗГ-ын 2016 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 290 дугаар тогтоол: “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай”
- ЗГ-ын 2016 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 304 дүгээр тогтоол: “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр. 2016-2022” батлах тухай.
- ЗГ-ын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 55 дугаар тогтоол: “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээний төв байгуулах тухай”
- ЗГ-ын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 27 дугаар тогтоол: “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай”

Эрх зүйн орчны дээрх мэдээллүүдийг нэгтгэн тоймлож, дараах хэд хэдэн дүгнэлт хийж болох байна. Үүнд:

1. “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль батлагдан хэрэгжиж байгаа нь мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэшүүлэх олон талт харилцааг зах зээлийн нөхцөлд, хуулийн хүрээнд зохицуулах боломж бүрдсэн.
2. “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох бусад хуулиудтай уялдаа холбоог хангах хэрэгцээ байна.
3. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль үндсэндээ хэрэгжиж байгаа ч дараах заалтуудын хэрэгжилтэд анхаарах шаардлагатай. (Тухайлбал, 6.2; 20.3; 22.1.5; 23.1.2; 24.2)
4. Засгийн газрын тогтоол, журам, дүрмүүд үндсэндээ хэрэгжиж байна. Цаашдаа хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүнд түлхүү анхаарах, мөн зарим тулгамдсан асуудлыг ЗГ-ын шийдвэрээр шийдвэрлэх хэрэгцээ байна. (Тухайлбал, МБС-ын удирдлагын тогтолцоог оновчлох, түүний тогтвортой ажиллах боломжийг бүрдүүлэх, МБСДС-г бие даалгаж ажиллуулах, МБСБ-ын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг мэргэжлийн өртөгт суурилж тогтоох журам, аргачлал, МБСБ өөрийн орлогоо зарцуулах боломж өгөх, “МБС-ын багш бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоо буй болгох зэрэг)

Бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэх, МБС-ын байгууллагын шинэчлэлийг гүнзгийрүүлэх чиглэлээр ЗГ болон ХНХЯ тодорхой ажлуудыг хийж, ахиц өөрчлөлт (ХНХЯ, 2018) гарч байна. Тухайлбал,

1. Бодлогын суурь зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд “Техникийн болон мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр. 2022”-ыг батлан хэрэгжүүлж байна.
2. Нийгмийн түншлэл нь МБС-ын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болж өргөжин үр нөлөөгөө өгч эхэлсэн. АХБ, Европын холбооны төслийн хүрээнд МБС-ын “Салбарын зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчилж, зөвлөлийн гишүүдийг сурган чадавхижуулж байгаагийн зэрэгцээ, МБСБ-ын дэргэд “Мэргэжлийн зөвлөл”-үүд ажиллах болсон нь түншлэлийн үр өгөөжийг дээшлүүлэх чухал алхмууд болсон.
3. Чадамжид суурилсан сургалт, үнэлгээний загварыг нэвтрүүлж байна. Энэ хүрээнд “Ажил мэргэжлийн лавлах” 43-ийг батлан мөрдөж, сургалтын байгууллагын 70 орчим хувь нь МБС-ын стандарт, “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр”-өө шинэчлэн боловсруулаад хэрэгжүүлж байна.

4. МБС-ын багшийг хөгжүүлэх хөтөлбөр батлан хэрэгжүүлснээр багшийн мэргэшлийн ур чадварт ахиц өөрчлөлт гарч байгаа. Зөвхөн сүүлийн 2 жилд ажил мэргэжлийн багшийн 40 гаруй хувийг сургаж, чадваржуулсан байна.
5. МБС-ын “Үнэлгээний төв”-ийг байгуулан ажиллуулах болсноор үнэлгээг хөндлөнгийн, бодитой болгох, чанарын баталгаажилтын тогтолцоог хэрэгжүүлэх боломж өргөжсөн.
6. Сургалтын төлөвлөгөөнд үйлдвэрлэлийн дадлага давамгайлах болж, суралцагчдад мэргэшлийн ур чадвар эзэмшүүлэхэд түлхүү анхаарч ахиц гарсан.
7. “Дэлхийн ур чадварын уралдаан”-д 2 удаа оролцож, бэлтгэж буй мэргэжилтэй ажилтнуудынхаа мэргэшлийн ур чадварыг дэлхийн зиндаанд сорих, харьцуулах, суралцах болсон.
8. Төгсөгчдийн ажлын байртай холбогдсон байдал, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа хийж, дүн, дүгнэлтийг үндэслэн элсэлт, сургалтад хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хандлагыг илүүтэй тусгах болж байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх зорилгоор УИХ-аас баталдаг бодлогын томоохон баримт бичгийн нэг нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр юм. Бид сүүлийн 7 Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ямар зорилт, заалт (Хүснэгт 1.3.1) тусган хэрэгжүүлж ирснийг нэгтгэж үзсэн. Судалгааны дүнгээс (АХБ, 2018) харахад, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрүүдийн зорилтууд 71.0 - 89.0 хувийн биелэлттэй хэрэгжиж ирсэн байна.

### 1.3.3. Хэрэгжилт, Үр дүн

#### 1.3.3.1. Хүртээмж, Оролцоо

##### Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага

МБС-ын тогтолцоо манай улсад 1964 оноос бүрдэн төлөвшиж, 2002 оноос зах зээлийн шинэ нөхцөлд нийцүүлэх чиглэлээр боловсронгуй болсоор ирсэн. МБС-ын удирдлагын тогтолцооны үүсэл хөгжил, давуу болон сул талыг тоймлож харвал:

*Зураг 1.3.1. Монгол Улсын мэргэжлийн боловсрол сургалт, удирдлага, зохион байгуулалтын өөрчлөлтүүд*


1961-1976	СНЗ-ийн Дээд, тусгай дунд, техник мэргэжлийн Улсын хороо	<ul style="list-style-type: none"> <li>Салбар дундын зохицуулалт хэрэгжиж, яамдын үйл ажиллагааг уялдуулж, сургууль, үйлдвэрлэлийн хамтын ажиллагааг үр нөлөөтэй болгож чадсан</li> </ul>
1982	АБЯ-ны бүтцэд Техник мэргэжлийн сургуулийг удирдах Ерөнхий газар	<ul style="list-style-type: none"> <li>Ерөнхий газрыг 1990 онд татан буулгаж, ТМС-иудыг яам, аймгуудад тарааж өгөв. МБС-ын нэгдсэн бодлого алдагдаж, агуулга, аргазүйн дэмжлэг туслалцаа зогсонги байдалд орсон.</li> </ul>
1990-1999	Гэгээрлийн яам.	<ul style="list-style-type: none"> <li>Яаманд МБС-ын асуудлыг мэргэжилтэн хариуцах болсон.</li> </ul>
2000-2009	БСШУЯ-д Мэргэжлийн боловсролын арга зүйн төв	<ul style="list-style-type: none"> <li>МБСБ-ыг дэмжих, багш нарыг чадваржуулахад ахиц өөрчлөлт гарсан.</li> </ul>
2009	ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагийн статустай Мэргэжлийн боловсрол, сургалтын газар багуулагдсан.	<ul style="list-style-type: none"> <li>Энэ нь олон улсын жишиг, эрэлтэд нийцсэн, оновчтой тогтолцоо болохоо богино хугацаанд харуулсан, ЧССҮ-нд шилжиж эхлэв.</li> </ul>
2012, 2016, 2018	ХНХЯ-д МБС-ын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, хэлтэс 2018 он	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлыг ажлын байр, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилттой уялдуулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чухал түлхэц болсон.</li> </ul>

МБС-ын удирдлагын тогтолцоо 2012 оноос хойш харьцангуй тогтворгүй байж, ихэнхдээ аль нэг яамны бүтцийн нэгж хэлбэрээр зохион байгуулагдаж ирсэн нь зарим сул талуудтай байсан. Үүнд:

- Яамны нэгж нь МБС-ын асуудлыг эрхлэх нөхцөлд шийдвэр гаргах үйл явц олон шат дамжлагатай, цаг хугацаа зарсан, шуурхай бус байв.

- Удирдлагын нэгж нь тухайн бодлогын яамны бүтцэд байх нь хэрэгжүүлэгч үүрэг давамгайлж МБС-ын хөгжлийн бодлогын хувьд тэрхүү чиг үүргээ хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байсан.
- Яамны бүтцийн онцлог, орон тооны дутагдлаас болж, яаманд ганц хүн МБС-ийн асуудлыг хариуцаж ирсэн ч практик бий.

Зураг 1.3.2. МБС-ын удирдлага, түншлэлийн тогтолцооны бүдүүвч (өнөөгийн байдлаар)



Тайлбар: БАЗТ гэдэг нь “боловсролын арга зүйн төв”

Дээрх бүдүүвч нь түншлэлийн орчин дахь МБС-ын удирдлагын тогтолцоог харуулахад чиглэсэн. “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд хувийн хэвшлийн төлөөллийн байгууллага болох МБСҮЗ-ийг МБС-ын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгож хуульчилсан байна.

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны бус байгууллага мөн” (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хууль), “..Зөвлөл нь мэргэжлийн боловсрол, сургалтын дээд удирдлагыг хэрэгжүүлнэ” (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2009) гэж заажээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд чиг үүрэг, бүрэн эрхийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Уг зөвлөл төр, хувийн хэвшлийн аль алинд хэрэгжих шийдвэр гаргах,
- МБС-ын төсвийг бүхэлд нь батлах,
- МБСДС-гийн санхүүгийн дэмжлэгээр дамжуулан санхүү, хөрөнгийн оролцоо, хариуцлагаар баталгаажсан хувийн хэвшлийн оролцоо ба хяналтыг МБС-ын удирдлагад бий болгох,
- Мэргэжилтэй ажилтан бэлтгэх салбарын тогтвортой байдлыг ханган ажиллах зэрэг болно.

Гэвч хуулийн энэхүү зохицуулалт бүрэн утгаараа хэрэгжээгүй явж ирсэн байна. Үүний гол шалтгаан нь МБСДС-гийн санхүүгийн дэмжлэгийг хэрэгжүүлж чадаагүй, Зөвлөлийн үйл

ажиллагаа тогтмол бус байсантай холбоотой ажээ. Энэхүү суурь мэдээллийн тайлангийн зөвлөмжийн хэсэгт энэ талаар авах арга хэмжээний талаар тодорхой саналыг тусгасан болно.


**1.3.3.2. Чанар, нийц**

Мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, багш, суралцагч, төгсөгчдийн мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх асуудал анхаарлын төвд байна. Монгол Улсын МБС-ыг 2010 оноос олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоо”-нд шилжүүлж, Мэргэшлийн түвшний үндэсний үйлийн хүрээг бүрдүүлэхээр ажиллаж байна.

**МБС-ын албан тогтолцоо**

Насан туршийн боловсрол ба идэвхтэй хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээийн тогтолцоо дахь мэргэжлийн чиг баримжаа, мэргэжлийн үндсэн мэдлэг олгох, мэргэжил сонгох үйл явцыг дараах зургаар хуруулав.

Зураг 1.3.3. МБС-НТБ ба хөдөлмөр эрхлэлтийн тогтолцооны бүдүүвч<sup>12</sup>



**МБС-ын албан бус тогтолцоо**

МУ-ын МБС-ын тогтолцоонд албан бус тогтолцоо бүрэлдэж бий болоогүй байна. Одоогоор албан бус МБС-ын тогтолцоо нь ажлын байранд дадлагажих, гадаадад ажил хөдөлмөр эрхлэх явцдаа

<sup>12</sup>Энэхүү бүдүүвч нь уншигчдад ерөнхий ойлголт өгөх зорилготой, албан ёсоор баталгаажуулаагүй болно. Тухайлбал, мэргэшлийн түвшнийг өнөөдөр ХНХЯ дээр хэлэлцэгдэж байгаа төслөөр авсан болно.

олж авсан ур чадварыг өөрийн эх орондоо хувиараа хөдөлмөр эрхлэхэд ашиглах, албан ёсоор МБСБ-д мэргэжил эзэмшээгүй ч тухайн мэргэжлийн ур чадварыг ажлын байран дээр эзэмших зэрэг хэлбэртэй байна.

Албан бус МБС-ын тогтолцоотой холбоотой албан ёсны мэдээлэл, эх сурвалж байхгүй байна.

### МБСБ-ын бүтэц, сургалтын төрөл

Монгол Улсад өнөөдөр төрийн ба хувийн хэвшлийн нийт 86 МБС-ын байгууллага үйл ажиллагаа явуулж, барилга, замтээвэр, уул уурхай, санхүү, бизнес худалдаа, хот байгуулалт зэрэг 15 салбарын 192 мэргэжлээр жилд дунджаар 20 орчим мянган мэргэжилтэй ажилтныг бэлтгэж, хөдөлмөрийн зах дээр нийлүүлж байна. Мэргэжлийн сургалтын эдгээр байгууллагуудад нийт 37039 суралцагч суралцаж, 2469 багш, 2155 ажилтан, ажилчид ажиллаж байна. (ХНХЯ, 2018-2019)

Монгол Улсад мэргэжлийн сургалтын байгууллага нь Политехник коллеж, МСҮТ, богино хугацааны Сургалтын төв, Үйлдвэрлэлийн харьяалалтай сургалтын төв, Хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төв, Хөдөлмөр эрхлэлтийн боловсролын төв, Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын байгууллага зэрэг олон хэв шинжтэй байна.

Мэргэжлийн сургалтыг бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалттай хослуулан мэргэжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж болдог.


- Мэргэжлийн сургалтад 1 жил хүртэл хугацаагаар сургаж мэргэжлийн үнэмлэх,
- Мэргэжлийн боловсрол олгох сургалтад 1-2.5 жил хүртэл хугацаагаар сургаж мэргэжлийн боловсролын үнэмлэх, бүрэн дунд боловсролын гэрчилгээ
- Техникийн боловсрол олгох сургалтад 3 жил хүртэл хугацаагаар сургаж мэргэжлийн дипломыг тус тус олгодог байна.

МСҮТ-д ЕБС-ийн IX анги төгссөн суурь, XII анги төгссөн бүрэн дунд боловсролтой хүүхэд залуучууд, суралцах сонирхол бүхий насанд хүрэгчдийг нас, хүйс, шашин шүтлэг, үндэс угсаа ялгаварлалгүй элсүүдэг. Сургалтын агуулгын 70-80 хувийг дадлага, 20-30 хувийг онолын хичээл эзэлдэг.

Монгол Улсад МСҮТ болон ЕБС-ийн XII анги төгсөгчид Политехник коллежид 1.5 жил суралцаад техникийн боловсрол эзэмшиж техникчийн диплом, Политехник коллежоос дээд сургуульд дэвшин суралцвал 2-3 жил сурч бакалаврын зэрэг тус тус авдаг.

МБС-ын байгууллагын тоо 2005-2006 оны хичээлийн жилээс 2013-2014 хичээлийн жил хүртэл жил дараалан өсөж байгаад сүүлийн жилүүдэд бага зэрэг хэлбэлзэлтэй байна (Зураг 1.3.4).

Зураг 1.3.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тоо: Өмчийн хэлбэрээр (2005/06-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: ХНХЯ

Бодлого, зорилгоо хэрэгжүүлэх хүрээнд чадамжид суурилсан сургалтын тогтолцоонд шилжиж, сургалтын агуулгад үйлдвэрлэлийн дадлага давамгайлах болсонтой уялдан сургалтын хөтөлбөрүүдийг сайжруулж, багшаа чадваржуулах, дадлагын бааз, лабораторийг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн нь үр өгөөжөө өгч байна. Чанарын баталгаажилтыг хангах цогц арга хэмжээний хүрээнд “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээний төв”-ийг олон улсын жишгээр байгуулан ажиллуулж байна.

## Сургалтын хөтөлбөр

МБС-ыг 2009 оноос чадамжид суурилсан сургалтын тогтолцоонд шилжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор “Үндэсний ажил мэргэжлийн ангилал, тодорхойлолт”-д үндэслэж, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ирсэн байна. Сургалтын шинэ хөтөлбөрийн агуулга, загварыг боловсруулахдаа ХБНГУ, Австрали, Сингапур зэрэг орнуудын туршлага, төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэж, сургалтууд, үндэсний сургагч багш бэлтгэх арга хэмжээг авсан. Сургагч багш нар ажил олгогч, мэргэжлийн холбоодын оролцоотойгоор сургалтын хөтөлбөрөө боловсруулж, Бүсийн арга зүйн төвүүд дүгнэлт гарган яамнаас баталгаажуулж ажилладаг.

Энэ хүрээнд яам, Үнэлгээний төв, БАЗТ, МБСБ-аас дараах нийтлэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- “Ажил мэргэшлийн лавлах” боловсруулж мөрдөх (Ажил олгогч, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэй)
- МБС-ын стандарт, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх
- Үйлдвэрлэлийн дадлага давамгайлсан сургалтын төлөвлөгөө боловсруулж мөрдөх
- Багшийг чадваржуулах, сургалтын идэвхтэй арга зүйг сургалтад нэвтрүүлэх
- Үйлдвэрлэлийн дадлагын сургагч дадлагажуулагч бэлтгэх
- Чанарын баталгаажуулалтын тогтолцоо (Тусгай зөвшөөрөл, Магадлан итгэмжлэл, Хөндлөнгийн үнэлгээ, Гэрчилгээжүүлэлт) бүрдүүлэх

Өнөөдөр МБСБ-ын 70 орчим хувьд чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна.

## Багш, хүний нөөцийн хөгжил

МБС-ын агуулга, арга зүй, хүний нөөцийн асуудлыг ХНХЯ, Бүсийн арга зүйн төв, МБСБ-ууд голлон хэрэгжүүлж байна.

2017 онд олон улсын төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр давхардсан тоогоор ажил олгогч компаниудын 273 ажилтныг дадлагажуулагч багшаар бэлтгэж, үйлдвэрлэлийн сургалтын 123 багш, үнэлгээний 76 багш, төрөл бүрийн түгээн дэлгэрүүлэх сургалтад 1629 багш, ажил олгогч, 650 удирдах албан тушаалтныг мэргэшил дээшлүүлэх сургалт болон ур чадвар, хүний хөгжлийн гадаад, дотоодын сургалтад хамруулж чадавхижуулсан байна. Харин 2018 оны 1-5 сард донор байгууллагуудын дэмжлэгтэйгээр 2100 багш, удирдах ажилтныг дахин чадавхижуулжээ (ХНХ-ын Сайд С.Чинзоригийн хэлсэн үгнээс). МБС-ын “Багшийг хөгжүүлэх хөтөлбөр” батлан хэрэгжүүлж байна.

## МБС-ын чанарын баталгаажуулалт

Монгол Улсад МБС-ын чанарын баталгаажуулалтын тогтолцоо төлөвшин хөгжиж байна. МБСБ-д тусгай зөвшөөрөл олгох журам, шалгуур үзүүлэлт, сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, чанарын үнэлгээний шинэ тогтолцоо хэрэгжиж байгаа нь МБС-ын багшийн заах аргазүйн чадвар, сургалтын чанар, төгсөгчдийн мэргэшлийн ур чадварт эерэг нөлөө үзүүлж эхэлсэн.

Монгол Улсын МБС-ын салбар дахь чанарын баталгаажуулалт дараах үе шаттай явагддаг. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл олголт
- МБС-ын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэл
- Мэргэшлүүдийн баталгаажуулалт
- Суралцах, сургах үйл явц
- Үнэлгээ ба баталгаажуулалт
- Гэрчилгээжүүлэлт

Тусгай зөвшөөрөл. МБС-ын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь МБС-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгодог.

Тусгай зөвшөөрөл олгох, авах тухай тодорхой удирдамж, журмыг саяхан Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд нийцүүлж, шинэчлэн баталсан бөгөөд үүнд тусгагдсан өргөдлийн баримт бичгүүд, маягтуудыг бүрэн бэлтгэж бөглөсөн байхыг шаарддаг.

Тусгай зөвшөөрлийг олгосны дараа тодорхой хугацааны давтамжтайгаар тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тасралтгүй хангаж байгаа эсэхийг үнэлж тогтоодог.

Магадлан итгэмжлэл. БМИУЗ-ийн 2016 оны 3 дугаар сарын 15-ны 01 тоот тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”-ыг тус тус баталсан. Сургалтын хөтөлбөрийн болон байгууллагын магадлан итгэмжлэлд цөөн тооны сургалтын байгууллага хамрагдаад байгаа бөгөөд цаашид хамрагдалтыг өргөжүүлэх зорилттой ажиллаж байгаа ажээ.

Хөтөлбөрийн мэргэшилүүдийн магадлан итгэмжлэл, мэргэшлийн баталгаажуулалт. Энэ нь МБС-ын салбарын үйл ажиллагааны чанарыг баталгаажуулах бас нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Мэргэшлийн баталгаажуулалт нь төгсөгчдийн эзэмшсэн мэргэшил нь “зорилгод нийцсэн”, ажил олгогчийн шаардлагыг хангасан байхыг илэрхийлнэ. Магадлан итгэмжлэлийн энэ хэлбэрийг Монголын МБС-д өргөн хүрээнд нэвтрүүлэх зорилттой ажиллаж байгаа ажээ.

Суралцах, сургах үйл явц. Монгол Улсын МБС-д чадамжид суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлснээр зарим ахиц өөрчлөлтүүд гарч байна. Суралцах, сургах үйл явц дахь багшийн мэргэшлийн ур чадвар, суралцагчийн сурах сонирхол, идэвх чармайлт, суралцах арга зүйд анхаарч ирсэн. Мөн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн зүгээс тавьж буй мэргэшлийн ур чадварын шаардлагад эдгээр үйл явцыг нийцүүлэхийг чухалчилж байна.

Үнэлгээ ба баталгаажуулалт. ЗГ-аас МБС-ын “Үнэлгээний төв”-ийг байгуулан (Засгийн газрын 216 дугаар тогтоол, 2016) ажиллуулж, МБСБ-ын өөрийн үнэлгээ, Хөндлөнгийн үнэлгээг үндэсний стандартад суурилан зөв, шударга хийх, баталгаажуулах ажиллагаа идэвхтэй хийгдэж байна.

Гэрчилгээжүүлэлт. Өмнө нь МБСБ-ууд гэрчилгээжүүлэлтэд гол үүрэг гүйцэтгэж ирсэн бол одоо ХНХЯ, “Үнэлгээний төв” сургалтын байгууллагуудтай хамтран гэрчилгээжүүлэх ажлыг гүйцэтгэх болсон. Энэ талаар бодлогын чиглэл, журам боловсруулагдаж байна.


Зураг 1.3.5. МБС-ын чанарын баталгаажуулалтын зарим үзүүлэлт

<p><b>ОУ-ын магадлан итгэмжлэл</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>•Барилгын политехник коллеж 2009 онд хүрэл медалийн болзол хангаж, 2 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн. 2012 онд хүрэл медалийн болзол хангаж, 2 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.</li> <li>•ЭМШУИС-ийн Эрүүл мэндийн технологийн сургууль 2012 онд мөнгөн медалийн болзол хангаж, 2 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.</li> <li>•Техник технологийн дээд сургууль 2012 онд мөнгөн медалийн болзол хангаж, 2 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн .</li> </ul>
<p><b>Үндэсний магадлан итгэмжлэл БМИУЗ</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>•2005 оноос хойш өнөөг хүртэл үндэсний хэмжээнд байгууллагын магадлан итгэмжлэлээр 12 сургууль анх удаагаа, 5 сургууль хоёр дахь удаагаа мөн ЭМШУИС-ийн Эрүүл мэндийн технологийн сургуулийн 4 сургалтын хөтөлбөр, Үйлдвэрлэл, урлалын сургуулийн 3 сургалтын хөтөлбөр тус тус магадлан итгэмжлэгдсэн.</li> <li>•Үүнээс өнөөдрийн байдлаар магадлан итгэмжлэл нь хүчинтэй байгаа 8 сургууль, 7 сургалтын хөтөлбөр байна.</li> </ul>
<p><b>МБСҮТ</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>•МБСҮТ нь Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөтөлбөрийн шаардлага хангасан төгсөгчдийн мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгах, баталгаажуулах, мэргэжлийн түвшинг тогтоох, зэрэг олгох, хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах үндсэн чиг үүргийн хүрээнд:</li> <li>•<i>Үнэлгээ, гэрчилгээжүүлэлт:</i></li> <li>•Албан болон албан бус сургалт, амьдрах орчноос чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэний мэргэшлийн түвшинг үнэлж баталгаажуулах, гэрчилгээжүүлэх</li> <li>•Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарт хөндлөнгийн үнэлгээ хийх, Сургалтын байгууллагын чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, агуулгад дүгнэлт гаргах, зөвлөмж гаргах <i>зэрэг МБС-ын чанартай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлж байна.</i></li> </ul>
<p><b>Төгсөгчдийн ажил эрхлэлт</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>•Сүүлийн 3 жилийн статистик мэдээллээс үзэхэд МСҮТ, Политехник коллежийг жил бүр дунджаар 19,5 мянга орчим суралцагч төгсөж, төгсөгчдийн 46-50 гаруй хувь нь нэг жилийн дотор байнгын ажлын байртай болж, 8-10% нь их, дээд сургуульд дэвшин суралцаж байна. Энэ нь дунджаар төгсөгчдийн 54-65 хувь нь ажилтай, сургуультай болж байгаа гэсэн үг юм. Энэ нь их, дээд сургуулийн төгсөгчидтэй харьцуулахад өндөр хувь юм.</li> </ul>



МБСБ-ын төгсөгчдийн эдийн засгийн идэвх, хөдөлмөр эрхлэлтийн талаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт (ХНХСИ)-ээс 2018 онд явуулсан судалгаа (ХНХСИ М.Алтансүх ба бусад, 2018)-наас харахад сургалтын гадаад үр ашиг хангалттай сайн биш байна (Зураг 1.3.6 ба 1.3.7).


Зураг 1.3.6. МБСБ төгсөгчдийн эдийн засгийн идэвх(2018)



Төрөөс МБСБ-ын суралцагчдад зарцуулж байгаа хөрөнгийн үр ашиг, үр нөлөөг сайжруулахад чиглэсэн төрөл бүрийн бодлого, ялангуяа эзэмшсэн мэргэжлээрээ үр бүтээлтэй хөдөлмөрлөх боломжуудыг нэмэгдүүлсэн үйл ажиллагаа, цалин ба урамшууллыг бодитой нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна. МБСБ-ын нийт төгсөгчдийн 28.0 орчим хувь нь төгссөнөөс хойш 24 сарын хугацаанд огт хөдөлмөр эрхлээгүй байгааг дээрх судалгаанд дурдсан бөгөөд түүний дотор 6.0 хувь нь урт хугацааны ажилгүйдэлд шууд өртсөн байна. Ийнхүү урт хугацаанд ажилгүй байх нь ажил олоход улам хүндрэлтэй болдог тул тэдэнд зориулсан тусгайлан, дахин мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах хэрэгцээ байна.


МБСБ төгсөгчдийн ажилгүйдэл хотод 32.8 хувь, хөдөө орон нутагт 67.2 хувьтай байгаа ажээ. Иймээс орон нутгийн ажлын байрыг нэмэгдүүлэхэд тусгайлан анхаарах шаардлагатай байгаа юм.

Зураг 1.3.7. МБСБ төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн хувь: Мэргэжлийн чиглэлээр (2017-2018)



Дээрх судалгаанаас харахад сүүлийн 2 жилийн байдлаар эрүүл мэнд, эрчим хүч, тээвэр, уул уурхай, аж үйлдвэр соёл урлаг зэрэг салбарын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт харьцангуй өссөн бөгөөд сургалтын гадаад үр ашиг нэмэгдсэн байна(Зураг 1.3.8).

Зураг 1.3.8. МБСБ төгсөгчдийн мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн хувь: Мэргэжлийн чиглэлээр (2018)




МБСБ-аар бэлтгэгдэж буй компьютер, санхүүгийн чиглэлийн мэргэжлүүд нь хөдөлмөрийн зах зээлд эрэлт бага, өрсөлдөх чадвар сул, мэргэжлээрээ хөдөлмөр эрхлэлтийн хувь бага байгааг анхааран элсэлтийн бодлого, үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах, мэргэжилтнүүдийн хөрвөх чадварт анхаарах шаардлагатай байна.

МБСБ-аас бэлтгэгддэг барилгын салбарын ажил мэргэжлүүд сүүлийн хэдэн жил эрэлттэй байгаа хэдий ч, тус мэргэжлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хангалтгүй байгаад анхаарал хандуулж ажиллах хэрэгтэй байна. Энэ нь нэг талаас, ур чадварын үл нийцэл, нөгөө талаас, ажлын байрны зуучлал мөн ажил олгогчийн гэрээнд заасан цалин хөлсийн нийт хэмжээ, түнийг олгох хугацаагаа баримталдаггүй зэрэг ажил олгогчдын үүрэг хариуцлагаас тус тус шууд шалтгаалж байна. Иймээс энэхүү мэргэжлийн салбарын төгсөгчдийн асуудлыг тусгайлан судлах хэрэгцээ, шаардлага байна.

Хөдөлмөрийн зах зээл дэх тухайн мэргэжлийн ажлын байранд тавигдах мэргэжлийн ур чадвараас гадна хувь хүнд тавигдах ерөнхий ур чадварууд МБСБ-ийн төгсөгчдөд хангалттай бус байгааг дээрх судалгааны үр дүнгээс харагдаж байна (Зураг 1.3.9).

Зураг 1.3.9. МБСБ төгсөгчдийн ажлын байран дахь ерөнхий ур чадварын хомсдол: Хувийн жингээр (2018)



Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөд мэргэжлийн онолын мэдлэгээс гадна гадаад хэл, компьютерын мэдлэг, баримт бичиг боловсруулах чадвар гол бэрхшээл байгаад анхаарч, энэ чиглэлийн сургалтын хөтөлбөрөө баяжуулах хэрэгцээ, шаардлага байна.

### 1.3.3.3. Инклюзив боловсрол ба үл алагчлах байдал

#### Элсэлт, бодлого, үйл ажиллагаа

Боловсролын тухай хууль (2002, нэмэлт, өөрчлөлт 2006)-д иргэдэд боловсрол эзэмших эрхийг баталгаажуулж, тэднийг боловсрол эзэмшихэд нь үл алагчлах суурь зарчмыг тусгасан байдаг. Иргэн бүр арьс өнгө, үндэс угсаа, иргэншил, хүйс, шашин шүтлэг, хөгжлийн бэрхшээл, нийгэмд эзлэх байр суурь, эдийн засгийн чадавх зэргээс үл хамааран боловсрол эзэмших тэгш эрхтэй (ЮНЕСКО 2008).

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд “Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь иргэнийг эзэмшсэн боловсрол, ур чадварын түвшин, хэрэгцээ, сонирхолд нь үндэслэн зохих модулийн сургалтад элсүүлнэ” (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2009) гэж заажээ. Бид энэ тайландаа МБС-ын салбарын тэгш байдлын хэмжүүрүүдийг авч үзэхдээ хүртээмж, хүйсийн тэгш харьцаа зэргийг суралцагчдынтодорхой зорилтод бүлгүүдэд олгогдож байгаа тэдний боловсролын тусгай хэрэгцээг хангах болон үл алагчилагдах байдал талаас нь салбарын статистикт үндэслэн дүн шинжилгээ хийхийг зорилоо. Албан ёсны мэдээлэл хомс байгаа тул энэ дэд салбар дахь инклюзив боловсрол, үл алагчилсан байдлын асуудлыг ерөнхий байдлаар гаргасан гэдгийг дурдах нь зүйтэй.

Өнөөдөр Монголд өсвөр үеийнхнээс эхлээд бүх насанд хүрэгчдэд МБСБ-д элсэн суралцах боломж нээлттэй байна. Гэвч энэ боломж бүрэн дүүрэн ашиглагдахгүй байна.

Энд онцлох асуудал бол хөгжлийн бэрхшээлтэй суралцагч харьцангуй цөөн буюу МБСБ-ын нийт суралцагчдын 5 орчим хувиас илүүгүй байдаг. Учир нь ХБИ-дэд зориулсан мэргэжлийн сургалт явуулдаг байгууллага улсын хэмжээнд ганцхан байдаг. Энэ нь сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв юм.

Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв дээр дараах чиглэлийн сургалтууд явагддаг байна.

- Мэргэжлийн боловсрол олгох сургалт
- Дохионы хэлний анхан болон дунд шатны сургалт
- Ажил олгогч нарт ХБИ-тэй ажиллах арга зүйд сургалт, зөвлөгөө
- Эцэг эх, асран хамгаалагч нарт нөлөөллийн сургалт
- Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлт


Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн тайлан (Б.Алтмаа, 2019)-аас үзэхэд энэ оны хичээлийн жилд тус төвд 10 чиглэлээр нийт 139 ХБИ (Хүснэгт 1.3.2) суралцаж байна.

*Хүснэгт 1.3.2. Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын тоо: Мэргэжлээр, суралцах хугацаагаар (2018/19 оны хичээлийн жил)*

№	Мэргэжил	1 жил	2,5 жил
1	Тогооч	13	
2	Талх, нарийн боов үйлдвэрлэлийн технологийн ажилтан	7	
3	Бэлэг дурсгалын зүйл урлаач	13	
4	Модон эдлэлийн мужаан	10	
5	Гар утас, телефон аппаратын засварчин	12	
6	Киттельчин	19	
78	Хэвлэлийн график дизайнерч		28
8	Оёмол бүтээгдэхүүний оёдолчин		20
9	Сүлжмэлийн үйлдвэрийн технологийн ажилтан		6
10	Сийлбэрчин		11
	<b>Нийт 139</b>	<b>74</b>	<b>65</b>

Тус төв суралцагчдийн бараг тал хувийг тулгуур эрхтний бэрхшээл (Зураг 1.3.10)-тэй хүмүүс, 40 гаруй хувийг 14-24 насны хүүхэд залуучууд (Зураг 1.3.11) тус тус эзэлж байна.


Зураг 1.3.10. Суралцагчдын хөгжлийн бэрхиээлийн төрөл ба насны ангилал (2019)



МБСБ-уудыг байршлаар нь авч үзвэл аймаг болгонд 1-5 МБСБ ажиллаж, 10-20 мэргэжлээр сургалт явуулж байна. Энэ нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байршлаас хамаарсан МБС-ын хүртээмж хангалттай байна гэж дүгнэж болохоор байна.

МБСБ-ын элсэлтийг Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлж нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа ч зарим жилүүдэд буурах хандлага гарчээ. Энэ нь тухайн үеийн эдийн засгийн хямрал, компаниуд олноор дампуурч үйл ажиллагаагаа зогсоосон, ажлын байрын тоо буурсантай холбоотой байв. МСҮТ-д суралцагчдад төрөөс 70.000 төгрөгийн тэтгэлэг өгч байсныг 2016 онд зогсоосон нь элсэлтэд сөргөөр нөлөөлсөн юм. Мөн суурь боловсрол эзэмшигчдээс Х ангид элсэн суралцах тоо нэмэгдэх болсон нь МСҮТ-д элсэгчдийн тоо буурахад нөлөөлсөн байна. ЕБС-иуд нэг сурагчид ногдох хувьсах зардлаар төсвөө бүрддэг тул сургуулиуд төсвөө бууруулахгүйгээр хадгалж байхын тулд суурь боловсрол эзэмшсэн төгсөгчдөөсөө IX ангид олноор дэвшүүлэн суралцуулах сонирхолтой байдаг. Үүнийг дэд секторүүд төдийгүй нийгэм эдийн засгийн сектор дамнасан дамнасан бодлогын хүрээнд тусгайлан судлах шаардлагатай. Харин сүүлийн 2 жилд МБСБ-д элсэгчдийн тоо өсөж байгаа нь эдийн засгийн хямрал саарч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа сэргэж эхэлсэн болон МБСБ-ыг элсэлтийг нэмэгдүүлэх талаар яам, МБСБ-аас авч байгаа тодорхой арга хэмжээтэй холбоотой (Зураг 1.3.11).

Зураг 1.3.11. Элсэгчдийн тоо: Хүйсээр (2005/06-2018/19 оны хичээлийн жил)




Эх сурвалж: ХНХЯ-ны статистик

### Сургуульд суурилсан ТМБС-ын сургуульд элсэгчдийн хүйсийн харьцаа

Боловсролын бусад түвшингийн суралцагчтай харьцуулахад МБСБ-д суралцах эмэгтэй элсэгчдийн тоо буурах хандлага ажиглагдаж байна (Зураг 1.3.12).

Зураг 1.3.12. Эмэгтэй элсэгчдийн эзлэх хувь (2005/06-2018/19 оны хичээлийн жил)



Үүнийг дараах үндэслэлээр тайлбарлаж болох юм.

- Сүүлийн жилүүдэд улс орны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүд болох уул уурхай, зам, барилга ХАА мэргэжлээр суралцах элсэгчдийн хяналтын тоог нэмэгдүүлэх бодлого барьсан. Эдгээр мэргэжлүүдээр элсэгчдийн олонх нь эрэгтэй байдаг.
- Хөдөлмөрийн зах зээл дээр мэргэжлийн эрэгтэй ажилтны эрэлт хэрэгцээ өндөр байдаг. Монголын хөдөлмөрийн зах зээл нь ажил мэргэжлийн хувьд жендэрээр хуваагдахын сацуу хувиараа хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байна (Дэлхийн Банк, 2013). Хөдөлмөрийн зах зээл дээр ажил мэргэжлүүд хүйсээр ангилалдсан байх нь элбэг байна. Тэгш цалин хөлс олгох тал дээр жендэрийн зөрүүтэй байдал хэвээр байна. (Швейцарын хөгжлийн агентлаг IRIM, 2014)

### Суралцагчдын боломж

Монгол Улсын иргэн бүр МБС-д чөлөөтэй хамрагдах эрхээр хангагдсан. Мөн МБСБ-д суралцагч “Боловсролын тухай” хуулийн 45.1-д зааснаас гадна Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн дагуу дараах эрхийг (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2009) эзэлдэг. Үүнд:

- Сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэгслийг үнэ төлбөргүй ашиглах,
- Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх,
- МСҮТ-ийг өндөр үнэлгээтэй төгсөгч дараагийн шатны сургуульд үргэлжлүүлэн суралцах
- ЗГ-аас тогтоосон журмаар нийгмийн баталгаагаар хангагдах (Боловсролын тухай хуулийн 43.2.). Мөн ЗГ-ын шийдвэрээр 2019 оны 1 дүгээр сараас МСҮТ, Политехник коллежийн суралцагчид сар бүрийн 100 000 төгрөгийн тэтгэлэг авах болсон.


Энэ бүхэн суралцагчийн суралцах эрхээ эдэлж, өөрт хэрэгтэй мэргэжил эзэмшиж, ажил хөдөлмөр эрхлэхэд бодитой дэмжлэг болж байна.

### Санхүүжилт

“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд МБС-ын олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. МБС-ын санхүүжилт бүхэлдээ Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд (МБСДС) төвлөрч зарцуулагдах, эрх бүхий байгууллагууд хяналт тавьж байхаар зохицуулагдсан байна. ЗГ-аас 2011 онд “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг (Засгийн газрын 117 дугаар тогтоол, 2011) батлан гаргасан нь “МБС-ын тухай хууль”-ийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх харилцааг хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн юм.

Энэхүү журмын агуулга, зохицуулалтыг хураангуйлан доорх бүдүүвчээр харуулав.

Зураг 1.3.13. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам (Засгийн Газрын 2011 оны 117 дугаар тогтоол)




“Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулиар тогтоосон санхүүжилтийн тогтолцоо хэрхэн хэрэгжиж ирсэн талаар

МБС-ын үйл ажиллагаанд сүүлийн жилүүдэд дунджаар улсын төсвөөс 65-72 тэрбум төгрөг зарцуулжээ. Монголын МБС-ын салбарт олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцооны эрх зүйн орчин бүрдсэн боловч үндсэндээ улсын төсвөөс санхүүжүүлдэг байдал хадгалагдсаар ирсэн байна. 2014 оны тоо баримтаас үзвэл, салбарын нийт санхүүжилтийн 95.0 гаруй хувь нь улсын төсвөөс олгогдсон бол дөнгөж 1-2.0 хувь нь сургалтын төлбөр, 1-3.0 хувь нь Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын өөрийн орлогоос тус тус бүрджээ.


Мэргэжилтэй ажилтан бэлтгэх санхүүжилтэд үйлдвэр аж ахуйн газрын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн хөрөнгө оруулалт онцгой ач холбогдолтой ч энэ нь бодитой хэрэгжиж чадаагүй байна.

Зураг 1.3.14. МБСДС-д ААН, байгууллагаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч



Сангийн яамнаас ХНХЯ-д санхүүжилт олгож, цааш нь МБСБ-ад хуваарилалт хийдэг. Нийтгөрийн өмчийн МБСБ Хөдөлмөрийн яамнаас үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардалд санхүүжилт авдаг.


Зураг 1.3.15. Төрийн өмчит МБСБ-д Хөдөлмөрийн яамнаас олгосон санхүүжилт, зардлын хуваарилалт (2016)



Эх сурвалж: СЯ, 2016 он

МБСБ-ын нэг суралцагчид ногдох хувьсах зардал нь дунд сургуулийн сурагчдад ногдох хувьсах зардлаас багахан хэмжээгээр илүү байдаг бөгөөд бүс нутгаас хамааран ялгаатай тогтоогддог (Зураг 1.3.16). 2016 оны байдлаар Улаанбаатар хотын хувьд нэг сурагчид ногдох хувьсах зардал 516,000₮ байгаа нь хамгийн бага хэмжээ, Баян-Өлгий аймагт 614,000₮ байгаа нь хамгийн их хэмжээ юм<sup>13</sup>.

Зураг 1.3.16. Нэг сурагчид ногдох хувьсах зардал: Бүсээр (2016, мян.төг)




Эх сурвалж: Хөдөлмөрийн яамны мэдээ, 2016 он

### Хөгжлийн түнш байгууллагуудын санхүүжилт

Хөдөлмөрийн зах зээлд шилжсэн үеэс авч үзвэл, 2009 онд Мянганы сорилтын сангийн төсөл ТМБС-ын салбарт хэрэгжиж эхэлснээс хойш хөгжлийн түнш байгууллагуудын санхүүжилт тус салбарт бодит хувь нэмрээ оруулсан. Германы Олон улсын Хамтын ажиллагааны Нийгэмлэг нь салбарын үр чадварыг хөгжүүлэх төсөл хэрэгжүүлсэн. Дэлхийн Банкны тусламжтайгаар “Боловсролын доноруудын зөвлөлдөх механизм”-ыг байгуулсан бөгөөд хурлыг АХБ, Японы ЖАЙКА гэсэн байгууллагууд хамтран даргалж байв. Сүүлийн жилүүдэд АХБ болон “Оюу Толгой” ХХК-ийн МБС-ын дэд салбарт оруулсан санхүүжилт хамгийн их байна. Мянганы сорилтын сангийн ТМБС-ын төсөл 2009-2013 онд хэрэгжсэн бөгөөд 5 жилийн хугацаанд асар их хөрөнгийг салбарын шинэчлэлд зориулжээ. 2009 оноос олгогдсон “Оюу Толгой” ХХК-ийн буцалтгүй зээлийг оруулаад нийт 230 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг “хөгжлийн түнш байгууллагууд хамтран” ТМБС-ын салбарт хийжээ (Stephen Duggan, 2015 он).

Зураг 1.3.17. Түнш байгууллагуудын ТМБС-ын салбарт одоо хэрэгжүүлж байгаа төслүүд сая ам.доллараар



Эх сурвалж: Мэргэжлийн боловсрол, сургалт түншлэл ТББ

Мянганы сорилтын сангийн төслийн хөрөнгө оруулалт нийт 27.8 сая ам.долларт хүрсэн. Үүний талаас илүүхувийгтоног төхөөрөмж, МБСБ-ын барилга ба тэдгээрийн засвар зэрэгт зарцуулжээ. Энэхүү тайлангийн эхэнд дурдсан зардалд (оролт) суурилсан загвараар МБСБ-ын санхүүжилт хийгдэж байна. Харин үр дүн (гаралт)-д суурилсан санхүүжилтийн тогтолцооны давуу тал нь сургалтын үр дүн, төсвийн хуваарилалтын уялдаа холбоог хангадаг онцлогтой.

Өмнө хийгдсэн судалгаанаас үзвэл, а) Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын төгсөгчдийг дунд сургууль төгсөгчидтэй харьцуулахад 21-24%-аар илүү цалин хөлс авдаг б) Техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын боловсролын өгөөж нь 9.1-10.4%-тай байна гэж дүгнэсэн байна. (RAND-ийн Монгол Улсын судалгаа, 2015 он). Гэхдээ олон улсын харьцуулах судалгааны өгөөж 18% орчим байна (Хорват-42%, Дани-87%; ЮНЕСКО, 2013 он).

<sup>13</sup>Одоогоор уг зардлыг тооцоолохдоо бүс нутгийн ялгаатай байдлыг харгалзаж байгаа боловч мэргэжлүүдийн хувьд ялгаагүй олгогдож байна.



МБС-ын тухай хуульд сүүлд оруулсан нэмэлт өөрчлөлтийн (2016 он) дагуу төрийн өмчийн МБСБ-ууд үйл ажиллагааны зардлаасаа нэмэлт орлого бүрдүүлэх боломжтой болсон.

#### 1.3.4 Дүгнэлт, Зөвлөмж

Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт багагүй амжилт гарч, тодорхой үр дүнд хүрсэн ч цаашид анхаарах, сайжруулах, шаардлагатай асуудлууд байсаар байна. Салбарын цаашдын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд *тулгамдаж буй асуудлууд, шийдвэрлэх боломжийг* дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

**Дүгнэлт 1.** МБС-ын тогтолцоог олон улсын жишиг, өөрийн орны хөгжлийн эрэлт, өвөрмөц онцлогт нийцүүлж, оновчтой тогтоох асуудал манай улсын хувьд тулгамдаж буй чухал асуудлын нэг болоод байна. Тогтолцооны оновчгүй, тогтворгүй байдлаас шалтгаалж, эл салбарт хийж буй шинэчлэл удаашрах, өмнө хүрсэн түвшнээсээ ухрах, мэргэшсэн хүний нөөцийн боломжоо алдах зэрэг сөрөг үр дагавар гарсаар ирсэн. МБС-ын салбарыг Боловсролын болон Хөдөлмөрийн яамдын хооронд ойр ойрхон шилжүүлэх, мэргэжлийн удирдлагын нэгжийг солих, улс төрийн нөлөөллөөр МБСБ-ын захирлууд, удирдах ажилтнуудыг олноор нь халж сэлгэх зэрэг нь салбарын үйл ажиллагаанд муу нөлөө үзүүлсэн. Ер нь мэргэжилтэй ажилтан бэлтгэх асуудал салбарын аль нэг сайдын эрхлэх асуудлын хүрээнд байх нь алинд нь ч давуу болон сул талыг адилхан агуулж ирснийг өнгөрсөн практик харуулсан байна. Олон улсын жишиг хандлагыг харвал, МБС-ын удирдлагын тогтолцоог салбар дундын зарчим (сектор дамнасан)-аар тогтоож, боловсрол, мэргэжлийн боловсрол, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээний бусад салбарууд үйл ажиллагаагаа адил тэгш уялдуулан зохицуулах боломжийг бүрдүүлдэг байна. Мөн МБС-ын төрийн удирдлага нь аль нэг яамны нэгж байхаасаа илүүтэй ЗГ-ын газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустай байх нь МБС илүү “эзэнжих”, асуудлаа бие даан хариуцах, шуурхай шийдвэрлэх, шат дамжлага багасах, сургалтын байгууллагууддаа илүүтэй хүрч ажиллах, салбар хоорондын зохицуулалт хийхэд хялбар дөхөм болох зэрэг тал бүрийн давуу талтайг олон улсын туршлага харуулдаг. Манай Улсад 2009 онд “Мэргэжлийн боловсрол, сургалтын газар” нэртэй ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагийг байгуулж, МБСҮЗ-ийг Монгол Улсын Шадар Сайд даргалж, ажилласан 2 жилийн хугацаанд бодлогын болон сургалтын чадамжид суурилсан сургалт (ЧСС)-ын тогтолцоонд шилжих гол шийдвэрүүдийн тал хувь шахам нь гарсан (МБСҮЗ-ийн 2011 оны тайлан, 2012) байна. Энэ хугацаанд МБСБ-даа илүү хүрч ажиллаж, түншлэлийн хүрээ өргөжиж, Үндэсний болон Салбарын зөвлөлүүдийн үйл ажиллагаа тогтмолжин үр нөлөө нь дээшилж, мэргэжилтэй ажилтан бэлтгэх салбарын үндсэн үзүүлэлтүүд бүхэлдээ ахисныг салбарын ажиллагчдын яриа, санал, статистикийн тоо баримт харуулж байна. Тухайлбал, МБС-ын байгууллагуудад элсэгч, суралцагчдын тоо сүүлийн 4 жил дараалан өсөж, элсэгчдийн дотор насанд хүрэгчдийн хувийн жин 34.6 хувьд хүрлээ. 2010-2011 оны хичээлийн жилд МСҮТ, Политехник коллеж төгсөгчдийн 70 шахам хувь ажилтай, сургуультай болсон нь 2008 оны тухайн үзүүлэлтээс 18.3 пунктээр өсжээ.<sup>14</sup>

**Зөвлөмж 1.** Иймд дээрх туршлага сургамжид үндэслэж төр, хувийн хэвшлийн түншлэлд суурилсан, салбар дундын зохицуулалтыг хэрэгжүүлж чадахуйц МБС-ын тогтолцооны шинэчлэлийг хийх хэрэгтэй байна. МБСҮЗ-ын статусыг өндөржүүлж, МБС-ыг эрхлэх төрийн захиргааны байгууллагыг салбар дундын зарчмаар байгуулж, тогтвортой ажиллуулах замаар олон улсын жишигт нийцсэн, удирдлагын илүү оновчтой, үр дүнтэй тогтолцоонд шилжих бүрэн боломж байна.

**Дүгнэлт 2.** Төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэхэд Үндэсний болон Салбарын зөвлөлүүд, мэргэжлийн холбоод, ажил олгогчдын оролцоог нэмэгдүүлж үйл ажиллагааг дэмжин хөгжүүлэх шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар байгуулагдсан салбарын зөвлөлүүдийн тогтвортой ажиллах нөхцөл бололцоо бүрдээгүйн улмаас үйл ажиллагаа нь зогсонги, зарим Салбар Зөвлөл байгуулагдаагүй байна. МБСҮЗ, түүний салбар зөвлөлүүд нь хууль, дүрэмд заасан бүрэн эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байна. Төр, сургалтын байгууллага дангаараа хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, мэргэшлийн ур чадвартай мэргэжилтэй ажилтан бэлтгэх боломжгүйг хүлээн зөвшөөрч, хувийн хэвшил-ажил олгогчдын оролцоо, түншлэлийг бүхий шатанд тогтмол, үр өгөөжтэй, хариуцлагатай болгох шаардлага байна.

<sup>14</sup>Монгол Улсын шадар сайд, МБСҮЗ-ийн дарга М.Энхболдын “МБС-ын 2012 оны шилдэг төгсөгчдөд өргөмжлөл гардуулах ёслол” дээр хэлсэн үгээс.

**Зөвлөмж 2.** Үүнийг хэрэгжүүлэх гол гарц нь МБСДС-г бие даалган ажиллуулах, сангийн санхүүгийн дэмжлэгийг хэрэгжүүлэх явдал юм. Аж ахуйн нэгж байгууллагууд мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд хөрөнгө, санхүүгийн оролцоотой болгох нь тэдний оролцоог бодитой болгож, хүлээх хариуцлагыг буй болгох хөшүүрэг болно. Тодорхой хэмжээний санхүүгийн дэмжлэг үзүүлсэн ААНБ-ын удирдлага МБСУЗ-д төлөөллөө ажиллуулах эрх бий болгох зэрэг арга хэмжээ авах нь зүйтэй байна.

**Дүгнэлт 3.** Жилд дунджаар 27,5 мянган гадаад иргэн Монгол Улсад ажиллаж, дийлэнх хувь нь барилга, уул уурхайн салбарт ажиллаж байгаа нь гадны ажиллах хүчний импортыг бууруулж, дотоодын мэргэжилтэй ажилтнаар орлуулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

**Зөвлөмж 3.** Гадаадаас ажиллах хүч авах тоо хэмжээг багасгах шаардлагатай байна

**Дүгнэлт 4.** Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт олон жил ашиглаж буй тоног төхөөрөмж, барилга байгууламж, тавилга, эд хогшил нь хуучирч элэгдэн орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байна. Салбарт хэрэгжсэн томоохон төслийн нэг болох Монголын Мянганы Сорилтын Сангийн “Мэргэжлийн боловсрол, сургалт” төслийн хүрээнд сургалтын орчныг сайжруулахад 30 гаруй сая ам.доллар зарцуулагдсан ба нийт төрийн өмчийн 49 МБСБ-ын зөвхөн 28 нь төсөлд хамрагдан тодорхой хэмжээгээр тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Үүнийг мэргэжлээр нь авч үзвэл нийт МБС-ын салбарт бэлтгэгддэг 193 мэргэжлийн 10 хүрэхгүй хувийг эзэлж байна (Хөдөлмөрийн яам, 2015).

**Зөвлөмж 4.** МБСБ-ын хичээлийн болон дотуур байр, үйлдвэрлэлийн дадлагын сургалтын байр, техник, тоног төхөөрөмжүүд, ЧСС-ын стандартын шаардлага хангаж буй эсэхэд судалгаа хийж, үнэлгээ өгөх хэрэгтэй байна. Ингэхдээ өнөөдөр Монгол Улсын үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглагдаж буй, цаашдаа шинэчлэх техник, технологийн шаардлагатай МБСБ-ын байгууллагын дадлагын сургалтын өнөөгийн бааз нийцэж буй эсэхийг ч тогтоох шаардлагатай. Ийм судалгааны дүн, дүгнэлтэд үндэслэж МБСБ-ын хичээлийн болон дадлагын байр, дотуур байрыг шинэчлэх, өргөтгөх болон үйлдвэрлэлийн дадлагын сургалтын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд төрөөс оруулах хөрөнгө оруулалт, ОУБ, гадаадын төсөл хөтөлбөрийн дэмжлэгийг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Мөн Үйлдвэрлэлийн дадлагын сургууль дундын төв байгуулж ажиллуулах, Аж ахуйн нэгж байгууллага дээр хийх үйлдвэрлэлийн дадлагыг өргөжүүлэх, дадлага хүлээн авч чанартай хийсэн ААНБ-д үзүүлэх эдийн засгийн дэмжлэг-хөшүүргийг бодитой болгох зэрэг олон талтай арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.

**Дүгнэлт 5.** МБС-ын санхүүжилтийн тогтолцоо хуульд заасан агуулгаараа хэрэгжиж чадаагүй байна. МБС-ын салбарын санхүүжилт үндсэндээ улсын төсвөөс бүрдэж байна. МБС-ын санхүүжилтийг олон эх үүсвэр бүхий болгох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх санхүүжилтэд гол захиалагч-хэрэглэгч болох аж ахуйн нэгж, байгууллагуудын үүрэг, оролцоог буй болгох зорилгоор “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуульд “Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан” (цаашид “сан” гэх)-г буй болгосон нь шинэ, ач холбогдолтой зохицуулалт болсон. Гэвч энэхүү зохицуулалт жинхэнэ утгаараа хэрэгжээгүй өнөөг хүрсэн.

**Зөвлөмж 5.** “МБСДС-г бие даалган ажиллуулж, ААНБ-ын санхүүгийн дэмжлэгийг хэрэгжүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх нь зүйтэй байна.

**Дүгнэлт 6.** МБС-ын санхүүжилтийн төлөвлөлтийн гол хэрэгсэл-анхдагч нэгж нь “нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив” юм. МБС-ын тухай хуульд “”өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг” (Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2009) гэж заасан. Харин өнөөдөр бид энэхүү хувьсах зардлыг “мэргэжлийн өөрийн өртөгт үндэслэн” тогтоож чадаагүй явж ирсэн байна.

**Зөвлөмж 6.** Энэ нь салбарын санхүүжилтийг бодитой төлөвлөх боломжийг хязгаарлаж байгаа учирхуулиа хэрэгжүүлж, МБС-ын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг мэргэжлийн өөрийн өртөгт үндэслэн тогтоох журам, аргачлалыг боловсруулан баталж хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Мөн МБСБ-ын байгууллагын өөрийн орлогыг багшаа хөгжүүлэх, шинэчлэлийг хэрэгжүүлэх чиглэлээр сургалтын байгууллага захиран зарцуулах асуудлыг журамлаж шийдвэрлэх шаардлага байна.

*Дүгнэлт 7.* МБС-ын салбарт гадаад, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр амжилттай хэрэгжиж, салбарын хөгжилд, бодитой хувь нэмэр оруулсаар иржээ.

*Зөвлөмж 7.* Цаашдаа **төсөл, хөтөлбөрүүдийг өргөтгөх, үр ашгийг нэмэгдүүлэх**, нэг талаар гадаад, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн **уялдаа холбоог хангах, нөгөө талаар зэрэгцэл, давхардлыг арилгах** хэрэгтэй байна.

**Тулгамдсан асуудлууд:**

ЧСС-ыг хөгжүүлэх чиглэлээр олон талт ажлууд хийгдэж байгаа ч дараах тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Үүнд:

- Ажил мэргэжлийн лавлах боловсруулж баталгаажуулах ажлыг өргөжүүлэх. Өнөөдөр салбарын хэмжээнд суралцагчид нийт 193 мэргэжлээр суралцаж байгаа бөгөөд зөвхөн 20 ажил мэргэжлийн лавлах боловсруулагдсан нь хангалтгүй тоо юм.
- МБС-ын стандартын дагуу ЧСС-ын чадамжийн сан бүрэн бүрдээгүйгээс сургууль бүр харилцан адилгүй сургалтын хөтөлбөрөөр хичээллэж байна.
- ЧСС-ыг олон хувилбарт, уян хатан хэлбэрээр явуулах чадавх дутмаг байна. Өөрөөр хэлбэл, суралцагчдын суралцах хэрэгцээ, боломж нөхцөлд тохируулсан сургалтын идэвхтэй арга хэлбэрүүд дутмаг байна.
- Төгсөгчдийн ур чадварыг хөндлөнгийн үнэлгээгээр үнэлэх, баталгаажуулах үйл ажиллагаа эхлэлийн шатандаа байна.
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн мэдээлэл ерөнхий байгаагаас элсэлтийг оновчтой төлөвлөх, зохион байгуулахад хүндрэлтэй байна.
- Суралцагч, төгсөгчдийн мэргэшлийн ур чадварыг сайжруулах гол арга замын нэг үйлдвэрлэлийн дадлагын сургалтыг чанаржуулах, ажил олгогчийн хариуцлагыг дээшлүүлэх шаардлага байна.
- МБС-ын төгсөгчдийн ур чадвар нь ЧСС-ын хөтөлбөр, багшийн ур чадвараас ихээхэн хамаардаг. МБС-ын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг өргөжүүлэх, стандартад нийцүүлэх шаардлагатай. Мөн Багш, хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх тогтолцоо бий болгох хэрэгцээтэй байна. МБС-ын багшийг тасралтгүй сургаж чадваржуулах, мэргэшүүлэх, давтан бэлтгэх тогтолцоо буй болгох, “Багшийн хөгжлийн төв” ажиллуулах шаардлагатай байна. Багш нарыг өндөр хөгжилтэй орны адил төстэй аж ахуйн нэгж, сургалтын байгууллагуудад явуулж сургах, дадлагажуулах ажлыг өргөжүүлэх хэрэгтэй байна.

## 1.4. Дээд боловсрол


### 1.4.1. Өмнөтгөл

Монгол Улсад 2018-2019 оны хичээлийн жилд дээд боловсролын 94 сургалтын байгууллага (ДБСБ) үйл ажиллагаа явуулж, 157,625 мянган суралцагч суралцаж байна. Нийт 94 ДБСБ-ын 37,2% нь их сургууль, 52 буюу 52,1% нь дээд сургууль, 7,4% нь коллеж, 3,2% нь гадаадын салбар сургууль байна.

БСШУСЯ-наас дээд боловсролын чанарыг сайжруулах, чанар муутай олон сургуулийн тоог цөөлөх талаар олон жил тууштай бодлого баримталсны үр дүнд 2004 онд хамгийн оргил үедээ 184 хүрч байсан ДБСБ-ын тоо 2006 онд 170, 2012 онд 99, 2018 онд 94 болж бараг 2 дахин буурав. Гэвч нийт суралцагчдын тоо 2006 онд 142411 байсан бол 2014 онд хамгийн оргил үедээ 178295 хүрч, сүүлийн жилүүдэд буурсаар 2018 онд 157625 болов. Хүн ам зүйн өсөлтийн ирээдүйн төлвөөс шалтгаалан ирэх жилүүдэд суралцагчдын тоо үүнээс ч буурах хандлагатай байгаа нь ДБСБ-уудын менежментийн гол асуудал болж байна.


2010 онд ЗГ-ын шийдвэрээр төрийн өмчийн сургуулиудыг нэгтгэсэн ба төрийн бус сургуулиудын хувьд зах зээлийн жам ёсоор чанаргүй сургуулиудын элсэлт буурч, улмаар зах зээлээс шахагдсан байна (Зураг 1.4.1).

Зураг 1.4.1. ДБСБ-ын тоо: Өмчийн хэлбэрээр (2006/07-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Зураг 1.4.2. Магадлан итгэмжлэгдсэн ДБСБ-ын эзлэх хувь (2006/07-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ДБСБ-ын тоог цөөлөхийн зэрэгцээ чанарыг сайжруулахын тулд БСШУСЯ-наас 2010-2015 онд тэдгээрийг аттестатчилалд хамруулж, 2016 оноос бүх ДБСБ-ууд 5 жил тутамд заавал магадлан итгэмжлэгдэж байхаар хуульчилсан. Магадлан итгэмжлэгдсэн ДБСБ-ын тоо болон тэдгээрт суралцагчдын эзлэх хувь жилээс жилд тасралтгүй нэмэгдсээр өнөөдөр нийт суралцагчдын 96% нь магадлан итгэмжлэгдсэн сургуульд суралцаж байна.

1995 онд Дээд боловсролын тухай хуулийг анх баталж, 2002, 2006, 2012, 2015, 2016 онуудад өөрчлөлт оруулсны дагуу дээд боловсролын дөрвөн шатлалтай (диплом, бакалавр, магистр, доктор) тогтолцоо бүрэлдэж хөгжиж байна. ДБСБ нь энэхүү хуульд заасны дагуу бие даасан хуулийн этгээд байх ба их сургууль, дээд сургууль, коллеж, технологийн коллеж гэсэн ангилалтай байна (УИХ, 2002).

Төрийн өмчийн ДБСБ нь улсын төсөв, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн санхүүжилт, сургалтын төлбөр, аж ахуйн үйл ажиллагааны орлого, хуульд заасан бусад эх үүсвэрээс, харин төрийн бус өмчийн ДБСБ нь улсын төсвөөс бусад эх үүсвэрээс санхүүждэг ба нийт орлогын дийлэнхийг сургалтын төлбөрөөс бүрдүүлдэг.

2018 оны байдлаар Төрийн өмчийн 18 сургуулийн 14 (77.8%) нь их сургуулийн, 4 (22.2%) нь дээд сургуулийн; төрийн бус өмчийн 73 сургуулийн 21 (28.8%) нь их сургуулийн, 45 (61.6%) нь дээд сургуулийн, 7 (9.6%) нь коллежийн ангилалд (үүнээс 3 нь технологийн коллеж байна) багтаж сургалтын ажил эрхэлж байна. Нийт сургуулиудын 19,1% нь төрийн сургууль боловч тэдгээрт нийт суралцагчдын 55,8% нь суралцаж байна. Энэ үзүүлэлт 2006 онд 65,6 байсантай харьцуулахад буурсан хэдий ч төрийн сургуулиуд жиндарсан хэвээр байгаа юм.

Дээд боловсролын сургалтын 94 байгууллагаас 86 нь Улаанбаатар хотод, 8 нь хөдөө орон нутагт байрлаж, нийт суралцагчдын 146,024 буюу 92.6 хувь нь Улаанбаатар хотод, 11,601 буюу 7.4 хувь нь хөдөө орон нутгийн сургуулиудад суралцаж байна.

100000 хүн амд ноогдох ДБСБ-ын тоогоор Монгол Улс нь ОХУ-аас 5 дахин, Японоос 5,4 дахин, Туркээс 15 дахин их байна. Дэлхийн өрсөлдөх чадварын 2016-2017 оны тайланд дурдсанаар дээд боловсролд хамрагдалтаар дэлхийн 138 орноос 38 дугаарт, математик, шинжлэх ухааны боловсролын чанараар 40 дүгээрт эрэмбэлэгджээ. Мөн өрсөлдөх чадварын 12 үзүүлэлтийн нэг болох дээд боловсрол ба мэргэжлийн сургалт гэсэн үзүүлэлт 2007-2009 онд 3,8-3,5 болж буурч байсан бол 2010-2016 онд жил бүр 0,1-0,3 оноогоор тогтмол өсөж 2017 оны байдлаар 4,6 болжээ (ННФ, 2016).

#### 1.4.2 Бодлого, Эрх зүй

“Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” (ЗГ, 2006), “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”(УИХ, 2007), “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” (УИХ, 2008) зэрэг тогтвортой хөгжлийн урт хугацааны төлөвлөгөөнд дээд боловсролын талаар тусгаж, мөн 2007 онд “Төрийн өмчийн их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлыг дэмжих дэд хөтөлбөр”, “Залуу судлаачдыг бэлтгэн дэмжих дэд хөтөлбөр”-ийг тус тус баталж хэрэгжүүлсэн нь дээд боловсролын салбарт энэ үеэс эхлэн бодлого боловсруулагчид урьд өмнөхөөс илүү анхаарал хандуулж эхэлснийг харуулдаг боловч эдгээр хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ хийгдсэн эсэх нь тодорхойгүй байдаг.

“Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд дээд боловсролын чиглэлээр 2015 он хүртэлх хугацаанд 1) хүртээмжийг “дээд боловсролын хамран сургалтын зохицуулалтыг сайжруулах”, 2) чанарыг “дээд боловсролын сургалтын чанарын баталгааг хангах таатай нөхцөлийг бүрдүүлнэ”, 3) менежментийг “дээд боловсролын удирдлага, санхүүгийн тогтолцоог оновчтой болгоно” гэсэн бодлогын зорилго дэвшүүлж, инженер технологи, байгалийн шинжлэл, багш, ХАА-н чиглэлээр бэлтгэх мэргэжилтэнг тоог нь нэмэгдүүлэх, ДБСБ-ын сургалт судалгааны ажил, сургалтын орчны стандартуудыг боловсруулж хэрэгжүүлэх, Нээлттэй их сургууль байгуулах” үүсгэл санаачилгыг дэмжих гэсэн товлосон зорилтуудыг дэвшүүлжээ. “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд “Их сургуулийн болон шинжлэх ухааны төрөлжсөн хотхон, кампус байгуулахыг төрөөс дэмжин хэрэгжүүлэх” гэж заажээ.

2008-2012 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрт (ЗГ, 2008) “их, дээд сургууль, мэргэжлийн төрөлжсөн сургууль болон тэдгээрийн салбарыг бүсийн төв болон орон нутгийн хотод байрлуулахыг дэмжинэ”, “Геологи уул уурхайн чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын сургуулиудын хотхоныг Эрдэнэт хотод хувийн хэвшлийн дэмжлэгтэйгээр байгуулна” гэж зааж, 2010 онд “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал 2010-2021” (ЗГ, 2010), “Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл” (ЗГ, Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл, 2010) тус тус баталсан байна. Гэвч энэ бодлогын хүрээнд бодит ажил болсон зүйл үгүй ажээ. Түүнчлэн 2012-2016 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрт (ЗГ, 2012) “их сургуулиудын хотхоны эрх зүйн орчинг бүрдүүлж, техник-эдийн засгийн үндэслэл, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг баталж, эхний ээлжийн барилга, байгууламжийг барьж эхлүүлэх” гэж заасан боловч 2014 онд “Их сургуулиудын хотхоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г баталснаар энэ чиглэлийн ажил зогссон байна.

2006-2013 онд дээд боловсролын салбарын үр ашгийг дээшлүүлэх, олон улсын стандартад шилжүүлэх зорилттой уялдан АХБ-ны “Мэдлэгт суурилсан нийгэмд зориулан дээд боловсролын шинэчлэл” техникийн туслалцааны төсөл хэрэгжүүлж, энэ төслийн хүрээнд шинэчлэлийн бодлогын зөвлөмж гаргаж, 4 чиглэлээр техникийн баримт бичгийг боловсруулжээ. Төсөл нь анхлан төлөвлөсөн хугацаанаасаа хэтэрч дууссан боловч баталсан төсөвт багтаж, төслийн зорилтот үр дүн хэрэгжсэн байна.

УИХ, ЗГ 2010 оноос хойш “Боловсрол-2021 үндэсний хөтөлбөр” (ЗГ, 2010), “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2015-2024” (УИХ-ын 12 дугаар тогтоол, 2015), “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” (УИХ, 2016), “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр” (УИХ, 2018), “Үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх бодлого”, “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (УИХ, 2018) зэрэг бодлогын баримт бичгүүдийг тус тус баталсан байна. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тусгасан эдгээр баримт бичгүүдэд дээд боловсролын салбарын үйл ажиллагааны бодлого, зорилтуудыг тусган хэрэгжүүлж байна.

2018 онд Ерөнхий Сайд У.Хүрэлсүхийн ивээл дор “Тогтвортой хөгжил-Дээд боловсрол” Улсын II зөвлөгөөнийг зохион байгуулж, энэ салбарын бүх талын төлөөллүүд зорилго, зорилт, үйл ажиллагаагаа хэлэлцэн, нэгтгэн дүгнэж, УИХ, Засгийн газар, БСШУСЯ, ДБСБ-уудад хандан зөвлөмж гаргаж, цаашид хэрэгжүүлэх ажлаа тодорхойлсон. Уг зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг БСШУСЯ-наас гарган ажиллаж байна.

Дээд боловсролын чанар, үр өгөөжийг олон улсын түвшинд хүргэх, хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор 2018 онд “Ази, Номхон далайн бүсийн дээд боловсролын эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай” Токиогийн конвенцод нэгдэж, холбогдох арга хэмжээнүүдийг авч эхэлжээ.

### 1.4.3 Хэрэгжилт, Үр дүн

#### 1.4.3.1. Хүртээмж, Оролцоо

##### Элсэлт

Боловсролын тухай хуульд тодорхойлсон боловсролын үндсэн зарчмуудын нэг нь бүх нийтэд хүртээмжтэй, адил тэгш нөхцөлийг хангах зарчим юм.

Дээд боловсролын тухай хуулийн 7.1-д “Их сургууль, дээд сургууль, коллежид бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэнийг түүний мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ, сурах чадварыг харгалзан элсүүлэх бөгөөд элсэлт нь сонголт хийх боломжтой, шалгаруулалт нь нээлттэй, хүртээмжтэй, үнэлгээний зохистой арга хэлбэр бүхий байна” гэж заасан.

БСШУСЯ-наас баталсан элсэлтийн нийтлэг журмын дагуу, өмчийн хэлбэрээс үл хамааран бүх ДБСБ-ууд уламжлалт болон онлайн хэлбэрээр элсэлтийг зохион байгуулдаг.

ДБСБ-д шинээр элсэгчдэд тухайн жилд ЕБС-ийн XII дугаар ангийг төгсөж, бүрэн дунд боловсрол эзэмшигчид 2006-2009 онд 74%, 2010-2013 онд 70% орчим байсан бол 2014-2018 онд дунджаар 81%-тай (75,6-90,3 хэлбэлзэлтэй) байна. Энэ хугацаанд нийт элсэгчдийн 3-4 хувь нь бусад хэлбэрийн сургуулиас, 15-20 хувь нь ажиллагчдаас, 2-3 хувь нь ажил эрхлээгүй хүмүүсээс элссэн байна.

Хүснэгт 1.4.1. ДБСБ-д шинээр элсэгчдийн тоо (2006/07-2016/17 оны хичээлийн жил)


Он	Шинээр элсэгч							
	Бүгд	Үүнээс эмэгтэй		Бакалаврт	Дипломын дээдэд	Тухайн жилд ЕБС төгсөгчдийн тоо	Тухайн жилд 12-р анги төгсөгчдө өс элссэн элсэгчийн тоо	12-р ангийг төгсөгчдийн бакалаврт шинээр элсэгчдийн нэгдэх
		тоо	хувь					
2006-2007	39,460	23871	60,5	35111	1624		29,331	74,3
2007-2008	43,897	26829	61,1	39216	1459		32,232	73,4
2008-2009	46,692	28321	60,7	40895	1838		35,338	75,7
2009-2010	43,829	26169	59,7	38312	1602		32,569	74,3
2010-2011	44,472	26425	59,4	38553	1449		31,334	70,5
2011-2012	44,484	26374	59,3	38665	-		30,536	68,6
2012-2013	47,744	27795	58,2	41329	-		33,328	69,8
2013-2014	47,182	27909	59,1	40927	-		33,273	70,5
2014-2015	43,834	25097	57,3	37,495	-		30,537	87,2
2015-2016	29,023	17032	58,7	23,562	-	19,735	17,828	90,3
2016-2017	41,195	24097	58,5	35,429	-	36,562	27,626	75,6
2017-2018	45,480	26592	58,5	39,311	66	38,525	32,919 <sup>15</sup>	85,4
2018-2019	44,094	26373	59,8	36,726	244	40,818	31,558	77,3

Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2015 онд ЕБС-ийн 12 жилийн тогтолцооны XII дугаар ангийн анхны төгсөлт хийгдэж, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн тоо өмнөх онуудаас бараг 2 дахин багассантай холбоотойгоор элсэлт 90.3 хувь болж өссөн байна.

2006 оноос БСШУ-ны Сайдын тушаалаар элсэлтийн ерөнхий шалгалтыг 800 оноонд шилжүүлж, хэрэгжүүлж ирсэн ба ДБСБ-д элсэн суралцах босго оноо 400-450 байв. Элсэгчдийн чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн боловсон хүчин бэлтгэхэд чухал ач холбогдолтой гэж үзээд БСШУС-ын Сайдын 2018 оны А/195 тоот тушаалаар ДБСБ-д элсэн суралцах босго оноог өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 480 болгосон ба хөдөө орон нутгийн сургуульд хамрагдалтыг өсгөх үүднээс 420 оноотой элсэгчийг элсүүлэн сургах болжээ. Ингэснээр хөдөө орон нутгийн элсэлт нийт дүнгээр сайжирсан боловч, суралцаж буй мэргэжлийн чиглэлүүдийг тухайн орон нутгийн хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах, мөн оюутны сурлагын амжилт, чанарыг хотын сургуулиудтай ижил түвшинд хүргэж, төгсөөд ажил хөдөлмөр эрхлэх чадвараараа бусад төгсөгчидтэй өрсөлдөх чадварыг дээшлүүлэх нь хөдөө орон нутгийн ДБСБ-уудын тулгамдсан асуудал болов.

Зураг 1.4.3. ДБСБ-д шинээр элсэгчдийн хувь: Боловсролын зэргээр (2018/19 оны хичээлийн жил)




Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2006-2018 онд жил бүр дунджаар нийт элсэгчдийн 59,3% нь эмэгтэй суралцагч байна. 2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар нийт элсэгчдийн 42,7% нь нийслэл хотын харьяалалтай иргэд байна. Нийслэл хотод суралцаж байгаа оюутнуудын 52% нь хөдөө орон нутгаас суралцаж байгаа ба тэд сургалтын төлбөрөөс гадна дотуур байр, замын зардал гэх мэтээр илүү зардлаар боловсрол эзэмшиж байна. Гэвч оюутнууд сургалтын төлбөр, замын зардалд санхүүгийн дэмжлэг авах боломжтой байдаг нь дээд боловсролын хүртээмжид эерэгээр нөлөөлдөг.

<sup>15</sup> Тухайн жилд 12-р анги төгсөөд бакалавр, дипломын дээдэд элссэн суралцагчдын нийлбэр дүн. Дипломын дээдэд 66 хүүхэд тухайн жил 12-р анги төгсөөд элсэн орсон байна.

Зураг 1.4.4. ДБСБ-д шинээр элсэгчдийн тоо (хувь): Бус нутаг, боловсролын зэргээр 2018/19 оны хичээлийн жил



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Дотоодод төдийгүй гадаадад дээд боловсрол эзэмших боломж Монголд нээлттэй байдаг. Өндөр мэргэжлийн боловсон хүчнийг дэлхийн улс оронд сургах бодлогыг, төрөөс баримталж, тодорхой хөтөлбөрүүд, олон төрлийн тэтгэлэг хэрэгждэг. “Дээд боловсролын эрэлт нийлүүлэлтийн шинжилгээ” (С.Батбилэг, 2013)-нд 2012 онд Монгол улсаас гадаад улсад суралцаж буй оюутны тоог дараах байдлаар гаргажээ (Хүснэгт 1.4.2).


Хүснэгт 1.4.2. Монгол улсаас гадаадын улс оронд суралцаж буй оюутны тоо: сургалтын төлбөрийн эх үүсвэрээр (2012)

	Бүгд	ОECD-ийн гишүүн улсууд	ОECD-ийн гишүүн бус улсууд	ОХУ	Хятад
Бүгд	12798	7588	22	1740	3448
ЗГ-ийн тэтгэлгээр докторт	1348	230	64	159	895
СТС-ийн зээлээр магистр, докторт	399	337	1	61	
Хувийн зардлаар болон бусад тэтгэлгээр	7954	6361	0	22	1571

Эх сурвалж: С.Батбилэг, 2013

2012-2018 оны хугацаанд Монгол Улсын ЗГ-ын шугамаар гадаадад нийт 8,088 суралцагч суралцсан байна. Эдгээр суралцагчдын 7,181 буюу 88.8 хувь нь ЗГ хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу, 907 буюу 11.2 хувь нь “Боловсролын зээлийн сан”-ийн зээлийн санхүүжилтээр суралцсан байна. Эдгээр суралцагчид төгсөөд эх орондоо эргэн ирж 5-оос доошгүй жил үр бүтээлтэй ажил хөдөлмөр эрхлэхээр зээлийн гэрээнд тусгасан байдаг. Анх энэ төрлийн зээл 1997 оноос эхлэн хэрэгжихдээ ямар нэгэн мэргэжил харгалзалгүйгээр төрийн албан хаагч, яам тамгын газар, бодлого боловсруулдаг газрын хүмүүсийг нэр хүндтэй сургуулиудад мэргэшүүлэх чиглэлээр сургаж байсан бол сүүлийн жилүүдэд Монгол Улсад хэрэгцээтэй гэж батлагдсан инженер, технологич, байгалийн ухаан зэрэг 40 гаруй мэргэжлээр түлхүү сургах чиглэл баримталж байна.

Зураг 1.4.5. Монгол Улсын Засгийн газрын шугамаар гадаадад суралцагчдын тоо (2012-2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцаж буй суралцагчдыг суралцаж буй орноор нь харуулбал, нийт суралцагчдын 34.6% нь ОХУ-д, 33.7% нь БНХАУ-д, 8.2% нь Унгар улсад, 4.5% нь Япон улсад, 4.4% нь Турк улсад суралцаж байгаа бол 0.1-0.2% нь Беларусь, Куба, Румын улсад тус тус суралцаж байна (хавсралт 4).

Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадад суралцагчдын тоо жилээс жилд өссөн дүнтэй байгаа бөгөөд 6 жилийн дундаж өсөлтийг авч үзэхэд 7.4-өөр өссөн байна. Жилээс



жилд гадаадад суралцах хүсэлтэй иргэдийн тоо өссөөр иржээ. 2018 оны байдлаар 4,346 иргэд бүртгүүлснээс 42.7% нь буюу 1855 иргэн шалгалтад тэнцэж, ярилцлагад орсноос 1,376 иргэн сонгогдсон байна. Бүртгүүлсэн иргэдийн 31.7 хувь буюу 1376 иргэн гадаадад суралцах эрхтэй болжээ.

Гадаадад суралцагчдын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл (мэргэжлийн чиглэл, нас, хүйс, суралцаж буй түвшин, сургуулийн нэр гэх мэт) хомс байна. Хувийн зардал болон бусад тэтгэлгээр суралцагчдын хувьд энэ төрлийн мэдээллүүд огт алга байна. Мөн оюутан солилцооны хөтөлбөр, түүнд хамрагдсан оюутны статистик мэдээллүүд ч олдсонгүй.

### Хамран сургалт

“Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд дээд боловсролын хамран сургалтын талаар дараах товлосон зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувийн жинг 29,1 хувиас 45,0 хувь болгож өсгөх бодлого баримтална. Үүнд:


- Инженер, технологийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 13,0 хувиас 25,0 хувьд
  - Хөдөө аж ахуйн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 3,1 хувиас 6,0 хувьд
  - Байгалийн шинжлэлийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 2,9 хувиас 4,0 хувьд
  - Багшийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 9,8 хувиас 10,0 хувьд тус тус хүргэнэ.
- Бусад мэргэжлийн чиглэлээр суралцагчдын нийт суралцагчдад эзлэх хувийн жинг 38,9 хувиас 34,0 хувьд хүргэнэ. Үүнд:
  - Нийгэм, хүмүүнлэгийн ухааны мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 18,5 хувиас 10,0 хувьд
  - Хуулийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 5,8 хувиас 4,0 хувьд
  - Анагаах ухааны мэргэжлийн чиглэлээр суралцагчдыг 7,7 хувиас 7,0 хувьд тус тус хүргэнэ.
- Хувийн их, дээд сургуулийн оюутнуудын хийт суралцагчдад эзлэх хувийг 6,7 хувиар бууруулж 25,0 хувьд хүргэнэ.
- Бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдөөс тухайн жилд их, дээд сургуульд элсэгчдийг 11,0 хувиар бууруулж 70,0 хувьд хүргэнэ.
- Их, дээд сургуульд шинээр элсэгч бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөгчдийн хувийг 31,0 хувиар бууруулж 50,0 хувьд, бусад элсэгчдийн хувийг 25,2 хувиар нэмэгдүүлж 50,0 хувьд хүргэнэ.

Зураг 1.4.6-д үзүүлсэн ДБСБ-д суралцагчдын мэргэжлийн чиглэлийн эзлэх хувиас үзэхэд Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээр суралцагчдын элсэх хувь 18,6 хувиас 14,5 хувь хүртэл, Хөдөө аж ахуйн чиглэлээр суралцагчдын эзлэх хувь 2,9 хувиас 2,2 хувь хүртэл, Байгалийн шинжлэлийн мэргэжлээр суралцагчдын эзлэх хувь 4.6 хувиас 2,7 хүртэл тус тус буурч, харин Мэдээлэл, харилцаа холбооны технологийн мэргэжлээр суралцагчдын эзлэх хувь 2,8 хувиас 3,2 хувь хүртэл, Багшийн мэргэжлийн чиглэлээр суралцагчдын эзлэх хувь 12,7 хувиас 14,8 хувь хүртэл тус тус өсжээ.

Энэ статистикаас үзэхэд дээд боловсролын хамран сургалтын талаарх товлосон зорилгууд хэрэгжээгүй байна. Тэргүүлэх чиглэл буюу инженер технологи, байгалийн ухаан, хөдөө аж ахуйн чиглэлээр голчлон төрийн өмчийн ДБСБ-ууд сургалт эрхэлж байгаагаас гадна хөдөө орон нутгийн ДБСБ-ууд эдгээр мэргэжлүүдээр бараг сургалт эрхлэхгүй байна. Харин сүүлийн жилүүдэд төрийн бус өмчийн ДБСБ-ууд боловсрол судлал, эрүүл мэндийн чиглэлээр шинэ хөтөлбөр нээж, салбар сургууль байгуулсантай холбоотойгоор эдгээр чиглэлээр суралцагчдын тоо нэмэгджээ. Гэсэн хэдий ч эрүүл мэндийн салбар эмч, эм зүйч мэргэжилтнүүд илүүдэлтэй, харин сувилагч болон туслах ажилтан дутагдалтай болж, ЭМЯ болон БСШУСЯ-ны хамтарсан ажлын хэсэг удаа дараа ажиллаж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн судалгаа, төлөвлөлтөд тулгуурлан дутагдаж буй мэргэжлээр илүү элсэлт авахыг ДБСБ-уудад зөвлөмжилсөн боловч нааштай үр дүн гараагүй байгаа ажээ. Эрүүл мэндийн чиглэлийн 15 хөтөлбөр хэрэгжиж байгаагаас анагаах ухаан, эм зүй, уламжлалт анагаах ухаан, сувилахуй, нүүр ам судлал гэсэн 5 хөтөлбөрөөр нийт суралцагчдын 91% нь суралцаж байна. Эмч болон сувилагч мэргэжлээр суралцаж байгаа тооны харьцаа нь 4,5:1 байгаа нь ЭМЯ-ны статистикт 1 эмчид 1,2 сувилагч ноогдож байгаатай харьцуулахад урвуу хамааралтай байна. Харин олон улсын жишигт 1 эмчид 3 сувилагч ноогддог ажээ. Энэ жишээнээс

үзэхэд үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, эрэлт, хэрэгцээтэй уялдуулах зайлшгүй шаардлага байна.

Зураг 1.4.6. ДБСБ-д тухайн мэргэжлээр суралцагчдын эзлэх хувь (2006-2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Одоогийн байдлаар суралцагчдыг суралцаж буй мэргэжлийн чиглэлээр ангилж үзвэл, нийт суралцагчдын 14.8 хувь нь боловсрол; 2.7 хувь нь байгалийн шинжлэх ухаан, математик, статистик; 3.2 хувь нь мэдээлэл, харилцаа холбооны технологи; 14.5 хувь нь инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт; 2.2 хувь нь хөдөө аж ахуй, ой, загасны аж ахуй, мал эмнэл зүй; бусад мэргэжлийн чиглэлээр 62,5 хувь нь тус тус суралцаж байна.


Хэдийгээр бодлогын баримт бичгүүдэд удаа дараа тусгагдсаар ирсэн боловч дээд боловсролын хамран сургалт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, үндэсний хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдахгүй байгаа нь уг бодлогыг хэрэгжүүлэх талаар илүү дорвитой арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

### Суралцагчид

2010-2011 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 148726 нь буюу 87,4% нь Улаанбаатар хотод, 21400 буюу 12,6% нь хөдөө орон нутагт суралцаж байв. Хөдөө орон нутагт суралцагчдын тоо жил бүр буурахын хирээр Улаанбаатар хотод суралцагчдын тоо өссөөр байсан.

2018-2019 оны хичээлийн жилд ДБСБ-д нийт суралцагчдын 146,024 буюу 92.6 хувь нь Улаанбаатар хотод, 11,601 буюу 7.4 хувь нь хөдөө орон нутгийн сургуулиудад (салбар сургуулиуд ороод) суралцаж байгаа нь өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад нийт сурагчдын дүнд нийслэл хотод суралцагчдын эзлэх хувь өмнөх оноос 0.2-оор буурсан бол, хөдөө орон нутгийнх эсрэгээрээ 0.2-оор өссөн байна. Энэ нь 2018 онд хөдөө орон нутгийн сургуульд элсэлтийн босго оноог ялгавартай тогтоосон бодлогын үр дүн юм. Нийт суралцагчдын 2,5% нь баруун бүсэд, 1,9% нь хангайн бүсэд, 2,5% нь төвийн бүсэд, 0,5% нь зүүн бүсэд тус тус суралцаж байна.


Зураг 1.4.7. ДБСБ-д суралцагчдын тоо: Бүс нутгаар (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2006-2007 оны хичээлийн жилд нийт суралцагчдаас дипломын хөтөлбөрт 2,9%, бакалаврт 91,2%, магистрт 4,4%, докторт 1,5% нь суралцаж байсан бол 2018-2019 онд нийт суралцагчдаас дипломын хөтөлбөрт 0,2%, бакалаврт 82,8%, магистрт 14,3%, докторт 2,7% нь суралцаж байна. Суралцагчдын тоогоор авч үзвэл магистрт суралцагчдын тоо 3,6 дахин, докторт суралцагчдын тоо 2 дахин өсжээ.


Зураг 1.4.8. ДБСБ-д суралцагчдын тоо: Боловсролын зэргээр (2006/07-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Нийт суралцагчдын 7.5 хувь нь 18 хүртэлх настай, 68.6 хувь нь 18-24 настай, 12.4 хувь нь 25-29 настай, 11.5 хувь нь 30 ба түүнээс дээш настай байна. Сүүлийн 5 жилийн судалгаанаас харахад: их, дээд сургууль, коллежид сурч байгаа 18 хүртэлх насны хүүхдийн тоо буурч байсан бол 2017 оноос өссөн байна. Энэ нь дипломын дээд зэргээр суралцаж буй оюутан нэмэгдсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Зураг 1.4.9. ДБСБ-д суралцагчдын тоо: Насны ангиллаар (2006/07-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

### Гадаадын суралцагчид

Төрийн өмчийн 10, төрийн бус өмчийн 27, гадаадын салбар сургууль 2, нийтдээ дээд боловсролын сургалтын 39 байгууллагад гадаадын оюутан, магистрант, докторант сурч байна.

2018-2019 оны хичээлийн жилийн статистикийн мэдээгээр гадаадын 33 орны 2,275 иргэн Монголын их, дээд болон гадаадын салбар сургуульд сурч байгаагийн 1,235 (54.3%) нь

бакалаврын (монгол хэлний бэлтгэл ороод), 731 (32.1%) нь магистрын, 309 (13.6%) нь докторын сургалтын хөтөлбөрт тус тус хамрагдаж байна. Эдгээр суралцагчдын 99 (4.4%) нь хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу Монгол Улсын ЗГ-ын тэтгэлгээр, 2,036 (89.5%) нь хувийн, үлдсэн нь 140 (6.2%) бусад зардлаар суралцаж байна.

Гадаадын суралцагчдын 53.1 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь өмнөх оноос 0.5-аар өссөн байна. Нийт суралцагчдын 76.5 хувь нь (1,740) төрийн өмчийн, 21.6 хувь нь (491) төрийн бус өмчийн, 1.9 хувь нь (44) гадаадын салбар сургуулиудад суралцаж байна.

БНХАУ-аас 1,640, ОХУ-аас 236, БНСУ-аас 171 суралцагч байгаа нь нийт гадаадын суралцагчдын 90.0 хувь болж байна. Эдгээр 3 улсаас суралцагчдын хувь өнгөрсөн хичээлийн жилийнхээс 2.4 хувиар өссөн ба тооны хувьд БНХАУ-ын суралцагчид 522-оор, ОХУ-аас суралцагчид 56-аар, БНСУ-ын суралцагчид 36-аар тус тус нэмэгджээ.


Дээд боловсролын эрэлт нийлүүлэлтийн шинжилгээ” (С.Батбилэг, 2013)-нд тооцон 2012 онд Монгол улсад гадаадаас сурч буй оюутны тоо, тэдний сургалтын зардлыг гаргасан байна (Хавсралт 10).

Зураг 1.4.10. Гадаадын улс орноос Монголын ДБСБ-д суралцагчдын тоо: Боловсролын зэргээр, (2008/09-2012/13 оны хичээлийн жил)



Эх сурвалж: С.Батбилэг, 2013

Зураг 1.4.11. Гадаадын улс орноос Монголын ДБСБ-д суралцагчдын тоо: Сургалтын төлбөрийн эх үүсвэрээр (2008/09-2012/13 оны хичээлийн жил)



Эх сурвалж: С.Батбилэг, 2013

Сүүлийн 5 жилийн статистик мэдээгээр гадаадаас Монголд суралцагчдын тоо өсөж байгаагийн дотор магистрантур, докторантурт суралцагчдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа БНХАУ-аас суралцагчдын тоо сүүлийн 5 жилд 2.9 дахин нэмэгджээ. Харин ОХУ, БНСУ-аас суралцаж буй суралцагчдын тоо буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1.4.3. Гадаадын улс орноос Монголын ДБСБ-д суралцагчдын тоо: Боловсролын зэргээр, (2014/15-2018/19 оны хичээлийн жил)


Үзүүлэлт	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Оюутан нь суралцдаг гадаад улсын тоо	32	27	32	31	33
Гадаадын суралцагчтай Монгол дахь сургуулийн тоо	39	46	38	38	39
Гадаадын суралцагчдын нийт тоо	1,245	1,450	1,520	1,636	2,275
Үүнээс: - БНХАУ-аас	561	837	969	1,118	1,640
- ОХУ-аас	254	206	182	180	236
- БНСУ-аас	176	137	132	135	171
Үүнээс: -Магистрантурт (тоогоор)	258	368	497	420	731
- Магистрантурт (хувиар)	<b>20.7</b>	<b>25.4</b>	<b>32.7</b>	<b>25.7</b>	<b>32.1</b>
Үүнээс: - Докторантурт (тоогоор)	114	138	173	150	309
-Докторантурт (хувиар)	<b>9.2</b>	<b>9.5</b>	<b>11.4</b>	<b>9.2</b>	<b>13.6</b>

Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

### Төгсөгчид, ажил эрхлэлт

2017-2018 оны хичээлийн жилд 29,164 суралцагч сургуулиа төгссөн нь өмнөх хичээлийн жилүүдээс буурсан байна. Нийт төгсөгчдийн 45 нь дипломын дээд (0.2%), 25120 нь бакалаврын (86.1%), 3,868 нь магистрын (13.3%), 131 нь докторын (0.3%) зэргээр төгсжээ.

Зураг 1.4.12. ДБСБ-ыг төгсөгчдийн тоо/хувь: Боловсролын зэргээр (2013/14-2017/18 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

2017-2018 оны хичээлийн жилийн нийт төгсөгчдийн 34.4 хувь нь төгссөн даруйдаа ажлын байртай болсон байна. Докторантур төгсөгчид бараг бүхэлдээ (96.2%), магистрантур төгсөгчдийн 80.1 хувь нь ажлын байртай хүмүүс байгаа бол бакалаврын зэргээр төгсөгчдийн ажил эрхлэлтийн байдал 27.1 орчим хувьтай байгаа нь нэгдүгээрт, зарим сургуулиуд төгсөгчдийн ажил эрхлэлтийн мэдээгээ бүрэн гаргаж чадахгүй байгаа, хоёрдугаарт, төгсөгчид төгссөн үедээ тэр бүр ажлын байртай болж амжихгүй байгаатай холбоотой гэж үзсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргасан “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2017”-д дурдсанаар 2015-2016 оны хичээлийн жилд мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагыг мэргэжлийн анхан шатны болон түүнээс дээш бакалаврын боловсрол эзэмшсэн нийт 44.9 мянган төгсөгчдөөс 4909 төгсөгчдийг түүвэрлэн, судалгаанд хамруулсан байна. Судалгааны дүнгээс харахад их, дээд сургууль төгсөгчдийн 68.4% нь хөдөлмөр эрхэлж байгаагаас тэдний 69.6% нь эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Их, дээд сургууль төгсөгчдийн хувьд барилга архитектурын мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр буюу 83.2% байгаа бол компьютер, анагаах ухаан, физик, хими, биологи, газар зүй, математик статистик, нийгэм, эдийн засаг, тээвэр, багш боловсрол судлал зэрэг мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 70.9-76.5% байна.

Монгол Улсын ажиллах хүчний 2018 оны судалгаанд боловсролын түвшингээр ажилгүй иргэдийг авч үзвэл, тодорхой мэргэжил эзэмших түвшний буюу техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд болон дээд боловсролтой ажилгүй иргэд нийт ажилгүй иргэдийн 75.0 хувь байгаа бол үлдсэн 25.0 хувь нь бүрэн дунд, түүнээс доош болон боловсролгүй иргэд байна. Хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам ажилгүй

байдаг бол манай улсад боловсролтой иргэд илүү ажилгүй байх хандлагатай байна. Энэ нь нөгөө талаас, мэргэжлийн болон дээд боловсролд хамрагдалт өндөр байгаатай холбоотой.

2014-2016 онд ХНХСИ-ээс гурван жил давтан явуулсан “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа”-ны үр дүнгээс харахад ажлын байранд тавигдаж буй ажил үүргийн шаардлага, боловсролын түвшингийн тохиромжтой байдал жилд дунджаар 70 гаруй хувь нь нийцэлтэй, үлдсэн 30% нь боловсролын түвшингээс хамаарсан ажил үүргийн үл нийцэлтэй байжээ. Харин төгсөгчдийн 10% гаруй нь ажил үүргийн шаардлага ур чадвараас нь өндөр ажил үүргийн шаардлагатай ажил хийж байна. Цаашид ямар мэргэжлээр төгссөн төгсөгчдөд ур чадварын зөрүү их гарч байгааг нарийвчлан судлах шаардлагатай гэж дүгнэжээ.

БСШУСЯ-наас АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд IRIM судалгааны хүрээлэн “Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах нь” зөвлөх үйлчилгээгээр гүйцэтгэсэн шинжилгээний тайланд дурдсанаар тухайн хүн бүрэн дунд боловсролтой, нас чацуу хүнтэй харьцуулахад цалин нь дунджаар хэдэн хувь зөрүүтэй байгааг тооцоолон бүрэн дундаас доош боловсролын түвшинтэй хүний боловсролын өгөөж -39%, бүрэн дунд боловсролын түвшинтэй хүний боловсролын өгөөж 0%, техник мэргэжлийн боловсролын түвшинтэй хүний боловсролын өгөөж 11%, тусгай мэргэжлийн дунд боловсролын түвшинтэй хүний боловсролын өгөөж 17%, дипломын дээд болон бакалаврын боловсролын түвшинтэй хүний боловсролын өгөөж 41%, дипломын дараах боловсролын түвшинтэй хүний боловсролын өгөөж 54% байна гэжээ. Ингэхээр дээд боловсрол эзэмших нь нийгэмд ч, хувь хүнд ч өгөөжтэй бөгөөд эдгээр хүчин зүйлээс шалтгаалж ЕБС төгсөгч бүр дээд боловсрол эзэмших эрмэлзэлтэй болсон (Р.Нямцэрэн, Р.Нурбек, 2018) гэж үзэж байна.

### 1.4.3.2. Чанар, Нийц

#### Чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэл

Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөнд дээд боловсролыг олон улсын жишигт хүргэх зорилтын хүрээнд чанарыг баталгаажуулах тогтолцоо бүрдүүлж, чанарын соёл төлөвшүүлэх дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- Дээд боловсролын сургалтын байгууллагуудын сургалт, судалгааны ажил, сургалтын орчны стандартуудыг боловсруулж хэрэгжүүлэх
- Сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагаанд тавих шаардлага, шалгуурыг боловсронгуй болгон мөрдүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн байгууллагын чиг үүргийг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх
- Дээд боловсролын байгууллагад ажиллагчдын ажил, үйлчилгээний стандарт, магадлан итгэмжлэлийг бий болгох
- Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд баримтлах ёс зүйн дүрмийг боловсруулж мөрдүүлэх
- Гадаад оронтой боловсролын баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх
- Их, дээд сургуулийн техник, технологийг дэмжихэд зориулсан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлогын таатай орчин бүрдүүлэх.

Эдгээр зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт шинжилгээний албан ёсны тайлан мэдээ гараагүй байна. Дээрх зорилтууд бүрэн хэрэгжээгүй боловч магадлан итгэмжлэлийн үндэсний тогтолцоог хөгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэхэд 2012-2016 онд нэлээд ахиц гарсан нь АХБ-ны санхүүжилтээр хэрэгжсэн Дээд боловсролын шинэчлэлийн төслийн үр дүн гэж үзэж болно.

Боловсролын бусад дэд салбараас анхлан дээд боловсролын салбарт 1998 оноос байгууллагын, 2004 оноос хөтөлбөрийн, 2017 оноос хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийг тус тус хэрэгжүүлж байна.

Өнөөдрийн байдлаар их дээд сургуулийн 75% буюу 72 сургууль магадлан итгэмжлэгдсэн. Түүнчлэн 250 гаруй хөтөлбөр Үндэсний Зөвлөлөөр, дээд боловсролын сургалтын 18 байгууллагын 90 гаруй хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлэгдсэн нь дээд боловсролын чанарыг сайжруулах бодлогын гол үр дүн гэж үзэж болно. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийн дийлэнх нь эдийн засаг бизнесийн хөтөлбөрүүд бөгөөд тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрүүдийн чанарыг сайжруулах зорилгоор 2012-2019 онд хэрэгжиж буй “Дээд боловсролын

шинэчлэл төсөл”-ийн хүрээнд инженер технологи, ХАА, багш, эмч чиглэлийн 7 хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлэхэд дэмжлэг үзүүлжээ. Ингэснээр эдгээр чиглэлийн хөтөлбөрүүдийг олон улсад магадлан итгэмжлүүлэх санаачилга гаргах нь нэмэгдэж байна.

Хүснэгт 1.4.4. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо (2004-2018)

Он	Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо			Төрийн өмчийн ДБСБ-ын	Төрийн бус өмчийн ДБСБ-ын	Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	
	Нийт тоо	Үүнд:					
		Бакалавр	Магистр	Доктор			
2004	3	2	1	-	3	-	-
2005	4	1	3	-	1	3	-
2006	8	8	-	-	7	1	-
2008	6	4	2	-	5	1	-
2009	16	16	-	-	15	1	1
2010	10	8	2	-	10	-	-
2011	41	38	3	-	37	4	1
2012	31	25	6	-	17	14	12
2013	37	35	2	-	35	2	27
2014	34	30	3	1	24	10	28
2015	29	28	1	-	13	16	1
2016	-	-	-	-	-	-	8
2017	1	1	-	-	1	-	17
2018	38	37	1	-	36	2	3

2015-2017 онд боловсролын магадлан итгэмжлэлийн ажлын албаны шинэчлэлийн үе буюу хууль эрх зүй, дүрэм журмыг шинэчлэх шаардлагатай гэдэг үндэслэлээр магадлан итгэмжлэх үйл ажиллагаа удааширсан ч 2018 оноос идэвхжиж байна.

2016 оноос эхлэн шинээр нээх хөтөлбөрт БСШУСЯ-наас сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгохын өмнө БМИҮЗ урьдчилсан магадлан итгэмжлэл хийж, дүгнэлт гаргах болсон нь сургалтын үйл ажиллагааг эхлэхээс нь төгсөгчдөд мэргэжлийн эрх олгох хүртэл нь чанарыг тасралтгүй сайжруулах тогтолцоог бүрдүүлэхэд чухал нөлөөтэй үзүүлэх болсон (Хүснэгт 1.4.5).

Хүснэгт 1.4.5. Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын үндэсний тогтолцоо

	Зорилго	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэгч	Стандарт, шалгуур	Объект
ХӨЛГӨӨГХ	Сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрх олгох	Урьдчилсан магадлан итгэмжлэл	БМИҮЗ	Урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага	Шинэ нээх хөтөлбөрт
		Тусгай зөвшөөрөл олгох	БСШУСЯ	Сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, стандартууд	
ХЭРЭГЖҮҮЛЭХ	Шаардлага, стандартыг хангуулах	Хяналт-шинжилгээ	БСШУСЯ	Сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах шаардлага, стандартууд	ДБСБ
	Чанарыг сайжруулах	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	БМИҮЗ	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шаардлага	Хэрэгжиж буй хөтөлбөр
	Чанарыг сайжруулах	Байгууллагын магадлан итгэмжлэл	БМИҮЗ	ДБСБ-ын магадлан итгэмжлэлийн шаардлага	ДБСБ
ҮР ДҮН	Мэргэжлийн эрх олгох	Лицензийн шалгалт	Салбарын яам, мэргэжлийн холбоо	Салбарын яам, мэргэжлийн холбооноос тогтоосон шаардлага, стандарт	Төгсөгчид
	Мэдээллээр хангах	Бүртгэл	БСШУСЯ, БМИҮЗ	Засгийн газар, салбарын яамдаас тогтоосон шаардлага	ДБСБ, хөтөлбөр

ДБСБ-ын болон хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийг заавал, харин хэрэгжиж буй хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг сайн дурын үндсэн дээр 5 жилийн давтамжтайгаар хийж байна. Боловсролын тухай багц хуульд 2016 онд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр өмнө нь хэрэгжиж байсан чанарын хяналт, үнэлгээний олон давхардсан механизм тухайлбал, аттестатчилал, мэргэжлийн хяналт, яамны үзлэг шалгалт зэргийг халж, дээрх тогтолцоог эрх зүйн хувьд

баталгаажуулж өгсөн ба сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог дэмжин хөгжүүлэхийг зорьж байна.

Сургалтын чанарыг хянах, үнэлэх, баталгаажуулах ажлыг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор АХБ-ны санхүүжилтээр 2012-2019 онд хэрэгжиж буй “Дээд боловсролын шинэчлэл төсөл”-ийн хүрээнд дээд боловсролын чанарын баталгаажуулалт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох ажлууд хэрэгжсэн. Ингэснээр 2016 онд Боловсролын тухай хууль, ЗГ-ын баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм” болон бусад эрх зүйн баримт бичгүүд шинэчлэгдэн батлагдаж, магадлан итгэмжлэлийн төв байгууллага болох БМИҮЗ нь олон улсын INQAAHE-GGP, Европын холбооны ESG, Ази-Номхон далайн орнуудын Чибагийн зарчимд нийцүүлэн байгууллагын дүрэм, магадлан итгэмжлэлийн журам, байгууллага, хөтөлбөр, хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага, үнэлгээний аргачлалыг 2016-2018 онд шинэчлэн баталжээ.

Байгууллагын магадлан итгэмжлэл нь тухайн ДБСБ сайн хөтөлбөр хэрэгжүүлэхэд, харин хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь тухайн хөтөлбөр суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд тус тус чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэхийг дэмжин зорьж байна. Дээд боловсрол ба хөдөлмөрийн зах зээлийн нийцийг сайжруулахын тулд цаашид хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг мэргэжлийн салбар чиглэл, боловсролын түвшингээр ялгаатай хийхээр ажиллаж байна.

БМИҮЗ нь АНУ-ын ACBSP, ХБНГУ-ын ASIIN байгууллагатай хамтран олон улсын 50 гаруй шинжээч, мөн үндэсний 300 гаруй шинжээчдийг бэлтгэж, байгууллагын чадавхыг бэхжүүлсэн тул Ази-Номхон далайн бүсийн APQR-т бүртгүүлэхээр өөрийн үнэлгээний тайлангаа хүргүүлж, хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээр бэлтгэж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа, элсэлт, төгсөлт, шилжилт хөдөлгөөн, диплом олголт, бүртгэл мэдээллийг нэгдсэн системд оруулж, удирдлагын шийдвэр гаргах, мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод байлгах нөхцөлийг хангах зорилгоор “Дээд боловсролын удирдлагын мэдээллийн систем”-ийг хөгжүүлж байна.

### **Дээд боловсролын стандарт, хөтөлбөр**

1990 оноос хойш Монгол Улсын дээд боловсролын хөгжлийн байдлыг тоймлон авч үзвэл, олон улсын чиг хандлагын дагуу тооны өсөлтөөс агуулгад, агуулгаас чанарт, чанарын сайжруулалтаас баталгаажуулалт руу чиглэн хөгжиж ирсэн байна. 1995 онд батлагдсан Боловсролын тухай багц хуулиар боловсролыг “*тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана*” гэж заасан ба дээд боловсролын агуулгыг бакалавр, магистр, докторын шатлал бүхий кредит цагт суурилсан зохион байгуулалтад шилжүүлж, “Боловсролын агуулгыг хуулиар тодорхойлж, стандартаар нарийвчлан тогтооно. Боловсролын стандарт нь суралцагчид зайлшгүй эзэмшсэн байх агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын байгууллагад тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно” хэмээн тусгасан. Эдгээр нь тухайн үеийн дэлхий нийтийн боловсролын хөгжлийн чиг хандлага, ялангуяа, Болонийн үйл явцад нийцсэн шинэчлэл байлаа.

1998 оны Боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтөд боловсролын зорилгыг “*иргэнд эрүүл чийрэг бие бялдар, оюуны зохих чадавхтай, хуулийг дээдлэн сахидар, хүмүүнлэг, ёс суртахуун, гоо зүйн мэдрэмж, таашаал олж, бие даан сурч, амьдрах чадвартай болоход нь үйлчлэх*” гэж тодорхойлсон юм. Мөн ЗГ-ын хөтөлбөрт “*Сургалтын агуулга, арга зүйг академик шинжээс онол, практик хосолсон сургалтын шинэ шинж, төлөвт шилжүүлж, шавь төвтэй сургалтыг дэмжинэ*” гэж дэлгэрүүлэн оруулжээ. Үүний дагуу Гэгээрлийн Сайдын 1998 оны 255 дугаар тушаалаар “*Дээд боловсролын зэрэг олгох сургалтад кредит цагийг хэрэглэх, суралцагчдын мэдлэг, чадварыг дүгнэх журам*”-ыг баталж, их дээд сургуулиуд хэрэглэж эхэлсэн нь ДБСБ-ын байгууллагуудын үйл ажиллагаанд хийгдсэн том шинэчлэл байв. Ингэснээр сургалтыг блок байдлаар, хэсэгчилсэн, мөн оюутны бие даан ажиллах ба танхимын хичээлийг нарийвчлан тооцсон америк стандартад нийцсэн сургалтын систем руу шилжиж эхэлжээ (Батчимэг.Н, Тамир.Ч, 2013). Үүнээс үзэхэд суралцахуйн үр дүнд суурилсан, суралцагч төвтэй боловсролын үзэл баримтлалыг 1998 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

Боловсролын тухай хуулийн (2002) хуулийн 7.2, 11.1, 11.2, 11.3, 11.4 дүгээр заалт, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай (2003) хуулийн 6 дугаар зүйлд боловсролын үндэсний стандартын зорилго, түүнийг боловсруулах, мөрдүүлэхэд хамаарах зохицуулалтыг тусгасан байна. Тухайлбал,



Дээд боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтөд “*ям бүх шатны боловсролын стандарт, норм, норматив боловсруулах, дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг тогтооно*” гэж заасны дагуу 2002 онд БСШУЯ-наас “Бакалаврын боловсролын стандартын үлгэрчилсэн загвар”-ыг баталж, улмаар 2006 онд уг загварт өөрчлөлт оруулсан байна. Үүний дагуу 2003-2013 онд 130 мэргэжлээр дээд боловсролын стандартыг баталж мөрджээ. Эдгээр стандартуудад төгсөгчдийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон нь өнөөдрийн “суралцахуйн хүрээ”, “суралцахуйн үр дүн” гэдэг ойлголтын үндэс суурь болсон ажүү.

Эдгээр стандартын эхний төслийг мэргэжлийн багш нар санаачлан бэлтгэж, яамны ажилтнуудын төлөөлөлтэй боловсролын салбарын стандартын техникийн хороогоор хэлэлцүүлж, Стандартчиллын үндэсний зөвлөлөөр батлуулдаг ба батлагдсан стандартуудаас зөвхөн 2 нь шинэчлэгдэж байсан байна. Сургалтын хөтөлбөрийг удаан хугацаанд өөрчлөлгүй мөрдөх стандарт болгосон нь үргэлж өөрчлөгдөж байгаа эрэлт хэрэгцээнд шуурхай нийцүүлэн хөтөлбөрийг сайжруулах боломжийг хязгаарлаж байсан тул нэг талаас нийгмийн болон хувь хүний эрэлт хэрэгцээг хангах илүү уян хатан тогтолцоог бий болгох нөгөө талаас, боловсрол эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор 2014 онд БСШУЯ-наас “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”, “Магистр, докторын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг тус тус баталжээ. ДБСБ-ууд академик байдлынхаа хүрээнд төгсөгчдийн ур чадвар, хичээлийн агуулгыг суралцахуйн хүрэх үр дүнгээр тодорхойлж, хөтөлбөрөө дээрх нийтлэг шаардлагуудын дагуу боловсруулан баталгаажуулж, хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэ нь сургалтын чанарыг үнэлэх, сайжруулах, баталгаажуулах үйл явцыг ч мөн өөрчлөн шинэчлэхэд хүргэжээ. Гэвч өөрчлөлт шинэчлэлийг хэрэгжүүлэх багш, удирдлагууд, бусад оролцогч талуудыг чадавхжуулах системтэй үйл ажиллагаа явуулаагүйн улмаас шинэчлэл нь сургууль бүрд харилцан адилгүй хэрэгжиж, үр дүнгээ өгөх нь удаашралтай байна. Дээд боловсролын чанарыг хангах чухал хэрэгсэл болох хөтөлбөрийн шинэчлэлийн явц, үр дүнд гүн гүнзгий судалгаа хийж, судалгаанд тулгуурлан ололт амжилтыг баталгаажуулах, алдаа дутагдлыг засах замаар шинэчлэлийг эрчимжүүлэх асуудал тулгамдаж байна.

НҮБ-ын ЮНЕСКО байгууллагаас 2013 онд шинээр баталсан боловсролын олон улсын стандарт ангилал (ISCED)-ын дагуу БСШУ-ны Сайдын 2010 оны 235 тоот тушаалаар мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн боловсруулж баталсан бөгөөд 2014 оны А/78 дугаар тушаалаар бакалаврын хөтөлбөрийн индексийг баталгаажуулсан байна. Энэ дагуу сургуулиудын академик эрх чөлөөг нэмэгдүүлэх үүднээс мэргэжлийн нэрийг БСШУЯ-аас тогтоохгүй, зөвхөн хөтөлбөрийн нэр, индексийг баталж, хянахаар эрхзүйн зохицуулалт хийгдсэн.

Үүнээс өмнө 24 салбарын 417 мэргэжил, нэмэлт хавсралтаар 400 орчим мэргэжил байсныг шинэ тушаалаар 10 чиглэл 181 хөтөлбөрт багцалснаар ДБСБ-ууд хэт олон мэргэжлээр сургалт эрхлэх бус цөөн хөтөлбөрөөр хөрвөх болон насан турш суралцах ур чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд анхаарах болсон байна. Гэвч эдгээр хөтөлбөрийн нэр, индекс нь Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, бэлчээрийн мал ахуй зэрэг үндэсний онцлогт тохирсон эсэхэд үнэлгээ хийж, шинэчлэх шаардлагатай байгааг ДБСБ-ууд санал болгож байгааг анхаарч үзэх шаардлагатай. Тухайн нэг хөтөлбөрөөр суралцсан төгсөгч нь ямар ямар ажлын байранд ажиллах боломжтойг өөрөөр хэлбэл, мэргэжлийн нэрийг заасан тодорхойлолтыг хийж, дипломын нэмэлт хавсралт өгдөг Europass Diploma Supplement Европын жишээг ашиглан хөтөлбөрийн болон төгсөгчийн чанар, нийцийг сайжруулах боломжтой юм.

Дээрх журмууд хэрэгжсэнээр ДБСБ-ууд Хөтөлбөрийн хороо байгуулан боловсролын тухайн зэргийн тодорхой индекс бүхий хөтөлбөрүд, тэдгээрийг хэрэгжүүлэх хичээлийн хөтөлбөрөө боловсруулах, батлах, шинэчлэх талаар бие даасан шийдвэр гаргаж, үр дүнд суурилсан боловсролын тогтолцоо руу шилжих алхам хийгдэж байна.

“Үр дүнд суурилсан боловсрол үндэсний хөтөлбөрийн төслийн нөхцөл байдлын шинжилгээнд (Эрдэнэхүү Н, 2018) бодлогын дараах 5 баримт бичигт тусгасан дээд боловсролын сургалттай холбоотой зорилго, зорилтууд, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээнүүдийн уялдаа, залгамж холбоо, ач холбогдлыг дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

- 2009 онд Монгол Улсын боловсролын салбарыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг ЗГ-ын үйл ажиллагаатай уялдуулан шинэчлэхдээ “олон улсын стандартад нийцсэн дээд боловсролын системийг бий болгох”, “Монгол Улсыг мэдлэгт суурилсан эдийн засагт шилжүүлэх” гэсэн зорилгууд дэвшүүлсэн нь дэлхий нийтийн дээд боловсролын чиг хандлагатай нийцсэн чухал зорилгууд байсан байна.

- 2010 онд гарсан “Боловсрол” үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн 6 зорилтын хүрээнд дээд боловсролтой холбоотой олон үйл ажиллагааг төлөвлөсөн бөгөөд сургалтын хөтөлбөрийг олон улсын жишиг хүргэн боловсронгуй болгох, суралцагчдад эх оронч үзэл, хандлага төлөвшүүлэх, багш бэлтгэдэг сургуулиудын сургалтын чанар, орчныг сайжруулах, дээд боловсролд чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх, багш нарын заах арга зүйн чадварыг дээшлүүлэх, нээлттэй, онлайн сургалтын тогтолцоог нэвтрүүлэх, магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох зэрэг сургалттай холбоотой үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлж иржээ.
- 2012-2016 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт их, дээд сургуулиудын сургалтын чанарыг дээшлүүлэх, багш бэлтгэдэг сургуулиудад тавих шаардлага, стандартыг өндөржүүлж дэмжлэг үзүүлэх талд түлхүү анхаарч ажиллахаар төлөвлөж байсан байна.
- 2014 онд гарсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр болон “Боловсрол” үндэсний хөтөлбөртэй уялдуулсан бөгөөд сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавих шаардлагатай уялдуулан хөгжүүлэх; дээд боловсролын чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх; суралцагчдад эх оронч үзэл, хандлага төлөвшүүлэх; багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэх зэрэг үйл ажиллагааг гол болгосон байна. Энэ бичиг баримтад тэргүүлэх чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын 20-оос доошгүй хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлэх, Монгол Улсын дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэх гэсэн шалгуур үзүүлэлт гаргасан нь 2024 он хүртэл дээд боловсролыг хөгжүүлэх гол чиг баримжаа болж байна.
- 2016-2020 оны ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрт мөн нь дээрх “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлоготой уялдуулан дээд боловсролын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх чиглэлд сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлэх, дээд боловсролын салбарын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх, дээд боловсролын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд үе шаттайгаар хамруулахад дэмжлэг үзүүлэх зэрэг зорилт, үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

МУ-ын ЗГ-аас 2006 онд Боловсролын салбарын мастер төлөвлөгөөг шинэчлэхдээ дээд боловсролын салбарт бүтцийн өөрчлөлт хийх замаар чанарын шинэчлэл хийх асуудлыг тусгасан бөгөөд түүнээс хойш 2010 онд баталсан “Боловсрол үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2012-2016, 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд “... сургалт судалгаа үйлдвэрлэл хосолсон, зах зээлд эрэлт хэрэгцээтэй боловсон хүчин бэлтгэдэг сургалтын системд шилжүүлэх, сургалтын стандарт, хөтөлбөрийг боловсронгуй болгох...” гэсэнтэй адил агуулга бүхий заалтууд тусгагдан тодорхой ажлууд хийгдсэн байна. Тухайлбал: Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд чанартай, сайн менежмент бүхий тэгш хүртээмжтэй дээд боловсролын тогтолцоог Монгол улсад бий болгох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд мэдрэмжтэй, дэлхийд өрсөлдөх чадвартай Монголын ДБСБ-ын төгсөгчдийн тоог нэмэгдүүлэх үндсэн зорилготойгоор 2012-2019 онд хэрэгжиж буй “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн хүрээнд сургалтын хөтөлбөрийн чанар нийцийг сайжруулах чиглэлээр дараах ажлууд хийгджээ. Үүнд:

- Магадлан итгэмжлэлийг олон улсын жишигт нийцүүлэх
- Хөтөлбөр/кирикулумыг хөгжүүлэх
- Инженер технологийн хөтөлбөрт CDIO стандарт нэвтрүүлэх
- Сургалтын орчныг сайжруулах
- Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх
- Судалгааны чадавхыг бэхжүүлэх
- ДБСБ-ыг интерпренёр сургууль болоход нь дэмжлэг үзүүлэх

Монгол-Япон хоёр орны стратегийн түншлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд 2014-2023 онд хэрэгжих “Инженер, технологийн дээд боловсрол” төсөл хэрэгжиж байна. Монгол улсад өндөр мэдлэг, ур чадвар бүхий инженер, технологийн мэргэжилтэн бэлтгэх, инженерийн боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, багшлах боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, сургалтын орчныг шинэчлэх, чанарыг сайжруулах гол зорилготой энэхүү төслийн хүрээнд “Барилга, хүрээлэн буй орчны инженер”, “Архитектур”, “Механик инженер” бакалаврын

хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхийн зэрэгцээ МУИС, ШУТИС-ийн судалгааны тэргүүлэх 8 чиглэлийн хүрээнд 20 сэдвээр хамтарсан судалгаа хийж байна.


ДБСБ-ууд гадаадын сургуулиудтай хамтарсан 2+2, 3+1 хөтөлбөр хэрэгжүүлэх нь сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа нь өөрсдийн хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлэхэд түлхэц болж байгаагийн зэрэгцээ олон улсад хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлэх зэргээр хөтөлбөрийн чанарыг сайжруулах санаачилгууд нэмэгдэж байна.

Хоёр орны 3Г хоорондын хамтын ажиллагааны хүрээнд 2013 онд Монгол-Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийг байгуулж, Фрайбергийн техникийн их сургууль, Аахены техникийн их сургууль болон бусад их, дээд сургуулиудтай сургалтын хөтөлбөрийг хамтран боловсруулах, мэргэжлийн хичээлийг заах профессор багш нарыг урих, сургалт, судалгааны үйл ажиллагаанд дэмжлэг авах, оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах, үйлдвэрлэлийн дадлага, бакалаврын ажлыг удирдуулах зэргээр өргөн хүрээтэй хамтын ажиллагааг БШУЯ болон Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ), Германы эрдмийн солилцооны алба (DAAD) хамтран хэрэгжүүлж байна. Энэ нь олон улсын жишиг, чанартай хөтөлбөрөөр эх орондоо суралцах боломжийг нээхийн зэрэгцээ хөдөлмөрийн зах зээл дээр нэн шаардлагатай байгаа нарийн мэргэжлүүдээр олон улсын түвшний өндөр ур чадвартай инженерүүдийг бэлтгэхэд чиглэж байна.

**Багш**


Дээд боловсролын чанарын нэг чухал хүчин зүйлс нь хүний нөөц, тэр дундаа чадварлаг багш, оюутны төвлөрөл юм. 2018-2019 онд ДБСБ-уудад нийт 12,633 хүн ажиллаж байгаагийн 62.6 хувь нь эмэгтэйчүүд, нийт ажиллагчдын 8,177 нь (64.7%) төрийн өмчийн ДБСБ-д ажиллаж байна.

Зураг 1.4.13. ДБСБ-д нийт ажиллагчдын тоо/хувь: Өмчийн хэлбэрээр (2014/15-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ


Зураг 1.4.14. ДБСБ-д нийт ажиллагчдын тоо: Байршилаар (2014/15-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

Нийт ажиллагчдын 6,668 нь (52.8%) үндсэн багш байна. Нийт үндсэн багшийн 62.7% нь төрийн өмчийн, 37.1% нь хувийн өмчийн, 0.2% нь гадаадын салбар сургуульд багшилж байна.

Зураг 1.4.15. ДБСБ-ын үндсэн багшийн тоо/хувь: Өмчийн хэлбэрээр (2014/15-2018/19 оны хичээлийн жил)




Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

2018-2019 оны хичээлийн жилд ажиллаж байгаа нийт үндсэн багшийн 2,033 нь (30.5%) докторын зэрэгтэй, 4,236 нь (63.5%) магистрын зэрэгтэй байна. Цагийн багш 1,282 байна. Нийт үндсэн багшийн 7.0 хувь нь дадлагажигч багш, 41.9 хувь нь багш, 29.0 хувь нь ахлах багш, 12.4 хувь нь дэд профессор, 9.6 хувь нь профессор багш байна.

Насны хувьд нийт үндсэн багшийн 18.0 хувь нь 30 хүртэлх насны залуучууд, 14.2 хувь нь 55-аас дээш насны ахмад багш нар бөгөөд тэдгээрээс 435 нь тэтгэврээ тогтоолгоод ажиллаж байна. Улсад ажилласан жилээр нь ангилж үзвэл: 18.1 хувь нь 1-5 жил, 14.7 хувь нь 25-аас дээш жил ажилласан ажлын дадлага туршлагатай хүмүүс байна. Нийт ажиллагсдын 62,6% нь, нийт үндсэн багшийн 60,4% нь эмэгтэй байна.

Дээд боловсролын салбарын багшлах боловсон хүчний хөгжлийг төрөөс зохицуулах, хэрэгжүүлэх механизм өнөө хир төлөвшөөгүй, ДБСБ-ууд өөрсдөө хариуцдаг боловч энэ чиг үүргийг системтэй хэрэгжүүлэх тогтолцоо, бүтэц, нэгж байдаггүй учраас ажлын дадлага туршлагатай багш нарын нөөц нь сургуулийн хөгжлийн гол хүчин зүйл болдог.


Зураг 1.4.16. ДБСБ-ын үндсэн багшийн тоо/хувь: Насны ангиллаар (2014/15-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

2015 оноос хүн ам зүйн төлөвөөс шалтгаалан оюутны тоо буурч байгаа боловч түүнийг дагаад багш нарын тоо буурч багш оюутны харьцаа 24:1 байгаа нь OECD-ийн орнуудын дунджаас хавьгүй өндөр үзүүлэлт юм.

Зураг 1.4.17. ДБСБ-ын багш оюутны тооны харьцаа (2006/07-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

### Санхүүжилт

Дээд боловсролын чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чухал хүчин зүйлсийн нэг нь дээд боловсролын санхүүжилтийн эх үүсвэр, механизм байдаг. Дээд боловсролын тухай хуулийн 12.2-т “Оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор их, дээд сургууль нь өөрийн үндсэн бүтцэд харьяалагдах сургалт-судалгааны бизнес-инкубатор, технологи дамжуулах төвийг дангаар болон үйлдвэрлэлийн кластерын тогтолцоогоор байгуулан ажиллуулж болно” гэсэн заалт 2016 онд шинээр нэмэгдсэн. Мөн “Ажил олгогчдын захиалга, санхүүжилтээр оюутан сургах, сургалт судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих сан, Тэтгэлгийн сан, Эрсдэлийн сан, Хөрөнгө оруулалтын сан, Тусгай зориулалтын сангуудыг ажиллуулах болон гарааны компани байгуулах зэрэг зүйл заалт нэмж оруулсан нь дээд боловсролын байгууллагын санхүүжилтээ олон эх үүсвэртэй болгох

эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болно. Мөн дээд боловсролыг улс төрийн нөлөөнөөс ангид байлгаж, удирдлага, зохион байгуулалт, менежментийг олон нийтийн оролцоонд суурилсан, ардчилсан, хараат бус, нээлттэй зарчимд тулгуурласан байх зохицуулалтыг тусгасан байна.

Иймээс дээд боловсролын санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нэмэгдүүлэхдээ түүний гол хэсэг болох оюутны сургалтын төлбөрийн хэмжээ, төлбөр төлөх арга хэлбэрийг оновчлох шаардлага гардаг. Энэ нь суралцагч бүрийн боловсрол эзэмших тусгай хэрэгцээ, үл алагчилагдах байдлыг хангах зорилттой шууд холбогддог. Тэгээд ч ТХЗ-2030-ын 4.3-т “2030 он гэхэд бүх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд боломжийн үнэтэй (affordable) чанартай (quality) техникийн болон мэргэжлийн, түүнчлэн их сургуулийн боловсролыг багтаасан гурав дахь шатны боловсролыг адил тэгш хүртэх (equal access) нөхцөлийг хангах” гэсэн товлосон зорилт дэвшүүлсэн байна.

*Шигтгээ 1.4.1. ТХЗ-4.3-ыг хангах арга замын нэгэн хувилбар*

- Хяналт-шинжилгээнд шинэ алхам хийх: тэгш боломжийг хангах үндэсний байгууллагыг бий болгох
- Элсэлтийн шалгууруудыг хувилбаруудтай болгох: Элсэлтийн ялгаатай шалгуурууд ашиглах, үйл ажиллагааг баталгаажуулах бодлого баримтлах
- Товлосон зорилтоо хараандаа байлгах: хамгийн их хэрэгцээтэй хүмүүс энэ тусламжийг авч байгаа гэдэгт итгэлтэй байх
- Оюутанд янз бүрийн тусламж дэмжлэг үзүүлэх: Оюутанд дэмжлэг, туслалцаа үзүүлдэг байгууллагыг бий болгох
- Оюутны зээлийн эргэн төлөлтийн хэмжээг 15% хүртэл хязгаарлах: Эргэн төлөлтийн хязгаарыг тэдний сарынх нь орлогын 15% хүртэл бууруулах

*Michaela Martin, IIEP-UNESCO, 2018*

Монгол Улсад дээд боловсролын байгууллагын санхүүжилтийн гол эх үүсвэрийг Боловсролын зээлийн сангаас олгодог тэтгэлэг, зээл, сургалтын төлбөр, бусад эх үүсвэрээс бүрдүүлдэг. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын орлогын 70-85 хувийг сургалтын төлбөр, 30-15 хүртэл хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж байна. Төрөөс авах тогтмол зардлын санхүүжилт 5-6% эзэлж байна. Төрийн бус өмчийн ДБСБ-уудын орлогын 96%-ийг үндсэн үйл ажиллагаанаас, үлдсэн хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

“Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд дээд боловсролын чанар, нийцийн талаар дараах товлосон зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- Инженер, технологи, байгалийн шинжлэл, багш, хөдөө аж ахуй, анагаах ухааны мэргэжлийн чиглэлээр суралцах 4 оюутан тутмын 3-т нь, бусад мэргэжлийн чиглэлээр суралцах 4 оюутны 1-д нь төрийн сургалтын сангаас сургалтын төлбөрийн зээл олгох бодлогыг баримтална
- Дээд боловсролын багш нарын дотоодод мэргэжил дээшлүүлэх зардлыг жилд 8 хувиар нэмэгдүүлнэ. Жил бүр 100 багшийн мэргэжлийг гадаад дээшлүүлнэ.
- Дээд боловсролын хөрөнгө оруулалтын зардлыг жилд 8 хувиар нэмэгдүүлнэ.

Гэвч төрөөс дээд боловсролд зарцуулах зардал сүүлийн 4 жилийн байдлаар жигд бус өсөлттэй ялангуяа, 2017 онд бууралттай байв (Хүснэгт 1.4.6). 2015 онтой харьцуулахад 2018 онд энэ зардал 35% өссөн байна. 2007 онд дээд боловсролын салбарт зарцуулах хувь 10% байснаас үзэхэд энэ үзүүлэлт сүүлийн 10 гаруй жил тогтвортой байжээ.

*Хүснэгт 1.4.6. Төрөөс боловсролын салбар болон дээд боловсролд зарцуулсан зардал (2015-2018)*

	2015	2016	2017	2018
Боловсролын салбарт (тэрбум төгрөг)	978,5	1147,6	1112,2	1305,8
Дээд боловсролын салбарт (сая төгрөг)	88,6	158,1	95,3	123,6
Дээд боловсролын салбарт ногдож буй хувь	9,1	13,8	8,6	9,4


*Эх сурвалж: Т.Амаржаргалан “Дээд боловсролын хөгжлийн хандлага, бодлого, чиглэл” илтгэлээс*

Төрийн өмчийн сургалтын байгууллагууд үндсэн үйл ажиллагаанаас нийт орлогын 70-85 хувийг, төрөөс авах тогтмол зардлын санхүүжилт 5-6 хувийг тус тус бүрдүүлж байгаа нь сургалтын их сургуулийн хэмжээнд байгааг харуулж байна. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, инновацийн үйл ажиллагаанаас олох орлого маш бага хувийг эзэлж байгааг өөрчлөх, судалгаанд суурилсан их сургуулийн хөгжлийн бодлого, үзэл баримтлалд тулгуурлан улсын их сургуулиудыг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Төрийн бус өмчийн их, дээд сургуулиудын орлогын 96.0 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу сургалтын төлбөр, үлдсэн хувийг төрийн сан болон төслийн санхүүжилт, дотуур байр, түрээсийн орлого бүрдүүлж байна.

2018-2019 оны хичээлийн жилийн байдлаар бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ төрийн өмчийн сургуульд 2,149.8 мянган, төрийн бус өмчийн сургуульд 2,316.8 мянган төгрөг байна.

Зураг 1.4.18. Бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ (2014/15-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик мэдээ

Сүүлийн 5 жилийн статистикийн мэдээнээс үзэхэд бакалаврын өдрийн сургалтын төлбөрийн жилийн дундаж хэмжээ өмчийн хэлбэрээс үл хамааран жил тутам нэмэгдэж ирсэн байгаа бөгөөд 2018 онд 2014 оныхоос төрийн өмчийн сургуульд 1.4, төрийн бус өмчийн сургуульд 1.5 дахин өссөн байна. Сургалтын төлбөрийн хэмжээ төрийн бус өмчийн сургуульд төрийн өмчийнхөөс арай өндөр байна.

### 1.4.3.3. Инклюзив боловсрол ба, үл алагчлах байдал

Боловсролын тухай хуульд “боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх” зарчмыг тодорхойлсон нь боловсрол инклюзив байх шаардлагыг ерөнхий утгаар хуульчилсан байна. Суралцагч төвтэй сургалтын арга зүйг тууштай хэрэгжүүлэх болсноор сургууль, багшийн зүгээс оюутанд тулгах бус өөрөө сонгох боломжийг нэмэгдүүлж байна. Уламжлалт бус сургалтын хэлбэр ялангуяа, зайн сургалт өргөжиж, онлайн нээлттэй эх ашиглах, бие даан суралцах орчин нөхцөл сайжирч байгаа нь хувь хүний хэрэгцээ, сонирхлыг харгалзах байдлыг улам бүр нэмэгдүүлж байна.

БМИҮЗ-ийн байгууллагын, хөтөлбөрийн, урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуурт багш, суралцагч, бусад оролцогч талуудын эрэлт хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, оролцоог дэмжих тухай олон шалгуур, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үзүүлэх үйлчилгээний талаар тусгай шаардлага тавьсан байдаг байна. Энэ шалгуурыг ДБСБ-ууд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт хийхдээ зайлшгүй харгалзан үзэж, улмаар сайжруулахад нь ач холбогдолтой юм.

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн энэ шалгуурт дээд боловсролын инклюзив ба үл алагчилах байдлыг үнэлэх шаардлагыг ерөнхий байдлаар томьёолсон учраас хэрэгжилт, үр дүнг нарийвчлан, эсвэл гүн гүнзгий үнэлгээ дүгнэлт хийх боломжгүй бөгөөд мэдээлэл тун хомс байна. Юуны өмнө инклюзив боловсролын агуулгыг эрэлт хэрэгцээ ба нийлүүлэлтийн аль аль талаас нь зөв ойлгох, тодорхойлох, суралцагч бүрийн ялгаатай хэрэгцээ сонирхлыг хэрхэн харгалзах талаар зөвлөмж өгөх, эерэг хандлагыг дэмжих зэрэг асуудал тулгамдаж байна. Түүнчлэн инклюзив

боловсрол ба үл алагчилах байдлыг үнэлэх шалгуур индикатор, өгөгдөл, мэдээллийг нарийвчлах шаардлагатай байна.

Дээд боловсрол эзэмших тэгш боломжийг хангахын тулд цаашид суралцагчдын нийгмийн баталгааг хангах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ тэдний тусламж дэмжлэг шаардлагатай байгаа ялгаатай байдлыг тооцож байх нь чухал болж байна.

### Суралцагчдын нийгмийн баталгаа

Сурах хүсэл эрмэлзэлтэй, их дээд сургуульд элсэх болзол хангасан боловч сургалтын төлбөрөө хувиараа төлөх боломжгүй иргэдэд сургалтын төлбөрийн болон санхүүгийн зарим дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй Сургалтын төрийн санг ЗГ-аас 1993 онд байгуулжээ. Төрийн сан нь 2016 он хүртэл дээд боловсролыг төрөөс санхүүжүүлэх тухай 20 гаруй бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах хүрээнд 10 гаруй төрлийн үйлчилгээг (хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж, замын зардал, үндэсний болон урамшууллын тэтгэлэг, гадаад зээл, оюутны хөгжлийн зээл зэрэг...) үзүүлж ирсэн байна (Хүснэгт 1.4.6).

Буцалтгүй тусламжийг бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, эцэг эх нь хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадвараа алдсан, мөн нэг гэр бүлээс 3 оюутан зэрэг суралцаж байгаа тохиолдолд олгодог. 2006-2017 онд давхардсан тоогоор 48516 буюу, нэг хичээлийн жилд 4043 суралцагч буцалтгүй тусламж авч сургалтын төлбөрөө төлжээ.

2006-2011 онд хагас өнчин, малчин өрхийн, гэрээт цэргийн албыг 2 буюу түүнээс дээш жил хаасан, амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой өрхийн бакалавр, магистрын зэргийн суралцагчдад хүүгүй, төгссөний дараа эргэн төлөгдөх хөнгөлөлттэй зээлийг дипломыг нь барьцаалж олгосон байна.

Хүснэгт 1.4.7. Боловсролын зээлийн сангийн зээл, тусламжид хамрагдсан суралцагчдын тоо (2006-2017)

Үзүүлэлт	Хөнгөлөлттэй зээл	Буцалтгүй тусламж	Олимпиад шагнал	Нэн ядуу өрхөөс суралцагчид	Малчин өрхөөс суралцагчид	3 хүүхэд зэрэг суралцагч	Бүгд дүн
2006	8460	2377	139	12156	4808	941	<b>28881</b>
2007	7782	2418	138	11523	4167	897	<b>26925</b>
2008	7048	2424	113	11117	3021	565	<b>24288</b>
2009	7319	2361	173	11242	2757	380	<b>24232</b>
2010	7280	2612	200	11606	2613	236	<b>24547</b>
2011	6013	2416	230	10876	2212	67	<b>21814</b>
2012	3381	3462	0	0	0	0	<b>6843</b>
2013	5849	8840	0	0	0	0	<b>14689</b>
2014	4421	5088	0	0	0	0	<b>9509</b>
2015	1985	5273	0	0	0	0	<b>7258</b>
2016	1830	5415	0	0	0	0	<b>7245</b>
2017	0	5830	0	0	0	0	<b>5830</b>
<b>Нийт</b>	<b>61368</b>	<b>48516</b>	<b>993</b>	<b>68520</b>	<b>19578</b>	<b>3086</b>	<b>202061</b>

МУ-ын ЗГ-ын 2016 оны 111 дүгээр тогтоолоор “Сургалтын төрийн сан” нь “Боловсролын зээлийн сан” болон өөрчлөгдөж зорилтот бүлгийн хэрэглэгчдэд үзүүлдэг үндсэн үйлчилгээ, гадаадад суралцагчдын сургалтын төлбөрийн зээлээс гадна орчин үеийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан, оюутан өөрийгөө хөгжүүлэх, хариуцлагатай суралцахад дэмжлэг үзүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн “Оюутны хөгжлийн зээлийн шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Боловсрол эзэмших тэгш боломжид байршлын ялгаа нөлөөлдөг. Иймд хөдөө орон нутгаас болон холоос суралцагчдад зориулсан оюутны дотуур байраар ихэнх ДБСБ-ууд үйлчилж байна. БСШУСЯ-ны 2018-2019 оны статистик мэдээнээс үзэхэд 12486 оюутан дотуур байранд суухаар хүсэлт гаргаснаас 11435 буюу 91,6% нь өөрийн сургуулийн дотуур байраар хангагдаж, 667 буюу 0,5% нь өөр сургуулийн дотуур байранд орсон байна. Үүнээс 68,6% нь эмэгтэй оюутнууд байна.

### Жендэрийн тэгш байдал

Хэдийгээр жендэрийн тэгш байдлыг дэмжих тусгайлсан бодлого, механизм байхгүй боловч хүйсээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглосон. Гэсэн хэдий ч анхаарал татахуйц нэг асуудал бол боловсролын бүх зэргээр нийт суралцагчдын дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувь

давамгайлах болсон явдал юм. Ялангуяа, магистрантурт суралцагч эмэгтэйчүүдийн эзлэх хувь бакалавр болон докторантурт суралцагчдынхаас илүү өндөр байна.

*Хүснэгт 1.4.8. ДБСБ-д суралцагчдын хүйсийн харьцаа: (2006/07-2018/19 оны хичээлийн жил)*

	Суралцагчид (хүйсээр, хүйсийн индекс)				
	Бүгд	Эмэгтэй суралцагч	Эрэгтэй суралцагч	Хүйсийн ялгааны индекс	Нийт суралцагчийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь
2006-2007	142411	86483	55928	1,55	60,7
2007-2008	150326	91720	58606	1,56	61,0
2008-2009	161111	97796	63315	1,54	60,7
2009-2010	164773	99472	65302	1,52	60,4
2010-2011	170126	101455	68671	1,48	59,6
2011-2012	172798	101557	71241	1,43	58,8
2012-2013	175591	102427	73164	1,40	58,3
2013-2014	174045	101783	72262	1,41	58,5
2014-2015	178,295	102,520	75,775	1.35	57.5
2015-2016	162,626	93,674	68,952	1.36	57.6
2016-2017	157,138	91,526	65,612	1.39	58.2
2017-2018	155,248	90,094	65,154	1.38	58.0
2018-2019	157,625	93,552	64,073	1.46	59.4

2017-2018 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 40.6 хувийг эрэгтэйчүүд, 59.4 хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж, хүйсийн ялгааны индекс 1.46 байна (Хүснэгт 1.4.8). Өөрөөр хэлбэл, 100 эрэгтэй төгсөгчид 146 эмэгтэй төгсөгч ногдож байна.

*Хүснэгт 1.4.9. ДБСБ-ыг төгсөгчдийн тоо: Хүйс, боловсролын зэргээр (2017/18 оны байдлаар)*

	ДИПЛОМЫН ДЭЭД	БАКАЛАВР	МАГИСТР	ДОКТОР
Эрэгтэй	62.2%	40.6%	36.8%	38.2%
Эмэгтэй	37.8%	59.4%	63.2%	61.8%

Хүснэгт 1.4.9-өөс үзэхэд суралцаж буй боловсролын түвшин ахих тусам эмэгтэй оюутны эзлэх хувийн жин өсөж, эрэгтэй оюутных буурч байна.

БСШУСЯ-наас хэрэгжүүлж буй ДБШТ-ийн хүрээнд хийсэн “Дээд боловсролын хууль эрх зүй, бодлогын баримт бичиг дэх жендэрийн дүн шинжилгээ” (2019)-нд бакалаврын сургалтын 188 хөтөлбөрөөс 42% нь эмэгтэй, 27% нь эрэгтэй, 31% нь аль аль нь элсэн суралцдаг хөтөлбөрүүд байна гэжээ.

*Шигтгээ 1.4.2. Жендэрийн тэгш байдлыг хангах арга замын зарим хувилбар*

Үндэсний хэмжээнд даган мөрдөж буй их, дээд сургуульд оюутан элсүүлэх бодлого, холбогдох эрх зүйн актад эрэгтэй, эмэгтэй элсэгчдийг “уламжлалт бус мэргэжил”-ийг сонгуулахтай холбоотой дэмжсэн хийгээд үл дэмжсэн агуулга бүхий тодорхой бодлого зохицуулалт байхгүй байна. Харин тодорхой ДБСБ-ын хувьд үүнд холбогдох бодлого суурьшиж эхэлжээ. Тухайлбал, МГТИС нь инженерчлэл, техник технологийн хөтөлбөрт эмэгтэй элсэгчдийн хувийн жинг дор хаяж 30% байлгах бодлогыг хэрэгжүүлж байна. МУБИС-ийн хувьд байгалийн ухаан, математик, сургуулийн өмнөх болон бага сургуулийн багш хөтөлбөрт оюутан элсүүлэхдээ эрэгтэй элсэгчдийг татах үүднээс сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох бодлогыг хэрэгжүүлж байна.

*“Дээд боловсролын хууль эрх зүй, бодлогын баримт бичиг дэх жендэрийн дүн шинжилгээ” (2019)*


### Байршлын ялгаатай байдал

Жилд дунджаар 30-40 мянган хүүхэд ЕБС төгсөж байгаагаас 40% нь Улаанбаатар хотын, 60% нь хөдөө орон нутгийн төгсөгч байна. Гэвч эдгээр төгсөгчдийн 91% нь Улаанбаатар хот дахь, 9% нь хөдөө орон нутаг дахь их, дээд сургуульд суралцаж байна.

Орон нутагт төрийн өмчийн бие даасан 2 их сургууль, мөн их, дээд сургуулийн салбар 11 сургууль, төрийн бус өмчийн бие даасан 4 дээд сургууль, их, дээд сургуулийн салбар 5 сургууль, нийт 22 сургууль сургалтын ажил эрхэлж, тэдгээрт 13454 оюутан суралцаж, 1584 албан хаагч ажиллаж байна (Р.Нямцэрэн, Р.Нурбек, 2018).



Зураг 1.4.19. Иргэдийн суурьшил ба боловсролын түвшин



Эх сурвалж: (Р.Нямцэрэн, Р.Нурбек, 2018).

Монгол Улсын үндэсний статистикийн хорооны ажиллах хүчний судалгаагаар 2013 онд АХС-д хамрагдсан 16-54 насны иргэдийн суурьшлыг тэдний боловсролоор харьцуулбал, боловсролын түвшний эрс ялгаа харагдаж байгаа бөгөөд нийслэлд амьдарч буй иргэдийн 34% нь бакалавраас дээш боловсролтой бол хөдөөд энэ хувь ердөө 5% байна. Харин хөдөөгийн иргэдийн 62% нь бүрэн дундаас доош боловсролтой байхад нийслэлд энэ тоо 10% байгаа нь (IRIM, 2018) хот хөдөөгийн ялгаа хэт их, улс орны нийгэм, эдийн засаг, хүн ам, бүс нутгийн хөгжлийн бодлого уялдаа холбоогүй байгааг илтгэж байна.

“Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4.7.4.а-д “бүсүүдэд их сургууль, коллежийн салбар, судалгаа, мэдээллийн болон сургалтын төвүүд байгуулахыг дэмжиж тухайн бүс нутгийн хөгжлийн чиглэлтэй уялдсан боловсрол, шинжлэх ухааны шинэ хэв шинж бүхий тогтолцоо бүрдүүлэх” гэж заасан бодлоготой ДБСБ-ын элсэлт, хамран сургалт, хөдөлмөрийн заах зээлийн нийц, төгсөгчийн чанар гэх мэт бодлогууд огт уялдаагүй, тодорхой зохицуулалтгүй байсаар байна.

Байршлын ялгаанаас үл хамааран хөдөө орон нутагт чанартай боловсрол эзэмших тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц бодлого боловсруулж, үүний зэрэгцээ бүс нутаг, орон нутгийн нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулах, хот хөдөөгийн ялгааг багасгах асуудал тулгарч байна.

Боловсролын тухай хуульд “иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангах” зарчмыг тодорхойлсон байдаг.

Үүнтэй холбоотойгоор ДБСБ-ууд нь багш, суралцагчийн ёс зүйн дүрэм болон бусад эрх зүйн актуудад ялгаварлан гадуурхахгүй байх зарчмуудыг тусган хэрэгжүүлдэг.

Шигтгээ 1.4.3. Үл алагчлалыг хангах арга замын зарим хувилбар

**Үүрэг болгосон хэм хэмжээ:**

“... Иргэний харьяалал, яс үндэс, нас, хүйс, шашин шүтлэг, оюуны чадавхи, үзэл бодолбайр суурь, судалгаа эрдэм шинжилгээний чиглэл, хэний шавь болох, нутаг ус, танилтал, гадаад үзэмж, хөрөнгө чинээ, нийгмийн гарал байдал, гэр бүлийн байдал, төгссөн сургууль, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлага зэрэг аливаа шинжээр ялгаварлахгүй тэгш хандах”

“МУИС-ийн багш, ажилтан, суралцагчийн ёс зүйн дүрэм”-ээс

**Үнэт зүйл:**

“МГТИС-ийн бүхий л үйл ажиллагаанд ёс зүйн зарчмыг чанд мөрдөж,нийгэм, соёлын олон янзтай байдлыг дэмжинэ. Ингэхдээ жендэрийн тэгш байдлыг хангаж, оюутан, ажилтнуудыг үндэс угсаа, гарал үүсэл, соёл, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаагаар ялгаварлахгүй.”

“МГТИС-ийн дүрэм”-ээс

#### 1.4.4. Дүгнэлт, Зөвлөмж

##### 1.4.4.1. Шийдвэрлэх асуудлууд:

##### Бодлого, эрх зүйн хүрээнд

###### Магадлан итгэмжлэл, өрсөлдөх чадварын тухайд

1. Олон улсын гэрээ конвенц, хөгжлийн бодлогод нийцүүлэн үндэсний бодлого, төлөвлөлтийг хандивлагчдын санхүүжилт бүхий хөтөлбөр төслийн хүрээнд хийсэн боловч тэдгээрийн хэрэгжилтийг хангах, хянан үнэлэх, сайжруулах PDCA мөчлөгийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс цаг тухайд нь засвар өөрчлөлт хийлгүй орхигдуулж тэдгээрийн хэрэгжилтийг доголдуулахад хүргэх.
2. Бодлогын залгамж, уялдаа, хамаарлыг сайтар тооцоогүйгээс гадна мониторинг, явцын үнэлгээ тогтмол хийгээгүйгээс хэрэгжилт удаашрах, үр дүн хангалтгүй байх, огт хэрэгжихгүй байхад хүрсэн. Үүнтэй холбоотойгоор дэвшүүлсэн зорилтууд нь олон хөтөлбөр, төсөл, дамжин үр дүнгүй үргэлжлэх хандлага нийтлэг ажиглагдаж байна.
3. Бодлого, төлөвлөлт, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн талаарх тайлан мэдээ, үнэлгээ, судалгаа хомс байна. Иймээс өмнөх бодлого, төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийн үр дүнд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, цаашид хэрэгжүүлэх, шийдвэрлэх асуудлуудыг зөв томъёолж, товлосон үр дүнд хүрэхэд чиглэсэн хөтөлбөр, төслүүдийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох
4. Дээд боловсролын тухай хуульд олон удаа өөрчлөлт хийсэн боловч энэ нь улс орны хөгжлийн бодлого, боловсролын хөгжлийн эрэлт хэрэгцээтэй сайн уядахгүй, дээд боловсролын салбарын үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадахгүй байгаад дүн шинжилгээ хийж, судалгаа шинжилгээ, үндэслэлтэйгээр нэмэлт өөрчлөлт оруулахыг зогсоох
5. Дээд боловсролын хуульд орсон өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх арга механизмуудыг тусган холбогдох дүрэм, журмуудыг шинэчлэх

##### Хэрэгжилт, үр дүнгийн тухайд

###### Хүртээмж, оролцоо

1. Инженер технологи, байгалийн шинжлэл, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэндийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд тулгуурлан суралцагчдад төрөөс дэмжлэг үзүүлэх
2. Бусад хөтөлбөрөөс инженер технологи, байгалийн шинжлэл, хөдөө аж ахуйн хөтөлбөрт шилжин суралцах боломж олгох
3. Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн хөдөө, орон нутгийн их сургуулиудыг дэмжиж, тэдний хөтөлбөрийн өрсөлдөх чадварыг сайжруулах
4. Үндэсний хөгжлийн бодлогод нийцүүлэн зарим мэргэжлийн боловсон хүчнийг захиалгаар бэлтгэх
5. Суралцагчдын сурлагын амжилтын ахиц дэвшил, төгсөлтийн хувь, ялангуяа хугацаандаа төгссөн оюутны тоо гэх мэт үзүүлэлтээр статистик мэдээллийг гаргаж, сургууль, хөтөлбөрөө сонгон суралцахад шаардлагатай бодит мэдээллээр үйлчлэх
6. Бакалаврт суралцсан мэргэжлээрээ ахисан түвшинд үргэлжлүүлэн суралцах төдийгүй хоёр дахь мэргэжлээрээ суралцахад дэмжлэг болоход чиглэсэн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
7. ДБСБ-ын багшлах боловсон хүчин, судлаачдын нөөцийг бэлтгэх чиглэлээр магистр, докторын хөтөлбөрт суралцагчдын тоог нэмэгдүүлэх
8. Тэгш хамран сургахад чиглэсэн санхүүгийн тэтгэлэг, авьяас чадвартай оюутныг дэмжих тэтгэлэг, тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг өргөжүүлэх
9. Хөдөө орон нутгийн ДБСБ-д суралцагчдыг дэмжих, сургалтын ээлтэй орчин бүрдүүлэхэд төрөөс дэмжих

###### Чанар, нийц

1. Дээд боловсролын чанарын удирдлагын тогтолцоог салбарын хөгжилд мэдэгдэхүйц үр нөлөөтэй байхаар хөгжүүлэхийн тулд хөтөлбөр, сургууль, салбарын түвшинд гүйцэтгэлийн болон чанарын шалгуур үзүүлэлтэд суурилсан удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлж хөгжүүлэх
2. Дээд боловсролын чанарыг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлэхийн тулд мэргэшлийн үндэсний хүрээг хөгжүүлэх

3. ДБСБ-ын үндэсний болон олон улсад эзлэх байр суурийг дээшлүүлэх зорилгоор бенчмарк, эрэмбэ, чансаа тогтоох зэргээр өрсөлдөх чадварыг дэмжих механизмыг хөгжүүлэх
4. Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг төгсөгчийн мэргэжлийн чиглэл, сургууль, хөтөлбөрөөр нарийвчлан судлах
5. Төгсөгчдийн ур чадварыг дээшлүүлэх богино хугацааны болон зайн сургалтуудыг дэмжих
6. Багшлах боловсон хүчний тоо, чанар, ажлын гүйцэтгэл, үр дүнд мониторинг, үнэлгээ хийх
7. Дээд боловсролын салбарын багш бэлтгэх, хөгжлийн төвийг төрийн өмчийн их сургуулиудыг түшиглэн байгуулах
8. Багшийн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
9. Докторын хөтөлбөрийг магадлан итгэмжилж, чанарыг олон улсын жишигт хүргэх замаар дээд боловсролын салбарын багшлах боловсон хүчний нөөцийг бэлтгэх

Боловсролын тусгай хэрэгцээ ба үл алагчлал

1. Дээд боловсрол дахь инклюзив ба үл алагчлах байдлыг үнэлэх шалгуур, үзүүлэлтийг задлан нарийвчлах, холбогдох өгөгдөл, мэдээллийн сантай болох
2. Хөтөлбөрийн чанар, чанарын дотоод баталгаажуулалтыг дэмжсэн урамшуулал, дэмжлэгийн механизм бүрдүүлэх
3. Өмчийн хэлбэрээс үл хамааран стратегийн тэргүүлэх чиглэлээр өрсөлдөөнт санхүүжилтийн механизм бүрдүүлэх

**Зөвлөмж**

1. Монгол Улсын дээд боловсролын салбарын статистик үзүүлэлтүүдээс харахад дээд боловсролд хамрагдалт сайн байгаа боловч зах зээлийн эрэлтээс давсан нийлүүлэлт хийснээр төгсөгчдийн ажил эрхлэлт муу байна. Улс орны болон орон нутгийн онцлог, хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, эрэлтэд нийцсэн хөтөлбөрөөр сургалт эрхлэх, мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэх шаардлагатай.
2. Дээд боловсрол эзэмших сургалтын уян хатан байдлыг дэмжин, сургалтын нээлттэй эх үүсвэр, онлайн сургалтын хүрээг өргөтгөн суралцагч, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэхэд шаардагдах ур чадвар, хөрвөх чадвар, түүнчлэн насан туршдаа суралцах боломжийг нэмэгдүүлэх зэргээр дээд боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой.
3. Санхүүгийн хомсдолоос үүдэлтэйгээр суралцагчийн тоог нэмэгдүүлэх, элсэгчийн татах зорилгоор олон хөтөлбөрөөр цөөн суралцагч элсүүлэх зэрэг нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлөхөөр барахгүй тухайн ДБСБ-ын тогтвортой үйл ажиллагаанд эрсдэл учруулах байдал байгаа нь суралцагч цөөнтэй, хувийн олон сургуулийн жишээгээр харагдаж байна. Сургалтын төлбөрөөр нийт орлогын дийлэнх хувийг бүрдүүлж байгаа тохиолдолд цөөн суралцагчтай сургууль өрсөлдөөнд шалгаран үлдэх боломж хомс тул олон нийтийн статустайгаар нэгдэн нийлэх чиглэлээр олон улсын сайн туршлагыг ашиглаж болох юм.
4. ДБСБ-ын статус, хэв шинж, ангиллыг оновчтой тогтоох, олон улсын жишигт нийцэхүйц мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн чиглэл, индекс, тавигдах шаардлагыг шинэчлэн мөрдөх, улс орны эдийн засгийн хөгжлийн эрэлт хэрэгцээ, Монгол Улсын өрсөлдөх чадварыг сайжруулах, дэлхий нийтийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулах мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэхэд чиглэсэн чанартай хөтөлбөрүүдийг дэмжих механизм бүрдүүлэх шаардлагатай. Энэ нь боловсролын чанарт нөлөөлдөг ээлтэй засаглал, чадварлаг багш, бүтээлч оюутан, хүрэлцээтэй санхүүжилт гэсэн хүчин зүйлсийг хөгжүүлэхэд чиглэх ёстой.
5. Ажил олгогчийн эрэлт хэрэгцээ, тэднээс авсан судалгаанд тулгуурлан хөтөлбөрийн боловсролын зорилго, суралцахуйн үр дүнг тодорхойлох, түүнд нийцүүлэн агуулга, арга зүйг сонгох, орчин нөхцөл, үнэлгээний аргачлалыг шинэчлэх, үр дүнгээ тасралтгүй хянаж чанарын баталгаажуулалтыг хийдэг ДБСБ-уудын сайн туршлага, соёлыг хэвшүүлэхэд чиглэсэн “Суралцахуйн үр дүнд суурилсан боловсрол” хөтөлбөрөөр дамжуулан дээд боловсролын диплом, бакалавр, магистр, докторын, зайн сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэхэд мэдэгдэхүйц өөрчлөлт хийх шаардлагатай байна.
6. Энд дурдаж буй асуудлуудыг 2006-2018 онд хийсэн олон судалгаа, тайлангуудад удаа дараа тодорхойлж, зорилт болон стратегийг бодлогын баримт бичгүүдэд тусган төлөвлөж ирсэн боловч хэрэгжилт нь хангалтгүй, удаан хугацаанд сунжирч байгаа тул өнгөрсөн жилүүдэд боловсруулж гаргасан хөгжлийн үзэл баримтлал, мастер төлөвлөгөө, стратегийн баримт бичиг, төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр дүнд нь системийн хандлагаар иж бүрэн шинжилгээ хийж, үнэлж, дүгнэх, цаашлаад бодлого, төлөвлөлтийг PDCA мөчлөгөөр хэрэгжүүлэх тогтолцоог салбарын хэмжээнд бүрдүүлэх нь чухал байна.

## 1.5. Насан туршийн боловсрол

### 1.5.1. Өмнөтгөл

1990 оноос эхэлсэн зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеэр үйлдвэр, хөдөө аж ахуй, нийгмийн салбар задран хувьчлагдаж, ажилгүйдэл, сургууль завсардалт, бичиг үсэг үл мэдэх явдал дахин бий болсон нь АББ-ын тогтолцоо үүсэх нийгмийн захиалга болсон билээ. Өөрөөр хэлбэл, өмнөх нийгэмд дангаар үйлчилж байсан албан боловсролын тогтолцоо нь хүн амын өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангахаа больж, илүү уян хатан арга, хэлбэр бүхий АББ-ын үйлчилгээ шаардлагатай болсон. 1992 онд сургууль завсардалтын хувь хамгийн их (8.8 %) түвшинд хүрч байсны гол шалтгаан нь мал хувьчлалын улмаас малчдын хүүхдүүд, тэр дундаа хөвгүүд сургуулиа олноор орхиж байсантай холбоотой юм. Ийнхүү бүх нийтээр бичигтэн болж 1970 онд ЮНЕСКО-гийн шагнал авч байсан монгол оронд бичиг үсэг үл мэдэгчид дахин үүсэж, бүх нийтээр бүрэн бус дунд боловсрол эзэмших зорилт биелэх боломжгүй болсноос үүдэн сургууль завсардагчдад боловсрол олгох, бичиг үсэгт тайлах арга зам нь гагцхүү АББ болсон байна. Энэхүү нөхцөл байдлын улмаас 1991 онд батлагдсан Боловсролын тухай хуульд боловсролыг албан ба албан бус арга замаар эзэмшиж болох тухай заалт анх удаа орж, үүнтэй уялдан 1991 оны 1 дүгээр сард Боловсролын хүрээлэнд “Тасралтгүй боловсролын тогтолцооны онолын үндэслэл боловсруулах” судалгааны хамтлаг байгуулан, улмаар сектор болж өргөжсөн байна (БШУЯ, 1991). 1992 онд Монгол Улсын засгийн газраас ЮНЕСКО-той хамтран “Говийн малчин эмэгтэйчүүдийн сурч боловсрох хэрэгцээг хангах нь” (1992-1997) төслийг хэрэгжүүлж эхэлсэн нь албан бус сургалтын суурийг тавьсан анхны алхам байв.


1997 онд “Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (1997-2004) (ЗГ-ын 116 дугаар тогтоол, 1997) гарсантай уялдуулан Боловсролын хүрээлэнгийн Албан бус боловсролын секторыг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүрэг бүхий бие даасан төв (Албан бус боловсролын төв) болгон зохион байгуулсан (Гэгээрлийн яам, 2007). Мөн ЮНЕСКО-той хамтран “Сурч амьдаръя” төсөл (1997-2001) хэрэгжүүлж, бүх аймгийг хамран радиод түшиглэсэн зайны сургалтаар дамжуулан нийт иргэдэд, тэр тусмаа ажил хөдөлмөр эрхлээгүй, хүүхэд залуучууд, насанд хүрэгчид, эмэгтэйчүүдэд зориулан өрхийн орлого нэмэгдүүлэх, амьдрах ухаанд суралцах, жижиг бизнес эрхлэх зэрэг олон чиглэлээр радиод түшиглэсэн зайны сургалт явуулж, нийт 8000 гаруй өрх, 34000 хүнийг хамруулсан нь ЮНЕСКО-гоос өндөр үнэлэгдсэн байна (UNESCO, 2004).

2002 онд “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр” (2002-2012) батлагдсантай (ЗГ-ын 14 дүгээр тогтоол, 2002) уялдан АББ-ын төвийг өргөтгөн судалгаа хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиг үүрэг бүхий “Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв” (АББЗСҮТ) болгон өөрчилжээ (БШУЯ, 2002). “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр”-ийн үндсэн зорилго нь албан болон албан бус боловсролд зайны сургалтыг нэвтрүүлэх замаар боловсролын хүртээмжийг дээшлүүлэх явдал байв. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 187.12-ын хүрээнд БШУ-ны Сайдын 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/178 тоот тушаалаар “Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв”-ийг “Насан туршийн боловсролын үндэсний төв” (НТБҮТ) болгон өөрчилж (БШУЯ, 2012), БШУ-ны Сайдын 2013 оны А/242 тоот тушаалаар НТБ-ын талаар баримтлах чиглэл, НТБҮТ-ийн дүрэм, бүтэц, захирлын ажлын байрны тодорхойлолтыг тус тус баталсан байна. Ийнхүү боловсролын салбарын нэг хэсэг болох НТБ-ын дэд тогтолцооны хөгжил, замналд хэд хэдэн үе шатыг ялгаж болно (Зураг 1.5.1 ба 1.5.2).

Зураг 1.5.1. НТБ-ын тогтолцооны институтчилалын замнал (1991-2012)


1991	1997	2002	2012
<ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын хүрээлэнгийн дэргэд Албан бус боловсролын сектор</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Гэгээрийн яамны харьяа Албан бус боловсролын төв</li> <li>• Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (1997-2004)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• БШУЯ-ны харьяа Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв</li> <li>• Зайн сургалтын үндэсний хөтөлбөр (2002-2010)</li> <li>• Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр (2004-2012)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• БШУЯ-ны харьяа насан туршийн боловсролын үндэсний төв</li> <li>• Насан туршийн боловсролын талаар баримтлах чиглэл 2013 он</li> </ul>

Зураг 1.5.2. НТБ-ын тогтолцооны хөгжлийн үе шатууд, үйлийн өрнөл



Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Насан туршийн боловсролын сургалт, судалгаа, арга зүйн байгууллага орон нутгийн насан туршийн болон албан бус боловсролын байгууллагыг нэгдсэн удирдлага, бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, энэ чиглэлээр боловсрол олгож байгаа багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааг эрхэлнэ” гэж заасан. Монгол Улсад Насан туршийн боловсролын удирдлагын бүтэц, зохион байгуулалтыг авч үзье (Зураг 1.5.3).

Зураг 1.5.3. Насан туршийн боловсролын удирдлага, зохион байгуулалтын бүтэц (БШУЯ, 2013)




Үндэсний түвшинд НТБ-ын бодлогыг хэрэгжүүлэх байгууллага нь БСШУЯ-ны харьяа НТБҮТ юм. НТБҮТ нь Насан туршийн боловсролын бодлого, шийдвэр боловсруулахад боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах, бодлогын хэрэгжилтийг үндэсний түвшинд зохионбайгуулах, орон нутгийн боловсролын байгууллага, хүний нөөцийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалт-судалгаа, арга зүйн байгууллага юм (Зураг 1.5.3).

Төвийн гүйцэтгэх чиг үүрэг нь НТБ ба сургалтын чиглэлээр бодлого, шийдвэрийн үндэслэлийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, БСШУСЯ-ыг мэдээллээр хангах, онол, арга зүйн судалгаа хийх, зөвлөмж аргачлал, сургалтын материал боловсруулах,

мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллийн сан бүрдүүлэх, үндэсний мэргэжилтнүүдийг сургахад чиглэх ба аймаг нийслэлийн Боловсролын газар, орон нутгийн НТБ-ын төвүүдийг арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг (Зураг 1.5.4).

Зураг 1.5.4.. Насан туршийн боловсролын тогтолцоо



НТБҮТ-д удирдах ажилтан 1, захиргааны ажилтан 2, мэргэжилтэн 8, техникийн ажилтан 2 ажиллаж байна. Тус төв нь радиогийн болон телевизийн дуу, дүрс бичлэгийн тоон системт тоног төхөөрөмжтэй, радио, теле хичээл, бүрэн хэмжээний нэвтрүүлэг, аудио, видео бичлэгийг мэргэжлийн түвшинд бичиж, бэлтгэх техникийн бололцоотой. Мөн бүрэн тоноглогдсон хэвлэлийн бага оврын үйлдвэртэй (FJ56 маркийн хэвлэлийн машинтай) бөгөөд ном, сурах бичиг болон бусад хэвлэмэл бүтээгдэхүүний эхийг бэлтгэн хэвлэх боломжтой байна.

*Аймаг орон нутгийн түвшинд* НТБ-ын асуудлыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга хүлээж байгаа ба түүний тамгын газар, БСГ нь орон нутгийн бодлого, шийдвэрийн үндэслэлийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлын зохион байгуулалт, зохицуулалтыг хариуцаж байна.

Орон нутгийн түвшинд НТБ-ын үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа явуулах, мэдээллээр хангах, орон нутгийн хөгжилд иргэдийг идэвхтэй оролцуулах зорилготой байгууллага нь сум, дүүрэг, аймгийн НТБ-ын төвүүд бөгөөд 2014 он хүртэл “Албан бус боловсролын гэгээрэл төв”, “Гэгээрэл хөгжлийн төв”, “Гэгээрэл төв” зэргээр нэрлэгдэж байжээ. 2019 оны эхний байдлаар үндэсний хэмжээнд НТБ-ын нийт **354** төв ажиллаж байгаагаас бие даасан төв **22** (*Архангай, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Ховд, Хэнтий аймаг, УБ хотын Баянзүрх, Баянгол, Багануур, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг*); ерөнхий боловсролын сургууль түшиглэсэн **төв 332** байна (НТБҮТ, 2019).

НТБ-ын үйлчилгээнд оролцогч бүх түвшний байгууллагуудын үйл ажиллагааны цар хүрээ үндсэн чиг үүргээсээ хамаараад адилгүй боловч бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах, хүн амын боловсролын түвшинг дээшлүүлэх, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлэх, амьдрах ухаанд сургах, ингэснээр ядуурлыг бууруулахад чиглэдэг (Зураг 1.5.5).

Зураг 1.5.5. НТБ-ын байгууллагуудын үндсэн чиг үүрэг



### 1.5.2. Бодлого, Эрх зүй

НТБ-ын салбарын үйл ажиллагаанд нөлөө үзүүлсэн бодлогын баримт бичгүүдийг үндэсний түвшний шийдвэр гаргадаг дараах 3 түвшинд төрөлжүүлэн авч үзлээ. Үүнд:

- 1) УИХ-аар батлагддаг Боловсролын хуулийн холбогдох заалтууд, удаа дараагийн Засгийн газрын мөрийн хөтөлбөрт орсон заалтууд
- 2) Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагддаг Боловсролын салбарын Мастер төлөвлөгөө болон үндэсний хөтөлбөрүүд, үндсэн чиглэл

- 3) Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БСШУЯ)-ын түвшинд батлагддаг холбогдох харилцааг зохицуулах журам, тогтолцоог дэмжих болон үйлчилгээг сайжруулахтай холбогдсон тушаал, заавар орж байна.

**Улсын Их Хурлын түвшинд:**

Боловсролын хуулиуд:

*Хүснэгт 1.5.1. Боловсролын хуулинд орсон өөрчлөлт*

Хугацаа	Орсон өөрчлөлт
1991 он	Боловсролын тухай хуульд анх удаа боловсролыг албан ба албан бус арга замаар эзэмшиж болох тухай заалт орсон нь АББ-ын эрх зүйн үндэс тавигдсан
1995 он	“Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байна” гэсэн тусгай заалт (Боловсролын хууль 1995) нэмэгдсэн.
2002 он	Боловсролын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр “Албан бус боловсрол нь албан боловсролын гадна байгаа хүн амд зохион байгуулалттайгаар боловсролын үйлчилгээг хүргэнэ” гэсэн тодруулга нэмэгдсэн.
2006 он	Боловсролын тухай хуульд АББ-ын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшиж болох тухай (8.2); дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдад төрөөс хувьсах зардал олгох (40.2) талаар нэмэлт заалтууд орсон
2016 он	Боловсролын хуульд (3.1.20) “насан туршийн боловсрол” гэсэн тодорхойлолт, албан бус сургалтаар боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх (5.1.3) тухай нэмсэн
2018 он	5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж олгох тухай хэсэгт АББ-ын багшийг хамруулсан заалт орсон

**Боловсролын салбарын Мастер төлөвлөгөө:**

**1993 он:** Боловсролын суурь судалгаанд АББ-ыг хөгжүүлэх бодлого боловсруулах талаар зөвлөмжилж (БСШУЯ, 1993), Боловсролын салбарын Мастер төлөвлөгөө (1993-2000)-нд: сургуулийн гаднах хүүхэд залууст боловсролын үйлчилгээ үзүүлэх, АББ-ын тогтолцооны эрхэм зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, бүтэц, үүрэг хариуцлагыг тодорхойлж, энэ талаар баримтлах төрийн бодлогын үндсийг боловсруулах, эдгээр арга хэмжээг авах нөөц бололцоог судалж тогтоох шаардлагатай байгааг дурдсан (ЗГ, БСШУЯ, 1994).

**2006 он:** “Боловсролын мастер төлөвлөгөө” (2006-2015)-нд (ЗГ, 2006) “АББ ба насанд хүрэгчдийн боловсрол”-ын асуудлыг бие даасан бүлэг болгон тулгамдсан асуудлыг тодорхойлж, хүртээмж, чанар, менежментийн чиглэлээр дараах зорилтуудыг дэвшүүлжээ. Үүнд:

- Албан бус боловсролын үйлчилгээг хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэх;
- Албан бус боловсролын бүх түвшинд сургалтын орчин, чанарыг сайжруулж, нөөцийн чадавхыг дээшлүүлэх;
- Албан бус, боловсролын салбарын бодлого, стратегийг боловсронгуй болгож, мэдээлэл, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;
- Бичиг үсэгт тайлагдалтын түвшинг 2008 он гэхэд 97.7-99.0 хувьд хүргэх;
- ЕБС-иас завсардсан сурагчдын 40.0 хувьд албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгох;
- Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв, сум, дүүргийн албан бус боловсролын төвийн санхүүжилтийг жил тутам 8.0 хувиар өсгөх;
- Багшийн мэргэжлийг дээшлүүлэх зардлыг мэргэжил дээшлүүлэх нэгдсэн зардалд тусган, жил бүр санхүүжүүлэх;
- Мэдээлэл, хяналт-шинжилгээний үндэсний систем бий болсон байх;

**Засгийн газрын түвшинд:**

АББ-ын салбарыг дэмжих, өргөжүүлэх, оновчтой бүтэц, менежментийн тогтолцоог бий болгох чиглэлээр Засгийн газрын түвшинд хэд хэдэн үндэсний хөтөлбөр гарсан. Үүнд:

Үндэсний хөтөлбөрүүд (НТБ-той шууд холбогдох):

- **1995 онд** “Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр” (1995-2005)-ийг Засгийн Газрын 19 дүгээр тогтоолоор баталж, суурь боловсрол эзэмших нэг арга зам нь албан бус сургалт болохыг бодлогын хувьд тодорхойлсон



- **1997 онд** “АББ-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (1997-2004) Засгийн газрын 1997 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан нь дэд тогтолцоо бүрдэхэд ихээхэн нөлөө үзүүлсэнтөрөөс баримтлах бодлогын гол баримт бичиг болсон юм. Хөтөлбөрийн эрхэм зорилго нь “Хүн амд хэрэгцээтэй боловсролыг сургуулиас гадуур өөрт нь тохиромжтой хэлбэрээр бололцоотой хугацаандаа тасралтгүй эзэмших тогтолцоо бүрдүүлж, үйлчлүүлэхэд оршино” гэж томъёолсон ба АББ-ыг хөгжүүлэх үндсэн 6 чиглэл (1. Хүн амын бичиг үсгийн боловсролын түвшинг дээшлүүлэх, 2. хүн амын боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх, 3. хүн амд боловсрол нөхөн олгох, 4.хүн амд мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлэх мэргэжлийн чадвар олгох, 5. хүн амыг бүтээлч үйл ажиллагаанд суралцахад нь туслах, 6. хүн амын бие дааж мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд нь туслах) -ийг тодорхойлсон (ЗГ, 1997) нь уг салбарын үйл ажиллагааны үндсэн чиглэл болсоор ирэв.
- **2002 онд** “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр”(2002-2012) батлагдсанаар боловсролын нээлттэй хүртээмжтэй орчин бүрдүүлэх алхмыг тавьсан.
- **2004 онд** “Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр (2004-2012)” (ЗГ-ын 244 дүгээр тогтоол, 2004) батлагдсан нь НҮБ-ын Бичигтэн болох 10 жилийн зорилтыг биелүүлэх үүднээс шат шатны бичиг үсгийн боловсролын дээшлүүлэхэд чиглэгдсэн юм.

Үндэсний хөтөлбөрүүд (НТБ-той дам холбогдох):

НТБ-ын салбарт шууд хамааралтай бус боловч үйлчилгээг өргөжүүлэхэд нөлөө үзүүлсэн үндэсний хөтөлбөр, бодлогын бусад баримт бичиг олон гарсан байна. Жишээ нь: Англи хэлний үндэсний хөтөлбөр (2002-2005), “Бүх нийтийн экологийн боловсрол” үндэсний хөтөлбөр (1998-2005), “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр (2002-2006), Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010) зэрэг 20 орчим хөтөлбөр салбарын хөгжилд үр дүнгээ өгчээ. (Хавсралт 1.5.2)

- Засгийн Газрын удаа дараагийн мөрийн хөтөлбөрт АББ-ын талаар тусгаж ирсэн. Тухайлбал, 2004 оны Засгийн газрын хөтөлбөрт “Мэргэжлийн болон эчнээ, алсын зайн сургалтыг өргөжүүлэх, сургууль завсардсан хүүхэд буюу сургуульд суралцаж чадаагүй насанд хүрэгчдэд боловсрол нөхөн олгохоор ажиллаж буй иргэний нийгмийн санаачилгыг дэмжих, ажил хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ суралцах аливаа хэлбэрийг дэмжинэ” хэмээсэн нь энэ чиглэлийн үйл ажиллагаа, боловсролын үйлчилгээг иргэн, иргэний нийгмийн байгууллагаар цаашид гүйцэтгүүлэх боломжийг нээсэн.
- **2008 оны** “Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д “боловсрол нөхөн олгоход дэмжлэг үзүүлэх; хөвгүүдийн боловсролын түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх; 2010 он гэхэд хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшинг 99.0 хувьд хүргэх” зэрэг тодорхой заалтууд (4.4 дэх заалт) орсон байна.
- **2017 оны** “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2017 оны 46 дугаар тогтоолын 1.4 дэх заалтад “БСШУЯ-ны харьяа НТБҮТ-өөр дамжуулан хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгаа орчинд суурилуулах, зайн сургалтын тоног төхөөрөмж худалдан авах зардал, багшийн цалинг тооцож улсын төсөвт тусгах;” хэмээн тусгасан.

**Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын түвшинд:**

БСШУЯ-ны түвшинд АББ-ын бодлого эрхзүйн зохицуулалт хийхэд чиглэсэн бодлогын баримт бичгүүд олон гарчээ.

- **2003 он:** БСШУ-ны Сайдын 2003 оны 169 дугаар тушаалаар “АББ-ын багшийн ажлын байрны тодорхойлолт”, “АББ-ын Гэгээрлийн төвийн үлгэрчилсэн дүрэм” аймаг, нийслэл, сум, дүүргийн “Гэгээрлийн төвийн үлгэрчилсэн дүрэм”, “Албан бус боловсрол, зайны сургалтын арга зүйчдийн ажлын байрны тодорхойлолт”, “Албан бус боловсрол, зайны сургалтын багшийн ажлын байрны тодорхойлолт”-ыг баталсан нь одоо хүртэл хэрэглэгдэж байна.
- **2007 он:** Боловсролын хуулийн нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх зорилгоор “Бага. Суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтын журам” гарсан (БСШУЯ, 2007)
- **2010 он:** БСШУ-ны Сайдын 556 дугаар тушаалаар хэд хэдэн төрлийн сургалтын хөтөлбөрүүд батлагдсан нь өнөө хүртэл хэрэглэгдэж байна (Хүснэгт 1.5.2).

Хүснэгт 1.5.2. НТБ-ын дэд салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүд

№	Он	Хөтөлбөрийн нэр	Баталгаажилт
1	2005	Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр	БСШУ-ы Сайдын 2005 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 387 тоот тушаалын 1 дүгээр хавсралт
2	2010	Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн сургалтын хөтөлбөр	БСШУ-ы Сайдын 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 556 дугаар тушаалын 2 дугаар хавсралт
3	2010	Холимог бүлгийн сургалтын хөтөлбөр	БСШУ-ы Сайдын 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 556 дугаар тушаалын 3 дугаар хавсралт
4	2010	Албан бус боловсролын амьдрах ухааны сургалтын хөтөлбөр	БСШУ-ы Сайдын 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 556 дугаар тушаалын 4 дүгээр хавсралт
5	2010	Албан бус боловсролын эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр	БСШУ-ы Сайдын 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 556 дугаар тушаалын 5 дугаар хавсралт
6	2010	Албан бус болон насанд хүрэгчдийн боловсролын багш бэлтгэх сургалтын хөтөлбөр	БСШУ-ы Сайдын 2010 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 556 дугаар тушаалын 6 дугаар хавсралт
7	2014	“Насан туршийн боловсрол” сургалтын багц хөтөлбөр	Хөтөлбөрийг үндсэн 5 чиглэлийн хүрээнд боловсруулан Боловсролын хүрээлэнгээс дүгнэлт гаргуулж БШУЯ-нд хүргүүлсэн боловч <b>батлагдаагүй байна.</b>
8	2013	Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөр /2013-2016/	БШУЯ-нд хүргүүлээд байгаа ч <b>батлагдаагүй байна</b>

Дээрх бодлого, стратегийн хэрэгжилт нь тусгайлан боловсруулж мөрдсөн эрх зүйн актуудаар зохицуулагдаж, тодорхой үе шатуудтайгаар явагдаж ирсэн байна (Зураг 1.5.6).

Зураг 1.5.6. НТБ-ын бодлого, стратегийн хэрэгжилтийн үе шатууд



Эдгээр бодлого эрхзүйн зохицуулалтыг ерөнхийд нь авч үзвэл 1) АББ, НТБ-ын тогтолцоо бүрдэх, үйлчилгээний эрхзүйн орчин бүрдүүлэхэд чиглэсэн; 2) АББ, НТБ-ын үйл ажиллагаа, үйлчилгээг бий болгоход чиглэсэн гэсэн 2 төрөлд ангилж болохоор байна (Хавсралт 1.5.2, 1.5.3).

## 1.5.2. Хэрэгжилт, Үр дүн

### 1.5.2.1. Хүртээмж, оролцоо

Үндэсний хэмжээнд НТБ-ын үйлчилгээний хэд хэдэн чиглэлийг ашиглаж байгаа нь 1. Бичиг үсгийн боловсролын сургалт, 2. Дүйцсэн хөтөлбөрийн сургалт, 3 Насан туршийн боловсролын бусад чиглэлүүд болох амьдрах ухааны, гэр бүлийн боловсролын, иргэний боловсролын, ёс суртахуун-төлөвшилийн боловсролын, гоо зүй-мэдрэмжийн боловсрол зэрэг болно.


#### Бичиг үсгийн хөтөлбөр

Бичиг үсгийн сургалтад БСШУ-ны Сайдын 2010 оны 556 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн хөтөлбөр”-ийг мөрддөг. Энэ хөтөлбөрийн зорилго нь : *Бичиг үл мэдэгч* насанд хүрэгчдийг бичиг үсэгт тайлах, ялангуяа үндэстний цөөнхийн бичиг үсэгт тайлагдалтын түвшинг нэмэгдүүлэхэд туслах; *Бичиг үсэг бага мэдэгчдийн* унших, бичих, тооцоолох мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар мэдлэг чадварын түвшинг ахиулах; *Бичиг үсгийн дараах сургалтаар* дамжуулан амьдрах ба аж төрөх ухаанд суралцуулах, ингэснээр өрхийн орлогоо нэмэгдүүлж, амьдралын чанараа дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх; Насанд хүрэгчдийн, ялангуяа алслагдсан нутгийн болон үндэстний цөөнхийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлснээр бүх хүн амыг *функционал бичигтэн* болгох; зэрэг болно.


Аймаг, сум, нийслэл дүүргийн НТБ-ын төвүүдэд зохион байгуулсан бичиг үсгийн сургалтад 1997-2018 онд нийт 174,342 хүн хамрагдсан байна. Суралцагчдын тоо 1997 онд 6895 байснаа 1999 онд 13691 хүрч өссөн нь тухайн үеийн нийгэм, засгийн байдал, АББ-ын талаарх бодлогын эхэн үеийн үр дүн юм. Энэ үед сургууль завсардсан хүүхэд олон тоогоор сургалтад хамрагдаж эхэлснийг гэрчилж байна (Зураг 1.5.7, 1.5.8).

2000 оноос эхлэн бичиг үсгийн сургалтад хамрагдагсдын тоо буурч эхэлсэн боловч “Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр” (2004-2012) хэрэгжих хугацаанд хамрагдалт дахин нэмэгдэж, давхардсан тоогоор нийт 83123 хүнийг танхимын болон танхимын бус хэлбэрээр сургалтад хамруулжээ. Харин уг хөтөлбөр хэрэгжиж дууссанаас хойш бичиг үсгийн сургалтад хамрагдагчдын тоо 10225-аас 3413 болтлоо огцом буурсан ба түүнээс хойш ч жил ирэх тусам буурах хандлагатай байгаа нь сайн үзүүлэлт юм. Учир нь бичиг үсэг үл мэдэгч ба бага мэдэгч хүн амын чадвар сайжирч, сургалтад хамрагдах шаардлага буурч байгаатай холбоотой. Энэ нь 2010 оны “Хүн ам орон сууцны улсын тооллого”-ын дүнгээр манай улсын бичиг үсэг тайлагдалтын түвшин 98,3 хувьд хүрсэн нь АББ-ын салбарын үйлчилгээний үр өгөөж юм.

Зураг 1.5.7. Бичиг үсгийн сургалтад хамрагдсан хүний тоо (1997-2018)




Зураг 1.5.8. Бичиг үсгийн сургалтад хамрагдсан ба тайлагдсан хүний тоо (2007-2018)



Бичиг үсгийн сургалтад хамрагдагчдын насны байдлыг авч үзвэл 15-аас дээш насныхан буюу насанд хүрэгчид голлож байгаа нь нэг талаас, НТБ-ын үйлчилгээний үр дүн нөгөө талаас, сургуулийн хамран сургалт сайжирсаны үр дүн юм (Зураг 1.5.9).

Зураг 1.5.9. Бичиг үсгийн сургалтад хамрагдагчдын насны байдал (2010-2012)




### Дүйцсэн сургалтын хөтөлбөр

“АББ-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (1997)-т сургуулийн гадна буй болон сургууль завсардсан хүүхэд, залууст **боловсрол нөхөн олгох** талаар тусгаснаар дүйцсэн сургалтын хөтөлбөр нь НТБ-ын үйлчилгээний нэг үндсэн хэсэг болсоор ирсэн. Энэхүү хөтөлбөр нь ямар нэгэн шалтгаанаар сургууль завсардсан болон сургуульд огт хамрагдаж байгаагүй хүүхэд, залууст боловсрол эзэмших хоёр дахь боломж олгож, ерөнхий боловсролыг бүх нийтэд хүртээмжтэй болгох, “*бүх нийтээр суурь боловсролыг заавал эзэмших*” тухай Боловсролын хуулийн заалтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Энэ сургалтад албан ба албан бус сургалтын үйл явц, үр дүнг “стандартын шаардлагыг хангасан байх” харьцаагаар дүйцүүлэн боловсруулсан “Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр”-ийг мөрдөж байна. Хөтөлбөрийн агуулга нь суралцагчдад харилцах, эрдэмших, амьдрах, иргэнших арга ухааны цогц чадамжийн төлөвшил бүхий дүйцсэн боловсролыг уян хатан хэлбэрээр эзэмшүүлж байгаа нь хамран сургалтыг нэмэгдүүлэх, суралцагчдын сурах онцлог, хэрэгцээнд үндэслэсэн сургалт зохион байгуулах зэргээр боловсролын чанарын шалгуур үзүүлэлтийг хангаж байна.


Дүйцсэн сургалтын хөтөлбөрт 1997-2018 онд нийт 193,589 хүн хамрагдагдсан байна. (Зураг 1.5.10)

Зураг 1.5.10. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдагчдын тоо (1997-2018)



Дүйцсэн сургалтад хамрагдсан суралцагч тухайн түвшний боловсролын шалгалт өгч гэрчилгээ авах эсэх нь сайн дурын хэрэг боловч сургалтын үр дүнг баталгаажуулах шалгуур болгох үүднээс төгсөлтийн гэрчилгээ авсан эсэхээр хэмжигдэж ирсэн. Гэвч угтаа гэрчилгээ авах нь гол бус түүнд хамрагдан боловсролын түвшингээ ахиулах нь хөтөлбөрийн гол зорилго юм. 2007-2018 оны хоорондох 11 жилийн дотор тус хөтөлбөрт хамрагдсан хүний тоо жилд 8500-13,000 хооронд хэлбэлзэж байсан ба гэрчилгээ авсан хүний тоо нь ойролцоогоор эдгээрийн гуравны нэгтэй тэнцэж байгаа нь чамлахааргүй үзүүлэлт юм (Зураг 1.5.11).

Зураг 1.5.11. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын үр дүн (2007-2017)



### НТБ-ын сургалтын бусад төрлүүд

БШУ-ны Сайдын 2013 оны А/242 тоот тушаалаар НТБ-ын үйлчилгээ үзүүлэх сургалтын агуулгын 5 чиглэл (гэр бүлийн, иргэний, ёс суртахуун төлөвшлийн, амьдрах ухааны, гоо зүй мэдрэмжийн боловсрол) баталсан боловч сургалтын хөтөлбөр нь батлагдаагүй байна. Иймд 2013 оноос өмнө “Амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд эрүүл мэнд, тогтвортой хөгжил, байгаль орчин, өрхийн орлого нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын нөөцийг ашиглаж байна. Дээрх тушаалаар НТБ-ын 5 чиглэлийн агуулгын хүрээг дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

**Гэр бүлийн боловсрол:** Хүн бүр гэр бүлээ төлөвлөх, үр хүүхдийнхээ бие бялдар, сэтгэц, оюун санааг эрүүл энх байлгаж, эрсдэлгүйгээр хөгжүүлэн өсгөх таатай орчин бүрдүүлэх, гэр бүлийн тулгамдсан асуудлыг зохистойгоор шийдвэрлэх, удмын сангаа цэвэр байлгах, төрөл садан, нийгмийн өмнө хүлээсэн гэр бүлийн гишүүнийхээ үүргийг биелүүлэхэд шаардагдах чадвар эзэмшихэд чиглэнэ.

**Иргэний боловсрол:** Хүн бүр үндэсний уламжлалт болон иргэний нийгмийн үнэт зүйлийг тэнцвэртэйгээр хослуулан эзэмшүүлэх, нийгмийн олон талт харилцаанд иргэний хувьд тэгш эрхтэйгээр оролцох, экологи, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд бие дааж болон бусадтай хамтран аж төрөхөд шаардагдах чадвар эзэмшихэд чиглэнэ.


**Ёс суртахуун төлөвшилийн боловсрол:** Хүн бүр өсвөр залуу насандаа амьдралын утга учрыг танин мэдэж, цаашдын зорилгоо зөв тодорхойлох, амьдралынхаа чанарыг дээшлүүлэхийн тулд авьяас чадвараа нээн хөгжүүлэх, мэргэжлээ сонгох, эрүүл мэнд, харилцаа, ёс суртахууны хувьд төлөвших, буруу зуршилд автахгүй байх, нийгэмд эзлэх байр сууриа баттай олоход шаардагдах чадвар эзэмшихэд чиглэнэ.

**Амьдрах ухааны боловсрол:** Хүн бүр амьдралынхаа туршид нийгмийн хөгжлөөс хоцрохгүй байх, бие бялдар, оюун санаа, авьяас чадвараа хөгжүүлэх, эзэмшсэн мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх, дүйцсэн хөтөлбөрийн болон бичиг үсэг, мэргэжлийн боловсрол эзэмших, санхүүгийн нөхцөлөө сайжруулах зорилгоор сургалт, өдөр тутмын үйл ажиллагааны олон арга хэлбэрийг ашиглах чадвар эзэмшихэд чиглэнэ.

**Гоо зүй-мэдрэмжийн боловсрол:** Хүн бүр байгаль нийгмийн зүй зохист хамаарал, түгээмэл гоо сайхныг танин мэдэж, энэхүү төсөөлөл, мэдрэмжээ хүн-байгаль, хүн-нийгмийн харилцаанд зохистойгоор тусган хэрэгжүүлж, аливаа урлагийн бүтээлээр дамжуулан хүний оршихуйн үнэ цэн, сайхныг түгээн дэлгэрүүлэх, хүртэн мэдрэх чадвар эзэмшихэд чиглэнэ.

2007-2018 оны хугацаанд НТБ-ын төвүүдэд нийт 34753 удаагийн сургалтад 1421990 иргэн хамрагдсан байна (Зураг 1.5.12).

Зураг 1.5.12. НТБ-ын сургалт ба хамрагдагчдын тоо<sup>16</sup> (2007-2018)



Эх сурвалж: НТБҮТ, 2018

### НТБ-ын салбарын санхүүжилт

НТБ-ын тогтолцоо хөгжиж ирсэн 20 жилийн санхүүжилтийг авч үзвэл 1997-2003 онд зөвхөн АББ-ын төв (1997-2002 он хүртэлх нэрээр)-д улсын төсвөөс хөрөнгө хуваарилж байсан ба тус төвийн ажилчдын цалин, байрны зардал зэрэгт энэ 6 жилд нийт 857,0 сая төгрөг зарцуулсан байна (Хүснэгт 1.5.4). Харин энэ хугацаанд аймаг, орон нутагт ажиллаж байсан “Гэгээрэл” төв (хуучин нэрээр)-ийн ажиллагчдын цалин ба сургалтын зардлыг ЮНЕСКО-гийн “Сурч амьдаръя” төсөл (1997-2002)-өөс санхүүжүүлж байжээ. БСШУЯ-наас 2003 онд Гэгээрэл төвийн ажиллах журам, АББ-ын багш, захирлын ажлын байрны тодорхойлолт зэрэг эрх зүйн баримт бичгүүд батлагдсанаар улсын төсөвт Гэгээрэл төвийн багш нарын цалин тусгагдах шийдвэр гарч, 2004 оноос санхүүжилт олгогдож эхэлсэн байна. Улмаар 2006 онд Боловсролын тухай хуульд дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдад хувьсах зардал олгох заалт орсноор 2007 оноос эхлэн үндэсний хэмжээнд улсын төсвөөс зарцуулах санхүүжилт нэмэгдсэн байна (Хүснэгт 1.5.3).

<sup>16</sup>2014 оноос хойших мэдээллийг давхардсан тоогоор авав

Хүснэгт 1.5.3. НТБ-д зарцуулсан нийт санхүүжилтийн хэмжээ: Эх үүсвэрээр (1997-2017)

Он	Улсын төсөв (сая төг)		ОУБ-ын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт (сая төг)	Нийт (сая төг)
	НТБ-ын орон нутгийн нэгжүүд	НТБ-ын Үндэсний төв		
1997	30.0	-	-	30.0
1998	58.0	-	-	58.0
1999	111.0	-	-	111.0
2000	103.0	-	-	103.0
2001	146.0	-	-	146.0
2002	190.0	-	-	190.0
2003	219.0	-	-	219.0
2004	152.8	21.6	5.5	179.9
2005	306.7	40.9	48.0	395.6
2006	290.7	57.9	80.0	428.6
2007	1,900.9	47.9	83.5	2,032.3
2008	1,301.6	78.0	43.4	1,423.0
2009	1,909.2	70.0	286.1	2,265.3
2010	2,501.4	105.0	236.9	2,843.3
2011	3,365.7	96.6	324.8	3,787.1
2012	3,480.5	124.6	140.6	3,745.7
2013	3,412.1	129.9	108.4	3,650.4
2014	3,777.0	167.6	193.3	4,137.9
2015	3,361.2	146.0	177.4	3,684.6
2016	4,110.8	142.5	467.0	4,720.3
2017	3,393.2	180.3	68.6	3,642.1
Нийт	34,120.8	1,408.8	2,263.5	37,793.1

Эх үүсвэр: НТБҮТ-ийн мэдээлэл, 2018

НТБ-ын салбарын хэмжээнд 2002-2012 оны хооронд нийт 13,145,2 сая төг улсын төсвөөс зарцуулсны ихэнхийг дүйцсэн хөтөлбөрийн хувьсах зардал (9,495,7 сая төг) эзэлж байна (Хүснэгт 1.5.4). Гэвч энэ нь салбарын үйл ажиллагаанд бус, зөвхөн ажиллагчдын цалинд зарцуулагддаг ажээ.


Хүснэгт 1.5.4. Үндэсний түвшинд НТБ-д зарцуулсан хөрөнгө (2002-2012)

Хичээлийн жил	Тухайн жилд зарцуулсан хөрөнгө (сая төгрөгөөр)					
	Улсын төсвөөс				Төсөл хөтөлбөр	Нийт
	ДХ-ийн хувьсах зардал	Бичиг үсгийн	АББ-олгох у/а-ны зардал	АББЗСҮТ- ын зардал		
2002-2003	0	0	52,8	22	8,5	83,3
2004-2005	0	0	52,8	16	24	92,8
2005-2006	0	0	273,75	25	110	408,75
2006-2007	0	0	262,5	25	72	359,5
2007-2008	1, 599,7	53	248,25	479	116,7	2496,65
2008-2009	1, 204,9	0	96,7	75,7	65	1442,3
2009-2010	1, 590,9	0	318,3	51	55	2015,2
2010-2011	2, 118,8	34,6	348	84,5	50	2635,9
2011-2012	2, 981,4	43,1	341,2	90,3	207,6	3663,6
Нийт	9, 495,7	130,7	1, 941,5	868,5	708,8	13, 145,2

Эх үүсвэр: НТБҮТ-ийн мэдээлэл, 2018

Монгол Улсад НТБ-ын тогтолцоог хөгжүүлэхэд 2004 оноос хойш зарцуулсан нийт санхүүжилтийн 81-98 хувийг улсын төсвийн санхүүжилт эзэлж байна (Зураг 1.5.13).

Зураг 1.5.13. НТБ-ын нийт санхүүжилтэд эх үүсвэрүүдийн эзлэх хувь (1997-2017)



НТБҮТ-ийн санхүүжилт нь улсын төсөв ба төсөл хөтөлбөрийн санхүүжилтээс бүрддэг. Улсын төсөв нь байгууллагын тогтмол ба хувьсах зардалд л зарцуулагддаг тул сургалтын материал боловсруулах зэрэг үйл ажиллагааны зардал олгодоггүй. Иймд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, гарын авлага, сурах бичиг, аудио, видео материал боловсруулан хэвлэж, түгээх зэрэг ажлыг олон улсын байгууллагуудын дэмжлэгтэй төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх замаар гүйцэтгэдэг. НТБҮТ-ийн санхүүжилтэд улсын төсвийн эзлэх хувь тасралтгүй өсөж ирсэн байхад олон улсын төсөл хөтөлбөрийн санхүүжилт тогтвортой бус байгаа нь тус төвөөс төсөл боловсруулан ЮНЕСКО, ЮНИСЕФ, НҮБ-ын хүн амын зэрэг байгууллагуудад хүргүүлдэг эсэх, тухайн төсөл батлагддаг эсэхээс шалтгаалдаг тул энэ нь санхүүжилтийн тогтмол эх үүсвэр биш юм (Зураг 1.5.14). Эндээс үзвэл гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй тохиолдолд тус төвийн үйл ажиллагаа доголдох эрсдэлтэй нь харагдаж байна.

Зураг 1.5.14. НТБҮТ ба үндэсний хэмжээн дэх НТБ-ын салбарын санхүүжилтийн харьцуулалт (2004-2017)



Гэсэн хэдий ч НТБ-ын төвөөс олон улсын байгууллагуудтай хамтран 2004 оноос хойш нийт 2,263.9 сая төгрөгийн төсөл хэрэгжүүлсэн бөгөөд ихэнхдээ сургалтын материал боловсруулан түгээх, тус салбарын боловсон хүчнийг чадавхжуулахад зарцуулагдаж ирсэн байна. Үүний дотор лам хүүхдүүдийн сургалт, эмзэг бүлгийн сургалт, сургууль завсардсан малчин хүүхдэд үзүүлэх боловсролын үйлчилгээ зэрэгт зарцуулагдаж ирсэн нь тэгш байдал, үл алагчлалд хувь нэмэр оруулж ирсэн гэх бүрэн үндэстэй. 20 гаруй жилд нийт 30 орчим төсөл хөтөлбөр хэрэгжүүлснээс 4 нь ШУТСан<sup>17</sup>-гаас, бусад нь ЮНЕСКО, НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүн амын сан, ОУХБ, АЙПЕК хөтөлбөр зэрэг НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, үүний дотор ЮНЕСКО-гийн Ази-Номхон далайн бүсийн соёлын төв (ACCU) болон Японы Хүүхдийн ивээх сан, “Дэлхийн зөн”

<sup>17</sup>ШУТС-ийн төслүүд: Насанд хүрэгчдийн боловсролыг дээшлүүлэхэд зайны сургалтыг ашиглах онол, арга зүй (1998-1999), Нээлттэй сургалтын онол, арга зүй (2002), Албан ба АББ-д зайны сургалтыг хэрэглэх туршилт-судалгаа (2003-2004),



ОУБ-ын Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтарсан төслүүд эзэлж байна. 2013 оноос хойш Швейцарын Хөгжлийн Агентлаг, Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр ТХБ-ын үзэл санааг НТБ-ын тогтолцоонд тусгахад чиглэсэн төслүүд хэрэгжжээ. Үндэсний байгууллагын дотроос Монгол банк, Сангийн яамнаас олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлж цуврал гарын авлага гаргаад байна. Үндсэнд нь дүгнэж үзвэл АББ болон НТБ-ын салбарт хүний болон сургалтын нөөц бүрдэхэд дээр дурдсан төсөл хөтөлбөрүүд гол үүргийг гүйцэтгэж иржээ. 1997-2018 оны хугацаанд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг Хавсралт 1.5.8-аас үзнэ үү.

### 1.5.3.2. Чанар, нийц

#### Сургалтын материалын хангамж хүрэлцээ

2000 онд БСШУЯ-наас батлан гаргасан “Бага, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөр”-ийн хүрээнд “Дүйцсэн хөтөлбөрийн суурь боловсрол”-ын 7 багц сурах бичиг (байгалийн ухаан; нийгмийн ухаан; монгол хэл, уран зохиол; гадаад хэл (орос, англи); зураг, техник хөдөлмөр) гаргаж, эхний жилүүдэд хэрэглэж байсан бөгөөд эдгээр нь угтаа ЕБС-ийн агуулгад үндэслэгдсэн байв.

2001-2003 онд “Бага, суурь боловсролын стандарт боловсруулах төсөл”-ийн хүрээнд “Бага, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн стандарт” боловсруулсан нь боловсрол нөхөн олгоход баримтлах норматив баримт бичиг болсон төдийгүй дараа дараачийн алхам хийхэд ихээхэн түлхэц өгсөн байна. АББЗСҮТ-өөс 2007 онд боловсролын стандартын цогц чадамжид тулгуурласан модулан бүтэц бүхий “Дүйцсэн сургалтын хөтөлбөр” боловсруулж, БСШУ-ны Сайдын тушаалаар батлуулан мөрджээ. Уг хөтөлбөрийн хүрээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын 150 орчим модулийг боловсруулан түгээсэн нь нэг төвд дунджаар 1-2 модуль ногдож байна. Энэ нь 15-25 суралцагч 1 модулиар хичээллэнэ гэсэн үг юм. Түүнчлэн сургалтад бусад гарын авлага, ЕБС-ийн сурах бичгийг хослуулан ашигласаар иржээ.

НТБ-ын төвүүд хүн амын боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх сургалтын бусад хөтөлбөрийг суралцагчдын хэрэгцээ, боловсролын түвшин, насны онцлог, сургалтын байгууллага болон орон нутгийн нөөцөд суурилан боловсруулан хэрэглэж байна.

НТБҮТ-өөс боловсруулан гаргасан сургалтын материалын товчоо:

- Онол, арга зүйн чиглэлийн ном, гарын авлага –16
- Судалгааны чиглэлийн гарын авлага – 13
- Бичиг үсгийн болон бичиг үсгийн дараах, зайны сургалтын гарын авлага, ном – 118
- Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын сурах бичиг – 9; Дүйцсэн хөтөлбөрийн сургалтын модуль – 138
- Аудио хичээл (1398 минутын 14 төрлийн, цуврал хичээл), Видео хичээл (944 минутын 39 төрлийн хичээл), Зайны сургалтын теле хичээл (1340 минутын 50 төрлийн хичээл)
- Баримтат кино (7 ш) – 158 мин CD, DVD (Бичиг үсгийн 4 сурах бичиг, бичиг үсгийн дараах 8 гарын авлага, амьдрах ухааны 5 гарын авлага, зайны сургалтын 17 ном, амьдрах ухааны 5 видеог болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтын 123 модуль, эрүүл мэндийн 5 гарын авлага, амьдрах ухааны 6 гарын авлага багтаасан)
- Бичиг үсгийн боловсрол олгох сургалтын хүрээнд бичиг үсгийн анхан, дунд, гүнзгий шатны сурах бичиг (Билгийн нүд 1, 2, 3) болон бичиг үсгийн дараах сургалтын гарын авлага 14 цуврал гарын авлага (Амьдралын хэрэгцээ - Эрүүл хүнс эмнээс чухал - Оюун тэлэхүй - Айлаас эрэхээр авдраа уудал - Та өөртөө хуульч - Эзэн сайтын мал эрүүл - Уур биеийг... - Тахиа шувуу ашигтай даа - Зүймэл эдлэл - Монос дахин цэцэглэнэ - Ноос цагаан алт - Ноосоор урлахуй - Та хүүхдэдээ итгэл хайрлаарай - Таны зоог)

Гэвч эдгээр сургалтын материалууд нь 2006-2007 оны үед гарч тараагдсан тул одоогоор хүрэлцээгүй болсон гэж үзэж болно.

Сургалтын чанар, боловсролын үр дүнг нэмэгдүүлэх нэг гол тулгуур хэрэгсэл нь суралцагч бүр судалж буй хичээл, сэдвийн хүрээнд сурах бичиг, сургалтын гарын авлагатай байх явдал гэж үзвэл НТБ-ын сургалтын чанар хангалтгүй гэж дүгнэж болохоор байна. Нөгөө талаас, суралцагчдын нас, сонирхол хэрэгцээ харилцан адилгүй байдгаас хамааран олон төрөл, хэлбэрийн сурах бичиг, гарын авлага шаардлагатай байдаг. Үүний дагуу багш нар орон нутгийн түвшинд гарын авлага, сургалтын материалыг боловсруулдаг ч техник хэрэгслийн хувьд хангалтгүй, хүний нөөц дутмаг, сургалтын материал бэлтгэх санхүүжилт байхгүйгээс төдийлөн амжилтад хүрэхгүй

байна. Тиймээс энд хөрөнгө санхүүжилтээс гадна багш нарыг чадваржуулах асуудлыг цаашид анхаарах хэрэгтэй байна.

### **Сургалтын орчин**

НТБ-ын төвүүд нь Боловсрол соёлын газар, сумын Засаг даргын Тамгын газар, ерөнхий боловсролын сургуулийн дэргэд ажиллаж байна. 1990-ээд онд сургууль завсардалт, бичиг үсэггүй хүмүүсийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан Гэгээрлийн төвүүд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол нөхөн олгох сургалтыг түлхүү зохион байгуулж байснаас үүдэн тэдгээрийн 87.5 хувь нь ЕБС-ийг түшиглэн байгуулагдсан байна. Сургууль түшиглэсэн төвийн хувьд НТБ-ын багшийг сургуулийн төсвөөс цалинжуулах, ЕБС-ийн нарийн мэргэжлийн багш нарыг дүйцсэн сургалтад татан оролцуулах, сургуулийн анги танхимыг ашиглах, суралцагчдыг сургуулийн орчинд оруулах зэрэг давуу талтай байсан боловч сургуулийн нийгмийн ажилтан эсвэл бага ангийн багшийг НТБ-ын багшийн орон тоонд хавсруулан гүйцэтгүүлж ирсэн нь үйл ажиллагаа тогтмол явагдахгүй, сургалтууд чанаргүй болоход нөлөөлдөг.

Харин Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёлын газрыг түшиглэн байгуулсан төвүүдийн хувьд орон нутаг, байгууллагын удирдлагын зүгээс дэмжлэг авах, үйл ажиллагаа нь насанд хүрэгчдэд илүү чиглэсэн байхаас гадна бусад байгууллагуудтай хамтран ажиллах өргөн боломжтой байдаг. Гэвч боловсрол нөхөн олгох сургалт явуулахад багшийн цалин хөлс, сургалтын орчин, анги танхим зэрэг асуудлыг давхар шийдвэрлэх хэрэгтэй болдог.

Цаашид НТБ-ын төв нь ямар нэгэн байгууллага түшиглэж, тэдний удирдлага дор үйл ажиллагаа зохион байгуулахаас илүүтэйгээр бие даасан хэлбэрээр оршин тогтнож, өөрийн байр, боловсон хүчин, материаллаг бааз, төсөв хөрөнгөтэй болбол түүний зорилго, үйл ажиллагааг бодит утгаар нь хэрэгжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

**Байр танхимын хувьд** авч үзвэл 2018 оны байдлаар үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй НТБ-ын нийт 354 төвөөс өөрийн гэсэн тусдаа байртай төв улсын хэмжээнд 4 (үүнээс Улаанбаатар хотод 3, хөдөө орон нутагт 1) байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм (Хавсралт 1.5.5). Бусад нь харьяа байгууллагын зөвхөн 1 өрөөнд үйл ажиллагаа, сургалтаа зохион байгуулдаг, сургалтын танхим нь дунджаар 10-20 хүний багтаамжтай. Орон нутгийн насан туршийн боловсролын төвүүдийн 4 төв нь өөрийн байртай, бусад нь түрээсийн болон ЕБС, БСУГ-ын байранд үйл ажиллагаа явуулж байна (НТБҮТ, 2018). Үүнээс үзвэл НТБ-ын төвүүд нь олон төрлийн сургалтыг зэрэг явуулах боломжгүйн дээр тэдгээрийн 60 гаруй хувь нь эрүүл ахуйн шаардлага хангаагүй, ширээ сандал нь хүрэлцээгүй, стандартын бус, суралцагчийн бие, насанд тохироогүй байна. Сургалтын танхимын багтаамжийн хувьд дунджаар 20 хүний хүчин чадалтай байгаа нь сумдад буй төвийн хувьд боломжийн гэж болох ч хүн ам ихтэй суурин газарт анги танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлага зайлшгүй тулгарч байгааг харуулж байна.

2018 оны байдлаар 354 төвд зөөврийн компьютер 208, суурин компьютер 239, өнгөт принтер 63, хар принтер 102, зурагт 32, камер 80, видео тоглуулагч 3, проектор 3, оёдлын машин 25 тус тус ашиглаж байгаа бөгөөд нэг төвд ногдох тооны хувьд харилцан адилгүй байгаа нь орон нутгийн удирдлагын дэмжлэг ба ойлголт болон тогтвор сууршилтаас шалтгаалж байна (Хавсралт 1.5.6). Дүйцсэн хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулах журамд танхимын сургалтын үед бүлгийг 15-аас, гэрийн буюу шавь сургалтын үед 10-аас дээш суралцагчтайгаар явуулахаар заасан. Нэг бүлэгт ноогдох суралцагчдын тоо дунджаар хөдөө орон нутагт 15-20, суурин газарт 20-25 байгаа нь ЕБС-тай харьцуулбал НТБ-ын багшийн ажлын ачаалал харьцангуй хялбар мэт санагдаж болох юм. Гэвч боловсролын түвшин, нас, сэтгэхүйгээрээ харилцан адилгүй холимог бүлэг бүрддэг тул багшаас өвөрмөц аргазүй, суралцагч бүрд тохирсон арга барил шаарддаг онцлогтой.

### **НТБ-ын хүний нөөц, багш боловсон хүчин**

НТБ-ын багш нарын боловсролын түвшин ЕБС-д ажилладаг багш нарынхтай ижил байна. 2018 онд гарсан Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын “Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08-д өөрчлөлт оруулах” (ХНХ-ын Сайдын А/179 тушаал, 2018) тушаал ёсоор төрийн үйлчилгээний цалингийн сүлжээнд “Насан туршийн боловсролын багш, нийгмийн ажилтан, менежер, захирал” гэсэн категорид хамрагдсанаар НТБ-ын багшийн нийгмийн асуудалд ахиц гарсан.


НТБ-ын үнэлгээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хүрээнд тухайн түвшний боловсролыг хөтөлбөрийн дагуу судалж, стандартын шаардлага хангасан эсэхээр тухайн

суралцагчийг үнэлж байна. Өөрөөр хэлбэл, бага, суурь, бүрэн дунд боловсролын гэрчилгээ авсан болон анги дэвшиж байгаа суралцагчдын тоо нь сурлагын амжилтын үзүүлэлт болдог. Харин боловсролын ерөнхий түвшнийг дээшлүүлэх чиглэлийн сургалтад хамрагдсан хүмүүсийн сурлагын амжилтыг тухайн суралцагчийн амьдрал, хэрэглээнд гарсан өөрчлөлт, сэтгэл ханамжийн түвшингээр үнэлдэг нь нэлээд хийсвэр байдаг боловч одоогоор үүнээс өөр үнэлгээний тохиромжтой хэлбэрийг сонгож чадаагүй байна. Нөгөө талаас, богино хугацааны сургалтыг урт хугацааны боловсролын тусгай стандарт хангах сургалттай адилтган үнэлэх нь боломжгүй юм.

**1.5.3.3. Инклюзив ба үл алагчлах байдал**

НТБ-ын үйлчилгээг хүртэгсэд буюу хамрах бүлэг нь сургууль завсардсан болон сургуулиас гадна буй хүүхэд, залуус, насанд хүрэгчид, гэрийн ажилтай эмэгтэйчүүд, ажилгүйчүүд, шилжин суурьшигчид, сургуулийн өмнөх насныхан, тэдний эцэг эх, эмзэг бүлгийнхэн, хөгжлийн бэрхшээлтэй сурах боломжоор хомс иргэд юм. Гэвч бодит байдал дээр авч үзвэл бичиг үсэг үл мэдэгчид болон сургууль завсардагчид, түүн дотроо насанд хүрэгчдээс илүү 15-аас доош насны хүүхдүүд суралцагчдын ихэнх хувийг эзэлж байна. Анхан шатны нэгж дээр 1997 оноос хойш явуулж ирсэн сургалтууд, түүнд хамрагдсан хүн амын бүтэц, хэрэгцээний судалгаанд үндэслэн НТБ-ын үйлчилгээнд хамрагдах бүлгийг үндсэн ба тусгай зорилтот хэмээн хоёр янзаар тодорхойлж болно (Зураг 1.5.15.).

Зураг 1.5.15. НТБ-ын хамрах бүлэг



Эдний дотроос бичиг үсэгт тайлагдах, бага, суурь боловсрол эзэмшихийг хүсэгчдийн ихэнх нь 15 хүртэлх насныхан буюу үндсэндээ хүүхдүүд байгаа бол харин тусгай бүлгийнхнийг насанд хүрэгчид голдуу эзэлдэг.


Хүн амын тооллогын мэдээгээр 2000 онд бичиг үсэг үл мэдэгч хүн амын эзлэх хувь 2.2 байсан бол 2010 онд 1.7 болж буурчээ (Хүснэгт 1.5.5).

Хүснэгт 1.5.5. Арав, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин (2000 ба 2010)

	Бичиг үсэггүй	Бичиг үсэгтэй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн ба мэргэжлийн	Тусгай мэргэжлийн дунд	Дээд
2000 он								
Бүгд	2.2	97.8	23.4	25.1	21.0	3.6	7.6	7.6
эрэгтэй			23.8	28.3	19.1	3.9	5.7	7.6
эмэгтэй			23.1	22.1	22.8	3.4	9.4	7.7
2010 он								
Бүгд	1.7	98.3	15.8	17.9	32.0	2.8	5.7	18.3
эрэгтэй			16.6	20.3	32.2	3.1	4.6	15.4
эмэгтэй			15.0	15.6	31.9	2.6	6.9	21.2

Эх сурвалж: National Statistical Office. (2010). Population and housing census 2010. Education and Literacy: Analysis based on the 2010 census. Ulaanbaatar.

Зураг 1.5.16. Арав, түүнээс дээш насны хүн амын тоо: Насны бүлэг, боловсролын түвшингээр (2010)




Эх сурвалж: National Statistical Office. (2010). Population and housing census 2010. Education and Literacy: Analysis based on the 2010 census. Ulaanbaatar.

Хөдөөгийн хүн амд тэр дундаа бүрэн бус дундаас доош боловсролтой хүмүүст зориулсан боловсролын үйлчилгээ үзүүлэхээс гадна орлого нэмэгдүүлэх зэрэг төслөөс санхүүждэг сургалтад эмзэг бүлгийнхэн хамрагдах нь түгээмэл байдаг. АББЗСҮТ-өөс 2012 оноос эхлэн НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр сүм хийдэд шавилан сууж буй лам хүүхдүүдэд тэгш боломж олгох зорилгоор дүйцсэн хөтөлбөрийн сургалт зохион байгуулж эхэлсэн нь 2016 он хүртэл үргэлжилж зохих үр дүнд хүрчээ. Жишээ нь: 2014-2016 онд нийт 558 лам хүүхэд дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдсан байна.

### Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хамрагдалт


Монгол Улсын Их хурлын 2017 оны "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 46-р тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс 2018 оноос эхлэн НТБ-ын төвүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалт явуулж эхлээд байна. НТБҮТ-ийн тайланд дурдсанаар 2018-2019 оны хичээлийн жилд улсын хэмжээнд нийт 7296 суралцагч НТБ-ын сургалтад хамрагдаж байгаагийн 12,8 хувь буюу 933 хөгжлийн бэрхшээлтэй суралцагч байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт суралцагчдын 42,1 хувь буюу 393 нь бага боловсрол, 47,2 хувь буюу 440 нь суурь боловсрол, 10,7 хувь буюу 100 нь бүрэн дунд боловсролын түвшинд суралцаж байна (Зураг 1.5.17)

Зураг 1.5.17. Дүйцсэн сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо: Боловсролын түвшингээр (2017/18-2018/19 оны хичээлийн жил)



Хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэрээр сургах үйл ажиллагааг үндэсний хэмжээнд 8 аймаг, 2 дүүргийн Насан туршийн боловсролын төвүүдэд зохион байгуулж байна. Уг сургалтад нийт 131 хүүхэд хамрагдаж байгаагийн 55 хувь буюу 72 нь эрэгтэй, 45 хувь буюу 59 нь эмэгтэй байна (Зураг 1.5.18).

Зураг 1.5.18. Дүйцсэн сургалтад хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувь: Насны ангиллаар (2018)



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй НТБ-ын багш нарыг чадавхжуулахад НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэг үзүүлж, 2018 оны байдлаар нийт 66 багш сургалтад хамрагджээ.

#### 1.5.4. Дүгнэлт, Зөвлөмж

##### Ололт амжилт

- Анх 1991 онд батлагдсан Боловсролын тухай хуулинд боловсролыг албан ба албан бус арга замаар эзэмшиж болох тухай заалт анх удаа орж эхэлж байсан үетэй харьцуулахад өнөөдөр аль ч насныханд тохирсон, орон зай, цаг хугацаанаас үл хамаарах, уян хатан, нээлттэй, хүртээмжтэй боловсролын үйлчилгээний шинэ хэлбэр өөрийн гэх өнгө төрхөө олж **ХЭН Ч, ХААНА Ч, ХЭЗЭЭ Ч**, ямар ч хэлбэрээр насан туршдаа тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлэхэд чиглэж хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүрчээд байгаа нь сүүлийн 20 гаруй жилийн дотор манай боловсролын салбарт гарсан гарсан томоохон өөрчлөлтийн нэг юм. НТБ-ын бодлогын үр нөлөө, ололт амжилтыг дараах байдлаар дүгнэн үзэж болох юм. Үүнд:
- *НТБ-ын хууль, эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн:* НТБ-ын эрх зүйн орчин хуулийн хүрээнд баталгаажиж, боловсролын тогтолцооны нэг дэд тогтолцоо хэмээн хүлээн зөвшөөрч, нийгмийн ухамсрын түвшинд өөрийн байр сууриа эзлэх боломжийг бий болгожээ. НТБ-ын үйлчилгээний эрхзүйн орчинг бүрдүүлэхэд чиглэсэн 12, үйл ажиллагаа, үйлчилгээг бий болгоход чиглэсэн 23 баримт бичиг гарчээ. Боловсролын тухай хуулийн 1996, 2002, 2006, 2010 оны шинэчилсэн хувилбар болгонд шат дараалсан заалтууд нэмэн орж, бага, суурь, бүрэн дунд боловсролыг дүйцсэн хөтөлбөрөөр эзэмшиж болох тухай, АББ (хуучин нэрээр)-ын суралцагчид нормативт зардлыг төрөөс олгох, АББ-ын хүртээмж, хамралтыг дээшлүүлэхэд сум, багийн засаг дарга, сургуулийн удирдлагын хүлээх үүрэг хариуцлагын талаар тусгагдаж, АББ-ын багш, аргазүйчдийн ажлын байрны тодорхойлолт, Гэгээрэл төвийн үлгэрчилсэн дүрэм, Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн сургалтын хөтөлбөр, түүнийг зохион байгуулах журам зэрэг баримт бичгүүд гарчээ. Боловсролыг хөгжүүлэх Мастер төлөвлөгөө (2006-2015)-нд “Албан бус ба насанд хүрэгчдийн боловсрол” бие даасан бүлэг болон орж, тодорхой зорилтуудыг дэвшүүлжээ. Засгийн газраас Зайны сургалтын үндэсний хөтөлбөр, Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр хэрэгжүүлсэн. НТБ-ын үйлчилгээний хамрах хүрээ өргөн учир бүх нийтийн эрүүл мэндийн, эрх зүйн, Тогтвортой хөгжлийн боловсролын гэхчлэн бусад үндэсний хөтөлбөрүүд ч энэ салбарт хамаатай юм.
- *НТБ-ын бүтэц, үндэсний тогтолцоо бүрэлдэн бий болсон:* Үндэсний, аймгийн ба орон нутгийн гэсэн гурван түвшинг хамарсан бүтэцтэй болов (энэ талаар өмнөтгөл бүлэгт тодорхой дурдсан).
- *Үндэсний болон орон нутгийн түвшинд зохих хэмжээний боловсон хүчин бэлтгэгдэн хүний нөөцийн чадавх дээшлэхэд нөлөөлсөн.* 2018 оны байдлаар НТБ-ын салбарт нийт 630 хүн, үүнээс 23 захирал, 23 сургалтын менежер, 14 нийгмийн ажилтан, 499 багш, 71 туслах ажилтан тус тус ажиллаж байна. 2015 оноос эхлэн МУБИС-д “Багш-Насан туршийн боловсрол” гэсэн анги нээгдэж 6 хүн төгсөж, 2018 оны байдлаар 1-3 курсэд нийт 45 оюутан суралцаж байна. Гэхдээ энэ нь НТБ-ын боловсон хүчинг тусгайлан бэлтгэх тогтолцоо бүрдсэн гэж хараахан үзэж болохгүй бөгөөд одоогоор тус салбарт ажиллаж буй 500-аад багш ихэнх нь давтан бэлтгэх төрөл бүрийн сургалтад хамрагдсан, энэ салбарт олон жил ажиллан зохих туршлага хуримтлуулсан хүмүүс байгаа болно. Ийм боловсон хүчний чадавхыг дээшлүүлэх тогтолцооны эхлэл тавигдсан гэж үзэж болно.
- *Сургалтын агуулга боломжийн хэрээр хэлбэржиж, боловсронгуй болсоор байна:* Тухайлбал, бичиг үсгийн анхан шатны болон бичиг үсгийн дараах сургалтын, дүйцсэн сургалтын

хөтөлбөрөөс эхлээд амьдрах ухааны, эрүүл мэндийн боловсролын, тогтвортой хөгжлийн боловсролын, холимог бүлгийн сургалтын гэх мэт олон хөтөлбөр батлагдсан гарсан нь үүнийг гэрчилнэ. Эдгээр хөтөлбөрүүд нь НТБ-ын төвөөс зохион байгуулж буй сургалтуудыг үлгэрчилсэн удирдамж болж байна.

- *НТБ-ын сургалтын арга зүйн хувьд олон янз боловч ялангуяа 2004 оноос эхэлсэн холимог бүлгийн арга зүй энэ салбарт өвөрмөц хэлбэрээр түгээмэл хэрэглэгдэж байна.* НТБ-ын багш нарт зориулсан холимог бүлгийн арга зүйн гарын авлага, материал олноор гарч, тэдний 60 орчим хувь нь энэ төрлийн сургалтад хамрагдаж эзэмшсэн гэрчилгээ авсан байна.
- *Сургалтын материал, гарын авлагын хангамж дээшлэн, янз бүрийн насны, өөр өөр бүлгийн хэрэгцээнд тохирсон сургалтын материал бэлтгэх бааз суурь бүрдэв.* 2018 оны байдлаар авч үзвэл зөвхөн үндэсний түвшинд гарсан 200-аад нэр төрлийн ном, гарын авлага сургалтын материал НТБ-ын төвүүд дэх сургалтад хэрэглэгдэж байна.
- *Хүн амд НТБ-ын үйлчилгээг ойртуулах, зайны сургалтын эхлэл тавигдаж үр дүнд хүрч, туршлага хуримтлагдсан:* Хэдийгээр интернетэд суурилсан, онлайн сургалт энэ салбарт үгүй хэвээр байгаа ч хэвлэмэлээс гадна аудио, видео болон СД сургалтын материалууд гарч сургалтад хэрэглэгдэж байна.
- *Олон улсын болон үндэсний хэмжээнд иргэд байгууллагын хоорондох хамтын ажиллагаа, түншлэл харьцангуй дээшилсэн.* НТБ-ын салбарт ЮНЕСКО, ЮНИСЕФ, ОУХБ, бусад олон улсын байгууллагууд хамтран ажиллаж байгаагаас гадна үндэсний болон олон улсын ТББ-ууд үйл ажиллагаа явуулж байна.
- *Төрийн болон ТББ-ын үйл ажиллагааг холбох алхмууд хийгдсэн:* НТБ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд НТБҮТ болон орон нутгийн НТБ-ын төвүүдтэй холбоотой ажиллан, үндэсний түвшинд явагддаг боловсон хүчний чадавх бэхжүүлэх сургалтад багш нараа хамруулан, бичиг үсгийн, дүйцсэн сургалтын болон амьдрах ухаан, эрүүл мэндийн албан бус сургалтын материалыг ашиглаж байна.
- *Албан бус замаар суралцах нь боловсрол эзэмших хоёр дахь арга зам болох нь нийгмийн ухамсрын түвшинд хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд хүрсэн.* Өөрөөр хэлбэл, 90 гаруй жилийн турш суралцахуйг зөвхөн анги танхимд суралцах буюу сургууллахуйгаар (schooling) ойлгож ирсэн бол “насанд хүрэгчдийн боловсрол”, “насан туршдаа суралцахуй” зэрэг ойлголт төлөвшихэд АББ (хуучин нэрээр)-ын нөлөө их байв. НТБ-ын тогтолцоо үүссэнээр сургуулийн гаднах болон “орхигдсон бүлгийнхэн”, тухайн насандаа бага, суурь боловсрол эзэмшиж амжаагүй насанд хүрэгчид, ажлын байр, гэр орноосоо хөндийрөхгүйгээр боловсролын ерөнхий түвшингээ дээшлүүлэхийг хүссэн бусад хүмүүст үйлчлэх боловсролын үйлчилгээний шинэ хэлбэр бий боллоо. Иймд боловсролыг зөвхөн сургуулиар олгох бус насанд хүрэгчдэд боломжтой үедээ, өөрт тохирсон боловсролын хэрэгцээгээ хангах нэг арга зам нээгдсэн.
- *Санхүүгийн орчин зохих хэмжээгээр бүрэлдэж эхэлсэн:* Улсын төсвөөс НТБ-ын салбарт зарцуулж буй хөрөнгө хэдийгээр боловсролын зардлын 0.5 хувьд ч хүрэхгүй байгаа боловч олон улсын байгууллагын тусламжаас өөр дэмжлэггүй байсан эхэн үетэй харьцуулахад ихээхэн ахицтай гэж үзэхээр байна. 2003 оноос эхлэн НТБ-ын багшийн цалин олгож эхэлсэн бол 2008 оноос эхлэн НТБ-ын дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдад хувьсах зардлыг хуулиар олгодог болсноос гадна НТБ-ын бусад үйл ажиллагааг дэмжихэд зориулсан төсвийг олгож байна.
- *Мэдээллийн бааз бүрдэх эхлэл тавигдав:* НТБ-ын сургалт, хамрах бүлэгтэй холбоотой тоон мэдээлэл БСШУЯ-ны албан ёсны статистикт 2005 оноос эхлэн тусгагдах болсноос гадна АББЗСҮТ (хуучин нэрээр) дээр хийгдсэн АББ (хуучин нэрээр)-ын мэдээллийн сан яамны нэгдсэн системд шилжих болсон байна.
- *Багш суралцагчдын харилцааны хэлбэрийг шинэ шатанд гаргасан.* Эхэн үедээ төсөөлөгдөхгүй байсан “багшгүйгээр суралцах” зарчим нэвтэрсэн нь тухайн хүн өөрөө өөрийгөө дайчилж бие даан сурах, чухамхүү “сурахад суралцах”, ингэснээр сурч мэдсэнээ амьдрал ахуйдаа хэрэглэх боломжийг олгосон. Нэг үгээр хэлбэл, зах зээлийн шинэ нийгмийн тогтолцоонд өрсөлдөж амьдрах сэдэл тэмүүллийг бий болгосон гэж үзэж болно. Жишээ нь: өрхийн орлогоо нэмэгдүүлэх, жижиг бизнес эрхлэх зэрэг зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохирсон сургалтуудаас гадна эрүүл мэндээ сахин хамгаалах, хууль эрхийн мэдлэгээ дээшлүүлэх замаар боловсролын түвшингээ дээшлүүлэхэд чиглэсэн, амьдрах ухаанд суурилсан хөтөлбөрүүд чухал үүрэг гүйцэтгэж байна

- “Нээлттэй” боловсролын тогтолцоог хөгжүүлэх эхлэл тавигдсан. Аудио, видео хичээлийг албан бус сургалтад хэрэглэж эхэлсэн нь радио, телевизийг зөвхөн мэдээллийн хэрэгсэл мэтээр ойлгож байсан хуучин ойлголтыг өөрчилж, монгол улсад боловсролын телевиз байгуулах үйл ажиллагааны эхлэл болсон. Боловсролын “нээлттэй эх”-ийг бүрдүүлэх суурь тавигдаж, улмаар “нээлттэй их сургууль” байгуулах талаар санал санаачилга гарах боллоо.
- Боловсролын хэрэглээний түвшинг дээшлүүлэхэд нөлөө үзүүлсэн. АББ-ын сургалтын материалууд нь цогц чадамжид суурилсан, чадвар олгоход илүү чиглэсэн, суралцагч хэрэгцээндээ тохируулан сонгон судлах боломжтой болсноор мэдлэг, чадварын хэрэглээний түвшинг нэмэгдүүлж байна. Сургалтын материал, хэрэгслүүдээс суралцагчид өөрсдийн хэрэгцээнд тохирсон агуулга, хувилбарыг сонгон авах боломж нээгдсэнээр дан ганц онолын мэдлэг эзэмших бус, мэдлэгээ амьдрал ахуйдаа хэрэглэх үүд хаалга нээгдсэн.
- Байгууллага, хүмүүс, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. Тухайлбал, сургалтын албан бус хэлбэр болон зайны сургалт эрхлэх нь дан ганц сургууль, боловсролын байгууллагын ажил биш болохыг ухааруулж, мэргэжил олгох, хөдөө аж ахуйн чиглэлээр гэх мэтчилэн тодорхой хүн амын бүлэгт таарч тохирсон төрөл бүрийн сургалт явуулах боломжийг олгож байна.

### Алдаа дутагдал

- НТБ-ын салбарт чамлахааргүй олон бодлого, эрх зүйн акт гарсан ч эдгээрийн хэрэгжилт нь яг газар дээрээ хангалттай бус, орон нутгийн түвшинд хэрэгжих механизм болж чадахгүй байна. Тухайлбал, Засгийн газраас батлан гаргаж буй үндэсний хөтөлбөрүүдэд үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүжилтийн нэг хэсэг нь улсын төсөв байна хэмээн заадаг нь зөвхөн цаасан дээр л үлдэж, хаанаас хэн, хэрхэн зохицуулах менежмент нь өнөөг хүртэл хийгдэхгүй байсаар иржээ.
- НТБ-ын үйл ажиллагаанд орон нутгийн болон сургуулийн удирдлагын үүрэг, оролцоо хангалтгүй байна. Хэдийгээр сургуулийн гадна буй хүүхдийг боловсролын үйлчилгээнд татан оролцуулах, талаар багийн засаг дарга болон сум орон нутгийн удирдлагуудын хүлээх үүрэг хариуцлагын талаар Боловсролын хуульд хэд хэдэн заалт орсон боловч түүнийг дээшлүүлэх хөшүүрэг үгүйлэгдэж байна.
- НТБ-ын үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хоорондох ажлын уялдаа муу, зохицуулах механизм байхгүй байна. Үүнээс болж, НТБ-ын салбарт үйл ажиллагаа явуулж буй ихэнх байгууллагууд зөвхөн завсардсан хүүхэд төдийхнөөр ажлаа хязгаарлаж, эмзэг бүлгийнхнийг бэлэнчлэх сэтгэлгээнд сургаж байна.
- НТБ-ын багшийн үнэлэмж доогуур байгаа нь тус салбарын нэр хүндийг унагаж, хэн дуртай нь хийж болдог, хоёрдогч салбар мэт ойлголт төрүүлж, улмаар багш нарын тогтвор суурьшилд нөлөөлж байна. Жишээ нь: НТБ-ын салбарт ажиллаж буй багш 500-аад багшийн 81,7 хувь 2-5 жил ажилласан бол 15-аас дээш жил ажилласан хүн дөнгөж 12 байгаа нь үүнийг гэрчилж байна. Үүний шалтгаан нь ажлын байр хавсардаг, сумын түвшинд НТБ-ын багшийн цалин тусдаа олгогддоггүйтэй холбоотой.
- НТБ-ын төвд орон нутгийн онцлогт таарсан, суралцагчийн хэрэгцээнд тулгуурласан боловсролын үйлчилгээ муу байгаагаас тус төвүүд нь мэдээлэл түгээдэг, хүмүүст тусалдаг, тасралтгүй боловсролын орчин болж чадахгүй байна.
- Боловсрол нөхөн олгох сургалтын чанар, үр дүн хангалтгүй, сургалтын зохион байгуулалт тааруу байна. Ялангуяа малчдын хүүхдийн хувьд тэр болгон цугларч чаддаггүй, түр хугацаанд суух айл, дотуур байр, хоол зэргийг хэрхэн шийдэх нь тодорхойгүй байгаагаас хүндрэл учирч байна. Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр олгож буй энэхүү сургалт нь тухайн түвшний боловсролыг нөхөн эзэмшихийг хүссэн хэнд ч нээлттэй боловч зөвхөн сургууль завсардсан хүүхдэд зориулсан мэтээр үздэг явцуу ойлголт хэвээрээ, сургалтыг “хоёрдугаар түвшин”-д тавьсан хэвээр байна. Гэтэл хүнээ хөгжүүлж, хүний хөгжилд тулгуурласан нийгэм байгуулъя гэвэл хэдхэн сайныг шилж аваад сургууль багшийн нэр хүндийг өсгөхөөс илүү “орхигдоод” буй тэр хэсгийг анхааралдаа авах нь чухал юм. Үүний нэг жишээ нь: 2017 оны 6 дугаар сарын 4-нд гарсан Засгийн газрын тогтоолоор Хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол нөхөн олгох асуудлыг НТБҮТ-өөр дамжуулан олгоно гэж заасан хэдий ч үүнийг зохион байгуулах,

зохицуулах ямар ч механизм байхгүй, санхүүгийн хувьд хаана ч тусгагдаагүй тул тогтоолын заалт хэрэгжих ямар ч үндэсгүй байна.

- НТБ-ын сургалтын орчин ба сургалтын чанарын талаар баримтлах бодлого үгүйлэгдэж байна.
- Төр засгийн тогтворгүй байдал тус салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, “Насан туршийн боловсрол” сургалтын багц хөтөлбөрийг үндсэн 5 чиглэлийн хүрээнд боловсруулан Боловсролын хүрээлэнгээс дүгнэлт гаргуулж БШУЯ-нд хүргүүлсэн боловч өнөө хүртэл **батлагдаагүй байна.**
- Насан туршийн боловсролын үндэсний хөтөлбөр (2013-2016) БШУЯ-нд хүргүүлээд байгаа ч мөн л **батлагдаагүй байна.**

### Сорилт бэрхшээлд

НТБ-ын салбарын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, менежмент төлөвлөлтийг сайжруулахад чиглэсэн бодлого, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, түүний үр нөлөөг нэгтгэн дүгнэвэл агуулга, хүртээмж, хамрах цар хүрээний хувьд өргөжин тэлж ирсэн хэдий ч зохицуулж чадаагүй болон шийдвэрлэгдээгүй асуудал ч байсаар байна

- НТБ-ын үйлчилгээ нь салбар дамнасан шинж чанарыг агуулдаг тулд сургуулийн өмнөх боловсролоос эхлээд насанд хүрэгчдийн тасралтгүй боловсролын орчинг хамарсан нэгдсэн зохицуулалт, менежмент хийгдэхгүй байсаар өнөөг хүрсэн тулд бодлогын зохицуулалт хийх, институтчлах, өнөөдөр бий болсон тогтолцооны хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай.
- НТБ-ын үйлчилгээний үндсэн хэсэг болох насанд хүрэгчдийн тасралтгүй боловсролыг дэмжсэн бодлого, эрхзүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.
- Санхүүжилтийн хувьд шийдэгдээгүй асуудал олон байна. Ялангуяа аль ч түвшиндээ үйл ажиллагааны зардалд төсөв хуваарилагддаггүй, зөвхөн олон улсын төсөл хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр л хэрэгжин урсгалаар явж ирсэн, дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдын хувьсах зардлаас өөр сургалтыг дэмжих санхүүгийн механизм бүрдээгүй байна. Энэ нь боловсролын салбарт зарцуулж хөрөнгийн дөнгөж 0.5 хүрэхгүй хувь нь НТБ-ын салбарт хуваарилагдаж байгаагаас харагдаж байна.
- НТБ-ын салбарт бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, сум орон нутаг, хариуцаж буй сургуулийн удирдлагын зүгээс үзүүлэх дэмжлэг туйлын хангалтгүй байна. Ингэснээр монгол оронд НТБ-ын тогтолцоо “хоёрдугаар” зэрэгт тавигдаж байгаа нь энэ салбарт ногдож буй санхүүжилт, багш нарынх нь зэрэглэл, цалин хангамж, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнээр хангагдсан байдал зэргээс харж болохоор байна.
- НТБ-ын мэдээллийн тогтолцоо боловсрогдоогүй, мэдээлэл авах аргачлал тодорхой бус байна.
- НТБ-ын салбарын үйл ажиллагаанд зөвхөн бичиг үсгийн болон дүйцсэн хөтөлбөрийн сургалтаас хэтэрч чадахгүй байгаагаас болоод нийт хүн ам, ялангуяа 15 ба түүнээс дээш насны иргэдэд үзүүлэх боловсролын бусад үйлчилгээ орхигдож байна.
- Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэхэд зориулсан сургалтын хүртээмж, зохион байгуулалт хангалтгүй, түүнд зориулсан санхүүжилт тодорхой бус байна. Нөгөө талаар насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролд шийдвэр гаргагчид болон сургууль, орон нутгийн удирдлага бага анхаарч байна. Хүн амын бичиг үсэгт тайлагдалд (97.8 хувь)-ыг аман асуулгад үндэслэсэн 2010 оны тооллогын мэдээг баримталсаар ирсэн нь санаа амирангүй хандах байдлыг үүсгэсэн нэг шалтгаан мөн.
- НТБ-ын үйлчилгээ нь голдуу хот суурин газрын оршин суугчдад чиглэж, алслагдсан газар амьдардаг хөдөөгийн хүн амд хүрч чадахгүй байна. Энэ нь дээр дурдсан менежмент, зохицуулалт муу байгаагийн илрэл юм.
- Албан ба албан бус боловсрол (хуучин нэрээр)-ын үйлчилгээний нийц, уялдаа холбоо хангалттай бус, зөвхөн дүйцсэн хөтөлбөрөөр суралцагчдын амжилт буюу суурь ба бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалт өгөх төдийгөөр л хязгаарлаж, НТБ-ын сургалтын чанарыг үнэлэх тогтолцоо бүрдээгүй байна.
- НТБ-ын үйлчилгээний нэг хэсэг болсон хүн амын амьдралд туслах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх арга замыг заахад чиглэсэн сургалтын материал олон гарсан хэдий ч НТБ-ын төвүүд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүйгээс энэ үйлчилгээг үзүүлэх боломж хомс байна.
- НТБ-ын салбарт онол арга зүйн судалгаа үгүйлэгдэж байна. Тухайлбал, насанд хүрэгчдийн сургалтын онцлогийг судлах, ялангуяа андрологийн чиглэлийн судалгааг өргөжүүлэх, дэмжих механизм бүрэлдээгүй байна.



**Зөвлөмж**

НТБ-ын тогтолцоог сайжруулж, үйл ажиллагааг тогтмолжуулан, хүртээмж, чанарыг дээшлүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай хэмээн үзэж байна. Үүнд:

- НТБ-ын салбарт бодлогын шинэ үе шат шаардлагатай. Энэ нь “Насанд хүрэгчдийн боловсролын тухай хууль” болон “НТБ-ын үндэсний хөтөлбөр” зэргээр тусгайлан боловсруулсан хууль эрх зүйн баримт бичиг байх нь зүйтэй. Ингэснээр насан туршийн боловсролын тогтолцоог шинэ шатанд гаргаж, статусыг тодорхой болгон менежмент болон санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох нөхцөл бүрдэнэ.
- НТБ-ын багшийн ажлын үнэлэмжийг дээшлүүлэхийн тулд тэдний ажлын байрны тодорхойлолтыг дахин шинэчлэх, цалин хангамжийг тодорхой болгон, багшийн хөдөлмөрийн норм тогтоож харьяа дээд газраар батлуулах зэрэг арга хэмжээг авах;
- Бүх шатны удирдлага (багийн засаг дарга болон сум орон нутгийн удирдлагууд)-ын хүлээх үүрэг хариуцлагын талаар Боловсролын хуульд орсон заалтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах, орон нутгийн иргэддээ боловсролын үйлчилгээг үзүүлж буй байдал болон тэдний бичиг үсгийн боловсролын түвшинд гарч буй ахиц зэргийг ажлын үзүүлэлтийн нэг хэсэг болгох арга хэмжээ авах;
- НТБ-ын талаар шийдвэр гаргагчид болон олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг өргөжүүлэхэд БСШУЯ болон холбогдох дээд байгууллагаас зохицуулалт хийх; Тухайлбал, “Боловсрол суваг” болон бусад мэдээллийн хэрэгслүүдээр сурталчлах, орон нутгийн болон сургууль байгууллагын ажлыг дүгнэхдээ харьяа нутаг дэвсгэрт оршин суух хүн ам, иргэдийн дунд зохиосон ажил, тэдний боловсролыг дээшлүүлэхийн тулд авсан арга хэмжээ зэргийг шалгуур үзүүлэлт болгон оруулж байх гэх мэт.
- НТБ-ын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд НТБ-ын түгээлтийн механизмыг сайжруулах, ялангуяа анхан шатны нэгж болох НТБ-ын төвүүд дээр сумын иргэдийн төлөөллөөс бүрдсэн менежментийн баг байгуулах, ажлаа төлөвлөх, дээд удирдлагадаа танилцуулах, дэмжлэг авахад хамтран ажиллах, боломжтой бүх хэлбэрийг ашиглахад арга зүйн туслалцаа үзүүлэх;
- Албан ба АББ (НТБ)-ын хоорондох уялдаа холбоог сайжруулах, сургуулийн анги танхим болон багш нарыг хичээл сургалтын бус үед нь албан бус сургалтын зорилгод ашиглах замаар боловсролын хүртээмжийг дээшлүүлэх, хүн хүч болон материал, санхүүгийн нөөцийг хэмнэхэд чиглэсэн бодлогын зохицуулалт хийх;
- НТБ-ын салбарт үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэхэд чиглэсэн өөр өөр зорилтот бүлгийн хэрэгцээнд тохирсон, ялангуяа насанд хүрэгчдэд зориулсан улс төрийн болон эрх зүйн боловсрол олгох, нийгэмд зөв зан үйл төлөвшүүлэх, эрүүл аж төрөх, бүх нийтийн тогтвортой хөгжлийн боловсрол олгох зэрэг сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, сургалтын материал, хангамжийг нэмэгдүүлэх, үүний тулд улсын төсвөөс зохих хөрөнгө хуваарилан олгодог болох;
- НТБ-ын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд МХХТ-ийг ашиглах, сургалтын материалыг онлайн хэлбэрт шилжүүлж, нээлттэй сургалтын орчин бүрдүүлэх;
- Бичиг үсгийн түвшинг тогтоох шалгуур боловсруулж турших, 2020 оны хүн амын тооллогод тестэд тулгуурласан шалгуураар бичиг үсгийн түвшинг тогтоох талаар холбогдох байгууллагууд арга хэмжээ авах;
- НТБ-ын үйлчилгээг хүртэх хүн амын тоог харгалзан нутаг дэвсгэр бүрд НТБ-ын төвийн тоог ялгавартайгаар тогтоон, тэнд ажиллах багш, фасилитаторын орон тоог батлах. Жишээ нь: нийт хүн амын тоо нь 6000 хүрэхгүй хөдөөгийн сум, 10000-20000 хүн оршин суудаг аймгийн төвийн сум хоёрт байх НТБ-ын төвийн хүчин чадал, тэнд ажиллагсдын тоо адилхан байх үндэсгүй юм. Гэтэл Улаанбаатар хотын нэг дүүрэгт хүн тоо нь 200000-аас дээш байгаа нь НТБ-ын үйлчилгээ хүртэх хүмүүсийн тоо ч бас их байх ёстойг харуулж байна. Иймд НТБ-ын төвийг сумын түвшинд, аймгийн төвийн түвшинд, нийслэл болон бусад томоохон хотын түвшинд гэхчлэн ялгаж, гүйцэтгэх үүрэг, орон тоо, хүчин чадал, үйлчлэх хүрээг гаргасан тодорхой шалгуур боловсруулах;
- Цаг үеийн хэрэгцээ шаардлагын улмаас гарч ирж буй хүмүүс сургуулийн гаднах хэлбэрээр суралцах, боловсролын түвшингээ ахиулах зэрэг шинэ хэрэгцээг хангахын тулд бэлтгэгдсэн боловсон хүчин байх зайлшгүй шаардлага зүй ёсоор урган гарч байна. Иймд НТБ-ын боловсон хүчнийг бэлтгэдэг, давтан сургадаг тогтолцоо бүрдүүлэхийн тулд юуны өмнө багш

- бэлтгэдэг их дээд сургууль коллежийн хичээлийн хөтөлбөрт НТБ-ын асуудлыг тусган оруулах, багш болох оюутнууд тодорхой кредит цаг судлах хөтөлбөр боловсруулах турших;
- НТБ-ын төвүүдийн хүчин чадал, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, сургалтын орчинг дээшлүүлэх (сургалтын материал олшруулах, хэвлэх, видео хичээл үзүүлэхэд шаардагдах компьютер, хувилагч машин болон амьжиргааны ухааны сургалтад шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах) багш нарыг нь чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх бодлого стратеги боловсруулан хэрэгжүүлэх;
  - НТБ-д хөгжингүй улс орнууд ч өндөр ач холбогдол өгч эхэлсний дотор Европын Холбоо (EU) хувь хүнийг хөгжүүлэх, иргэн төлөвшүүлэх, нийгэмд эерэг өөрчлөлтийг авчрах зөв зан үйлийг бий болгож, гишүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд НТБ чухал үүрэгтэй хэмээн үзэж байна (European Union, 2006). НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 62 дугаар чуулганаас баталсан “Дэлхийн эдийн засагт залуус” баримт бичигт ч МХЗ-ыг хэрэгжүүлэхэд АББ-ын ач холбогдлыг дурдаад зогсоогүй гишүүн орнуудыг тус салбарт зориулсан хөрөнгөө нэмэгдүүлэхийн чухлыг заасан билээ. АББ-ыг “хүлээн зөвшөөрөх” (recognition) асуудал олон улсын хэмжээнд чухлаар тавигдаж байгаагийн дотор сургалтын чанарыг үнэлэх, үр дүнг баталгаажуулахад бэрхшээлтэй хэвээр байна. Дээрх чиг хандлагыг харгалзан боловсролын шинэ хандлага болон гарч ирж буй “хөгжлийн боловсрол”, “энх тайвны боловсрол”, “усны боловсрол”, “уур амьсгалын өөрчлөлтийн боловсрол”, “байгалийн гамшгаас сэргийлэх боловсрол”, “тогтвортой хөгжлийн боловсрол”, “тогтвортой хөгжлийн зорилгын төлөөх боловсрол” зэргийг нийт иргэд, ялангуяа насанд хүрэгчдэд олгоход НТБ-ын үйлчилгээг чиглүүлэх;
  - Насан туршийн суралцахуй, насанд хүрэгчдийн боловсрол сургалтын арга зүйн (андрологийн) чиглэлийн судалгааг өргөжүүлэх, дэмжих;



2.1. Боловсролын  
инклюзив ба үл  
алагчлах байдал



2.2. Боловсролын  
чанарын  
үнэлгээ



2.3. Багшийн хангалт  
ба хөгжил



2.4. Сургалтын  
байгууллагын  
удирдлага



2.5. Боловсрол дахь  
мэдээлэл харилцаа,  
холбооны технологи



2.6. Боловсролын  
салбарын төсөв,  
санхүү, хөрөнгө  
оруулалт



2.7. Боловсролын  
статистик хяналт –  
шинжилгээ, үнэлгээ



2.8. Боловсролын сектор  
дамнасан бодлого,  
төлөвлөлт

## БҮЛЭГ 2

### БОЛОВСРОЛЫН ДЭД СЕКТОР ДАМНАСАН АСУУДЛУУД

## 2.1. Боловсролын инклюзив ба үл алагчлах байдал

### 2.1.1. Өмнөтгөл

Энэ тайланд “inclusive education” гэсэн англи үгийг “тусгай буюу онцлох хэрэгцээтэй боловсрол”, “equitable education” англи үгийг “үл алагчлагдах шударга байдал”, “education for disability children`s” “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол” гэсэн утгаар тус тус ойлгож хэрэглэсэн болно. Боловсролын эдгээр чухал зарчмуудын талаар уг тайлангийн Удиртгал хэсэгт товч тайлбарласан билээ.

Энэ дэд бүлэгт Монгол Улс дахь инклюзив боловсрол ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй, үндэсний цөөнх болон бусад зарим ялгаатай бүлгийн суралцагчдын боловсролын талаарх шаардлагатай мэдээ, мэдээллийг аль болох найдвартай, хэд хэдэн эх сурвалжаас цуглуулж тайлагнахыг зорилоо.

Бид үндсэндээ баримт бичгийн шинжилгээний аргыг ашиглахыг оролдсон бөгөөд үүнд, УИХ, ЗГ-аас баталсан инклюзив боловсролтой холбоотой бодлогын болон зохицуулалтын баримт бичиг, эрх зүйн акт, мөн энэ чиглэлээр сүүлийн үед хийсэн судалгааны тайланг тус тус ашиглав. Тухайлбал,

#### *Бодлогын баримт бичиг*

- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, 2014
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх (ХБХ)-ийн эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр, ЗГ-ын тогтоол, №321, 2017
- Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай, ЗГ-ын тогтоол №66, 2010

#### *Нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц (Гадаад харилцааны яам, 2018)*

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948
- Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц, 1965
- Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц, 1960

#### *Хууль тогтоомж*

- Боловсролын тухай багц хууль, 2002
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016
- Монгол хэлний тухай хууль, 2016
- Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам, ЗГ-ын тогтоол №136, 2016
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн Сайдын хамтарсан тушаал №, 2018
- Засгийн газарт чиглэл өгөх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг №42, 2013
- Цаа бугын аж ахуйг сэргээх, цаашдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр, Засгийн газрын тогтоол, №255, 2007

#### *Илтгэл, тайлан, гарын авлага*

- Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэл, Улаанбаатар хот, 2011
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцын хэрэгжилт Монгол Улсын 23-24 дүгээр ээлжит тайлан
- Монгол Улсын засгийн газар, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын үндэсний тавдугаар тайлан илтгэл, УБ, 2014
- БСШУСЯ болон ҮСГ-ын тайлангууд

Мэдээлэл цуглуулахдаа олон улсын болон Монгол Улсын боловсролын статистикийн (ҮСХ, 2018) үзүүлэлтийг эх үндэс болгож дараах шалгуурыг баримталсан.

Хүснэгт 2.1.1. Боловсролын инклюзив ба үл алагчлах байдлыг үнэлэх шалгуур, индикаторууд

Шалгуур		Тэмдэглэл
Хүртээмж	1. Инклюзив боловсрол шаардлагатай гэж үзэж буй бүлэг	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны тайлан болон олон улсын баримт бичгээс</li> <li>• БСШУСЯ болон бусад холбогдох эх сурвалжийн хүрээнд: ҮСГ, ХНХЯ...</li> </ul>
	2. Тухайн бүлгийн хүүхдийн СӨБ болон БДБ, ДБ-д хамрагдалт	
	3. Инклюзив боловсролын үйлчилгээ үзүүлж буй сургууль, цэцэрлэгийн тоо	
	4. Инклюзив боловсролын багшийн хүртээмж	
Чанар	1. Инклюдив боловсролын сургалтын хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>• Холбогдох эрх бүхий байгууллагаас батлан хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөр</li> <li>• Тэдгээрийн хэрэгжилт болон суралцагчдын сурлагын амжилттай холбоотой судалгаа /мэдээлэл</li> <li>• БСШУСЯ-ны статистик</li> </ul>
	2. Бичиг үсэг тайлагдалтын түвшин – инклюзив боловсролын үйлчилгээ шаардлагатай суралцагчдын сурлагын амжилт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн	
	3. Сурагч-багшийн харьцаа	
	4. Мэргэжлийн багшийн эзлэх хувь	
	5. Мэргэжлийн багш бэлтгэх байдал ба багшийн мэргэжил дээшлүүлэлт	
	6. Сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгийн боловсруулалт, хангалт	
Үл алагчлах байдал	1. Инклюзив боловсрол эзэмших боломж, үйлчилгээ	Үзүүлж буй боловсролын үйлчилгээ: <ul style="list-style-type: none"> <li>• Мэдээллээр хангах байдал</li> <li>• Зөвлөх үйлчилгээ</li> <li>• Сэргээн засах.....</li> <li>• Суралцагч, багш, сургуулийн удирдах ажилтны хүйсийн харьцаа</li> </ul>
	2. Сургалтын хөтөлбөр нь тусгай, ялгаатай хэрэгцээг харгалзсан байдал	
	3. Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын норм (тусгай хэрэгцээг харгалзсан байдал)	
	4. Инклюзив боловсрол дахь жендэрийн тэгш байдал	

Тайлан боловсруулах явцад дээрх индикатор бүрээр ялангуяа, “Бичиг үсэг тайлагдалтын түвшин–ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын сурлагын амжилт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, Сурагч-багшийн харьцаа, Мэргэжлийн багшийн эзлэх хувь” зэрэг үзүүлэлтээр мэдээлэл дутмаг болон олдоогүй болно.

Бид энэхүү БСМТ-д инклюзив боловсролыг “бие махбод, оюун ухаан, сэтгэл мэдрэхүйн онцлог байдал, нийгэм, хэл зүйн зэрэг бусдаас ямар нэг ялгаатай нөхцөл байдлаасаа үл хамааран хүүхэд бүр сургуульд хамрагдах боломжтой байх явдал (Саламанкагийн тунхаглал-1994, 2014)” гэсэн Саламанкагийн тунхаглалыг иш үндэс болгон боловсролын гадна үлдэх эрсдэл бүхий дараах бүлгийг хамруулан авч үзлээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид
- Малчдын хүүхдүүд
- Лам хүүхдүүд
- Үндэсний цөөнх болон гадаадад суралцаж буй монгол иргэдийн хүүхдүүд зэрэг болно.

Дээрх бүлгүүдийн хүүхдийн боловсролын асуудлыг энэхүү тайлангийн СӨБ, бага, дунд боловсрол, насан туршийн боловсролын хэсгүүдэд тусгайлан авч үзсэн. Иймд тайлангийн энэ бүлэгт Монгол Улсын инклюзив боловсролын талаарх бодлого, түүний хэрэгжилтийг ерөнхий байдлаар авч үзсэн.

Тайланд дээр дурдсан тодорхой бүлэг хүүхдийн боловсролын асуудлыг авч үзсэн нь бусад тусгай болон ялгаатай хэрэгцээтэй бүлэг байгааг үгүйсгэсэн хэрэг бус болохыг тэмдэглэж байна. Тухайлбал,

- Онцгой авьяастай хүүхдүүд,
- Суралцахуйн бэрхшээлтэй хүүхэд,
- Гадаадад суралцаж байгаад эх орондоо эргэн ирсэн хэлний бэрхшээлтэй хүүхдүүд,
- Эцэг, эх нь гадаад улс оронд хууль бусаар ажиллаж, амьдарч буй хүүхдүүдийн боловсролын чиглэлээр Монгол Улсаас хийж, хэрэгжүүлж буй зарим ажил байх боловч энэ нь инклюзив боловсролын бодлогод байр сууриа хараахан олоогүй, мэдээлэл нь олдоц муутай байгааг тэмдэглэж байна.

Мөн суралцахуйн бэрхшээлийг илрүүлэх, ийм бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй Монгол Улсад туйлын шинэ тутам, зөвхөн яригдаж эхлэх түвшинд байна гэж үзэж болохоор байна. Ийм байдал гадаад суралцаж байгаад эх орондоо эргэн ирсэн хэлний бэрхшээлтэй хүүхдүүд, эцэг, эх нь гадаад улс оронд хууль бусаар ажиллаж, амьдарч буй хүүхдүүдийн тухайд ч адил байна.

Харин монголын уламжлалт соёл, нүүдлийн соёл иргэншилтэй холбоотойгоор буддын шашин судалж буй лам хүүхдүүд, малчин өрхийн хүүхдүүдийн боловсролын тухайд зарим нэг судалгаа, мэдээлэл байгааг холбогдох хэсгүүдэд авч үзсэн болно.

### 2.1.2. Бодлого, Эрх зүй

Монгол Улсад инклюзив боловсролын түүх “тусгай хэрэгцээт боловсрол” гэсэн нэр томъёогоор, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол гэсэн утгаар 1960-аад оноос эхэлсэн гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын боловсролын түүхэн дэх инклюзив боловсролын үзэл санаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролоор эхэлжээ Тухайлбал, 1962-1964 онд хараа, сонсгол, оюуны бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай анги, бүлэг 1964 онд тусгай сургууль байгуулагджээ (Г.Батцэнгэл, 2013). Харин үндэстний цөөнхийн (казах) хэлээр сургалт явуулдаг анхны сургууль 1928 онд, Заах арга зүйн зөвлөл (Ардын гэгээрлийн яамны дэргэд) 1961 оноос байгуулагдаж үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Гэхдээ энэ тохиолдолд дээрх нэр томъёог хэрэглэж байгаагүй ажээ.

2000-аад оны эхэн үеэс боловсролын салбарт хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгш бус байдлыг арилгах, боловсролын чанарыг дээшлүүлэх хөгжлийн бодлогын хүрээнд тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсролын асуудалд илүү анхаарах болсон байна. Тухайлбал, 1998 оноос эхэлсэн тусгай хэрэгцээт боловсролын интерацчилсан сургалтын үзэл санаа, үйл ажиллагаа 2003 оноос эрчимжиж энэ чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж, Боловсролын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Мөн үндэстний цөөнхийн сургуулийн орчинд эх хэлээрээ харилцах нөхцөл боломжийг хангах талаар Боловсролын хуульд нэмэлт өөрчлөлт оруулжээ.

Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй дараах хууль тогтоомжид инклюзив боловсролтой холбоотой заалтуудыг тусган хэрэгжүүлж байна. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Боловсролын тухай багц хууль, 2002
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, 2016
- Монгол хэлний тухай хууль, 2016
- Хүүхдийн эрхийн тухай хууль, 2016
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахорон тооны бус зөвлөлийн ажиллах журам Засгийн газрын тогтоол №136, 2016 он
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар, ХНХ-ын сайд, БСШУС-ын сайд, ЭМ-ийн Сайдын хамтарсан тушаал, 2018

Тайлан бэлтгэх хүрээнд дээрх хуулиудаас Боловсролын тухай багц хууль болон Монгол хэлний тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Хүүхдийн эрхийн тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод “хөгжлийн бэрхшээл, тусгай хэрэгцээ, үндэстний цөөнх, ялгаатай байдал, эх хэл, төрөлх хэл, боловсрол, малчин, лам” гэсэн түлхүүр үгээр хайлт хийхэд нийт 66 заалт илэрснээс Боловсролын тухай хууль-д 8, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд 7, Бага, дунд боловсролын тухай хуульд 9, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд 1, Монгол хэлний тухай хуульд 3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд 35, Хүүхдийн эрхийн тухай хуульд 1, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод 2 заалт тус тус илэрчээ. Харин Дээд боловсролын тухай хуулиас дээрх тулгуур үгсээр хайлт хийхэд үр дүн илрээгүй боловч ХБХЭТХ-ийн 15.6, 15.7 заалт нь дээд боловсролын байгууллагын суралцагчтай холбогдож байна.

Хүснэгт 2.1.2. Хууль, тогтоомж дахь холбогдох заалтуудын ангилал

<p><b>1. Ерөнхий заалт (тодорхойлолт, ойлголт)</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт байж болно.</li> <li>• Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлж, бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.</li> <li>• Ерөнхий боловсролын бусад сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.</li> <li>• Мэргэжлийн сургалтын байгууллага нь үйлдвэрлэлийн харьяалалтай сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн боловсролын төв, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын байгууллага зэрэг хэв шинжтэй байж болно.</li> </ul>
<p><b>2. Талуудын үүрэг хариуцлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн бие эрхтэн, хөгжлийн онцлогийг хүндэтгэн үзэж, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч бусдаас үл алагчлагдах нөхцөлийг бүрдүүлэх;</li> <li>• Үндэсний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.</li> <li>• Сургууль, цэцэрлэгийн хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд санал өгөх, зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдэд 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх.</li> <li>• ЕБС-д суралцах хөгжлийн бэрхшээлтэй хүний насны зөрүүг боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын үнэлгээний журмыг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</li> <li>• ЕБС-д ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоог боловсрол, санхүү, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудыг тэдний хүйс, оршин суугаа газар, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээс үл хамааран бүх шатны боловсролд тэгш хамруулах, тухайн хүүхэд, залуучуудын онцлог, хэрэгцээг харгалзсан боловсролын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх, тэдний шаардлагад нийцсэн хичээлийн анги, танхимыг ердийн сургуулиудад зохион байгуулах үүргийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүлээнэ.</li> <li>• Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</li> </ul>
<p><b>3. Боловсон хүчин, хүний нөөц, хөтөлбөр, хэрэглэгдэхүүн</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• СӨБ олгож байгаа байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч тусгай мэргэжлийн багш, туслах багш, эмч, сэргээн засалч, нийгмийн ажилтан ажиллуулж болно.</li> <li>• СӨБ олгож байгаа байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тогтооно.</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон заах арга барилыг эзэмшсэн байна.</li> <li>• Тусгай цэцэрлэгт ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын, нийгмийн хамгааллын, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.</li> <li>• Ерөнхий боловсролын тусгай сургуульд энэ хуулийн 12.6-д заасан ажилтнаас гадна хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллана.</li> </ul>
<p><b>4. Хуулиар тавьж буй тусгай шаардлага</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.</li> </ul>
<p><b>5. Санхүүжилт, цалин хөлс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг сургуулийн байршил, хэв шинж, мэргэжлийн чиглэл, олон улсын хөтөлбөрийн сургалттай ЕБС-ийн сургалтын онцлог болон хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээтэй уялдуулан энэ хуулийн 40.3-т заасан сургалтын байгууллага тус бүрээр ялгавартай тогтоох бөгөөд аргачлалыг нь боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</li> <li>• ЕБС-ийн эмч, бага ангийн багшид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 7.8-д заасан нэмэгдлийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тооноос хамаарч сар бүр олгоно.</li> <li>• Цэцэрлэгийн багшид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, ажил, мэргэжлийн онцлогоос шалтгаалан нэмэгдэл цалин олгоно.</li> </ul>

Хүснэгтэд үзүүлсэн ихэнх заалт ХБХ-ийн боловсрол эзэмших эрх, эрх ашгийг хангах, хамгаалахтай холбоотой байх бөгөөд мөн талуудын үүрэг хариуцлагыг тогтоосон байна.

Харин энд “үндэстний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах” нэг заалт байх бөгөөд энэ нь Бага, дунд боловсролын тухай хуульд байна. Хүснэгтэд тусгагдаагүй үндэстний цөөнхийн талаарх заалт нь Монгол хэлний тухай хуульд туссан байдаг. Үүнд:

- Үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;
- Үндэстний цөөнхийн хэл, монгол угсаатны аман аялгууг судлах, хамгаалах, хөгжүүлэх...;

Дээр танилцуулсан хайлтаар малчин иргэдийн хүүхэдтэй холбоотой нэг заалт байгаа нь “... зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх” тухай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хамгийн олон заалт илэрсэн бөгөөд “Бүх шатны боловсрол олгох сургалтын байгууллагын багш, нийгмийн ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээ, шаардлагад нийцсэн заах арга зүй, арга барилыг эзэмшсэн байна” гэсэн нь чухал заалт байна. Мөн Боловсролын тухай багц хуулийн 2013, 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр дор дурдсан чиглэлээр заалт орсон нь ХБХ-ийг боловсролд тэгш хамруулахад ач холбогдолтой байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сэргээн засах, чийрэгжүүлэх, бие даалгах үйлчилгээ үзүүлэх талаар,
- ХБХ-д сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллах талаар.

Монгол Улс захиргааны акт батлан хэрэгжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролтой холбоотой бодлогыг хэрэгжүүлэхэд анхаарч байна. Үүний жишээ нь,

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор “ХБХ-ийн эрх оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газар 2017 онд баталсан байна.
- ЗГ-ын “Журам батлах тухай” 2012 оны 185 дугаар тогтоолоор хөгжлийн бэрхшээлтэй 1 суралцагчид ногдох хувьсах зардлын нормативыг 3 дахин нэмэгдүүлсэн бөгөөд энэ заалт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургаж байгаа ердийн цэцэрлэг, сургуульд нэгэн адил хамаарч байна.
- ЗГ-ын 2014 оны 71 дүгээр тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ыг баталсан бөгөөд тус журмын 4.1.2-т “хөгжлийн бэрхшээлтэй эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын суралцагч”, 4.1.3-т “хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг олгоно” гэсний дагуу улсын төсвөөс хариуцаж байна.
- БСШУЯ-наас ХБХ-ийг хүүхдийг илрүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын цогц үйлчилгээ арга зүй, аргачлал боловсруулан зарим цэцэрлэг, сургуульд туршин хэрэгжүүлж байна.
- Мөн Боловсролын тухай хуульд оруулсан өөрчлөлтийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхдүүдтэй хамт сургах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоогоор хувьсах зардлыг нэмэгдүүлэх, багшид нэмэгдэл хөлс олгох тухай журмыг тогтоосон байна.

Үндэстний цөөнх түүний дотор тува (цаатан) иргэдийн хүүхдийн боловсролтой холбоотой бодлого, чиглэл нь ЗГ-аас 2007 онд баталсан “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаашдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр”, энэхүү хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны зарлигт тусгагдсан байна. Тухайлбал, Хөтөлбөрт Цаатны хүүхдүүд боловсролд хамрагдах тэгш боломжийг хангаж, сургууль завсардалтаас сэргийлэх дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан:

- Цаатны хүүхдийг СӨБ-д хамруулах
- ЕБС-ийн бага ангид тува хэлний хичээлийг сургалтын төлөвлөгөөн дэх сургуулийн мэдлийн цагийн хүрээнд зохицуулан оруулах;
- Сурах бичиг, сургалтын зарим хэрэглэгдэхүүнийг тува хэл дээр орчуулах ажлыг дэмжих
- Материаллаг баазыг бэхжүүлэх
- Тайгад амьдардаг цаатны хүүхдийг их, дээд сургуульд элсэн суралцах сургалтын болон дотуур байрны төлбөрийг төрөөс хариуцах зэрэг байна.



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны зарлигт “Үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах эрхийг баталгаажуулсан Үндсэн хуулийн наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ЕБС-ийн бага ангийн сургалтын хөтөлбөрт Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайдын 2005 оны 387 дугаар тушаалаар батлагдсан “Тува хэлний хөтөлбөр”-ийг тусган, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; Цаатан иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хүүхдийн цэцэрлэг, ЕБС болон дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах; Цаатан иргэдийн их, дээд сургуульд суралцаж буй хүүхдийн сургалтын төлбөрийг жил бүрийн 9 дүгээр сарын дотор нэрийн дансанд нь шилжүүлэх, орон нутгийн захиалгаар цаатан иргэдийг сургалтад хамруулах тохиолдолд сургалтын зардлыг төрөөс бүрэн хариуцах асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх” зэргийг зарлиг болгожээ. “Цаа бугын аж ахуйг сэргээх, цаашдын амьдралын түвшинг сайжруулах хөтөлбөр” нь 2015 он хүртэл хэрэгжсэн байна.

ЗГ-аас 2010 онд баталсан “Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолд:

- Боловсролын хүрээлэнгийн бүтцэд казах хүүхдийн сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх чиг үүрэг бүхий сектор байгуулах
- Казах хэл дээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хянаж, казах болон монгол хэл судлах цагийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоох замаар сургалтын чанарыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Баян-Өлгий аймгийн боловсролын байгууллагын удирдлага, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, казах иргэдийн монгол хэлний мэдлэгийг дээшлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар заажээ.

Монгол Улс зөвхөн дотоодын хууль тогтоомж төдийгүй олон улсын хүний эрхийн гэрээ конвенцод нэгдэн орж, хүлээсэн үүргийн дагуу тайлан илтгэлийг хүргүүлж, санал зөвлөмж авч ажиллаж байна. Тухайлбал, Хүүхдийн эрхийн тухай конвенц (1989), Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (1965), Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц (1960)-д тус тус нэгдэн орсон байх бөгөөд хүлээсэн үүргийн дагуу олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн талаар тайлан илтгэл хэлэлцүүлсэн байна.

Инклюзив боловсролын талаар баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалтаас харахад Монгол Улс суралцагчдынхаа боловсролын тусгай, ялгаатай хэрэгцээг хангах бодлогын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хүүхдийн боловсрол, нийгмийн хамгаалалд илүү ач холбогдол өгч тусгайлсан хууль, журам, зааврыг баталсан байна. Үндэсний цөөнхийн хүүхдийн боловсролын тухайд холбогдох хуульд зарим зүйл заалтыг тусгах байдлаар бодлогоо тодорхойлж, зохицуулж байгаагийн зэрэгцээ Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоолын хүрээнд бодлого, шийдвэрийг тодорхойлж байна гэж үзэхээр байна.

### 2.1.3. Хэрэгжилт, Үр дүн


**Монгол Улсын инклюзив боловсролын удирдлагын үндэсний тогтолцоо, сектор дамнасан арга хандлага**

Инклюзивболовсролын бодлого, түүний дотор ХБХ-эд хандсан боловсрол нь үндэсний түвшиндээ сектор дамнасан шинжтэй бөгөөд энэхүү шаардлагыг хангаснаараа илүү үр дүнд хүрдэг онцлогтой. Монгол Улсын хувьд ч энэ чиглэлээр ахиц дэвшил гаргахыг зорьж байна. Тухайлбал, инклюзивболовсролын бодлогыг хэрэгжүүлэх, ХБИ-ийн эрх, эрх ашгийг хангах чиглэлээр үндэсний бүтэц тогтолцоог бий болгох чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд УИХ тусгайлсан хуулиудыг баталсны зэрэгцээ холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулж, хуулийн хэрэгжилтийг хангах бүтэц, тогтолцоог бий болгож эхэлжээ. Тухайлбал, ХНХЯ-ны бүтцэд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэлтэс байгуулсан байна. Мөн сүүлийн жилүүдэд батлан хэрэгжүүлж буй хууль тогтоомж, дүрэм журмыг харахад боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн секторууд энэ чиглэлээр сектор дамнасан бодлого, хамтарсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх зүйл заалт олон байна. Жишээлбэл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангахорон тооны бус зөвлөлийн ажиллах журам, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар зэргийг дурдаж болохоор байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын

комисс тогтоож байна. Уг комисс нь ЗГ-аас баталсан дүрмийн дагуу ажилладаг бөгөөд Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэгт салбар комисстой. Тус комиссын тайлангаас үзвэл 2017 оны байдлаар аймаг, дүүргийн Салбар комиссууд нийт 3949 хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг, 3487 хүүхдэд байнгын асаргаа шаардлагатай болохыг тодорхойлж, 239 хүүхдийг СӨБ-д, 314 хүүхдийг ЕБС-д, 11 хүүхдийг боловсролын бусад үйлчилгээнд холбон зуучилж, хамруулсан байна. Одоогоор нийслэлд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай сургалттай ерөнхий боловсролын 6 сургууль ажиллаж байгаагийн дөрөв нь (25, 55, 63, 70 дугаар сургуулиуд) оюуны бэрхшээлтэй, 29 дүгээр сургууль сонсголын бэрхшээлтэй, 116 дугаар сургууль харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлдэг байна. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсролын үйлчилгээний гадна орхигдох эрсдэлтэй.

Зураг 2.1.1. Тусгай хэрэгцээг хангах боловсролын удирдлагын үндэсний тогтолцоо



Тайлбар: ҮЦГМХБС гэдэг нь “Үндэсний цөөнх болон гадаад дахь Монгол хүүхдийн боловсролын судалгааны сектор”

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх заавар нь ХБХ-ийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын цогц тусламж үйлчилгээ, хөгжлийн дэмжлэгт хамруулах үүрэг бүхий Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс (цаашид “Комисс” гэх), орон нутаг дахь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (цаашид “Салбар комисс” гэх)-ын гишүүд, энэ үйл явцад

оролцдог аймаг, нийслэлийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Боловсрол, соёлын газрын мэргэжилтнүүд, цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш, эмч нар, эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд, амаржих газар, клиник, өрх, сумын эмч, сувилагчид, эцэг эх, гэр бүлийн мэдлэг хандлагыг сайжруулж, үйлчилгээ үзүүлэгчдийн өдөр тутмын үйл ажиллагааг лавлагаа болон мэргэжил, арга зүйгээр хангах зорилготой.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн ажиллах журам”-д зааснаар Зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, дэд дарга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байх бөгөөд холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын төлөөллөөс бүрдэнэ. Мөн журмын дагуу төрийн захиргааны төв байгууллага болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд орон тооны бус дэд зөвлөл, аймаг, нийслэл, дүүрэгт орон тооны бус салбар зөвлөлтэй байна. Дэд зөвлөлийн дарга нь тухайн яамны Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга байна. Салбар зөвлөлийн дарга нь тухайн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга байна. Дэд зөвлөл нь салбарын хэмжээнд, салбар зөвлөл нь нутаг дэвсгэрийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг жил бүрийн тухайн төсөвт тусгах замаар санхүүжүүлнэ.

Зөвлөлүүд нь ХБХ-ний талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулж удирдамж, чиглэл өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийг боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулах эрх бүхий байгууллагад уламжилна.

Монгол Улсын ХБХ-ийн нийгмийн болон боловсролын асуудалд ТББ-ууд ихээхэн үүрэг гүйцэтгэж байдаг бөгөөд ХБИ-ийн нэгдсэн холбооноос өгсөн мэдээллээр 99 ТББ-нэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гэжээ.

Харин “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого, үйл ажиллагаа, Мэдээллийн лавлах”-д “Монголын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”, “Монголын Хараагүйчүүдийн үндэсний холбоо”, “Монгол Улсын Сонголгүй иргэдийн үндэсний холбоо”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоо”, “Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн эрхийн үндэсний төв”, “Дохионы хэлний хэлмэрч орчуулагчдын холбоо”, “Дауны холбоо”, “Монголын Аутизмын холбоо” зэрэг ХБИ-ийн ТББ болон дэмжигч төрийн бус 43 байгууллагыг танилцуулсан байна. Эдгээр байгууллага нь ерөнхийдөө ХБИ-ийн эрх, эрх ашгийг хангах, хамгаалах, хөдөлмөрлөх эрхийг хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг боловч ХБХ-ийн нийгэм, боловсролын чиглэлээр дараах байдлаар оролцдог байна. Үүнд:

- ХБИ-ийг нийгэм хамт олон дунд хөгжүүлэхэд эцэг, эхийг чадавхжуулах, эрх мэдэлжүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хангах
- Дохионы хэлмэрчийн үйлчилгээг хувь хүн болон хуулийн этгээдийн захиалгаар гэрээний дагуу гүйцэтгэх, дохионы хэлний хэлмэрч орчуулагч нарыг шат дараалсан сургалтаар бэлтгэн гаргах
- Даунтай хүүхэд, иргэнийг нийгэмшүүлэх, боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн талаар дэмжлэг үзүүлэх
- Аутизмтай хүүхэд, залуусын гэр бүл эцэг, эхийг чадавхжуулах, нийгэмд аутизмын талаарх ойлголт мэдлэгийг түгээх, энэ хүрээний эмгэгтэй байж болзошгүй хүүхдүүдэд оношилгоо хийлгэх, оношлогдсон хүүхдүүдийг эмчилгээ, сургалтад хамруулах, тэдний эцэг, эхчүүдэд сэтгэл зүйн болон мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт хийх, түүнчлэн мэргэшсэн согог зүйч, багш, мэргэжилтнүүдийг бэлтгэх
- Хүүхдийн хөгжлийг дэмжих, сургууль, цэцэрлэгт хамрагдах боломжгүй амьжиргааны түвшин доогуур өрхийн ХБХ-эд гэрээр үзүүлэх үйлчилгээ нөлөөллийн ажил болон арга зүйн сургалт хийх зэрэг байна.

### **Инклюсив боловсрол-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол**

Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх тоо мэдээллийг цуглуулж, нэгтгэн боловсруулах, шинжлэн судалж, тооцон гаргахад Монгол Улсын Статистикийн тухай хууль (2016), Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016), Албан ёсны статистикийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2017-2020), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн

эрхийн тухай НҮБ-ын конвенц (Монгол Улс 2009 онд соёрхон баталсан), Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенц (Монгол Улс 1990 онд соёрхон баталсан), Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт–2030, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030, Ази, Номхон далайн бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан “Эрхийг бодитой болгоё” Инчоны стратеги зэрэг үндэсний болон олон улсын түвшинд баримталж буй хөгжлийн стратегиуд, хууль, тогтоомжууд, хөтөлбөрүүдийг үндэслэл болгон ажилладаг байна.

Хүснэгт 2.1.3. Мэдээллийн эх үүсвэр: Төрлөөр

	Үндэсний статистикийн хороо	Засгийн газар
Албан ёсны статистик мэдээ	<p><i>Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ (жил бүр)</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нас, хүйс, төрөл, хэлбэрээр</li> </ul> <p><i>Хүн ам, орон сууцны 2010 оны тооллого</i></p> <p><i>Хүн ам, өрхийн мэдээллийн сан</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нас, хүйс, төрөл, хэлбэрээр</li> </ul> <p><i>Өрхөд Бүх шатлалын эмнэлэг</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа</li> <li>• Ажиллах хүчний судалгаа</li> <li>• Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, амьдралын туршлагын судалгаа</li> <li>• Хүүхэд хөгжил судалгаа (Хөвсгөл аймаг, Улаанбаатар-Налайх дүүрэг)-2016</li> <li>• Вашингтон бүлгийн өргөтгөсөн багц асуултын ойлгомжтой байдлыг турших судалгаа</li> </ul>	<p><i>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэг, ЕБС-д суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо</li> </ul> <p><i>Эрүүл мэндийн яам</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бүх шатлалын эмнэлгээр үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо</li> </ul> <p><i>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар</li> <li>• Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо</li> <li>• 16 насанд хүрсэн одой хүний тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэтгэвэр, тэтгэмж авагчид</li> <li>• Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газар</li> </ul>
	Захиргааны бүртгэл, тайлан	

Эх сурвалж. Монгол Улсын НХХЯ, ЖАЙКА олон улсын байгууллагаас гаргасан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал: Бодлого үйл ажиллагаа – Мэдээллийн лавлах


Үндэсний статистикийн хорооны 2017 оны албан ёсны тайланд дурдсанаар Монгол Улсын хүн амын 3.2 хувь нь (103630) ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй, тэдгээрийн 11 орчим хувийг (11453) 0-17 насны хүүхэд эзэлж байна. Эдгээр хүүхдийн 11.1 хувь нь харааны, 7.4 хувь нь хэл ярианы, 7.4 хувь нь сонсголын, 17.4 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй, 22.4 хувь нь хөдөлгөөний, 23.6 хувь нь хавсарсан бэрхшээлтэй байна

Хүснэгт 2.1.4. Хөгжлийн бэрхшээлтэй хүн амын насны бүлэг, бэрхшээлийн төрөл (2017)

Насны бүлэг	Бүгд	Хөгжлийн бэрхшээлийн төрлөөр			
		Төрөлхийн		Олдмол	
		Хүний тоо	Хүний тоо	Эзлэх хувь	Хүний тоо
Бүгд	103630	44384	42.8	59246	57.1
0-14	8835	6656	75.3	2179	24
15-17	2618	1759	67.1	859	32.8
18, түүнээс дээш	92177	35969	39	56208	60.9
Улаанбаатар	34246	14106	41.1	20140	58.8
0-14	3617	2875	79.4	742	20.5
15-17	830	620	74.6	210	25.3
18, түүнээс дээш	29799	10611	35.6	19188	64.3

Эдгээрээс цэцэрлэг, ЕБС-д хамрагдаж буй ХБХ-ийн тоог БСШУСЯ гаргадаг байна. Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй 1599 хүүхэд цэцэрлэгт, 7279 хүүхэд ЕБС-д суралцаж байна. ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 1637 нь ерөнхий боловсролын тусгай сургуульд суралцаж байна.

Зураг 2.1.2. ЕБС-д хамрагдаж буй ХБХ-ийн тоо: Бүс нутгаар (2008-2017)



Эх сурвалж. БСШУСЯ

Монгол улсад ХБХ-д суралцдаг тусгай сургууль 6 байдаг бөгөөд дээрх зурагт эдгээр сургуульд суралцаж буй хүүхдийн тоог харуулсан болно.

### Мэргэжлийн багш, хүний нөөц

Тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн согог зүйч, хэл засалчийг 1968 оноос ОХУ, Унгар улсад суралцуулж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд 160 орчим мэргэжилтнийг бэлтгэжээ. Монгол Улс 1990 оноос эхлэн төлөвлөгөөт эдийн засгийн системээс зах зээлийн эдийн засгийн системд шилжсэнээр энэ салбарын мэргэжилтнийг гадаадын улс орнуудад төлөвлөгөөтэйгөөр бэлтгэж байсан бодлого алдагдаж, энэ чиглэлийн мэргэжлийн багшийн “хомсдол”-д орсон гэж үзэх нөхцөл үүссэн байна.

Сүүлийн жилүүдэд салбарын яамнаас анхаарч 2013 онд Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)-ийн Боловсрол судлалын төвийн дэргэд Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх (D40300 индекстэй) 1 жилийн бакалаврын хөрвөх сургалтыг нээж, уг сургалтад хамрагдсан ерөнхий боловсролын тусгай сургуулийн 16 багшид сургалтын тэтгэлэг олгосон байна. Мөн Хөвсгөл аймагт ердийн ЕБС-д инклюзив боловсролын бүлэг хичээллүүлж байгаа бөгөөд эдгээр сургуулийн 14 багшийг инклюзив боловсролын арга зүйн сургалтад хамруулжээ.

Эдүгээ МУБИС дээр дараах ажил хийгдэж байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын багшийг бэлтгэх нийт 120 кредит бүхий сургалтын хөтөлбөрт тусгай хэрэгцээт боловсролын сэдвээр 2 кредитийн заавал судлах хичээлийг оруулсан байна.
- Багшийн сургууль нь Тэгш хамруулах боловсролын үндэс (Тусгай боловсролын арга зүй) сэдэвт хичээлийг заавал эсхүл сонгон суралцах хэлбэрээр сургалтын хөтөлбөрт (2 кредит) оруулан зааж байна. Бага боловсролын магистрын ангид суралцаж буй оюутнууд инклюзив боловсролын сэдэв сонгож, дипломын ажил бичих боломж олгож байна.
- Боловсрол судлалын сургууль (БСС) бакалаврын 1 жилийн хөрвөх сургалтын хөтөлбөрийг 2015-2016 оны хичээлийн жилээс өргөжүүлэн 3,5 жилийн бакалаврын сургалт болгосон байна.
- Тусгай хэрэгцээт боловсролын багш мэргэжлийн 3,4-р курсийн оюутнуудын сонгон судалдаг “Дохионы хэл” хичээлийн хөтөлбөр, агуулгыг сайжруулах ажлыг “Дохионы хэлний орчуулагч хэлмэрчдийн холбоо”-той хамтран хийжээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ) нь ХБХ-үүд суралцдаг тусгай сургуулийн багш нарт зориулан богино хэмжээний сургалтыг зохион байгуулж ирсэн байна. Тухайлбал, 2013-2017 онд 600 гаруй багшийг хамруулан 3-10 хоногийн сургалт хийжээ. Мөн 2015, 2017 онд зарим тусгай сургуульд зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан байна.

#### Шигтгээ 2.1.1. Дохионы хэлний сургалт зохион байгуулсан тухай

2017 онд зохион байгуулсан хоёр дахь сургалт нь дохионы хэлний эрчимт сургалт байсан байна. Энэ сургалтыг сургуульд нь дохионы хэлээр хичээл зааж чадах мэргэжлийн багш нар хичээл заадаггүйгээс болж гарсан тусгай сургуулийн сонголын бэрхшээлтэй сурагчдын гаргасан эсэргүүцлийн (29-р тусгай сургуулийн дүлий ба сонголын хүнд бэрхшээлтэй сурагчид уг эсэргүүцэлд оролцсон) мөрөөр зохион байгуулжээ. Энэхүү 10 хоногийн эрчимжсэн сургалтын гол зорилго нь 29-р тусгай сургуулийн багш нарын шинжлэх ухааны хичээлүүдийг дохионы хэлээр заах чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бөгөөд уг сургалтад тус сургуулийн 88 багш, удирдах ба туслах ажилтнууд хамрагдсан байна.

Эх сурвалж: БХ-ийн гаргасан тайлангаас

ХБХ-тэй ажиллаж, тэдэнд багшлах хүний нөөцийг бэлтгэх, чадваржуулах талаар дээр дурдсан ажил хийгдэж буй сайн талтай байх боловч сургуулийн анги танхимд энэ арга хэмжээний үр нөлөө нь хэрхэн илэрч байгааг БХ-ээс 2018 онд хийсэн “Үндэсний сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт” судалгааны хүрээнд цуглуулсан мэдээллээс харж болохоор байна.


Тухайн судалгаанд сонгогдсон сургуульд суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй цөөн сурагчдын тухайд хөнгөн хэлбэрийнх тухайлбал, хараа муу, ойлгоц удаан цөөн сурагч байдаг бол оюуны, хэл ярианы, сонсголын бэрхшээлтэй, саажилттай сурагчид бас бий. Эдгээр сурагчидтай ажиллахад сургууль багш нарын бэлэн байдал харилцан адилгүй байна. Нэг л аймаг энэ чиглэлээр тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, сайн туршлага цуглуулсан байх ба уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн эцэг эх сэтгэл ханамжтай байдаг гэжээ.

Гэвч сургууль бүр харилцан адилгүй байна. Судалгаанд сонгогдсон олонх сургуульд ХБХ-эд зориулсан тусгай хөтөлбөр байхгүй, багшийг мэргэшүүлээгүй байх бөгөөд “яхав энэ сургуулийн хэмжээнд тийм их олон хүүхэд байхгүй”, “энэ нэг юу ч сурахгүй хүүхэд манай ангид яваад байдаг ангийн онооноос хасаад байна” гэсэн хандлага ажиглагдсан байна. Энэ бэрхшээлтэй байдал судалгаанд сонгогдсон хувийн сургуулийн хувьд ч адил байна.

Анхаарал татах бас нэг асуудал нь эцэг, эхийн ойлголт хандлага, тэдэнд үзүүлэх дэмжлэг юм. Судалгаанд сонгогдсон нэгэн сумын сургуульд суралцдаг ХБ-тэй 3 сурагчийн эцэг эхчүүд оношилгоо хийлгэх дургүй байдаг учраас тэдэнтэй хэрхэн ажиллах аргаа олохгүй байгаагаа сургалтын менежер мэдэгдсэн байна.

Боловсролын хүрээлэнгийн цуглуулсан мэдээлэл нь Монгол дахь Хүүхдийг Ивээх Сангийн захиалгаар Хараат Бус Судалгааны Хүрээлэнгээс 2018 онд хийсэн “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь -Хэрэгцээ тодорхойлох судалгаа”-гаар мөн нотлогдсон байна. Уг судалгааны тайланд ТХХ<sup>18</sup>-ийг үр дүнтэй тэгш хамруулан сургахад багш, боловсон хүчний бэлтгэгдсэн байдал чухал хүчин зүйл болдог бөгөөд судалгаанд хамрагдсан багш нараас ТХХ-тэй ажиллахад бэлэн эсэхийг тодруулахад “дунд” болон “хангалтгүй” гэсэн үнэлгээг дийлэнх нь өгч байжээ.

Зураг 2.1.3. Багш нар ТХХ-ийн талаарх өөрийн мэдлэг чадвараа үнэлсэн байдал(2018)



Эх сурвалж. “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь -Хэрэгцээ тодорхойлох судалгаа”-ны тайлангаас

Багш нар ТХХ-ийг ЕБС болон тусгай сургуульд сургах аль хувилбар нь илүү тохиромжтой талаар хоёрдмол байр суурьтай байна. Багш нарын энэ байр суурь нь сургуулийн орчинд тулгарч байгаа олон хүндрэл бэрхшээлтэй холбоотой ба гол бэрхшээлүүдэд ТХХ-тэй ажиллах багш нарын арга зүй, материаллаг орчин, дэд бүтэц, сурах бичиг, тоног төхөөрөмжийн хүрэлцээгүй байдал, эцэг эхийн сөрөг хандлага, сургуулийн бодлого, эрх зүйн орчны дутмаг байдлуудыг дурдсан байна. Эдгээрээс оролцогчдын хувьд хамгийн их буюу 60-аас дээш хувь нь санал нийлсэн нь дараах бэрхшээл байна. Үүнд:

<sup>18</sup> Уг судалгаанд тусгай хэрэгцээтэйхүүхэд (ТХХ) гэх нэр томъёог ашигласан байх ба төслийн хүрээнд боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхдийн ангиллыг дараах байдлаар авч үзсэн: Хараа, сонсгол, хөдөлгөөн, хэл яриа, оюуны бэрхшээл, аутизмийн хүрээний эмгэг, суралцахуйн бэрхшээл, анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг, сургууль завсардсан хүүхдүүд (тайлангийн 8 т)

- ТХХ-ийг сургах, инклюзив боловсролын аргачлал, аргазүй, модуль, хөтөлбөр дутмаг, 81.3 хувь
- ТХХ-тэй ажиллах багш нарын мэдлэг, чадвар, туршлага сул, 70.1 хувь,
- ТХХ-ийн талаарх хөгжлийн бэрхшээлгүй хүүхдүүдийн эцэг эхийн ойлголт дутмаг, 62.1 ТХХ-тэй ажиллах багш, ажилтнуудын хандлага сөрөг 62.9

### **ХБХ-ийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, хэрэглэгдэхүүн**

Монгол Улс ХБ-тэй суралцагчдад зориулсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгох талаар дараах ажлыг хийж, хэрэгжүүлж байна.

- БСШУ-ны Сайдын 2013 оны “Сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтцийг шинэчлэн багтах тухай” А/311 дүгээр тушаалаар “Оюуны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”, “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”, “Харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө”-г тус тус баталсан. Үүнийг 2018 онд мөн БСШУС-ын Сайдын А/491 тушаалаар өөрчлөн баталсан байна.
- БСШУС-ын Сайдын 2018 оны А/155 дугаар тушаалаар “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг баталсан нь ХБХ-ийн боловсролын чанарыг сайжруулахад чухал дэмжлэг болсон гэж мэргэжилтнүүд үздэг байна.
- ХБ-тэй сурагчдын онцлогт тохирсон шалгалтын арга зүйг нэвтрүүлэх талаар анхаарч ажиллаж байна. Тухайлбал, харааны бэрхшээлтэй сурагчид зориулан шалгалтын материалыг брайл үсгээр хэвлэж, шалгалт өгөх орчин нөхцөлийг бүрдүүлэх зэрэг эхлэл тавигдаж байх бөгөөд энэ чиглэлээр ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний шинэчилсэн журам-д (БСШУС-ын Сайдын тушаал, №425) дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал,
  - Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна. (журмын 3.15.)
  - Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэнэ.
  - Тусгай хэрэгцээт боловсролын сурах бичгийн эх зохиох багийг анх удаа 2012 онд шалгаруулж, гэрээ байгуулан сурах бичиг зохиолгох, хэвлүүлэх ажлыг эхлүүлжээ. 2013-2014 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулсан 3 сурах бичгийг хэвлүүлсэн бол 2016-2017 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын тусгай сургуулийн бага ангийн 4 нэр төрлийн сурах бичгийг 175 сая төгрөгийн санхүүжилтээр улсын төсвөөс хэвлэжээ. Үүнд:
    - Дүрслэх урлаг, технологи I-V (Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын)
    - Математик IV (Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын)
    - Монгол хэл V (Оюуны хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын)
    - Монгол хэл V (Сонсголын бэрхшээлтэй сурагчдын)
  - Үүний зэрэгцээ “Хэл засал” сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн багшийн ном анх удаа хэвлэгдсэн байна.
  - “Монгол хэлний тухай” хуулийг хэрэгжүүлэх хүрээнд сургуулийн өмнөх насны сонсголтгүй хүүхдэд зориулсан анхан шатны хэрэглээний 1000 үг бүхий “Дохионы хэлний зурагт толь бичиг”-ийг НҮБ-ын хүүхдийн сангийн 24,5 сая төгрөгийн санхүүжилтээр 1000 хувь хэвлүүлсэн.
  - Засгийн газрын 2017 оны 162 дугаар тогтоолоор тусгай сургуульд суралцагчийн үдийн хоолны зардлыг 2400 төгрөг болгон баталснаар 2017-2018 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын тусгай сургуулийн I-XII ангийн суралцагчид анх удаагаа үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж эхлээд байна.
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд ерөнхий боловсролын тусгай сургуулийн бүх суралцагчийн үдийн хоолны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр заасан байна.
  - Мөн тусгай 6 сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хэрэгцээнд тохирсон зориулалтын автобусаар хангах арга хэмжээ авч байна.

Ерөнхий боловсролын тусгай сургуульд ХБХ-дэд сэргээн засах, чийрэгжүүлэх, эрүүл мэндийн анхан шатны чиглэлээр тусламж үзүүлэх чиглэлээр мэргэшсэн эмч, сувилагч, туслах багш, сэргээн засалч, сэтгэл зүйч ажиллах, сургууль сургалт-үйлдвэрлэлийн дадлагын газартай байж болох талаар бодлого, шийдвэр гарсан боловч дараах бэрхшээл байна. Үүнд:

- ЕБС-д өөрийн хүсэлтээр болон хөгжлийн бэрхшээлийн хөнгөн хэлбэрээс хамааран суралцаж буй хүүхдүүдийн хувьд дээрх бодлого шийдвэрийн үр нөлөөг хүртэж чадахгүй байна.
- Мэргэжил арга зүйн төв сургуулийг 29-р сургуулиар тодорхойлсон боловч энэ нь сонсголын, хэл ярианы бэрхшээлийн хүрээнд үүрэг гүйцэтгэж байна. Бусад төрлийн бэрхшээлтэй хүүхэд сургадаг сургуулиуд орхигдсон байна.
- Судалгаа, эрдэм шинжилгээг төвлөрүүлэн хийж байгаа сургууль байхгүй.
- Эмч тусгай сургуулиудад ажиллаж байгаа боловч мэдрэлийн мэргэжлийн эмч байх шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байна.
- Тусгай сургуулиуд нь суралцагчдаа мэргэжлийн чиг баримжаа олгох, цаашилаад мэргэшүүлэх зорилго тавин ажилладаг боловч зориулалтын мэргэжлийн кабинетын хүрэлцээ дутмаг, материалын зардал төсөвт тусгагддаггүй, тоног төхөөрөмж дутагдалтай зэрэг нь сургалтын үр өгөөжид сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Тайлангийн хүрээнд цуглуулсан бодлого, хэрэгжилтийн мэдээллээс үзэхэд ХБХ-ийн боловсролын чиглэлээр зарим ахиц дэвшил байх боловч ялгаатай, тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсролын талаарх багш нарын төдийгүй мэргэжлийн олон нийт, иргэдийн ойлголт зөрүүтэй байна. Тухайлбал, “Монгол Улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” Хэрэгцээ тодорхойлох судалгаа”-ны тайланд “ТХХ-тэй ажиллаж буй багш нараас ангид нь суралцаж байгаа ТХХ-ийн тоог тодруулж, сургуулийн нэгдсэн мэдээлэлтэй харьцуулахад зөрүү их байсан нь багш нарын дунд боловсролын ТХХ, түүний ангиллын талаарх ойлголт ихээхэн зөрүүтэй байгааг харуулсан байна. Багш нар ХБХ-ийг эмчийн магадлагаа, эцэг эхийн мэдээлэлд үндэслэн тодорхойлж байгаа бол бусад тусгай хэрэгцээтэй хүүхдүүд (Аутизмийн хүрээний эмгэг, суралцахуйн бэрхшээл, анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй)-ийг хувь хүний ойлголт, мэдээлэлдээ үндэслэн ялгаатай арга зүйгээр тодорхойлж байгаа нь сургалтын менежерүүдтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс харагдсан. Дээрх нөхцөл байдал нь манай улсын боловсролын тогтолцоонд ТХХ-ийн тодорхойлолт, нэгдсэн ангилал байхгүйтэй холбоотой байна.” гэжээ.

Мөн БХ-ээс гаргасан тайланд (Боловсролын хүрээлэн, 2018) нэр томъёоны хувьд жигдрээгүй, “тэгш хамруулах боловсрол”, “тусгай боловсрол”, “тусгай хэрэгцээт боловсрол”, “тэгш боломж (equality)”, “ялгаварлан гадуурхал (discrimination)” зэрэг нэр томъёог нэгийг нөгөөгөөр нь орлуулан ашиглаж байна. Энэ нь тусгай (онцлох) хэрэгцээг хангах боловсролын талаар нэгдмэл ойлголт байхгүй, хүн бүрийн боловсролын тусгай хэрэгцээг хангах боловсролын суурь зарчим (хүн бүрийн боловсролын тусгай онцлох хэрэгцээг хангасан байх)-ыг талаарх ойлголт цэгцрээгүй байгаатай холбоотой.

Үүнтэй адил, хөгжлийн бэрхшээлийн “нийгмийн загвар”, “хүний эрхэд суурилсан боловсролын загвар”-ын талаар ярьж байгаа хэдий ч хөгжлийн бэрхшээлийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн тусгай конвенцийн дагуу томъёолох, хөгжлийн бэрхшээл, согог хоёрын ялгааг гаргахад хүндрэлтэй байна гэдгийг тэмдэглэсэн байна.

#### **Үндэстний цөөнхийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсрол**

Тайлангийн энэ хэсэгт Монгол Улсаас Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах Хорооны дүгнэлтийн дагуу гаргаж тус хороонд илгээсэн 2018 оны ээлжит тайлан болон БСШУСЯ, ҮСГ-ын баримт, БСШУСЯ-ны харьяа БХ-ийн Үндэстний Цөөнх Болон Гадаад Дахь Монгол Хүүхдийн Боловсролын Судалгааны Секторын 2013-2017 онд хийсэн судалгаа болон бусад бусад эх сурвалжийг ашиглав.


Монгол Улсад казах угсаатан нийт хүн амын 3.9 хувийг, тува (түрэг) угсаатан 0.1 хувийг эзэлдэг. Казах, тува угсаатны олонх нь Баян-Өлгий аймагт төвлөрөн оршдог бөгөөд тус аймгийн хүн амын 89.8 хувийг казах, 5.7 хувийг урианхай, үлдсэн хувийг тува, халх, дөрвөд, буриад, баяд, өөлд, захчин болон бусад угсаатны бүлэг эзэлдэг гэсэн тоо баримт байна. Тус аймгийн Цэнгэл суманд Монгол Улсын угсаатны бүлгийн цөөнх болох казах, тувачуудын төлөөлөл амьдардаг бөгөөд 2015



оны байдлаар Цэнгэл сум нь 9155 хүн амтайгаас 83.1 хувь нь казах, 14.1 хувь нь буюу 1300 орчим тува угсаатан байна.

Нийт казах иргэдийн 2.9 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. 6 ба түүнээс дээш насны казах иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл, 77.4 хувь нь боловсролтой, үүнээс 11.6 хувь нь дээд, 3.9 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.8 хувь нь техникийн болон мэргэжлийн, 21.5 хувь нь бүрэн дунд, 19.3 хувь нь суурь, 17.3 хувь нь бага боловсролтой иргэд байна. Мөн боловсролгүй иргэд 22.6 хувийг бүрдүүлж байна.

Зураг 2.1.4. Нийт казах угсаатанд дипломын болон бакалаврын дээд ба түүнээс дээш түвшний боловсрол эзэмисэн хүний эзлэх хувь (2000, 2010, 2015 оны тооллогоор)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Тува угсаатны бүлгийн хувьд нийт 4063 тува иргэд амьдарч байгаагийн дийлэнх нь Хөвсгөл аймагт, мөн Баян-Өлгий, Сэлэнгэ, Ховд, Дархан-Уул, Төв аймгуудад тархан суурьшсан байдаг. Нийт тува иргэдийн 32.8 хувь нь 0-14 насныхан, 63.6 хувь нь 15-64 насныхан, 3.6 хувь нь 65-аас дээш насныхан байна. 15 ба түүнээс дээш насны тува угсаатныг гэрлэлтийн байдлаар авч үзвэл, 36.1 хувь нь огт гэрлээгүй, 54.1 хувь нь гэрлэсэн, 9.8 хувь нь бэлэвсэн, гэрлэлтээ цуцалсан, өрх тусгаарласан байна. Нийт тува иргэдийн 3.1 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд эзэлж байна. Зургаа ба түүнээс дээш насны тува иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл 83.0 хувь нь боловсролтой, үүнээс 6.6 хувь нь дээд, 2.6 хувь нь тусгай мэргэжлийн дунд, 3.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, 21.7 хувь нь бүрэн дунд, 23.8 хувь нь суурь, 25.0 хувь нь бага боловсролтой, 17.0 хувь нь боловсролгүй иргэд байна.

Монгол Улсын төр, засгийн газраас казах, тува үндэстний цөөнхийн боловсролын онцлог хэрэгцээг хангаж, боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор өөрчлөлт шинэчлэлийн бодлогыг 2005 оноос эрчимтэй хэрэгжүүлсэн ба 2015 оноос хилийн чанад дахь монгол иргэд, тэдний үр хүүхдүүдийн монгол эх хэл, түүх, соёл, ёс заншлын боловсролд ихээхэн анхаарахын зэрэгцээ хэлний цөөнх хүүхдийн боловсролыг дэмжих бодлогын орчныг судалж эхэлсэн байна.

Хүснэгт 2.1.5. Үндэстний цөөнхийн сурч боловсрох эрхийн хүрээнд хийгдсэн судалгаа (БСШУЯ, Боловсролын хүрээлэн, 2010)

Судалгаа	Судалгааны зорилго	Хамарсан хүрээ
Английн Хүүхдийг ивээх сан: Казах хүүхдийн боловсролын байдлын шинжилгээ (2005 он)	Казах хүүхдүүдийн боловсролд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, бодлогын түвшинд анхаарах асуудлаар зөвлөмж боловсруулах	Баян-Өлгий, Ховд аймаг, Улаанбаатар хотын Налайх дүүрэг
ХЗДХЯ, ШЭЗШ төсөл, Бахытгүл: Монгол дахь казах үндэстний цөөнхийн харилцаа холбооны хэрэгцээ (2006 он)	Казах иргэдийн харилцаа, холбооны хэрэгцээ, эрх зүйн боловсролын түвшин хэр хэмжээнд байгааг тогтоох	Баян-Өлгий аймгийн Толбо, Бугат, Сагсай, Улаанхус, Цэнгэл сум
ЦХА. ХЭАСТөв: Казак үндэстний эрх XXI (2008-2009 он)	Үндэстний цөөнхийн эрхийг хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, үүний дотор эх хэлээрээ сурч боловсрох эрх	Баян-Өлгий, Ховд аймаг, Улаанбаатар хотын Налайх дүүрэг

Хүснэгт 2.1.6. Үндэстний цөөнхийн боловсролын чанар, сургалтын агуулга, арга зүйн хүрээнд хийгдсэн болон хийгдэж буй судалгаа

	Судалгааны төсөл	Хугацаа	Байгууллага		Зорилго-Хүлээгдэж буй үр дүн
			Хэрэгжүүлэгч	Санхүүжүүлэгч	
1.	Бага ангид Бага ангид монгол хэлийг эх хэлтэй нь зэрэгцүүлэн заах нь	2008-2009	Английн Хүүхдийг ивээх сан		<ul style="list-style-type: none"> <li>Туршилт судалгаа</li> <li>Арга зүй боловсруулах</li> <li>Сургалтын хэрэглэгдэхүүнээр дэмжих</li> </ul>

2.	...орон нутгийн боловсролыг дэмжих нь	2009 оны III-ҮI сар	БХ, БСШУЯ	АХБ-ны Боловсролын хөгжлийн хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> <li>• БХХ-ийн хэрэгжилтэд мониторинг хийх</li> <li>• Иргэдийн боловсролын хэрэгцээ, түүний өнөөгийн байдлыг судлан тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх</li> </ul>
3.	Казах сургуулийн сургалтын агуулга	2009 - 2010	БХ, БСШУЯ	Шинжлэх ухаан, технологийн сан	<ul style="list-style-type: none"> <li>• Казак сургуулийн сургалтын агуулгын талаар баримтлах хос хэлний бодлогын төслийг боловсруулах</li> <li>• Бага ангийн монгол, казах хэл, нийгмийн ухааны боловсролын сурах бичгийн бүтэц, агуулгын талаар зөвлөмж боловсруулах</li> </ul>

Монгол Улс нь “Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэт өв, үндэсний соёл иргэншлийн язгуур үндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн” гэж үзэж, Монгол Улсын нутаг дэвсгэрт “төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт; “төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг байгууллагаас бусад бүх шатны боловсролын байгууллагын сургалт” монгол хэл дээр байхыг хуульчилсан. Үүний зэрэгцээ үндэстний цөөнх иргэдийнхээ эх хэлээрээ сурч боловсрох эрхийг баталгаажуулж, эх хэлээрээ сурч боловсрох боломжоор төрийн зүгээс хангахыг Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Монгол хэлний тухай хуульд тодорхой хуульчилсан байна. Тухайлбал,

- Монгол Улсын Үндсэн хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол хэл бол төрийн албан ёсны хэл мөн” гэж, 2 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсгийн заалт нь хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг үл хөндөнө” гэж тус тус заасан.
- Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “... эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана”, 30 дугаар зүйлийн 30.1.12-т “үндэсний цөөнхийн боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, сургуулийн орчинд төрөлх хэлээрээ харилцах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах” гэж тус тус заасны зэрэгцээ Бага, дунд боловсролын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т боловсролын агуулга нь эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж, бичиж сургах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ гэж тусгасан.
- Монгол хэлний тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т “суралцагчдын дийлэнх олонх хүн амын өөр хэл бүхий үндэстний цөөнх байвал сургалтыг хос хэлний хөтөлбөрөөр явуулах бөгөөд хос хэлний хөтөлбөрийн агуулгыг батлах”, 13.1.5-д “үндэстний цөөнх монгол хэл болон эх хэл дээр боловсрол эзэмших, соёл, зан заншлаа өвлөх, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах” гэж боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын үүргийг тодорхойлсон.

Хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн цөөнхийн хүүхдийн боловсролын чиглэлээр 2006-2016 онд дараах гол гол арга хэмжээг авсан байна. Үүнд:

- Олон улсын байгууллага болон Боловсролын хүрээлэнгээс хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн цөөнхийн хүүхдийн боловсролын чиглэлээр 2005, 2009, 2013-2014, 2016 онд мэдээлэл цуглуулж, үндэстний цөөнхийн хүүхдийн боловсрол, түүний дотор хэлний боловсролд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдалд дүгнэлт өгсөн.
- 2007 онд БСШУ-ны Сайдын 425 тоот тушаалаар баталсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр” хэрэгжиж эхэлсэн ба үр дүнд үндэстний цөөнхийн хүүхдийн (казах, тува) хэл, соёлын ялгаатай байдлаас шалтгаалан үүсэж байсан бэрхшээлийг багасгаж, тэдний өвөрмөц хэрэгцээнд нь нийцсэн боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, тэгш байдлыг сайжруулах цогц арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлсэн.
- 2010 онд Монгол Улсын Засгийн газраас баталсан “Баян-Өлгий аймгийн боловсрол, соёлын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Баян-Өлгий аймгийн боловсрол, соёлын салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тус аймгийн боловсрол, соёл урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах бодлогыг

боловсруулан хэрэгжүүлэхдээ үндэстний цөөнх (казах, тува)-ийн хэлээр сургалт явуулж буй сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийх чиг үүрэг бүхий Боловсролын хүрээлэнгийн нэгжийг байгуулж, 2015 оноос тус секторт гадаадад сурч, амьдарч буй иргэдийн монгол хүүхдийн боловсролын судалгааны чиг үүргийг нэмсэн байна.

- БСШУ-ны Сайдын 2010 онд “Баян-Өлгий аймгийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө” баталсан ба 2 багц зорилт, 14 зүйл бүхий уг төлөвлөгөө нь 2010 -2013 онд тус аймгийн боловсролын салбарыг өөрчлөн шинэчлэх ойрын хугацааны төлөвлөгөө болсон.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Цаатан хүүхдийн боловсролыг дээшлүүлэх тухай” 42 тоот зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор БСШУ-ны Сайдын 2013 оны тушаалаар “Цаатан хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, үндэстний цөөнх болох Баян-Өлгий аймагт амьдарч буй тува, Хөвсгөл аймагт амьдарч буй цаатан иргэдийн хэл, соёл, боловсролын асуудалд онцгой анхаарч, орон нутгийн бодит байдал, чадамж болон сургалтын орчныг тооцоолж, бага боловсролыг үндэстний хэлээр зохион байгуулах бүхий л боломжийг дэмжсэн арга хэмжээг төлөвлөсөн байна.
- Боловсролын багц хуулиуд, “Монгол хэлний тухай хууль”-д гадаад дахь монгол хүүхдийн боловсролын асуудалтай холбогдох зүйл заалт бүхий нэмэлт өөрчлөлт орсон, түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу БСШУСЯ-наас хилийн чанадад ажиллаж буй сургалтын байгууллага, тэнд суралцаж буй хүүхдүүдэд зориулсан монгол хэл, соёлын жишиг сургалтын хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулах хэрэгтэй гэж үзжээ.

Монгол Улсын Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын 43 сургуулийн 2 нь монгол, 1 нь монгол-англи-турк, 6 нь монгол, казах зэрэгцсэн бүлэгтэйгээр, 1 сургууль тува, монгол холимог хэлээр, 33 сургууль казах хэлээр сургалтаа явуулж ирсэн. Сүүлийн жилүүдэд казах сургалттай 33 сургууль болон зэрэгцсэн бүлэгтэй 6 сургуулийн казах сургалттай бүлгүүд хос хэлний сургалтад шилжиж байна. Хос хэлний сургалттай сургуулийн сурагчид бага боловсролын түвшинд бүх хичээлийг эх хэл дээр судалж, төрийн албан ёсны хэлийг бичиг үсэгт тайлагдсаны дараа буюу 2 дугаар ангиасаа судалж эхэлдэг ба суурь боловсролын түвшинд эх хэл, уран зохиолоос бусад бүх хичээлийг төрийн албан ёсны хэл дээр судалдаг бол бүрэн дунд боловсролын түвшинд бүх хичээл монгол хэл дээр явагдаж, цөөн тооны сонгосон сурагчид эх хэлээ гүнзгийрүүлэн судалж байна. ЕБС-ийн 22156 сурагчийн 19283 нь казах-монгол, 278 нь тува-монгол хос хэлээр суралцаж байна. Бага ангийн эх хэл дээрээ эзэмшиж буй казах хүүхдүүдэд зориулж бага ангийн бүх сурах бичгийг казах хэл дээр орчуулан түгээж байгаа бөгөөд 1 дүгээр ангид суралцаж буй тува хүүхдэд зориулан тэдний 5 сурах бичгийг тува хэлд орчуулан сургалтад хэрэглэж байна.

БСШУСЯ-ны харьяа БХ-ийн Үндэсний цөөнх болон гадаад дахь Монгол хүүхдийн боловсролын судалгааны секторээс 2013-2017 онд цуглуулсан мэдээллээс үзэхэд угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн боловсролын чанарт дорвитой өөрчлөлт гараагүй байна. Тухайлбал, 2016-2017 оны хичээлийн жилд тус секторын цуглуулсан мэдээллээс үзэхэд сурагчдын казах хэлний сорилын гүйцэтгэл 59 хувьтай, тува хэлний сорилын гүйцэтгэл 58,2 хувьтай, монгол хэлний сорил 38,7 хувьтай байна.

Хүснэгт 2.1.7. Унших, бичих чадварын сорилын ерөнхий дүн

Сорил	Авах ёстой оноо			Авсан оноо			Дундаж		
	казах	тува	монгол	казах	тува	монгол	казах	тува	монгол
Унших	1428	238		834	128	1307.5	53.4	53,7	50,7
Бичих	1224	204		794.8	128	1126.8	64.9	62,7	26,7
Нийт	2652	442		1628.8	256	2434,3	59	58,2	38,7

Хүснэгт 2.1.8. Суралцагчдын унших, бичих чадварын сорилын харьцуулсан гүйцэтгэлийн хувь (2013 ба 2017)

Сорил	Нийт гүйцэтгэл		Үүнээс			
			Унших		Бичих	
	2013	2017	2013	2017	2013	2017
Казах хэл	55,8	59	50,6	53,4	61	64,9
Тува хэл	42,6	58,2	42,8	53,7	42,5	62,7
Монгол хэл	43,3	38,7	49,9	50,7	36,7	26,7

Сурагчийн сорилын гүйцэтгэлийг 2013 оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд тува, казах хэл дээр сорил өгсөн сурагчдын гүйцэтгэл ерөнхийдөө ахисан үзүүлэлттэй байна. Ялангуяа эх хэл дээр бичих сорилын даалгаврын гүйцэтгэл нэлээд ахисан, харин монгол хэл дээр бичих үзүүлэлт буурсан байна.

*Хүснэгт 2.1.9. Багшийн унших, бичих, хэл зүйн мэдлэг, чадварын сорилын харьцуулсан гүйцэтгэлийн хувь (2013 ба 2017)*

Сорил	Нийт гүйцэтгэл		Үүнээс					
			Унших		Бичих		Хэл зүй, зөв бичих дүрмийн сорил	
	2013	2017	2013	2017	2013	2017	2013	2017
Казах хэл	48,6	62	-	77	-	43	48,6	67
Тува хэл	25	77,8	-	80,6	-	85,7	25	67,1
Монгол хэл	44,7	43,6	58,6	40,8	34,8	46,5	40,8	65,2

Багш нараас авсан сорилын үр дүнг 2013 оныхтой харьцуулахад ахисан үзүүлэлттэй байгаа бол, монгол хэлний унших чадварын сорилын гүйцэтгэл буурсан үзүүлэлттэй байна.

Боловсролын хүрээлэнгийн ажлын хэсгийн цуглуулсан мэдээллээр Цагааннуур сумын сургуульд 454 сурагч суралцаж байгаагийн 160 нь цаатан (тува) хүүхдүүд байна. Үүнээс баруун тайгад 30, зүүн тайгад 24 сурагч, бусад нь сумын төвийн хүүхдүүд байна. Эдгээр хүүхдийн 79 эрэгтэй, 78 нь эмэгтэй байна.

Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс болон БСГ-ын дарга, холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагаас үзэхэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг дахь цаатан иргэдийн амьдралын нөхцөлийг сайжруулах зорилгоор тайгад амьдардаг 18 хүртэл насны цаатан хүүхдэд тухайн бүс нутагт тогтоосон амьжиргааны доод түвшний 50 хувьтай тэнцэх хэмжээний, насанд хүрсэн иргэнд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр сар бүрмөнгөн тэтгэмж олгох, цаатан иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, тэдгээрийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах, мөн эмч нартай холбоотой, оюутнуудад тэтгэлэг олгохтой холбоотой заалтуудыг хэрэгжүүлэхэд илүү анхаарал тавьдаг нь харагдаж байна. Тухайлбал, аймгийн хэмжээнд цаатан иргэдийг нийгмийн халамж, даатгалд хамруулах, зарлигийн дагуу тайгын тэтгэмж олгоход чиглэлээр анхаарч ажиллаж ирсэн байна.

*Шигтгээ 2.1.2. Тайгын иргэдэд тэтгэмж олгох тухай*

Аймгийн нийгмийн бодлогын хэлтсээс цаатан иргэдийг нийгмийн үйлчилгээнд тэгш хамруулах, орчин нөхцөлийг сайжруулах чиглэл барьж ажилласан байна. Тухайлбал, 100 хүүхдийн дотуур байрыг шинээр бариулж, сургууль, цэцэрлэгийн засвар хийсэн ба тайгад явуулын цэцэрлэг ажиллуулсан.


Ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд цаатан иргэдэд тэтгэмж олгох ажил хэвийн явагдаж байгаа хэдий ч тайгад амьдарч буй цаатан иргэн мөн эсэх тал дээр асуудал гардаг байна.

*Аймгийн ЗДТГ-ын НХХ-ийн удирдах албан тушаалтан мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Цаатан иргэдийн нийгмийн амьдралыг дэмжих талаар хийсэн ажил, түүний үр дүнг бусад эх сурвалжид ч тэмдэглэсэн байна. Тухайлбал, “Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцын хэрэгжилт Монгол Улсын 23-24 дүгээр ээлжит тайлан”-д дурдсанаар Засгийн газрын 2013 оны 168 дугаар тогтоолын дагуу цаатан иргэдийн амьдралын нөхцөлийг сайжруулах зорилгоор сар бүр олгох мөнгөн тэтгэмжид 2015 онд 94 өрхийн 334 иргэн (128 хүүхэд 206 том хүн), 2016 онд 95 өрхийн 368 иргэн (155 хүүхэд, 213 том хүн), 2017 онд 382 иргэн, 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар 369 иргэн тус тус хамрагдсан байна. Мөн цаатан иргэдийн нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах арга хэмжээнд 2016, 2017 онд нийт 164 иргэн хамрагджээ. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авч байгаа иргэний тоо 36 байна. Цаатан иргэдийн бүх хүүхдүүд хүүхдийн мөнгөн тэтгэмжид хамрагддаг байна (Human RIGHTS, 2019). Уг тайланд тэмдэглэснээр тайгад амьдардаг цаатан иргэдэд төрөөс сар бүр тэтгэмж олгож, нийгмийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцах, нийгмийн даатгалд хамруулах болсноор цаатан иргэдийн нийгмийн хамгааллын байдал дээшилсэн гэж үзсэн байна.

Их, дээд сургуульд цаатан иргэдээс элсүүлэх зорилгоор Хөвсгөл аймагт цаатан иргэдэд зориулсан тусгай квот бий болгосон. 2017 оны элсэлтээр Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын сургуулийг төгссөн цаатан иргэдийн 5 хүүхэд их дээд сургуульд элссэн байна. Их дээд сургуульд суралцаж байгаа 11 цаатан хүүхдэд сургалтын төрийн сангаас сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгожээ.

Зураг 2.1.5. Цаатан иргэдэд олгосон тэтгэмж (сая.төгрөг, 2013-2017)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Зураг 2.1.6. Зүүн тайгын иргэдээс 2018 оны 7 сард авсан асуулгын дүн



Эх сурвалж: Орон нутгийн цуглуулсан мэдээллийг ашиглав

Гэвч Хүний эрхийн үндэсний комисс (ХЭҮК)-ын 2009 оны илтгэлд Цагааннуур суманд үндэстний цөөнх оршин амьдардаг онцлогт нийцүүлсэн бие даасан бодлогын баримт бичиг байхгүй байгааг (Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2009) тэмдэглэсэн ба энэ байдал өнөөдөр ч хэвээрээ байна. Тус аймагт “Эх хэл, бичиг” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байгаа боловч ялгаатай бүлгийн хэлийг дэмжих чиглэлээр тусгайлсан зүйл заалт тусгаагүй болохыг ярилцлагын оролцогчид тэмдэглэж байлаа. Мөн Цагааннуур сумын удирдлагын төлөөлөл ч хүн амын хэл, соёлын ялгаатай байдлыг харгалзан “Тусгайлан энэ чиглэлээр дорвитой зүйл хийгээгүй. Сумын бодлого 2016 оноос хойш одоо нэг ажлын хэсэг гараад боловсруулж байгаа” талаар танилцуулсан болно. Харин тус сум 2019 оны 08 дугаар сард 2000 цааны баяр хийхээр нэлээн эртнээс бэлтгэж байна.

Аймаг, сумын зүгээс дээрх байдалд дүгнэлт хийж, уг хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах замаар Цагааннуурын тува-цаатан иргэдийн хэл, соёлыг дэмжих боломжтойг тэмдэглэж байв. Мөн Цагааннуур сумын сургуулийн удирдлагыг орон нутгийн уугуул иргэдээр ажиллуулах бодлого баримталж, сургуулийн захирлаар тухайн цөөнхийн төлөөллийг томилсон, тайгын цэцэрлэг ажиллуулдаг зэрэг сайн туршлага байна.

Өмнө тэмдэглэсэнээр Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 454 сурагчийн 160 нь буюу 35 хувь нь тува хүүхдүүд байх бөгөөд тус сургуульд тува хэл зааж байсан дараах туршлагууд байна. Үүнд:

- 1994-1995 онд нэг жилийн хугацаатай Тува улсаас хоёр багш ирж тува хэлийг хичээлийн бус цагаар зааж байсан ба тус улсын сурах бичгийг ашиглаж байжээ.
- 2000 онд зарим багш нар тува хэлийг хичээлийн цагаар зааж эхэлсэн боловч, хичээл менежментийг зөв хийгээгүйгээс болон сурах бичиг байхгүйгээс 2 сар ороод зогсоожээ. Энэ үед “... дархад, халх хүүхдүүдтэй хамт заахаар эцэг эх нь хэл ам гаргадаг. Хүүхдүүдэд тусад нь заах гэхээр би заавал энэ хэлийг сурах ёстой юм уу, надад ямар хэрэгтэй юм ч гэх юм уу, бас тува хүүхдийг ялгаад заахаар ичих ч гэх юм уу байдлууд гарах” бэрхшээл тулгарч байжээ.
- ХЭҮК-ын 2009 оны Хүний эрхийн тайлангаас үзэхэд тува хэлний хичээлийг 7 хоногт 7 цагаар сонгон суралцах хэлбэрээр зөвхөн 7-9 дүгээр ангийн хүүхдүүдэд ордог бөгөөд зөвхөн ярианы дадлага олгох хэмжээнд заадаг байжээ.
- 2013-2014 онд одоогийн ИТХ-ын дарга Навчаа Тува хэлийг хичээлээс гадуур төслийн шугамаар зааж байсан байна.

Өнөөгийн байдлаар тус сургуульд тува хэлийг заадаггүй, харин сургуулийн “Хүүхдийн урлагийн наадам”-аар найрал дуунд тува дуу оруулах, үндэсний уламжлалыг харуулсан нэг үзүүлбэр оруулахыг даалгадаг байна. Тус сургууль хоёр жилийн өмнө амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны цагаар “Тайгын аялал” хийж, судалгаа явуулж тайлан тавьсан ба энэ нь их сонирхолтой ажил болсон тухай багш, сурагчид ярьж байв. Харин энэ ажлыг үргэлжлүүлэн хийх эсэх нь тодорхойгүй байна. Мөн бага ангийн багш нар Хүн орчин, Иргэний боловсрол хичээлийн үеэр “Танай нутагт энэ талаар ямар ёс заншил байдаг вэ?” гэх зэрэг асуултаар соёл, ёс заншлын ялгаатай байдлыг ойлгуулахыг оролддог тохиолдол байна. Мөн сумын төв дээр “Духа хэл, соёлын төв” ТББ байгуулагдсан, үйл ажиллагаа явуулж байгаа, жижигхэн музей байгуулжээ. Мөн сургуультай хамтран “Духа дууны тэмцээн” хийхээр төлөвлөж байгаа гэсэн мэдээлэл байна.

Тува – цаатан сурагчдад эх хэлийг нь заах, мартуулахгүй байх, сэргээх талаар тодорхой ажил хийхгүй байгаа нь тува хэлний мэргэжилтэн байхгүй, сургуульд тува хэлний багшийн орон тоо байхгүй, аль нэг багшийн орон тоон дээр тува хэлний багш ажиллуулах боломжгүй зэрэгтэй холбоотой гэж оролцогчид үзсэн. Боловсролын хүрээлэнгээс ЮНИСЕФ-ийн дэмжлэгтэй боловсруулсан тува хэлний гарын авлагууд тус сургуулийн номын санд бүгд шинээрээ хадгалагдаж байсан бөгөөд оролцогчдоос үүний шалтгааныг тодруулахад уг гарын авлагыг Цагааннуурын тува – цаатан хүүхдүүдэд хүндэдсэн гэж үнэлсэн байна.

Орон нутгийн Энх тайвны корпусын хэрэгжүүлж буй амьжиргааг дээшлүүлэх, англи хэл заах төслийн хүрээнд БСГ зарим мэдээллийг цуглуулсан байна. Мөн Орон нутгийн боловсрол, эрүүл мэнд нийгмийн хамгааллын байгууллагаас 2018 оны зун зүүн тайгад ажиллах хугацаандаа янз бүрийн насны 100-аад иргэдээс тэдний боловсролын байдал болон эх хэлээрээ ярих, бичих чадварын талаар асуулга авсан байна. Энэхүү асуулга нь зөвхөн нөхцөл байдлыг илрүүлэх эхний шатны оролдлого байсныг ярилцлагын оролцогч тэмдэглэсэн (асуулгад оролцогчдын насны ангилал хийгдээгүй, оролцогчдын дотор 4-6 настай 10 гаран оролцогч байсан). Асуулгад оролцсон зарим оролцогч “Тува хэлийг дунд сургуульд албан бусаар зааж, цаатны отогт нь албан бус сургалт зохион байгуулах” санал бичсэн байна.

Эцэг эхчүүд тува ёс заншил, хэл соёлоо мартаж байгаад сэтгэл зовниж байгаа бөгөөд хүүхдүүддээ төдийгүй өөрснөө төрөлх хэлээ сурах хүсэлтэй байна. Тэд тува хэлний сургалтыг хүүхдүүдэд чанартай заахаас гадна тайгад, насанд хүрэгчдэд заах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна. Мөн сурагчид эх хэлээ сурах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. Тэдний эх хэлээрээ өөрийгөө илэрхийлэх, ярих, бичих, унших чадварыг тандаж үзэхэд гэртээ эцэг эх нь эх хэлээрээ ярьдаг хүүхдүүд бага зэрэг ярьж байсан харин унших, бичих хүүхдүүд цөөн байжээ.

*Шигтгээ 2.1.3. Тува хэлний сургалтын тухай*

- Эх хэлээ гэрээр сурах оролдлого хийж байсан. Аав, ээж, өвөө, эмээ тувагаар ярьдаг.
- 2014 онд баруун, зүүн тайгад Оюунбадам багш тува хэл зааж байсан. Тэгэхэд их юм сурсан. Том хүмүүс бас сурч байсан. Ёс заншлын талаар хөгшин хүмүүс хичээлийн үеэр зааж байсан.

*Сурагчидтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс*

Багш нараас хэл, соёлын ялгаатай хүүхдүүдтэй ажиллах онцлогийн тухай, тухайн хичээлийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх, нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургалтаа явуулахдаа энэхүү онцлогийг хэрхэн харгалздаг, тусгадаг талаар асуухад багш нар “бид хүүхдийг үндэс угсаагаар нь ялгаварладаггүй, үндсэрхэг үзэл гаргадаггүй, ялгаварлан гадуурхалт болно” гэсэн хариулт өгөв. Үүнээс үзэхэд тэдэнд сурагчийн ялгаатай байдал ба ялгаварлан гадуурхалт гэх ойлголтуудыг ялгаж ойлгуулах шаардлага байна.

Хөвсгөл аймгийн Цагаануур сумын тува - цаатан иргэдийн ахуй амьдрал харьцангуй дээшилж, цаа бугын тоо толгой өсөж байна. Үүнд Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу авч хэрэгжүүлсэн нийгмийн хамгааллын арга хэмжээ тодорхой нөлөө үзүүлсэн гэж үзэж болохоор байна. Гэвч аймгийн удирдлагын дүгнэж байгаачлан “...зөвхөн нийгмийн хамгаалал, хангамж, тэтгэмжид анхаараад хэл, соёлд нь бага анхаарч иржээ”. Тус орон нутагт Ерөнхийлөгчийн зарлигийн 6 дугаар заалт буюу тува хэл заахтай холбоотой зарим ажил хийж байгаа боловч тогтмолжиж, үр дүн нь тодорхой харагдахгүй байна. Тэр ч байтугай тува – цаатан хүүхдүүдэд эх хэлийг нь эзэмшүүлж байсан сургалт, үйл ажиллагаа тасалдаж, одоогийн байдлаар зогсонги байна. Аймгийн удирдлагын зүгээс Цагаануур сумын сургуулийн удирдлагыг орон нутгийн уугуул иргэдээр томилсон боловч үүний үр дүн одоогоор харагдахгүй байна.

Цуглуулсан мэдээллээс үзэхэд Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын тува – цаатан иргэд, хүүхдүүд эх хэлээ мартаж болзошгүй байна. Тэдний хувьд эх хэл нь 2, монгол хэл 1 дүгээр хэл болсон байна. Орон нутагт сурагчдад төдийгүй залуучуудад эх хэлийг нь эзэмшүүлэх, мартуулахгүй байх, сэргээхтэй холбоотой орон нутгийн онцлогийг харгалзсан цогц бодлого, дэмжлэг үгүйлэгдэж байна.

### **Хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн хүүхдэд зориулсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг**

Дээр танилцуулсан Баян-Өлгий аймгийн хос хэлний сургуулиуд бага ангидаа (1-5 дугаар анги) эх хэлээрээ суралцдаг дунд, ахлах ангидаа эх хэлээ судлагдахуунаар судалдаг. Орон нутгийн төр захиргааны байгууллагаас үндэсний сургалтын төлөвлөгөөнд үндэслэн сургалтын төлөвлөгөөг боловсруулан мөрддөг байна.

Бага ангийн сурагчдад зориулан үндэсний сурах бичгийг казах, тува хэл дээр орчуулж, эх хэлний (казак, тува) сурах бичгийг тусгайлан боловсруулж сургалтад ашигладаг. Үүнээс казах хэл дээр орчуулах болон казах эх хэлний сурах бичгийг боловсруулах ажлыг БСШУСЯ хариуцан сурах бичиг боловсруулах ажлын төлөвлөгөөнд тусган, улсын төсвөөс санхүүжүүлдэг бол тува хэл дээр орчуулах, тува эх хэлний сурах бичгийг боловсруулахад НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгийг авдаг байна.

Үүний зэрэгцээ казах, тува хүүхдэд зориулсан Монгол хэл 1, Монгол хэл 2 гарын авлага гарсны зэрэгцээ хилийн чанад дахь монгол хүүхдэд зориулсан “Монгол хэл, соёл” цахим сурах бичгийг боловсруулаад байна.

Хилийн чанад дахь монгол хүүхдийн эх хэл, соёлын боловсролын тухайд нийт 17 оронд үйл ажиллагаа явуулж буй 57 хэл, соёлын сургалтын төвд хичээллэн монгол хэл, соёлдоо суралцаж байна. Эдгээр төвд нийт 1500-2000 хүүхэд л хамрагдаж байгаа гэсэн тоо байна.

Дээд боловсролын тухайд “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс 2011 онд хийсэн, “Улаанбаатар хотод сурч байгаа, Баян-Өлгий аймгийн оюутан залуусын сурч боловсрох эрх хэрхэн хангагдаж байна вэ? Кейс цуглуулга ба дүн шинжилгээ”-нд нийт 25 кейс цуглуулж дүгнэлт гаргасан байна. Тухайлбал, “Дунд сургуульд монгол хэлний хичээл дээр зөвхөн уншиж бичих чадварт сургадаг тул оюутан болоод суралцахад нь ярьж, хэлэлцэх, өөрсдийгөө илэрхийлэхийг шаарддаг нийгмийн ухааны хичээлүүд дээр тааруухан дүн авдаг. Дээд сургуулийн лекцийг гүйцэж бичиж чаддаггүй” гэжээ. Гэвч өнөөг хүртэл дээд боловсролын салбарт энэ мэт ялгаатай, тусгай хэрэгцээтэй суралцагчдад үзүүлэх бодлого, дэмжлэг, үйлчилгээ алга байна.

### **Малчдын хүүхдийн боловсрол**

Монголын уламжлалт соёл, нүүдлийн соёл иргэншилтэй холбоотойгоор нүүдэллэн амьдарч буй малчдын<sup>19</sup> хүүхдийн боловсролын хүртээмж, хамрагдалт чанар нь онцгой анхаарал татдаг. Ялангуяа 2000-аад оны дунд үеэс ерөнхий боловсролын тогтолцоо, сургуулийн бүтэц өөрчлөгдөж, 2008 оноос сургуульд орох насыг 6 нас<sup>20</sup> болгосон нь бага насны хүүхдийн эрх ашиг, малчдын аж амьдралд дараах байдлаар нөлөөлж байна. Үүнд:

- 6 настай хүүхэд сургуулийн дотуур байр болон хамаатныдаа амьдардаг.
- Аав нь малаа маллаж, ээж нь сумын төвд хүүхэдтэйгээ хамт байж хүүхдээ сургуульд явуулж, гэр бүл салангид амьдардаг.
- Хүүхдээ 7-8 нас хүртэл нь сургуульд явуулахгүй байх болдог.
- Малчин өрхийн хүүхдүүдийн ихэнх нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдалгүйгээр сургуульд шууд ордог зэрэг болно.

<sup>19</sup>Нийт хүн амын 30 гаран хувь нь малчид байдаг, малчдын тоо сүүлийн жилүүдэд өсөж байна.

<sup>20</sup> Монгол улс 2002 онд 7 настай, 2006 онд 6 настай хүүхдийг сургуульд хамруулахаар хуульчилж, 2004-2005 оны хичээлийн жилээс 11 жилд, 2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилд шилжих үйл явц эхэлсэн. Өөрөөр хэлбэл, өмнө нь 8 настай хүүхэд сургуульд элсэн суралцдаг байсан бол 12 жилийн сургалтад шилснээр 6 настай хүүхэд сургуульд элсэн суралцах болсон.

Хүснэгт 2.1.10. ЕБС-ийн малчин өрхийн хүүхэд<sup>21</sup> (2008-2017)

Аймаг	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Улсын дүн	119902	122024	119588	118145	118145	112097	109599	96810	104530	109618
Баруун бүс	36316	37239	37486	37001	35883	35313	33353	30374	31332	32258
Хангайн бүс	48665	48883	47616	46133	44307	43114	41789	35828	39497	41702
Төвийн бүс	18414	18974	18011	18317	17612	17411	17881	16532	18007	18536
Зүүн бүс	12959	12687	11925	11882	14957	11502	11078	9673	10782	11920
Улаанбаатар	3548	4241	4550	4812	5386	4757	5498	4403	4912	5202

Эх сурвалж БСШУСЯ

Нийслэл хүрээнд 1921 онд анх 2 багштай анхны сургууль байгуулагдсан үеэс эхлэн Монгол Улсад сургуулийн дэргэд дотуур байр ажиллаж эхэлсэн түүхтэй бөгөөд малчдын хүүхдийг боловсролд хамруулах үндсэн шийдэл нь дотуур байр байсаар ирсэн. ЗГ-аас малчин өрхийн хүүхдийн сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх, тэдэнд чанартай боловсрол эзэмшүүлэхийн тулд дотуур байрны орны тоог нэмэгдүүлэх, сурч, амьдрах орчныг сайжруулахад тасралтгүй анхаарал тавьж байна<sup>22</sup>. Дотуур байр ажиллуулахтай холбогдон үүсэх харилцааг 1982, 1991, 1995, 2002 оны боловсролын хууль тогтоомжоор зохицуулж ирсэн. Сургуулийн дотуур байранд хүүхдүүд хичээлийн жилийн туршид 224-245 хоногийг буюу 9 сар эцэг, эхээсээ хол, байрын багшийн асран хамгаалалд амьдарч хоол хүнсээр үнэ төлбөргүй хангагдан зохих түвшний боловсрол эзэмшин төгсдөг. Дунд нь нийтдээ гурван удаа нэг долоо хоногоос гурван долоо хоног хүртэл амарч гэртээ очдог. Улсаас дотуур байрны бүх зардал, хоол хүнсийг хангадаг.

2005-2006 оны хичээлийн жилээс 7 настай, 2008-2009 оны хичээлийн жилээс 6 настай хүүхэд сургуульд элсэн суралцах болсноор дотуур байрны орчин ба үйлчилгээнд бага насны хүүхдийн хөгжлийн хэрэгцээнд нийцүүлэх асуудал чухалчлагдах болсон. Эдүгээ улсын төсвөөс жил бүр ерөнхий боловсролын салбарт зарцуулж буй нийт урсгал зардлын 8 хүртэлх хувийг дотуур байрны үйлчилгээнд, үүнээс хүүхдийн хоолны зардалд жилд 21.0-24.3 тэрбум төгрөг зарцуулж байна (Б.Ургамалцэцэг, 2014).

Гэвч дотуур байрны халаалт, дулаан, бие засах газрын эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах, баталгаат ундны цэвэр ус болон хүүхэд дотуур байранд хэвийн аж төрөхөд шаардагдах тоног төхөөрөмжөөр хангах асуудал анхаарал татсан хэвээр, хөрөнгө оруулалт ч шаардсаар байна. 2014 онд ХТҮГ-аас хийсэн “Сургуулийн дотуур байрны хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа”-гаар судалгаанд хамрагдсан дотуур байрны хоёр хүүхэд тутмын нэг нь гадаад төрх байдал, хувцаслалт, амьжиргааны түвшин, сурлагын байдлаас хамаарч, нэр хоч авах, нэр төрөө гутаалгах асуудалд ордог гэжээ. Мөн айлган сүрдүүлэх (16,9 хувь), зодох (12,5 хувь), дооглох (22,9 хувь), тохуурхах (14,3 хувь), гадуурхах (17,9 хувь), бүлэглэн гадуурхах (18,6 хувь) зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн хэлбэрүүд дотуур байранд байгааг гаргажээ. Хүүхдүүд тэнд учирдаг ялгаварлал, үе тэнгийнхний хүчирхийлэл, багш, бусад хүмүүсийн ширүүн харилцааны талаар санал гомдол гаргаж чаддаггүй талаар илэрхийлсэн байна.

Дотуур байрны өмнө тулгамдсан эдгээр асуудлыг шийдвэрлэхэд Япон Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн Сан, ЮНЕСКО, Дэлхийн банк, АХБ, Англи, Япон, Норвегийн Хүүхдийг ивээх сан, ТИКА, Дэлхийн зөн зэрэг гадны байгууллагууд БСШУЯ-тай хамтран ажиллаж, тусламж дэмжлэг үзүүлж иржээ.

Дотуур байрын багшийн ажлын үүрэг, хариуцлага, нийгмийн баталгааг хангах зорилгоор тэдний ажлын байрын тодорхойлолтыг 2008 онд БШУ-ны сайд, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан 84/43 дугаар тушаалаар батлан мөрдөж байна. “ЕБС-ийн дотуур байрын үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага”-д дотуур байрын 50 хүүхэд тутамд нэг багш байх, дотуур байрын багш нь багш мэргэжлийн байх<sup>1</sup> талаар тусгасан хэдий ч (Хамтарсан тушаал, 2008, хууд. 84/43) 2014-2015 оны хичээлийн жилд дотуур байрын багшаар ажиллаж буй 509 багшийн 115 нь багш бус мэргэжлийн хүн байсан байна (Б.Ургамалцэцэг, 2014). БМДИ-ийг 2012 онд байгуулснаар дотуур байрын багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх, тэдний мэргэжил дээшлүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулах боломж бүрдсэн байна.

<sup>21</sup> Дотуур байранд сурагчид хамрагдаж буй тоог энэхүү тайлангийн 1.2 Бага, дунд боловсролын хэсгээс харна уу.

<sup>22</sup> Энэ тайлангийн 2.5 Санхүүжилт, хөрөнгө оруулалтын болон 1.2 Бага, дунд боловсролын хэсэгт байгаа дотуур байрны барилга, хүүхдийн хамрагдалтын тоог харна уу.



Малчдын хүүхдийн боловсролтой холбоотой тэдний сургуульд бэлтгэгдсэн байдал болон сургууль завсардалт нь тулгамддаг асуудал хэвээрээ байна.<sup>23</sup>

Монгол улсын ерөнхийлөгчийн 2014 оны 98 тоот зарлигаар ЗГ-т дараах чиглэлийг өгч, 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөхийг үүрэг болгожээ. Үүнд:

1. Хөдөөгийн малчин өрх гэр бүлдээ 6 настай хүүхдээ харж асрах, аж ахуйгаа эрхлэх амьдралын таатай орчныг бүрдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын I ангийн сургалтыг эцэг эх, асран хамгаалагчийн сонголтод суурилан гэр бүлд нь түшиглэсэн, дүйцсэн хөтөлбөр, хувилбарт хэлбэрээр зохион байгуулах,
2. Хөдөөгийн сургуулийн дотуур байранд амьдран сурч буй бага насны хүүхдийн сурах, хөгжих таатай орчныг бий болгохтой холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2016 онд Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн чиг үүрэгт "... зайлшгүй нөхцөл байдлын улмаас хүүхдээ 6 наснаас нь сургуульд элсүүлэх боломжгүй талаар малчин эцэг, эхийн гаргасан хүсэлтийг үндэслэж шийдвэрлэх; гэсэн заалтыг шинээр нэмсэн байна.

Монгол дахь Японы Хүүхдийг Ивээх Сан (ЯХИС)-гаас 2012-2017 оны хооронд Дэлхийн Банкны итгэлцлийн сан болох Японы Нийгмийн Хөгжлийн Сангийн нийт 2,5 сая ам.долларын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр "Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах нь гэсэн 5 жилийн хугацаатай төслийг хэрэгжүүлжээ. Уг төсөлд Архангай, Өвөрхангай, Дорнод, Сүхбаатар аймгийн алслагдсан 301 сумын малчид хамрагдсан байна. Төслийн үр дүнд зорилтот дөрвөн аймгийн малчин өрхийн 5-10 насны 7500 орчим хүүхдүүдийн боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлж дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

1. "Тэр бүлийн орчинд хүүхдийг сургуульд бэлтгэх хөтөлбөр"-ийг туршин, төсөлд хамрагдсан орон нутгийн малчин өрхийн хүүхдийг сургуульд амжилттай бэлтгэн, эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлсэн.
2. "Хичээлийн бус цагийн нэмэлт хөтөлбөр"-өөр дамжуулан эцэг эх, гэр бүлээсээ тусдаа айлд болон сургуулийн дотуур байранд амьдарч буй бага ангийн хүүхдүүдийн сургууль болон дотуур байрын амьдралд дасан зохицох, сурах, хөгжих үйл явцыг дэмжсэн.
3. Сургуульд сурч байгаагүй болон бага ангиас сургууль завсардсан хөдөөгийн хүүхдүүдэд зориулсан "Бага боловсрол нөхөн олгох сургалтын хөтөлбөр"-ийг боловсруулан туршиж хэрэгжүүлэх замаар тэдний сургуульдаа эргэн суралцах үйлийг дэмжсэн.
4. Нутгийн захиргааны болон боловсролын байгууллагууд, эцэг эх, олон нийт бага насны хүүхдийн хөгжлийн асуудлаар хамтран ажиллах нь үр дүнтэй болохыг олон нийтэд харуулсан. Малчдын 5-10 насны хүүхдийн өмнө тулгамдаж буй боловсролын асуудлыг шийдвэрлэхэд оролцогч талуудын оролцоог хангах зорилго бүхий Олон нийтийн боловсролын зөвлөл (ОНБЗ) гэсэн бүтцийг бий болгож туршсан нь эцэг эх, сургууль, багш, орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын үүрэг, оролцоо чухал болохыг харуулж, сургууль, цэцэрлэгийн хамтын ажиллагаа, залгамж холбоо сайжирсан.

2016 онд Боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, бага насны хүүхдийн боловсролд эцэг эх, олон нийтийн оролцоог баталгаажуулж өгсөн байна.

#### *Шигтгээ 2.1.4. Аав нарт гарсан дам үр дүн*

Аав нарын оролцоо эрс дээшилсэн. Хүүхдийн сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн хуралд оролцох, багштай нь уулзах зэрэг ажлыг ээж, эмээ нарт ихэвчлэн даатгадаг байсан бол "Миний номын өргөө"-нд тогтмол ирж багцаа сольж, багшид нь шалгуулж, зөвлөгөө авдаг болсноор аав нарын оролцоо эрс сайжирсан дам үр дүн гарсан байна.

Дээд боловсролын салбарт 2011 онд БСШУСЯ-ны боловсролын зээлийн сангийн хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжид 36881 малчин өрхийн хүүхэд хамрагдсан байна. 2011 онд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль, 2018 онд Засгийн газрын тогтоолоор "Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ыг баталсан байна. Эдгээр хууль, журамд тусгайлан ХБХ болон үндэсний цөөнх, малчин өрхийн суралцагчдыг тусгайлан заагаагүй боловч оюутны хөгжлийн зээлд хамрагдагчдыг сонгон шалгаруулахдаа дараах суралцагчдыг эхлэн дэмжихийг чухалчилжээ. Үүнд:

- Тэргүүлэх ач холбогдолтой мэргэжлээр суралцагчид
- Хагас өнчин суралцагчид

<sup>23</sup> Энэ тайлангийн 1.1. СӨБ-ын хэсгээс тодруулан харна уу.

- Амьжиргааны төвшнөөс доогуур орлоготой өрхийн суралцагчид
- Малчин өрхийн суралцагчид

Уг зээлд сурлагын голч оноо нь 2.8-аас дээш оюутан, голч оноо нь 3.2-оос дээш суралцагчид хамрагдах боломжтой байна.

### **Сүм хийдэд шавилан сууж байгаа хүүхдийн боловсрол**

Буддын шашин нь Монголд олон зууны турш зонхилох шашин байсаар ирсэн. Ирээдүйд лам болох хүүхэд нь бага наснаасаа сүм хийдэд шавилан сууж, шавь орсон багшийн удирдлага зааврын дор Буддын шашны сургаал ном, ёс жаягт суралцдаг. ХЭҮК-ийн судалгаагаар 2002 онд шашны сургууль, дацанд 1248 хүүхэд суралцаж байснаас 8 хүртэл насны хүүхэд 29 байсан бол эдгээр тоо 2006 он хүртэл өсөж, нийт хүүхдийн тоо 6522, үүнээс 8 ба түүнээс доош настай хүүхдийн тоо 284 болжээ. Харин 2006 оны 7 дугаар сарын 1-ээс эхэлж хэрэгжүүлсэн Хүүхдийн мөнгө хөтөлбөрт ЕБС-д хамрагдаагүй, гэр бүлтэйгээ хамт амьдраагүй хүүхдийг хамруулахгүй гэсэн шалгуур үзүүлэлт тавьсны дагуу 2007 оны статистикийн бүртгэлээр дацан хийдэд шавилан суусан нийт хүүхдийн тоо 2251, 8-аас доош настай хүүхдийн тоо 25 болж буурсан байна. 2011 онд нийт хүүхдийн тоо 1362, бас 8-аас мөн доош насны хүүхдийн тоо 15 болсноос үзэхэд шашны сургууль, дацанд суралцагч хүүхдийн тоо цөөрчээ.

2014 онд ХТҮГ болон орон нутгийн байгууллагууд хамтран хийсэн "Сүм, хийдэд шавилан суудаг болон сүмийн үйл ажиллагаанд хамрагддаг хүүхдийн нөхцөл байдал" судалгаанд 21 аймаг, Улаанбаатар хотын 3 дүүргийн сүм хийдийн төлөөлөл болгон Будда, Христ, Исламын шашны сүмийн үйл ажиллагаанд оролцдог 2282 хүүхэд хамрагдсан байна. Тэднээс буддын шашны хийдэд тогтмол шавилан суудаг 502 хүүхэд байсан бөгөөд 1780 хүүхэд бусад шашны сүмд хүссэн үедээ ирж, үйл ажиллагаанд нь тогтмол хамрагддаг гэсэн тоо баримт гарчээ. Сүм хийдэд хүүхдэд зориулсан журам, ялангуяа хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар нэгдсэн журам, зохицуулалт байхгүй учир лам багш, ажилтнуудын хувьд хүмүүжлийн эерэг арга, хандлагын талаар мэдлэг дутмаг байгааг дээрх судалгаагаар тогтоожээ. Шашны байгууллага зөвхөн шашны ном заахыг урьтал болгодог шалтгаалан тэнд шавилан сууж байгаа хүүхэд орчин цагийн шаардлагад нийцсэн боловсрол эзэмшиж чадахгүйн дээр тэдний заримын эрх зөрчигдөхөд хүрч байжээ.

Дээрх нөхцөл байдлыг тогтоосны дүнд хувилбартай сургалтын хөтөлбөрөөр сүм хийдэд шавилан сууж буй хүүхдийг сургах ажил эхэлсэн бөгөөд үүнийг НТБ-ын төв хариуцан гүйцэтгэж байна. Тухайлбал, 2016 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Дүйцсэн хөтөлбөрөөр ерөнхий боловсрол нөхөн олгох сургалтад 6 хийд (Гандантэгчилэн, Сэлэнгэ аймгийн Амарбаясгалант, Сүхбаатар аймгийн Эрдэнэмандал, Дархан-Уул аймгийн Гэцогдаржаалан, Өвөрхангай аймгийн Эрдэнэзуу, Ганданпунцоглин) -ийн 183 лам хүүхэд хамрагджээ. Мөн лам хүүхдийн сурах эрхийг дэмжих, цаашид тасралтгүй үргэлжлүүлэн суралцахад орон нутгийн байгууллагын үүрэг оролцоог тодорхойлох, хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн БСГ-ын мэргэжилтэн, НТБ-ын төвийн захирал, менежер, багш, харьяа хийдийн сургалт хариуцсан лам нарыг оролцуулсан сургалтыг зохион байгуулсан байна.

Сүүлийн жилүүдэд буддын шашинтай орнууд түүний дотор Энэтхэг, Төвд зэрэг оронд бурхны ном үзэхээр явсан хүүхдийн боловсролын асуудал урган гарч байна. Тухайлбал, албан бус тоогоор Энэтхэгт 700 орчим хүүхэд сүм хийдэд шавилан сууж байх бөгөөд эдний дотор сургуулийн насны хэдэн хүүхэд, хэрхэн суралцаж буйг тусгайлан судлах хэрэгцээ байна.

#### **2.1.4. Дүгнэлт, Зөвлөмж**

1. Монгол Улс инклюзив боловсролын үзэл баримтлалыг боловсролын бодлогод тусган хэрэгжүүлэхийг улам бүр хичээж байна гэж үзэхээр байна. Ялангуяа, ХБХ-ийн боловсрол, нийгмийн хамгааллын чиглэлээр цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэхийг чармайж байгаа нь харагдаж байна. Энд ХБХ-ийн боловсрол, хөгжил, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэхдээ зөвхөн “анагаахын загвар”-ыг бус “нийгмийн загвар”-ыг баримтлах хандлага ажиглагдаж байгааг тэмдэглэж байна.
2. Угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн боловсролын талаар дараах нааштай ололт амжилт байна байна. Тухайлбал,
  - Үндэсний хууль тогтоомж болон бодлогын баримт бичигт угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын асуудлыг тусгайлан тусгах болсон.

- Угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын асуудлыг тусгайлан хариуцан судлах нэгжтэй болсон. Ингэснээр эдгээр хэл, соёлын ялгаатай бүлгийн хүүхдүүдийн ялангуяа, эх хэл болон монгол хэлний боловсролын чиглэлээр мэдээллийн бааз бий болгох боломжтой болжээ.
3. Мөн тэдний хэл, соёлын хэрэгцээг харгалзсан гарын авлага, цахим сурах бичиг боловсруулах, хэрэгжүүлэх эхлэл тавигджээ. Үүний жишээ нь казах, тува хүүхдэд зориулсан Монгол хэл 1, Монгол хэл 2 гарын авлага гарсны зэрэгцээ хилийн чанад дахь монгол хүүхдэд зориулсан “Монгол хэл, соёл” цахим сурах бичгийг боловсруулсан байна. Гэвч Монгол Улсад өөр хэл, соёл бүхий угсаатны цөөнхийн хүүхдүүд төрөлх хэлний орчинд олон хэл эзэмших боломжийг дэмжсэн сургалтын дидактик арга зүй, оновчтой сургалтын хөтөлбөр одоогоор байхгүй байгаагийн зэрэгцээ хос хэлт болон олон хэлний боловсролын багш нарыг бэлтгэж, тэдний мэргэжлийг дээшлүүлж ирсэн туршлага хомс байна.
  4. Монгол Улсын нүүдлийн соёл иргэншилтэй холбоотойгоор малчдын хүүхдийг боловсролд тэгш хамруулахын тулд дотуур байраар хангах, түүний орчин нөхцөлийг сайжруулахын төлөө ЗГ хүчин чармайлт гаргаж, өөрийн гэсэн туршлага, сургамжийг бий болгосон байна. Мөн сүм хийдэд шавилан сууж буй хүүхдийн ерөнхий боловсролын хүртээмж, чанарт анхаарч эхэлжээ.
  5. Тайлан боловсруулах явцад бүх түвшний боловсролын албан ёсны мэдээллийн санд инклюзив боловсрол, боловсрол дахь үл алагчлалтай холбоотой өгөгдөл, тухайлбал, хэл соёлын ялгаатай болон бусад ялгаатай бүлгийн (малчдын хүүхэд болон лам зэрэг) суралцагчдын талаарх тоон болон чанарын мэдээлэл туйлын хомс байгаа нь харагдлаа.

БСМТ-ийн хүрээнд цуглуулсан мэдээллээс инклюзивболовсролын хүрээнд Монгол Улсад тулгарч буй *сорилт бэрхшээлийг* дараах байдлаар тодорхойлж болохоор байна.

1. Монгол Улсын иргэд олон нийт төдийгүй боловсролын мэргэжлийн байгууллагын дотор инклюзив боловсрол ба үл алагчлах зарчмын, олон хэл/соёлын боловсролын талаархүзэл санаа ойлголт мэдлэг, хандлага хангалттай бус байна.
2. Улс орны хувьд ялангуяа, инклюзив боловсрол, ХБХ-ийн боловсролын талаар анхаарал тавьж, сүүлийн жилүүдэд бодлого эрх зүйн талаас нь цогц байдлаар хандаж буй сайн тал байх боловч эдгээрийн хэрэгжилт хангалттай гэж үзэх боломжгүй байна. Тухайлан энэ бүлгийн хүүхдийн боловсролын чанар, хүртээмжийн талаар нэгдсэн статистик олдсонгүй. ЕБС-д хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй сурагчийн үнэлгээний талаар хамгийн сүүлийн журамд тусгасан тодорхой заалт байгаа боловч сурагчдын явцын болон ахицын үнэлгээний талаар мэдээлэл үндэсний хэмжээнд алга байна.
3. Хүүхдийн аутизмийн хүрээний эмгэг, суралцахуйн бэрхшээл, анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэг зэргийг багш нар хувь хүнийхээ ойлголт, мэдээлэлдээ үндэслэн ялгаатай арга зүйгээр тодорхойлж байгаа нь Монгол Улсын боловсролын тогтолцоонд ТХХ-ийн тодорхойлолт, нэгдсэн ангилал байхгүйтэй холбоотой гэсэн судалгааны дүн анхаарал татаж байна.
4. Мөн хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн хүүхдүүд, бусад ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн хувьд бодлого, зохицуулалт гэхээсээ илүү хэсэг бусад үйл ажиллагаа явуулж байгаа дүр төрх харагдаж байна. Тухайлбал, БХ-ийн хийсэн судалгаанаас үзэхэд казах, тува хүүхдийн эх хэл болон монгол хэлний сургалтын үр дүнд дорвитой ахиц гарахгүй байгаа бөгөөд бүрэн дунд боловсрол төгсөгчид монгол хэл, түүх, нийгмийн ухаан, газар зүйн хичээлийн ЭЕШ-аар жил дараалан доогуур үнэлгээтэй шалгагдаж байна. Энэ нь тухайн хүүхдүүдийн дараагийн шатны боловсрол эзэмших, улмаар хөдөлмөрийн зах зээл дээр бусадтай эн тэгш өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.
5. Дээд болон мэргэжлийн боловсролын салбарт энэ чиглэлийн бодлого, зохицуулалт хангалтгүй байна. Цаатан иргэдийн хүүхэд дээд боловсрол эзэмшихэд тэтгэлэг олгох, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зээлийн сангаас хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгохоос өөрөөр тэдний суралцахуй болон суралцах нөхцөлийг дэмжсэн цогц бодлого, чиглэл үгүйлэгдэж байна.
6. Инклюзив боловсролын багш түүний дотор Тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэж буй сайн эхлэл байх боловч тэдний хүртээмж, нийт багш нарын ойлголт хандлагад анхаарах шаардлага байна. Мөн хос хэлээр суралцаж буй хүүхдүүдэд хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж буй багш нар болон сургуулийн чадавх шаардлага хангахгүй байгаа судалгааны дүн анхаарал татаж байна. Тухайлбал,

- Багш нарын хос хэлний боловсролын онцлог, энэ чиглэлийн сургалтыг зохион байгуулахтай холбоотой мэдлэг чадвар хангалтгүй,
- Угсаатны ялгаатай бүлэг суралцдаг сургуулийн удирдлага, сургалтын менежер нь багш нартаа хоёр дахь хэлийг заах, зөвлөн туслах мэдлэг чадвар хомс, энэ чиглэлээр мэргэжил дээшлүүлж байгаагүй зэргийг судалгаанд дурдсан байна.
- Мөн хос хэлний сургалт явуулж буй бага ангийн багшийн хувьд эх хэлний (казах, тува) болон монгол хэлний мэдлэг, чадварын түвшин доогуур байна.
- Угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн болон гадаад дахь монгол хүүхдийн онцлогийг харгалзсан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад арга зүйн болон хүний нөөцийн хурэлцээ, туршлага бэрхшээл учирч байна.

### **Зөвлөмж**

*Инклюзив боловсрол болон боловсрол дахь үл алагчлах байдлын талаар иргэд болон ялангуяа, боловсролын салбарын мэргэжилтнүүдийн ойлголт, хандлагад анхаарлаа хандуулах*

Хүүхэд бүрийн түүний дотор боловсролын гадна үлдэх, түүний үйлчилгээг тэгш хүртэх боломж хязгаарлагдмал бүлэг, тэдний боловсролын ялгаатай хэрэгцээг ойлгож хүлээн зөвшөөрөхөд инклюзив боловсрол болон боловсрол дахь үл алагчлалын талаарх ойлголт, хандлага чухал болохыг бодлого тодорхойлогчид болон хэрэгжүүлэгчид анхааралдаа авах шаардлагатай. Үүний тулд өнөөдрийг хүртэл хийж буй үйл ажиллагааг үндэсний хэмжээнд дэмжиж, компани ажил өрнүүлэх боломжтой.

*Монгол Улсын хувьд инклюзив боловсрол болон боловсрол дахь үл алагчлах байдлын талаар баримтлах бодлого, зохицуулалтыг илүү өргөн хүрээтэй, тодорхой болгох, төлөвлөх*

Монгол Улс өнөөг хүртэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдэд чиглэсэн инклюзив боловсролд анхаарлаа хандуулж ирсэн сайн туршлага байна. Гэвч тайланд нэр дурдсан эмгэгтэй хүүхдүүд болон хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн хүүхдүүд, боловсролын бусад ялгаатай хэрэгцээт бүхий суралцагчийн хувьд бодлого, зохицуулалт гэхээсээ илүү эхлэлийн төдий салангид үйл ажиллагаа явуулж байгаа нийтлэг дүр төрх харагдаж байна.

*Инклюзив боловсрол шаардлагатай хүүхдүүдтэй ажиллах хүний нөөц, түүний дотор багшлах болон сургууль удирдах хүний нөөцийн хурэлцээгүй байдлыг шийдэх, тэдний хөгжлийг дэмжих*

Багш нарыг инклюзив боловсрол шаардлагатай, хэл соёлын ялгаатай орчинд ажиллах мэдлэг, ур чадвар эзэмшихэд анхаарах шаардлагатай. Тухайлбал, инклюзив боловсролын багш хүрэлцэхгүй байдаг бол ердийн ЕБС-ийн багш нар инклюзив боловсрол шаардлагатай суралцагчтай ажиллах мэдлэг, чадвар хомс байна. Мөн хэл соёлын ялгаатай бүлгийн суралцагч сургуулийн багш нарын энэ талын мэдлэг, ур чадвар хангалтгүй байдаг нь судалгаагаар илэрсэн байна. Иймээс багш бэлтгэх сургуулиудын болон багшийн мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих сургалтын хөтөлбөрүүдэд инклюзив боловсролын үзэл санаа, ойлголт, тусгай, ялгаатай хэрэгцээтэй суралцагчидтай ажиллах арга зүй зэргийг тухайлан тусгах боломжтой бөгөөд энэ нь зөвхөн инклюзив боловсролын багшид бус бүх багш нарт шаардлагатай мэдлэг, ур чадвар болж байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Мөн боловсролын байгууллага, сургуулийн удирдлагуудад инклюзив боловсрол шаардлагатай, хэл соёлын ялгаатай сурагчидтай ажиллах, ялгаатай бүлгийн суралцагчид сурч буй боловсролын байгууллага, сургуулийг удирдах мэдлэг, ур чадвар шаардлагатай.

*Инклюзив боловсрол болон боловсрол дахь үл алагчлах байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур аргачлалыг тусгайлан ялгаж, боловсролын албан ёсны мэдээллийн санд тэдгээртэй холбоотой өгөгдөл, мэдээллийг бүрэн бүтэн цуглуулах*

Монгол Улсын хувьд СӨБ-оос эхлээд дээд боловсрол, НТБ хүртэлх боловсролын тогтолцоонд хөгжлийн бэрхшээлтэй, хэл соёлын ялгаатай болон бусад ялгаатай бүлгийн суралцагчдын талаарх тоон болон чанарын мэдээллийг цуглуулах нэгдсэн бодлого бүхий өгөгдөл, мэдээллийн санг бүрдүүлэхэд анхаарах цаг болсон байна. Ялангуяа мэргэжлийн болон дээд боловсролын түвшинд энэ талаар онцгой анхаарах шаардлагатай байгаа нь тайлан боловсруулах явцад илт харагдсан болно.

Нэгдсэн мэдээллийн сан нь бодлого боловсруулах, хэрэгжилтийн мониторинг, үнэлгээ хийх, шаардлагатай дэмжлэг тусалцааг хэзээ, хаана хэрэгтэй байгааг илрүүлэхэд чухал ач холбогдолтой.

## 2.2. Боловсролын чанарын үнэлгээ

### 2.2.1. Өмнөтгөл

Монгол улсад сүүлийн 20 гаруй жилийн дотор боловсролын салбарт хийгдсэн томоохон өөрчлөлт шинэчлэлийн хүрээнд боловсролын чанарын үнэлгээтэй холбоотойгоор багш ба суралцагчийг үнэлэх журмыг хэд хэдэн удаа өөрчлөн мөрдсөн байна. Энэ дэд бүлэгт Монгол Улсын боловсролын чанарын үнэлгээний тогтолцоо, түүний хөгжлийн талаар УИХ, ЗГ, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баримталсан бодлого, батлан мөрдүүлсэн эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн хэрэгжилтийн зарим үр дүнг танилцуулна.

### 2.2.2. Бодлого, Эрх зүй

УИХ-ын 2005 оны 25 дугаар тогтоолоор Мянганы хөгжлийн зорилтуудыг баталж, түүнийг 2008 оны 13 дугаар тогтоолоор “Үндэсний хөгжлийн цогц бодлого” болгон шинэчилж, нийт 9 зорилго, 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлттэй байхаар баталжээ.

“Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 4.4 Боловсролын хөгжлийн бодлого хэсэгт – *Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ. “Боловсрол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ гэсэн* зорилт дэвшүүлсэн байна.

ЗГ-ын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Боловсрол” үндэсний хөтөлбөрийг боловсруулан батлахаар тусгаж, боловсролын хүртээмж, чанарыг дээшлүүлэхийн тулд “СӨБ болон бага, дунд боловсролын чанарын үнэлгээг хөндлөнгөөс тогтоох тогтолцоог бий болгоно” гэсэн зорилт дэвшүүлжээ.

Улмаар “Боловсрол” үндэсний хөтөлбөрийн 2 дахь стратегийн зорилтын хүрээнд “Бага, дунд боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгон шинэчлэх”, “Суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээний тогтолцоог шинэчилж, олон улсын үнэлгээний сүлжээнд хамрагдах” талаар тодорхой зорилтууд дэвшигдсэн байна.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд ЗГ-ын 2013 оны 295 дугаар тогтоолоор “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийг баталж, дараах зорилтуудыг дэвшүүлсэн. Үүнд:

- “6.3.1. сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжилд гарч буй ахиц өөрчлөлтийг үнэлэх, шаардлагатай мэдээллийг цуглуулж баримтжуулах арга технологийг боловсруулж хэрэгжүүлнэ”;
- “6.3.2. бага, суурь, бүрэн дунд боловсролын сурлагын амжилтыг үнэлэх үнэлгээний арга зүйг шинэчлэн хэрэгжүүлнэ”;
- “6.3.3. боловсролын үр дүнгийн үнэлгээний үндсэн шалгуур нь суралцагчдын эзэмшсэн мэдлэг чадвар, төлөвшил байхаар үнэлгээний шалгуур үзүүлэлт (бенчмарк) боловсруулж хэрэгжүүлнэ”;
- “6.3.4. бага, дунд боловсролын стандартын хэрэгжилтийг үнэлэх ажлыг олон улсын үнэлгээний аргачлалаар үндэсний хэмжээнд тодорхой давтамжтайгаар хийнэ.”

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур, индикаторыг ашиглан үнэлэхээр заажээ. Үүнд:

- “олон улсын үнэлгээний аргачлалаар үндэсний хэмжээнд авсан сурлагын амжилтын үнэлгээний онооны зөрүү багассан хувь”;
- “боловсролын стандарт, хөтөлбөрийн түвшин хангаагүй хүүхдүүдээс ахиц дэвшил гаргаж, амжилт үзүүлсэн сурагчдын эзлэх хувь”;
- “суралцагчдын сурлагын амжилтыг үнэлэх олон улсын жишигт нийцсэн даалгаврын сангийн өсөлтийн хэмжээ” зэрэг болно.

ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын салбарын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд “Бүх шатны боловсролын үйлчилгээний чанар, үр дүнг үнэлэх боломжтой болгож, стандартад суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлнэ” гэсэн зорилгыг тавьж, түүнийг хэрэгжүүлэхээр “Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж, үйлчилгээний чанар, үр дүнг эцэг, эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломжтой болгоно” гэсэн зорилтыг дэвшүүлжээ.

Үндэсний хэмжээнд баримталж ирсэн дээрх бодлого, стратегийн зорилтод тус тус үндэслэн салбарын хүрээнд ямар үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж ирсэн тоймыг дараах хэсэгт тодорхойлж байна.

Мөн үндэсний хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг хэд хэдэн байгууллага байдаг бөгөөд тэдгээр байгууллагууд нь өөрсдийн чиг үүргийн хүрээнд тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тухайлбал, Боловсролын хүрээлэн бүх шатны боловсролын түвшинд “Хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа”-г зохион байгуулах замаар хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг бол Мэргэжлийн хяналтын ерөнхий газар нь чиг үүргийнхээ хүрээнд сургалтын байгууллагын эрүүл ахуй, орчны стандартын хэрэгжилт, хөтөлбөрийн хэрэгжилт, багшлах боловсон хүний нөөц, хүрэлцээ, багшийн үндсэн үйл ажиллагаа болон сургалтын чанарыг үнэлэх замаар сургалтын байгууллагын эрсдэлийг тооцож зөвлөн туслах үйлчилгээг үзүүлдэг.

Монгол Улс сүүлийн 20 гаруй жил боловсролын стандарт, сургалтын хөтөлбөр, сургалтын зохион байгуулалт, менежмент болон орчин хэрэглэгдэхүүнд шинэчлэл хийсээр ирсэн бөгөөд 2008 оноос хойш тэдгээрийн хэрэгжилт, чанарыг үнэлэх асуудлыг бодлогын хэмжээнд тодорхойлон чанарын үнэлгээний тогтолцоог боловсролын бүх түвшинд бий болгох, түүнийг бэхжүүлэх чиглэлээр (Зураг 2.2.1) ажиллаж байна.

Зураг 2.2.1. Боловсролын чанарын үнэлгээний тогтолцооны бүдүүвч

МОНГОЛ УЛС ДАХЬ БОЛОВСРОЛЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОГТОЛЦОО				
Боловсролын түвшин	Үнэлгээний оролцогч субъект ба объект			
	Суралцагч	Багш	Сургалтын байгууллага	Сургалтын хөтөлбөрүүд
Сургуулийн өмнөх боловсрол	Хүүхдийн хөгжлийн судалгаа	Багшийн ажлыг үнэлэх журам	Цэцэрлэгийг үнэлэх журам	Хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа
Бага, суурь, бүрэн дунд боловсрол	УШ, ЭЕШ	Багшийн ажлыг үнэлэх журам	Сургуулийг үнэлэх журам	ЧҮС, Хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа
Мэргэжлийн боловсрол	УШ, ЭЕШ	Багшийн ажлыг үнэлэх журам	МС-ын байгууллагыг үнэлэх журам	МС-ын байгууллагын хөтөлбөрийн үнэлгээ
Дээд боловсрол	зөвхөн ЭЕШ	Сургуулийн шалгуураар	Оролт-ЭЕШ	Хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа

Монгол Улс дахь чанарын үнэлгээний тогтолцооны зураглалд үзүүлснээр суралцагчдын түвшинд сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн судалгаа, ЕБС-ийн түвшинд бичгийн болон элсэлтийн уралдаант шалгалтын үр дүнг үнэлж байгаа бол багш, сургуулийн ажлыг үнэлж дүгнэх журам, зааврын дагуу өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийгдэж байна. Харин хөтөлбөрийн үнэлгээ нь хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлах судалгаа гэдэг утгаараа тодорхой хугацааны давтамжтайгаар судалгааны байгууллага дээр явагдаж байна.

### Эрх зүйн зохицуулалт

Үндэсний хэмжээнд боловсролын бүх түвшинг хамарсан чанарын үнэлгээний тогтолцоог бий болгож бэхжүүлэх, түүний дотор сурлагын амжилтыг үнэлэх шалгуур, индикаторууд болон үнэлэх арга зүйг шинэчлэх, турших, хэрэгжүүлэх чиглэлээр үнэлгээний дүрэм, журамдаа салбарын хэмжээнд нэлээд хэдэн удаа өөрчлөлт оруулжээ.

Тухайлбал, СӨБ, Бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, хөтөлбөр, сургалтын зохион байгуулалтын шинэчлэлээр ЕБС-ийн суралцагчийн үнэлгээний журамд тодорхой өөрчлөлтүүд үе шаттайгаар хийгдсээр ирсэн байна. 2008 оноос хойш боловсрол дахь чанарын хяналт-шинжилгээ,

үнэлгээний талаар баримталж ирсэн бодлогыг салбарын түвшинд дараах журмуудын хэрэгжилтээр зохицуулж иржээ. Үүнд:

УИХ-ын 2006 оны 89 дүгээр тогтоолоор ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх шийдвэрийг гарган 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургах болсон. Энэхүү үйл ажиллагаатай холбогдуулан бага насны хүүхдийн хөгжил, тэдний сургуульд амжилттай бэлтгэх асуудалд анхаарал хандуулан 2008 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Боловсролын хүрээлэнгээс “6 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал” судалгааг хийсэн байна. Тус судалгаа нь хүүхдийн сургуульд сурахад бэлэн байх асуудлыг хүүхэд, гэр бүл, боловсролын байгууллага, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааны үүднээс цогцоор нь авч үзсэн ажээ.

Улмаар 2011 онд уг судалгааг “Таван настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал” гэсэн нэртэйгээр явуулжээ. Тус судалгааны зорилго нь цэцэрлэгт хамрагдсан болон хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг судалж шинжлэх замаар бодит нөхцөл байдлыг тодорхойлсон баримт мэдээлэл цуглуулах зорилготой байсан байна. Судалгааг дараах чиглэлээр зохион байгуулсан байна. (Зураг 2.2.2)

Зураг 2.2.2. “5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал” судалгааны чиглэл



Мэдээллийн найдвартай байдлыг дээшлүүлэх, мэдээллийг баталгаажуулах үүднээс судалгаанд 5 настай хүүхэд, гэр бүл, асран хамгаалагчид болон цэцэрлэгийн багш, орон нутгийн удирдлага буюу шийдвэр гаргагчдыг хамруулсан байна.

Судалгааны үр дүнг дараах чиглэлээр боловсруулан гаргаснаас гадна зөвлөмжийг гэр бүл, боловсролын байгууллага, орон нутгийн хүрээнд, салбарын болон үндэсний хүрээнд гэсэн байдлаар тайлагнасан байна. Үүнд:


- 5 настай хүүхдийн бэлтгэгдсэн байдал
- Эцэг, эх, гэр бүлийн бэлтгэгдсэн байдал
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багшийн бэлтгэгдсэн байдал
- Орон нутгийн бэлтгэгдсэн байдал

Энэхүү судалгаа нь тухайн насны хүүхдийг сургуульд бэлтгэхэд хүүхэд, гэр бүл, боловсролын байгууллага, олон нийтийн гүйцэтгэх үүрэг, оролцоо, тэдний өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа арга хэмжээнүүдийн ерөнхий хүрээг гаргаж өгснөөрөө өмнөх судалгаанаас илүү ач холбогдолтой болсон байна.

Мөн СӨБ-ын стандарт, хөтөлбөр нь 2003, 2011, 2015 онд тус тус шинэчлэгдсэн ба түүнтэй уялдуулан сургалтын талаар баримтлах бодлогын чиглэлийг 2 удаа боловсруулан гаргасан байна. Тухайлбал, БСШУ-ны Сайдын 2007 оны **20 дугаар** тушаалаар баталсан баримт бичигт “Хүүхдийн эзэмшсэн мэдлэг, чадвар, дадал, төлөвшилийг сургалтын явц болон эцэст хөгжлийн ахисан түвшингээр нь үнэлнэ. Сургалтын чанарын өөрийн үнэлгээг үнэлгээний стандартад үндэслэн улирал бүрийн эцэст тухайн цэцэрлэг, Хөндлөнгийн үнэлгээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Боловсролын газар, эрх бүхий бусад байгууллага хийнэ” хэмээн тусгасан бол БШУ-ны Сайдын 2013 оны **А/327 дугаар** тушаалаар батлагдсан бодлогод “Хүүхдийн хөгжлийн үнэлгээ нь түүнд гарч буй ахиц, өөрчлөлтийг үнэлэх, тэдний цаашидын хөгжил, суралцах үйлд оновчтой дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлнэ. Тухайн хүүхдийн онцлогийг илрүүлэх, хөгжлийн ахицыг тогтоохын тулд шаардлагатай мэдээллүүдийг цуглуулж, баримтжуулна. Багийн ажлын үнэлгээний шалгуур нь хүүхдийн хөгжлийн ахиц болон багийн хүүхдүүдтэй харилцаж, ажиллаж буй арга барил, чадвар байна. Багийн үнэлгээ нь өөрийн болон хөндлөнгийн үнэлгээгээр хийгдэнэ гэсэн байна.

2013 онд шинэчлэн боловсруулсан бодлого болон СӨБ-ын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд тулгуурлан боловсруулсан сургалтын цөм хөтөлбөрт хүүхдийн хөгжлийн үнэлгээг дараах 3 баримт бичигт тодорхойлогдсон шалгуур, аргачлалын хүрээнд хийхээр тусгажээ. (Зураг 2.2.3)

Зураг 2.2.3. СӨБ-ын сургалтын стандарт, хөтөлбөрийн шинэчлэгдэн боловсруулагдсан товчоон



Бага, дунд боловсролын агуулгын өөрчлөлттэй холбоотойгоор сурагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийг үнэлж дүгнэх журмууд 1998 оноос хойш 3 удаа шинэчлэгдэн холбогдох өөрчлөлтүүд орсон байна (Хүснэгт 2.2.1).

Хүснэгт 2.2.1. ЕБС-ийн суралцагчийг үнэлэх журмуудад орсон өөрчлөлтүүд

№	Журам	Агуулгын өөрчлөлт
1	“ЕБС-ийн суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийг үнэлж дүгнэх үлгэрчилсэн журам”, “Бага, дунд боловсролын улсын шалгалтын журам” (Гэгээрлийн Сайдын 259 дүгээр тушаал, 1998)	<ul style="list-style-type: none"> <li>• 5 үсгэн дүнд харгалзах процентын дүн болон сурлагын дээд, дунджаас дээгүүр, дундаж, дунджаас доогуур, хангалтгүй гэсэн 5 агуулгын түвшний дүн тавигдахаар болж өөрчлөгдсөн.</li> <li>• Дунд, ахлах ангийн суралцагчийг бүлэг сэдвээр үнэлж, жилийн эцэст дүн гаргана.</li> <li>• Улирал бүрд хөндлөнгийн үнэлгээ хийнэ.</li> <li>• Энэхүү журам хэрэгжүүлэх зөвлөмжтэйгөөр боловсруулагдсан.</li> </ul>
2	ЕБС-ийн суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийг үнэлж дүгнэх журам (БСШУ-ы Сайдын 471 дүгээр тушаал, 2010)	<ul style="list-style-type: none"> <li>• Улирлын үнэлгээг I ба II нэгж хичээлүүдийн хагас жил болон жилийн эцэст стандарт үнэлгээгээр үнэлнэ.</li> <li>• Суралцагчийг стандарт бус болон стандарт үнэлгээгээр үнэлнэ.</li> </ul>
3	ЕБС-ийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам (БШУ-ы Сайдын А/287 дугаар тушаал, 2013)	<ul style="list-style-type: none"> <li>• Суралцагчийн ахиц, амжилтыг тооцож улирлын үнэлгээг ирц-10, явц-60, улирлын шалгалт-30 хувиар тооцож дунд ангид 5 шатлалтайгаар өмнөх оны дүнгээр үнэлж байна. харин ахлах ангид 13 шатлалт үсгэн (А, А+, А-, В, В+, В- гэх мэт) дүн, процент, агуулгын түвшний тоон дүнгээр дүгнэх болсон. Мөн бага боловсролын түвшинд I-III ангид суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилтыг үгэн үнэлгээгээр, IV-V ангид гүйцэтгэлийн хувиар тооцож, үгэн үнэлгээгээр үнэлнэ хэмээн тусган өгсөн байна.</li> </ul>
4	ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам (БСШУС-ын Сайдын А/425 дугаар тушаал, 2018)	<ul style="list-style-type: none"> <li>• Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын ба үр дүнгийн гэсэн 3 төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.</li> <li>• Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхдээ I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох болон явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана. Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд гүйцэтгэлийг хувиар үнэлж, 8 түвшинд ангилах бөгөөд түвшин тус бүр нь шалгуур (тодорхойлолт)-тай байна гэж заасан байна.</li> <li>• Уг журмыг хэрэгжүүлэх зөвлөмж боловсруулагдан түгээгдсэн байна.</li> </ul>

Ийнхүү 2004 оноос хойш бага, дунд боловсролын цогц чадамжид суурилсан шинэ стандартууд, тэдгээрт нийцүүлэн боловсруулсан үндэсний сургалтын хөтөлбөрүүд (БСШУЯ, 2008-2013) болон цөм хөтөлбөрүүд (БСШУЯ, 2014-2018), тэдгээрийн ЕБС-д хэрэгжүүлсэн дам үр дүнг илэрхийлэх суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж дүгнэх бодлого, журам, зааврыг олон улс болон МУ-ын хөгжлийн чиг хандлага, боловсролын салбарт гарч буй боловсролын өөрчлөлт шинэчлэлд нийцүүлэн тасралтгүй шинэчлэн хөгжүүлж ирсэн байна.



### 2.2.3 Хэрэгжилт, Үр дүн

#### Хүүхдийн хөгжлийн үнэлгээ

СӨБ-ын цөм хөтөлбөрт тусгасан үнэлгээний нэг хэлбэр болох “Нарийвчилсан бүтэцтэй ажиглалт”-ын хуудас нь 3 хүртэлх (29 асуулттай) болон 3-6 нас хүртэлх (115 асуулттай) насны ангиллаар боловсруулагдсан байна. Боловсролын үнэлгээний төв нь энэхүү нарийвчилсан бүтэцтэй ажиглалтын хуудасны асуулт дээр үндэслэн 2015 оноос эхлэн жил бүр “Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн **улсын дундаж, норм, нормативыг тогтоох**, хүүхэд бүрийн **хөгжлийн гарааг үнэлэх, ахиц амжилтыг тодорхойлох**, улмаар **сургалтын үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх**” зорилгоор онлайн судалгааг зохион байгуулж эхэлсэн.

Энэхүү судалгаа нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллага болон бүлэг тус бүрээс санамсаргүй түүврийн арга хэрэглэн сургуулийн өмнөх сургалтын байгууллагад хамрагдаж буй нийт хүүхдийн 10 хүртэлх хувийг хамруулан зохион байгуулагддаг.

2018 оны байдлаар судалгаанд 1332 цэцэрлэгийн 6348 бүлгийн нийт 22968 хүүхэд хамрагдсан байна. Үүнээс 3 хүртэлх насны хүүхдийн судалгаанд 1056 цэцэрлэгийн 5231 хүүхэд, 3-6 хүртэлх насны хүүхдийн судалгаанд 1113 цэцэрлэгийн 17737 хүүхэд тус тус хамрагджээ. Нийт цэцэрлэгүүдийг хот, хөдөөгийн бүсээр ялган харвал, 51.5 хувь нь Улаанбаатар хотын, 48.5 хувь нь орон нутгийн цэцэрлэгүүд байна.

Судалгааны үр дүнг насны 4 ангиллаар тухайлбал, 3 хүртэлх, 4 нас, 5 нас, 6 настай хүүхдийн дундаж үзүүлэлтийг 6 түвшинд чадвар ба чадамж гэсэн 2 шалгуурын хүрээнд нийт 10 индикатораар хэмжиж гүйцэтгэлийн нийлбэр оноогоор илэрхийлэн боловсруулдаг байна. Жишээ болгож, 2018 оны 3 хүртэлх болон 4-5 насны хүүхдийн хөгжлийн гүйцэтгэлийн онооны улсын дунджийг Хүснэгт 2.2.2 ба 2.2.3-т үзүүлэв.

Хүснэгт 2.2.2. 3 хүртэлх насны хүүхдийн хөгжлийн улсын дундаж (2018)

Чадвар	Түвшин					
	I	II	III	IV	V	VI
Биеийн хөдөлгөөнөө удирдах чадвар	< 14	14 - 19	20 - 26	27 - 32	33 - 36	36 <
Нийгэмшихүйн чадвар	< 9	9 - 12	13 - 18	19 - 22	23 - 24	24 <
Оюун ухааны чадвар	< 10	10 - 12	13 - 18	19 - 23	24 - 27	27 <

Хүснэгт 2.2.3. 4-5 настай хүүхдийн хөгжлийн улсын дундаж (2018)

Чадамж	Түвшин					
	I	II	III	IV	V	VI
Хөдөлгөөн, эрүүл мэндийн чадамж	< 43	43 - 66	67 - 86	87 - 106	107 - 124	124 <
Нийгэмшихүйн чадамж	< 38	38 - 57	58 - 75	76 - 91	92 - 107	107 <
Хэл ярианы чадамж	< 30	30 - 46	47 - 61	62 - 76	77 - 89	89 <
Орчноо таньж мэдэх, орчинтойгоо харилцах чадамж	< 15	15 - 23	24 - 30	31 - 38	39 - 45	45 <
Математикийн чадамж	< 18	18 - 30	31 - 41	42 - 52	53 - 61	61 <
Дүрслэх урлагийн чадамж	< 16	16 - 26	27 - 36	37 - 45	46 - 53	53 <
Хөгжмийн чадамж	< 12	12 - 18	19 - 24	25 - 30	31 - 36	36 <

Дээрх судалгааны үр дүнг багш нар дараах үйл ажиллагаандаа хэрэглэдэг. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн түвшинг тодорхойлох
- Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн ялгаатай байдлыг илрүүлэх
- Сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг оновчтой төлөвлөх
- Хүүхдийн ахиц, амжилтыг тооцох

Нэг талаас, сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж буй суралцагчдын хөгжлийг үнэлэх хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр тогтмол үйл ажиллагаа явагддаггүй нөгөө талаас, мэдээллийн эх сурвалжийн найдвартай байдал болон баталгаажилтын талаар дутмаг зүйл байгаа учраас цаашид бага насны хүүхдийн хөгжлийг үнэлэх тогтолцоог бий болгох, цогцоор нь хөгжүүлэх шаардлагатай байна.

### Чанарын үнэлгээ (national assessment on learning achievement)


Боловсролын стандартын хэрэгжилт болон олон улсын аргачлалаар явуулсан зарим туршилт судалгааны тайлангаас харахад 2010 оноос өмнө боловсролын салбарт хэрэгжиж буй бодлогын үр дүнг үнэлэх, үндэсний хэмжээнд чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээний арга механизмыг бүрдүүлэх талаар холбогдох журмуудад тусгайлсан заалтууд нарийвчлан тусгагдаагүй боловч Монголд сурлагын амжилтын судалгааг тодорхой давтамжтайгаар үндэсний хэмжээнд зохион байгуулж байсан байна.

Хүснэгт 2.2.4. Сурлагын амжилтын судалгаанууд (2000-2012)

Огноо	Судалгааны нэр, чиглэл	Хэрэгжүүлсэн байгууллага	Анги
2008	Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ	БСШУЯ, БҮТ, Дэлхийн банк, Хөдөөгийн боловсролыг дэмжих төсөл (READ)	5
2011	TIMSS-ПИРЛС 2011 олон улсын туршилт судалгаа	БСШУЯ, БҮТ, Дэлхийн банк,	4
			8
2012	Бага, суурь боловсролын стандартын хэрэгжилтийг тогтоох хөндлөнгийн шалгалт	БШУЯ, БҮТ	7
			10 (шилжилтийн)

Дээрх хүснэгт дэх бага боловсролын судалгааны үр дүнг жишээ болгон доор үзүүлэв (Зураг 2.2.4).

Зураг 2.2.4. 2008-2012 онуудад зохион байгуулагдсан сурлагын амжилтын судалгааны үр дүн (математикийн хичээлийн жишээн дээр)




Сурлагын амжилтын судалгаануудын дүнгээс харахад 2008 онд зохион байгуулагдсан судалгаагаар математикийн шалгалтын гүйцэтгэлийн дундаж 45.4 хувьтай шалгагдсан бол түүнээс хойш зохион байгуулагдсан олон улсын сурлагын амжилтын судалгаа болон стандартын хэрэгжилтийг судлах судалгааны дүнгээр энэ үзүүлэлт буурсан байна.

Дотоодын болон гадаадын донор байгууллагуудын тусламжтайгаар зохион байгуулж ирсэн сурлагын амжилтын судалгааны арга зүйг боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхээр 2010 онд боловсруулсан сурагчийн үнэлгээний журмын 8 дугаар бүлгийн 8.2-т “Бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний төгсөлтийн өмнөх ангийн суралцагчийн сурлагын амжилтын судалгааг яам, Боловсролын хүрээлэн 4 жил тутам хийнэ” гэж заасан боловч ямар хичээлээр, хэрхэн зохион байгуулах талаар тусгайлсан заалт байхгүй байна.

- Дараагийн журам шинэчлэгдэн боловсруулагдахаас өмнө буюу 2012 онд “Бага, суурь боловсролын стандартын хэрэгжилтийг тогтоох хөндлөнгийн шалгалт”-ыг VII ба X (шилжилт) ангийн суралцагчдаас математик, монгол хэлний хичээлээр зохион байгуулсан байна.
  - Математикийн стандартын хэрэгжилтийг тогтоох шалгалтад VII ба X ангийн суралцагч хамрагдсан.
  - Монгол хэлний стандартын хэрэгжилтийг тогтоох хөндлөнгийн шалгалтад VII ангийн 2110 суралцагч, X ангийн 1679 суралцагч тус тус хамрагджээ.

- Стандартын хэрэгжилтийг тогтоох тус шалгалтаар VII ба X ангийн суралцагчид ямар амжилттай үнэлэгдсэн болохыг Зураг 2.2.5-д харууллаа.

Зураг 2.2.5. Стандартын хэрэгжилтийг үнэлэх судалгааны дүн: 7 ба 10-р ангид (2012)



Судалгааны дүнгээс харахад VII ангийн суралцагчдын математикийн шалгалтын гүйцэтгэлийн дундаж 39.1 хувьтай, X ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж 19.2 хувьтай байна. Монгол хэлний шалгалтын хувьд VII ангийн гүйцэтгэлийн дундаж 41.7 хувь, X ангийн дундаж 49.1 хувьтай тус тус гарсан байна.

**2013 онд** батлагдан гарсан журмын 4 дүгээр бүлгийн 4.2-т:

- “Улсын шалгалтын даалгаврыг бага, дунд боловсролын стандартад үндэслэн Боловсролын үнэлгээний байгууллага боловсруулж, шалгалтын товч хамт аймаг, нийслэлийн боловсролын газарт хүргүүлнэ. Боловсролын чанарыг тогтоох үндэсний судалгааг Боловсролын үнэлгээний байгууллага түүврийн аргаар зохион байгуулна.” гэж тусган өгсөн байна.
- Чанарын үнэлгээний судалгааг 2014 онд V, IX ангийн суралцагчдаас, 2015 онд V, IX, XII ангийн суралцагчдаас тус тус авсан байна. Шалгалтын агуулгыг тус журмын 4.1-т зааснаар зохион байгуулсан.

Хүснэгт 2.2.5. Сурлагын амжилтыг үнэлэх шалгалтын тоо ба агуулга: Боловсролын түвшингээр (2014–2018)

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын тоо	Шалгалтын агуулга
Бага	V	3	1. Монгол хэл 2. Математик 3. Байгаль шинжлэл
Суурь	IX	4	1. Монгол хэл (нэгдмэл агуулга) 2. Математик 3. Байгалийн ухаан (нэгдмэл агуулга) 4. Нийгмийн ухаан (нэгдмэл агуулга)
Бүрэн дунд	XII	4	1. Монгол хэл, уран зохиол (нэгдмэл агуулга) 2. Математик 3. Сонгосон агуулга: байгалийн ухаан, нийгмийн ухаан Гадаад хэл

2013 оны “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-д заасанчлан 2013-2014 оны хичээлийн жилд анх удаа чанарын үнэлгээний судалгааг зохион байгуулагдах боломж бий болсон байна. Тус журамд чанарын үнэлгээний судалгааны зорилго нь “Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага тэдгээрийн хэрэглээний чадварыг бодитой үнэлж, үндэсний хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөрийн хэрэгжилт, түүний чанарыг тодорхойлох зорилго”-той бөгөөд үндэсний түвшинд ЕБС-ийн V, IX, XII ангийн сурагчдын хамруулан зохион байгуулж, тайлагнадаг байна.


Чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд үндэсний хэмжээнд сурлагын амжилтын судалгааг тогтмол зохион байгуулах болсноор даалгавар боловсруулах, засаж үнэлэх арга зүй болон програм хангамж техник, технологийн чиглэлээр тодорхой ахиц дэвшил гараад байна.

- Сурлагын амжилтын судалгаа нь анх удаа бага боловсролын V, суурь боловсролын IX ангийн сурагчдыг хамруулан зохион байгуулсан бол түүнээс хойш бага, суурь, бүрэн дунд боловсролын V, IX, XII ангийн суралцагчдаас түүврийн аргаар нийт суралцагчдын 10 хувийг сонгох замаар судалгааг жил бүр зохион байгуулдаг болжээ.

- Үндэсний хэмжээнд албан ёсоор зохион байгуулж буй чанарын үнэлгээний судалгааг Кембрижийн олон улсын шалгалтын төвөөс зөвлөх үйлчилгээ авах замаар зохион байгуулсан бөгөөд тус зөвлөх үйлчилгээ нь судалгааг зохион байгуулах, сэдэв даалгавар боловсруулах, шалгалтын материалыг засах, үнэлэх, тайлагнах чиглэлээр 3 жилийн хугацаанд үргэлжилжээ.

Зөвлөх үйлчилгээний үр дүнд сэдэв даалгавар боловсруулах арга хандлага өөрчлөгдсөн бөгөөд сургалтуудаар дамжуулан хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах сургалтуудыг амжилттай зохион байгуулсан. Энэ нь цаашлаад олон улсын сурлагын амжилтын судалгааны суурийг тавьж өгсөн хэдий ч даалгавар боловсруулах чиглэлээр хүний нөөцийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх шаардлага байсаар байна. Судалгааны үр дүнг сүүлийн 3 жилээр харьцуулан Зураг 2.2.6-д харуулав.

Зураг 2.2.6. Сурлагын амжилтын судалгааны дүн: Боловсролын түвшингээр (2016–2018)



Сүүлийн 3 жилийн боловсролын түвшингээр харьцуулсан судалгааны дүнгээс харахад:

- Бага боловсролын хувьд сурлагын амжилт 52.6 – 41.7 хувьтай;
- Суурь боловсролын түвшинд сурлагын амжилт 40.3 – 37.1 хувьтай;
- Бүрэн дунд боловсролын түвшинд 34.7 – 39.9 хувьтай байна.

ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн доогуур үзүүлэлттэй байгаа нь олон хүчин зүйлсээс хамаарах боловч бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн менежментийг дэмжих, хөтөлбөрөө үнэлж сайжруулах шаардлага байгааг харуулж байна.

Чанарын үнэлгээний судалгааны хүрээнд тухайн ангийн сурагчдаас сурлагын амжилтыг тогтоох бичгийн шалгалт авахын зэрэгцээ түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахаар суралцагч, багш, эцэг эх, сургуулийн захирлаас асуулга судалгаанууд авч, судалгааны үр дүнд задлан шинжилгээ хийж, холбогдох байгууллагуудад судалгааны тайланг хүргүүлдэг.

### Сурлагын амжилтын судалгааны зохион байгуулалт ба тайлан түгээлт

2018 онд шинээр батлагдсан суралцагчийн үнэлгээний журмын 6 дугаар бүлэгт нийт 12 заалтад үндэслэн Боловсролын чанарын үнэлгээг зохион байгуулах үйл ажиллагаа зохион байгуулдаг байна.

- Тус судалгааны зорилго нь: “... суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ” хэмээн тодорхойлсон.
- Чанарын үнэлгээний судалгааг 2018-2019 оны хичээлийн жилд ЕБС-ийн III, X ангийн суралцагчдаас түүврээр, IX ангийн бүх суралцагчдаас авах ажлыг БСШУСЯ-тай хамтран БҮТ зохион байгуулахаар ажиллаж байна. Суурь боловсролын түвшингийн судалгаанд хамрагдсан бүх сургуулиудын үр дүнд үндэслэн боловсролын чанар, сурлагын амжилтыг тогтоох, хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгөөс үнэлгээ өгөх бодит нөхцөл байдлыг бүрдүүлж өгөх ач холбогдолтой юм.

### Сургалтын амжилтын сургуулийн өөрийн үнэлгээ


Боловсролын үнэлгээний байгууллага нь шалгалтын хуваарь гаргах, бюопринт боловсруулах, даалгаврын нээлттэй сан бүрдүүлэх, шинэчлэх, баяжуулах ажлыг хариуцан ажиллах үндсэн чиг үүрэгтэй.

Хүснэгт 2.2.6. Улсын шалгалтын агуулга (2010-2018)

	Бага - VI	Суурь - IX	Бүрэн дунд - XII
2010	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл</li> <li>Математик</li> <li>Англи хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг</li> <li>Математик</li> <li>Физик</li> <li>Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, уран зохиол</li> <li>Математик</li> <li>Сонгосон агуулга</li> </ul>
2013	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл</li> <li>Математик</li> <li>Байгаль шинжлэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг</li> <li>Математик</li> <li>БУ-ны нэгдмэл</li> <li>НУ-ны нэгдмэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, уран зохиол</li> <li>Математик</li> <li>Сонгосон агуулга</li> <li>Гадаад хэл</li> </ul>
2018	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл</li> <li>Математик</li> <li>Хүн ба байгаль</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол (нэгдмэл агуулга)</li> <li>Математик</li> <li>Сонгох шалгалт (суралцагч аль нэгийг нь сонгоно)                             <ul style="list-style-type: none"> <li>Байгалийн ухаан (нэгдмэл агуулга)</li> <li>Нийгмийн ухаан (нэгдмэл агуулга)</li> </ul> </li> <li>Гадаад хэл (англи хэл, орос хэлнээс нэгийг сонгох)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Сонгох шалгалт (хими, биологи, физик, газар зүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно.)</li> <li>Гадаад хэл (англи хэл, орос хэлнээс нэгийг сонгох)</li> </ul>

Боловсролын үнэлгээний төв нь 2014–2018 онуудад улсын шалгалтын материалыг боловсруулах, нууцлалыг ханган түгээх ажлын хүрээнд дараах ажлуудыг шинээр санаачилж хийсэн байна. (Зураг 2.2.7)

Зураг 2.2.7. Улсын шалгалтын зохион байгуулалтын онцлог (2014-2018)



2017–2018 оны хичээлийн жилд зохион байгуулагдсан улсын шалгалтад нээлттэй даалгаврын сангийн анхны хувилбарыг нэвтрүүлсэн бөгөөд Боловсролын үнэлгээний төв нь нийт 14055 даалгавар боловсруулсан байна. Боловсролын түвшин тус бүрээр боловсруулсан даалгаврын тоог Зураг 2.2.8-д харууллаа.


Зураг 2.2.8. Нээлттэй даалгаврын сан дахь даалгаврын тоо



Боловсролын түвшин болон шалгалтын агуулга тус бүрээр боловсруулсан блопринтийг ашиглан сургуулийн шалгалт зохион байгуулах комисс 1 өдрийн өмнө шалгалтын материалыг даалгаврын нээлттэй сангаас боловсруулж, нууцлалыг хангахаар тусган өгсөн байдаг.

2015-2018 онуудад зохион байгуулагдсан улсын шалгалтын үр дүнг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшингээр нь харьцуулан Зураг 2.2.9-т харууллаа.

Зураг 2.2.9. Улсын шалгалтын үр дүн (2014/15-2017/18 оны хичээлийн жил)



Зургаас харахад боловсролын тухайн түвшний эцсийн үнэлгээний үзүүлэлтэд савалгаа бага байгаа нь харагдаж байна. Тухайлбал, бага боловсролын V анги төгсөгчдийн хувьд гүйцэтгэлийн зөрүү 7.1 хувийн, суурь боловсролын түвшинд 3 хувийн, бүрэн дунд боловсролын түвшинд 4.3 хувийн хооронд хэлбэлзэлтэй шалгагдсан байна.


2018 оны сургуульд суурилсан үнэлгээ болон үндэсний хэмжээнд зохион байгуулагддаг чанарын үнэлгээний харьцуулсан дүнг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин тус бүрээр Зураг 2.2.10-2.2.12-д үзүүлэв.

Зураг 2.2.10. Бага боловсролын төгсөх ангийн улсын шалгалт болон чанарын үнэлгээний дүн (2018)




Бага боловсролын V дугаар ангийн суралцагчдаас авсан улсын шалгалт, чанарын судалгааны дүнгээс харахад сургуулийн өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний хооронд 31.1–41.1 хувийн зөрүү байна.

Зураг 2.2.11. Суурь боловсролын төгсөх ангийн улсын шалгалт болон чанарын үнэлгээний судалгааны дүн (2018)



Суурь боловсролын IX ангид зохион байгуулагдсан улсын шалгалт ба чанарын судалгааны дүнг шалгалтын агуулга тус бүрээр гаргасан дүнгээс харахад сургуулийн өөрийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээний 29.4 – 46.8 хувийн зөрүүтэй байна.

Зураг 2.2.12. Бүрэн дунд боловсролын төгсөх ангийн улсын шалгалт болон чанарын үнэлгээний дүн (2018)



Харин бүрэн дунд боловсролын XII дугаар ангийн суралцагчдаас авсан улсын шалгалт бачанарын судалгааны дүнгээс харахад сургуулийн өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний зөрүү 30.1 – 51.5 хувьтай байна.


ЕБС-ийн түвшинд зохион байгуулагдаж буй хөндлөнгийн болон сургуулийн өөрийн үнэлгээний зөрүү их байгаагаас харахад БСШУСЯ-ны харьяа мэргэжлийн байгууллагууд суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэх ном, гарын авлага, модульд сургалтуудыг шат дараалан зохион байгуулах хэрэгтэйг харуулж байна. Мөн үнэлгээний даалгаврыг боловсруулахдаа танин мэдэхүйн түвшний доод эрэмбийн даалгавраас илүүтэй дээд эрэмбийн сэтгэх чадварыг сорьсон асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах, бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэх даалгавар боловсруулах аргазүйг багш нарт эзэмшүүлэх хэрэгтэй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

### Суралцахуйн анги танхим дахь үнэлгээ

1995, 1998 онуудад батлагдсан журмуудад үнэлгээний хэлбэрүүдийг тусгайлан заагаагүй боловч үнэлгээ хийхдээ суралцагчийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон, сурах хүсэл эрмэлзэл, сонирхлыг төрүүлсэн, тэдний суралцах үйлийг дэмжиж, хөгжилд чиглүүлсэн, тэдний авьяас чадварыг нээн илрүүлэхэд чиглэсэн, идэвхжүүлсэн, урам хайрласан, ил тод, нээлттэй байхаар нийтлэг зарчмыг тусган өгсөн байна.

1995 оноос хойш батлагдан мөрдөгдөж байсан журмуудад анги танхимд хэрэгжүүлэх үнэлгээг хэрхэн тусгасан болохыг нэгтгэн Зураг 2.2.13-д харууллаа.

Зураг 2.2.13. Анги танхимд хэрэгжүүлэх үнэлгээ (1995-2018)



Зургаас харахад анги танхимд явцын үнэлгээг хийх талаар тусгасан байгаа боловч үнэлгээний хэлбэр, төрлийг төдийлөн нарийн тусгаж өгөөгүй байсан ба 2013 онд цухас төдий дурдсан бол 2018 онд шинэчлэгдэн гарсан журамд шалгуурт суурилсан үнэлгээний хэлбэр, төрлийг тодорхой зааж өгсөн байна.

АХБ-ны Техник туслалцааны төслийн хүрээнд 2016 онд хийсэн “*Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс*” судалгааны тайланд “...явцын үнэлгээний ач холбогдлын талаар багш нар нэгдмэл ойлголттой боловч түүнийг мөн чанараар нь сургалтад хэрэглэж чадахгүй байгааг тэмдэглэн, багш нарын чадавхыг бэхжүүлэхэд анхаарах нь зүйтэй ...” гэж дурдсан байна (ADB, TA-8931 MON, 2017). Мөн тус судалгааны дунд хугацааны тайланд анги танхимд хийгдэж буй бодит үнэлгээ нь дорвитой өөрчлөгдөөгүй, хөндлөнгийн шалгалт, багш нарын үнэлгээ нь мэдлэг голлосон, чадварыг үнэлэхэд чиглэдэггүй хэвээр байна гэжээ. Түүнчлэн лаборатори болон лаборатори бус сургуулиудын багш нарын 80 гаруй хувь нь явцын үнэлгээний ач холбогдлыг чухал гэдэг дээр санал нэг байгаа бөгөөд “явцын үнэлгээг хичээлийн төлөвлөгөөнд тусгах нь маш чухал” гэж үзсэн ба багш нарын 50 орчим хувь нь явцын үнэлгээг хийхэд илүү их дэмжлэг, үнэлгээний хялбаршуулсан заавар удирдамж, гарын авлага хэрэгтэй гэжээ. Мөн ЮНЕСКО-ийн бүсийн төвөөс Монгол Улсын боловсролын үнэлгээний тогтолцоонд хийсэн шинжилгээний тайланд “...сурагчдын мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний талаарх багш нарын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, үнэлгээний олон төрлийн аргазүйд сургах, багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт үнэлгээний асуудлыг онцгойлон авч үзэх”-ийг зөвлөмжилсөн байна (UNESCO Bangkok, 2015).

ЮНЕСКО-ийн Бангкок дахь салбарын ERI-NET судалгааны төвөөс 2013 онд .... XXI зуунд эзэмшвэл зохих шинэ чадамжуудыг тодорхойлж гаргасан байдаг. Ази-Номхон далайн бүсийн орнууд тэдгээр чадамжийг үндэсний, сургуулийн, багшийн түвшинд үнэлж буй сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор үе шаттай судалгаа зохион байгуулж байна. Уг судалгаанд манай улс 2015 онд хамрагдсан бөгөөд “...суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд дэмжлэг үзүүлэх ном, гарын авлага багш нарт хомс болохыг судалгаанд оролцогчид дурдсан”-ыг тайланд тэмдэглэжээ (UNESCO-NEQMAP, 2016). Иймд суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлэхэд багш нарын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг үнэлгээний олон төрлийн аргазүйд сургах,

багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт үнэлгээний асуудлыг онцгойлон авч үзэх шаардлагатай байна. ЕБС-ийн багш нарт явцын үнэлгээний арга хэрэгслийг боловсруулж эзэмшүүлэх шаардлагатай байгаа нь шинэ журмыг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа бэрхшээлүүдийн нэг байна.

### Дүнгийн шатлал

1995 онд батлагдсан суралцагчийн үнэлгээний журмаар дүнгийн шатлалыг “онц”, “сайн”, “дунд”, “хангалтгүй” гэсэн 4 шатлалаар үнэлж байсан бөгөөд 1998 оны шинэчилсэн журмаар А, В, С, D, F гэсэн үнэлгээний 5 шатлал руу шилжсэн байна. Түүнээс хойш шинэчилсэн журмуудад дүнгийн шатлал хэрхэн тусгагдсан болохыг дараах зургаар харуулъя. (Зураг 2.2.14)

Зураг 2.2.14. Суралцагчийн үнэлгээний журам дахь дүнгийн шатлал



Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшил (дадал)-ийг үнэлж дүгнэх журам өөрчлөгдөхдөө дүнгийн шатлалын хувьд дээрх байдлаар өөрчлөгдөж ирсэн байна.

Сүүлийн жилүүдэд дэлхийн боловсрол, судалгааны байгууллагаас XXI зууны суралцагчийн эзэмшвэл зохих чадварыг судлан тогтоож, дэлхий нийтээрээ тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хөгжлийн чиг хандлага болгосон. Иймээс 2018 онд батлагдан гарсан журамд суралцагчийн хандлага төлөвшлийг үнэлэхээр тусгасан бөгөөд *хандлага гэдэг нь тухайн хүний байр байдал, аливаа зүйлд хандах хандлагын илэрхийлэл* юм. Харин “төлөвшил” гэдгийг боловсролын тухай хуулийн 3.1.11 заалтад “*суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогц*” гэж тодорхойлсон байдаг. Иймээс зөвхөн хандлага эсвэл төлөвшлийг үнэлэх нь оновчгүй хэмээн үзэж хандлага төлөвшил гэдгийг хамтад нь авч үзэхээр тус журамд тусгажээ.

Суралцагчийн хандлага, төлөвшлийг үнэлж дүгнэх асуудлыг өмнөх журмуудад “төлөвшилийг үнэлэх, хандлагыг үнэлэх” гэх зэргээр тусгасан боловч, ямар шалгуураар хэрхэн үнэлэхийг тодорхой заагаагүй байсан бол 2018 онд баталсан журамд суралцагчийн хандлага төлөвшлийн дараах шалгуурыг хэрэглэн үнэлэх аргачлалыг зааж өгсөн байна. Үүнд:

- Санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил маргааныг эв дүйгээр шийдвэрлэх байдал
- Бие даан суралцах барил, бусадтай хамтран ажиллах байдал
- Шинжлэн судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо
- Соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч, ажил хэрэгч байдал,
- Хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах, байгальтай харьцах хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт
- Шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт

### Сурлагын амжилтыг үнэлэх олон улсын судалгаа (PISA)

“Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” (УИХ-ын 12 дугаар тогтоол, 2015)-ын 4.8-д “*сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандарт, цөм хөтөлбөрийг төрөөс тогтоож, чанар, үр дүнг үнэлнэ*” гэж, Бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийн 7.8-д



“Сурлагын амжилтын олон улсын чанарын үнэлгээний судалгаанд 2021 онд хамрагдана” гэж заасан.


“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030” (ЗГ-ын 19 дүгээр тогтоол, 2016)-д чанарын баталгаажилтын талаар “Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд (PISA) хамрагдах бэлтгэлийг хангах” чиглэлийг тусгасан.

Монгол Улсын хөгжлийн чиг хандлага, төрөөс баримталж буй бодлого, үндэсний хөтөлбөрүүдэд боловсролын салбарт баримтлах бодлогын чиглэлд “Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд (PISA) хамрагдах” шийдвэрийг тусгасан.

Олон улсын сурлагын амжилтын судалгаа нь “Улс орнуудад боловсролын салбарын бодлогын түвшиний шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах” зорилготойгоор зохион байгуулагддаг ба Монгол Улс энэ судалгаанд боловсролын чанарыг дээшдүүлэх бодлого боловсруулах, хөтөлбөр, сурах бичгийн агуулгыг сайжруулахад суурь судалгаа болгон ашиглах, өөрийн орны сурлагын амжилтыг олон улстай харьцуулах зорилготойгоор оролцож байна.

Дээр дурдсан бодлого, чиглэлд үндэслэн салбарын хүрээнд олон улсын судалгаанд оролцох чиг үүргийг Боловсролын үнэлгээний байгууллага хүлээн ажиллаж байна. Энэ удаагийн сурлагын амжилтын судалгаа нь өмнөх судалгаануудаас ялгагдах онцлогтой бөгөөд шинээр суралцагчдын бүтээлч сэтгэлгээний чадамжийг үнэлэхээр тусгасан байна. Олон улсын судалгаа нь дараах агуулгын хүрээнд зохион байгуулагдана. (Зураг 2.2.15)

Зураг 2.2.15. Сурлагын амжилтыг үнэлэх ОУ-ын судалгааны шалгалтын агуулга



Судалгааг компьютерт суурилсан (computer-based) хэлбэрээр зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлуудыг ханган ажиллаж байна.

**Элсэлтийн ерөнхий шалгалт**

Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам (БСШУ-ы Сайдын 422 дугаар тушаал, 2005) болон Элсэлтийн ерөнхий шалгалтын журам (БҮТ-ийн захирлын 8 дугаар тушаал, 2006)-ыг тус тус үндэслэн жил бүр их, дээд сургуульд элсэгчдээс элсэлтийн ерөнхий шалгалтыг зохион байгуулж байна.

Тус шалгалт нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэд дараагийн шатны их, дээд сургууль элсэн суралцах ерөнхий чадвар, мэдлэгийн түвшинг тогтоох зорилготой бөгөөд олон улсын жишиг, аргачлалын дагуу зохион байгуулагддаг. Элсэлтийн ерөнхий шалгалтыг математик, монгол хэл, нийгэм судлал, англи хэл, орос хэл, газар зүй, физик, биологи, хими, МУ-ын түүх гэсэн 10 хичээлээр шалгалтын зорилготойгоо уялдуулан боловсролын стандарт, агуулгын хүрээнд бюпринтийн дагуу сорил даалгаврыг боловсруулдаг. Сорил даалгавар нь Блумын таксаномийн танин мэдэхүйн түвшинд тулгуурлан боловсруулагддаг.

Элсэлтийн ерөнхий шалгалтын үнэлгээг олон улсад ашиглагддаг үнэлгээний аргачлалаар тооцон шалгуулагчдын амжилтыг анхны оноо (raw score), хэмжээст оноо (scaled score), проценталь оноо (percentage score) гэсэн гурван үзүүлэлтээр эрэмбэлэн дүгнэж байна. Элсэлтийн ерөнхий шалгалтыг жилд дунджаар 40.000 орчим суралцагчид өгдөг бөгөөд улсын дундаж үзүүлэлтийг сүүлийн таван жилээр Хүснэгт 2.2.7-д нэгтгэн харууллаа.

Хүснэгт 2.2.7. ЭЕШ-ын улсын дундаж үзүүлэлт (2014-2018)

Шалгалтын агуулга	2014 он		2015 он		2016 он		2017 он		2018 он	
	а.оноо	х.оноо	а.оноо	х.оноо	а.оноо	х.оноо	а.оноо	х.оноо	а.оноо	х.оноо
Математик	23	500	25	500	28	500	29	500	29.1	500.1
Монгол хэл	52	500	55	499	48	499	50	500	51.2	500.0
Нийгмийн тухай мэдлэг	45	501	45	500	47	500	43	500	53.1	500.1
Англи хэл	29	500	31	500	33	500	46	500	33.2	500.1
Орос хэл	49	527	55	521	56	511	59	515	68.2	535.3
Газар зүй	34	500	25	499	34	500	41	499	44.7	500.0
Физик	28	499	29	500	25	500	31	500	25.5	500.1

Биологи	37	499	46	500	45	500	44	500	46.0	500.2
Хими	24	500	31	500	31	499	26	500	28.0	500.4
МУ-ын түүх	36	500	34	499	43	500	33	500	37.3	500.0

Элсэлтийн шалгалтын сүүлийн 5 жилийн ерөнхий үр дүнгээс харахад математик, байгалийн ухааны хичээлийн шалгалтуудын анхны онооны дундаж 4-10 оноогоор, нийгмийн ухааны хичээлийн шалгалтуудын дундаж 4-19 оноогоор ахисан үзүүлэлттэй байна.

Их, дээд сургуульд элсэгчдийн анхны онооны дундаж доогуур үзүүлэлттэй байгаатай холбогдуулан босго оноог 400-450 байсныг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн БСШУС-ын Сайдын А/195 тоот тушаалаар их, дээд сургуульд элсэн суралцах босго оноог төрийн өмчийн их, дээд сургуульд 480 байхаар тогтоосон нь элсэгчдийн чанарыг дээшлүүлэх, дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт, хөтөлбөрийн чанарыг сайжруулах, ажил олгогчдын зүгээс тавьж буй шаардлагад нийцсэн боловсон хүчин бэлдэхэд чухал нөлөө үзүүлнэ хэмээн үзэж байна.

Мөн бүрэн дунд боловсрол эзэмшин дараагийн шатны сургуульд элсэн суралцах хүсэлтэй шалгуулагчдад шалгалт өгөх тэгш боломжийг олгох зорилгоор тусгай хэрэгцээт боловсролын сургуулийг төгссөн шалгуулагчдын шалгалт өгөх орчинг бүрдүүлж сэдэв даалгаврыг тэдний хөгжлийн бэрхшээлд нийцүүлэн брайлаар хэвлэх, үсгийн хэмжээг томруулах, сонсоод ойлгох шалгалтыг багшаар дамжуулан асуух, саажилттай шалгуулагчдын хариултын хуудсыг бөглөхөд нь туслах багшийг шалгалтын байранд ажиллуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Цаашид их, дээд сургуульд мэргэжлийн хөтөлбөрөөр элсэн суралцаж буй суралцагчдын сурлагын амжилт, хэв шинж болон хандлага төлөвшлийг судлах, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох шаардлага бий болоод байна.

Мөн их, дээд сургуульд элсэгчдийн чанарыг сайжруулах, мөн бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг сайжруулах, ЭЕШ-ыг улам боловсронгуй болгох зорилгоор 2018 онд АХБ-ны санхүүжилтээр Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд “Элсэлтийн ерөнхий шалгалтын хичээл сонголтыг боловсронгуй болгох” ажлын хэсэг байгуулагдан ажиллаж 2 хувилбар бүхий саналыг гарган БСШУС-ын яаманд хүлээлгэн өгөөд байна. Хичээл сонголтыг боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан төслийг их, дээд сургуулийн хөтөлбөрийн албаны багш нараар хэлэлцүүлэн эцсийн дүгнэлт, шийдвэрийг гарган үйл ажиллагаанд нэвтрүүлнэ.

### **Дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ**

Дээд боловсролын сургалтын байгууллага (ДБСБ), тэдгээрийн хөтөлбөрийн хөгжил, чанарын баталгаажуулалт хийгдэж, холбогдох судалгаанууд явагдаж буй хэдий ч ижил мэргэжлийн хөтөлбөрүүдээр суралцаж буй суралцагчдын чанарыг өөр хооронд нь харьцуулах, суралцагчдад эзэмшүүлж буй мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг хөндлөнгөөс үнэлж дүгнэх тогтолцоо хараахан бүрэн төлөвшөөгүй байна. Өөрөөр хэлбэл, дээд боловсролын сургалтын байгууллагуудад элсэн суралцаж буй суралцагчдын оролтын талаарх мэдээлэл байдаг боловч явц буюу сургалтын чанар, гаралт буюу төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага, төлөвшлийг үнэлж дүгнэх хөндлөнгийн хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоо байхгүй байна. Дээр дурдсан байгууллагууд өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааныхаа хүрээнд тус тусдаа судалгаа, шинжилгээний ажлуудыг хийдэг боловч тэдгээр нь ДБСБ-ын сургалтын чанар, суралцагчдын мэдлэг, чадварын түвшин болон ажлын байран дээр ажил олгогчоос тавьж буй шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлэх ажил дутмаг байна.

Мөн ДБСБ-ын сургалтын чанарт үнэлгээ өгөгдөхгүй байгаагаас бодлого боловсруулах, шийдвэр гаргах, хэрэгжилтэд үнэлгээ өгөх зэрэгт шаардагдах хангалттай баримт нотолгоо байхгүй байна. Өөрөөр хэлбэл, ДБСБ-ын сургалтын үйл ажиллагааг хөндлөнгөөс үнэлэх, хяналт-шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах ажил дутагдалтай байна гэж үзэж болно.

Тухайлбал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс жил бүр гаргадаг “**Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, 2017**” тайланд

*Хөдөлмөрийн зах зээлд ажил олгогчдын хүсээж буй зан чанар, ажлын хариуцлага, хандлага, эерэг зан чанар гэх мэт зөөлөн ур чадвар сул байгаагаас хамаарч ажиллах хүчний хомсдол бий болоод байна. Мөн ажиллах хүчний хомсдол бий болоход ажил олгогчдын хувьд шинээр авах ажилтны боловсрол, мэргэжлийн ур чадвар, ажлын туршилага шаардлага хангахгүй байгаа бол ажил хайгчдын хувьд ажлын байрны нөхцөл, цалин хөлс голох байдал, тогтвор суурьшилтай*

ажиллахгүй байх зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлж байгаа талаар дурдсан байна. Дээрх судалгааны үр дүнг бататгасан өөр нэгэн мэдээлэл нь хөдөлмөр эрхэлж буй төгсөгчидөд хамгийн түгээмэл тохиолддог ур чадварын дутагдлуудад багаар ажиллах чадвар, харилцааны ур чадвар, гадаад хэлний мэдлэг, математик сэтгэлгээ, тооцоолон бодох зэрэг чадваруудыг нэрлэн дурджээ.

Мөн уг тайланд ДБСБ-ыг төгсөгчдийн ажилд орох хүртэл зарцуулсан хугацаанд хийсэн шинжилгээний дүнг танилцуулсан ба судалгаанд хамрагдагчдын 10.1 хувь нь төгсөхөөсөө өмнө, 25.7 хувь нь 3 хүртэл сарын дотор, 12.8 хувь нь 4-6 сарын дараа, 22.1 хувь нь 7-12 сарын дараа, 28.9 хувь нь 13 ба түүнээс дээш сарын дараа ажилд орсон хэмээсэн байна. Их дээд сургуулийг төгссөн нийт төгсөгчдийн 68.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагаас 69.6 хувь нь эзэмшсэн мэргэжлээрээ, 9.8 хувь нь өөрийн эзэмшсэн боловсролын түвшнээс доогуур ур чадвар шаардсан ажлын байранд ажиллаж байна хэмээн дурджээ. Энэ байдал нь боловсролтой ажилгүйчүүдийн тоог нэмэгдүүлэхэд хүргэж байна.

Иймээс ажил олгогчдын зүгээс тавьж буй нийтлэг шаардлагад нийцсэн мэдлэг, чадвартай боловсон хүчин бэлтгэн гаргахын тулд дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөр түүнд тавигдах шаардлагуудыг сайжруулах, сургалтын чанар, суралцагчдын сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ хийж байх тогтолцоо, механизмыг зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Боловсролын үнэлгээний төв нь чиг үүргийнхээ хүрээнд дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар, элсэлт, төгсөлтийн дүнгийн мэдээллийг судалгааны үндсэн хэрэгсэл болгон 3 жил дараалан бичиг баримт болон оюутны сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулсан байна. Судалгаа хийсэн огноо болон хамрагдсан мэргэжлийн хөтөлбөрүүдийг Зураг 2.2.16-д нэгтгэн харууллаа.

Зураг 2.2.16. Судалгаа хийсэн мэргэжлийн хөтөлбөрүүд



Жил дараалсан эдгээр судалгаа нь дараах бүтэцтэйгээр зохион байгуулагдсан байна. Үүнд:

- II курст суралцагчдын ЭЕШ-ын дүн оноо ба мэргэжлийн суурь хичээлийн харьцуулсан судалгаа
- Судалгаа зохион байгуулж буй жилд төгссөн төгсөгчдийн мэргэжлийн хичээлүүдийн дипломын дүнгийн дунджийг ЭЕШ-ын дүн оноотой жишин харьцуулсан судалгаа
- Төгсөх ангийн оюутнуудаас сонгон суралцсан хөтөлбөрийн талаарх сэтгэл ханамжийн асуулга судалгаа
- Дээд боловсролын сургалтын байгууллагын багшлах нөөцийн судалгааг үндсэн мэргэжлийн багш нарын мэдээллийг үндэслэн хийж сургуулиудыг хооронд нь харьцуулсан судалгаа
- Мэргэжлийн багш нарын асуулга судалгаа.

Судалгаанд нийтдээ 75 сургуулийн 5672 төгсөх ангийн суралцагчийн сэтгэл ханамжийн болон 342 багшийн асуулга судалгааны үр дүнг нэгтгэн шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна. Нийт 3 удаагийн судалгааны явцаас дараах нийтлэг нөхцөл байдлууд ажиглагдсан байна. Үүнд:

- Мэргэжлийн чиглэл бүрээр сургуулиудын элсэгчдийн анхны онооны дундаж хамгийн өндөр ба бага байгаа үзүүлэлтүүдийн зөрүү маш их байна. Тухайлбал, математикийн хичээлээр элсэлтийн шалгалт өгч бага оноо авсан элсэгчид дээд математикийн хичээлд өндөр үнэлгээтэй шалгагдсан байна.

- Дипломын голч дүнгээс болон мэргэжлийн хичээлийн голч дүнг ялган хооронд нь харьцуулж үзэхэд бараг бүх тохиолдолд мэргэжлийн хичээлийн голч дүн арай хатуу шаардлага өндөртэй үнэлэгдсэн байдал ажиглагдаж байсан байна.
- Төрийн бус өмчийн сургуулиудад дүнгийн хөшүүрэг хэмээн нэрлэж болохуйц үзэгдэл мэргэжлийн аль ч чиглэлийн судалгаан дээр байнга тохиолдож байна гэсэн дүгнэлтийг судлаачид гаргасан байна.

Дээрх судалгаануудад үндэслэн цаашид ДБСБ-ын сургалтын хөтөлбөрийг харьцуулан судлах замаар сургалтын чанарыг хөндлөнгөөс үнэлэх ажлын хүрээнд БСШУСЯ-ны захиалгаар БҮТ нь дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүн болох суралцагчдын сурлагын чанарт хөндлөнгийн үнэлгээ хийх, суралцагчдын хэв шинж (temperament), хандлага төлөвшлийг судлах ажлыг 2018 оноос эхлүүлээд байна.


Цаашид их, дээд сургуульд мэргэжлийн хөтөлбөрөөр элсэн суралцаж буй суралцагчдын сурлагын амжилт, хэв шинж болон хандлага төлөвшлийг судлах, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох шаардлага бий болоод байна.

### Багшийн ажлын үнэлгээ, дүгнэлт

БСШУ-ны Сайд, НХХ-ийн Сайд, Сангийн Сайдын 2007 оны **307/91/237** тоот хамтарсан тушаалаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам батлах тухай” журмыг баталсан. Энэ журмаар өмнө нь олон жилийн туршид багшийн ажлыг 40-45 минутын ээлжит хичээлээр хэмждэг байсан журмыг халж, суралцагч өөрийн бүтээлч үйлээрээ шинэ мэдлэгээ бүтээх суралцахуйн шинэ зарчмыг хэрэгжүүлэх боломжийг багшид олгодог байхаар тэдний ажлыг төлөвлөх, хэмжиж үнэлэх нэгжийг хэд хэдэн ээлжит хичээлийн цогц болох “нэгж хичээл” болгож томсгожээ.

Улмаар багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг БСШУ-ны Сайдын 2007 оны 351-р тушаалаар баталж, багш албан тушаалтны үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа (Зураг 2.2.17) тэдгээрийг гүйцэтгэхэд тавигдах ерөнхий шалгуур индикаторууд (Хүснэгт 2.2.8) шинэчлэгдсэн байна.

Зураг 2.2.17. Багшийн ажлын үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа



БСШУ-ны Сайдын 2009 оны 561 тоот тушаалаар батлан 2013 он хүтэл мөрдөж байсан “Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэхэд баримтлах журам”-д сонгосон багшийн ажлыг үнэлэх шалгуур индикаторууд (Хүснэгт 2.2.8) нь ЕБС-ийн багшийн ажлын байрны тодорхойлолтод үндэслэн энэ албан тушаалтны гүйцэтгэх ёстой үндсэн чиг үүрэг, гол түйл ажиллагаанд төвлөрсөн, мөн багш ажлаа төлөвлөх, үнэлүүлэх, дүгнүүлэх харилцан уялдаатай 3 үйл ажиллагааны холбоо хамаарлыг хангахад чиглэж байсан онцлогтой (БСШУ-ны Сайдын 561 дүгээр тушаал, 2009).

Хүснэгт 2.2.8. Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх шалгуур индикатор (2009-2013)

Шалгуур	Индикатор
<b>1. Стандартыг хэрэгжүүлэх ажлын шалгуур, үзүүлэлт</b>	
<b>1.1. Нэгж хичээлийн хөтөлбөрийн боловсруулалт</b>	<b>а.</b> Тухайн ангийн суралцагчдын бие бялдар, оюун ухаан, сэтгэл нийгэмшихүйн хөгжлийн онцлог, тэдний хэрэгцээ сонирхол, мэдлэгийн өмнөх төсөөллийн оношилсон байдал
	<b>б.</b> Суралцагчдынхаа оношлогоонд суурилан, стандартад тодорхойлогдсон цогц чадамжийг сургалтын товлосон зорилт болгон нарийвчилсан байдал
	<b>в.</b> Анги хоорондын агуулгын залгамж холбоог хангаж, төлөвлөсөн хугацаанд сургалтын товлосон зорилт хэрэгжих боломжтой байхаар сургалтын агуулгаа сонгосон байдал
	<b>г.</b> Сонгосон агуулгаа үр өгөөжтэй эзэмшүүлсэн байхаар мэдлэг бүтээлгэх технологит суурилсан дидактик шийдэл, суралцахуйн үйл бүрд харгалзуулан оновчтой сонгосон бүтээлч аргууд бүхий сургалтын арга зүйг боловсруулсан байдал
	<b>д.</b> Боловсролын үнэлгээний стандартын шаардлагын хэрэгжилт болон сургалтын товлосон зорилтоо бодитой үнэлэхүйцээр үнэлгээний агуулга, гүйцэтгэлийн төрлийг оновчтой сонгож, бүх сурагчдад тэгш боломж олгосон үнэлгээний даалгавар боловсруулсан байдал
	<b>е.</b> Суралцагчдын гүйцэтгэлийг үнэлж, тэдний суралцахуйд гарсан өөрчлөлтийг үнэлэх арга зүйг боловсруулсан байдал
<b>1.2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сайжруулалт</b>	<b>а.</b> Хичээлийн явц, үр дүнгийн судалгаа хийсэн байдал
	<b>б.</b> Хичээлийн хэлэлцүүлэгт оролцсон тоо, оруулсан хувь нэмэр
	<b>в.</b> Сургалтын дараа сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болох хэрэгцээ, зорилт, агуулга, арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээг боловсронгуй болгох чиглэлээр оруулсан өөрчлөлт
	<b>г.</b> Хичээлийн загвар, төрөл, дизайн, төлөвлөлтөд оруулсан өөрчлөлт
<b>1.3. Сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалт, ашиглалт, сургалтын үйлийн болон сэтгэл зүйн орчин бүрдүүлэлт</b>	<b>а.</b> Сонгосон агуулга, арга зүй, үнэлгээнд нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэсэн арга технологи, хэрэглэгдэхүүний төрөл, хүртээмжийн байдал
	<b>б.</b> Сургалтын хэрэглэгдэхүүнийг тогтмол, үр өгөөжтэй, ариг гамтай хэрэглэсэн байдал
	<b>в.</b> Сургалтад мэдээлэл харилцааны технологийг ашигласан байдал
	<b>г.</b> Сургалтын хэрэглэгдэхүүний сэтгэл зүй, жендэр, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан байдал
<b>1.4. Суралцагчдын хөгжил, төлөвшилд гарсан өөрчлөлт</b>	<b>а.</b> Суралцагчдын сурлагын амжилтын өөрчлөлт
	<b>б.</b> Суралцагчдын бие бялдар, оюун ухаан, сэтгэл нийгэмшихүйн хөгжилд гарч байгаа өөрчлөлтийг бодитой тогтоосон байдал
	<b>в.</b> Суралцагчдын сурлагын амжилт, хөгжил, төлөвшилд гарсан өөрчлөлтийн мөрөөр хийсэн ажил
<b>2. Бусад ажлын чанарыг үнэлэх шалгуур үзүүлэлт</b>	
<b>2.1. Сургалтад үзүүлэх дэмжлэг</b>	<b>а.</b> Сургууль, танхимын орчныг тохижуулахдаа суралцагч, багш, ажилчдын эрүүл мэнд, сэтгэл зүйд нийцсэн, сургалт, хүмүүжлийн ажлын технологийн шаардлагыг хангасан, сурагч, багш, ажилтан, эцэг эхэд дарамтгүйгээр шийдсэн байдал
	<b>б.</b> Хичээлээс гадуурх үйл ажиллагааг үр өгөөжтэй төлөвлөж, зохион байгуулсан байдал, суралцагч, эцэг эхийн сэтгэл санамжийн түвшин
	<b>в.</b> Боловсролын бичиг баримт боловсруулах, хөтлөх стандартыг хангасан байдал
<b>2.2. Иргэд, олон нийтийн хамтын ажиллагаа</b>	<b>а.</b> Төрийн алба, Боловсролын болон бусад хууль, тогтоомжийн мэдлэг, түүнийгээ хэрэглэх болон шийдвэр гаргах чадвар
	<b>б.</b> Нийгэмд хандсан үйл ажиллагаа явуулж, эцэг эх, иргэд, олон нийтийн хамтын ажиллагаанд оруулсан хувь нэмэр
<b>2.3. Багшийн хөгжил</b>	<b>а.</b> Судалгааны ажлын арга зүйг эзэмшсэн байдал, хэрэглэх чадвар
	<b>б.</b> Гадаад хэлээр мэдээлэл ашиглах, харилцах чадвар
	<b>в.</b> Мэдээлэл харилцааны технологи ашиглах, мэдээлэл боловсруулах чадвар

БСШУ-ны Сайдын 2013 оны А/293 тоот тушаалаар батлан мөрдөж буй “ЕБС-ийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-д багшийн ажлыг үнэлэхээр сонгосон шалгуур индикаторууд (Хүснэгт 2.2.9) нь “багш” албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа (ажил)-ны гүйцэтгэлийг үнэлэхэд бус харин суралцагч бүрийнхээ хөгжил, төлөвшилд оруулах хувь нэмрийг үнэлэхэд чиглэсэн онцлогтой байна. Бодит амьдрал дээр хүүхэд бүрийн хөгжил төлөвшилд оруулсан багшийн хувь нэмэр, тэдгээрт гарсан ахиц, амжилтыг эцэг эх, асран хамгаалагч, болон эрүүл мэнд мэтийн төрийн үйлчилгээний бусад субъектүүдийн хувь нэмрээс ялгаж бодитоор үнэлэх нь нарийн төвөгтэй асуудал юм.

*Хүснэгт 2.2.9. Багшийн үнэлгээний шалгуур*

Шалгуур	Индикатор
1. Төлөвшил	<p><b>а.</b> Хүүхэд нэг бүрийн сургуулийн болон нийгмийн орчны хэм хэмжээг дагаж мөрдөж байгаа байдал, эрмэлзэл</p> <p><b>б.</b> Хүүхэд нэг бүрийн нийгмийн орчинд өөрийгөө зөв авч явах, илэрхийлэх, бусадтай зөв харилцах (ажилсаг, эвсэг, тусархаг) зан чанар төлөвшүүлсэн байдал</p>
2. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилт	<p><b>а.</b> Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахицын түвшин</p> <p><b>б.</b> Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын улирлын амжилтын үнэлгээ</p>
3. Авьяасыг нээн хөгжүүлсэн байдал	<p><b>а.</b> Авьяасыг судалсан, нээсэн байдал</p> <p><b>б.</b> Авьяасыг хөгжүүлсэн байдал (сурсан, чаддаг болсон зүйлийн тоо, чанар)</p>
4. Боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж	<p>Сурагч, эцэг эх, асран хамгаалагч, бусад оролцогчдоос авсан санал асуулгын үр дүн:</p> <p><b>а.</b> Багшийн хүүхэд нэг бүрийн хөгжилд үзүүлсэн дэмжлэг</p> <p><b>б.</b> Багшийн ёс зүй</p>
5. Эрүүл мэндийн байдал	<p><b>а.</b> Хүүхдийн эрүүл мэндийг сайжруулсан байдал</p> <p><b>б.</b> Эрүүл харилцааг бүрдүүлэхэд оруулсан хувь нэмэр</p> <p><b>в.</b> Эрүүл аюулгүй орчин бүрдүүлэхэд оруулсан хувь нэмэр</p>

Дээрх журмуудад багшийн ажлын гүйцэтгэлийг хувиар илэрхийлж, дараах түвшингүүдээр үнэлэхээр журамласан байна.

*Хүснэгт 2.2.10. Багшийн ажлын үнэлгээний дүнгийн шатлал*

Түвшин	Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх дүгнэх журам (2009)		Багшийн ажлыг үнэлэх дүгнэх журам (2013)	
	Оноо	Үнэлгээ	Оноо	Үнэлгээ
1	90-100	“А” буюу “Маш сайн”	90-100	“Маш сайн”
2	80-89	“В” буюу “Сайн”	80-89	“Хангалттай сайн”
3	70-79	“С” буюу “Хангалттай”	70-79	“Сайн”
4	60-69	“D” буюу “Дутагдалтай”	60-69	“Дундаж”
5	0-59	“E” буюу “Хангалтгүй”	31-59	“Дунджаас доогуур”
6			0-30	“Хангалтгүй”

Багшийн ажлыг үнэлэн, дүгнэх 2013 оны журмын хэрэгжилтийг тандах судалгааг 1907 хүний дунд зохион байгуулсан бөгөөд судалгаанд оролцогчид багшийн ажлыг үнэлэх дүгнэхэд дараах нийтлэг бэрхшээл тулгардаг гэж үзжээ.

- Багшийн ажлын байрны тодорхойлолт-д заасан багшийн үндсэн зорилтын хүрээнд хийж гүйцэтгэх зарим үйл ажиллагаа “Багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ын нийтлэг шалгуур үзүүлэлт хоёр уялдахгүй байна.
- Зарим шалгуур үзүүлэлтүүд нь хэмжигдэхүйц бус байна.
- Багшийн ажлыг үнэлэх шалгуур үзүүлэлт нь хэтэрхий нарийвчилсан, оновчтой биш, дүгнэхэд цаг хугацаа, бичиг цаас их шаардсан ажиллагаа болж байна.
- Багш нар хичээл зохион байгуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах, сайжруулах цагаа судалгаанд зардаг байна.
- Багшийн хөгжлийн асуудлыг аль шалгуур, үзүүлэлтэд хамруулан үнэлэх нь тодорхойгүй;
- Үнэлгээ нь бодитой бус, багшийн хөгжлийг дэмжиж чаддаггүй.
- Үнэлгээний үр дүнгийн хэрэглээ тодорхой бус, эргэх холбоо байхгүй гэсэн байна.

Дээрх дүгнэлтээс харахад багшийн ажлын байранд тавигдах стандартыг боловсруулах, түүний ажлыг үндсэн ажилтай нь уялдуулан шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

**Сургуулийн үйл ажиллагааг үнэлгээ**

“Шалгуур үзүүлэлт батлах тухай журам” (БСШУ-ы Сайдын 321 дүгээр тушаал, 2003)-аар цэцэрлэг болон ЕБС-ийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг зохион байгуулж байна. Хяналт- шинжилгээ, үнэлгээ нь тоон ба чанарын 2 хэлбэрээр хэрэгжих ба цэцэрлэг, ЕБС-ийн захирал, эрхлэгч нар өөрсдийн үйл ажиллагаандаа уг журмыг мөрдлөг болгон ажиллаж, харин үнэлэх, дүгнэх үйл ажиллагааг хөндлөнгөөс аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газрын дарга нар хэрэгжүүлэхээр заасан байна.Цэцэрлэг, ЕБС-ийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөх журмын хувьд шалгуур үзүүлэлт тэдгээрийг тооцох

аргачлалууд нь бүгд индексжүүлсэн тоон утгатай бөгөөд тоон үзүүлэлтүүдийн нийлбэрийг тооцоолох томъёо, хөндлөнгийн үнэлгээнд авсан үр дүнг мэдээлэх дүнгийн нэршил зэргийг оруулж өгсөн ажээ.

*Хүснэгт 2.2.11. Цэцэрлэг, ЕБС-ийнүйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх тоонболон чанарын үзүүлэлт*

Тоон индикатор	Чанарын индикатор
1. Хамран сургалт	1. Байгууллагын менежмент
2. Сургалтын чанар, үр дүн	2. Сургалтын хөтөлбөр, арга зүй
3. Багшлах боловсон хүчин	3. Багшийн хөгжил, үнэлгээ
4. Санхүү материаллаг нөөц	4. Боловсролын үйлчилгээний хүртээмж
	5. Хүүхдийн эрх, оролцоо
	6. Цэцэрлэг, сургуулийн санхүү, нөөцийн удирдлага
	7. Цэцэрлэг, сургууль, эцэг эх, олон нийт, үйлдвэр аж ахуйн газруудын хамтын ажиллагаа

Сургуулийн үнэлгээний журам нь тухайн байгууллагын ажлыг хэмжих үнэлхэд шууд чиглэгдэж сургуулийн үндсэн үйл ажиллагаа буюу хамран сургалт, сургалтын үйл явц, багшлах бүрэлдэхүүн, хүний нөөц, материаллаг орчны ашиглалт зэрэгт тоон үнэлгээ хийх, мөн сургалтыг чанаржуулахад ач холбогдол бүхий индикаторуудаар чанарын үнэлгээ хийх гэсэн 2 чиглэлийн үнэлгээг зохицуулдаг. Энэ журмаар жил бүр улсын, аймаг, нийслэлийн, дүүргийн оны тэргүүний цэцэрлэг, сургуулийг шалгаруулж, урамшуулж, сурталчилдаг уламжлалтай.

Мөн улсын тэргүүний, цэцэрлэг, ЕБС шалгаруулах журмын дагуу жил бүр шалгаруулалт явагддаг бөгөөд энэхүү журам нь 2005 онд батлагдан 2008 онд шинэчлэгдэн өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Тус журам нь цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг хэрэгжүүлэх, хүүхэд бүрд сурч, хөгжих тэгш боломжийг бүрдүүлж, тэдний оролцоог хангах, улмаар хүүхдэд ээлтэй сургалтын орчин бүрдүүлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой бөгөөд уг журамд шалгаруулах үйл ажиллагааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна хэмээн тусгасан байна.

*Хүснэгт 2.2.12. Улсын тэргүүний цэцэрлэг, сургуулийг шалгаруулах шалгуур, индикатор*

№	Шалгуур	Индикатор
1	Байгууллагын менежментийн хөгжил	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын байгууллагын хөгжлийн бодлого, стратегийн төлөвлөгөөг боловсруулсан байдал</li> <li>Сургалтын байгууллагын хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байгаа байдал</li> <li>Сургалтын байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал</li> </ul>
2	Боловсролын үйлчилгээний хүртээмжийн өсөлт	<ul style="list-style-type: none"> <li>Хамран сургалтыг нэмэгдүүлсэн байдал</li> <li>Сургалтын байгууллагын үйл ажиллагаанд мэдээлэл харилцааны технологийг ашигладаг байдал</li> <li>Эцэг, эх, олон нийтийн байгууллагатай хамтран ажилладаг байдал</li> </ul>
3	Сургалтын чанарын ахиц	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын хөтөлбөрийг боловсруулсан байдал</li> <li>Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдал</li> <li>Суралцагчдын сурлагын амжилтын ахиц</li> <li>Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлсэн байдал</li> </ul>
4	Сургалтын орчны бүрдүүлэлт	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлсэн байдал</li> <li>Сургалтын эрүүл, аюулгүйн орчныг бүрдүүлсэн байдал</li> <li>Нийгэм, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлсэн байдал</li> </ul>

Дээр дурдсан шалгуур, индикаторыг ашиглан жил бүр шаардлага хангасан цэцэрлэг, сургуулийг шалгаруулан батламж олгодог байна.

## 2.2.4 Дүгнэлт, Зөвлөмж

### Дүгнэлт

1. ЕБС-ийн суралцагчдын сурлагын амжилтын үнэлгээ, дүнгийн шатлал болон багш нарын ажлыг үнэлэх шалгуур, үзүүлэлтүүд нь ойр ойрхон өөрчлөгдөж тогтворгүй явж ирсэн байна. Энэ нь суралцах болон багшлах үйлийн гаралтын үр дүнгүүдийн тогтвортой өсөлт хангагдахгүй байх хүчин зүйлсийн нэг болж байгааг сүүлийн үеийн хэдхэдэн судалгаанд дурдсан байна.

2. СӨБ-ын сургалт, үйлчилгээний чанар, сургуульд бэлэн байдлын судалгааг тогтмолжуулах, хөндлөнгөөс чанар, үр дүнг үнэлэх тогтолцоог бий болгох шаардлагатай ч одоогийн байдлаар тогтвортой эрх зүйн орчин бүрдээгүй байна.
3. 2013 оноос өмнө чанартай боловсрол гэхээсээ илүүтэй хамран сургалт, жендэрийн тэгш байдал болон сургалтын орчин талаас нь түлхүү бодлого төлөвлөн хэрэгжүүлж ирсний улмаас өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний зөрүү их байгаа нь өөрийн үнэлгээ хийж буй багш, сургалтын байгууллагын хувьд хуучин арга барилаасаа салж чадахгүй байх нэг үндэслэл болж байна.
4. Хөндлөнгийн үнэлгээ болон олон улсын сурлагын амжилтын үе үеийн судалгаагаар сурлагын амжилт харьцангуй доогуур түвшинд тодорхой ахицгүй байгаа нь боловсролын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр өгөөж сул байгааг харуулж байна.
5. Боловсролын түвшин тус бүрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний судалгаа, сурлагын амжилтын хөндлөнгийн үнэлгээний үр дүнгээс харахад үр дүнд суурилсан үйл ажиллагааг аль ч түвшиндээ хэрэгжүүлдэггүй болох нь харагдаж байна.
6. Манай улс сургуульд суурилсан үнэлгээг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний суралцагчдын нас, сэтгэхүйн онцлогийг харгалзан ялгавартайгаар хийх, сурлагын амжилтын үндэсний судалгааг жил бүр зохион байгуулах, улмаар олон улсын чанарын үнэлгээний TIMSS, PISA зэрэг судалгаанд оролцох замаар боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэхийг зорьж байна.
7. Улсын хэмжээнд боловсролын чанар, сурлагын амжилтыг үнэлж эхэлснээр хөтөлбөр, сурах бичгийн агуулга болон хэрэгжилтийг дэмжих үйл ажиллагааг судалгаанд суурилан сайжруулах суурь тавигдсан боловч судалгааны үр дүнг хэрэглэн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх ажил бүх шатны байгууллагад дутмаг байна.
8. Сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд хэрэгжилтийг үнэлсэн шалгалт, судалгааны үр дүнг авч ашиглах байдал (feedback) хангалтгүй байна.
9. Дээд боловсролын түвшинд зорилтот бүлгийн хэмжээнд эрдэмтэн судлаачид судалгаа хийдэг боловч үндэсний хэмжээнд үнэлгээ өгөх найдвартай арга, аргачлал бий болгох, хөндлөнгийн үнэлгээний тогтолцоог бүрдүүлэх нь зайлшгүй хэрэгцээ байна.
10. Боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэлтийг багш нарт очих ачааллыг багасгах чиглэлээр тогтмол хийх хэрэгтэй байгаа нь нэгж дээр хэрэглэдэг хэрэглэгчдийн зүгээс ирүүлж буй санал, гомдлоос харагддаг.
11. Боловсролын салбарын мэдээллийн систем хэдийгээр бий болсон боловч түүнд буй мэдээллийг ашиглах, байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, солилцох, бодлогын хэмжээнд хамтран ажиллах байдал дутмаг байна.

### **Зөвлөмж**

1. Сургуулийн өмнөх насны хүүхдийн хөгжлийн судалгааны мэдээллийн найдвартай, бодит байдлыг сайжруулах замаар үүсч буй тогтолцоог бэхжүүлэх нь чухал юм.
2. Сургуулийн өмнөх боловсрол дахь хүүхдийн хөгжлийн судалгааг эхлүүлэн бага боловсролын сурлагын амжилттай холбох, улмаар дээд боловсролын хөтөлбөр сонгоход нь дэмжлэг үзүүлэх зэрэг боловсролын тогтолцоо чанарын үнэлгээний судалгааныхолбоо хамаарлыг хангах бодлого боловсруулаж, хэрэгжүүлэх нь хойшлуулашгүй зорилтын нэг юм.
3. Сургуулийн өмнөх сургалтын байгууллагад хамрагдаж буй болон хамрагдаж чадаагүй, түр сургалтад хамрагдаж буй суралцагчдын сургуульд бэлэн байдлын судалгааг тогтмол хийж мэдээлэл цуглуулан ач холбогдолыг авч байх нь зүйтэй .
4. Боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжилтийг дэмжих ажил хийгдэж байгаа боловч тэдгээрийн хэрэгжилтийн явц, үр дүнд шинжилгээ хийж, түүнд тулгуурласан төлөвлөлтийг хөгжүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгох хэрэгтэй байна.
5. Стандартчилагдсан даалгаврын нээлттэй сан бий болгосноор хөндлөнгийн болон өөрийн үнэлгээний зөрүүг багасгах чухал ач холбогдолтой юм. Иймээс түүний хөгжүүлэхэд улсаас тодорхой хэмжээний төсөв зарцуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах, баяжуулах, практик ач холбогдлыг олон нийтэд таниулан сурталчлах, хэрэглээг нэмэгдүүлэх шаардлага байна.
6. Боловсролын чанар, сурлагын амжилтыг тогтоох, үр дүнг сургалтын хөтөлбөрийг сайжруулахад ашиглахад чиглүүлэн тухайн жилийн судалгаанд сонгогдсон боловсролын түвшин болон ангийн хүрээнд бүх сургуулийг хамруулах, жил бүрийн улсын төсөвт шаардлагатай санхүүжилтийг суулган баталгаажуулах шаардлагатай.
7. Боловсролын чанарын үнэлгээний судалгаанд сул үнэлгээтэй шалгагдсан сургуулийн жилийн төсвийг нэмэгдүүлэх, мэргэжлийн байгууллагуудын зөвлөн туслах үйл ажиллагааг



- тогтмолжуулах, байгууллага бүрийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээг тогтмол тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллах нь боловсролын чанарыг ахиулахад дэмжлэг үзүүлэх чухал ач холбогдолтой юм.
8. Суралцагчийн сурлагын ахиц, амжилтыг тооцох, үнэлгээг бодитой, найдвартай, ижил шалгуур, индикатораар үнэлэхэд сургууль, багш нарт мэргэжлийн байгууллагууд дэмжлэг үзүүлж, ном, гарын авлага, модульд сургалтуудыг шат дараалан зохион байгуулах хэрэгтэйг харуулж байна.
  9. Их, дээд сургуульд багш хөтөлбөрөөр суралцаж буй оюутнууд болон ЕБС-ийн багш нарт сургалтын хөтөлбөрт суурилсан үнэлгээний даалгавар боловсруулах арга, аргачлалыг таниулах, танин мэдэхүйн түвшний доод эрэмбийн даалгавраас илүүтэй дээд эрэмбийн ур чадварыг сорьсон асуудал шийдвэрлэх, мэдээлэлтэй ажиллах, боловсруулах, бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн даалгавар боловсруулах аргазүйг багш нарт эзэмшүүлэх тулгамдсан хэрэгцээ байна.
  10. ЕБС-ийн багшийн тасралтгүй хөгжлийг хангах үүднээс ажлын байран дээрээ хөгжих нөхцөл боломжоор хангах тусгайлсан бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих онлайн сургалтуудыг тогтмол зохион байгуулах гэх мэт арга хэлбэрүүдийг практикт нэвтрүүлэх хэрэгтэй байна.
  11. Нотолгоонд суурилсан бодлого төлөвлөлт болон хяналт-шинжилгээний тогтолцоог бий болгох, хэрэгжилтийг үнэлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудад чиглэл өгч төлөвлөгөөнд тусгуулан ажиллах хэрэгтэй байна. Үүнтэй холбоотойгоор мэдээллийн урсгал, түүний ашиглалтын цогц шийдлийг бий болгох шаардлага байна.
  12. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн хөгжүүлэлтийг бодит ажил болгох, хөтөлбөрт тавигдах шаардлага, үнэлэх аргачлалыг боловсронгуй болгож, хөтөлбөрийн өөрийн болон хөндлөнгийн магадлан итгэмжлэлээр дамжуулан сургалтын чанарыг сайжруулах, төгсөгчид нь ажлын байран дээр гарч шууд ажиллах чадвар, чадамжтай байх боломжийг бий болгох тогтолцоог хууль эрх зүйд тусгах, үйл ажиллагааг тогтворжуулах шаардлагатай.
  13. Шинээр батлагдсан суралцагчийн үнэлгээний журмын 3.4-т заасанчлан судлагдахуун, анги тус бүрээр үнэлгээний шалгуур (бенчмарк) боловсруулан гаргаж өгөх нь журамд заасан *оношлох, явцын, үр дүнгийн* үнэлгээг илүү бодитой хийх боломжийг багш нарт олгох ба түүнийг бодит үйл болгох ажлыг яаравчлан эхлүүлэх хэрэгцээ шаардлага нийгэмд бий болоод байна.
  14. Шинээр боловсруулагдсан суралцагчийн үнэлгээний журмын дүнгийн шатлал нь эрдэмтэн судлаач болон ЕБС-ийн багш нарын дунд маргаантай байгаа учраас цаашид тэдгээр шалгууруудын боловсруулалтад харьцуулах судалгаамөн тус журмын хэрэгжилтэд тандах судалгаахийж, дүгнэлт гарган нэг шийдэлд хүрэх шаардлагатай байна. Иймд журамд заасанчлан үнэлгээний шалгуурыг (criteria assessment) боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх аргачлалыг багш нарт түгээн дэлгэрүүлэх сургалтыг тогтмол явуулах хэрэгтэй байна.
  15. Дээд боловсролын сургалтын байгууллагад тавигдах шаардлагын биелэлтэд боловсролын үнэлгээний байгууллагаар жил бүр мэргэжлийн чиглэл заан чанарын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэж байх ажлыг Боловсролын Сайдын тушаалаар эрх зүйн хувьд баталгаажуулж өгөх хэрэгтэй юм.
  16. Боловсролын аль ч түвшинд мэдээлэл цуглуулах, индикатор боловсруулж, үнэлгээ өгөх арга аргачлалыг тодорхой болгох шаардлагатай байна.

## 2.3. Багшийн хангалт ба хөгжил

### 2.3.1. Өмнөтгөл

Багшийн хангалт ба хөгжил гэсэн энэ дэд бүлгийг боловсролын бүх түвшин дэх багштай холбоотойгоор 1990-2018 оны хооронд баталж хэрэгжүүлсэн бодлого, эрх зүйн баримт бичгүүд, 2007-2017 оны БСШУСЯ-ны статистик мэдээ, боловсролын салбарын мэдээллийн систем дэх өгөгдлүүд, Боловсролын мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлангууд болон бусад ажлын танилцуулгууд, холбогдох судалгааны үр дүнгүүдийг тус тус ашиглан агуулгын дараах 6 хэсэгтэйгээр бичлээ. Үүнд:

- Бодлого, эрх зүй
- Багш бэлтгэх сургалт
- Багш, мэргэжлийн багшийн хангалт
- Багшлах эрх
- Багшийн хөгжил, мэргэжил дээшлүүлэлт
- Мэргэжлийн зэрэг
- Багшийн ажлын норм, цалин хөлс эдгээрт холбогдох дүгнэлт, зарим зөвлөмжүүдийг тусгалаа.

### 2.3.2 Бодлого, Эрх зүй

#### Боловсролын тухай багц хууль ба багшлах эрх үүрэг, тэдэнд тавигдах шаардлага

Төрийн албаны тухай хууль болон Боловсролын тухай багц хуульд багштай холбоотой эрх зүйн суурь харилцаанууд тодорхойлогдсон байдаг.

Боловсролын тухай хууль (УИХ, 2002)-д багшийн нийгмийн баталгааг 9 заалтаар, багшийн эрх (7 эрх), үүргийн (8) харилцааг 15 заалтаар тус тус зохицуулсан байдаг ба багшийн мэргэжил, ур чадвартай холбоотой тодорхой заалт бий

- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (УИХ, 2002)-д СӨБ-ын багшийн эрх, үүргийг 17 заалтаар, туслах багшийн эрх үүргийг 7 заалтаар тодорхойлж өгсөн бол Бага, дунд боловсролын тухай хууль (УИХ, 2002)-д 6 заалт бүхий “ЕБС-ийн багшийг бэлтгэх, давтан бэлтгэх тухай” зүйлээр, 11 заалт бүхий “Багшийн эрх, үүрэг” гэсэн зүйлээр тус тус багштай холбоотой харилцааг зохицуулж өгсөн байдаг.
- Дээрх заалтууд нь Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад багшлах эрхтэй мэргэжлийн багш ажиллах, багш нь мэргэжлийн зэрэгтэй байхыг хуульчилж өгснөөс гадна Боловсролын тухай хуулийн 44.1, 44.2-т зааснаас бусад эрх үүргийг тусгаж хөдөлмөрийн харилцааг нь зохицуулж өгсөн байна.
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (УИХ, 2009)-д “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын “багш” нь бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй, эсвэл үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байхаар заасан ба онолын болон дадлагын багш нь мэргэжлийн зэрэгтэй байхыг хуульчилсан байна. Мөн энэ хуульд Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн хувьд Боловсролын тухай хуулийн 44.1, 44.2-т зааснаас бусад эрх, үүрэг, нийгмийн баталгаа тусгагдсан.
- Дээд боловсролын тухай хууль (УИХ, 2002)-д “Их сургууль, дээд сургууль, коллежид мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заах бөгөөд магистр, докторын хөтөлбөрийн хичээлийг докторын зэрэгтэй багш заана. Инженер, технологийн чиглэлээр сургалт явуулдаг коллежид мэргэшсэн инженер зааж болно” хэмээн зааж өгсөн бөгөөд багшийн мэргэжил эзэмшээгүй өөр мэргэжлийн орон тооны багш, багшлах арга зүй эзэмшсэн байхаар тусгаж өгсөн юм. Энэ хуулиар дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн албан тушаалын ангиллыг зааж, тэдэнд цол, зэрэг хэрхэн олгох тухай хуульчилсан. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагын багшидхамарах боловсролын тухай хуулийн 44.1, 44.2-т зааснаас бусад эрх үүргийг тодорхойлсон.

Боловсролын тухай дээр дурдсан багц хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд холбогдох албан тушаалтнууд, байгууллагуудын шийдвэрээр батлагдсан эрх зүйн баримт бичгүүдэд багшийн ажлын байрны тодорхойлолт, багшийн чиг үүрэг, үйл ажиллагаа, тэдгээрт тавигдах шаардлага, мэргэжлийн хөгжил, ёс зүй, цалин хөлс, нийгмийн хамгаалалтай холбоотой дараах харилцаанууд зохицуулагдсан байна.

Зураг 2.3.1. Багшийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтууд



### Мэргэжлийн багшийн хангалт ба хөгжлийн үе шатууд, бодлого, эрх зүйн зохицуулалт

Тайлангийн энэ хэсэгт багшийн хангалт ба хөгжлийн асуудлыг авч үзэхдээ СӨБ, БДБ эзэмшүүлдэг хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн багшийн асуудалд илү төвлөрсөн болохыг тэмдэглэх нь зүйтэй. Харин МБС, ДБ, НТБ-ын багшийн хангалт ба хөгжлийн асуудлууд тайлангийн 1.3, 1.4, 1.5 дэд бүлэгт тодорхой тусгагдсан болно.

#### 1990-1995 он (өмнөх тогтолцооны задралын үе)

Нийгэм, эдийн засгийн тогтолцоо өөрчлөгдсөн 1990 оноос 1995 он хүртэл өмнөх нийгмийн үед бүрэлдэн төлөвшсөн багшаар хангах, тэднийг хөгжүүлэх хуучин тогтолцоо задарч, шинэ тогтолцоо бүрдэж амжаагүй “аномали” үе байсан.

Энэ үед боловсролын агуулгыг коммунист, социалист үзэл суртлаас ангижруулах зорилгоор түүх, нийгмийн ухааны хичээлүүд хуучин агуулга, арга зүйгээрээ явагдах боломжгүй болохын зэрэгцээ англи хэлийг албан ёсны гадаад хэл болгон судлах болсноор эдгээр хичээлүүд сурах бичиггүй болж, мэргэжлийн багш нарыг давтан сургах хэрэгцээ гарсан байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо задарснаас багш нарын цалин хөлсний систем доголдож, багш нар цалингаа олон сараар авч чадахгүйд хүрч, улмаар олон багш тухайлбал, эрэгтэй багш нар боловсролын салбараас гарч өөр салбарт ажил эрхлэх болсноос багшийн дутагдал үүсэж байв. Асуудал хүндэрсээр 1995 онд цалин хөлс болон бусад асуудлыг шийдвэрлүүлэхээр багш нарын үндэсний хэмжээний ажил хаялт болж байсан түүхтэй.

1982 онд хуралдсан АИХ-ын чуулганы шийдвэрийг үндэслэн 1983 онд АБЯ-ны Сайдын 83 тоот тушаалаар Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт 2 дахь удаагаа байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж байсан ч 1990 онд ЗГ-ын 154 тоот тогтоолыг үндэслэн Боловсролын Сайдын 151 тоот тушаалаар тус институт татан буугдаж, 1991 оны 4-р сараас УБДС-ийн харьяанд “Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт” нэрээр ажиллах болжээ. (Оюунцэцэг, 2019) Ийнхүү багш нарын мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд өөрчлөлт гарсан байна.

#### 1995-2006 он (Боловсролын шинэ тогтолцоог дэмжсэн мэргэжлийн багшийн хангалтын бодлого, хөтөлбөр, төлөвлөлт эхэлсэн үе шат)

Монгол Улсын ЗГ-ын 2001 оны 120 дугаар тогтоолоор 2001-2004, 2005-2010 он гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжих “Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг эхний үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний хамт анх удаа батлан хэрэгжүүлжээ. Үндэсний хөтөлбөрт дараах зорилгыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Багш бэлтгэх тогтолцоог шинэчлэх
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх уян хатан, төвлөрсөн бус тогтолцоог түншлэлд тулгуурлан төлөвшүүлэх
- Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчныг бэхжүүлэх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох
- Багшийн ажлын үнэлгээг боловсронгуй болгох, тэдний идэвхтэй үйл ажиллагааг дэмжих механизм бүрдүүлэх.

2005 онд явуулсан “Бүх нийтийн боловсролын орчлын нэгдсэн үнэлгээ” ба “Салбарын нөхцөл байдлын судалгаа”-гаар боловсролын салбарын өнөөгийн төлөв байдал, хөгжлийн чиг хандлага, олон эрэмбэт хүчин зүйлсийн нөлөөллийг тус тус тодорхойлох замаар салбарын оношилгоо хийгджээ. Энэхүү үнэлгээ, оношилгоонд тулгуурлан “Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө” (ЗГ-ын 192 дугаар тогтоол, 2006) болон “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” (УИХ-ын 2008 оны 12 дугаар тогтоол, 2008)-ыг тус тус боловсруулан баталсан байна. Эдгээр стратегийн баримт бичгүүдэд

2006-2015 ба 2016-2021 гэсэн хөгжлийн хоёр үе шатанд баримтлах боловсролын, түүний дотор багшийн хөгжлийн талаар баримтлах бодлого ба стратегиуд тодорхойлогджээ. Тухайлбал, Мастер төлөвлөгөөнд мэргэжлийн багшийн хангалт, багшийн хөгжилтэй холбоотой дор дурдсан 5 хөтөлбөр, 26 хөтөлбөрийн бүрэлдэхүүн, 21 хүрэх үр дүн, тэдгээрийн үнэлэх шалгуур, үзүүлэлт бүхий Бага, дунд боловсролын үйл ажиллагааны бие даасан төлөвлөгөөг тусгасан байна. Үүнд:

- 1 Багшийн хангалт, ашиглалт ба багшийн ачааллыг оновчтой болгох (4)
- 2 Багш, удирдах ажилтан бэлтгэх тогтолцоог шинэчлэн сайжруулах (6)
- 3 Сургууль төвтэй мэргэжил дээшлүүлэх тогтолцоог төлөвшүүлэх (5)
- 4 Шинэ стандарт, киррикулимийг хэрэгжүүлэх багш нарын мэргэжил, арга зүйн ур чадварыг дээшлүүлэх (5)
- 5 Багш, арга зүйчид, удирдах ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой болгож, тэдний цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, тэтгэлэг, урамшууллын тогтолцоог шинэчлэн мөрдүүлэх (6)

Энэ хугацаанд Үндэсний хөтөлбөрүүд болон Мастер төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилтууд, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд багшлах үйлтэй холбоотой дүрэм, журмуудыг батлан хэрэгжүүлжээ. Тухайлбал, Багшийн ажлын байрны тодорхойлолтыг 2001 (БСШУ-ы Сайдын 173 дугаар тушаал, 2001) ба 2003 (БСШУ-ы сайдын 392 дугаар тушаал, 2003) тус тус шинэчлэн баталж мөрджээ.

Түүнчлэн 2002 онд БСШУ-ны Сайдын 202 тоот тушаалаар “Бага, дунд боловсролын стандарт ба киррикулимийг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал” батлагдан, түүнд суурилсан боловсролын стандартууд боловсрогдон батлагдаж, 2004 оноос үндэсний хэмжээнд мөрдөх шийдвэр гарчээ. Энэ нь багшийн албан тушаалын үндсэн чиг үүрэг, багшлах үйлийн агуулга, хөдөлмөрийн харилцааг цоо шинээр авч үзэж, шийдвэрлэх хүндхэн сорилтыг бий болгосон байна. Учир нь энэ үзэл баримтлал болон стандарт нь суралцахуйн конструктив онолын суурь зарчмууд, хүн судлалын шинжлэх ухаануудын интеграцыг суралцахуйд буулгасан дидактикийн ухааны гол шийдлүүдэд суурилсан байжээ.

*2007-2011 он (Суралцахуйн конструктив онолын зарчмуудад суурилсан багшлах үйлийн эрх зүйн шинэ орчинг бүрдүүлсэн үе шат)*

Багшийн үндсэн чиг үүрэг багш төвтэй сургалтаас шавь төвтэй сургалтад шилжиж, суралцагчид өөрсдийн бүтээлч үйлээр шинэ мэдлэг бүтээн суралцах үйлийг нь дэмждэг “менежер” болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор суралцахуйг эзэмшихүйн зүй тогтлын дагуу чиглүүлэх бодит боломжийг багшид олгохын тулд багшийн ажлыг хэмжих нэгжийг томсгох, улмаар багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх, урамшуулах хөшүүргийг цогцоор нь цоо шинээр авч үзэх хэрэгцээ гарсан байна. Энэ шинэ хэрэгцээний дагуу 2007-2012 онд багшийн шинэ чиг үүрэгтэй холбоотойгоор багшлах үйл ажиллагааны харилцааг харилцан хамааралд нь зохицуулсан эрх зүйн цогц шинэчлэл хийгдсэн байна (Хүснэгт 2.3.1).

*Хүснэгт 2.3.1. Багшийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчин (2007-2012)*

**УИХ-ын тогтоол**

- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого: Бүлэг V; 1995 (36)
- Боловсролын тухай хууль: Бүлэг VI; 1991, 1995, 1998, 2002, 2006, 2008, 2012
- Бага, дунд боловсролын тухай хууль: Бүлэг VI; 1991, 1995, 1998, 2002, 2006, 2008, 2012
- Төрийн албаны тухай хууль: 2002,

**ЗГ-ын тогтоол**

- Төрийн албан тушаалын ангилал, зэрэглэл 2007 оны 354 (236)
- Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишиг 2010 оны 239 2007 оны 351 (237)
- Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээ 2007 оны 219 ба 2010 оны 148
- Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр 2008 оны 316
- Улирлын ажлын үр дүнгийн улирлын мөнгөн урамшуулал 2008 оны 54

**БСШУ-ны Сайдын тушаал**

- Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ёс зүйн дүрэм 2007 оны 41
- Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт **2007 оны 351** (179)
- Улс, аймаг, нийслэлийн “Оны тэргүүний багш” шалгаруулах болзол, түүнийг дүгнэх аргачлал 2007 оны 440
- Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам 2008 оны 72
- Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам 2008 оны 73
- Багшлах эрх олгох, хасах журам 2008 оны 74
- “Багшийн хөгжлийн танхим”-ын стандарт 2008 оны 114
- Хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэх 2010-2012 оны үйл ажиллагааны төлөвлөгөө 2009 оны 555
- Багшийн ажлын төлөвлөх, үнэлэх, дүгнэх журам 2009 оны 561

**Хамтарсан тушаалууд**

- Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож, олгох журам **2007 оны 307/91/237**
- Цэцэрлэг, ЕБС-ийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт 2010 оны 362/112/183

Иймд Боловсрол, Нийгмийн хамгаалал, хөдөлмөр, Сангийн Сайдын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар багшийн сургалтын ажлыг 30-45 минутын ээлжит хичээлээр бус хэд хэдэн ээлжит хичээлийн цогц болох “нэгж хичээлээр” хэмждэг болох шийдвэр гарсан. Мөн БСШУ-ны Сайдын 2007 оны 351-р тушаалаар Багшийн ажлын байрны тодорхойлолт шинэчлэгдэж, цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөрүүдээ боловсруулах, түүнийгээ хэрэгжүүлэх, мөн үнэлэх сайжруулж байх үндсэн чиг үүрэгтэй болгожээ.

Энэ 2 журмаар нь багшийн үйл ажиллагааны агуулга, мөн чанарт зарчмын суурь шинэчлэл хийгдсэн бөгөөд бусад журмууд, холбогдох шийдвэрүүд нь эдгээр суурь өөрчлөлтийг дэмжихэд чиглэгдэн цогцоороо шинэчлэгдсэнээр багшийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн шинэ орчин бүрдсэн байна.

Цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, нээлттэй киррикулимийг хэрэгжүүлэх чадвартай багш бэлтгэх, тэдний мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжих зорилтуудыг бодит үйл хэрэг болгоход тодорхой дэмжлэг болохуйц бие даасан үндэсний хөтөлбөртэй болох талаар БСШУЯ-аас 2007 оны 4 сард зохион байгуулсан “Багш нарын улсын анхдугаар зөвлөгөөн”-өөс гаргасан санаачилгыг дэмжиж, “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” (ЗГ, 2008)-ийг баталжээ. Үндэсний хөтөлбөрийг 2008-2015 онд хэрэгжүүлсэн бөгөөд дараах 2 гол зорилгын хүрээнд 12 товлосон зорилт, 55 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- “Багш” боловсролын зорилго, агуулгын өөрчлөлт, бага, дунд боловсролын чанарыг тасралтгүй сайжруулж байх хэрэгцээ шаардлага, ЕБС-ийн бүтэц, хэмжээ, хэв шинжийн онцлогт нийцсэн, багшийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд баримжаалсан, багш бэлтгэх нээлттэй, уян хатан, тогтвортой тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх
- Нийгмийнхээ аж төрөх ёсонд нийцсэн, багш ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих бодит хэрэгцээнд нь суурилсан, сургууль төвтэй мэргэжил дээшлүүлэх нээлттэй, сонголттой, тогтвортой тогтолцоог хөгжүүлэхээр тус тус заажээ.

Мөн боловсролын чанар, үр өгөөжийг тогтмол дээшлүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлэхэд чиглэсэн бодлогод шилжих үндсэн зорилтыг дэвшүүлсэн “Боловсрол үндэсний хөтөлбөр (2010-2021 он)” (ЗГ-ын 31 дүгээр тогтоол, 2010) батлагдсан байна. Тус хөтөлбөрт “Багшийн мэргэжил, арга зүйн хөгжил болон цалин, урамшуулал, нийгмийн хамгааллын асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, хөрөнгө оруулалтын хэмжээ, үр өгөөжийг нэмэгдүүлэх” стратегийн зорилт тусгасан бөгөөд багштай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж байжээ.

- Бүх шатны боловсролын байгууллагын багш, ажиллагчдын хүйсийн тэгш байдлыг хангах
- Багш, удирдах ажилтан бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог хөгжүүлж, энэ чиглэлд мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх
- Бага, дунд боловсролын багш мэргэжлээр амжилттай суралцаж буй оюутнуудад тэтгэлэг олгох
- Багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын чадавхыг дээшлүүлэх
- Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын нийт зардлын 15-аас доошгүй хувийг багш нарын мэргэжил дээшлүүлэхэд зарцуулах, сургуулийн төсөвт багш нарын мэргэшил дээшлүүлэх бие даасан зардлын ангиллыг бий болгох
- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш бэлтгэх тогтолцоог шинэчлэх
- Их, дээд сургуулийн багшийг чадавхжуулах тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
- Бүх шатны сургуулийн багш нарт газар нутгийн алслал, цаг уурын онцлог, амьжиргааны өртөгтэй холбогдуулан онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох асуудлыг судалж шийдвэрлэх

Орон нутгийг мэргэжлийн багшаар хангах, тэднийг тогтвортой ажиллуулах эдийн засаг, эрх зүйн орчныг сайжруулах зэрэг заалтуудыг тусгажээ.

Энэ үед багшийн ажлын байр, багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр нэлээд олон эрх зүйн баримт бичгүүд шинээр батлагдаж, цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын байранд тавигдах шаардлага, ажлын норм, багшийн ажлыг үнэлж дүгнэх, цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал тооцож олгох зохицуулалтууд хийгдсэн төдийгүй багшийн ёс зүйн асуудлыг журамлах болсон ба багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах, оны тэргүүний багш шалгаруулах харилцааг зохицуулж, багшийн мэргэжил дээшлүүлэх журмыг баталж хэрэгжүүлсэн байна. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн албан тушаалын орон тоонд тавих нийтлэг шаардлага, дээд боловсрол: ЕБС-ийн багш мэргэжлийн стандарт (MNS 5323-95:2009, 2009)-ууд батлагдан хэрэгжиж эхэлжээ (БОНХАЖЯ, 2016).

**2012-2018 он** (Багшийн мэргэжил дээшлүүлэх институтчилагдсан тогтолцоо сэргэсэн үе шат)

2012 онд Боловсролын тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу 40.8 дахь хэсэгт “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ” хэмээн зааж өгсөн нь багшийн мэргэжил дээшлүүлэх институтчилагдсан тогтолцоог сэргээх чухал үндэс болсон юм. Ийнхүү багшийн мэргэжил дээшлүүлэх институтчилагдсан тогтолцоог бий болгож, бэхжүүлэх нь багшлах арга зүйн хөгжлийг хангах тулгамдсан хэрэгцээ болоод байсан тул 1990 онд татан буугдсан Багшийн мэргэжил дээшлүүлэх институт (БМДИ) (ЗГ-ын 180 дугаар тогтоол, 2012) гуравдахь удаагаа дахин бие даасан институт болон байгуулагджээ. БМДИ-ийн дүрэмд заасан үйл ажиллагааны үндсэн чиглэлд нь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн, төрөлжсөн, захиалгат сургалтууд болон багшийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, хөгжүүлэх, багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох ажлуудыг орчин үеийн МХХТ-д суурилан үндэсний, орон нутгийн түвшинд зохион байгуулах зэрэг заалтуудыг тусгасан байна.

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд шаардлагатай багшлах арга зүйд тулгамдаж буй асуудлыг судлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг сонгон ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх, хүүхдийг хөгжүүлдэг багш төлөвшүүлэх, тэргүүн туршлагыг түгээх, нэр хүндийг нь өсгөх зорилготой “Багшийн хөгжил” (БШУ-ы Сайдын А/136 дугаар тушаал, 2012) гэсэн салбарын түвшний хөтөлбөр батлагдаж, дараах 3 зорилтыг дэвшүүлж, 16 үйл ажиллагаа хэрэгжүүлсэнээр хүлээгдэж буй 8 үрдүн гарахаар төлөвлөсөн байна. Үүнд:

1. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүйд тулгамдаж байгаа асуудлыг судалж, шийдвэрлэхэд арга замыг тодорхойлох (5)
2. Багш мэргэжил, ур чадвараа хөгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх (7)
3. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга барилтай багшийг төлөвшүүлэх (4) гэсэн зорилтыг тус тус дэвшүүлжээ.

Түүнээс гадна 2013 оноос эхлэн сургууль, цэцэрлэгийн багшийн ажил, үр дүнгийн үнэлгээг бусад ажилтны үйл ажиллагаатай уялдуулж, хүүхэд, суралцагчийн хөгжил рүү чиглүүлэх зорилгоор багшийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчны журмуудыг шинэчилсэн байна.

Хүснэгт 2.3.2. Багшийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн орчин (2012-2018)

<b>УИХ-ын тогтоол</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024</li> <li>• Төрийн албаны тухай хууль: 2017</li> <li>• Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль: 2018</li> </ul>
<b>ЗГ-ын тогтоол</b>
<ul style="list-style-type: none"> <li>• “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох журам” (ЗГ-ын 346 дугаар тогтоол, 2017)</li> <li>• Дээд боловсролын сургалтын суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам (ЗГ-ын 71 дүгээр тогтоол, 2014)</li> <li>• Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”(ЗГ-ын 382 дугаар тогтоол, 2018)</li> </ul>
<b>Салбарын Сайдын тушаал</b>
<ul style="list-style-type: none"> <li>• Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам (БШУ-ы Сайдын А/287 дугаар тушаал, 2013)</li> <li>• ЕБС-ийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам (БШУ-ы Сайдын А/293 дугаар тушаал, 2013)</li> <li>• ЕБС-ийн багш, ажилтны ажлыг үнэлэх дүгнэхэд баримтлах чиглэл (БШУ-ы Сайдын А/299 дүгээр тушаал, 2013)</li> <li>• Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам (БШУ-ы Сайдын А/305 дугаар тушаал, 2013)</li> <li>• СӨБ-ын багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах, арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох, хасахад баримтлах шалгуур үзүүлэлт батлах тухай (БШУ-ы Сайдын А/52 дугаар тушаал, 2014)</li> <li>• Цэцэрлэгийн ажилтны ажлыг үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл батлах тухай (БШУ-ы Сайдын А/112 дугаар тушаал, 2014)</li> <li>• “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм” (БСШУС-ын Сайдын А/243 дугаар тушаал, 2018)</li> <li>• Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам (БСШУС-ын Сайдын А/812 дугаар тушаал, 2018)</li> </ul>

2015 онд “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он)” (УИХ-ын 12 дугаар тогтоол, 2015) шинэчлэгдэн батлагдаж, хүний нөөцийн хөгжлийг дэмжих тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр дараах заалтуудыг тусгаж өгсөн юм. Үүнд:

- Багш бэлтгэх сургалтын байгууллагын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулж, бүх талын дэмжлэг үзүүлнэ
- Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ
- Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ хэмээн тус тус тодорхойлжээ.

2018 онд анх удаа УИХ-аас “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль” баталсан бөгөөд 2019 оноос энэ хууль хэрэгжиж эхэлсэн. Энэ хуулинд төрөөс багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо, багшийн ёс зүй, нэр хүндийг сахих тухай бүлгүүдэд зарим онцлог заалтууд тусгагдсан байна. Тухайлбал:

- СӨБ, ЕБС, МБСТ-ийн багшийн хөгжлийн төвд хувьсах зардлын 2 хувь хүртэл хэмжээний зардал зарцуулах,
- ЕБС-ийн 44-өөс дээш суралцагчтай 1,2 дугаар ангид туслах багштай байж болох
- Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байхаар тус тус хуульчилж өгсөн байна.

Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулинд Боловсролын тухай хуулийн зарим заалтуудтай зөрчилдсөн заалт тусгагдсан байна. Тухайлбал, Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулинд “Багш нь багшлах эрхтэй байна” гэж заасан боловч Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулинд “Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байна” гэсэн заалтууд тусгасан нь хоорондоо зөрчилдөж байна. Мөн “Багш мэргэжлээр их, дээд сургууль төгсөөгүй дээд боловсролтой төгсөгчид багшлах эрх олгох, сунгах шалгалтыг зохион байгуулна”

гэсэн заалт боловсролын сургалтын байгууллагын түвшин заагаагүй, цэцэрлэг, ЕБС-д багш бус мэргэжилтэй хүн шалгалт өгөөд багшлах эрх авч ажиллаж болох юм шиг ойлголтыг бий болгож байна.

“Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм” (БСШУС-ын Сайдын А/243 дугаар тушаал, 2018), Мэргэжлийн зэрэг олгох хасах журам (БСШУС-ын Сайдын А/812 дугаар тушаал, 2018) тус тус шинэчлэгдэн батлагдаад хэрэгжиж эхэллээ. Харин багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх, багшид багшлах эрх олгох, багш мэргэжлээр их, дээд сургууль төгсөөгүй дээд боловсролтой төгсөгчид багшлах эрх олгох, сунгах шалгалтыг зохион байгуулах харилцааг зохицуулах дүрэм, журмууд шинэчлэгдэх шаардлагатай байна.

Цэцэрлэг, ЕБС-ийнбагштай холбоотой эрх зүйн баримт бичгүүд дэх багшид тавих шаардлага, шалгуур үзүүлэлт нь ижилхэн бөгөөд энэ нь ЕБС-ийн багшийн онцлогт илүү тохирсон, цэцэрлэгийн багшийн ажлын онцлогт тохирохгүй, зарим үзүүлэлтийг хэмжих боломжгүй байх тохиолдол гарч байна. Энэ нь цэцэрлэгийн багшид зориулсан тусгайлсан бодлого, эрх зүйн зохицуулалт шаардлагатайг харуулж байна. Үүнээс гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш нар, ялангуяа тэнд ажиллаж буй ерөнхий эрдмийн хичээл (математик, физик, хими, монгол хэл гэх мэт) заадаг багш нарын хөгжлийн тухай бодлогын асуудлыг ЕБС-ийн багш нарынхтай ижил түвшинд авч явах шаардлагатай байна.

Ийнхүү цэцэрлэг, ЕБС-ийн багшийн эрхэлж буй ажил үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтыг 2007-2012 ба 2013-аас өнөөг хүртэл гэсэн 2 үе шатад зааглан үзэж болохоор байна.

БОНХАЖЯ, ШХА-аас 2015 онд явуулсан судалгаанд энэ 2 үед харгалзах багшлахтай холбоотой эрх зүйн актуудад баримталсан бодлого, хийгдсэн шийдлүүдийн үндэслэл, тэдгээрийн харилцан хамаарал болон тус бүрийнх нь зорилго, зориулалт, агуулгын дэлгэрэнгүй тайлбар, зарим харьцуулалтууд хийгдсэн байна (БОНХАЖЯ, ШХА, 2015). Иймд сонирхсон хэрэглэгч энэ талаар дэлгэрүүлэн танилцах боломжтой.

### 2.3.3. Хэрэгжилт, Үр дүн

#### 2.3.3.1. Багш бэлтгэх сургалт

Бүрэн дунд боловсрол, түүнтэй дүйцүүлэх боловсрол эзэмшсэн, багш мэргэжлээр суралцах хүсэлтэй иргэн элсэлтийн ерөнхий шалгалт өгч тэнцсэнээр их дээд сургуулийн багш мэргэжлийн бакалаврын хөтөлбөрт элсэн суралцаж болно. Багш бэлтгэх сургалтын хөтөлбөртэй төрийн болон төрийн бус өмчийн их дээд сургуулиуд мэргэжлийн багш бэлтгэж байна. Эдгээрээс багш бэлтгэх төрийн өмчийн сургууль болох Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС) нь нийт цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын 50 гаруй хувийг бэлтгэж байна.

Багш мэргэжилтний загварын үзэл санаа, онол, арга зүйн шийдэлд суурилан 2004 онд монгол хэл, уран зохиол, нийгмийн ухаан, дүрслэх урлаг зэрэг мэргэжлийн багшийн стандартууд улмаар 2009 онд ЕБС-ийн багш мэргэжлийн стандартыг батлан их, дээд сургуульд 2010 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэхүү стандартаар ЕБС-ийн багш чиглэлийн бакалаврын түвшний боловсролын агуулга, үнэлгээ, сургалтын хугацаа, орчинд тавих үндсэн шаардлагыг баталгаажуулах зорилго тавьжээ. Уг стандартаар ЕБС-ийн багш мэргэжлийн сургалтад дараах хичээлүүдийг заавал судлах, сонгон судлахаар ангилан багц цагийг тусгаж өгсөн байна.

Хүснэгт 2.3.3. “ЕБС-ийн багш” бэлтгэх сургалтын хөтөлбөрийн агуулгын ерөнхий бүтэц


Ерөнхий суурь хичээл		Мэргэжлийн суурь хичээл
Заавал судлах	Сонгон судлах	Заавал судлах хичээл
<ul style="list-style-type: none"> <li>• Англи хэл</li> <li>• Мэдээллийн технологи, мэдээллийн систем</li> <li>• Биеийн тамир</li> </ul>	<p><i>Хүмүүнлэгийн ухааны хичээл</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Гадаад хэл</li> <li>• Философийн үндэс</li> <li>• Монголын түүх</li> <li>• Соёл судлалын үндэс</li> <li>• Экологи, байгаль хамгаалал</li> <li>• Хүний хөгжил</li> <li>• Монгол хэлний найруулга зүй</li> </ul> <p><i>Нийгмийн ухааны хичээл</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн онолын үндэс</li> <li>• Улс төр судлалын үндэс</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн боловсрол</li> <li>• Сэтгэл судлал</li> <li>• Сурган хүмүүжүүлэх зүй</li> <li>• Мэргэжлийн дидактик</li> <li>• Сурган хүмүүжүүлэх дадлага</li> </ul>



	<ul style="list-style-type: none"> <li>• Социологийн үндэс</li> <li>• Менежментийн үндэс</li> </ul>	
--	---	--

Их дээд сургуулиудыг жилд дунджаар 31000 орчим оюутан төгсдөг ба үүний 16.3 хувь буюу 5000 орчим суралцагч нь багш мэргэжлээр төгсөж байна. Тухайлбал, 2017 онд их дээд сургуулийг нийт 30301 иргэн төгссөн бөгөөд үүнээс 4587 нь багш мэргэжлээр төгсжээ.


Зураг 2.3.2. Бакалаврын зэрэгтэй нийт төгсөгчдийн дотор багш мэргэжлээр төгсөгчийн эзлэх хувь (2012-2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Их дээд сургууль төгсөгчдийн дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь дунджаар 62.4 байдаг бол багш мэргэжлээр суралцагчдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь 83 хувьтай байна (Зураг 2.3.3.).

Зураг 2.3.3. Багш мэргэжлээр төгсөгчдийн хүйсийн харьцаа (2012-2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Багш мэргэжлээр суралцагч, төгсөгчдийн хүйсийн харьцаа сүүлийн 5 жилд өөрчлөлт гараагүй болохыг дээрх зургаас харж болохоор байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох 2014 оны журам (ЗГ-ын 71 дүгээр тогтоол, 2014)-ын дагуу 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар энэхүү тэтгэлгийг нийт 4 сургуулийн 6774 оюутан хүртэж, тэдэнд нийт 13.7 тэрбум төгрөгийн тэтгэлэг олгоод байна.

Мөн дээр дурдсан журмуудын хүрээнд гадаадын магистр, докторын хөтөлбөрт Боловсролын чиглэлээр 2006 оноос хойш 90 оюутан элсэж 2.56 сая ам.долларын зээл олгогджээ.

2013 онд гарсан Дэлхийн шилдэг сургуульд оюутан суралцуулах тухай ерөнхийлөгчийн зарлигийн хүрээнд боловсролын чиглэлээр 9 оюутан 554 мянган долларын санхүүжилт авсан байна (Эх сурвалж: Боловсролын зээлийн сангийн мэдээ).

### 2.3.3.2. Мэргэжлийн багшийн хангалт


2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 1416 цэцэрлэгт 7745, 798 ЕБС-д 29242, 355 НТБ-ын төвд 362, 83 МСҮТ-д 2230, 96 их, дээд сургууль коллежид 6724, нийт 46,303 багш ажиллаж байна (Зураг 2.3.4.).

Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багшийн тоог сүүлийн 10 жилээр харьцуулж харахад нийт багшийн тоо 2007-2008 оны хичээлийн жилд 35686 байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 46303 болж өссөн байна. Сүүлийн 10 жилд цэцэрлэгийн тоо 1.8 дахин, цэцэрлэгт явж буй хүүхдийн тоо 2 дахин өссөнөөр СӨБ-ын багшийн тоо 2.4 дахин өсчээ.

Харин ЕБС-ийн тоо өнгөрсөн 10 жилд 754-өөс 798 болж 44-өөр өссөн ба сурагчдын тоо 2007-2008 оны хичээлийн жилд 551503 байснаас 2012-2013онд 509792 болж багассан боловч 2017-2018 оны хичээлийн жилд 581160 болж өссөн байна. Сурагчдын тоо буурч, өссөн үзүүлэлттэй байгаа ч энэ хугацаанд ЕБС-ийн багшийн тоо тогтмол өссөөр 23897-оос 29242 болсон байна. Үүнийг ЕБС-ийн тоо нэмэгдэж, анги, суудлын тоо нэмэгдсэнээр бүлэг дүүргэлт багасахтай холбон тайлбарлаж болох юм.

МСҮТ-ийн тоо сүүлийн 10 жилд 56-аас 83 болж 1.48 дахин өссөн бөгөөд үүнтэй адил МСҮТ-ийн багшийн тоо 1451-ээс 2230 болж 1.54 дахин өссөн байна. 2007-2008 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежийн тоо 162-аас 2017-2018 оны хичээлийн жилд 96 хүртэл буурсан ч суралцагчдын тоо 150326-аас 155248 болж өссөн бөгөөд багшийн тоо 6892-оос 6724 болж өөрчлөгдсөн байна. Их дээд сургуулийн тоо 1.7 дахин цөөрсөн ч сургалтын хөтөлбөр, суралцагчдын тооноос шалтгаалан багшийн тоонд бараг өөрчлөлт гараагүй байна.


Зураг 2.3.4. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн тоо (2006/07-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Боловсролын салбарын хөгжлийн бодлого, үндэсний хөтөлбөрүүдэд сургалтын байгууллагын багш, ажилтны жэндэрийн зохистой харьцааг хангах зорилтыг тусгадаг боловч сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш нарын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувь олон жилийн туршид өндөр хэвээр байсаар байна. Боловсролын түвшин ахих тутам эрэгтэй багш нарын эзлэх хувь өссөн үзүүлэлттэй байгаа ч дээд боловсролын сургалтын байгууллагын багш нарын 40.6 хувь нь эрэгтэй багш байна. Боловсролын сургалтын байгууллага, үйлчилгээний төрлөөс хамаарч эрэгтэй багшийн эзлэх хувь ялгаатай байна гэж үзэж болох талтай (Зураг 2.3.5.).


Зураг 2.3.5. Бүх шатны боловсролын сургалтын байгууллагын багш нарын хүйсийн харьцаа (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Бүх шатны боловсролын байгууллагын багш нарын дунд эмэгтэй багшийн эзлэх хувийг сүүлийн 10 жилээр харьцуулж харахад эмэгтэй багшийн эзлэх хувь цэцэрлэгт 99.9-өөс 97.4 хувь, ЕБС-д 81.4-өөс 81.6 МСҮТ-д 62.4-өөс 61.4, их дээд сургууль, коллежид 58.3-аас 59.4 болж өөрчлөгдсөн байна. СӨБ-ын багш 2007-2008 оны хичээлийн жилд нийт багшийн 9.7 хувийг эзэлдэг байсан бол 2017-2018 оны хичээлийн жилд 16.7 хувьд хүрч нэмэгдсэнээр эмэгтэй багшийн эзлэх хувийг харуулсан улсын дундаж үзүүлэлтэд нөлөөлж, 78-аас 80 болж өссөн байна.


Зураг 2.3.6. Бүх шатны боловсролын сургалтын байгууллага дахь багш нарын дунд эмэгтэй багшийн эзлэх хувь (2006/07-2017/18 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн багш нарын 28.5 хувийг 30 хүртэлх насны 36 хувийг 30-39 насны, 23.3 хувийг 40-49 насны, 12.2 хувийг 50 ба түүнээс дээш насны багш нар эзэлж байна. Энэ нь багш нарын 64.5 хувь нь 40 хүртэлх насны залуу багш нар ажиллаж байгааг харуулж байна (Зураг 2.3.7.).


Зураг 2.3.7. ЕБС-ийн багш нарын насны бүтэц (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар бага, дунд боловсролын сургалтын байгууллага дахь мэргэжлийн багшийн хангалтын улсын дундаж хувь 98.8 хувьтай байна.

Зураг 2.3.8. ЕБС-ийн мэргэжлийн багшийн хангалтын хувь (2012/13-2017/18 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик


2015-2016 оны хичээлийн жилд мэргэжлийн багшийн хангалтын хувь 99.6-аас 98.6 болж буурсан үзүүлттэй байна. СӨБ-ын хувьд мэргэжлийн багшийн хангалт нь 2014 оноос хойш өссөөр 97.3 хүрчээ. Энэ нь БСМС-ийн хүний нөөцийн модуль ашиглалтад орж багш нарын мэдээллийг хүн нэг бүрийн мэдээлэлд үндэслэн гаргадаг болсонтой холбон тайлбарлаж болох юм (Зураг 2.3.8.).

2017-2018 оны хичээлийн жилд ажиллаж буй хими-биологи, математик-физик, дуу хөгжим, мэдээлэл зүй, түүх-уран зохиолын хичээл заадаг мэргэжлийн багшийн хангалт 95.4-96.8 хувь, математик-мэдээлэл зүй, физик, нийгмийн ухаан, хими, түүх-нийгэм судлал, биологи, байгаль шинжлэл, зураг дүрслэх урлаг, математик, газарзүй, байгаль шинжлэл, орос хэл, технологи, зураг технологийн хичээл заадаг мэргэжлийн багшийн хангалт 97.3-98.7 хувь, монгол хэл, уран зохиол, англи хэл, бага анги, түүх-газарзүй, орос-англи хэл, биеийн тамир 99.2-99.8 хувь гадаад хэл, түүхийн хичээл заадаг мэргэжлийн багшийн хангалт 100 хувь байна.

2017-2018 оны хичээлийн жилд ЕБС-д ажиллаж буй багшийн 10.7 хувь нь дипломын дээд, 72.4 хувь нь бакалавр, 13.8 хувь нь магистр, 0.1 хувь нь докторын боловсролтой байна (Зураг 2.3.9.). Докторын зэрэгтэй нийт 23 багш ажиллаж байгаагаас монгол хэл, уран зохиолын 5, зураг технологийн 4, химийн 3, түүх-нийгэм судлалын, физик, бага ангийн багш тус бүр 2, хятад хэл, хими-биологи, газар зүй, орос-англи хэл, биеийн тамирын багш тус бүр 1 байна. Магистрын зэрэгтэй нийт 4034 багш ажиллаж байгаагаас 18.6 хувь нь бага анги, 14 хувь нь Англи хэл, 13.5 хувь нь МХУЗ, 7.9 хувь нь математик, 5.7 хувь нь түүх-нийгэм судлалын багш нар байна. Харин согог судлалын багшийн 57.1, нийгмийн ажилтны 35, орос-англи хэлний багшийн 29.3, түүх-уран зохиолын багшийн 29 хувь нь магистр зэрэгтэй байна.

Дипломын дээд боловсролтой 3131 багш ажиллаж байгаа ба эдгээр багш нарын 50.3 хувь нь бага анги, 8.8 хувь нь дуу хөгжмийн, 6 хувь нь математикийн, 5.9 хувь нь биеийн тамирын багш бөгөөд үлдсэн 29 хувийг бусад мэргэжлийн багш нар эзэлж байна.

Зураг 2.3.9. Цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын боловсролын түвшин (2012/13-2017/18 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн багш нарыг боловсролын түвшингээр ангилж үзвэл дипломын дээд боловсролтой багшийн эзлэх хувь 2012 оноос хойш жил бүр буурсаар 8.8 хувиар багассан байна. Харин энэ хугацаанд бакалавр 4.1 болон магистрын зэрэгтэй багшийн эзлэх хувь 2.1 хувиар нэмэгдсэн байна. Энэ байдлыг Бага, дунд боловсролын тухай хуулинд багш нь бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх шаардлага тавигддаг, нөгөө талаар дээд боловсролын сургалтын байгууллагууд дипломын дээд боловсролын хөтөлбөрөөр элсэлт авахгүй болсонтой холбон тайлбарлаж болох юм.

2017-2018 оны хичээлийн жилд докторын зэрэгтэй 23 багш ажиллаж байгаагийн 15 нь Улаанбаатар хотод, Дорнод, Увс, Ховд, Орхон аймагт тус бүр 2 багш докторын зэрэгтэй байна. Харин магистр зэрэгтэй багш нарын эзлэх хувиар Говь-Алтай 31.3 хувьтай хамгийн өндөр байгаа бол Дархан-Уул, Ховд, Дорнод, Завхан, Орхон, Баянхонгор аймаг 15.3-19.5 хувьтай байна. Улаанбаатар хотын багш нарын 14.9 хувь нь магистр, бусад аймгуудад магистр зэрэгтэй багш нарын эзлэх хувь 6.4-13.44 хувьтай байна. Энэ нь орон нутагт нь болон ойрхон аймаг, бүсэд нь боловсролын үйлчилгээ үзүүлж буй их, дээд сургууль байдагтай холбож тайлбарлаж болохоор байна. Тухайлбал Завхан, Орхон аймагт МУИС-ын харьяа салбар сургуультай, Ховд аймагт Ховд Их сургууль, Дорнод аймагт Дорнод дээд сургууль үйл ажиллагаа явуулдаг. Дархан-Уул аймагт ШУТИС-ийн харьяа салбар сургуулиас гадна хувийн хэд хэдэн дээд сургууль үйл ажиллагаа явуулдагас гадна Улаанбаатар хотын их, дээд сургуульд суралцах боломж өндөртэй байдаг.


### 2.3.3.3. Багшлах эрх

Монгол Улсын “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “Багш нь багшлах эрхтэй байна” гэсэн заалт тусгагдсан байдаг. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь 2004-2013 онд багшлах эрх олгох ажлыг хариуцаж байсан ба 2013 онд БШУ-ы Сайдын тушаалаар багшлах эрх олгох, сунгах, хасах журам шинэчлэгдэн батлагдаж, тус журмыг хэрэгжүүлэх ажлыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд шилжүүлсэн юм.

Багшийн мэргэжил, мэргэжлийн ур чадвартай холбоотой 2008 оны багц журамд багшлах эрхийг багш мэргэжлийн онцгой хариуцлага, үндсэн чиг үүрэг, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэх чадварыг баталгаажуулах; мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг багш нэг бүрийн хөгжлийг дэмжиж, багш бүрд тэгш боломж олгох; мэргэжлийн ур чадварын өсөлт, энэ өсөлтийн төлөө шударга өрсөлдөөнийг 3 шатлал бүхий хэмжээсжүүлсэн шалгуураар үнэлэн шалгаруулж, боловсролын агуулга, арга зүйн шинэчлэлийг сургууль, орон нутаг, үндэсний түвшин бүрд түүчээлэн үр нөлөөгөө үзүүлж, хөгжлийн дотоод хөдөлгөгч хүч болгох бодлогыг тус тус баримтлан боловсруулжээ.


Харин 2013 оны багц журамд дээр дурдсан суурь шийдлүүдийг үндсэндээ хадгалсан боловч, зарим шинэ харилцааг бий болгож, 2014 оноос эхлэн дараах үйл явцын дагуу багшлах эрх олгох, сунгах ажлыг БМДИ зохион байгуулах болсон байна (Зураг 2.3.10.).

Зураг 2.3.10. Багшлах эрх олгох, сунгах зохицуулалт (2014-2018)



Багшлах эрх олгохдоо БШУ-ы Сайдын 2014 оны А/234 дугаар тушаалаар байгуулагдсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт багшаар ажиллах эрх олгох зөвлөл”-өөс мэргэжил арга зүйн удирдлагаар хангадаг бөгөөд БМДИ нь аймаг, нийслэлийн боловсролын газруудтай хамтран цэцэрлэг, ЕБС-д эхний нэг жил ажиллах эрхийн шалгалтыг орон даяар нэг өдөр, нэгэн зэрэг онлайнаар зохион байгуулж тестийн шатны шалгалтын дүнг системээс шууд харах боломжийг олгож ажилладаг байсан (Зураг 2.3.11).

Зураг 2.3.11. Эхний нэг жил багшаар ажиллах эрх олгох шалгалтын зохион байгуулалт (2014-2018)



2014-2018 онд 10 удаагийн шалгалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулахад давхардсан тоогоор 34267 иргэн оролцсон ба шалгалтад тэнцсэн 14986 иргэнд Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын сургалтын байгууллагад эхний нэг жил ажиллах эрх олгогдсон байна (Зураг 2.3.12).

Зураг 2.3.12. Эхний нэг жил ажиллах эрхийн шалгалтын тоон мэдээлэл (2014-2018)




ЕБС, цэцэрлэгийн багшид багшлах эрх олгохдоо журамд заасны дагуу дараах шалгуурыг баримталдаг (Хүснэгт 2.3.4.).

Хүснэгт 2.3.4. Цэцэрлэг, ЕБС-ийн багшид багшлах эрх олгох шалгуур (2014-2018)

Нийтлэг шалгуур	Тусгай шалгуур
<ul style="list-style-type: none"> <li>• Багш мэргэжлийн бакалавр, түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх</li> <li>• Багшийн ёс зүйг чанд сахин, холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажилласан байх</li> <li>• Суралцагч нэг бүрийн авьяасыг нээх, хөгжлийг дэмжих арга зүй, технологийг эзэмшсэн байх</li> <li>• Судалгаа хийх, гадаад хэл, МХХТ-ийн зохих түвшний мэдлэг, чадвартай байх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цэцэрлэг, ЕБС-д нэгээс доошгүй хичээлийн жил ажилласан байх</li> <li>• Эхний жилдээ ажиллаж буй багшийн үндсэн сургалтад хамрагдсан байх</li> <li>• Ажиллах хугацаандаа хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа өөрийн үнэлгээ дүгнэлт гаргасан байх</li> <li>• Харьяалагдан ЗАН-ийн үнэлгээ дүгнэлтээр багшлах эрх олгохыг дэмжсэн байх</li> </ul>

Дээрх шалгуурын дагуу БМДИ нь 2014-2018 онд нийт 10515 багшид багшлах эрх шинээр олгож, 13074 багшийн багшлах эрхийг сунгасан байна (Зураг 2.3.13).

Зураг 2.3.13. Багшлах эрх олгосон, сунгасан тоо (2014-2018)



Сургуулийн өмнөх болон Бага, дунд боловсролын тухай хуулинд “Багш нь багшлах эрхтэй байна” гэсэн заалтыг үндэслэн багшлах эрх олгох, сунгах харилцааг зохицуулж байсан боловч 2018 онд УИХ-аас Багшийн хөгжлийг дэмжих тухай шинэ хууль батлагдаж тус хуулинд “Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй” байхаар хуульчилж өгсөн тул цаашид энэ харилцааг хэрхэн зохицуулах нь тодорхойгүй хэвээр байна.

### 2.3.3.4. ЕБС-ийг 12 жилд шилжүүлэн 6 настай хүүхдийг сургах хүний нөөцийн бэлтгэл

2008-2009 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийг 12 жилийн сургалтад шилжүүлж, 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэх болсонтой холбоотойгоор БСШУ-ны Сайдын 2007 оны 04 дүгээр тушаалаар баталсан графикайн дагуу БСШУ-ны Сайдын 2008 оны 298 дугаар тушаалаар Дэлхийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байсан “Үр дүнд түргэн хүрэх санаачилга” хөтөлбөрийн “Бага боловсролын чанарыг дээшлүүлэх” төсөл, мөн АХБ-ны төслийн хүрээнд 6 настай хүүхдэд хичээл заах, тэдэнтэй ажиллах арга зүйн сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлыг 4 жил дараалан зохион байгуулсан байна.

- БСШУЯ-аас 2008-2012 онд 6 настай хүүхдийг сургууль, нийгмийн орчинд дасгаж, сурах арга барил эзэмшүүлэх, тэдний бие бялдар, оюун ухаан, сэтгэл нийгэмшлийн хөгжлийг багшлах үйлээр дэмжин тэтгэх арга зүйд бага ангийн бүх багшаа сургах зорилгоор харилцан уялдаатай модулиуд бүхий нэгдсэн агуулгатай цуврал сургалтыг 4 жил дараалан зохион байгуулжээ. 2008-2009 оны хичээлийн жилд
  - Бага ангийн сургалтын менежерийн сургалт (532 менежер)
  - БСГ-ын бага ангийн арга зүйчдийн сургалт (30 арга зүйч)
  - Дотуур байрны багш нарын сургалт (589 дотуур байрны багш)
- 2009-2010 оны хичээлийн жилд
  - II, III, VIII ангид хичээл заах багш нарын сургалт (14 чиглэлээр 358 үндэсний сургагч, хичээл заах бүх багш)
  - Шилжилтийн VII ангийн багш багш нарын сургалт (135 үндэсний сургагч, хичээл заах бүх багш)
- Сургуулийн нийгмийн ажилтны сургалт (624 нийгмийн ажилтан)
- 2010-2011 оны хичээлийн жилд
  - IV ба IX ангийн багш нарын сургалт (27 хөтөлбөр, хичээл заах бүх багш)
 (Хүснэгт 2.3.5).

Хүснэгт 2.3.5. ЕБС-ийн I ангид хичээл заах багш нарын сургалтууд (2008/09-2011/12 оны хичээлийн жил)

Хичээлийн жил	Хамрагдсан багш	Гарын авлагын нэр	Хэвлэлийн хуудас, хэвлэсэн тоо	Сургалт, гарын авлагын нийт зардал (сая ₮)	Санхүүжүүлэгч	Зохион байгуулагч
2008-2009	1541	“Зургаан настай хүүхдийн сурах, сургах арга зүй”	25, 2000 хувь	220	Дэлхийн Банк, Каталик сан, Бүх нийтийн боловсролын үр дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөр	БСШУЯ
2009-2010	1597	“Зургаан настай суралцагч”	25, 9000 хувь	302,4		БСШУЯ
2010-2011	1727	“Зургаан настай суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилтийн үнэлгээ”	7, 2000 хувь	234,3		БСШУЯ
2011-2012	1703	Дээрх 3 гарын авлага		78,9	АХБ	БХ

Эдгээр сургалтын үр дүнд бага ангийн бүх багш 6 настай хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцах үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан бөгөөд эдгээр цуврал сургалтаар бэлтгэгдсэн багш нар жил дарааланаймаг, нийслэлийн болон сургуулийн түвшний сургалтуудыг зохион байгуулж, бүх багш гарын авлагаар хангагдах замаар Монгол Улсад 6 настай хүүхдийн сургуульд сургах арга зүйг бага ангийн бүх багш эзэмшсэн байна. Түүнчлэн үндэсний сургагчид бэлтгэх сургалтад багш бэлтгэдэг их дээд сургуулийн багш нар хамрагдаж, багш бэлтгэх сургалтын хөтөлбөрт ч 6 настай хүүхэдтэй ажиллах арга зүй тусгагдаж, улмаар бага насны хүүхдүүдтэй ажиллаж чадах багш нар бэлтгэгдэж эхэлсэн байна.

БСШУЯ-аас ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх графикийн дагуу 6 настай хүүхдийн I ангийн багш нараас гадна бусад албан тушаалтны сургалтууд болон сургалтын шинэ төлөвлөгөө, хөтөлбөрөөр хичээллэх бүх багшийг бэлтгэх сургалтуудыг жил дараалан 2 үе шаттайгаар зохион байгуулж, тухайн хичээлийн жилийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж, гарын авлагыг бүх багш нарт хүрэлцэхүйц хэмжээнд хэвлэн хүргүүлж иржээ.

### 2.3.3.5. Багшийн хөгжил, мэргэжил дээшлүүлэлт

1990 онд Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт татан буугдсанаар энэ төрлийн үйл ажиллагаа олон улсын болон, гадаад улсаас боловсролын салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүдийн дэмжлэгтэйгээр явагдаж байсан ба 2008 онд “Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам” батлагдсанаар мэргэжил дээшлүүлэх шинэ тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх үндэс суурь тавигдсан. Энэ журмаар *үндсэн, төрөлжсөн, бие даасан* гэсэн хэрэгцээ, зорилго, арга хэлбэрээрээ ялгаатай 3 төрөл бүхий сургалтад суурилан мэргэжил дээшлүүлэх үндэсний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, эдгээр сургалтын төлөвлөлт, зохион байгуулалт, зардлын санхүүжилт, мэдээлэл, хяналт-шинжилгээний асуудлыг цогцоор шийдвэрлэх эхлэл тавигджээ. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт нь багш бүрд арга зүй, ур чадвараа дээшлүүлэх тэгш боломж олгож, багш нарт адил тэгш хандах зарчмыг хэрэгжүүлж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой байв. Төрөлжсөн сургалтууд нь сургууль, багш нарын тусгай эрэлт хэрэгцээнд түлхүү суурилах бол бие даах сургалтад мэдээлэл харилцааны технологийг түлхүү ашиглах онцлогтой ажээ.

“Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам” (БСШУ-ы Сайдын 72 дугаар тушаал, 2008)-ыг үндэслэн БСШУЯ-аас багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг эхлүүлэхийн тулд 2010-2012 оны хэрэгцээний судалгааг аймаг, нийслэлээс авч, ойрын гурван жилийн сургалтын төлөвлөлт, зураглал хийх, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтыг зохион байгуулах ажлыг эхлүүлсэн байна. (БСШУЯ, 2012). Санхүүгийн болон хүний нөөцийн боломж, тухайн үеийн багш нарын ажилласан жилийн бүтцийн онцлог зэргийг тооцоод эхний ээлжид анхны болон тав дахь жилдээ ажиллаж буй багш нарт зориулсан үндсэн сургалтыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн байна. Энэ шийдвэр нь 2009-2010 оны хичээлийн жилийн байдлаар сургуульд ажиллаж байгаа нийт багшийн гуравны нэг гаруй нь эхний 5 ба 6 жил ажилласан багш нар эзэлж байсан тул тэдний цогц чадамжид суурилсан боловсролын шинэ стандарт, ТХБ-ын үзэл санаа, агуулга, аргазүйд үндэслэсэн үндэсний нээлттэй хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн талын мэдлэг сул, туршлага бага байгааг харгалзан үзсэн явдал байв.

Дээрх журмын холбогдох заалтын дагуу 2010 онд анх удаа цэцэрлэг, ЕБС-д таван жил ажилласан багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын хөтөлбөрийг агуулгын 8 чиглэлээр шалгаруулан сайжруулж, “Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ”-ний зарчмаар Боловсролын хүрээлэн хариуцан гүйцэтгэсэн байна. Улаанбаатар, Ховд, Завхан гэсэн гурван бүсэд зохион байгуулсан 7 хоногийн хугацаатай эдгээр сургалтад 5 дахь жилдээ ажиллаж байсан нийт 847 багш хамрагдаж, улсын төсвөөс 202,0 сая төгрөг зарцуулжээ. Өмнөх жилийн сургалтын хөтөлбөрийг сайжруулж, 2010 оны менежментээр 2011 оны үндсэн сургалтыг зохион байгуулсан бөгөөд нийт 9 удаагийн 41 сургалтад цэцэрлэгийн 205, ЕБС-ийн 1242, нийт 1447 багш хамрагдаж, улсын төсвөөс 320.5 сая төгрөг зарцуулжээ (БСШУЯ, 2012). Харин 2012 онд мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт зохион байгуулагдаагүй байна.

2012 онд Багшийн мэргэжил дээшлүүлэх институт 3 дахь удаагаа дахин шинээр байгуулагдсан билээ. Ийнхүү төсөл, хөтөлбөрийн менежментээр эхэлж, улмаар журмаар зохицуулагдаж байсан багшийн мэргэжил дээшлүүлэх харилцаа хуульчлагдаж, институтчилагдсанаар Монголд багш нэг бүр ажиллах нийт хугацаандаа төрийн санхүүжилтээр мэргэжил, арга зүйгээ системтэйгээр дээшлүүлж байх тогтолцоо бүрэлдэн төлөвшиж байна.




Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа нь институцэд суурилан энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлдэг төрийн болон иргэний нийгмийн байгууллага, олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулах зарчимд тулгуурладаг. Салбарын хэмжээнд багшийн мэргэжил дээшлүүлэх харилцааг 2013 онд шинэчлэн баталсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-аар зохицуулж байна.

Тус журмаар ЕБС, цэцэрлэг, албан бус боловсрол/насан туршийн боловсролын төвийн багш, ажилтан (захирал, эрхлэгч, сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйч, дотуур байрын багш, номын санч, эмч, туслах багш)-ы мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг зохицуулдаг. Мэргэжил дээшлүүлэх сургалтыг танхимын, зайн, онлайн сургалтын хосолсон хэлбэрээр үндэсний, орон нутгийн болон ажлын байранд нь буюу байгууллагын түвшинд зохион байгуулдаг (БШУ-ы Сайдын А/287 дугаар тушаал, 2013).

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь үндэсний хэмжээнд багшийн мэргэжил дээшлүүлэх чиг үүрэг бүхий сургалт арга зүйн байгууллага бөгөөд Аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх, боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш, иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэжлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд нь туслах чиг үүргийг хэрэгжүүлж байна (БШУ-ны Сайдын А/315 дугаар тушаал, 2013).

Багш мэргэжлийн тасралтгүй хөгжих хэрэгцээ судалгааны тайлангийн (БМДИ & Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл, 2016) үр дүнд үндэслэн “Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангах үйл ажиллагаанд сургууль ба багш, орон нутгийн БСГ, БМДИ зэрэг субъектүүдийн үүрэг, оролцоо, ажлын уялдаа”-г диаграммаар үзүүлжээ (Зураг 2.3.14).

Зураг 2.3.14. Сургууль ба багш, орон нутгийн БСГ, БМДИ зэрэг субъектүүдийн үүрэг, оролцоо, ажлын уялдаа



Эх сурвалж: Багш мэргэжлийн тасралтгүй хөгжих хэрэгцээ судалгааны тайлан.

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дээрх үйл ажиллагаа дотроос багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтуудын зохион байгуулалт нь багшийн мэргэжил дээшлүүлэх журмаар зохицуулагдсан байдаг (Зураг 2.3.15).


Зураг 2.3.15. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын зохион байгуулалтын хэлбэр (2019)



**Үндэсний хэмжээний үндсэн сургалт**


БМДИ байгуулагдсанаар 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш, ажилтны үндэсний хэмжээний үндсэн сургалтыг 2013 оноос эхлэн зохион байгуулж байна. Энэ хугацаанд нийт 27499 багш үндсэн сургалтад хамрагджээ (Зураг 2.3.16).

Зураг 2.3.16. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын тоо (2013-2017)




Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 2013-2017 онд нийт 26190 багш, ажилтан хамрагдаж, нийт 7 тэрбум төгрөгийн төсөв зарцуулсан байна (Зураг 2.3.17).

Зураг 2.3.17. Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын төсөв (2013-2017, сая төгрөг)



ЕБС-д 1,5,10 дахь жилдээ ажиллаж буй багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын зардлын хэмжээ буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2017 онд нэг багшид ногдох сургалтын зардлын хэмжээ 2015 оныхоос 2 дахин багассан байна (Зураг 2.3.18). Энэ нь нэг талаар батлагдсан төсвийн хүрээнд бага, зардлаар сургалт явуулахад анхаарч эхэлсэн ч сургалтын орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, цахим агуулга боловсруулах гэх мэт шаардлагатай хэсгүүдэд санхүүжилт олгохгүй байгаа сул талтай.

Зураг 2.3.18. Нэг багшид ногдох сургалтын зардлын хэмжээ (2013-2017, төгрөг)



Эхний, 5 ба 10 дахь жилийн үндсэн сургалтуудын агуулга нь боловсролын чанарын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, мэргэжлийн онол, мэргэжлийн дидактик, сурган хүмүүжүүлэх ухаан-сэтгэл судлал болон цахим сургалт гэсэн 5 багцаар төлөвлөгддөг ба сургалтыгонол, арга зүйн сургалт-семинар, лекц-мэдээлэл, практик-дадлага, туршлага хуваалцах, ярилцлага-хэлэлцүүлгийн хэлбэрээр тус тус зохион байгуулдаг.

Эхний жилийн сургалтын агуулга нь ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд түлхүү анхаарч, багшийн сурган хүмүүжүүлэх арга барил, ажлын байранд шаардлагатай ур чадварыг дэмжихэд чиглэсэн “Албан бичиг хөтлөлт”, “Анги удирдсан багш, эцэг эхийн харилцаа” зэрэг сэдвийн багтаамж илүү төлөвлөгддөг.

5 дахь жилийн багшид зориулсан үндсэн сургалтын агуулга нь хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга, технологид суралцуулах, цаашид бие даан ажлын байран дээр өөрийгөө хөгжүүлэх арга барил эзэмшүүлэхэд илүү анхаарч, багшийн мэргэжлийн арга зүйг дэмжихэд чиглэсэн агуулга түлхүү төлөвлөгдсөн байдаг байна.

Харин 10 дахь жилдээ ажиллаж буй багшийн сургалтын хөтөлбөрийн агуулга нь багшийн мэдлэг, чадвар, арга туршлагаа хуваалцах, харилцан суралцах, дидактикийн шинэ онол, арга зүй, туршилт судалгааны ур чадвар, зөвлөн туслах арга барил эзэмшихэд чиглэсэн агуулга, арга зүйд түлхүү төвлөрдөг байна.


Багшийн үндсэн сургалтыг мэргэшлийн 15 чиглэлээр, ажилтны үндсэн сургалтыг сургалтын менежер, нийгмийн ажилтан, арга зүйч, захирал, эрхлэгч, номын санч, эмч дотуур байрны багш, согог зүйч зэрэг зорилтод бүлэг бүрийн ажил, үүргийн чиглэлээр тус тус зохион байгуулж байна.

**Төрөлжсөн сургалт**

Багшийн мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн сургалтыг БМДИ, аймаг, нийслэлийн боловсролын газрууд зохион байгуулахаас гадна багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд өөрсдийн санаачилгаар зохион байгуулдаг.

Багшийн мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн сургалтын зорилго нь боловсролын бодлого, чиглэлийг таниулах, хэрэгжүүлэх арга зам болон мэргэжлийн тусгай дидактикийн ур чадварт суралцах, хувь хүний хөгжил, мэдлэг ур чадварыг дэмжихэд орших ба БМДИ нь БСШУСЯ, боловсролын мэргэжлийн байгууллага, хөтөлбөрийн багуудтай хамтран жил бүр төрөлжсөн сургалт зохион байгуулдаг.

Зураг 2.3.19. БМДИ-ээс зохион байгуулсан төрөлжсөн сургалтад хамрагдсан цэцэрлэг, ЕБС-ийн багш, ажилтны тоо (2013-2017)



БМДИ нь зөвхөн 2013 онд “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга зүй, технологи”-ийг 23,871 багш, ажилтанд зориулан зохион байгуулсан бол 2013-2017 онуудад жил бүр Бага дунд, боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Үндэсний хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалт”-ыг 48,671 багш, “Боловсролын газрын мэргэжилтэн, лаборатори сургуулийн удирдах ажилтны сургалт”-ыг 1205 багш, “Лаборатори сургуулийн багш нарт хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалт”-ыг 4324 багш ажилтныг хамруулан тус тус зохион байгуулснаас гадна нийт 220 сургуульд Мониторинг, зөвлөн туслах үйл ажиллагааг БШУЯ, БХ, Хэрэгжилтийн багтай хамтран БСШУСЯ-ны төсөв, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, ТХБ төслийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан байна.

Үүнээс гадна БМДИ нь үндэсний хэмжээнд 2016-2017 онд дараах төрөлжсөн сургалтуудыг зарим олон улсын төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр зохион байгуулжээ (Хүснэгт 2.3.6).


Хүснэгт 2.3.6. БМДИ-ийн зохион байгуулсан төрөлжсөн сургалтууд (2016-2017)

№	Сургалтын нэр	Хамрагдсан хүний тоо	Зарцуулсан хөрөнгө	Санхүүжилтийн эх үүсвэр	Он
1	Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хүрээнд "Бүрэн дунд боловсролын багш нарт зориулсан" сургалт	10,500	172,752,295	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг	2016
2	Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хүрээнд "Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт" сургалт	2,648	94,923,217	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг	2016
3	Мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсролыг интеграцчилах арга зүй сургалт	243	65,586,200	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг	2016
4	Залуучуудын хөгжлийн төслийн хүрээнд "Амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсрол болон амьдрах ухааны боловсролын тогтвортой байдлыг хангах" сургалт 21 аймаг БСУГ, 9 дүүргийн Боловсролын хэлтсийн дарга нарт	243	18,249,188	НҮБ-ийн Хүн амын сан	2016
5	Тогтвортой хөгжлийн боловсрол төслийн хүрээнд аймаг нийслэлийн БСУГ-ын мэргэжилтнүүдэд	243	65,471,278	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг	2016
6	Залуучуудын хөгжлийн төслийн хүрээнд "Амьдрах ухаанд суурилсан эрүүл мэндийн боловсрол болон амьдрах ухааны боловсролын тогтвортой байдлыг хангах" сургалт боловсролын удирдах ажилтнуудад	45	9,075,000	НҮБ-ийн Хүн амын сан	2016
7	STEM боловсролыг бага боловсролд хэрэгжүүлэх арга зүй	3,393	192,485,090	Дэлхийн банк	2017
8	Багшийн ёс зүй, харилцаа	761	248,850,865	Германы хамтын ажиллагааны нийгэмлэг	2017
9	29-р тусгай сургуулийн багш нарт мэргэжлийн хичээлийг дохионы хэлээр заах аргагүй, ур чадварыг сайжруулах эрчимжүүлсэн сургалт	95	14,377,300	Улсын төсөв	2017
10	Гамшгаас хамгаалах менежмент	60	20,711,700	Японы хүүхдийг ивээх сан болон Дэлхийн зөн ОУБ	2017
11	Сарын тэмдгийн эрүүл ахуй сургуулийн орчинд	50	7,666,703	НҮБ-ийн Хүүхдийн сан	2017
		<b>18281</b>	<b>910,148,836</b>		

2013 онд “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам” (БШУ-ы Сайдны А/287 дугаар тушаал, 2013) шинэчлэгдэн батлагдсанаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн боловсруулж ирүүлсэн хөтөлбөрт сургалт явуулах эрх олгох ажлыг 2014 оноос эхлэн БМДИ хариуцдаг болсон.


БМДИ нь 2014-2018 онд давхардсан тоогоор нийт 495 хөтөлбөрт дүгнэлт гаргаж, 339 хөтөлбөрт тодорхой агуулга бүхий төрөлжсөн сургалт явуулах эрх олгосон байна (Зураг 2.3.20). Эдгээр хөтөлбөрүүдийг ижил шалгуураар үнэлж дүгнэлт гаргадаг боловч эрх олгогдсон хөтөлбөрийн тоо буурсан нь шаардлага хангасан хөтөлбөрийн тоо цөөн байгааг илтгэж байна.

Зураг 2.3.20. Төрөлжсөн сургалтын хөтөлбөрийн тоо (2014-2018)



Эдгээр хөтөлбөрүүдийг сургалтын агуулга, хөтөлбөрийн нэрээр ангилж үзвэл хүүхэдтэй ажиллах арга зүй, багшийн хөгжил, сургалтын арга зүй, технологи, тухайн судлагдахууны мэргэжлийн онол, арга зүйн сургалтууд хамгийн олон давтамжтай байна (Зураг 2.3.21).

Зураг 2.3.21. БМДИ-ээс батлагдсан төрөлжсөн сургалтын хөтөлбөрийн чиглэл, тоо (2014-2018)



Дээрх хөтөлбөрүүдийн 50 гаруй хувь нь бүх багшид зориулсан байдаг бол 22 хувь нь бага боловсрол, 15 хувь нь СӨБ-ын багшид үлдсэн хувь нь бусад мэргэжлийн багш, ажилтанд зориулсан хөтөлбөрүүд байна (Хүснэгт 2.3.7).

Хүснэгт 2.3.7. Төрөлжсөн сургалтын хөтөлбөрийн зорилтот бүлэг (2018)

№	Зорилтот бүлэг	2014	2015	2016	2017	2018
1	Бүх багш нарт	46	44	30	29	32
2	Бага боловсрол	7	12	14	17	13
3	Сургуулийн өмнөх боловсрол	4	9	7	9	9
4	Удирдах ажилтан	8	4	5	1	2
6	Биологи	3	2	2	1	0
7	Математик	1	1	2	2	1
8	Англи хэл	2	1	1	0	0
9	Физик	4	0	0	0	0
10	Мэдээллийн технологи	3	0	0	1	0
11	Түүх, нийгмийн ухаан	2	0	1	1	0
12	Дизайн технологи	0	1	1	0	1
13	Монгол хэл, Уранзохиол	1	0	0	0	1
14	Хими	1	0	0	1	0
15	Орос хэл	1	0	0	0	0
16	Газарзүй	1	0	0	0	0
	<b>Нийт батлагдсан хөтөлбөрийн тоо</b>	<b>84</b>	<b>74</b>	<b>63</b>	<b>62</b>	<b>59</b>

Багш мэргэжлийн тасралтгүй "хөгжлийн хэрэгцээ" судалгааны тайланд (БМДИ & Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл, 2016) багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хэрэгцээг дараах байдлаар тодорхойлсон байна (Хүснэгт 2.3.8).

Хүснэгт 2.3.8. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтууд юунд илүү анхаарах шаардлагатай талаар багцлан үзүүлсэн байдал

<i>Багшийн мэргэжлийн үр чадварт</i>	
1	Сайн туршлагыг хуваалцах, түгээн дэлгэрүүлэх
2	Багш нарын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх
3	Сурагчдын сэтгэл судлал, зан авирыг судлах, зөвлөн туслах
<i>Багшийн мэргэжилдээ хандах хандлагад</i>	
1	Багш нарын мэргэжилдээ хандах хандлагыг сайжруулах
2	Багш нарт шинэ сэдэл, тэмүүлэл төрүүлэх
<i>Багшийн боловсролын талаарх мэдлэгт</i>	
1	Боловсролын талаарх ерөнхий мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх
<i>Бусад</i>	
1	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
2	Сургалтын үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах

ТХ, ТХБ, ТХЗ-2030-ыг сургалтын хөтөлбөр, арга зүйдээ интеграцчилах дэлхий нийтийн зорилтын хүрээнд Монгол Улс чамлалтгүй хүчин чармайлт гарган ажиллаж ирсэн байна. Тухайлбал, 2015-2018 онд ШХА болон түүнтэй хамтрагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Тогтвортой хөгжлийн боловсрол” төслийн хүрээнд БМДИ нь 5 дахь жилдээ ажиллаж байгаа багш, ажилтны үндсэн сургалтын хөтөлбөрт ТХБ-ын агуулга арга зүйг хэрхэн туссан байдлыг үнэлсэн томоохон судалгааны ажил (ТХБ төсөл, БОНХАЖЯ, 2016) хийгдсэн байна.

БМДИ-ээс санаачлан 2018 онд “ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй” гэсэн багш нарт зориулсан 880 хуудас бүхий гарын авлагыг хэвлэн гаргаж, бүх сургуульд хүргэсэн ба тус байгууллагын сайт дээр тавьж, багш бүр судлах, ашиглах боломжтой болсон байна. Энэ бүтээл нь гарын авлага гэсэн нэртэй боловч түүнийг боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн томоохон 2 судалгааны үр дүнд үндэслэн багш нар ТХЗ-2030-ийн 17 зорилтын агуулга, мөн чанар, харилцан хамаарлыг ойлгож, ТХЗ төлөөх боловсролын литерасид тайлагдах, боловсролын хөгжлийн шинэ алсын хараанд чиглүүлэн өөрсдийн үйлээ тохируулан өөрчилж, багш нарт ТХЗ-ын бодит хэрэгжилтийг дэмжих итгэл үнэмшил төрүүлж, хүчин чармайлтаа дайчлахад сэдэлжүүлэх зорилготой ажээ. Энэ бүтээлийн хүрээнд дараах шууд үр дүн-бүтээгдэхүүнийг гаргасан байна. Үүнд:

- Дэлхий нийтийн түвшин дэх 1972 оноос хойших ТХ, ТХБ-ын хөгжлийн замнал өрнөлийг 4 үе шатанд бүдүүвчлэн тоймлож тайлбарлах, мөн Монгол Улс дахь ТХ, ТХБ-ын хөгжлийн замнал, өрнөлийг 3 үе шатанд ялгаж нэгтгэн дүгнэх замаар “ТХЗ 4-Боловсрол-2030 Үйлийн хүрээ”-нд тодорхойлсон боловсролын алсын хараа, зорилтууд, стратегийг ойлгож ухаарах боломжийг олгосон цэгцтэй мэдээлэл ТХЗ-ын төлөөх боловсрол: Суралцахуйн зорилтууд (UNESCO, 2017) удирдамжид өгөгдсөн 255 суралцахуйн зорилт, санал болгосон 171 сэдэв,


- 119 арга техник, 8 цогц чадамж тус тус сонгож, нийт 553 индикатораар ЕБС-ийн бүх ангийн бүх хичээлийн бүх цөм хөтөлбөрт 24 үнэлгээ хийжээ. Энэ судалгаагаар цөм хөтөлбөрт тусгагдсан давхардсан тоогоор 567 суралцахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд ТХЗ-ын арга хандлагын 4 төрөлд харгалзах 895 арга техникийг хэрэглэж, ТБ-ын 8 цогц чадамжийн төлөвшилт хувь нэмэр оруулах 957 боломж байгааг илрүүлжээ.
- ЕБС-ийн цөм хөтөлбөрөөс илрүүлсэн эдгээр боломжийг ашиглаж болохыг харуулсан 1-12 ангийн нийт 24 судлагдахуунаар 46 хичээлийн жишээг боловсруулсан байна.

**Багшийн хөгжлийг дэмжих олон улсын хөтөлбөр, үйл ажиллагаа**

Монгол Улс 2006-2018 онд ОХУ, БНХАУ, БНСУ, Япон зэрэг улсуудад БСШУСЯ болон олон улсын байгууллага, бусад улс орны санхүүжилтээр нийт 1487 багшийг урт, богино хугацааны сургалтад хамруулсан байна (Зураг 2.3.22). Тухайлбал,

- 2012 оноос АРСЕИУ-ийн санхүүжилтээр Монгол-Солонгосын багш солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд БНСУ-ын дунд сургуульд Монгол улсаас 100 багш ажиллаж, арга зүй, туршлагаа хуваалцсан. Мөн тооны Солонгос багш нар Монгол улсад ажилладаг.
- 2013 онд ОХУ-ын Эрхүүгийн улсын их сургуультай байгуулсан гэрээний хүрээнд ОХУ-ын Русский мир фондын болон улсын төсвөөр орос хэлний багш нарыг зуны сургалтад, 2018 онд орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг зохион байгуулахад хамтран ажиллаж, нийт 160 багшийг сургалтад хамруулаад байна.
- БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ажил мэргэжлийн дээд сургуульд монгол бичгийн сургалтад 2016, 2017 онд хоёр талын санхүүжилтээр нийт 87 багш ажилтныг хамруулсан.
- Япон улсын ЖАЙКА олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр Япон улсад туршлага судлах хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор хичээлийн судалгааны чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээний хуралд жил бүр багш нарыг хамруулдаг.
- БСШУСЯ, Олон улсын нийгмийн халамжийн “Глокал” төв болон БНСУ дахь эмэгтэйчүүдийн холбооноос 2017, 2018 онд “Урлаг-танин мэдэхүйн боловсрол” сургалтад бага ангийн 80, технологийн 30, хөгжмийн 90 нийт 200 багшийг хамруулаад байна.
- 2017 онд БНСУ-ын Ёжү Технологийн дээд сургуультай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу 2018 онд БСШУСЯ-ны санхүүжилтээр нийслэлийн Сүхбаатар, Багануур, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн ЕБС-иудын нийт 13 багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлсэн.
- БНСУ-ын Дэжон хотын боловсролын газартай хамтран мэдээллийн технологийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах гэрээг 2002 онд байгуулж, 2007, 2011 онд тус тус сунган ажиллаж байна. Энэ гэрээгээр жил бүр 20-25 багшийг Дэжон хотод сургалтад хамруулж, нийт 350 гаруй багш МХХТ-ийн чадвараа нэмэгдүүлсэн ажээ.

Зураг 2.3.22. Гадаадад мэргэжил дээшлүүлсэн багшийн тоо: Улс орноор (2012-2018)



Хэдийгээр хүний нөөц чадавхжуулах тал дээр анхаарч ажиллаж байгаа ч тэдний сурч мэдсэн зүйлийг хэрхэн түгээн дэлгэрүүлж, үр дүнтэй ашигласан байдлын талаар мэдээлэл хомс байна.

<sup>24</sup>Судалгааны объект болгож ЕБС-ийн бүх ангийн бүх хичээлийн сургалтын цөм хөтөлбөр, шаардлагатай тохиолдолд суралцахуйн удирдамж, сурах бичгүүдийг нэмж, нийт 230 гаруй сургалтын үндсэн баримт бичгийг ашигласан байна. Судалгааны объект болгосон сургалтын эдгээр баримт бичгүүдийг энэхүү тайланд цаашид “цөм хөтөлбөр” гэсэн ерөнхий нэг нэр томъёогоор хэрэглэжээ.

**2.3.3.6. Мэргэжлийн зэрэг**

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын тухай хуулинд багшид *заах аргач, тэргүүлэх, зөвлөх багш* гэсэн мэргэжлийн 3 зэрэг олгохоор хуульчилсан байдаг. Багшид мэргэжлийн зэрэг олгох, сунгах, хасах журам 2007 онд батлагдан хэрэгжиж байгаад 2013 онд БШУ-ны Сайдын тушаалаар шинэчлэгдэн батлагдсан юм. 2014 оноос эхлэн багшид мэргэжлийн зэрэг олгохдоо дараах шалгуурыг баримталж байна (Хүснэгт 2.3.9).

*Хүснэгт 2.3.9. Цэцэрлэг, ЕБС-ийн багшид мэргэжлийн зэрэг олгох шалгуур (2014-2018)*


	Заах аргач	Тэргүүлэх	Зөвлөх
<i>Нийтлэг шалгуур:</i>			
Цэцэрлэг, ЕБС-д багшлах эрхтэй байх			
Багшийн ёс зүйг чанд сахих			
Суралцагч нэг бүрийн авьяасыг нээх, хөгжлийг дэмжих арга зүй, технологийг эзэмшсэн байх			
Судалгаа хийх, гадаад хэл, мэдээллийн технологийг зохих түвшний мэдлэг, чадвартай байх			
<i>Тусгай шалгуур:</i>			
СӨБ, ЕБС-д багшаар ажилласан жил	5 ба түүнээс дээш	10 ба түүнээс дээш	15 ба түүнээс дээш
Суралцагч бүрийг хөгжүүлэх арга зүй, технологийг сургалтын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, үр дүнд хүрсэн байх		2-оос доошгүй	4-өөс доошгүй
Суралцагч бүрийг хөгжүүлэх үйл ажиллагааныхаа хүрээнд судалгаа хийх чиглэлээр	Судалгаа хийсэн байх	Судалгаа хийж үр дүнд хүрсэн байх	4-өөс доошгүй сургуульд зөвлөн тусалсан байх

Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам (БСШУС-ын Сайдын А/812 дугаар тушаал, 2018) 2018 оны 12 сарын 20-нд шинэчлэгдэн батлагдсан ба шинэчлэгдсэн журмыг хэрэгжүүлсэн үр дүн хараахан гараагүй байна. Энэхүү журам шинэчлэгдсэнээр мэргэжлийн зэрэг олгоход дараах нийтлэг шалгуурыг баримтлахаар болсон байна. Үүнд:

- Сурагчдын сурлагын амжилт
- Багшийн мэргэжил, арга зүйн ур чадвар
- Суралцагч, багш, хамт олон, эцэг эх, асран хамгаалагчийн сэтгэл ханамж
- Өөрийгөө хөгжүүлсэн байдал гэсэн шалгуурыг баримтлахаар болжээ.

2017-2018 оны хичээлийн жилд цэцэрлэгийн багш нарын 67.5 хувь нь зэрэггүй, 27.1 хувь нь заах аргач, 5.3 хувь нь тэргүүлэх, 0.1 хувь нь зөвлөх зэрэгтэй байгаа бол ЕБС-ийн багш нарын 59.8 хувь нь мэргэжлийн зэрэггүй, 28 хувь нь заах аргач, 11.9 хувь нь тэргүүлэх, 0.4 хувь нь зөвлөх зэрэгтэй байна (Зураг 2.3.23).

*Зураг 2.3.23. Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн мэргэжлийн зэрэг (2017-2018)*




*Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик*

2012 оноос хойш мэргэжлийн зэрэгтэй багш нарын эзлэх хувь жил бүр буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд СӨБ-ын багш нарын дунд мэргэжлийн зэрэгтэй багш нарын эзлэх хувь ЕБС-ийн багш нарынхаас бага байна. Ялангуяа зөвлөх зэрэгтэй багшийн эзлэх хувь маш бага буюу ЕБС-д 0.4%, СӨБ-д 0.1 байна. Зэрэггүй багш нарын эзлэх хувь ЕБС-д 2012 онд 50 хувь байсан бол 2018 онд 60 хувь болтол, СӨБ-д 62 хувиас 67.5 хувь болтол өссөн байна (Зураг 2.3.24).

Багшид мэргэжлийн зэрэг олгоход 2014 оноос хойш ижил шалгуураар дүгнэж байгаа ч жил бүр зэрэгтэй багшийн тоо буурч байгаа нь шинээр мэргэжлийн зэрэг авч буй багшийн хувь буурсан болохыг харуулж байна.



Зураг 2.3.24. Цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын мэргэжлийн зэрэг (2012/13-2017/18)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Тухайн аймаг, орон нутагтаа зөвлөх зэрэгтэй багшийн эзлэх хувь хамгийн өндөр нь Дархан-Уул 3.41, Ховд 1.27, Орхон 1.18 байна. Харин Завхан, Говь-Алтай, Говьсүмбэр, Хэнтий, Баянхонгор, Баян-Өлгий, Булган аймгийн багш нарын 0.3-1 хувь нь зөвлөх зэрэгтэй бол Дорнод, Сүхбаатар, Дундговь, Архангай аймагт зөвлөх зэрэгтэй багш байхгүй байна. Дорнод, Сүхбаатар, Баянхонгор, Завхан, Баян-Өлгий, Өвөрхангай, Говь-Алтай аймгийн багш нарын 20-30 хувь нь тэргүүлэх зэрэгтэй бол Улаанбаатар, Хөвсгөл, Увс аймгийн багш нарын 10 хүрэхгүй хувь нь л тэргүүлэх зэрэгтэй байна.

Заах аргач зэрэгтэй багшийн эзлэх хувь Улаанбаатар, Хөвсгөл, Увсад 8-9.8 хувь, Говь-Алтай, Өвөрхангай, Баян-Өлгий, Завхан, Баянхонгор, Сүхбаатар, Дорнод аймагт 20-30 хувь, бусад аймагт 10-20 хувьтай байна. Зэрэггүй багшийн эзлэх хувь хамгийн өндөр нь Увс 61.1, Улаанбаатар 59.2, Хөвсгөл 59.1, Сэлэнгэ 58.4 хувьтай бөгөөд бусад аймагт 33.6-55.7 хувь байна.

2014-2018 онд зөвлөх багш мэргэжлийн зэрэг олгуулах хүсэлт гаргаж зэрэг авсан багш нарын мэдээллийг Хүснэгт 2.3.10-т харуулав.

Хүснэгт 2.3.10. Зөвлөх багш мэргэжлийн зэрэг олгуулах хүсэлт гаргасан, зэрэг авсан багш нарын тоо (2014-2018)

	2014	2015	2016	2017	2018	Нийт
Материал ирүүлсэн	66	86	100	97	103	456
“Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг авсан	28	39	59	72	68	266
Шалгуур хангасан багшийн эзлэх хувь	42.4%	45.3%	59%	74.2%	66%	58.3%

2013-2014 онд “зөвлөх багш” мэргэжлийн зэрэгтэй багш нарыг сургалтуудад хичээл заалгах, зөвлөн туслуулах чиглэлээр хамтын ажиллагаа хязгаарлагдаж байсан бол 2015 оноос эхлэн “Зөвлөх багш нарын уулзалт зөвлөгөөн”-ий үйл ажиллагааг зохион байгуулж, хоорондын туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн. “Зөвлөх багш нарын тэргүүн туршлагын гарын авлага”-ыг эмхтгэн хэвлүүлэн бүх сургуулиудад түгээж, цахим хуудсанд онлайн хэлбэрээр байршуулж нийтэд унших боломжийг олгодог байна.

### 2.3.3.7. Багшийн ажлын норм, цалин хөлс

БСШУ, НХХ, Сангийн Сайдын 2007 оны 307/91/237 тоот хамтарсан тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн цалин хөлсийг тооцож олгох журам”-д багшийн ажлын бүтэц, нормыг дараах байдлаар тодорхойлсон байна.

- Цэцэрлэг, сургуулийн багш нарын долоо хоногт ажиллах ачаалал нь 40 цаг.
- ЕБС-ийн багш долоо хоногт стандартыг хэрэгжүүлэх 34 цаг, бусад 6 цагийн ажил гүйцэтгэх ба стандартыг хэрэгжүүлэх 34 цагийн 19 нь хичээл заах цаг байна.

Түүнчлэн багшийн ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт (БСШУ-ы Сайдын 351 дүгээр тушаал, 2007)-од багшийн гүйцэтгэх үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа, тэдгээрийг гүйцэтгэхэд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагууд тус тус тодорхойлогдсон байна (Хүснэгт 2.3.11)..

*Хүснэгт 2.3.11. Багшийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн чиг үүрэг, гол үйл ажиллагаа*

<p><b>Стандартыг хэрэгжүүлэх</b>  <i>Сургалтын хөтөлбөр (куррикулум) төлөвлөн боловсруулах</i></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Заах аргын нэгдлийн гишүүдтэй хамтарч ажиллах</li> <li>2. Боловсролын стандарт, бүх түвшний сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг судлах</li> <li>3. Суралцагчдынхаа суралцах хэрэгцээ, сонирхлыг судлах</li> <li>4. Судлах агуулгаа сонгох, төлөвлөх, боловсруулах</li> <li>5. Сургалтын хэлбэрээ сонгох, арга зүйгээ боловсруулах</li> <li>6. Сургалтын хэрэглэгдэхүүнээ судлах, сонгох, бэлтгэх</li> <li>7. Сурагчдын сурлага, хүмүүжлийг үнэлэх үнэлгээний даалгавар, арга, хэлбэрээ сонгох, боловсруулах</li> <li>8. Явцын болон үе шатны хяналт-шинжилгээ, үнэлгээг төлөвлөх, зохион байгуулах</li> </ol> <p><i>Сургалтын хөтөлбөрөөр хичээл заах</i></p> <ol style="list-style-type: none"> <li>9. Хичээлдээ бэлтгэх</li> <li>10. Хичээлээ зохион байгуулах</li> <li>11. Журнал хөтөлж, ажиглалт тэмдэглэл хийх</li> </ol> <p><i>Сургалтын хөтөлбөрөө үнэлж, сайжруулах</i></p> <ol style="list-style-type: none"> <li>12. Бусад багш нарын болон өөрийнхөө хичээлд анализ хийх</li> <li>13. Суралцагчдын хүмүүжил, төлөвшилт анализ хийх, зөвлөх</li> <li>14. Сурагчдын суралцах үйл явц, үр дүнг үнэлэх, оношлох</li> <li>15. Сургалтын хөтөлбөртөө анализ хийх</li> <li>16. Сургалтын хөтөлбөрөө сайжруулах</li> </ol>	<p><b>Бусад ажил гүйцэтгэх</b>  <i>Сургалтын үйл ажиллагааг дэмжих</i></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Анги, танхим, кабинет, сургууль орчноо тохижуулах</li> <li>2. Сургалтын баримт бичиг (журнал, судалгаа, хувийн хэрэг, мэдээ) хөтлөх</li> <li>3. Олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулах, оролцох</li> <li>4. Жижүүр багшаар ажиллах</li> </ol> <p><i>Багшийн хөгжлийг хангах</i></p> <ol style="list-style-type: none"> <li>5. Судалгаа шинжилгээний ажил хийх</li> <li>6. Илтгэл, ном, гарын авлага, зөвлөмж боловсруулах</li> <li>7. Мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах, бусад багш нарт зориулан сургалт, семинар зохион байгуулах</li> <li>8. Мэргэжил, арга зүйгээ ажлын байран дээрээ тасралтгүй дээшлүүлэх</li> </ol> <p><i>Иргэд, суралцагчидтай ажиллах</i></p> <ol style="list-style-type: none"> <li>9. Дотуур байрны сурагчидтай ажиллах</li> <li>10. Эцэг эх, иргэд, олон нийттэй ажиллах</li> <li>11. Сургуулийн захиргааны болон сонгуульт ажил гүйцэтгэх</li> <li>12. Шаардлагатай тайлан мэдээ, судалгаа гаргах</li> <li>13. Урлаг, спорт, соёл хүмүүжлийн ажил зохиох, оролцох</li> </ol>
---	---

Төрийн албаны хуульд заасны дагуу багш нь төрийн үйлчилгээний албан хаагчийн ангилалд багтдаг бөгөөд түүний цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл ажил, мөнгөн урамшууллаас тус тус бүрддэг. Түүнээс гадна Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу нормоос илүү цаг хичээл заавал илүү цагийн хөлс авах боломжтой.

*Хүснэгт 2.3.12. Багшийн ажлыг үнэлж, дүгнэж, цалин хөлс, нэмэгдэл олгож буй дүрэм, журамд заасан хувь хэмжээ*

№	Цалин хөлс	Агуулга, он	Тайлбар
1.	Үндсэн цалин	Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам (2007 он)	Боловсролын стандартыг хэрэгжүүлэх (34 цаг) Бусад ажил (6 цаг)
2.		Багшийн ажлын байрны тодорхойлолт (2007)	
3.		Багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам (2013)	- Суралцагчийн хөгжил, төлөвшил, - Эзэмшсэн чадварын түвшин, ахиц, амжилт, - Хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлсэн амжилт, туршлага, - Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, - Эрүүл мэнд гэсэн 5 шалгуур, 12 үзүүлэлтээр ажлыг үнэлж, дүгнэх
4.	Нэмэгдэл ажил	Анги удирдах (2007)	Сар бүрийн үндсэн цалингийн 10%
5.		Заах аргын нэгдэл удирдах (2007)	Сар бүрийн үндсэн цалингийн 5%
6.		Кабинет удирдах (2007)	Сар бүрийн үндсэн цалингийн 5%
7.	Нэмэгдэл	Багшийн мэргэжлийн зэргийн нэмэгдэл (2007)	Сар бүрийн үндсэн цалингаас Зөвлөх-20% Тэргүүлэх-15% Заах аргач-10%
8.		Орон нутгийн нэмэгдэл (2001)	Сар бүрийн үндсэн цалингийн 8-10%
9.		Ур чадварын нэмэгдэл (1995)	Сарын үндсэн цалингийн 30%-аас доошгүй байна

10.		Тусгай сургалтын нэмэгдэл (1999)	Сарын үндсэн цалингийн 10-30%
11.		Докторын зэргийн нэмэгдэл (1995)	Сар бүрийн үндсэн цалингийн 15%
12.	Урамшуулал	Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал (2013)	Сар бүр үндсэн цалингийн 10, 13, 15 хувь
13.	Илүү цагийн хөлс	Илүү цагаар хичээл заасан хөлс (2007)	Хичээл заасан 1 цагийн хөлсийг 1,5 дахин өсгөж тооцно. Дээд хязгаар нь багшийн нормын 10% буюу 7 хоногт 4 цаг байна.
14.	Тэтгэмж	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	5 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээтэй
15.		Өндөр насны тэтгэвэр тогтоолгох үеийн тэтгэмж	Багш нийслэлд 12, сум, тосгон багт 18 сарын үндсэн цалинтай тэнцэх тэтгэмж

Дээрх хүснэгтээс харахад Монголын багш нар үндсэн цалингаас гадна хууль тогтоомжийн заалтаар тодорхой хэмжээний олон төрлийн нэмэлт мөнгөн орлого авах боломжтой байдаг байна. Гэвч багш бүр эдгээр нэмэгдэл хөлс болон урамшууллыг авах боломжгүй байдаг. Багшийн дундаж цалинг улсын дундажтай ойртуулах арга нь нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал зэрэг байдаг нь багшийн ажлыг төдийгүй сургуулийн ачааллыг нэмэгдүүлэх бас нэг субъектив хүчин зүйл болдог.


Багшийн үндсэн цалин 2007 оноос 2019 оны хооронд дараах байдлаар нэмэгдэж ирсэн байна (Хүснэгт 2.3.13).

Хүснэгт 2.3.13. Цалингийн сүлжээ, шатлал (2007-2019)

Цалингийн сүлжээний шатлал	ЗГ-ын 2007 оны 351-р тогтоол	ЗГ-ын 2010 оны 239-р тогтоол	ЗГ-ын 2012 оны 78-р тогтоол	ЗГ-ын 2014 оны 75-р тогтоол	ЗГ-ын 2018 оны 264-р тогтоол	ЗГ-ын 2019 оны 24-р тогтоол
	ТҮБД-4	ТҮБД-4	ТҮБД-4	ТҮБД-4	ТҮБД-4	ТҮБД-3
1	229560	298428	378428	535286	578109	648977
2	231877	301440	381440	539547	582711	654193
3	237762	309091	389091	550069	594399	667449
4	252694	328502	408502	577826	624052	701075
5	269351	350157	430157	608475	657134	738589

2019 оны байдлаар багшийн 1 сарын үндсэн цалин (цалингийн 1-р шатлалаар) 648980 төгрөг буюу 2019 оны 01 сарын 01-ний ханштай харьцуулсан долларын ханшаар 245.48 ам.доллартай тэнцэх хэмжээтэй байна. Багшийн үндсэн цалингийн өсөлтийн өөрчлөлтийг зургаар харуулав. Хэдийгээр төгрөгөөр хэмжигдэх цалингийн хэмжээ нэмэгдсэн үзүүлэлттэй харагдаж байгаа боловч ам.долларын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан багшийн үндсэн цалин өссөн, буурсан үзүүлэлттэй харагдаж байна (Зураг 2.3.25).


Зураг 2.3.25. Багшийн үндсэн цалингийн хэмжээ (2007-2019, төгрөг, ам.доллар)



Эх сурвалж: (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2019)

Харин статистикийн мэдээллийн нэгдсэн сан дахь ААН байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин, боловсролын салбарын ажилтнуудын сарын дундаж цалингийн зөрүү 2006 оноос хойш хэрхэн өөрчлөгдсөнийг (Зураг 2.3.26)-т харуулав.


Зураг 2.3.26. Дундаж цалингийн харьцуулалт (2006-2018, мянган төгрөг)



Эх сурвалж: (Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, 2019)

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай (УИХ, 1994) хуулиар даатгуулагч нь хуулинд заасан үндэслэлээр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болдог. Багшаар ажиллаж байсан даатгуулагч иргэн өндөр насны тэтгэвэрт гарах, тэтгэвэрт гарах үед нь нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг хэрхэн олгодгийг доор бүдүүвчлэн харуулав (Зураг 2.3.27).

Зураг 2.3.27. Багшаар ажиллаж байсан иргэн өндөр насны тэтгэвэр тогтоолгохба тэтгэмж авах нөхцөл



### 2.3.4. Дүгнэлт, Зөвлөмж

#### Дүгнэлт

1. Багштай холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт Монгол Улсын Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай болон Боловсролын тухай багц хуулийн хүрээнд 1990 оноос хойш өнөөг хүртэл хөгжлийн тодорхой үе шатуудыг туулан боловсронгуй болж ирсэн байна. Гэвч багшийн хөгжлийг дэмжсэн эрх зүйн нэгдсэн зохицуулалт алдагдсан байна.
2. Багшийг их дээд сургуулиудаар бэлтгэх тогтолцоотой боловч төрийн болон хувийн хэвшлийн 40 гаруй их дээд сургуулиуд багш бэлтгэх магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөрүүдээр сургалт явуулж байгаа нь бэлтгэж буй багшийн чанарт сөргөөр нөлөөлөхөд хүргэж байна.
3. ЭЕШ-д өндөр оноотой сурагчийг багш мэргэжлээр суралцвал тэтгэлэг олгох хөтөлбөр нь элсэлтийн чанарыг нэмэгдүүлэх, цаашлаад чадварлаг багш бэлтгэхэд чиглэсэн чухал арга хэмжээний нэг болж байна.
4. Суралцагчдад ТХБ-ыг эзэмшүүлэх нийгмийн хэрэглүүр болох сургалтад мөрдөх сургалтын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө, сурах бичиг үнэлгээний журам зэрэг нь ойр ойрхон өөрчлөгдөж байгаа нь сургууль багш нарын үйл ажиллагааны тогтвортой байдлыг алдагдуулахад хүргэж байна. Улмар анги танхимын түвшин дэх сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байна.

5. 2017-2018 оны хичээлийн жилд мэргэжлийн багшийн хангалт ЕБС-д 98.8 хувь, цэцэрлэгт 97.3 хувьтай байна. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын хувьд боловсролын тухай хууль, холбогдох эрх зүйн зохицуулалтаар цаашид мэргэжлийн багшийн хангалт нэмэгдэх төлөвтэй байна.
6. Боловсролын салбарын бодлого, хөтөлбөрүүдэд багш, боловсролын байгууллагын ажилтны хүйс, жендэрийн харьцааг тэнцүүлэх зохистой болгох бодлого тусгадаг боловч багш мэргэжлээр суралцагч, төгсөгчдийн дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь сүүлийн 6 жилд 17.8 хувиас хэтрэхгүй, боловсролын салбарт ажиллагчдын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 20 хувиас хэтрэхгүй байна. Иймд жендэрийн тогтвортой харьцааг бий болгох бодлогыг хэрэгжүүлэх ажил хангалтгүй байгааг харуулж байна.
7. Багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо институтчилагдсан байна. БМДИ нь цэцэрлэг, ЕБС-д 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш нарт зориулсан үндэсний хэмжээний үндсэн сургалтыг зохион байгуулж, тус сургалтад 2013 оноос хойш жилд дунджаар 5070 багш хамрагдаж байгаа бөгөөд энэ нь нийт багшийн 13.7 хувь болж байна. 10 ба түүнээс дээш жил ажиллаж буй багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоо байхгүй, багш нар өөрсдөө хүсвэл сургалтад хамрагдаж болдог зохицуулалттай байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын зардлын төсөв жил бүр буурсаар байна. Мөн нийслэл, орон нутгийн боловсролын газар, төрөлжсөн сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлж буй багш нарын нэгдсэн мэдээлэл улсын хэмжээнд нэгтгэгдэх ажил хийгдэхгүй байна.
8. 2019 оны байдлаар багшийн 1 сарын үндсэн цалин (цалингийн 1-р шатлалаар) 648,980 төгрөг буюу тухайн үеийн харьцуулсан долларын ханшаар 245.48 ам.доллартай тэнцэх хэмжээтэй байна. Багшийг сургалтын үндсэн үйл ажиллагаанаас хөндийрүүлэхгүй байх, олон төрлийн нэмэлт ажилд дайчлахаас хамгаалах нь чухал юм. Иймд олон төрлийн нэмэгдэл ажлын үндсэн дээр багшид нэмэгдэл хөлс олгох гэхээс илүү багшийн үндсэн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтлах шаардлагатай байна.
9. ЕБС, МСҮТ, Насан туршийн боловсролын төвд ажиллаж буй ижил мэргэжлийн багш нарын хөгжлийн талаар баримталж буй бодлого, эрх зүйн зохицуулалт ялгаатай байна.

### **Зөвлөмж**

1. Багшийн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулан баталж, түүнд суурилсан багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх, тэдний тасралтгүй хөгжлийг хангах, багшийн хангалтыг сайжруулах эрх зүйн нэгдсэн зохицуулалттай болж тогтвортой мөрдөх шаардлага байна.
2. Багш бэлтгэхдээ үндэсний хэмжээний багш мэргэжлийн үйлийн хүрээ боловсруулан баталж, хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх замаар суралцахуйн оролтын тэгш боломжийг хангах, улмаар багш мэргэжлээр төгсөгчдийн суралцахуйн гаралтын үр дүнг харьцуулан хөтөлбөрүүд тасралтгүй сайжирч байх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага байна.
3. Багш бэлтгэхэд дараах хүчин зүйлсийг тооцох хэрэгтэй. Үүнд:
  - a. Багш бэлтгэх мэргэжлийн хослол, индексийг ЕБС-ийн зураглал (байршил, хэмжээ, хэв шинж)-д нийцсэн, сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангах боломжийг тооцсон байхаар уян хатан болгох
  - b. Боловсролын салбар дахь багш, ажилтны жендэрийнзохистой харьцааг багш бэлтгэх сургалтаас эхлүүлэн мөрдөх
  - c. Чадварлаг элсэгчдийг татах цогц арга хэмжээ авах
4. Багшийн хөгжил, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх дараах арга хэмжээг харилцан уялдаатайгаар хэрэгжүүлэх шаардлагатай Үүнд:
  - a. Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, бүх төрлийн сургалтын хэрэгцээг тодорхойлох, оролцогчдын талаар урьдчилсан мэдээ гаргах, зардал төсвөө төлөвлөн санхүүжилтийн эх үүсвэрүүдийг баталгаажуулах, сургалтын хөтөлбөрөө чанаржуулах, сургагч багш бэлтгэх, сургалт зохион байгуулах, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан гаргах зэрэг цогц үйл ажиллагааны менежментийг улам боловсронгуй болгож байх
  - b. Багшийн мэргэжил дээшлүүлэх, хөгжих хэрэгцээнд нийцсэн төрөлжсөн сургалтуудыг нэгдсэн зохицуулалт, менежментээр хангаж зохион байгуулах
  - c. Багшийн хөгжих хэрэгцээнд суурилсан нээлттэй, сонголттой онлайн сургалтын хөтөлбөр, модулиудыг санал болгодог төр, төрийн бус байгууллага, их дээд сургуулиудыг оролцоог хангасан үйлчилгээний мэргэжлийн хяналттай тогтолцоо бий болгох
  - d. Цэцэрлэгийн туслах багшийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх бодлого, зохицуулалтыг оновчлох

- e. Багш бэлтгэх болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын үйлчилгээний уялдаа холбоог сайжруулах
5. Багшийг тогтвор суурьшилтай, бүтээлчээр ажиллахад дэмжлэг болсон ажлын байр, сургалтын орчинг бүрдүүлж, сэтгэл ханамжтай ажиллах нийгмийн баталгааг хангах чиглэлээр дараах бодлогыг баримталж, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах нь зүйтэй. Үүнд.
- a. Багшийн цалин хөлсийг эрс нэмэгдүүлэх, ингэхдээ үндсэн цалинг эрс нэмэгдүүлэх нэг удаагийн интервенц хийх замаар, багш ба бусад албан хаагчдын цалин хөлсний хоорондох харьцаанд бодитой өөрчлөлт гаргаж, цаашид тэр харьцааг тогтвортой мөрдөх. Тухайлбал багшийн албан тушаалын “үйлчилгээний” гэсэн ангилалыг “тусгай” гэсэн ангилалд дэвшүүлж болох юм. Ингэснээр багшийн хөдөлмөрийн үнэлэмж, мэргэжлийн статус, нэр төр өргөгдөж, чадварлаг элсэгчид татагдаж, багшлахуйн чанарын төлөө өрсөлдөөн үүсэж, жендэрийн асуудал ч шийдэгдэж эхэлнэ.
  - b. Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх арга механизмыг цогцоор нь оновчтой болгох
  - c. ЭЕШ-д өндөр оноотой сурагчийг багш мэргэжлээр суралцвал тэтгэлэг олгох, амжилттай суралцсан төгсөгчдийг ажлаар хангах зэрэг завсрын үеийн тусгай хөтөлбөрүүдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
  - d. Цэцэрлэгийн эрхлэгч, ЕБС-ийн захирал болон багшийг ажилд томилох бүрэн эрхийг сургуулийн түвшингээс аймаг, нийслэлийн түвшинд татаж, багш, удирдах ажилтанг тодорхой хугацаагаар сургалтын байгууллагуудад шилжүүлэн ажиллах боломжийг нээлттэй болгох. Энэ нь тухайн багш, ажилтны хөгжилд төдийгүй тухайн орон нутагт ажиллаж байгаа олон цэцэрлэг, сургуулийн менежментийг сайжруулах, сургалтын чанарыг дээшлүүлэх, улмаар хүн ам зүйн хөгжлийн бодлогод ч эерэг нөлөө үзүүлэх давуу талтай.
  - e. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг үнэлгээний журам болон сургуулийн менежментийг тогтвортой мөрдөх, хэрэгжүүлэх
6. Их дээд сургуулийн харьяа лицей сургууль, НТБ, ТМБ олгох сургалтын байгууллагын ерөнхий эрдмийн багш нарт зориулсан үйлчилгээг ЕБС-ийн багш нартай ижил байлгах бодлого, эрх зүйн зохицуулалт хийх

## 2.4. Сургалтын байгууллагын удирдлага

### 2.4.1. Өмнөтгөл

Бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтны талаар бодлого, эрх зүйн баримт бичгүүд, 2009-2019 оны БСШУСЯ-ны статистик мэдээ, боловсролын салбарын мэдээллийн систем дэх өгөгдлүүд, Боловсролын мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлангууд болон бусад ажлын танилцуулгууд, холбогдох судалгааны үр дүнгүүдийг тус тус ашиглан энэ хэсгийн мэдээллийг боловсрууллаа. Үүнд:

- Боловсролын салбар дахь албан тушаалын ангилал, сонгон шалгаруулалт зохион байгуулах эрх бүхий субъект, томилох эрх бүхий албан тушаалтны жагсаалт, албан тушаал ахихад тавигдах шаардлага
- Сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагуудын захирал, удирдах ажилтны статистик мэдээ
- Удирдах ажилтныг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалт
- Энэ хэсгийн дүгнэлт, сорилтууд, тэдгээрт холбогдох зарим зөвлөмжүүдийг тусгалаа.

Гэхдээ мэдээллийн олдоц, бүрэн гүйцэт байдал зэргээс хамаарч цэцэрлэг, ЕБС-ийн удирдах ажилтны асуудалд түлхүү төвлөрсөн болно.

### 2.4.2. Бодлого, Эрх зүй

Боловсролын удирдлага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, боловсролын байгууллагын болон түүний өөрийн удирдлагаас бүрддэг (УИХ, 2002). Бүх түвшний боловсролын сургалтын болон мэргэжлийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг Боловсролын тухай хуулинд тодорхойлж өгсөн байдаг.

Өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч буюу түүний эрх олгосон этгээдийн томилсон захирал, эрхлэгч удирдана. Захирал, эрхлэгч нь Сургуулийн өмнөх боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай болон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ (УИХ, 2002).

Монгол Улсын “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он) (УИХ-ын 12 дугаар тогтоол, 2015)” болон бусад хууль тогтоомжид багш нарын тогтвортой ажиллах, албан тушаал ахих нөхцөл, тэдэнд үзүүлэх дэмжлэгийн талаар тодорхой хэмжээгээр тусгаж үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Тухайлбал,

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2015 онд шинэчлэгдэн батлагдсанаар боловсролын байгууллагын удирдах ажилтны хувьд

3.1.2-д “Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангах бодлого боловсруулж, үе шаттай хэрэгжүүлнэ”

5.3-д “Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ” хэмээн тус тус заасан байна.

Монгол Улсын ЗГ-аас батлан хэрэгжүүлж буй боловсролын салбарт хамаарах үндэсний хөтөлбөрүүдэд ч мөн ЕБС-ийн багшийн мэргэжил дээшлүүлэх, удирдах ажилтантай холбоотой тодорхой заалтууд тусгагдсан байдаг. Тухайлбал, “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” (ЗГ-ын 316 дугаар тогтоол, 2008)-т удирдах ажилтны талаар дараах зорилтуудыг тусгажээ. Үүнд:

3.1.3. ББ1.3 багш, боловсролын удирдах болон мэргэжлийн ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжилж байх;

3.12.2. МД6.2 багш, удирдах болон мэргэжлийн ажилтны мэргэшил дээшлүүлэх сургалтын модулийн тогтолцоо боловсруулж, магадлан шинжилгээ хийж бүртгэх,

Түүнчлэн, “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021 он) -т удирдах ажилтны талаар (ЗГ-ын 31 дүгээр тогтоол, 2010):

- Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчид болон багш, ажиллагчдын, хүйсийн тэгш байдлыг хангах:
  - боловсролын салбарын хөгжлийн асуудлаар шийдвэр гаргах түвшин дэх хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх

- Багш, удирдах ажилтан бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог хөгжүүлж, энэ чиглэлд мэргэжлийн төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх:
  - бүх түвшний сургуулийн удирдах ажилтан бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;
- Багш, боловсролын байгууллагын удирдах ажилтны ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийг үнэлэх шалгууруудыг зөв тогтоож, цалин хөлс нэмэгдүүлэх, урамшуулал олгох зэргээр нийгмийн хамгааллын асуудлыг сайжруулах:
  - багш, сургуулийн удирдах ажилтны ажлын ачааллыг оновчтой тогтоож, тэдний ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн явц, үр дүнгийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, арга хэлбэрийг боловсронгуй болгох;
- Боловсролын салбарын бодлого төлөвлөлтийг шинэ шатанд гаргаж, удирдлагын чадавх, ур чадвар, манлайллыг сайжруулах;
- Боловсролын салбарын захиргааны болон мэргэжлийн удирдлагыг боловсронгуй болгох:
  - цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтныг салбарын мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор томилж, чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
- Сургуулийн өөрийн удирдлагыг бэхжүүлж, эрх зүйн орчинг сайжруулах; гэж тус тус тусгажээ.

Эндээс үзэхэд Монголын төрөөс бага дунд боловсролын сургалтын байгууллагын түвшинд мэргэжлийн болон захиргааны удирдлагын асуудлыг дийлэнх тохиолдолд “багш” албан тушаалтай хамтад нь авч үзэж, энэ түвшинд мэргэжлийн удирдлагатай байх бодлого баримталж ирсэн нь харагдаж байна.

### 2.4.3. Хэрэгжилт, Үр дүн

#### 2.4.3.1. Боловсролын салбар дахь албан тушаалын ангилал

Боловсролын бүх түвшний сургалтын байгууллагад ажиллаж буй багш нь сургууль, дүүрэг, орон нутгийн боловсролын байгууллагын түвшинд болон үндэсний хэмжээний буюу БСШУЯ-ны харьяа мэргэжлийн байгууллагын түвшинд, мөн салбарын яаманд дэвшин ажиллах боломж байдаг.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулинд зааснаар ажил олгогч нь ажилтныг ажилд томилох, чөлөөлөх эрхтэй байдаг ба Төрийн албаны тухай, Боловсролын тухай хуулиуд болон бусад хууль тогтоомжид удирдах ажилтанг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулахад тавигдах шаардлага ба үүсэх харилцааны зохицуулалтын талаар тодорхой заасан байдаг. (Зураг 2.4.1).


Зураг 2.4.1. Боловсролын салбар дахь албан тушаал:



Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөхөөр болсон билээ. Уг хуулинд заасны дагуу боловсролын салбарын албан тушаалуудыг ангилж Зураг 2.4.2-г харуулав (УИХ, 2017).



Зураг 2.4.2. Боловсролын салбар дахь албан тушаалын ангилал



Хүснэгт 2.4.1. Боловсролын салбарын албан тушаалууд, тэдгээрт нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, томилох эрх зүйн зохицуулалт

Байгууллага	Албан тушаал	Ангилал зэрэглэл	Сонгон шалгаруулалт зохион байгуулах газар	Томилох эрх бүхий албан тушаалтан
Салбарын яам (ЗГ-ын 354 дүгээр тогтоол, 2007)	Төрийн нарийн бичгийн дарга	T3-14	Төрийн албаны зөвлөл (УИХ-ын 13 дугаар тогтоол, 2003)	Ерөнхий Сайд, МУ-ын ЗГ (ЗГ-ын тухай хууль)
	Газрын дарга	T3-12		
	Алба, хэлтэс, нэгжийн дарга	T3-8	Төрийн албаны зөвлөл (Төрийн албаны зөвлөлийн 99 дүгээр тогтоол, 2009), (Төрийн албаны зөвлөлийн 86 дугаар тогтоол, 2013)	Төрийн нарийн бичгийн дарга (Төрийн нарийн бичгийн даргын А/58 дугаар тушаал, 2012)
	Мэргэжилтэн, ажилтан	T3-7		
Боловсролын мэргэжлийн байгууллага болон их, дээд сургууль	Захирал, дарга	ТҮ-9 (ТҮШУ-5) (ЗГ-ын 354 дүгээр тогтоол, 2007) ТҮМБ-7 (ЗГ-ын 25 дугаар тогтоол, 2019)	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл (МУ-ын Төрийн албаны зөвлөлийн 60 дугаар тогтоол, 2013)	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн (Хөдөлмөрийн тухай хууль, 1999).
	Дэд захирал, орлогч	ТҮ-8 (ТҮШУ-5) ТҮМБ-6	Байгууллагын захирлын тушаалаар томилогдсон сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс	Байгууллагын захирал
	Алба, хэлтэс, нэгжийн дарга, тэнхимийн эрхлэгч	ТҮ-7 (ТҮШУ-4) ТҮМБ-6		
	Арга зүйч, мэргэжилтэн, багш	ТҮ-6 (ТҮШУ-3) ТҮМБ-5		
Аймаг, нийслэлийн боловсролын газар (ЗГ-ын 354 дүгээр тогтоол, 2007)	Дарга	T3-12	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл (УИХ-ын 13 дугаар тогтоол, 2003)	Аймаг нийслэлийн засаг дарга болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөнө (Боловсролын тухай хууль, 2002).
	Орлогч дарга	T3-11	Сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс (Аймаг, нийслэлийн БСГ-	Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга
	Алба, хэлтэс, нэгжийн дарга	T3-8		

	Мэргэжилтэн	ТЗ-6	ын даргын тушаалаар томилогдсон)	
ЕБС (ЗГ-ын 25 дугаар тогтоол, 2019)	Сургуулийн захирал	ТҮБД-5	Аймаг, нийслэлийн БСГ-ын даргын тушаалаар (БШУ-ны Сайдын А/315 дугаар тушаал, 2013) томилогдсон сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс (МУ-ын Төрийн албаны зөвлөлийн 60 дугаар тогтоол, 2013)	Аймаг, нийслэлийн Засаг дарга (Боловсролын тухай хууль, 2002)
	Сургалтын менежер	ТҮБД-4		Сургуулийн захирал (БСШУ-ы Сайдын 471 дүгээр тушаал, 2010)
	Багш	ТҮБД-3	Аймаг, нийслэлийн Боловсрол, Соёлын газрын даргын эсвэл сургуулийн захирлын тушаалаар томилогдсон сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс	Сургуулийн захирал (Бага, дунд боловсролын тухай хууль, 2002)
Цэцэрлэг (ЗГ-ын 25 дугаар тогтоол, 2019)	Цэцэрлэгийн эрхлэгч	ТҮБД-5	Аймаг, нийслэлийн Боловсрол, Соёлын газрын даргын тушаалаар (БШУ-ны Сайдын А/315 дугаар тушаал, 2013) томилогдсон сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс (МУ-ын Төрийн албаны зөвлөлийн 60 дугаар тогтоол, 2013)	Аймаг, нийслэлийн Засаг дарга (Боловсролын тухай хууль, 2002)
	Арга зүйч	ТҮБД-3		Цэцэрлэгийн эрхлэгч (БСШУ-ы Сайдын 471 дүгээр тушаал, 2010)
	Багш	ТҮБД-4	Аймаг, нийслэлийн Боловсрол, Соёлын газрын даргын эсвэл сургуулийн захирлын тушаалаар томилогдсон сонгон шалгаруулалт зохион байгуулах комисс	Цэцэрлэгийн эрхлэгч (Бага, дунд боловсролын тухай хууль, 2002)

Монгол Улсын ЗГ-ын тогтоолоор “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишиг”-ийг тогтоодог ба тухайн албан тушаалын ангилал, зэрэглэлийн дагуу тогтоогдсон цалингийн сүлжээ болон доод жишигт үндэслэн цалин хөлсний хэмжээ тогтоогдон олгогддог (ЗГ-ын 332 дугаар тогтоол, 2014). Өөрөөр хэлбэл, албан тушаалын зэрэглэл нэмэгдсэнээр цалингийн хэмжээ тодорхой хэмжээгээр өсөж байдаг. Мөн албан тушаалын хувьд өөрчлөгдөөгүй боловч ажлын байрны тодорхойлолтод заагдаагүй нэмэлт ажил гүйцэтгэдэг тухайлбал заах аргын нэгдлийн ахлагчаар ажиллах үед үндсэн цалингийн 5%-тай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгож байна (ЗГ-ын 219 дүгээр тогтоол, 2007).

**Албан тушаал дэвшихэд тавигддаг шаардлага**

Боловсролын салбарт албан тушаал дэвшихэд дараах ерөнхий шаардлагууд тавигддаг;

- Боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлагын хувьд
  - Багш мэргэжлийн эсвэл, боловсролын чиглэлээр бакалавр, ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
  - Багш мэргэжлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Ур чадварын хувьд
  - Мэдээлэл, харилцааны технологийг ашиглах чадвартай
  - Баримт бичиг боловсруулах
  - Мэдээлэл боловсруулах, судалгаа шинжилгээ хийх
  - Гадаад хэлний зохих мэдлэгтэй
  - Манлайлах, асуудал шийдвэрлэх чадвартай
  - Багаар ажиллах чадвартай
  - Харилцааны соёлтой

- Сургалтын байгууллагын ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлдэг байх.

Тухайн ажлын байрны онцлогоос шалтгаалан удирдах ажилтны ур чадварын дараах шаардлагууд тавигдаж байна. Үүнд:

- Боловсролын удирдлага, боловсролын менежмент, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр мэргэшсэн байх
- Стратегийн ба үйл ажиллагааны төлөвлөлт хийх
- Багш, ажилтанд мэргэжлийн зөвлөгөө өгөх, арга зүйн мэргэшсэн үйлчилгээ үзүүлэх
- Боловсролын шинэчлэлийн онол, арга зүйн мэдлэг чадвартай байх
- Сургалт зохион байгуулах, зөвлөн туслах, хамтран ажиллах чадвартай байх
- Хариуцлага хүлээх, ажлын ачаалал даах чадвартай байх
- Санаачилгатай, бүтээлч, шинийг эрэлхийлэгч байх
- Өөрийгөө хөгжүүлэх чадвартай байх
- Удирдан зохион байгуулах
- Шийдвэр гаргах чадвартай байх
- Байгууллагын нууцыг хадгалах
- Ажиллах гэж буй байгууллагынхаа хэв шинж, онцлогийн талаар зохих мэдлэг, туршлагатай байх
- Нийгмийн бүх давхаргын иргэд, байгууллагуудтай харилцах, хамтран ажиллах чадвартай байх шаардлагууд тавигдаж байна.

Тухайлбал: ЕБС-ийн захирал, сургалтын менежерийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах шаардлагыг БСШУ-ны Сайдын 2007 оны 351-р тушаалаар баталсан байна. Эдгээр шаардлагыг Хүснэгт 2.4.2 ба 2.4.3-т үзүүлэв.

Хүснэгт 2.4.2. ЕБС-ийн захирлын ажлын байранд тавигдах шаардлага (2007)

	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
1.1.Ерөнхий шаардлага:	Боловсрол		Бакалавраас доошгүй зэрэгтэй
	Мэргэжил		Боловсролын чиглэлээр
	Мэргэшил		Боловсролын менежментээр
	Туршлага		Багшлах ба боловсролын удирдлагаар хосолсон дадлага, туршлагатай байх
	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Багаар ажиллах</li> <li>• Асуудал шийдвэрлэх</li> <li>• Шийдвэр гаргах</li> <li>• Стратегийн ба үйл ажиллагааны төлөвлөлт хийх</li> <li>• Бусдыг манлайлах</li> <li>• Мэдээлэл, харилцааны технологи ашиглах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Түгээмэл гадаад хэлээр мэдээлэл ашиглах, боловсруулах, харилцах</li> <li>• Компьютерийн хэрэглээний программуудыг хэрэглэх</li> <li>• Мэдээлэл боловсруулах</li> <li>• Судалгаа, шинжилгээ хийх</li> <li>• Соёлтой харилцах</li> </ul>
1.2.Тусгай шаардлага:		Сургуулийнхаа хэв шинжийн онцлогийн талаар зохих мэдлэг, туршлагатай байх	

Хүснэгт 2.4.3. ЕБС-ийн сургалтын менежерийн ажлын байранд тавигдах шаардлага (2007)

	Үзүүлэлт	Чухал шаардлагатай	Шаардлагатай
1.1.Ерөнхий шаардлага:	Боловсрол		Бакалавраас доошгүй зэрэгтэй
	Мэргэжил		Багшийн боловсролтой
	Мэргэшил		Ерөнхий болон тусгай дидактик
	Туршлага		<b>5-аас доошгүй жил багшилсан байх</b>
	Ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Дидактик шийдэл, боловсруулалт хийх, тэдгээрт анализ хийх</li> <li>• Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх</li> <li>• Бусдыг манлайлах</li> <li>• Асуудал шийдвэрлэх</li> <li>• Мэдээлэл, харилцааны технологи ашиглах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Бусдыг дэмжих</li> <li>Багаар ажиллах</li> <li>Гадаад хэлээр харилцах</li> <li>Компьютер хэрэглэх</li> <li>Бичиг баримт боловсруулах</li> </ul>
1.2.Тусгай шаардлага:		Багшлах эрхтэй байх Багшийн мэргэжлийн зэрэг	

Эдгээр шаардлагыг харьцуулбал, ЕБС-ийн удирдлага, зохион байгуулалт, менежментийн үүрэг, хариуцлагаас шалтгаалан захирлын ажлын байранд дараах онцлог шаардлага тавигдаж байна.

- Стратегийн ба үйл ажиллагааны төлөвлөлт хийх
- Шийдвэр гаргах
- Багшлах ба боловсролын удирдлагын чиглэлээр хосолсон дадлага, туршлагатай байх
- Судалгаа, шинжилгээ хийх
- Сургуулийнхаа хэв шинж, онцлогийн талаар зохих мэдлэг, туршлагатай байх

Сургалтын менежерийн албан тушаалын багш нарт сургалтын технологи, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах үндсэн чиг үүрэгтэй холбоотойгоор ажлын байранд тавигдах шаардлага нь ялгаатай байна. Тухайлбал энэ албан тушаалд дараах онцлог шаардлага тавигдаж байна.

- Дидактик шийдэл, боловсруулалт хийх, тэдгээрт анализ хийх
- Багшлах эрхтэй, багшаар ажилласан 5-аас дээш жилийн ажлын туршлагатай байх.

#### 2.4.3.2. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын эрхлэгч, арга зүйч


Эрхлэгч нь цэцэрлэгийн удирдлагыг хэрэгжүүлэх ба Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан нийтлэг эрх, үүрэг болон ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг удирдлага болгон ажиллана (БСШУС-ы Сайдын А/118 дугаар тушаал, 2019). Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулинд цэцэрлэгийн эрхлэгчийн нийтлэг эрх, үүргийг тодорхойлж өгсөн байдаг (Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2008).

Цэцэрлэгийн эрхлэгч нь ажлын байрны үндсэн (БСШУ-ы Сайдын 351 дүгээр тушаал, 2007) тодорхойлолтын дагуу дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Боловсролын тухай багц хууль болон холбогдох хууль, тогтоомж, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх
- Сургуулийн өмнөх боловсролын стандартыг хэрэгжүүлэх, хүүхдийг эрүүл, таатай орчинд сургаж хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулах
- Багш, ажилчдын мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх
- Цэцэрлэгийн төсвийг оновчтой төсөвлөх, зөв зарцуулах, хянах

2018-2019 оны хичээлийн жилд нийт 1435 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээр цэцэрлэгүүдэд 1359 эрхлэгч, 665 арга зүйч ажиллаж байна.


Зураг 2.4.3. Цэцэрлэгийн удирдах ажилтны хүйсийн харьцаа, хувиар (2018/19)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Цэцэрлэгийн нийт удирдах ажилтны 2.6 хувь нь эрэгтэй, 97.4 хувь нь эмэгтэй багш нар байна. Харин боловсролын түвшнийг Зураг 2.4.4-т харуулав.


Зураг 2.4.4. Цэцэрлэгийн эрхлэгчийн боловсролын түвшин, хувиар (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Цэцэрлэгийн эрхлэгчдийн боловсролын түвшин дээшилж, магистр болон түүнээс дээш боловсролтой эрхлэгчийн эзлэх хувь 26.4-өөс 41.9 хувь болж нэмэгдсэн ба дипломын боловсролын зэрэгтэй эрхлэгчийн эзлэх хувь 26.5-аас 12.9 болж буурсан байна. 2018-2019 оны хичээлийн жилд дипломын 175, бакалавр 615, магистр 562, доктор зэрэгтэй 7 эрхлэгч ажиллаж байна.


Зураг 2.4.5. Цэцэрлэгийн арга зүйчийн боловсролын түвшин, хувиар (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Цэцэрлэгийн арга зүйчдийн боловсролын түвшин дээшилж, магистр болон түүнээс дээш боловсролтой арга зүйчийн эзлэх хувь 31.1-өөс 36.4 хувь болж нэмэгдсэн ба дипломын боловсролын зэрэгтэй арга зүйчийн эзлэх хувь 14.5-аас 10.2 болж буурсан байна. 2018-2019 оны хичээлийн жилд дипломын 68, бакалавр 355, магистр 242 арга зүйч ажиллаж байгаа бол доктор зэрэгтэй арга зүйч байхгүй байна.


Зураг 2.4.6. Цэцэрлэгийн эрхлэгчийн мэргэжлийн зэрэг, хувиар (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2010 онд цэцэрлэгийн эрхлэгчийн 63 хувь нь мэргэжлийн зэрэгтэй байсан бол 2018 онд 15.9 хувь болж, мэргэжлийн зэрэгтэй эрхлэгчийн тоо илт буурсан байна. Энэ бууралт нь тухайн үедээ мэргэжлийн зэрэгтэй байсан эрхлэгчдийн мэргэжлийн зэрэг нь 5 жилдээ хүчинтэй байдаг журмын дагуу мэргэжлийн зэрэг хадгалагдаж байгаад хүчингүй болсонтой холбоотой байж болох юм.


Зураг 2.4.7. Цэцэрлэгийн арга зүйчийн мэргэжлийн зэрэг, хувиар (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2010 онд цэцэрлэгийн арга зүйчдийн 71.7 хувь нь мэргэжлийн зэрэгтэй байсан бол 2018 онд 52.3 хувь болж буурчээ.


Зураг 2.4.8. Цэцэрлэгийн эрхлэгчийн боловсролын салбарт ажилласан жил (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Цэцэрлэгийн эрхлэгчээр ажиллаж буй албан тушаалтны боловсролын салбарт ажилласан жилээр нь харвал 15 хүртэлх жилийн туршлагатай багш нарын эзлэх хувь 25.3 хувь байсан бол 2018 онд 46.5 хувь болтол 11.2 хувиар нэмэгдсэн төдийгүй 0-5 жил боловсролын салбарт ажиллаж буй залуу удирдах ажилтны эзлэх хувь сүүлийн 4 жилд 99-350 болтол эрс нэмэгдэж байгааг харж болохоор байна.


Зураг 2.4.9. Цэцэрлэгийн арга зүйчийн боловсролын салбарт ажилласан жил (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Цэцэрлэгийн арга зүйчээр ажиллаж буй албан тушаалтны боловсролын салбарт ажилласан жилээр нь харвал 15 хүртэлх жилийн туршлагатай багш нарын эзлэх хувь 41.2 хувь байсан бол 2018 онд 55.5 хувь болтол 14.3 хувиар нэмэгдсэн төдийгүй 0-5 жил боловсролын салбарт ажиллаж буй залуу арга зүйчийн эзлэх хувь эрхлэгч нарынхтай ижил сүүлийн 4 жилд 3 дахин нэмэгдсэнийг харж болохоор байна.


Зураг 2.4.10. Цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд ажилласан жил (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Эрхлэгчийн албан тушаалд ажилласан жилээр нь харьцуулж харвал 5 хүртэлх жил ажиллаж буй эрхлэгчийн эзлэх хувь 2010-2018 оны хугацаанд 37 хувиас 63.9 хувь болтол 26.9 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 2.4.11. Цэцэрлэгийн арга зүйчийн албан тушаалд ажилласан жил (2010/11-2018/19 оны хичээлийн жил)




Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Арга зүйчийн албан тушаалд ажилласан жилээс харахад 74.3 хувь нь 5 хүртэлх жилдээ ажиллаж буй арга зүйчид байна.

Нөгөө талаар сүүлийн 8 жилийн турш цэцэрлэгийн арга зүйчдийн 70-аас доошгүй хувь нь 5 хүртэлх жил ажиллаж буй байдал, энэ ажлын байран дахь удирдах ажилтан тогтвор суурьшилтай ажилдаггүй болохыг харуулж байна.


Зураг 2.4.12. Шинээр томилогдсон цэцэрлэгийн эрхлэгчийн тоо болон шинээр ашиглалтад орсон цэцэрлэг, ажлаасаа чөлөөлөгдсөн эрхлэгчийн тоо (2010/11-2017/18 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2013-2014 оны хичээлийн жилд 122 цэцэрлэг шинээр ашиглалт орсон бөгөөд тэнд шинээр томилогдсон цэцэрлэгийн эрхлэгчийн 64.2 хувь нь ажиллаж байна. Харин 2014-2018 онд шинээр ашиглалтад орсон цэцэрлэгийн эрхлэгчийн хувь нийт шинэ эрхлэгчийн 30-45.8 хувь нь болж байна.


Зураг 2.4.13. Цэцэрлэгийн эрхлэгчийн шинээр албан тушаалд томилогдсон байдал (2010/11-2017/18 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Шинээр томилогдсон эрхлэгчийн 44-өөс дээш хувь нь байгууллага дотроо болон тухайн аймаг, хотынхоо цэцэрлэгээс шилжиж ирж ажилладаг байна. Гэвч боловсролын бус байгууллага болон сургууль төгссөний дараа эрхлэгчийн албан тушаалд ажиллаж буй эрхлэгчид багагүй хувийг эзэлж ирсэн байна.

Зураг 2.4.14. Цэцэрлэгийн удирдах албан тушаалаас чөлөөлөгдсөн байдал (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Дээрх зургаас харахад ажлаасаа чөлөөлөгдсөн цэцэрлэгийн эрхлэгчид дунджаар 23.4 хувь нь л нас барсан эсвэл тэтгэвэртээ гарсан байгаа бол дунджаар 50 хувь нь байгууллага дотроо албан тушаалаа өөрчилсөн эсвэл, тухайн аймаг, хотынхоо цэцэрлэгт шилжиж ажилладаг болох нь харагдаж байна.

### 2.4.3.3. Бага, дунд боловсролын сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер

Захирал нь сургуулийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх ба Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нийтлэг эрх, үүрэг болон ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг удирдлага болгон ажиллана (БСШУ-ы Сайдын 471 дүгээр тушаал, 2010). Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хуулинд ЕБС-ийн захирлын нийтлэг эрх, үүргийг тодорхойлж өгсөн байдаг (Бага, дунд боловсролын тухай хууль, 2002).




ЕБС-ийн захирлын ажлын байрны тодорхойлолтод заасан дараах үндсэн чиг үүргийг (БСШУ-ы Сайдын 351 дүгээр тушаал, 2007) хэрэгжүүлдэг. Үүнд:

- Боловсролын тухай багц хууль, бусад хууль тогтоомж, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэх
- Сургуулийн хэв шинжийн онцлогт нийцүүлэн бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Сургуулийн хүний нөөцийн хөгжлийг хангах, эрүүл, бүтээлч хамт олон төлөвшүүлэх
- Сургуулийн санхүүгийн болон материаллаг нөөцийн хөгжлийг хангаж, хүүхдийг эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд сурч, хүмүүжих, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд “зорилт 3”-ын хүрэн дэх багш, ажилтны хөгжлийг дэмжих чиглэлээр ажлын байрны гол үйл ажиллагаа нь
  - Сургуулийг багш ажилтнаар хангах, хамт олныг төлөвшүүлэх, тэдний хөдөлмөр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэргэшлийг дээшлүүлэх
  - Багш ажилтны хөдөлмөрийн үр дүнг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцох хэмээн тодорхойлогдсон байдаг. Энэ нь нөгөө талаар бага, дунд боловсролын тухай хуулийн дагуу сургуулийн захирлын хүлээсэн үүрэг нь болдог.

2018-2019 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй 803 ЕБС-д нийт 843 захирал, 1469 сургалтын менежер ажиллаж байна. Нийт удирдах ажилтны 27.8 хувь нь эрэгтэй, 72.2 хувь нь эмэгтэй байна. Захирлуудын тоо ЕБС-ийн тооноос 40-өөр олон байгаа нь зарим цогцолбор сургуульд гүйцэтгэх захирал ажилладагтай холбоотой.


Зураг 2.4.15. ЕБС-ийн захирлуудын мэргэжлийн чиглэл, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн захирлуудын 18 хувь нь математик, физик, мэдээлэл зүйн багш нар байгаа бол бага анги, түүх - нийгмийн ухааны багш нарын эзлэх хувь тус бүр 10 хувьтай байна. Захирлуудын дунд 32 хувийг эзэлж буй “бусад” гэсэн ангилалд боловсролын салбарын бус хүний тоо орсон байна. Өөрөөр хэлбэл, ЕБС-ийн удирдах албан тушаалд нийт захирлуудын 32 хувь нь ажлын байрны тодорхойлолт дахь шаардлагыг хангаагүй багш бус мэргэжлийн хүмүүс ажиллаж байна.


Зураг 2.4.16. ЕБС-ийн сургалтын менежерүүдийн мэргэжлийн чиглэл, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн сургалтын менежер, дунд-ахлах ангийн сургалтын менежерийн албан тушаал тусдаа байдаг учир менежерүүдийн дунд бага ангийн багш мэргэжилтэй менежерүүд 29.2 буюу бусад мэргэжлийн багш нараас их хувийг эзэлж байна.


Зураг 2.4.17. ЕБС-ийн удирдах ажилтнуудын боловсролын түвшин, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Удирдах ажилтнуудын боловсролын түвшинг нь харьцуулж харвал магистр, докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь захирлуудын 50.1 хувь, сургалтын менежерийн 41.8 хувийг эзэлж байна. Энэ нь удирдах ажилтны боловсролын түвшин багш нарынхтай харьцуулахад өндөр байгааг харуулж байна.


Зураг 2.4.18. ЕБС-ийн удирдах ажилтны хүйсийн харьцаа (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн сургалтын менежерүүдээс илүү захирлын хүйсийн харьцаанд эрэгтэйчүүдийн эзлэх хувь илүү өндөр байгаа нь харагдаж байна.


Зураг 2.4.19. ЕБС-ийн захирлын хүйсийн харьцаа, хувиар (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Сургуулийн захирлын хүйсийн харьцаа 46.6%-иас 42.1% болж 4.5 хувиар буурсан ч сургуулийн түвшинд багш нарын хүйсийн харьцаа 18.4:81.6 байгаагаар харьцуулахад эрэгтэйчүүдийн удирдах албан тушаалд томилогдох байдал өндөр байдаг нь харагдаж байна.


Зураг 2.4.20. ЕБС-ийн сургалтын менежерийн хүйсийн харьцаа, хувиар (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн сургалтын менежерийн хүйсийн харьцаанд эрэгтэйчүүдийн эзлэх хувь багасч байгаа бөгөөд багш нарын хүйсийн харьцаатай ойролцоо түвшинд байна.


Зураг 2.4.21. ЕБС-ийн захирлын мэргэжлийн зэрэг (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2015 оноос хойш ЕБС-ийн захирлуудын 70-аас дээш хувь нь мэргэжлийн зэрэггүй болсон байна. Энэ бууралтыг захирлуудын мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа дуусахад шинээр мэргэжлийн зэрэг авдаггүйтэй холбон тайлбарлаж болох юм (Зураг 2.4.7 тайлбартай ижил).


Зураг 2.4.22. ЕБС-ийн сургалтын менежерийн мэргэжлийн зэрэг (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2009 оноос хойш мэргэжлийн зэрэгтэй сургалтын менежерүүдийн эзлэх хувь буурсан ч 60-аас дээш хувь нь мэргэжлийн зэрэгтэй байна.


Зураг 2.4.23. ЕБС-ийн удирдах ажилтны насны ангилал, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Удирдах ажилтны насны бүтэц нормал тархалтын мурийтай давхцаж байгаа бөгөөд дунд насныхан удирдах албан тушаал эрхлэх байдал илүү байна.


Зураг 2.4.24. ЕБС-ийн захирлын насны бүтэц (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2009-2019 онд ЕБС-ийн захирлын насны бүтцэд дунд насныхны эзлэх хувь давамгайлсаар ирсэн бөгөөд энэ бүтэц алдагдаагүй байна.


Зураг 2.4.25. ЕБС-ийн сургалтын менежерийн насны бүтэц (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн сургалтын менежерийн насны бүтэц сүүлийн 10 жилд дунд насны бүлгийнхэн буюу 40-49 насныхан 35.4 хувиас 45.3 хувь болтол нэмэгдсэн бол 39 хүртэлх насныхны эзлэх 42-30 хувь болж багассан байна.


Зураг 2.4.26. ЕБС-ийн захирлын боловсролын салбарт ажилласан жил (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн захирлуудын хувьд боловсролын салбарт ажилласан жилээр нь ангилж харвал 0-5 жил ажиллаж байгаа буюу салбартаа туршлага багатай шинэ залуу захирлуудын эзлэх хувь 2015-2016 оны хичээлийн жилд 21.4 хувь болтол огцом нэмэгдсэн бол 2018-2019 онд 17.4 хувьтай байна.


Зураг 2.4.27. ЕБС-ийн сургалтын менежерийн боловсролын салбарт ажилласан жил (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн сургалтын менежерт тавигдах шаардлагад 5-аас доошгүй жил багшилсан туршлагатай байх шаардлага тавигдаж бусад багш нарт сургалтын арга зүй, технологийн чиглэлээр зөвлөн туслах үүрэгтэй байдаг боловч энэ шаардлагыг хангаагүй менежерийн тоо 2015-2016 оны хичээлийн жилд 15 хувь болтол огцом нэмэгдсэн бол 2018-2019 оны хичээлийн жилд 9.7 хувь болжээ.


Зураг 2.4.28. ЕБС-ийн захирлаар ажилласан жил (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн захирлууд тухайн албан тушаалд 0-5 жил ажиллаж буй залуу удирдах ажилтны хувь 2015-2016 оны хичээлийн жилд өмнөх жилээс 20 хувиар нэмэгдэж 74.6 хувь болтол нэмэгдсэн бол 2018-2019 оны хичээлийн жилд 70 хувь болжээ. Энэ үзүүлэлт нь 0-5 жил ажиллаж буй хугацаанд хамааралтай учир өмнөх онуудын шинэ залуу удирдах албан тушаалтны тоо нэмэгдсээр дээрх хувьд хүрсэн байх боломжтой.


Зураг 2.4.29. ЕБС-ийн сургалтын менежерээр ажилласан жил (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Тухайн албан тушаалд 5 хүртэлх жил ажиллаж буй залуу удирдах ажилтны эзлэх хувь 2015-2016 оны хчээлийн жилд 56 хувиас 70 хувь болтол нэмэгдсэн байна.


Зураг 2.4.30. Шинээр томилогдсон ЕБС-ийн захирлын тоо болон шинээр ашиглалтад орсон сургууль, ажлаасаа чөлөөлөгдсөн захирлын тоо (2009/10-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2009-2019 оны хооронд хамгийн багадаа 2012-2013 оны хичээлийн жилд 77 захирал ЕБС-д шинээр томилогдож байсан бол 2013-2014 оны хичээлийн жилд 209 захирал шинээр томилогдож байжээ. 2012 оноос хойш сүүлийн 7 жилд нийт 783 захирал, жилд дунджаар 112 захирал шинээр томилогдсон байна. 2009-2012 онд нийт 392 захирал, 2012-2016 онд нийт 507, 2016-2019 онд нийт 276 захирал шинээр томилогдсон байна. Энэ нь жил бүр нийт сургуулийн 12-оос доошгүй хувьд захирлуудыг шинээр томилж өөрчилдөг болохыг харуулж байна.


Зураг 2.4.31. ЕБС-ийн захирлын албан тушаалд шинээр томилогдсон байдал (2007/08-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн захирлын албан тушаалд шинээр томилогдсон багш нарын 50%-75% нь тухайн сургууль дотроо эсвэл тухайн аймаг, хотынхоо ЕБС-аас шилжиж очсон байна. Захирлын албан тушаалд дөнгөж сургууль төгссөн, шинэ багш томилогдсон тохиолдлууд 2015 оноос хойш сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай болсон байна.


Зураг 2.4.32. ЕБС-ийн захирлын албан тушаалаас чөлөөлөгдсөн байдал (2007/08-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

ЕБС-ийн захирлын албан тушаалаас чөлөөлөгдсөн багш нарын 25 хувиас доош хувь нь л тэтгэвэрт гарсан байна. 75-аас дээш хувь нь сургууль дотроо албан тушаал өөрчлөгдөх, өөр ЕБС-д шилжих, бусад байгууллагад шилжих гэх мэт тайлбартай байна. Эндээс харахад ЕБС-ийн удирдах ажилтны мэргэшсэн байдал, тогтвор суурьшилтай ажиллах байдал алдагдсан байна.

Зураг 2.4.33. ЕБС-ийн сургалтын менежерийн албан тушаалаас чөлөөлөгдсөн байдал (2007/08-2018/19 оны хичээлийн жил)




Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Сургалтын менежерүүдийн 20 хувь нь л тэтгэвэрт гарснаар ажлаас чөлөөлөгддөг бол 80-иас дээш хувь нь бусад шалтгаанаар чөлөөлөгдсөн байна.

**2.4.3.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирал, удирдах ажилтан**

2018-2019 оны хичээлийн жилд төрийн өмчийн 51, төрийн бус өмчийн 35, нийт 86 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа ба захирал 90, дэд захирал 23, сургалтын албаны дарга 80, нийт 193 удирдах ажилтан ажиллаж байна.

Зураг 2.4.34. МСҮТ-ийн удирдах ажилтны хүйсийн харьцаа, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Нийт удирдах ажилтнуудын дунд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 47.2 хувь байгаа бол захирлуудын 68 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Энэ нь албан тушаал ахих тусам эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж байгааг харуулж байна.

Зураг 2.4.35. МСҮТ-ийн удирдах ажилтны боловсролын зэрэг, хувиар (2018)




Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик



Захирал, дэд захирлуудын 78 хувь, сургалтын албаны даргын 64 хувь нь магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна. Энэ нь ЕБС-ийн захирлуудтай харьцуулахад 27 хувиар илүү байна.


Зураг 2.4.36. МСҮТ-ийн удирдах ажилтны боловсролын салбарт ажилласан жил, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Удирдах ажилтны боловсролын салбарт 10 хүртэлх жил ажилласан туршлагатай захирлууд 14 хувь, дэд захирал 22 хувь, сургалтын албаны дарга 28 хувьтай байна. Захирлуудын хувьд 11-20 жилийн туршлагатай захирлууд 47 хувийг, 21 ба түүнээс дээш жилийн туршлагатай захирлууд 30 хувийг эзэлж байна.

Зураг 2.4.37. МСҮТ-ийн удирдах ажилтны насны бүтэц, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Захирлын 21 хувь, дэд захирлын 43 хувь, сургалтын албаны даргын 51 хувь нь 30 хүртэлх насны бүлэгт хамаарах залуучууд байна. Захирлуудын 68 хувь нь 30-50 насныхан байгаа бол, дэд захирлын 52 хувь, сургалтын албаны дарга нарын 43 хувь нь энэ насны бүлэгт хамаарч байна.

#### 2.4.3.5. Дээд боловсролын сургалтын байгууллагын захирал, удирдах ажилтан

Их, дээд сургуулийн захирал нь Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, томилсон этгээдийн өмнө ажлаа тайлагнана (УИХ, 2002).


Төрийн өмчит их сургуулийн захирлын ажлын байрны үндсэн зорилт нь (БСШУЯ, 2008)

- Дээд боловсрол, шинжлэх ухаан, технологийн харилцааг зохицуулсан хууль, төрөөс баримтлах бодлого, Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах
- Дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи хөгжүүлэх төрийн бодлого, Засгийн газраас дэвшүүлсэн зорилт, их сургуулийн боловсрол, эрдэм судлалын хөгжлийн олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн сургуулиа хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө, зорилгыг тодорхойлон батлуулах, хэрэгжилтийг хангах
- Сургуулийн эрхэм зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохион байгуулалтын бүтэц, хүний, санхүүгийн болон материаллаг нөөц, нөхцөлийг бүрдүүлэн дээд боловсролын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх
- Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сайд, сургуулийн Удирдах зөвлөл, харилцагчид, хамтран ажиллагчид, хэрэглэгчдийн өмнө хүлээсэн бүх үүргийн биелэлтийг хангах зорилтын дагуу ажилладаг.

2018-2019 оны хичээлийн жилд төрийн өмчийн 18, төрийн бус өмчийн 73, нийт 94 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээр байгууллагуудад захирал 95, дэд захирал 94,

салбар сургуулийн захирал 119, салбар сургуулийн дэд захирал 31, сургалтын албан дарга 115, нийт 454 удирдах ажилтан ажиллаж байна.


Зураг 2.4.38. Их, дээд сургуулийн удирдах ажилтны хүйсийн харьцаа, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Сургалтын албаны даргын хувьд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 27.8 хувь байгаа бол захирлуудын хувьд эрэгтэйчүүдийн эзлэх хувь 57.9–өөс 63.0 хувьтай байгаа буюу албан тушаал ахих тусам эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж байна.


Зураг 2.4.39. Их, дээд сургуулийн удирдах ажилтны насны бүтэц, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Удирдах ажилтны 48-74 хувь нь 30-50 насныхан байна. Харин 30 хүртэлх насны захирал 1, дэд захирал 2, харьяа сургуулийн захирал 8, сургалтын албаны даргын хувьд 11 хувийг эзэлж байна.


Зураг 2.4.40. Их, дээд сургуулийн удирдах ажилтны боловсролын түвшин, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Удирдах ажилтны 55-81 хувь нь доктор, 16-44 хувь нь магистр, 2-3 хувь нь бакалавр байгаа бол дипломын боловсролтой 1 захирал ажиллаж байгаа нь энэ нь нийт захирлуудын 0.01 хувь нь болж байна.

Зураг 2.4.41. Их, дээд сургуулийн удирдах ажилтны ажилласан жил, хувиар (2018)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Захирлуудын 5.3, дэд захирлын 12.8, харьяа сургуулийн захирлын 6.7, сургалтын албаны дарга нарын 13 хувь нь 1-5 жил ажилласан туршлагатай байна. Нөгөө талаар захирлуудын 77.9, дэд захирлын 71.3, харьяа сургуулийн захирлын 60.5, харьяа сургуулийн дэд захирлууд 93.5, сургалтын албаны дарга нарын 40.9 хувь нь 16 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай удирдах ажилтан байна. Захирлуудын туршлага, боловсролын түвшин харьяа сургуулийн захирал, дэд захирлынхаас бага байгаа нь хувийн их, дээд сургуулиудын удирдлагыг үүсгэн байгуулагч нь томилдогтой холбоотой байж болно.

#### 2.4.3.6. Удирдах ажилтныг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалт

Мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаа нь боловсролын салбарт институтэд суурилан мэргэжил дээшлүүлэх үйлчилгээг төрийн болон иргэний нийгмийн байгууллага, олон улсын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр зохион байгуулах зарчимд тулгуурладаг. Салбарын хэмжээнд багшийн мэргэжил дээшлүүлэх харилцааг зохицуулж буй “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-д зааснаар удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт нь дараах төрлүүдээр зохион байгуулагдаж байна. Үүнд:

- Удирдах ажилтны ажил, мэргэжлийн чиглэлээрээ эзэмшсэн мэдлэг, ур чадвараа ахиулах *үндсэн сургалт*
- Боловсролын бодлого, чиглэлийг таниулах, хэрэгжүүлэх болон мэргэжлийн тусгай дидактикийн ур чадварт суралцах *төрөлжсөн сургалт*,
- Ажлын байрны тодорхойлоход чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа хөгжих *ажлын байран дахь сургалт* гэсэн төрөлтэйгөөр зохион байгуулагдаж байна.

Тус журмаар цэцэрлэг, ЕБС, НТБ-ын төвийн захирал, эрхлэгч, сургалтын менежер, арга зүйчийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг зохицуулж байна. Мэргэжил дээшлүүлэх сургалтыг танхимын, зайн, онлайн сургалтын хосолсон хэлбэрээр үндэсний, орон нутгийн болон ажлын байранд нь буюу байгууллагын түвшинд зохион байгуулдаг (БШУ-ы Сайдын А/287 дугаар тушаал, 2013).

Аймаг, нийслэлийн боловсролын газар, нийслэлийн дүүргийн боловсролын хэлтэс нь тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх, боловсролын байгууллагын удирдах ажилтанд мэргэшлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд нь туслах чиг үүргийг хэрэгжүүлдэг (БШУ-ны Сайдын А/315 дугаар тушаал, 2013).

Удирдах ажилтныг бэлтгэх хөтөлбөрөөс илүүтэйгээр удирдах албан тушаалд томилогдсоны дараа мэргэшлийг нь дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэн төрийн үйлчилгээ үзүүлэхээр тусгажээ.

Багш нь боловсролын менежмент, боловсролын удирдлагын чиглэлээр Их, дээд сургуульд суралцаж боловсролын зэрэг ахиулах болон бусад сургалтын байгууллагын мэргэшүүлэх сургалтад өөрийн санаачилгаар хамрагдаж албан тушаал ахих боломжтой байдаг.

Багш боловсролтой иргэд удирдлага, менежментийн чиглэлээр мэргэших, боловсролын зэргээ ахиулах хэрэгцээ өсөххандлагатай байна. Боловсролын хөдөлмөрийн зах зээл дээрх энэхүү хэрэгцээнд тулгуурлан МУБИС, Удирдлагын академи болон их, дээд сургуулиуд боловсролын удирдлага, менежментийн чиглэлээр боловсролын зэрэг ахиулах сургалтуудыг зохион байгуулж байна.

- Мэргэшүүлэх сургалт (7 хоног)
- Магистрын сургалт (1.5-2 жил, 33-35 кредит)
- Доктор (Ph.D)-ын сургалт (3 жил, 60 кредит) гэсэн шатлалаар явагдаж байна.

БМДИ-ээс 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй цэцэрлэг, ЕБС-ийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үндэсний хэмжээний үндсэн болон төрөлжсөн, захиалгат сургалт, ажлын байранд зөвлөн туслах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулдаг.

Түүнчлэн БМДИ-ээс сургалтын байгууллагын удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх чиглэлээр төрөлжсөн сургалт явуулах хүсэлт гаргасан төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагуудын хөтөлбөрүүдийг магадлан үнэлж, сургалт явуулах эрх олгож байна.

2015-2018 оны байдлаар ЕБС-ийн багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах эрх олгогдсон хөтөлбөрүүдээс боловсролын удирдлага, менежментийн чиглэлээр дараах хөтөлбөрүүд батлагдсан байна.


*Хүснэгт 2.4.4. Боловсролын удирдлага, менежменттэй холбоотой төрөлжсөн сургалтын хөтөлбөрүүд*

2015 онд батлагдсан төрөлжсөн сургалтын хөтөлбөрүүдээс (Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирлын А/27 дугаар тушаал, 2015)	
Боловсролын хүрээлэн	Боловсролын удирдлага менежмент
БХАН	Сургалтын менежер багшийн дотны дэмжин туслагч
2016 онд батлагдсан төрөлжсөн сургалтын хөтөлбөрүүдээс (Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирлын А/34 дүгээр тушаал, 2016)	
Байгаль орчин мэдээлэл сургалтын төв	1. Олон улсын ЭКО сургууль хөтөлбөрийн арга зүй-менежментэд суралцах
Амжилттай боловсрол ТББ	2. Иргэний боловсролын үйл ажиллагааны цагийг хөтлөн явуулах арга зүй ба сургуулийн менежмент 3. Амьдрах чадварт суралцах үйл ажиллагааны цагийг хөтлөн явуулах арга зүй ба сургуулийн менежмент 4. Бага, суурь боловсролын багш нарт хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагийг хөтлөн явуулах арга зүй ба сургуулийн менежмент 5. Сургуулийн менежмент сургуулийн хөтөлбөр боловсруулах арга зүй
БХАН	6. “Сургалтын менежер багшийн дотны дэмжин туслагч”, 7. Сургуулийн өөрийн үнэлгээ, олон нийтийн оролцоот нээлттэй сургууль
2017 онд батлагдсан төрөлжсөн сургалтын хөтөлбөрүүдээс (БМДИ, 2017)	
Бага насны хүүхдийн хөгжил дэмжих төв	СӨББ-ын эрх зүйн орчин
2018 онд батлагдсан төрөлжсөн сургалтын хөтөлбөрүүдээс (Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирлын А/46 дугаар тушаал, 2018)	
Бага насны хүүхдийн хөгжил дэмжих төв	СӨББ-ын эрх зүйн орчин
БХАН	Сургуулийн өөрийн үнэлгээ – Олон нийтийн оролцоот сургууль

Боловсролын удирдах ажилтныг тусгайлан бэлтгэдэггүй бөгөөд мэргэшүүлэх, мэргэжлийг нь дээшлүүлэх хэлбэр зонхилж байгаа ба боловсролын удирдах ажилтны нөөцийг бэлтгэх төрийн үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна.

Боловсролын удирдлага, менежментийн чиглэлээр мэргэшүүлэх урт болон богино хугацааны сургалтыг төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд зонхилон зохион байгуулж байна.


*Зураг 2.4.42. Цэцэрлэгийн эрхлэгчийн мэргэжил дээшлүүлсэн байдал, хувиар (2010/11-2018/19 оны хичээлийн жил)*



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Цэцэрлэгийн эрхлэгчийн мэргэжил дээшлүүлсэн байдал сүүлийн жилүүдэд дунджаар 74.2 хувьтай байгаа бөгөөд түүний дотор орон нутагт мэргэжил дээшлүүлсэн байдал хамгийн их буюу 41.0 хувийг эзлэж байна. Статистикийн мэдээнд төрөлжсөн сургалтад хамрагдсан тухай мэдээг цуглуулаагүй байна.


Зураг 2.4.43. Цэцэрлэгийн арга зүйчийн мэргэжил дээшлүүлсэн байдал, хувиар (2010/11-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Цэцэрлэгийн арга зүйчийн мэргэжил дээшлүүлсэн байдал сүүлийн жилүүдэд дунджаар 69.1 хувьтай байгаа бөгөөд орон нутагт мэргэжил дээшлүүлсэн хувь нь хамгийн их буюу 36.9 хувьтай байна. Статистикийн мэдээнд төрөлжсөн сургалтад хамрагдсан тухай мэдээг цуглуулаагүй байна.


Зураг 2.4.44. ЕБС-ийн захирлын мэргэжил дээшлүүлсэн байдал, хувиар (2014/15-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Дээрх зургаас мэргэжил дээшлүүлсэн захирлуудын тоо, хувь хэмжээ нь давхардсан тоогоор байгаа ч сүүлийн 3 жилд нийт захирлуудын 10 хүрэхгүй хувь нь л мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан болох нь харагдаж байна. 2014-2016 оны хичээлийн жилд мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны хамгийн их хувийг төрөлжсөн сургалт, түүний дараа ажлын байран дахь сургалт эзэлж байна. Үндэсний хэмжээний сургалтад хамрагдаж буй захирлуудын эзлэх хувь буурсан байна.

Зураг 2.4.45. ЕБС-ийн сургалтын менежерийн мэргэжил дээшлүүлсэн байдал, хувиар (2014/15-2018/19 оны хичээлийн жил)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Харин сургалтын менежерүүдийн хувьд сүүлийн 3 жилд 16 хүрэхгүй хувь нь л мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан болох нь харагдаж байна. 2014-2016 онуудад мөн л захирлуудтай адил төрөлжсөн сургалт болон ажлын байран дахь сургалтад хамрагдсан байдал давамгайлж байна.

#### 2.4.4. Дүгнэлт, Зөвлөмж

##### Дүгнэлт

1. Монгол Улсын Төрийн албан тухай хуулийн дагуу төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний удирдах ажилтныг сонгон шалгаруулах, дэвшүүлэн ажиллуулахтай холбогдсон дүрэм, журам, заавруудыг шинэчлэн мөрдөж байгаа ч эдгээр нь багш нар салбартаа карьераа өсгөхөд нь төдийлөн дэмжлэг үзүүлж чадахгүй байгаа байдал ажиглагдаж байна. Тухайлбал, “удирдах ажилтны нөөцийг бэлтгэх” асуудал өнөөг хүртэл бараг орхигдсоноос хүний нөөцийн түүний дотор боловсролын удирдах ажилтны сонгон шалгаруулалт, томилгоо оновчгүй, ажлын арга туршлага, онол, арга зүйн хувьд бэлтгэлгүй хүмүүсийг хариуцлагатай, албан тушаалд томилох явдал сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай болсон байна. Өнөөдрийн байдлаар Монгол улсад боловсролын салбар дахь төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтныг бэлтгэх, сонгон шалгаруулах, томилох, дэмжих чиглэлээр баримтлах нэгдсэн бодлого, тогтолцоо хараахан бүрдээгүй байна.
2. Багш нарын албан тушаал ахиж, удирдах албан тушаалд томилогдох үйл явц нь үндсэндээ тодорхой төлөвлөлтгүй, тохиолдлын шинжтэй, тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаагүй туршлагагүй, шинэ залуус удирдах ажилтнаар томилдог болох нь дээрх статистикийн тоо баримтаар нотлогдож байна. Тухайлбал, цэцэрлэгийн эрхлэгчийн 25.8, ЕБС-ийн захирлын 17.4, МСҮТ-ийн захирлын 8, их, дээд сургуулийн захирлын 5.3 хувь нь боловсролын салбарт 5 хүртэлх жил ажилласан туршлагатай шинэ, залуу удирдах ажилтан байна. Үүний нэг шалтгаан нь өргөн уудам газар нутаг, тархай суурьшсан хүн амтай, дэд бүтцийн хөгжлөөс хамаарч хөдөө, орон нутагт ажиллах удирдах албан тушаалтны ажлын байрны сонгон шалгаруулалтад орж буй иргэд ажлын байранд тавигдах шаардлагыг бүрэн хангасан байх боломж, хомс байгаатай холбоотой байж болох юм.
3. Багш хүн тушаал дэвшиж сургуулийн захирал, сургалтын менежер зэрэг удирдах албанд томилогдсон тохиолдолд тэдэнд үндсэн цалингаас гадна нэмэгдэл хөлс олгогдохгүй байгаагаас нийт цалин хөлс буурч, цэцэрлэг, сургуулийнхаа бусад албан тушаалтнаас бага цалин хөлстэй байгаа асуудлыг тусгайлан судалж оновчтой шийдвэрлэх шаардлага байна.
4. Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх үйл ажиллагаа нь боловсролын удирдлага, менежментийн чиглэлээр боловсролын зэрэг ахиулах магистр, докторын зэрэг горилсон сургалтуудаар үндсэндээ хязгаарлагдаж, энэ хэрэгцээг хангах төрийн нэгдсэн үйлчилгээ дутагдалтай байна.
5. Багшийг удирдах ажилтнаар мэргэшүүлэн бэлтгэх тусгай үйлчилгээ байхгүй бөгөөд удирдах ажилтныг томилогдсоны дараа мэргэжлийг нь дээшлүүлэх, удирдлага, арга зүйн зөвлөмж өгөх үйл ажиллагаа голлон явагдаж байна.

##### Зөвлөмж

Боловсролын удирдах албан тушаалтныг бэлтгэх, сонгон шалгаруулах, томилох, тэдний мэргэшүүлэх талаар дараах зарим зүйлийг анхаарч авч үзэхийг санал болгож байна. Үүнд:

1. Боловсролын салбар дахь мэргэжлийн байгууллагуудын мэргэжилтэн, албан тушаалтан, сургалтын байгууллагын удирдах албан тушаалтныг бэлтгэх, сонгон шалгаруулах, томилох, дэмжих чиглэлээр баримтлах нэгдсэн бодлогыг тодорхойлж, оновчтой тогтолцоог бүрдүүлэх
2. Тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг зөв, бодитой тодорхойлж, шаардлага хангасан иргэнийг сонгон шалгаруулалтад оруулах, томилох, мөн тухайн шаардлагыг хангаагүй хүнийг томилсон тохиолдолд шийдвэр гаргасан эрх бүхий этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгож хэрэгжүүлэх
3. Боловсролын салбарын удирдах ажилтныг бэлтгэх, мэргэшүүлэх тогтолцоо бий болгох, БМДИ нь татан буугдахаас өмнөх түүхэнд боловсролын удирдах ажилтныг бэлтгэх 45-90 хоногийн курс хичээллэдэг байсан зэрэг туршлагаа эргэн харж, удирдах ажилтныг бэлтгэх ажлыг энэ чиглэлийн бодлого, хөтөлбөрүүдэд тусган хэрэгжүүлэх
4. Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны хүртээмж, давтамжийг нэмэгдүүлэх тухайлбал, сургалтын менежерүүд тухайн сургуулийнхаа нийт багшид сургалт, арга зүйн зөвлөмж, чиглэл өгч ажилладгийнх нь хувьд 5 жил тутамд бус харин ч 2-3 жил тутамд үндэсний хэмжээнд мэргэжлийг нь дээшлүүлэх албан ёсны сургалт, үйл ажиллагаанд хамруулдаг байх
5. Сургалтын болон сургуулийн менежментэд МХХТ-ийг нэвтрүүлж, холбогдох програмуудаар ханган мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, ашиглах замаар багш, удирдах ажилтнуудын техник ажлын ачааллыг хөнгөвчилж мэдээллийн урсгалыг сайжруулж шийдвэр гаргалтын үндэслэлийг сайжруулах, хурдасгах зэрэг саналыг тус тус дэвшүүлж байна.

## 2.5. Боловсролын салбар дахь мэдээлэл харилцаа, холбооны технологи

### 2.5.1 Өмнөтгөл

Боловсролын салбар дахь мэдээлэл, харилцаа, холбооны технологи (МХХТ)-ийн салбарт нэвтрүүлж, хөгжүүлэх үйл явцын суурь мэдээллийг цуглуулж, боловсруулахдаа мэдээллийн дараах эх сурвалжуудыг ашиглав. Үүнд:

- 2000-2018 оны хооронд баталж, хэрэгжүүлсэн бодлого, эрх зүйн баримт бичгүүд
- БСШУСЯ-ны статистик мэдээ, боловсролын салбарын мэдээллийн систем дэх өгөгдлүүд
- Боловсролын мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлангууд болон энэ чиглэлээр хийж буй ажлуудын танилцуулгууд
- Боловсролын салбарт МХХТ нэвтрүүлж, хөгжүүлэх чиглэлээр хийгдсэн зарим судалгаанууд Тухайлбал, ЮНЕСКО-ийн Ази, Номхон далайн бүс нутгийн товчоо, БНСУ-ын Итгэлцлийн сантай хамтран хэрэгжүүлж буй “Ази, Номхон далайн бүс нутагт цахим иргэний боловсролыг дэмжих үндэсний чадавхыг бэхжүүлэх” төслийн хүрээнд ЕБС-ийн багш нарын МХХТ-ийг ашиглах чадварын стандарт хэрэгжүүлэхэд бэлэн байдлын судалгааны үр дүнгүүдийг тус тус ашигласан болно.

### 2.5.2 Бодлого, Эрх зүй

Монгол Улсын төрөөс МХХТ-ийг боловсролын салбарт нэвтрүүлэх, хөгжүүлэхэд анхаарч, сүүлийн 20-иод жилийн туршид тодорхой бодлогууд баримтлан, тусгайлсан хөтөлбөрүүд хэрэгжүүлж иржээ. Боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсад 2000 оноос хойш батлагдан гарсан төрөөс баримтлах бодлого, үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд, хууль, эрх зүйн нийт 26 баримт бичиг (Хавсралт)-т тусгагдсан зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зүйл, заалтуудыг харьцуулан судлаад энэ салбар дахь МХХТ-ийн хөгжлийн дараах 4 үе шатыг ялган тодорхойлж үзлээ. Үүнд:

- **2000-2005 он:** *Боловсролд МХХТ-ийг нэвтрүүлэх техник, тоног төхөөрөмжөөр хангах*  
Энэ үеийн баримт бичгүүдэд тусгагдсан зорилт, үйл ажиллагаа нь зайн сургалтыг хөгжүүлэх, төрийн албан хаагчид, насанд хүрэгчдэд МХХТ-ийн анхан шатны боловсрол эзэмшүүлэх, сургалтын төвүүд байгуулах, ЕБС-ийн сургалтад хэрэглэж буй компьютерийн тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх, сургуулиудын телевиз, бусад техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, ЕБС-ийн багш нарын МХХТ ашиглах анхан шатны чадвар эзэмшүүлэх, ялангуяа сургалтын байгууллагуудыг интернетэд холбоход тус тус түлхүү чиглэгдсэн байна.
- **2006-2010 он:** *Сургалт, үйл ажиллагаанд МХХТ-ийн хэрэглэх дэд бүтцийг бий болгох*  
Энэ үед дээрх зорилтуудыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийн зэрэгцээ бага, дунд боловсролд мэдээлэл, удирдлагын нэгдсэн сүлжээ, мэдээллийн сан бий болгох, мэдээллийн технологийн дэд бүтцийг бий болгох, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх зэргээр дэвшилтэт технологийг хөгжүүлэхэд түлхүү анхаарсан байна. МХХТ-ийг нэвтрүүлэх бодлого, зорилтуудаа багшийн хөгжлийг дэмжихэд чиглүүлэн илүү нарийвчлах, багш бүрийг зөөврийн компьютероор хангах, МХХТ ашиглах сургалтын орчны стандарт боловсруулж мөрдөх зорилтыг дэвшүүлэх болсон байна.
- **2010-2015 он:** *Үндэсний, олон улсын түвшинд мэдээллийн болон боловсролын нээлттэй үйлчилгээ авах орчин нөхцөлийг бүрдүүлэх*  
Хөгжлийн энэ шатны бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд их, дээд сургуулийг ЕБС-ийн багш мэргэжлээр төгсөгчид нь МХХТ-ийн суурь чадвартай байх шаардлага тавигдаж эхэлсэн төдийгүй боловсролын бүх түвшний агуулгаар дахин сургалт явуулах нээлттэй болон зайны сургалтын төв байгуулж ажиллуулах, иргэдийн хэрэгцээнд тулгуурласан **онлайн** сургалтыг хөгжүүлэх, МХХТ-ийн соёлтой хэрэглээг бий болгох, МТХХТ-ийн аюулгүй байдлын талаар арга хэмжээг авах талаар тусгасан байна. Энэ нь нэг талаас, МХХТ-ийн хэрэглээ өсөн нэмэгдэж, дараагийн түвшний хэрэгцээ, шаардлага үүсэх болсныг харуулж байна. Нөгөө талаас, сургалтад МХХТ-ийг интеграцчилах, багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр сургалтын цахим хэрэглэгдэхүүний санг бүрдүүлэх, багш нар сургалтын агуулга хөгжүүлэх, харилцан туршлага, мэдээлэл солилцох, бүтээлч хамтын ажиллагааг дэмжихэд тус тус МХХТ хэрэглэх зорилтуудыг чухалчлах болсны илрэл юм. Түүнчлэн 2013 онд Засгийн газрын “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрт “Боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем” програм хангамж боловсруулж, нэвтрүүлэх тухай зорилт дэвшүүлжээ. Эдгээрээс гадна Их дээд

сургууль, ЕБС-ийг мэдээлэл, холбооны өндөр технологид суурилсан ухаалаг сургууль болгох, нээлттэй сургалтын багц үйлчилгээ нэвтрүүлэх, нээлттэй сургалтын онлайн систем бий болгох, сургалтын програм хангамжийг хөгжүүлэх, насан туршийн боловсролын нээлттэй их сургуулийг бий болгох, боловсролд зориулсан нээлттэй төрөлжсөн мэдээллийн сан байгуулах зорилтууд бүхий МХХТ-ийн дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагад баримжаалсан үндэсний бодлого, хөтөлбөрүүд батлагдан гарчээ.

- **2015 он:** *Боловсролын салбарт МХХТ-т суурилсан цогц үйлчилгээг бий болгож, хөгжүүлэх*  
2015 оноос хойших бодлогын баримт бичгүүдэд боловсролд удирдлага, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлэх, боловсролд мэдээллийн технологи, нээлттэй агуулга, хөтөлбөрийг хөгжүүлэх, мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын тогтолцоог эрчимтэй хөгжүүлэх, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгох, МХХТ-ийг ашиглах ЕБС-ийн багшийн чадварын стандарт боловсруулах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Гэвч өнөөдөр Боловсролын салбарт МХХТ-ийн талаар баримтлал бие даасан бодлого хөтөлбөр дутагдаж байна.

### 2.5.3. Хэрэгжилт, Үр дүн

#### Боловсролын салбарын мэдээллийн систем

Бага, дунд боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлж хэрэглээнд нэвтрүүлэхээр 2006 оноос хойш тодорхой ажлуудыг хийж байсан бөгөөд 2013 онд Засгийн газрын “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрт “Боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн систем” програм хангамж боловсруулж, нэвтрүүлэх тухай зорилт дэвшүүлэн 2014 оноос улсын төсөв болон АХБ-ны Боловсролын салбарын шинэчлэл төслийн хүрээнд боловсролын салбарын мэдээллийн системийн үндсэн платформ, системийн модуль, хүний нөөц, статистик модулиудыг боловсруулжээ.

Бага, дунд боловсролын нэгдсэн мэдээллийн системийн түүхийг дараах зургаар харуулав.

Зураг 2.5.1. Боловсролын салбарын мэдээллийн системийн түүх



Эх сурвалж: (Ю.Алтантуяа, 2018)

Боловсролын салбарын мэдээллийн системд ЕБС-ийн статистик мэдээ цуглуулах ажлыг 2014 оноос эхэлсэн ба 2018 оны байдлаар тус системд нийт 798 сургууль, 1,182 хичээлийн байр, 517 дотуур байр, 20,211 бүлэг, 572,752 сурагч, 29,242 багш, 47,991 ажилтны бүртгэл тус тус хийгдсэн байна.

Харин СӨБ-ын статистик мэдээ цуглуулах ажлыг 2017 онд туршиж, 2018 оноос хэрэгжүүлж эхэлсэн ба өнөөдрийн байдлаар тус системд нийт 1,354 цэцэрлэг, 256,720 суралцагч, 29,424 багш, 25,639 ажилтны бүртгэл хийгдсэн байна.



Хүснэгт 2.5.1. “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн хөгжүүлэхэд зарцуулсан төсөв (2013-2017)

	2013	2014	2015	2016	2017	Нийт
“Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн хөгжүүлэх зардал (сая төг.)	412,4	739,1	823,4	879,2	773,9	3,628,0

2018 оны байдлаар тус системд дараах модулиудыг хөгжүүлэн хэрэглэж байна.

**Хүний нөөцийн дэд систем:** Байгууллагын хүний нөөцийн бодлого, ажилтны бүртгэл, мэдээлэл, ажлын харилцаа, цаг бүртгэл, цалин хөлс, тэтгэмжийн бодлогыг загварчлах, зохион байгуулж удирдах, тайлан боловсруулах боломж бүрджээ.

**Боловсролын удирдлагын систем:** Өнөөдрийн байдлаар төр, хувийнхэвшлийн бүх ЕБС-ийн сургалтын орчин, бүтэц, хөтөлбөр, хичээл, суралцагч, багш, анги бүлэг, хичээлийн хуваарь, шилжилт хөдөлгөөн, сурагчийнөдөр тутмын үйл ажиллагааг хөтлөн явуулж байна.


**Санхүүгийн удирдлагын систем:** Байгууллагын үндсэн хөрөнгийн мэдээллийн бүртгэл, ашиглалтыг хянах хэсгийг боловсруулж, компьютер, тоног төхөөрөмж, барилга байгууламжийн бүртгэл хийгдээд байна.

**Статистик мэдээллийн систем:** Тодорхой зорилгын хүрээнд мэдээлэл цуглуулах загварыг зохион байгуулах, мэдээлэл цуглуулах, олон төрөл, хэлбэрээр шинжилгээ хийх, үр дүнг түгээх, бусад мэдээллийн системтэй холбогдож мэдээлэл солилцох, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах үйл ажиллагааг зохион байгуулна (БСШУСЯ, 2017).

### Цэцэрлэг дэх МХХТ-ийн хэрэглээ

Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд “боловсролын бүх байгууллага, цэцэрлэг, сургуулийг интернеттэй холбосноор сургалт, мэдээлэл солилцоо, хяналт-шинжилгээ, үнэлгээ, бүртгэл тооцооны мэдээлэл харилцааны технологийг нэвтрүүлэх” гэсэн заалт байдаг. Бодлого, эрх зүйн баримт бичгүүдэд МХХТ-ийн талаар цэцэрлэгтэй холбоотой тусгайлсан заалт байхгүй байна. Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд 1416 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаагаас 115 буюу улсын цэцэрлэгийн дунджаар 78,7 хувь нь интернетэд холбогдсон байна. Энэ хувь 2007 онд 2.3 хувь, 2010 онд 24.1 хувь 2015 онд 69.3 хувь болж жил дараалан өссөөр 2017 онд 78.7 хувьд хүрчээ.


Зураг 2.5.2. Интернетэд холбогдсон цэцэрлэгийн эзлэх хувийн өсөлт: Бүсээр (2006-2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Хэдийгээр интернетэд холбогдсон цэцэрлэгийн хувь жил бүр өссөөр ирсэн боловч баруун бүсийн алслагдсан сум, орон нутаг дахь цэцэрлэгүүдийн интернетэд холбогдсон хувь улсын дунджаас даруй 13.6 хувиар бага байна. Улаанбаатар хотод энэ үзүүлэлт улсын дунджаас 7.6 хувиар өндөр байгаа ч интернетэд холбогдоогүй цэцэрлэг 13.6 хувийг эзэлж байгаа нь техник, технологийн дэвшил хурдацтай хөгжиж буй нийслэл хотод хангалтгүй үзүүлэлт болохыг илтгэж байна.

Зураг 2.5.3. Интернетэд холбогдсон цэцэрлэгийн хувь: Аймаг, нийслэлээр (2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик


2017 оны байдлаар интернетэд холбогдсон цэцэрлэгийн хувийг аймгаар нь ангилж харвал Булган аймаг 100%, Орхон, Ховд, Дархан-Уул, Хэнтий, Дундговь аймгууд 90 хувиас дээш үзүүлэлттэй байна. Харин Сүхбаатар, Говьсүмбэр, Архангай аймгийн хувьд энэ үзүүлэлт 50 хувьд ч хүрэхгүй бага байна.

Хүснэгт 2.5.2. Цэцэрлэгийн нэг компьютерт ногдох багшийн тоо: Улсын дунджаар (2006-2017)

Он	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Үндсэн багшийн тоо	3974	4242	4465	4651	4907	5332	5895	6158	6833	7302	7745
Компьютерийн тоо	1327	1453	1775	2214	2526	3266	4040	4801	5360	5826	6468
Нэг компьютерт ногдох багшийн тоо	3.0	2.9	2.5	2.1	1.9	1.6	1.5	1.3	1.3	1.3	1.2

2017 онд 1416 цэцэрлэгт 7745 үндсэн багш ажиллаж байгаа бөгөөд 2017 онд нийт 6468 компьютертой буюу нэг компьютерт ногдох багшийн тоо улсын дунджаар 1.2 байна. Хэдийгээр 2006-2017 он хүртэл жил бүр компьютерийн тоо, мөн багшийн тоо өсөн нэмэгдсээр ирсэн боловч нэг компьютерт ногдох багшийн тоон үзүүлэлт буурсан байна.


Зураг 2.5.4. Цэцэрлэгийн нэг компьютерт ногдох багшийн тоо: Бүсээр (2006-2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2006-2017 онд цэцэрлэгүүдийн компьютерийн тоо жилд дунджаар баруун бүсэд 56.7, хангайн бүсэд 89.7, төвийн бүсэд 104, зүүн бүсэд 32.9, Улаанбаатар хотод 298.8-иар тус тус өссөн байна. 2017 онд нэг компьютерт ногдох багшийн тоон үзүүлэлтээр баруун, зүүн бүсийн цэцэрлэг улсын дунджаас их буюу 1.5-1.6 байгаа нь өнгөрсөн жилүүд дэх компьютерийн хангамж бага байсантай холбоотой гэж үзэж болохоор байна.

Зураг 2.5.5. Цэцэрлэгийн нэг компьютерт ногдох багшийн тоо: Аймаг, нийслэлээр (2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Завхан, Дорноговь, Өмнөговь, Дундговь, Булган, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын багш бүр нэг компьютертой байгаа нь эдгээр аймаг, нийслэлийн СӨБ-ын багш нарын хувьд компьютер ашиглан хичээл, үйл ажиллагааны хэрэглэгдэхүүн бэлтгэх, өөрийгөө хөгжүүлэхэд хэрэглэж болохуйц компьютероор хангагдсан гэж үзэж болохоор байна. Харин Баян-Өлгий, Сүхбаатар аймаг дахь СӨБ-ын 3 багш дундаа нэг компьютер ашиглах боломжтой байгаа бол бусад аймгийн хувьд 2 багш дундаа нэг компьютер хэрэглэж байна.

### Ерөнхий боловсролын сургууль дахь МХХТ-ийн хэрэглээ

Монгол Улсын бага, дунд боловсролын тухай хуулинд

- Бага боловсролын агуулгын хүрээнд гадаад хэл, мэдээлэл зүйн анхны мэдлэг олгож болно.
- Суурь боловсролын агуулгын хүрээнд эх хэл болон гадаад хэл, математик, мэдээлэл зүй, шинжлэх ухаан, эрх зүйн зохих шатны мэдлэг, өөрийн авьяас, чадварт тулгуурлан бие даан амьдрахад шаардлагатай чадвар, дадал эзэмшүүлэх;
- Бүрэн дунд боловсролын агуулгын хүрээнд байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх тухай тус тус заасан байдаг.

ЕБС-ийн дунд буюу VI-IX ангид 7 хоногт 1 цаг буюу хичээлийн жилд 35 цаг, ахлах буюу X-XII ангид 7 хоногт заавал судлахаар 1 цаг, сонгон судлах тохиолдолд X ангид 1-2 цаг, XI ангид 2-3, XII ангид 3-4 цаг нэмж судлахаар тусгаж өгсөн байна.


Хүснэгт 2.5.3. Суурь, бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр дэх МТ хичээлийн зорилго, сурагчдад эзэмшүүлэх чадвар

	Суурь боловсрол (VI, VII, VIII, IX)	Бүрэн дунд боловсрол (X, XI, XII)
Зорилго	Мэдээлэл боловсруулах, асуудлыг шийдвэрлэх үйл ажиллагаандаа МХХТ-ийг бүтээлчээр ёс зүйтэй хэрэглэдэг, мэдээлэлжсэн нийгэмд соёлтой амьдарч, хамтран ажиллах чадвартай иргэн болгон төлөвшүүлнэ.	Сурагч нь хичээл сургалт, ахуй амьдралын мэдээлэл боловсруулах, асуудал шийдвэрлэхэд МХХТ, компьютерийн шинжлэх ухааны техникийн болон програм хангамжийн арга, хэрэгслийг бүтээлчээр хэрэглэдэг, мэдээллийн ёс зүй эрх зүй, соёлын хэм хэмжээг мөрддөг иргэн болж төлөвшинө
Чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Мэдээллийг таних, ойлгох, тодорхойлох</li> <li>• Мэдээлэл боловсруулах хялбар аргуудыг ойлгох, тайлбарлах, хэлэлцүүлэх</li> <li>• Мэдээллийн шинж чанар, онцлогоос хамааруулан түүнийг боловсруулах технологийг тодорхойлох</li> <li>• МХХТ-ийн хэрэглээний болон хамтран эзэмших соёл, ёс зүйд суралцах</li> <li>• Бусад хичээл, ахуй амьдралд түгээмэл тохиолдох юм үзэгдлийн нийтлэг шинж чанарыг тодорхойлох, түүний хялбар загварыг байгуулах</li> <li>• Мэдээллийн эх үүсвэрээс хичээлд болон ахуй амьдралд хэрэгцээт мэдээллийг олж цуглуулах, шинжлэх, ашиглах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• МХХТ, компьютерийн шинжлэх ухааны нэр томъёо, ойлголт, зарчим, дүрэм зүй тогтол, харилцан хамаарлыг тайлбарлах</li> <li>• Мэдээллийг системтэйгээр төлөвлөн, мэдээллийн онцлог, хэлбэрээс хамааруулан боловсруулах техник, хэрэгслийг оновчтой сонгон хэрэглэх</li> <li>• МХХТ, компьютерийн шинжлэх ухааны хөгжлийн чиг хандлага, нийгэм дэх хэрэглээг тайлбарлах</li> <li>• МХХТ ашиглан ёс зүйтэй харилцах, хамтран ажиллах</li> </ul>

2008 оноос төрийн болон орон нутгийн хөрөнгө, төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд ерөнхий боловсролын сургууль, боловсролын байгууллагуудыг шилэн кабелиар холбооны дэд бүтцэд холбож байсан ажлыг үрэгжүүлэн боловсролын салбарын өргөн зурвасын нэгдсэн сүлжээ байгуулах зорилт тавин ажиллаж, одоогийн байдлаар Улаанбаатар хотын 37, аймгийн 200, сумын төвийн 255 ерөнхий боловсролын сургуулийг шилэн кабелиар холбооны дэд бүтэцтэй холбон интернет үйлчилгээг хүргэж байна.

Улсын хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд 798 сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас 690 буюу улсын дунджаар 86.5 хувь нь интернетэд холбогдсон байна. Энэ хувь 2010 онд 59.5 хувь, 2015 онд 81.4 хувь байсан бол 2017 онд 86.5 хувь болтол өсжээ.

Зураг 2.5.6. Интернетэд холбогдсон сургуулийн хувь: Бүсээр (2007-2017)




Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Боловсролын дата төв байгуулах, Эрдэмнэт сүлжээний төвийн өргөтгөл хийх ажлыг 2012 оноос эхлүүлэн Улсын төсөв болон АХБ-ны төслийн санхүүжилтээр 2013 онд 1.5 тэрбум, 2014 онд 953 сая, 2015 онд 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтээр нийт 3.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж сервер, тоног төхөөрөмж, сүлжээний нөөц эх үүсвэр худалдан авч суурилуулан ажиллаж байна.

Боловсролын дата төвд тулгуурлан “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд боловсролын нэгдсэн сүлжээний төв байгуулах ажлыг 2016 онд хийж гүйцэтгэсэн. Сүүлийн жилүүдэд хэрэгжиж буй төслүүдийн үр дүнд орон нутгийн ЕБС-иудад интернет үйлчилгээ хүргэх томоохон сүлжээний үндэс тавигдаж байна. Одоо МХС ТӨК-ийн суурь дэд бүтэц дээр суурилсан энэ сүлжээнд 247 сумын 255 ЕБС, 21 аймгийн төв, Улаанбаатар хотын алслагдсан 200 гаруй ЕБС холбогдож, интернетийн болон бусад үйлчилгээг авч байна. (М.Мөнхбаатар, О.Дүнжиннамдаг, 2017) Интернетэд холбогдсон сургуулийн хувь 2014 онд 67.8 хувь байсан бол 2015 онд 81.4 хувь болж 13.6 хувиар өссөн нь эдгээр төсөл, хөтөлбөрүүдийн бодитой үр дүн юм.

Зураг 2.5.7. Интернетэд холбогдсон сургуулийн хувь: Аймаг, нийслэлээр (2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Говь-Алтай, Баян-Өлгий, Төв аймгийн сургуулиудын интернетэд холбогдсон хувь хамгийн бага буюу 65 хувиас доогуур үзүүлэлттэй байна. Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн хувьд алслагдсан сумын сургуулиуд интернетэд холбогдоогүй байж болох талтай.

“Хүүхэд бүрд компьютер” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 92-р тогтоолоор Хөтөлбөр хэрэгжүүлэх тогтоол гарч, БСШУЯ-ны 2008 оны 471 тоот тушаалаар “Хүүхэд бүрд компьютер” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар баримтлах бодлого” батлагджээ. Уг хөтөлбөр нь 2008-2012 оны 05 дугаар сар хүртэл хэрэгжиж хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн сургуулиудад 11,813 ширхэг Икс Өү компьютер тарагдсан байна. Багш, сурагчдын Икс-Өү компьютер ашиглах үйл ажиллагаануудыг судлан, сургалтад хэрэглэхэд зориулан 60 гаруй гарын авлага, цахим хэрэглэгдэхүүнээр хангасан байна (Хүүхэд бүрд компьютер хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж, 2011).

Монгол Улсын Засгийн Газраас баталсан “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийн хүрээнд багш нарт 25,000 зөврийн компьютер төлбөргүйгээр тарагдсанаас гадна ЕБС-иудын компьютерийн сургалтын танхимд 11,240 зөврийн компьютер түгээгдсэн. Эдгээр томоохон хөтөлбөрөөс гадна олон төсөл, хөтөлбөрүүд, хөрөнгө оруулалтын дэмжлэгтэйгээр ЕБС-ийн багш, сургалтын үйл ажиллагаанд зориулсан компьютер, техник, тоног төхөөрөмжийн хангамж нэмэгдсээр ирсэн байна. 2017 оны байдлаар ЕБС-д 572,752 суралцагч суралцаж, сургалтын үйл ажиллагаанд ашиглагдаж буй компьютерийн тоо 45836 байна. Энэ нь нэг компьютерт ногдох сурагчийн тоо 12.5 байгааг харуулна.


Хүснэгт 2.5.4. ЕБС-ийн нэг сурагчид ногдох компьютерийн тоо (2007-2017)

Он	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Нэг компьютерт ногдох сурагчийн тоо	43.9	31.3	25.2	21.1	16.4	14.4	14.9	20.5	5.3	12.5	12.5
Сурагчдын тоо	537,546	532,058	522,066	512,213	505,409	505,409	497,022	505,816	535,055	551,953	572,752
Компьютерийн тоо	12,254	17,009	20,706	24,314	30,755	35,211	33,457	24,732	34,954	44,044	45,836

2005 онд батлагдсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрт (ЗГ-ын 216 дугаар тогтоол, 2005) “Мэдээллийн технологийг сургалтад ашиглах болон цахим сургалтын материал бэлтгэхэд нь зориулан сургууль бүрийг МХХТ-ийн иж бүрэн техник хэрэгслээр хангаж, 2012 он гэхэд ахлах ангийн 10 сурагч тутамд нэг компьютер ногдох хэмжээнд хүргэх” гэсэн зорилт, арга хэмжээг тусгасан байдаг. Нэг компьютерт ногдох сурагчийн тоо 2007 онд 43.9 байсан бол 2010 он гэхэд 21.1 болж 2 дахин буурсан, 2012 онд 14.4, 2016, 2017 оны байдлаар энэ үзүүлэлт 12.5 болжээ.

2006 онд батлагдсан Монгол Улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд 2015 он хүртэл хэрэгжүүлэх арга хэмжээнд “ЕБС-ийн компьютержүүлэлтийг эрс нэмэгдүүлнэ. Үүнд: Бага боловсролын хүүхэд, компьютерийн харьцааг 1250-иас 50, ахлах ангийн хүүхэд компьютерийн харьцааг 25-иас 5-д хүргэнэ” гэж тусгасан байдаг. Дээрх графикт харуулснаар нэг компьютерт ногдох сурагчийн тоо 2007 онд 43.9 байснаас 2015 онд 15.3 болсон үр дүн харагдаж байна.


Зураг 2.5.8. ЕБС-ийн нэг компьютерт ногдох сурагчийн тоо: Бүсээр (2007-2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Нэг компьютерт ноогдох хүүхдийн тоо 2017 оны байдлаар зүүн бүсийн дундаж 15.1, Улаанбаатар 13.6, Хангайн бүс 13.4 буюу улсын дунджаас дээгүүр байна. Харин төвийн бүс 9.6, баруун бүс 11.5 буюу улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байгаа нь төв, баруун бүсийн сургалтад хэрэглэж буй компьютер, тоног төхөөрөмжийн хүртээмж илүү сайн байгааг харуулж байна.

Зураг 2.5.9. ЕБС-ийн нэг компьютерт ноогдох сурагчийн тоо. Аймаг, нийслэлээр (2017)




Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2017 оны байдлаар нэг компьютерт ноогдох сурагчийн тоо 10-аас бага үзүүлэлттэй 8 аймаг байгаа бол 16-аас дээш үзүүлэлттэй 4 аймаг байна. Энэ 4 аймагт сургалтын зориулалттай компьютер, техник тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай нь харагдаж байна.

2017 оны байдлаар ЕБС-д 29,242 үндсэн багш ажиллаж, багшийн хөгжлийн болон багшийн албан хэрэгцээний үйл ажиллагаанд ашиглагдаж буй компьютерийн тоо 18,279, нэг компьютерт ноогдох багшийн тоо улсын дунджаар 1.6 байна.


Зураг 2.5.10. ЕБС-ийн нэг компьютерт ноогдох багшийн тоо: Бүсээр (2007-2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

2005 онд батлагдсан “Цахим Монгол” үндэсний хөтөлбөрт (ЗГ-ын 216 дугаар тогтоол, 2005) 2012 гэхэд багш бүрийг компьютертой болгож, түүнээс 10%-ийг нь зөөврийн компьютертой болгох тухай үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан байдаг. Улсын дунджаар 2012 онд нэг компьютерт ноогдох багшийн тоо 5.2 байсан бол 2017 онд 1.6 болж буурсан байна. Багш бүрд зөөврийн компьютер түгээх ажлын явц 2016, 2017 онд дамнаж хийгдсэн тул энэ үзүүлэлт 2018 оны мэдээгээр дахин буурах төлөвтэй байгаа юм. Хэдийгээр багш бүр зөөврийн компьютертэй болсон ч энэхүү компьютерийг сургалтад болон өөрийн мэргэжлийн хөгжил, ажил албан хэрэгцээнд хэрхэн үр ашигтай хэрэглэж байгаа талаар дэлгэрэнгүй судалгаа хийгдээгүй байна.

Зураг 2.5.11. ЕБС-ийн нэг компьютерт ногдох багшийн тоо: Аймаг, нийслэлээр (2017)



Эх сурвалж: БСШУСЯ-ны статистик

Дундговь, Архангай, Завхан, Говьсүмбэр аймгуудын ЕБС-ийн багш бүр сургалт, албан хэрэгцээндээ ашиглах компьютертой байна. Харин Сүхбаатар, Увс, Баян-Өлгий, Хөвсгөл, Төв, Баянхонгор аймгуудын ЕБС-ийн хувьд 2 багшид 1 компьютер ногдож байна.

Багшийн хөгжлийг дэмжсэн сургалт, үйл ажиллагаа онлайн, цахим хэлбэрт шилжиж байгаа энэ цаг үед багш бүр компьютер хэрэглэх боломж нэмэгдүүлэх нь тухайн багш мэргэжлийн хөгжил, суралцахуй болон багшлахуйн үйл, албан хэрэг хөтлөлт гэх мэт бүхий л үйл ажиллагаандаа МХХТ-ийг ашиглах боломж нэмэгдэж байгаагаараа ач холбогдолтой юм.

### ЕБС-ийн багш нарын МХХТ-ийг ашиглах чадвар, сургалт үйл ажиллагаандаа хэрэглэж буй байдал

Өнөөгийн ЕБС-ийн багш нарын МХХТ-ийг ашиглах чадварын түвшин харилцан адилгүй байна. “Ерөнхий боловсролын сургуулийн багш” чиглэлийн бакалаврын төгсөгчдөд тавих нийтлэг шаардлагад “... **орчин үеийн мэдээллийн технологийг ашиглан** шинэ мэдлэг олж авах, бүтээлчээр, тасралтгүй бие даан суралцах чадвартай байх”, “МХХТ хэрэглэж хичээлээ явуулах” (Стандартчилал хэмжилзүйн үндэсний зөвлөл, 2009) гэсэн шаардлагыг тусгаж 2010 оны 09 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн байдаг. ЕБС-ийн орчин дахь МХХТ-ийн үйлчилгээ багш нарын чадварыг дээшлүүлэх дэмжлэг үзүүлэхэд мэдээлэл зүйн багш нар голлох үүрэгтэй ажилладаг.

2016-2017 оны хичээлийн жилд ЕБС-д мэдээлэл зүйн 618, мэдээлэл зүй-математикийн 312, нийт 930 мэдээлэл зүйн мэргэжлийн багш ажиллаж байна. Тэдгээрийн 65.5 хувь нь аймаг, орон нутагт ажиллаж байна (Боловсролын салбарын статистик, 2017). Мэдээлэл зүйн багш нь мэдээлэл зүйн хичээл захаас гадна, ажиллаж буй сургуулийнхаа багш нарт компьютер, мэдээллийн технологийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлдэг.

ЕБС-ийн багш нарын МХХТ-ийг ашиглах чадварын стандарт хэрэгжүүлэхэд бэлэн байдлын судалгааг 2018.06.04-2018.06.20 өдрүүдэд санамсаргүй түүврийн аргаар зохион байгуулсан бөгөөд түүвэрт сонгогдсон нийслэл, орон нутгийн ЕБС-ийн 1917 багш, ажилтан хамрагдсан судалгааны үр дүнгээс зарим хэсгийг энэ тайланд тусгав. Судалгаанд оролцогчид МХХТ-ийн өөрийн чадварыг 1-7 оноогоор үнэлсэн ба 7 оноо хамгийн өндөр чадамжийг илэрхийлнэ.

МХХТ-ийн чадварыг үнэлэх 35 үзүүлэлтэд хариулт авсан бөгөөд эдгээрийг 6 бүлэгт багцалж үзжээ.


#### 1. Мэдээллийн технологийн үндэс (Компьютерийн хэрэглээ)

- Бичвэр боловсруулах /MS Word эсвэл OpenOffice writer гэх мэт програм ашиглалт
- Танилцуулга бэлтгэх /MS Powerpoint эсвэл OpenOffice Impress гэх мэт програм ашиглалт
- Хүснэгт боловсруулах /MS excel эсвэл OpenOffice Calc гэх мэт програм ашиглалт
- Файл, хавтсуудыг хадгалах, зохион байгуулах
- Програм татаж авах, суулгах
- Өөрөө бие даан шинэ МХХТ-ийн програм, хэрэгсэл ашиглаж сурах
- Цаанаас заасан сургуулийн удирдлагын системийн ашиглалт

2. Мультимедиа хэрэглэгдэхүүн боловсруулах
  - Компьютер дээр зураг засвар хийх, бусад график засвар хийх
  - Аудио (дуун) болон видео дүрс бичлэг хийх (цахим ном, дижитал түүх, видео, энимейшн) гэх мэт
  - Мультимедиа (видео дүрс бичлэг, хөдөлгөөнт дүрс эсвэл симуляц)-г суралцахуйн үйл ажиллагаанд ашиглах
3. Интернет хэрэглээ
  - Цахим шуудан (email) унших, бичих, илгээх
  - Чат, бусад сошиал сүлжээний ашиглалт
  - Боловсрол, сургалтад ашиглах материал, хэрэгслийг интернетээс хайх, ашиглах
  - Вэбсайт дахь мэдээллийн найдвартай байдал, магадлалыг үнэлэх
  - Видео хурал хийдэг програм ашиглалт (Skype, facebook видео чат, Google чат, WebEx) гэх мэт
  - Онлайн орчинд дундын хавтас, файл дээр ажиллах (Google Drive, Dropbox гэх мэт)
4. Сургалтад буюу багшлахуйн үйлдээ МХХТ хэрэглэх
  - Суралцагчийн сорил, туршилт, сургалтын үйл ажиллагааг дижитал хэрэгсэл ашиглан явуулах
  - Суралцагчийн оролцоог идэвхжүүлэхэд дижитал хэрэгсэл (дижитал тоглоом) ашиглах
  - Суралцагчдыг өөрсдийн санал бодлоо онлайн асуулга, судалгаа, блог болон бусад сошиал хэрэгсэл ашиглан бусадтай хуваалцахад туслах
  - Суралцах үйл явцад ашиглах дижитал програм болон агуулгын холбоог үнэлэх
  - Суралцагчдыг онлайн орчинд судалгаа хийхэд зааварчлан туслах
  - Суралцагчдын шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч чадварыг идэвхжүүлэхэд МХХТ-ийг багшлах арга зүйдээ ашиглах
  - Суралцагчдыг төрөл бүрийн МХХТ-ийн хэрэгсэл ашиглан хамтын үйл ажиллагаа/төсөлт ажлыг зохион байгуулах
  - Суралцагчдыг өөрийгөө болон хамтрагчаа үнэлэхэд зориулан онлайн форм, судалгааг ашиглах
  - Суралцагчидтай тэдний цахим орчны эрх, аюулгүй байдал, хувийн хамгаалал, ёс зүйн талаар хэлэлцэх
5. Дижитал бүтээлч хамтын ажиллагаа
  - Онлайн орчноор дамжуулан гадны мэргэжилтэн, экспертэй харилцах (цахим шуудан, форум, видео хурал гэх мэт)
  - Онлайн үнэлгээний хэрэгсэл ашиглах (тест, даалгавар болон ажлын үр дүнгээ онлайн орчноор өгөх, дижитал танилцуулга гэх мэт)
  - Төрөл бүрийн МХХТ-ийн хэрэгсэл/програм ашиглан эцэг эх, асран хамгаалагч, бусадтай харилцах
  - Бусад сургуулийн багш нартай туршлага хуваалцах үүднээс виртуал орон зайд нэгдсэн
6. Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, багшийн мэргэжлийн хөгжилд МХХТ хэрэглэх
  - Багшлахуйн зорилгоор зохих сошиал сүлжээний сайтуудыг ашиглах
  - Өөрийн ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор боловсролын вэбсайтуудад байнга тогтмол орж байдаг
  - Вэб семинар болон онлайн сургалтад хамрагддаг
  - Өөрийн заах арга зүйдээ тусгадаг
  - Боловсролын салбарт ашиглаж буй МХХТ-ийн шинэлэг ажлуудын талаар сургуулийн хамт олон, хамтрагчдаа хуваалцдаг
  - Боловсролын салбарт МХХТ-ийг ашиглах талаар хамтрагч, хамт олондоо тусалж, зааж зөвлөдөг




Зураг 2.5.12. ЕБС-ийн багшийн МХХТ ашиглах чадварын өөрийн үнэлгээ: Сургуулийн байршлаар (1-7 оноо, 2018)




МХХТ-ийн ашиглах чадварын үнэлгээг харахад мэдээллийн технологийн үндэс, интернет хэрэглээний чадвар бусад хэсгүүдээс илүү сайн байгаа нь байнгын хэрэглээтэй холбоотой, харин мультимедиа хэрэглэгдэхүүн боловсруулах, сургалтад буюу багшлах үйлдээ МХХТ хэрэглэх, дижитал бүтээлч хамтын ажиллагааны чадварууд дундаж үзүүлэлттэй байна. Байршлын хувьд нийслэлийн багш нарын чадвар орон нутгийн багш нараас илүү, орон нутаг дахь аймгийн төвийн багш нар сумын сургуулийн багшаас илүү өндөр байгаа нь дээрх графикаас харагдаж байна.

Зураг 2.5.13. ЕБС-ийн багшийн МХХТ ашиглах чадварын өөрийн үнэлгээ: Насаар (1-7 оноо, 2018)



Багшийн МХХТ ашиглах чадвар нь насны бүлгээс урвуу хамааралтай буюу насны бүлэг залуужих тусам МХХТ ашиглах чадвар нэмэгдэж байгаа нь харагдаж байна. Энэ нь МХХТ-ийн хөгжил, их дээд сургуулиудын тус хичээлийг судлах агуулгын хүрээ төдийгүй цаг үеийн хөгжилтэй зайлшгүй холбогдож байна.

Зураг 2.5.14. ЕБС-ийн багшийн МХХТ ашиглах чадварын өөрийн үнэлгээ: Мэргэжлийн зэргээр (1-7 оноо, 2018)




ЕБС-ийн багшийн МХХТ-ийг ашиглах чадвар нь мэргэжлийн зэрэгтэй харьцуулахад сонирхолтой үр дүн ажиглагдаж байлаа. Ерөнхийдөө зэрэггүй багш нь заах аргач, тэргүүлэх зэрэгтэй багш нараас илүү МХХТ-ийн чадвартай гэж харагдаж байгааг насны бүлэгтэй холбож тайлбарлаж болох ч зөвлөх зэрэгтэй багш нарын чадвар бусад багш нарынхаас илүү байгаа нь харагдаж байна. Энэ нь ахмад багш гэлтгүй цаг үеэ даган байнга хөгжиж байдаг багш нарын чадвар бусад багш нараас өндөр байгааг харуулж байна.

Мэдээллийн технологийн үндэс (Компьютерийн хэрэглээ), интернет хэрэглээний чадваруудын дундаж үнэлгээ 5-аас дээш үзүүлэлттэй байгаа нь багш нарын Office-ийн өргөн хэрэглээний болон вэб, нийгмийн сүлжээ, сургалтын цахим материалын хэрэглээний мэдлэг чадвар харьцангуй сайн байгааг илтгэж байна.

Нөгөө талаар мультимедиа хэрэглэгдэхүүн боловсруулах, сургалтад буюу багшлахуйн үйлдээ МХХТ хэрэглэх, дижитал бүтээлч хамтын ажиллагаа, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, багшийн мэргэжлийн хөгжилд МХХТ хэрэглэх чадваруудын дундаж оноо 5 хүрэхгүй байгаа нь энэ чиглэлээр багш нарыг илүү сайн хөгжүүлэхэд анхаарч, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааны хөтөлбөр, агуулгад тусгах шаардлагатайг харуулж байна.

Зураг 2.5.15.ЕБС-ийн багш хичээл заахдаа МХХТ ашигладаг цагийн эзлэх хувь (2018)



Та дунджаар хичээлийн цагийн хэдэн хувийг МХХТ-ийг ашиглан заадаг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцсон 1917 багшийн 13 хувь нь хичээлийн 10-аас бага хувьд, 28 хувь нь хичээлийн 10-аас 30 хувьд, 19 хувь нь 31-ээс 50 хувьд, 10 хувь нь 51-ээс 70 хувьд, 4 хувь нь 71-ээс 100 хувьд гэж хариулжээ. Харин МХХТ-ийг хичээлдээ ашигладаггүй гэж 1 орчим хувь нь хариулжээ.

Судалгаанд оролцогчдын 25 хувь нь уг асуултад хариулаагүй байна. Судалгаанд оролцсон багш нарын 70 гаруй хувь нь МХХТ-ийг хичээл сургалтдаа тодорхой хэмжээгээр ашиглаж байгааг энэхүү хариулт харуулж байна.

Өөрийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээнд тулгуурлан дараах жагсаалтыг дараалуулна уу гэсэн асуултын үр дүнг эрэмбэлж үзвэл:

1. Суралцахуйн мультимедиа материал бэлтгэх
2. МХХТ-ийг ашиглан шинэлэг арга зүй боловсруулах (төсөлд суурилсан суралцахуй, компьютер ашигласан хамтын суралцахуй гэх мэт)
3. Сургуулийн систем
4. Суралцагчийн үнэлгээнд МХХТ-ийг ашиглах
5. МХХТ-ийг өөрийн судлагдахууны тодорхой нэгэн хэсэгтэй хамтатгах
6. Багшлахуй болон суралцахуйд социал сүлжээг ашиглах
7. МХХТ-ийг судлагдахууны хувьд заах
8. Интернет орчноос материал олох, өөрчлөх, үнэлж дүгнэн ашиглах
9. Анхан шатны МХХТ мэдлэг (текст боловсруулалт, презентаци үзүүлэн бэлтгэл, хүснэгттэй ажиллах гэх мэт)

Асуултын хариултыг боловсруулалт хийж хэрэгцээтэй сургалтаас эрэмбэлэхэд багш нарт хамгийн эрэлт хэрэгцээтэй гурван сургалт нь “Суралцахуйн мультимедиа материал бэлтгэх”; “МХХТ-ийг ашиглан шинэлэг арга зүй боловсруулах (төсөлд суурилсан суралцахуй, компьютер ашигласан хамтын суралцахуй гэх мэт)”; “Сургуулийн систем” гэсэн сургалтууд байна. Мөн түүнчлэн “Суралцагчийн үнэлгээнд МХХТ-ийг ашиглах”, “МХХТ-ийг өөрийн судлагдахууны тодорхой нэгэн хэсэгтэй хамтатгах”, “Багшлахуй болон суралцахуйд социал сүлжээг ашиглах”, “МХХТ-ийг судлагдахууны хувьд заах”, “Интернет орчноос материал олох, өөрчлөх, үнэлж дүгнэн ашиглах” чиглэлийн сургалт ч бас хэрэгцээтэй байна. Харин “Анхан шатны МХХТ мэдлэг олгох” сургалт хамгийн сүүлд эрэмбэлэгдэж байгаа нь багш нарын МХХТ-ийн суурь мэдлэг, чадвар харьцангуй сайн байгааг харуулж байна.

Мөн түүнчлэн “бусад сургалт” гэдэгт дараах сургалтуудыг хэрэгцээтэй байна гэжээ. Үүнд:

- МХТ ашиглан шинэлэг арга зүй боловсруулах
- Цахим журнал, хувийн хэрэг хөтлөх, дүн боловсруулах арга
- Онлайн сургалт, МХХТ ашиглан гадаад багш болон суралцагчидтай онлайн сургалт явуулах арга зүй
- Цахим хичээл бэлдэх, хөдөлгөөнт зураг, анимэйшн боловсруулах
- Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх
- Компьютерийн програмууд дээр чөлөөтэй ажиллах
- Багшлахуй болон суралцахуйд социал сүлжээг ашиглах, хичээлээс гадуурх ажилд МХХТ-ийг ашиглах
- Боловсролын сайтуудаас мэдээлэл авах
- Ангийн мэдээлэл боловсруулах амар хялбар програмын хэрэглээ

Бага, дунд боловсролын үйлчилгээг чанартай хүргэх, техник технологийн хурдацтай хөгжил, 21 зууны багшид тавигдах шаардлага гэх мэт олон улсын чиг хандлагыг дагаж багш нарын МХХТ-ийг ашиглах чадвар өндөр байх шаардлага цаг үргэлж тавигдаж ирсэн билээ. ЮНЕСКО-ийн Ази, Номхон далайн бүс нутгийн товчоо, БНСУ-ын Итгэлцлийн сантай хамтран хэрэгжүүлэх “Ази, Номхон далайн бүс нутагт цахим иргэний боловсролыг дэмжих үндэсний чадавхыг бэхжүүлэх” төсөлд Монгол улсыг хамруулахаар болж БСШУС-ын Сайдын 2018 оны А/153, А/209 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын мэдээлэл, технологийн ур чадварын стандартын төсөл боловсруулах ажлын хэсэг” байгуулагдан ажиллаж байна. Уг стандарт нь 2019 онд батлагдан гарч цаашид ЕБС-ийн багш болон их дээд сургуулийг ЕБС-ийн багш мэргэжлээр төгсгөгчдийн МХХТ-ийг ашиглах чадварын стандартыг нэвтрүүлэх үе шаттай ажлууд хийгдэхээр төлөвлөгдөж байна.

### **Багшид зориулсан МХХТ болон онлайн сургалт**

Монгол Улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнд а) Багш нарт компьютерийн хэрэглээний програмын боловсрол эзэмшүүлэх, б) Багш нарын мэргэжил дээшлүүлэхэд МХХТ-ийг өргөн ашиглахад зориулсан иж бүрэн хөрөнгө


оруулалт хийхээр төлөвлөсөн байсан бол Бага, дунд боловсролын салбарт 2015 он хүртэлх хугацаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндсэн чиглэл (БСШУ-ы Сайдын 2006 оны 450 дугаар тушаал, 2006)-д хүний нөөцийн хөгжлийн талаар “Мэдээллийн технологийн хөгжлөөс мэдлэг чадварын хувьд хоцрохгүйгээр өөрийгөө хөгжүүлж, сургалтад мэдээллийн технологийн ололтыг ашиглах чадвартай багшлах боловсон хүчинтэй болох” гэсэн зорилт дэвшүүлсэн байна.

Багшийн МХХТ-ийн чадварыг дээшлүүлэх, олон төрлийн сургалт, үйл ажиллагааг ОУ-ын төсөл, хөтөлбөрийн хүрээнд үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшинд зохион байгуулсаар ирсэн.

2013 онд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжил дээшлүүлэх үндэсний хэмжээний үндсэн сургалтыг танхимын, зайн, **онлайн** сургалтын хосолсон хэлбэрээр зохион байгуулах эрх зүйн орчин баталгаажсан. Тухайлбал, Үндэсний түвшинд үндсэн сургалтын 5 өдрийн 0.5-1 өдрийг МХХТ-ийн сургалтад зориулдаг бөгөөд энэ сургалтад хамрагдсан хүний тоог хөтөлбөр бүрээр ялгаж Зураг 2.5.16-д үзүүлэв.

Үндсэн сургалтын танхимын сургалтын агуулгын 10-30 хувийг МХХТ-ийг хэрэглэх арга зүйн агуулга эзэлдэг. Танхимын сургалт 5 хоног, онлайн сургалт 45 хоног гэсэн бүтэцтэйгээр анх явуулж эхэлсэн бол 2019 оноос үндсэн сургалтыг танхимын 5, онлайн 35 хоногийн сургалтаар зохион байгуулж байна.

Зураг 2.5.16. МХХТ-ийн сургалтад хамрагдсан багш, ажилтны тоо (2013-2018)




Эх сурвалж: БМДИ-ийн 2013-2018 оны тайлан

Үндсэн сургалтад хамрагдаж буй бүх мэргэжлийн багш нарт МХХТ-ийн хэрэглээний анхан шатны сургалт, онлайн сургалтад хэрхэн хамрагдах арга зүйн сургалт явуулахаас гадна зарим мэргэжлийн багш нарт интернетийн орчинд Google бүлгэм үүсгэх, хамтарч ажиллах арга, Youtube хуудсанд бичлэг оруулах, түүнийг бусдад түгээх арга, бичлэг засварлах, бичлэг татах, Онлайн асуулга (google form) бэлтгэх, авах, боловсруулах арга, Геогейбра /geogebra/ сургалтын програм ашиглах арга зүй, Moodle системийг суулгаж, сургалтад ашиглах, нээлттэй эхийн Gimp, inkscape програмыг суулгах, хэрэглэх арга зүй, Musescore хөгжмийн ноот бичих програмыг суулгах, хэрэглэх арга зүй, Movie maker бичлэг засварлах, эвлүүлэг бэлтгэх програмыг суулгах, хэрэглэх арга зүй гэсэн агуулгаар сургалт явуулжээ. Жил бүр багш нарын 20 хүртэлх хувьд МХХТ-ийг сургалт, үйл ажиллагаандаа хэрэглэх арга зүйн сургалтыг тодорхой хэмжээгээр явуулж байгаа ч энэ нь богино хугацаанд бага агуулгаар явагддаг тул нийт багш нарын МХХТ-ийг ашиглах чадварыг дээшлүүлэхэд хангалттай дэмжлэг болж чадахгүй байна. Нөгөө талаар багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 1,5,10 дахь жилдээ ажиллаж буй багш нар хамрагддаг тул 11 ба түүнээс дээш жил ажиллаж буй багш нарын сурах хэрэгцээ бүрэн хангагдаж чадахгүй байна.

Онлайн сургалтыг нээлттэй эхийн MOODLE системийг ашиглан (esurgalt.itpd.mn) явуулдаг. Уг онлайн системд багшийн мэргэжлийн чиглэлийн дагуу курсуудыг БМДИ-ийн арга зүйчид удирдан хөтөлдөг.

Зураг 2.5.17. БМДИ-ийн онлайн сургалтын систем дэх виртуал анги, суралцагчдын тоо (2014-2018)



Эх сурвалж: БМДИ-ийн 2014-2018 оны тайлан

Мөн орон нутгийн Боловсрол, соёл, урлагийн газрууд, багш бэлтгэдэг их дээд сургуулиуд, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжүүд, төрийн бус байгууллагууд үндэсний, орон нутгийн, байгууллагын түвшинд багшийн хөгжлийг дэмжих олон төрлийн сургалтын тодорхой хувийг МХХТ-ийн сургалтууд эзэлж байна.

Тухайлбал, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд сургалт явуулах эрх олгогдсон байгууллагуудын МХХТ-ийн агуулга бүхий хөтөлбөрийг харвал дараах хөтөлбөрүүд батлагдсан байна.

- Идэвхтэй сургалтын аргаар баримтат кино аудио, видео материалыг хичээлд ашиглах нь
- Сургалтын цахим хэрэглэгдэхүүн бэлтгэх арга зүй (БМДИ-ийн захирлын А/46 дугаар тушаал, 2018)
- Бага боловсролын багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтын хөтөлбөр (МХХТ-ийг багшлахуй болон суралцахуйд) (БМДИ-ийн захирлын А/34 дүгээр тушаал, 2017)
- Хан академийг сургалтад ашиглах нь
- Веб хөгжүүлэлт түүнийг сургалтад хэрэглэх арга зүй
- Цахим хичээл бэлтгэх арга зүй (БМДИ-ийн захирлын А/34 дүгээр тушаал, 2017)
- Дизайн технологийн хичээлд зураг зүй дизайны агуулгыг интеграцчилан мэдээллийн технологи ашиглах нь
- Ухаалаг гар утсыг сургалтад ашиглах нь (БМДИ-ийн захирлын А/27 дугаар тушаал, 2015)

Үүнээс гадна Монгол Улсад сургалт явуулах тусгай зөвшөөрөл бүхий сургалтын төвүүдэд багш нар өөрсдийн санаачилгаар сургалтад хамрагдах боломжтой байдаг.

### Цахим нөөц, агуулга

УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он)”-ын 7.14-д “Боловсролд мэдээллийн технологи, нээлттэй агуулга, хөтөлбөрийг хөгжүүлсэн байна” хэмээн заасан байна.

Үндэсний хэмжээнд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, сурагчдад зориулсан боловсролын цахим агуулга, цахим нөөцүүдийг бий болгох чиглэлээр БСШУСЯ, гадаад, дотоодын тодорхой төсөл, хөтөлбөрүүд Боловсролын мэргэжлийн байгууллагууд, их дээд сургуулиуд, төрийн бус байгууллагуудаас зохион байгуулж буй ажлууд тодорхой үр дүнд хүрч багш, сурагчдын хэрэглээнд нэвтрээд байна. Эдгээрээс заримыг дурдвал:

#### Цахим контент (<http://econtent.edu.mn>)


БСШУСЯ 2013 оноос эхлэн АХБ-ны санхүүжилтийн дэмжлэгтэйгээр ЕБС-ийн VIII-XII ангийн математик, байгалийн ухааны хичээлд зориулсан 144 цахим объектыг анх удаа бүтээж, <http://econtent.edu.mn> цахим хуудаст байршуулан олон нийтийн хэрэглээнд шилжүүлсэн. Мөн I-XII ангийн 300 гаруй сурах бичгийг тус цахим хуудаст байршуулжээ (БСШУСЯ, 2013). Ингэснээр багш, сурагчид, эцэг, эхчүүд сурах бичгүүдийг худалдаж авахгүйгээр цахим эх сурвалж ашиглан үзэх, судлах боломж нээлттэй болсон. Мөн Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын байгуулсан хэлэлцээрийн дагуу 2018 оноос хэрэгжиж буй “Мэдээллийн технологид суурилсан анги танхим” төслийн хүрээнд суурь боловсролын математик, байгалийн ухаан, Англи хэлний хичээлээр 483 цахим объект бүтээх ажил эхэлсэн байна.

Багшийн хөгжил портал сайт (<http://teacher.itpd.mn/>)

БМДИ нь багшийн хөгжлийг дэмжихэд МХХТ-ийг ашиглах, хөгжүүлэх ажлын хүрээнд хэд хэдэн цахим портал, системүүдийг хэрэглэж байна. Үүний нэг болох Багшийн хөгжил портал сайтыг 2013 онд АХБ-ны санхүүжилтээр бүтээсэн ба энэ сайтыг байнгын тогтвортой ажиллагааг ханган ажиллаж байна. Тус портал сайтыг цэцэрлэг, ЕБС-ийн багш нар харилцан мэдлэг, мэдээлэл, туршлагаа солилцох, хамтран ажиллахыг дэмжих, мэдлэг боловсролоо дээшлүүлэх, сургалтын цахим хэрэглэгдэхүүнийг онлайнаар нээлттэй түгээх боломжийг бүрдүүлэх зорилготойгоор ажиллуулж байна (БМДИ, 2014).

Тус системд цэцэрлэг, ЕБС-ийн багш нар өөрсдөө хичээлийн агуулга, дасгал даалгавар, үнэлгээний материал, арга зүйн материал, дидактик гэсэн чиглэлээр агуулгуудыг ангилан байршуулдаг бөгөөд эдгээр нөөц, түүнийг хэрэглэгчдийн зарим тоон үзүүлэлтийг зургаар харуулав.

Зураг 2.5.18. Багшийн хөгжил портал сайтын тоон үзүүлэлт (2014-2018)



Эх сурвалж: Багшийн хөгжил портал сайтын статистик

Дээрх зургаас харахад жил бүр бүртгэлтэй хэрэглэгчийн тоо нэмэгдэхийн хэрээр тус порталд байршсан агуулгын тоо нэмэгдэж байна. Энэхүү портал сайтад бүртгэлтэй хэрэглэгч бүр агуулга байршуулах боломжтой ба тэр нь шаардлага хангасан эсэхээс үл хамааран байршиж байгаа тул тогтмол өссөн дүнтэй харагдаж байж болох талтай ч энэ дүр зураг нь сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш ажилтны бэлтгэн байршуулж буй цахим нөөцүүдийн эргэлт өндөр байгааг харуулж байна.

2019 оны байдлаар Математик-3637, Монгол хэл-2674, Англи хэл-2010, Мэдээлэл зүй-1103, Физик -1089 агуулга байршсан байна. Энэ нь тухайн мэргэжлийн багшийн тооноос хамаарч байна гэж үзэж болох юм.

Бага, дунд боловсролын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдийн агуулга тус порталд байршихаас гадна СӨБ-978, хүүхдийн хөгжил-863, боловсролын нээлттэй нөөц-557, сургалтыг дэмжих хэрэглэгдэхүүн-202, цахим хэрэглэгдэхүүн-170, боловсролын байгууллага-132, боловсролын удирдлага-127, тогтвортой хөгжлийн боловсрол-60, тусгай хэрэгцээт боловсрол-58, онлайн зайн сургалт-51 гэх мэт ангилал бүхий агуулгууд байршиж байна (БМДИ, 2019).

Тус систем нь багш нарт харилцан мэдлэг, мэдээлэл, туршлага солилцоход нь дэмжлэг үзүүлж өдөр тутмын зочилдог систем болон хөгжсөн байна.

Онлайн зөвлөмж (<http://bagsh.itpd.mn/>)

БМДИ-ийн санаачилгаар сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд зориулсан онлайн зөвлөмжийн цахим хуудсыг 2016 онд нээн ажиллуулж эхэлсэн байдаг. “Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дэмжих, шинэчилсэн хөтөлбөрөөр сурах бичиггүй зөвхөн суралцахуйн удирдамжтай хичээллэж байгаа багш нарт дэмжлэг үзүүлэх зорилгоор БМДИ-ийн арга зүйчид судлагдахуун бүрээр зөвлөмж бэлтгэн онлайн хэлбэрээр түгээн дэлгэрүүлэх ажлыг эхлүүлсэн. Тус сайтад ахлах ангийн сургалтын 75, суурь боловсролын 8, бага боловсролын 3 агуулга байршсан нь багш нарын талархлыг хүлээсэн ач холбогдолтой ажил болсон хэдий ч одоогоор (2019 оны 01 сарын байдлаар) энэ систем дэх агуулгыг цааш нь үргэлжлүүлж хөгжүүлээгүй байна (БМДИ, 2019)

Хичээлийн сайн технологийн сан (<http://urchadvar.itpd.mn/>)

Цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын дунд жил бүр багшийн ур чадварын улсын уралдаан зохион байгуулагддаг байсныг 2013-2014 оны хичээлийн жилд онлайн хэлбэрт шилжүүлэн “Хичээлийн сайн технологийн сан” болгон хөгжүүлсэн билээ. Хичээлийн сайн технологийн санд видео бичлэг хүлээж авч байршуулах ажлыг 3 жилийн турш өөр, өөр сэдвийн хүрээнд хийсэн (БМДИ, 2019).

*Хүснэгт 2.5.5. Хичээлийн сайн технологийн сан дахь бичлэгийн тоо (2018)*

Сэдэв	Хичээлийн бичлэгийн тоо		
	СӨБ	ЕБС	Нийт
Багшийн ур чадвар (2014)	29	296	325
Хичээлийн сайн технологи (2015)	44	428	472
Сайн хичээл, үйл ажиллагааны улсын зөвлөгөөн (2016)	45	81	126
Сургалтад мэдээлэл харилцааны технологи, боловсролын нээлттэй нөөцийг үр дүнтэй хэрэглэж буй СӨБ ба бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багшийг шалгаруулах үйл ажиллагаа (БМДИ, 2016)	10	52	62
<b>Нийт</b>	<b>128</b>	<b>857</b>	<b>985</b>

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд СӨБ-ын 128 үйл ажиллагаа, ЕБС-ийн 857 хичээлийн сайн технологийн сан бүрдэж багш, сурагчдад нээлттэй хэрэглэгдэж байна.

Ийнхүү нийслэл, орон нутгаас шалгарсан багш нарын хичээлийн видео бичлэгийг тус системээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүргэдэг болсноор багш нарт хичээлийн сайн технологийн чиглэлээр туршлага судлах, харилцан суралцах боломж нэмэгдсэн юм. Мөн хичээлийн ангилал тус бүрээр багш нар өөрийн мэргэжлийн онол, арга зүйн чиглэлээр хэлэлцүүлэгт оролцож мэдлэг, туршлагаа хуваалцах онлайн талбартай болсон.

Даалгаврын сангийн систем (<http://itembank.eec.mn/>)

Боловсролын Үнэлгээний Төвөөс ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн дагуу 2019 оны 03 сарын байдлаар бага (1758), суурь (5702), бүрэн дунд (6595) боловсролын түвшин тус бүрд харгалзах даалгаврын сангаас шүүлт хийж хэрэглэх боломжтой нээлттэй нөөцийг багш, сурагчдын хэрэглээнд нэвтрүүлсэн. Даалгаврын хэлбэр нь сонгох, задгай гэсэн 2 хэлбэртэй, үнэлгээний зорилт нь мэдлэг ойлголт, чадвар, хэрэглээ гэсэн 3 төрөлтэй байна.

Хан Академийн нээлттэй сургалтын систем (<http://mn.khanacademy.org>)

Нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөр (ЗГ-ын 105 дугаар тогтоол, 2014) батлагдаж, “ЕБС-ийн сурагч, багш нарт зориулсан үнэ төлбөргүй, нээлттэй онлайн боловсролын үйлчилгээ”-г боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх зорилт тавин ажилласан байдаг. Тус сангаас Хан академийн нээлттэй сургалтын материалыг Монгол хэлнээ хөрвүүлэх ажлыг зохион байгуулж, 813 видео хичээлийг монгол хэлнээ хөрвүүлэн [mn.khanacademy.mn](http://mn.khanacademy.mn) сайтад байршуулж, нийтийн хүртээл болгоод байгаа бөгөөд “Нээлттэй боловсрол” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, багш, судлаачдын нээлттэй эх ашиглан хичээл сургалтын ажлаа чанаржуулах, туршлагаа түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулж байна. (Нээлттэй Мэдлэг Боловсролын Сан, 2018) Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр багш, сурагчдын хэрэгцээнд зориулсан нээлттэй цахим агуулга, нөөц нэмэгдэж үндэсний хэмжээнд түгээн дэлгэрч байна. Нээлттэй мэдлэг боловсролын сангаас хүн бүрд тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлсэн, дэлхий нийтэд асар хурдтай тархаж, сургалтад өргөнөөр ашиглаж байгаа цахим боловсролын сүлжээ болох Хан академи ([khanacademy.org](http://khanacademy.org))-ийн нээлттэй сургалтыг Монголын боловсролд түгээн дэлгэрүүлэх талаар амжилттай ажиллаж байна (Цэдэвсүрэн, 2018).

Нээлттэй боловсролын вэб <http://one.mn/>

Нээлттэй боловсролын вэб хуудсанд үндэсний бичгийн 40 онлайн хичээл байршуулж, багш нар нээлттэйгээр хичээлээ оруулж, цаашлаад онлайн нээлттэй ухаалаг анги үүсгэж багшлах боломжийг бүрдүүлж ажиллагаанд оруулсан. Энэ веб хуудсанд англи хэл болон мэдээлэл зүйн 140 хичээлийг оруулсан байна.

Шилдэг туршлагын сан <http://www.edub.edu.mn/skill-default>

Нийслэлийн боловсролын газар нь багш нарын шилдэг туршлагын сан бүрдүүлж олон нийтэд нээлттэй түгээж байна. Тус санд дараах төрлөөр цахим агуулгыг үүсгэн байршуулсан байна.

*Хүснэгт 2.5.6. Нийслэлийн багш нарын шилдэг туршлагын сан (2019 оны 01 сарын байдлаар)*

№	Агуулгын төрөл	Тоо
1	Хичээл (I-XII анги)	450
2	Хөтөлбөр (I-XII анги)0	191
3	Илтгэл лекц	113
4	Зөвлөмж	65
5	Туршлага	106
6	Хэрэглэгдэхүүн	68
	Нийт	993

Эдгээр нээлттэй цахим агуулга, нөөцүүд нь нийслэлийн төдийгүй улсын хэмжээнд багш нарын хүртээл болж хэрэглэгдэж байна.

### “Мультимедиа програм хангамжийг сургалтад хэрэглэх, хөгжүүлэх нь” үндэсний уралдаан

Математик, байгалийн ухааны сургуулийн Мэдээлэл зүйн тэнхимээс ЕБС-ийн багш нарыг өөрсдийн үйл ажиллагаандаа болон сургалтын арга зүйдээ МХХТ, мультимедиа програм хангамжийг интеграцчилан хэрэглэж байгаа сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, багшийн хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр “Мультимедиа програм хангамжийг сургалтад хэрэглэх, хөгжүүлэх нь” сэдэвт үндэсний уралдааныг сүүлийн 11 жил амжилттай зохион байгуулж байна. (МУБИС, 2019)

Дээр дурдсан болон бусад олон бүтээлч санаачилгуудын үр дүнд боловсролд зориулсан цахим агуулгууд хангалттай ихээр бүтээгдэн нийтийн хүртээл болж байна.

Цэцэрлэг, ЕБС-ийн багш нарт зориулсан нээлттэй цахим агуулга, нөөц материалууд нь хичээлийн хөтөлбөр, агуулга, арга зүй, үнэлгээний материал, даалгавар, сургалтын хэрэглэгдэхүүн, зөвлөмж, илтгэл, лекц гэсэн агуулга, төрөлтэй байна. Эдгээр материалууд нь бичвэр, хүснэгт, танилцуулга хэлбэртэйгээс гадна цахим объект, мультимедиа агуулгуудаас бүрдэж байна. Харин видео бичлэгүүд нь хичээл, үйл ажиллагааны бичлэг, хичээлийн агуулгын чиглэлээр хийгдэж байршсан байна.

#### 2.5.4 Дүгнэлт, Зөвлөмж

##### Дүгнэлт

1. Монгол Улсын төрөөс МХХТ-ийг боловсролын салбарт нэвтрүүлэх, хэрэгжүүлэх, хөгжүүлэх чиглэлээр сүүлийн 20 жилд тодорхой бодлого, хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх, эрх зүйн зохицуулалтаар хангах замаар онцгой ач холбогдол өгч ажилласан байна. Боловсролын салбарын бодлогын болон эрх зүйн баримт бичгүүдэд боловсролын сургалтын байгууллагын компьютер, техник, тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, технологийн дэд бүтэц бий болгох, багшийн хөгжлийг дэмжих бүх нийтийг мэдээллийн технологийн бичиг үсэгтэн болгох, онлайн, зайны сургалтыг хөгжүүлэх, нээлттэй боловсролын үйлчилгээг бий болгоход үе шаттай арга хэмжээ авч иржээ. Үүний үр дүнд сүүлийн жилүүдэд боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх ажил илүү цогц, нэгдмэл шинжтэй болж, тэр нь салбарын хэмжээний нэгдсэн сүлжээ бүхий мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтэц, програм хангамжийн шийдэлтэй болон хөгжиж байна.  
Гэвч 2015 оноос хойш Боловсролын салбарт МХХТ-ийн талаар баримтлах бие даасан бодлого, хөгжлийн хөтөлбөр батлагдаж гараагүй бөгөөд ийм төрлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх хэрэгцээ үүсээд байна. Нөгөө талаар Боловсролын талаарх хуулинд боловсролын үйлчилгээг онлайн сургалтын хэлбэрээр олгож болох талаар заалт байхгүй байна.
3. БСМС-ийг хөгжүүлж, үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлснээр салбарын хэмжээний өгөгдөл, мэдээллийг нэгтгэж МХХТ-ийг боловсролын салбарын бодлого, төлөвлөгөө, удирдлагын менежментэд үр дүнтэй хэрэглэж их дээд сургууль, цэцэрлэг, ЕБС-ий мэдээлэл, суралцагч, суралцагчдын сурлагын амжилт, хүний нөөцийн хуваарилалт гэх мэт бүхий л мэдээллийг нэгтгэж хэрэглэх боломж бий болжээ.
4. МХХТ-ийн чадварын стандарт боловсруулах ажил зөвхөн ЕБС-ийн багш болон их дээд сургуулийг ЕБС-ийн багш мэргэжлээр төгсөгчдийн хувьд хийгдэж байна.
5. СӨБ-ын байгууллага 2017 оны байдлаар 78.7 хувь интернетэд холбогдож, нэг компьютерт ногдох багшийн тоо 1.2 байна. СӨБ-ын байгууллагад МХХТ-ийн хэрэглээг нэмэгдүүлэхэд тухайн цэцэрлэгийн интернетэд холбох, багшийн компьютер хэрэглэх боломж, нөхцөл байдлыг хангахаас гадна цэцэрлэгүүдийг камержуулах, эцэг эхийн хараа хяналтыг сайжруулахад анхаарч байгаа төдийгүй сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт (Стандарт, хэмжил зүйн газар, 2015) батлагдсанаар сургалтын орчинд техник, тоног төхөөрөмжийг хэрэглэх шаардлага бий болж бага насны хүүхдийн орчин дахь эрүүл ахуйн шаардлагыг хангасан сайн тал бий болжээ.
6. ЕБС-ийн МХХТ-ийн хэрэглээ өсөн нэмэгдэхийн хэрээр дараагийн шатны хэрэгцээ, шаардлага үүсэж байна. 2017 оны байдлаар улсын дунджаар ЕБС-ийн 86.5 хувь нь интернетэд холбогдож нэг компьютерт ногдох сурагчийн тоо 12.5, багшийн тоо 1.6 болсон байна. ЕБС-ийн интернет холболтын хурд, хэрэглэх боломж, нөхцөл байдал, түүнчлэн техник, тоног төхөөрөмжийн



засвар үйлчилгээ, техникийн шаардлага хангасан эсэхийг нарийн тодорхойлж тооцож үзсэн судалгаа тайлан байхгүй байна.

7. Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн хэрэгцээний компьютер, техник хангамжийн хүртээмж нэмэгдсэн төдийгүй багш нарын МХХТ ашиглах суурь чадвар дээшилсэн байна.
8. Хүүхэд хамгааллын тухай хуулинд дахь “Хэвлэл мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгаалал”-ын тухай зүйл нь 6 заалттай бөгөөд энэ хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Өсвөр насныхан төдийгүй бага насны хүүхдийн цахим хэрэглээ өсөн нэмэгдэхийн хирээр тэдний эрүүл, зөв зохистой хэрэглээ, цахим орчин дахь аюулгүй байдал хангах чиглэлээр тууштай бодлого, үйл ажиллагаа шаардагдаж байна.
9. Суралцагчдын МХХТ-ийг ашиглах мэдлэг чадварын түвшинг тогтоох судалгаа явуулан тодорхой хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломж нөхцөл дутмаг байна.
10. Онлайн орчин дахь сургалтын цахим агуулга, нөөц өсөн нэмэгдэж байгаа сайн тал харагдаж байна. БСШУСЯ, боловсролын мэргэжлийн байгууллага, үндэсний хөтөлбөрийн хүрээнд бүтээсэн агуулгын тоо 1,000 гаруй байхад багш нарын өөрсдөө бүтээж байршуулсан агуулгын тоо 27,000-д хүрсэн байна. БСШУСЯ, боловсролын мэргэжлийн байгууллагын зүгээс хүргэж буй цахим хэрэглэгдэхүүн, зөвлөмж, гарын авлага, материалууд нь багш, сурагчдын хэрэгцээнд нийцсэн чанартай агуулга бүтээгдэж байгаа ч бүх судлагдахууны чиглэлээр боловсруулагдсан чанартай агуулгын хүртээмж бага байна. Багш нарын өөрсдөө бүтээсэн цахим агуулга, хэрэглэгдэхүүн, материалууд нь хангалттай их байгаа боловч тэдгээрт тавигдах чанарын шаардлагыг хангуулах чиглэлээр бодлого, менежмент дутагдаж байна.

### **Зөвлөмж**

1. Шинээр боловсруулж буй боловсролын хөгжлийн мастер төлөвлөгөөнд боловсролын салбарт МХХТ-ийг нэвтрүүлэх талаар тусгах, баримтлах бодлого, цогц хөтөлбөрүүдийг тусган хэрэгжүүлэх шаардлагатай. Тухайлбал:
  - Цэцэрлэг, ЕБС, МСҮТ, Их дээд сургууль, НТБ-ын төвүүдэд ямар нийтлэг болон ялгаатай бодлого баримтлахаа ялган тодорхойлж хэрэгжүүлэх
  - Цахим орчин дахь хүүхэд хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлэх
  - Насан туршийн боловсролын төвүүдэд иргэд олон нийтийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн онлайн сургалт явуулах, хөтөлбөрүүд гаргаж дэмжих
  - Боловсролын багц хуулинд боловсролын үйлчилгээг онлайн сургалтын хэлбэрээр олгож болох талаар тусгайлсан заалт оруулах
  - Боловсролын салбарын мэдээллийн системийн модулиудыг бүрэн хөгжүүлж бүх шатны боловсролын сургалтын байгууллагад а) Багш, ажилтны мэдээллийн санг бодитой, зөв үүсгэх, хэрэглэх, б) Сургалтын хөтөлбөрийн сан бий болгох, в) Төгсөгчдийн мэдээллийн санг бүрэн үүсгэж хэрэглэхарга хэмжээг хэрэгжүүлэх
2. Багш, боловсролын байгууллагын ажилтны МХХТ-ийн чадварын стандарт боловсруулж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай байна. Үүнд:
  - Цэцэрлэг, ЕБС МСҮТ, НТБ-ын төв, их, дээд сургуулийн багш, удирдах ажилтнууд, боловсролын мэргэжлийн байгууллагын ажилтнуудын МХХТ-ийг ашиглах чадварын стандарт баталж, мөрдөх
  - Одоо ажиллаж буй багш нарын МХХТ-ийг ашиглах чадварын түвшинг тодорхойлох
  - ЕБС-ийн багш нарын МХХТ-ийн чадварын стандартад тусгагдсан чадвар, шалгууруудын дагуу сургалтын агуулга, арга зүй боловсруулах
3. СӨБ-ын багш нь сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, багш мэргэжлийн хөгжилдөө МХХТ-г хэрэглэх боломж, орчин нөхцөлийг хэрхэн хангах талаар стандартад нийцсэн зохицуулалт хийх
4. ЕБС-ийн интернет холболтын хурд, хэрэглэх боломж, нөхцөл байдлыг сайжруулах
  - Хот, хөдөөд МХХТ-ийн үйлчилгээг жигд нэвтрүүлж иргэдийн мэдээллийн ялгааг багасгах
  - Техник, тоног төхөөрөмжийн техникийн болон технологийн өсөн нэмэгдэж буй шаардлагыг нарийвчлан тодорхойлж тэдгээрийн засвар үйлчилгээ, сэлбэлт, шинэчлэлийн тогтвортой менежментийг бий болгож төлөвшүүлэх. Тухайлбал, цаашид техникийн насжилт, засвар үйлчилгээ, програм хангамжийн зардлыг улсын төсөвт тусгаж хэрэгжүүлдэг болгох.

5. Багшийн хөгжлийг дэмжихэд МХХТ-ийн сургалтын агуулгыг өргөжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх. Тухайлбал,
  - МХХТ-ийг сургалтад хэрэглэх, мультимедиа хэрэглэгдэхүүн боловсруулах, боловсролын нээлттэй нөөцийг олж хэрэглэх, цахим ёс зүй, цахим аюулгүй байдлыг хангах чиглэлээр сургалтын агуулгыг өргөжүүлэх
  - Их дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудаас багш ажилтанд зориулсан МХХТ-ийн сургалтын үйлчилгээг нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх
  - Багшийг ажлын байрандаа тасралтгүй хөгжихөд нь олон сонголтод онлайн сургалтын хөтөлбөрийг бүх багш нарт санал болгодог тогтолцоо бий болгох
6. Цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр хийгдэх шаардлагатай зарим зүйлийг дурдвал
  - Суралцагчид, иргэд олон нийтэд зориулсан боловсролын нээлттэй эх, нөөцүүдийг нэмэгдүүлэх, тэдэнд нээлттэй онлайн сургалтын хөтөлбөрүүд санал болгох
  - Хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдал хангагдаж буй эсэх талаар тандалт, судалгааг тогтмолжуулах, хариу арга хэмжээ авах
  - Суралцагчид, иргэд олон нийтэд зориулсан цахим орчин дахь аюулгүй байдал, кибер халдлагаас сэргийлэх арга, аргачлалын талаарх нээлттэй материалууд, агуулгыг хөгжүүлж түгээх
7. Сурагчдад МХХТ-ийг зүй зохистой хэрэглэх чадвар, дадал эзэмшүүлэх дараах асуудлуудад анхаарал хандуулах. Тухайлбал,
  - Сурагчдын МХХТ-ийн боловсрол, хөгжлийн түвшинг дэлхий нийтийн жишигтэй харьцуулж харах. Тухайлбал Ази, Номхон далайн бүсийн дижитал хүүхдүүд (DKAP Digital Kids Asia Pacific) төсөл хэрэгжиж байгаа ч Монгол Улс одоогоор оролцоогүй байна.
  - Их дээд сургуулийн элсэлтийн ерөнхий шалгалтад МХХТ-ийн хичээлийг нэмж оруулах
  - Суралцагчдад зориулсан боловсролын нээлттэй эх, нөөцүүдийг нэмэгдүүлэх, нээлттэй онлайн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх
8. Багш нар болон хэрэглэгчид өөрсдөө бүтээсэн цахим агуулга, нөөц бүрдүүлэх, чанартай агуулга бүхий боловсролын нээлттэй эх, нээлттэй сангийн эргэлтийг нэмэгдүүлэхийг бодлогоор дэмжих.

## 2.6. Боловсролын салбарын төсөв, санхүү, хөрөнгө оруулалт

### 2.6.1. Урсгал төсөв

Боловсролын салбарын санхүүжилт нь Үндсэн хууль, Боловсролын тухай багц хуулийн холбогдох заалт, Төсвийн тухай хууль, бусад хууль тогтоомжид үндэслэсэн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт суурилсан төсвийн харилцаагаар зохион байгуулагдаж байна.

Боловсролын тухай хуулийн төсөв, санхүүгийн холбогдох заалтад үндэслэн боловсролын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлж байна.

Энэхүү тогтмол болон нормативт зардал нь хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангилал гэсэн үндсэн төрлүүдэд хуваагдаж байгаа бөгөөд эдийн засгийн ангилал нь хувьсах зардал, тогтмол зардал, сургалтын төлбөрийн зээл, нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, хөрөнгө оруулалтын зардал гэсэн үндсэн бүлгүүдэд хуваагддаг.

Төсвийн тухай хууль 2013 оноос эхлэн хэрэгжиж эхэлсэн бөгөөд орон нутгийн боловсролын салбарын байгууллагын төсөв нь салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчаар дамжуулан тусгай зориулалтын шилжүүлэг хэлбэрээр тухайн аймаг, нийслэлийн орон нутгийн төсвийн нэг хэсэг болж орон нутгийн өөрөө удирдах байгууллагаар батлагдаж байна (ЗГ, 2011).

Ингэхдээ Төсвийн ерөнхийлөн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг даргатай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ (ЗГ, 2011) байгуулан хэрэгжүүлж байна.

УИХ-аар батлагдсан Монгол Улсын 2019 оны төсөвт орон нутгийн тусгай зориулалтаар санхүүждэг байгууллагын (төрийн өмчийн хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль) тогтмол зардал нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт батлагдаагүй болно. Орон нутаг дахь байгууллагын өмчийн эзэмшигч нь УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн Засаг дарга тул өмчийг эзэнд нь ойртуулах, ашиглалтыг сайжруулах, төсвийн төвлөрлийг бууруулж, орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор тухайн байгууллагатай холбоотой гарах ашиглалтын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлж байна.

Дээд боловсролын хувьд “Боловсролын тухай хууль”, “Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль”-ийг (УИХ, 2011) тус тус үндэслэн санхүүжилт, хөрөнгө оруулалт хийгддэг. Үндсэн санхүүжилт нь “Оюутны зээл, буцалтгүй тусламж, багш мэргэжлээр суралцаж буй оюутан, магистрантуудад олгох сургалтын төлбөрийн зээл, дэлхийн шилдэг 100 сургуульд суралцагчдын сургалтын төлбөрийн зээл” эзэлж байна. Гэвч 2019 оны төсөвт төрийн өмчит их, дээд сургуулийн тогтмол зардал (түлш халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус) батлагдаагүй болно.


Өнөөгийн шатанд салбарын хөрөнгө оруулалтын гол бодлого нь сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжийг арилгахад чиглэж барилга, их засвар, тоног төхөөрөмжийн төсвийг батлан хэрэгжүүлж байна.

Энэхүү судалгааны тайланд боловсролын салбарын төсөв, санхүүтэй холбоотой асуудлыг дэд салбар тус бүрээр дээр дурдсан хууль, тогтоомжийн хүрээнд хэрхэн зохион байгуулагдаж байгаа болон гүйцэтгэл, санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд цаашид юуг анхаарах талаар товч тусгалаа.

#### Салбарын нийт төсвийн макро үзүүлэлт

Боловсролын салбарын 2008-2018 оны төсвийн ДНБ-д эзлэх хувь дунджаар 5.6%, улсын төсвийн орлогод боловсролын салбарын төсөв дунджаар 15.7% байна. ДНБ-д эзлэх хувь 2012 оноос хойш аажмаар буурсаар байна.

Зураг 2.6.1. Монгол Улсын боловсролын төсвийн үндсэн үзүүлэлтүүд (2008-2018)




Эхсурвалж: Салбарын батлагдсан болон төсвийн гүйцэтгэл


Дэлхийн дунджаар ДНБ-ний боловсролын салбарт зарцуулж буй хувь нь 4.2%-тай байна.

(The World bank, 2016)

Зураг 2.6.2. ДНБ-ний боловсролын салбарт зарцуулж буй дэлхийн дундаж хувь (2016)



Зураг 2.6.3. Боловсролын нийт төсөв: (2008-2018, сая төгрөг)




**Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн шинжилгээ**

Ерөнхий боловсролын төсвийн дундаж судалгаа хийж (Төсвийн гүйцэтгэл, 2017) үзэхэд нийслэлээс бусад байршилтай ЕБС-ийн сурагчдын тоо болон төсвийн хоорондын хамаарал дараах байдалтай байна.


Судалгааны үр дүнгээс харахад хэдийгээр ойролцоо тооны сурагчтай боловч зарим сургуулийн төсөв нь эрс ялгаатай байдал харагдаж байна (Зураг 2.6.4).

Зураг 2.6.4. Сургуулиудын төсөв



Нийслэлийн хувьд судалгааны дүн мөн адил дүр зурагтай байна (Зураг 2.6.5).

Зураг 2.6.5. Нийслэлийн сургуулиудын төсөв



**Салбарт хэрэгжиж буй норм, норматив**

Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу салбарын хэмжээнд норматив зардлаар санхүүжүүлж байгаа бөгөөд 2019 оны төсвийн жилийн байдлаар дараах нормативт зардлыг баримтлан орон нутгийн байгууллагын хүүхдийн цэцэрлэг, ЕБС-ийн хувьсах зардал болон бусад зардлыг санхүүжүүлж байна.

*Хүснэгт 2.6.1. Хувьсах зардлын норматив (2019)*

Зардлын зүйл	Цэцэрлэг	ЕБС	Шийдвэр
Хувьсах зардал (нэг хүүхдэд жилд дунджаар, мянган төгрөг)			Засгийн газрын 2016 оны 242 тоот тогтоол
Сум, аймгийн төв	905.3	437.9	
Нийслэл	807.8	374.0	
Дотуур байр		387.5	
Хоол (өдөрт)	1.650		Засгийн газрын 2012 оны 106 тоот тогтоол
Дотуур байрны хүүхдийн хоол (өдөрт)		2.315	
Үдийн цай (өдөрт) I-V анги		0.600	
Тусгай сургуулийн үдийн хоол (өдөрт)		2.400	Засгийн газрын 2017 оны 162 тоот тогтоол

**Хувьсах зардал**

Боловсролын тухай хуулийн холбогдох заалтын дагуу төрийн болон төрийн бус өмчийн сургалтын байгууллагыг тогтмол болон нормативт зардлаар санхүүжүүлдэг.

ЗГ-аас 2016 онд “хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай” 242 дугаар (Хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай, 2016) тогтоолыг батлан төрийн болон төрийн бус өмчийн хүүхдийн цэцэрлэг, ЕБС, МСҮТ-ийн нормативт зардлыг олгож байна.

Тухайн тогтоолоор нэг сурагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативоор санхүүжих аргачлал, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг тооцох бүрэлдэхүүн, төрийн бус өмчийн ЕБС-ийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг тусад нь баталж өгснөөрөө онцлогтой болж, хувьсах зардлын санхүүжилтийг улам нарийвчлан хуваарилах боломжийг бүрдүүлсэн.

Хувьсах зардлын бүрэлдэхүүнд дараах эдийн засгийн ангилалд хамаарах зардал багтаж байна (Хүснэгт 2.6.2).

*Хүснэгт 2.6.2. Хувьсах зардлын бүрэлдэхүүн (2019)*

№	Үзүүлэлт
1	Багшийн албан тушаалын цалин болон нэмэгдэл цалин, хүүхдийн цэцэрлэг, дотуур байрны багш, ажилтны албан тушаалын цалин болон зарим нэмэгдэл (Зарим нэмэгдэл гэдэгт: цалин, хөдөө орон нутагт ажилласан, ур чадварын, анги кабинет болон заах аргын нэгдэл хариуцсан нэмэгдлийг ойлгоно)
2	Багшийн үндсэн болон нэмэгдэл цалинд ногдох ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл
3	Бараа үйлчилгээний бусад хувьсах зардал
	1. Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх
	2. Бичиг хэрэг
	3. Ном хэвлэл
	4. Шуудан холбоо, интернетийн төлбөр
	5. Дотоод албан томилолт
	6. Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс
	7. Нормын хувцас, зөөлөн эдлэл
	8. Эм, бэлдмэл
	9. Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал
	10. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж
	11. Бараа үйлчилгээний бусад зардал

**Цалин хөлсний тогтолцоо**

Монгол Улсын төрийн нийт албан хаагчдын 40 гаруй хувийг зөвхөн төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ЕБС-д ажилладаг албан хаагчид эзэлж байгаа бөгөөд өнөөдөртэд нийт хүн амын 30 гаруй хувийг эзэлж байгаа 2-17 насны хүүхэд, өсвөр үеийнхэнд өдөр бүр боловсролын үйлчилгээ үзүүлж байна. Төрийн албанд ийм хувь (жин) эзэлж байгаа төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн асуудлыг шаардлагатай түвшинд шийдвэрлэж байх нь төрийн албан хаагчдын ажил, амьдралын баталгааг төдийгүй, нийт иргэдэд, ялангуяа Монгол Улсын үнэт баялаг болсон хүүхэд, өсвөр үеийнхний чадавхыг хөгжүүлэхэд төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, үр өгөөжийг тодорхойлох нийтлэг ач холбогдолтой юм.

Өнөөгийн байдлаар багш ажилтнуудын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг зохицуулсан 30 гаруй тогтоол, шийдвэр үйлчилж байна.

### Үндсэн цалин болон нэмэгдлийн харьцаа

Төрийн үйлчилгээний албан хаагчид нь хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг тул Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйл болон Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1-д заасан болзол, нөхцөлийг хангасан тохиолдолд нэмэгдэл хөлс авах эрхтэй.

“Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох тухай” Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 3 дугаар зүйлд тэдэнд олгох нэмэгдэл нь төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын сарын цалин, нэмэгдэл хөлсний дүнгийн 40 хувиас хэтрэхгүй байхаар (энэхүү заалтад Засгийн газрын 1996 оны 90 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан) хязгаарлалт тогтоосон нь өнөөдөр ч хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1, 50.2; 52 дугаар зүйлийн 52.1; 53 дугаар зүйлийн 53.1-д заасан болон Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр нэмэгдэл хөлс авдаг. Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9-д заасны дагуу нэмэгдэл, нэмэгдэл хөлсний доод хэмжээг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн ЗГ тогтоож байна. Боловсролын салбарын хувьд “Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2007 оны 219 дүгээр тогтоолыг мөрдөж байна.

1997 оны батлагдсан төсвийн гүйцэтгэлд судалгаа хийж үзэхэд судалгаанд хамрагдсан нийт багш ажилтны ажил хавсарсан нэмэгдлийг хассан тоогоор 50197 багш ажилтныг нэмэгдэл хөлсийг дээрх хуулийн дагуу тооцож үзэхэд 7971 багш, ажилтны 9 сард олгосон нийт нэмэгдэл хөлсний хэмжээ үндсэн цалингийн 41 хувь түүнээс дээш хувьтай тэнцэж байна. Үүнд илүү цагийн нэмэгдэл хөлс хамгийн их хувийг эзэлж байгаа бөгөөд илүү цагийн нэмэгдлийг хасаж тооцсоноор 1302 багш, ажилтны нэмэгдлийн хэмжээ мөн л дээрх хуулийн заалтыг зөрчиж олгогдсон байна. Үүнд сургуулийн 1045 багш ажилтан (үүнээс 719 нь хөдөө орон нутгийн), цэцэрлэгийн 257 (үүнээс хөдөө орон нутагт 216) багш ажилтан байна.

Үүнд захиргааны албан тушаалтан 515 буюу 40 хувийг, 646 буюу 51 хувийг, үлдсэн 141 буюу 9 хувийг үйлчилгээний ажилтнууд эзэлж байна.

### Цалин хөлсний өсөлт

Монгол Улсын ЗГ-аас төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 2008 оноос үе шаттайгаар нэмэгдүүлж иржээ (Хүснэгт 2.6.3).

Хүснэгт 2.6.3. Цалин, хөлсний бүтэц


Он	Байгууллага	Дундаж цалин	Мэргэлийн эрэг	Ур чөлөө	Анги удирдах	Заах арга	Кабинет	Ур дүн	Орон нутгийн нэмэгдэл	Дундаж нэмэгдэл	Сарын цалин хөлс	Өмнөх онтой харьцуулсан байдал
2018 оны 9-р сар	Бага ангийн багш	618.0	46.4	46.4	30.9	15.5	15.5	38.6	30.9	224.0	842.0	1.123
	Дунд, ахлах ангийн багш	594.4	44.6	44.6	29.7	14.9	14.9	37.1	29.7	215.5	809.9	1.080
	Сургууль өмнөх боловсрол	618.0	46.4	38.6	-	6.2	-	38.6	30.9	160.7	778.7	1.123
2014-2018.09.01	ЕБС	550.4	41.3	41.3	27.5	13.8	13.8	34.4	27.5	199.5	749.9	1.150
	СӨБ	550.4	41.3	34.4	-	5.5	-	34.4	27.5	143.1	693.5	1.150
2013	ЕБС	478.6	35.9	35.9	23.9	12.0	12.0	29.9	23.9	173.5	652.1	1.000
	СӨБ	478.6	35.9	29.9	-	4.8	-	29.9	23.9	124.4	603.0	1.000
2012	ЕБС	478.6	35.9	35.9	23.9	12.0	12.0	29.9	23.9	173.5	652.1	1.548
	СӨБ	478.6	35.9	29.9	-	4.8	-	29.9	23.9	124.4	603.0	1.548
2011	ЕБС	309.1	23.2	23.2	15.5	7.7	7.7	19.3	15.5	112.0	421.1	1.000
	СӨБ	309.1	23.2	19.3	-	3.1	-	19.3	15.5	80.4	389.5	1.000
2010	ЕБС	309.1	23.2	23.2	15.5	7.7	7.7	19.3	15.5	112.0	421.1	1.300
	СӨБ	309.1	23.2	19.3	-	3.1	-	19.3	15.5	80.4	389.5	1.300
2009	ЕБС	237.8	17.8	17.8	11.9	5.9	5.9	14.9	11.9	86.2	324.0	1.000
	СӨБ	237.8	17.8	14.9	-	2.4	-	14.9	11.9	61.8	299.6	1.000
2008	ЕБС	237.8	17.8	17.8	11.9	5.9	5.9	14.9	11.9	86.2	324.0	
	СӨБ	237.8	17.8	14.9	-	2.4	-	14.9	11.9	61.8	299.6	

Засгийн газрын 2019 оны 24-р тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэн баталсан байна. Тогтоол батлагдсанаар төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхдээ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Багш нарын цалингийн ангилал, зэрэглэлийг өөрчилж 20-оос доошгүй хувиар нэмэгдүүлсэн
- Албан хаагчдын цалинг 2019 оны 01-р сарын 01-нээс 8% нэмэгдүүлсэн
- Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг тогтоохдоо доод жишгийг баталдаг байсан бол тухайн шийдвэрээр цалингийн сүлжээг баталсан.

Тус арга хэмжээнд салбарын батлагдсан төсвийн хүрээнд нийт 73177 албан хаагч хамрагджээ.

Зураг 2.6.6. Салбарт ажиллагчдын тоо (2019)



Салбарын 2019 оны төсөвт нийт цалин хөлс болон НДШ-д 865.8 тэрбум төгрөг батлагдсан байна. Ангилал зэрэглэл нь нэмэгдсэн албан хаагчдад цэцэрлэгийн эрхлэгч, цэцэрлэгийн багш, дунд, ахлах ангийн багш хамрагдаж байна.

Ингэснээр цэцэрлэгийн багшийн (8224 багш) цалингийн ангилал, зэрэглэл нэг шатаар нэмэгдэн дундаж үндсэн цалин 780,280 төгрөг болж, 2014 онтой харьцуулахад 229,911.0 төгрөгөөр (41.8%), 2018 оны 9 сартай харьцуулахад 162,272 төгрөгөөр (26.3%) нэмэгджээ.

Бага ангийн багшийн (9200 багш) дундаж үндсэн цалин 713,468 төгрөг болж 2014 онтой харьцуулахад 163,099.0 төгрөгөөр (29.6%), 2018 оны 9 сартай харьцуулахад 95,460 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Дунд, ахлах ангийн багш (19707 багш), сургуулийн нийгмийн ажилтан (760 ажилтан), цэцэрлэгийн арга зүйчийн (562 арга зүйч) цалингийн ангилал, зэрэглэл нэг шатаар нэмэгдэж дундаж үндсэн цалин 713,468 төгрөг болж 2014 онтой харьцуулахад 163,099.0 төгрөгөөр (29.6%), 2018 оны 9 сартай харьцуулахад 119,069 төгрөгөөр (20.0%) тус тус нэмэгджээ.

Дотуур байрны багшийн (585 багш) дундаж үндсэн цалин 669,861 төгрөг болж 2014 онтой харьцуулахад 159,238 төгрөгөөр (31.2%), 2018 оны 9 сартай харьцуулахад 118,388 төгрөгөөр (21.5%) тус тус нэмэгдсэн байна.

Цэцэрлэгийн туслах багшийн (4720 багш) дундаж үндсэн цалин 558,387 төгрөг болж 2014 онтой харьцуулахад 131,027 төгрөгөөр (30.7%), 2018 оны 9 сартай харьцуулахад 96,838 төгрөгөөр (21.0%) тус тус нэмэгдсэн ажээ.

Энэ арга хэмжээний үр дүнд багш нарын дундаж үндсэн цалин 20%-26.3%-иар нэмэгдсэн байна.

#### Бусад албан хаагчдын тухайд

Төрийн захиргаа (499 мэргэжилтэн), биеийн тамир (41 мэргэжилтэн), төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн (23788 албан хаагч) дундаж үндсэн цалин 2018 онтой харьцуулахад 8%-иар нэмэгдлээ.

Үүнээс төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын дундаж үндсэн цалин 481,021 болж дунджаар 35,631 төгрөгөөр нэмэгдсэн байна.



### Ерөнхий боловсролын суралцагчдын үдийн цайны зардал

ЕБС-ийн бага ангид "Үдийн цай" хөтөлбөрийг 2006 оноос хэрэгжүүлж байгаа бөгөөд өмчийн хэлбэр үл харгалзан бага ангийн суралцагчдад өдрийн 600 төгрөгөөр үдийн цайны үйлчилгээг үзүүлж байна. 2017-2018 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус байгууллагын ерөнхий боловсролын сургуулийн бүх ангийн сурагчдын үдийн цайнд хийт 32 тэрбум төгрөг зарцуулжээ (Хүснэгт 2.6.4).

*Хүснэгт 2.6.4. Үдийн цай хөтөлбөрийн зардал (2017/18 оны хичээлийн жил)*

	ЕБС	I-V ангийн сурагчдын тоо	Үдийн цайны зардалд
<b>Бүгд</b>	<b>798</b>	<b>309.355</b>	<b>32.0 тэрбум төгрөг зарцуулж байна.</b>
Төрийн өмч	652	291.334	
Төрийн бус өмч	146	18.021	

Нийслэлийн төрийн болон төрийн бус өмчийн нийт 238 ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 139,730 сурагчид үдийн цайны үйлчилгээнд хамрагдаж байгаа бөгөөд нийт 14.4 тэрбум төгрөгийг улсын төсвөөс зарцуулж байна.

Үдийн цай хөтөлбөрийн нэг сурагчид олгох зардлын хэмжээ 2006 оноос хойш дараах байдлаар шинэчлэгдсэн. Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолоор нэг хүүхдийн өдрийн цайны зардлыг 600 төгрөгөөр тогтоосон нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

*Хүснэгт 2.6.5. Үдийн цайны норматив зардлын өөрчлөлт (2006/07-2017/18 оны хичээлийн жил)*

Хичээлийн жил	Нэг хүүхдэд ногдох мөнгөн дүн	Засгийн газрын тогтоол	Хамрагдаж буй бага ангийн сурагчид
2006-2007	300 төгрөг	ЗГ-ын 2006 оны 194 дүгээр тогтоол	I-II анги
2007-2008			
2008-2009	400 төгрөг	ЗГ-ын 2008 оны 45 дугаар тогтоол	I-V анги
2009-2010			
2010-2011			
2011-2012			
2012-2013	400/600	ЗГ-ын 2012 оны 106 дугаар тогтоолоор 2013.1.1-с 600 төгрөг	
2013-2014	600 төгрөг		
2014-2015			
2015-2016			
2016-2017			
2017-2018			

Үдийн цай хөтөлбөрт 15-20 нэр төрлийн бүтээгдэхүүн (хоол, шүүс, боов) түгээмэл ашиглаж байна.

### Салбарын харьяа орон нутгийн байгууллагын тогтмол зардал

Орон нутаг дахь байгууллагын өмчийн эзэмшигч нь УИХ-ын 1999 оны 29 дүгээр тогтоолоор орон нутгийн Засаг дарга тул өмчийг эзэнд нь ойртуулах, ашиглалтыг сайжруулах, төсвийн төвлөрлийг бууруулж орон нутгийн төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор тухайн байгууллагатай холбоотой гарах ашиглалтын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна.

Ашиглалтын зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх болсон нь дараах шалтгаантай. Үүнд:

1. Төсвийн тухай хуулийн орон нутгийн харьяа байгууллагын төсөв тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих хууль мөрдөгдөж байгаа хэдий ч Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.4 дүгээр заалтын дагуу тусгай зориулалтын шилжүүлгийн зардал нь орон нутгийн төсвийн нэг хэсэг болж батлагдаж байгаатай
2. Орон нутагт төсвийн жилийн дундуур тогтмол зардлын үнэ нэмэгддэг нь төсөвт хүндрэл учруулж өр үүсгэдэгтэй
3. Салбарын 2013 оны санхүүгийн тайлант жилээс эхлэн орон нутгийн байгууллагын санхүүгийн байдлын тайлан орон нутгийн нэгдсэн тайланд тусгагдаж төсвийн гүйцэтгэлийг орон нутаг хариуцдаг болсонтой
4. Төсвийн төвлөрлийг бууруулах зэрэгтэй тус тус холбон үзэж болно.

Иймээс салбарын орон нутаг дахь байгууллагын ашиглалтын зардлыг (цэвэр, бохир ус, түлш халаалт, цахилгааны зардал, байрын түрээсийн зардал, урсгал засвар) орон нутгийн төсвөөс санхүүжүүлснээр санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлж, улсын төсвийн алдагдлыг бууруулах боломж байна гэж харж байна. Харин Төсвийн Ерөнхийлөн захирагч нь хувьсах зардал болон бусад арга хэмжээний зардлаараа дамжуулан салбарын бодлогоо орон нутагт хэрэгжүүлэх боломжтой.

Өнөөгийн хуулийн үйлчлэлийн дагуу салбарын харьяа орон нутгийн байгууллагын байр ашиглалттай холбоотой зардал Төсвийн Ерөнхийлөн захирагчийн төсөвт (улсын төсөвт хамрагддаг) батлагддаг бөгөөд хуульд өөрчлөлт орсноор тухайн зардал улсын төсвөөс орон нутгийн төсөвт шилжинэ. Ингэснээр улсын болон орон нутгийн төсөвт ямар нэгэн ачаалал үүсэхгүй болно.

Хуульд өөрчлөлт оруулснаар үүсэх үр нөлөө нь:

- Төсвийн жилийн дундуур тогтмол зардлын үнэ нэмэгддэг байдал дахин үүсэхгүй
- Байр ашиглалтын зардлыг орон нутаг хариуцсанаар өмч өөрөө эзэндээ ойртож, өмчийн ашиглалтын хугацаа нэмэгдэнэ
- Төсвийн төвлөрлийг бууруулна
- Улсын төсөвт хуваарилагддаг байсан ашиглалтын зардлын төсөв орон нутагт шилжих тул Улсын нийт төсөвт нөлөөлөхгүй

Англи болон Австралийн боловсролын салбарын байгууллагуудын санхүүжилт нь 2 эх үүсвэртэй байдаг. Тухайлбал, а) Орон нутгийн санхүүжилт, Тухайн байгууллагын байр ашиглалттай холбоотой зардал, орон нутгийн төсвөөс болон иргэдээс олгох хандив, зарим хөрөнгө оруулалт, б) хувьсах зардлын санхүүжилт, тэтгэмж урамшуулал, шинэ хөрөнгө оруулалт зэрэг болно.

### Төрийн өмчит их, дээд сургуулийн санхүүжилт

Боловсролын тухай хуулийн холбогдох заалтын (Боловсролын тухай хууль) дагуу 2019 оны төсвийн жил хүртэл төрийн өмчийн их, дээд сургуулийн тогтмол зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж ирсэн байна (Хүснэгт 2.6.6).

Хүснэгт 2.6.6. Тогтмол зардлын судалгаа: мянган, төгрөг (2016-2018)

№	Сургуулийн нэр	2016		2017		2018	
		Олгосон санхүүжилт	Өглөг/Авлага	Олгосон санхүүжилт	Өглөг/Авлага	Олгосон санхүүжилт	Өглөг/Авлага
1	МУИС	1,100,000.00	866,263.10	882,983.40	1,082,752.59	350,000.00	1,799,421.59
2	МУБИС	870,000.00	1,469,677.10	1,367,413.40	1,843,196.73	412,749.36	3,045,441.71
3	ХААИС	580,000.00	719,639.60	1,128,241.00	470,642.00	200,000.00	1,213,158.00
4	ШУТИС	1,375,647.90	1,204,983.40	966,363.90	1,597,833.87	400,000.00	2,639,119.06
5	Соёл урлагийн их сургууль	218,335.00	(12,856.30)	115,000.00	76,681.10	90,000.00	223,543.73
6	АШУҮИС	992,786.80	988,878.20	1,212,554.50	943,691.53	300,000.00	1,469,949.85
7	Дорнод их сургууль	112,519.70	(13,230.60)	-	67,601.92	50,000.00	109,648.65
8	Ховд их сургууль	643,404.00	731,417.00	874,797.30	490,834.84	200,000.00	940,171.61
9	Дархан-Уул ХААИС	170,093.40	(17,957.70)	-	80,099.40	25,631.80	96,371.80
10	Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль			43,580.40	(11,143.58)	40,000.00	92,990.40
11	Улаанбаатарын их сургууль			67,447.10	(2,928.08)	40,000.00	11,085.70
	<b>Нийт дүн</b>	<b>6,062,786.80</b>	<b>5,936,813.80</b>	<b>6,658,381.00</b>	<b>6,639,262.31</b>	<b>2,108,381.16</b>	<b>11,640,902.08</b>

Боловсролын тухай хуульд өөрчлөлт орсноор тухайн байгууллагад тогтмол зардлыг санхүүжүүлэх хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй болжээ.

### Боловсролын зээлийн сан

Тус сан нь “Сургалтын төрийн сан” нэртэйгээр 1993 онд байгуулагдсан ба 2016 оны Засгийн газрын 111-р тогтоолоор “Боловсролын зээлийн сан” болж өөрчлөгдөн зохион байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус сан нь үүсгэн байгуулагдсанаасаа хойш төрийн бодлого хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын дотоодын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламжийн болон бусад төрийн үйлчилгээг үзүүлж ажилладаг.

Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 1997-2018 онд зарим улсын дээд боловсролын сургалтын байгууллагад Монгол Улсаас хамгийн олон оюутан суралцсан байна. Жич: АНУ-ын Колорадогийн их сургууль (1997 оноос эхлэн 134оюутны сургалтын төлбөрт нийт 5,4 сая ам.доллар), Калифорнийн ИС (1997 оноос эхлэн 112оюутны сургалтын төлбөрт нийт 5,7 сая ам.доллар), Массачусетсийн их сургууль (2012 оноос эхлэн 32 оюутны сургалтын төлбөрт нийт 5,2 сая ам.доллар), Австрали улс (1997 оноос эхлэн 221 оюутны сургалтын төлбөрт нийт 7,1 сая ам.доллар)гэх мэтчилэн өндөр хөгжилтэй оронд суралцагчдын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах тухай” 78 тоот зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны “Журам шинэчлэн батлах, журамд өөрчлөлт оруулах тухай” 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд оюутан суралцуулах журам”, Монгол Улсын ЗГ-ын 2014 оны “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” 71 дүгээр тогтоол, Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2013 оны “Журам батлах тухай” А/316 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Дэлхийн шилдэг их сургуульд суралцуулах оюутныг сонгон шалгаруулах журам” зэрэг эрх зүйн актуудын хүрээнд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагын бакалаврын хөтөлбөрт 2013 оноос 302 оюутан суралцуулахаар шийдвэр гарснаас нийт 280 оюутандсанхүүжилт олгосон ба нэг жилд дунджаар тэдэнд 14.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон байна. Бакалаврын түвшний хөтөлбөрт суралцагчдын судалгааг суралцсан улсаар ангилсан байдлыг Хүснэгт 2.6.7-д үзүүлэв.

*Хүснэгт 2.6.7. Тэтгэлэг авсан гадаадын их, дээд сургуулийн бакалаврын түвшний сургалтад суралцагчдын тоо: Улс орноор (2013-2018)*

№	Улс	Нийт суралцагчдын тоо
1	АНУ	182
2	ИБУИНВУ	26
3	Австрали	28
4	Япон	2
5	Франц	1
6	Канад	37
7	Швейцар	3
8	БНХАУ	1
Нийт		280

2018 онд 198 суралцагчийн сургалтын төлбөрт 14.5 тэрбум төгрөг төлөвлөснөөс одоогийн байдлаар 176 суралцагчид 13.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож, 48 (давхардсан тоогоор) оюутны санхүүжилт хүлээгдэж байна. Ам долларын ханшийн өсөлт, сургалтын төлбөрийн нэмэгдсэн байдал, 2017 оны төсөв хүрэлцээгүйгээс тус онд авах ёстой байсан 24 суралцагчийн төлбөрийг 2018 онд санхүүжүүлсэн зэрэг шалтгаанаас 2018 оны батлагдсан төсөв болох 14.5 тэрбум төгрөг нь 198 суралцагчийн бүтэн жилийн төлбөрийг бүрэн төлөхөд хүрэлцэхгүй байгаа тул сургуулиудаас улирал тус бүрээр нь нэхэмжлэх авч санхүүжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

## 2.6.2. Хөрөнгө оруулалт

### Салбарын хөрөнгө оруулалт


Боловсролын салбарын хөрөнгө оруулалт 2019 онд 488.9 тэрбум төгрөгөөр батлагдаж, 2015 оныхтой харьцуулахад 5 дахин нэмэгдсэн байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын нийт хөрөнгө оруулалтын төсөвт боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төсвийн эзлэх хувь дунджаар 63.9 хувьтай байна.

*Хүснэгт 2.6.8. Боловсролын салбарын хөрөнгө оруулалт (2015-2019)*


Үзүүлэлт	2015	2016	2017	2018	2019
Нийт салбарын хөрөнгө оруулалт(зээл багтсан, сая.төгрөг)	127,905.5	179,305.9	178,475.0	371,082.7	616,453.7
Боловсролын салбарын хөрөнгө оруулалт (сая.төгрөг)	96,701.6	115,107.1	77,197.5	211,642.6	488,997.2
Боловсролын салбарын хөрөнгө оруулалт (хувиар)	75.6%	64.2%	43.3%	57.0%	79.3%

Зураг 2.6.7. Боловсролын салбарын хөрөнгө оруулалт (2010-2018, сая.төгрөг)



Боловсролын салбарын хэмжээнд 2010-2016 онд хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тоо болон төсөвт өртгөөс харахад хүүхдийн цэцэрлэг, сургуульд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр бусад хөрөнгө оруулалтаас өндөр, харин их дээд сургуульд оруулсан хөрөнгө оруулалт харьцангуй маш бага байна (Хүснэгт 2.6.8).

Зураг 2.6.8. Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тоо ба зардлын хэмжээ (2010-2018, сая төгрөг)




Боловсролын салбарт 2010-2018 онд нийт 536 төсөл арга хэмжээ хэрэгжиж дуусгасан ба хүчин чадал 103453-аар нэмэгдэж, нийт 657.5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

Үүнээс хэрэгжсэн төслийн тоогоор хүүхдийн цэцэрлэг (267) илүү олон байгаа боловч, ашиглалтад орсон хүчин чадалаар авч үзвэл 142 сургууль ашиглалтад орж хүчин чадал 62838-аар нэмэгдэж, нийт 327.2 тэрбум төгрөг зарцуулжээ (Хүснэгт 2.6.9).

Хүснэгт 2.6.9. Хөрөнгө оруулалт: Ангилалаар (2010-2018)

Хөрөнгө оруулалтын ангилал	Тоо	Эзлэх хувь	Хүчин чадал	Дүн (сая.төгрөг)
Сургууль	142	26.5%	62838	327,203.0
Дотуур байр	56	10.4%	5875	52,860.2
Спорт заал	53	9.9%	-	34,197.0
Цэцэрлэг	267	49.8%	27600	197,811.8
Цэцэрлэг, сургуулийн цогцолбор	8	1.5%	2240	20,000.0
Их дээд	10	1.9%	4900	25,432.7
Нийт боловсролын салбар	536		103453	657,504.7

Зураг 2.6.9. Сургалтын байгууллагуудын тавилга, тоног төхөөрөмжид 2018 оны улсын төсвөөс оруулсан хөрөнгө оруулалт: Аймаг, нийслэлээр



### Сургалтын орчны талаарх шинэ хандлага

Сургалтын орчны талаарх ойлголт ихээхэн өөрчлөгдөж байна. Урьдын “сургалтын бүх загварт тохирсон нэг төрлийн хэмжээ, загвар” гэдэг ойлголтоос суралцах, багшлах таатай боломжийг дэмжсэн шинэ загварын талаарх ойлголт руу шилжиж байна. Энэ шинэ хандлага нь сургуулийн орчныг хүнд таатай байхаар өөрчлөх буюу “Хүнд хамгийн их таатай байхаар ямар загвар гаргах вэ” гэдэг асуултад хариулахад төвлөрдөг. Тухайлбал, бид өмнө нь ангиар хичээллэх танхимын тоог хамгийн олон байлгахыг л үр ашигтай төлөвлөлт, үр ашигтай зураг төсөл гэж үздэг байсан бол сургалтын үйл ажиллагаа заавал ангид ширээний ард сууснаар амжилттай явагддаг гэж үзэх боломжгүй болсон. Сургуулийн эргэн тойрны бүх зүйл сургалтад, хүүхдийн хөгжилд хувь нэмэр оруулдаг. Сургуулийн гаднах орчин, зам, талбай ч мөн адил хүүхдийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг.

Сургалтын орчин хэрхэн хүүхдийн сурах үйл явц болон багшийн хичээл заах үйл ажиллагаанд нөлөөлж болох талаар олон судалгаа хийгддэг болсон бөгөөд энэ төрлийн судалгаагаар олж илрүүлсэн үр дүнг нэгтгэсэн тойм судалгаанд (University of Newcastle, 2005) “суралцахуйн орчин нь багшлах, суралцахад аль алинд нь ихээхэн нөлөөлдөг” гэж дүгнэжээ. Хамгийн гол нь нэг зүйлийг нэг л анги танхимд, нэг л аргаар заагаад байх нь хүүхдийн хөгжилд таагүй нөлөөлдөг байж болох талаар олонтоо бичдэг болсон байна. Хүний тархинд “суралцахуй” явагдаж байгааг шууд мэдэх арга одоогоор байхгүй учраас энэ асуудлыг нотлох боломж бага, гэхдээ хүүхдүүд “маргааш аялалаар явна гэхэд ямар их догдолж байгаа нь мэдрэгддэг шүү дээ” хэмээн багш нар бичжээ.

Бидний уламжлалт нэг төрлийн үйлчилгээ, нэг төрлийн ширээний засалт бүхий анги танхим цаашид тохиромжтой сонголт хэвээрээ үргэлжлээд байж чадахааргүй болсон байна. Хичээл бүрийн онцлогоос хамаарч сургалтын орчин өөр өөр байх шаардлагатай нь ойлгомжтой. Тухайлбал, бид урлаг, загвар, дизайны боловсрол муу олгодог. Энэ нь хүний хөгжлийн хамгийн чухал чиглэлүүд болох гоо зүйн мэдрэмж, бүтээлч байх, шинэ санаа гаргах, сэтгэн бодох, төсөөлөх чадвар хөгжихөд муугаар нөлөөлж байна. Манай сургуулиудад шаардлага хангасан хангалттай тоноглогдсон урлагийн (арт) өрөө танхим, хэрэгсэл, тоног төхөөрөмж байдаггүй. Өнөөг хүртэл бид задгай ангид хичээл хийх нь хүүхдүүдэд таатай байж болох тухай ярих боломж багатай байгаа. Яагаад гэвэл өнөөгийн сургуулиудын загвар нь үүнийг амьдралд хэрэгжүүлэх боломж багш нарт олгохгүй, мөн дуу чимээ дамжуулалтыг зохицуулаагүй гэх мэт олон шалтгаан байдаг.

Багшлах, суралцах загвар өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор уламжлалт сургалтын орчныг нэмж тохижуулан өндөр хурдны интернет орчин бүхий сууж, босоход амар орон зай, тухалж суух боломжтой орчин, хамтаараа тойрч суугаад ярилцаж суралцах орчин, туршилт хийх багаж хэрэгсэл бүхий өрөө танхимтай болгох шийдлүүдийг ашиглан орчин үеийн суралцагчдын хэрэгцээг хангахад нь сургууль багшид туслах ёстойг (Kuuskorpi, Marko, 2012) чухалчлан тэмдэглэсэн байна.

Хүснэгт 2.6.10. Сургалт явуулах орон зайн гол шаардлагууд

Төрөл	Сурагчдын тоо	Ажиллах арга барил	Хийгдэх үйл ажиллагааны төрөл	Ажлын орчны төрөл
Рефлексив суралцах орчин	1-2	Зөвхөн тухайн сурагчтай	Бие даасан үйл ажиллагаа	Бие даан ажиллах орчин
Бүтээлч суралцах орчин	3-6	Бүлгээр	Багаар хийж гүйцэтгэх үйл ажиллагаа	Уян хатан орчин
Хамтран суралцах орчин	20-40	Ангиар эсвэл илүү том бүлгээр	Олон нийттэй харилцаж сурах, өөрийгөө илэрхийлж сурах үйл ажиллагаа	Уян хатан, өөрчилж болохоор орчин

Эх сурвалж: Финландын Боловсролын яам (2014)

Эндээс харахад анги танхим, тоног төхөөрөмжтэйгөө нийлээд нэгэн зайлшгүй бүхэл цогц объект болж, сургалтын тусгай зориулалтаар ашиглагдана гэдэг ойлголтоос бид хол байдаг. Сургууль барина гэхээр зориулалтын тоног төхөөрөмжийг бүгдийг суурилуулан бэлдээд шууд ороод хичээл хийхэд бэлэн байх тухай ойлголт боловч бид барилгыг нь нэг тусдаа, доторх тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг тусдаа, сургуулийг ажиллуулахад гарах урсгал зардлыг тусдаа төлөвлөдөг. Энэхүү хоцрогдсон ойлголтоос болоод математик болон шинжлэх ухааны хичээлүүдийг хүртэл самбар дээр биш “ширээн дээр байрлуулсан хэрэгсэл дээр”, эсвэл материал ашиглан өөрөө туршин бүтээх замаар (context based), мөн зориудаар бүрдүүлсэн хиймэл орчинд заах (simulation), суралцах боломж бидэнд хязгаарлагдмал хэвээр байна.

Финлянд улсын сүүлийн үед барьсан шинэ сургуулийн барилгууд мэргэжлийн хүмүүсийн анхаарлыг ихээхэн татаж байна. Тэд сургалтын орчны талаар үзэл баримтлалаа “сургууль бол хүүхдүүд өдөр тутмын хичээлээ хийхээр л ирдэг газар биш харин тэднийг өдөөдөг, суралцахад хүргэдэг, сэтгэлийг нь баясгадаг, тааламжтай байлгадаг, гоо сайхны мэдрэмжийг нь төрүүлдэг газар байх ёстой” гэж тодорхойлжээ (Finnish National Board of Education, 2014).

Зураг 2.6.10. Финландын шинэ сургуулийн анги



Эх сурвалж: АХБ (2016)

Анги танхим гэхээсээ илүү хичээл заах, хүүхдүүдтэй ажиллах “динамик орон зай” багш нарт хэрэгтэй байгаа энэ цаг үед бид шинэ барилга барих, өргөтгөх, их засвар хийхдээ бүх зүйлийг нэг дор тавьж төлөвлөж, хэрэгжүүлж сурах хэрэгцээ байна.

**2.6.3. Дүгнэлт, зөвлөмж**

**Дүгнэлт**

- Хууль, тогтоомжид тусгагдсан боловч хэрэгждэггүй санхүүтэй холбоотой заалтуудыг хэрэгжүүлэх
- Хувьсах зардлын хуваарилалт ялгаатай байна.
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт байхгүй байна.

**Зөвлөмж**

- Хувьсах зардлын хуваарилалтын механизмыг оновчтой болгох
- Багшийн ажлын үнэлэмжийг нэмэгдүүлэх
- Санхүүжилтийн зөвхөн улсын төсвийн санхүүжилтээс хамааралтай байдлыг бууруулж бусад эх үүсвэрийг өргөжүүлэх
- Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг судалгаанд тулгуурлаж оновчлох, мэдээллийн технологи нэвтрүүлэх

## 2.7. Боловсролын статистик хяналт-шинжилгээ, үнэлгээ

### 2.7.1 Өмнөтгөл


Статистикийн мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ нь хоорондоо салшгүй холбоотой.

**А. Статистик** нь шинжилгээ судалгааны тухайн нэг хэсэг дэх бие биетэйгээ холбогдох баримтуудыг илэрхийлсэн тоон илэрхийлэл юм. Математикийн шинжлэх ухааны нэг салбар болох статистикийн шинжлэх ухаан нь энэхүү тоон илэрхийлэл дэх харилцан хамаарлын шүтэлцээ, зүй тогтол, түүний өөрчлөлтийн чиг хандлага, магадлал зэргийг судалдаг бөгөөд судалгааг тоон өгөгдөл цуглуулах, боловсруулах, дүрслэн үзүүлэх, шинжлэх, тайлбарлах замаар явуулдаг. Мөн статистикийн мэдээлэл нь ямагт тоогоор илэрхийлэгддэг онцгой төрлийн баримт бичиг бөгөөд хэрэглэсэн хүнд мэдлэг болж хүрдгээрээ онцлог юм.

Боловсролын статистик бол хүн амын амьдралын чанар нь улс орны хам нөхцөл, хөгжлийн чухал хүчин зүйлсээс хэрхэн хамаарч байгааг харуулдаг боловсролын салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн менежментийн амин чухал асуудал байдаг. Монгол Улсын Боловсролын статистикийн түүхэн замналыг тоймлон Зураг 2.7.1-д үзүүлэв.

Хүн ам, эд хөрөнгө, малын тооллого явуулах, улсын бүртгэл, мэдээлэл нэвтрүүлэх талаар Монгол Ардын Нам, Ардын Засгийн Газраас 1921 онд тусгай шийдвэр гаргасан бөгөөд БНМАУ-ын ЗГ-ын 1921 оны 08 сарын 21-ний тогтоолд “... Засгийн газраас олон хөвгүүд, охидын бага сургуулийн дүрэм хэмжээг тус тус хянан тогтоосныг хэлэлцээд энэхүү зохиосон дүрмийн дотроос зарим зүйлийг залруулан засаад дараагийн хуралд зөвлөлдөн тогтоож эрхлэх газраас зохих олон газар зарлан тушааж дагаж явуулахаар тогтоосноос гадна сургуулийн танхимыг урьдах цахилгаан мэдээний ерөнхий хороо байсан орос байшинд нээх...” гэж заасны дагуу 1921 оны 11-р сарын 2-нд Нийслэл хүрээнд анхны бага сургуулийг байгуулснаар манай улсад албан боловсролын суурь тавигдсан төдийгүй боловсролын тоо мэдээллийг гаргаж эхэлсэн байна. 1960 онд Тоо бүртгэлийн улсын төв газарт боловсролын хэлтэс байгуулагдсанаар боловсролын статистикийн мэдээллийг тусад нь нарийвчлан гаргах болжээ.

Зураг 2.7.1. Боловсролын статистикийн хөгжлийн түүхэн зураглал (1921-2016)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Боловсролын статистикийн мэдээллийг ЗГ-ын мөрийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг дүгнэх, салбарын нэмэгдэл өртгийн тооцоо хийх, хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцох, МХЗ, БНБ, ТХЗ-ийн биелэлт, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд, хүний хөгжлийн үзүүлэлтийг тооцоход ашиглаж байгаагаас гадна ЮНЕСКО-ийн Статистикийн хүрээлэнд жил бүр хүргүүлснээрээ Монгол Улсын боловсролыг бусад улс орны боловсролтой харьцуулах боломжийг бий болгодог.

**Б.** *Хяналт-шинжилгээ* буюу мониторинг нь аливаа бодлого, зорилтын үйл явцыг “анхааралтай нарийн судлах, бодит байдлыг хэмжих, мэдээлэх үйл ажиллагаа юм. Үнэлгээ нь хэрэгжиж буй болон хэрэгжсэн бодлого, хөтөлбөр, төсөл, түүний хэрэгжилт, үр дүнг системтэй, бодитой үнэлж дүгнэх үйл ажиллагаа байдаг (Жо Золл Кусек). Хяналт-шинжилгээ нь хөгжлийн зорилгод хүрэхэд гарч байгаа ахиц дэвшил, хуваарилсан хөрөнгийн ашиглалтын явц, болон бодлогын хэрэгжилтийг тодорхойлох шалгуур индикаторуудын тусламжтайгаар хэмжиж, системтэй мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийж, бодлогын хэрэгжилтийн талаар удирдлага болон гол оролцогч талуудад тасралтгүй мэдээлэх зориулалттай.

**В.** Аливаа систем дэх өөрчлөлтийг судлах, хөгжлийн чиг хандлагыг тогтоох зорилгоор 1970 оноос макро-эдийн засагт “*индикатор*” хэмээх хэрэгслийг хэрэглэж эхэлсэн бөгөөд нийгмийн салбарт ч өргөн хэрэглэх болсон байна. Боловсролын системийн чанарыг суралцахуйн гаралтад баримжаалан олон шалгуур индикатор ашиглан үнэлэх болсон.

### 2.7.2. Бодлого, Эрх зүй

Монгол улсад 1970 оноос статистикийн талаар төрөөс баримтлах бодлого батлагдсан, хууль тогтоомжийн хүрээнд тусгай индикаторууд ба аргачлалын дагууболовсролын статистикийн үзүүлэлтийг тооцож, боловсролын статистикийн тогтолцоог бүрдүүлж ирсэн. Өнөөдөр Монгол Улсад статистикийн талаар дараах бодлого эрх зүйн орчин мөрдөгдөж байна.:

УИХ-аас баталсан “Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх үндэсний хөтөлбөр (2017)-ийн 1.1-д Хөтөлбөрийн хүрээнд дараах зорилгыг хэрэгжүүлнэ гэжээ. Үүнд:

1. Үндэсний статистикийн системийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, тогтолцоог бэхжүүлэх
2. Статистикийн тогтвортой үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн статистикийн дэд бүтцийг хөгжүүлэх
3. Статистикийн мэдээллийн менежментийг сайжруулах
4. Мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх
5. Статистикийн үйл ажиллагааг боловсронгуй болгох

Энэ хөтөлбөрт статистикийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үндсэн шалгуур, зарчим, хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон хүрэх үр дүнг тодорхой тусгасан байна.

Боловсролын салбарт бодлогын дээрх баримт бичгийн зэрэгцээ боловсролын салбарын статистикийн мэдээллийн маягт, ангилал код, аргачлалыг тусгайлан батлуулж, мөрдөн ажиллаж байна.Тухайлбал,

- *Боловсролын ангилал кодын хувьд:* Монгол Улсын боловсролын түвшний ангиллын код 2014 онд батлагдсан бөгөөд түүнийг өнөөдөр мөрдөж байна. (ҮСХ-ны даргын А/153 тушаал, 2014 оны 12 дугаар сарын 05)
- *Боловсролын статистикийн үзүүлэлт, аргачлалын хувьд:* Боловсролын статистикийн индикаторуудыг тооцох аргачлалыг 2013 онд батлуулан мөрдөж байна. (ҮСХ-ны даргын 1/145 тушаал, 2013)
- *Боловсролын статистикт мөрддөг хуулиудын тухайд:* Статистикийн тухай хууль (1997, 1999, 2004, 2008, 2012, 2015, 2016), Боловсролын тухай хууль (2002), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008), Бага, дунд боловсролын тухай хууль (2002), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2009), Дээд боловсролын тухай хууль (2002), Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016), Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996), Зөрчлийн тухай хууль (2017)-д туссан тодорхой заалтуудыг тус тус мөрдөн ажиллаж байна.
- *Боловсролын хяналт-шинжилгээ, үнэлгээний тухайд:* Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.1, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.1-ийг мөрдөхөөс гадна Засгийн газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89-р тогтоолыг тус тус мөрдөн ажилладаг. Энэхүү журамтай



холбогдуулан жил бүр тус яам нь Төрийн нарийн бичгийн тушаал гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байна.

Дээрх хуулиудад боловсролын статистикийн мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөх үүргийг заасан нэг өгүүлбэр бүхий заалтаас өөр заалт тусгагдаагүй байгаа нь боловсролын статистикийн хууль эрх зүйг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Түүнчлэн олон улсын түвшинд боловсролын статистикийн индикаторууд, аргачлал ихээхэн өөрчлөгдөж буйтай холбогдуулан боловсролын статистикийн маягт, шалгуур, индикаторууд, аргачлал, ангилал, кодчиллыг сайжруулан батлах хэрэгцээ үүсэж байна.

### 2.7.3. Хэрэгжилт, үр дүн

Боловсролын бүх түвшинд холбогдох хууль дүрмийн дагуу статистикийн мэдээллийг гарган, холбогдох байгууллагад хүргүүлэхийн зэрэгцээ бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгч, судлаач, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна. Боловсролын статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлага, бүтэц зохион байгуулалт, хүний нөөц, мэдээллийн урсгал, үйл ажиллагааг энэ хэсэгт тоймлон танилцууллаа.

#### Удирдлага, зохион байгуулалт, хүний нөөц

*Үндэсний түвшинд:* ҮСХ-ны Хүн ам, нийгмийн статистикийн газар нь боловсролын статистикийн мэдээллийг, харин ЗГХЭГ төрийн захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээг;

*Салбарын түвшинд:* Боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн нь боловсролын статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг хариуцан дараах бүтэц, зохион байгуулалттайгаар ажиллаж байна (Хүснэгт 2.7.1).

Хүснэгт 2.7.1. Статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боловсролын байгууллагуудын чиг үүрэг

Боловсролын түвшин	Бүтэц, чиг үүрэг
Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол	<i>Орон нутгийн түвшинд:</i> Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх БСГ нь Статистикийн тухай хуульд зааснаар цэцэрлэг, сургуулиас холбогдох мэдээллийг цуглуулах, боловсруулах, мэдээллээр үйлчлэх, цэцэрлэг, сургуулийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг хүлээн ажиллаж байна.
	<i>Сумын түвшинд:</i> Сумын цэцэрлэг, сургууль нь Статистикийн тухай хууль, боловсролын тухай хуулийн дагуу мэдээллийг цуглуулах, боловсруулах, мэдээллээр үйлчлэх, хангах үүргийг хүлээж байна.
	<i>Дүүргийн түвшинд:</i> Боловсролын хэлтсээр дамжуулан орон нутгийн төрийн ба хувийн өмчийн цэцэрлэг, сургуулиудаас мэдээлэл цуглуулах, боловсруулах, мэдээллээр үйлчлэх, хангах үүргийг хүлээнэ. Цэцэрлэг, сургуульд тусгайлсан хариуцсан мэргэжилтэн ажилладаггүй тул сургуулийн сургалтын менежер, цэцэрлэгийн арга зүйч, эсвэл эрхлэгч хариуцан мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийг хүргүүлэх ажлыг хариуцдаг.
Дээд боловсрол	<i>Дээд боловсролын түвшинд:</i> Их, дээд сургууль нь Статистикийн тухай, Боловсрол болон Дээд боловсролын тухай хуульд тус тус зааснаар мэдээллийг цуглуулах, боловсруулах, мэдээллээр үйлчлэх, хангах үүргийг гүйцэтгэж байна. ДБСБ дээр Сургалтын алба боловсролын бүх төрлийн мэдээллийг хариуцах ба элсэлт, төгсөлт, санхүү хариуцсан мэргэжилтнүүд давхар хариуцан өөрсдийн чиглэлийн статистикийн мэдээллийг гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг.
Техникийн болон мэргэжлийн боловсрол	<i>Засгийн газрын түвшинд:</i> Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нь техникийн болон мэргэжлийн боловсролын статистикийн асуудлыг хариуцаж, тус яамны Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нь бодлого, үйл ажиллагаагаар ханган ажиллаж байна.
	<i>МБСБ-ын түвшинд:</i> Статистикийн тухай, Боловсрол болон МБС-ын тухай хуульд тус тус зааснаар мэдээллийг цуглуулах, боловсруулах, мэдээллээр үйлчлэх, хангах үүргийг гүйцэтгэж байна. Сургууль дээр Сургалтын алба боловсролын бүх төрлийн мэдээллийг хариуцаж буй бөгөөд элсэлт, төгсөлт, санхүү хариуцсан мэргэжилтнүүд давхар хариуцан өөрсдийн чиглэлийн статистикийн мэдээллийг гаргаж, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудлыг хариуцан ажиллаж байна.

Боловсролын статистикийн мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдийг жилд нэг удаа мэргэжил дээшлүүлэх үндэсний сургалтад тогтмол хамруулдаг. Тэднийг 2018 оноос олон улсын сургалтад хамруулж эхэлсэн бөгөөд ЮНЕСКО-оос мэргэжилтэн урьж, сургалт зохион байгуулж байна.

Ажил үүргийн хариуцлага, уялдаа холбоог сайжруулах үүднээс аймаг, нийслэлийн мэргэжилтнүүдийг Статистикийн улсын байцаагч болгож давтан бэлтгэсэн явдал мэдээллийн чанар сайжрахад эерэгээр нөлөөлж байна. Нийт мэргэжилтний 81.8 хувь нь улсын байцаагчийн эрхтэй байна. Харин МБСБ болон их, дээд сургуульд боловсролын статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн ажилладаггүй тул энэ чиглэлээр хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхижуулах шаардлага байна.

**Боловсролын статистикийн мэдээллийн маягт, үзүүлэлт, эх үүсвэр, тооцох аргачлал**

Боловсролын статистикийн үзүүлэлт нь хүн ам, нийгмийн статистикийн үзүүлэлтэд хамаарахаас гадна тус хуулийн 6.2-т заасны дагуу БСШУСЯ, ХНХЯ нь боловсролын статистикийн мэдээллийг эрхлэн гаргаж, ҮСХ-д хүргүүлж байна. Боловсролын статистикийн мэдээллийг гаргахдаа дараах эх үүсвэрээр гаргаж байна.

*Хүснэгт 2.7.2. Статистикийн мэдээллийн эх үүсвэр, давтамж*

Эх үүсвэр	Мэдээ, судалгааны нэр	Давтамж	Үзүүлэлт
БСШУСЯ	Албан ёсны болон захиргааны мэдээлэл	Жилд 1 удаа	2217 үзүүлэлт
	Албан ёсны мэдээлэл		1002 үзүүлэлт
ҮСХ	<ul style="list-style-type: none"> <li>Хүн амын мэдээ</li> <li>Өрхөд суурилсан судалгаагаар (Ажиллах хүчний судалгаа, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа)</li> </ul>	5 жилд нэг удаа	Боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, боловсролын зардлын мэдээлэл
	<ul style="list-style-type: none"> <li>Хүн ам, орон сууцны улсын тооллого</li> <li>Аж ахуйн нэгж байгууллага (ААНБ)-ын улсын тооллого</li> </ul>	10 жилд нэг удаа	Хүн амын боловсрол болон бичиг үсэг тайлагдалтын түвшин Боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын мэдээлэл

Боловсролын статистикийн мэдээллийн гол эх үүсвэр нь БСШУСЯ, ХНХЯ-ны захиргааны статистикийн мэдээллүүд юм.


Нийт мэдээллийн 80 орчим хувийг албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллээр 1 жилийн давтамжтайгаар гаргаж байгаа бөгөөд эдгээр мэдээллээр тодорхойлогддоггүй боловсролын бусад индикаторыг томоохон тооллого судалгаагаар гаргаж байна.

Боловсролын статистикийн мэдээллийг гаргахдаа дараах зарчмыг баримтлан ажилладаг. Тухайлбал,

- Мэдээлэл нь хараат бус, бие даасан, шинжлэх ухааны үндэслэл бүхий нэгдмэл арга зүйтэй байх
- Мэдээлэл нь үнэн бодитой, шуурхай, нийтэд хүртээмжтэй, хуулиар зөвшөөрсөн хэмжээнд ил тод байх
- Индикатор, арга зүй нь олон улсын статистикийн стандарт, арга зүйтэй нийцсэн байх
- Статистикийн мэдээллийг бага зардлаар, мэдээлэгчид ачаалал багатай арга, хэлбэрээр цуглуулдаг байх зэрэг болно.

Статистикийн мэдээллийг албан ёсны болон захиргааны гэсэн хэлбэрээр цуглуулан боловсруулж, баталгаажуулж олон нийтэд түгээдэг.

Зураг 2.7.2. Албан ёсны болон захиргааны маягтын тоо, батлагдсан тушаал, хэлбэр



СӨБ, БДБ, ДБ-ын статистикийн мэдээллийг БСШУСЯ; МБС-ын статистикийн мэдээллийг ХНХЯ тус тус хариуцан гаргаж байна.

Боловсролын салбарт нийт 111 маягт ашиглан 2,958 индикатораар мэдээлэл боловсруулан гаргаж, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Хүснэгт 2.7.3. Боловсролын салбарт хэрэглэж буй мэдээллийн маягт ба индикаторын тоо

Салбарын нэр	Нийт маягтын тоо	Үүнээс:	
		Албан ёсны мэдээллийн	Нийт үзүүлэлтийн тоо
Сургуулийн өмнөх боловсрол	28	6	941
Бага, дунд боловсрол	53	14	1,225
Техникийн болон мэргэжлийн боловсрол	15	9	395
Дээд боловсрол	15	6	397
Нийт	111	36	2,958

Боловсролын статистикийн маягт нь аливаа бодлого, хөтөлбөрийн үр дүнг тооцох, хэрэгжилтэд хяналт тавих, олон улсын үзүүлэлттэй харьцуулах зэрэгт ашиглагдан хөгжлийн хэрэгцээ шаардлагын дагуу өөрчлөгдөн шинэчлэгдэж иржээ (Хүснэгт 2.7.4).

Хүснэгт 2.7.4. Салбарын статистикийн маягтууд өөрчлөгдсөн он ба үндэслэл

Салбарын маягтын нэр	Батлагдсан он	Үндэслэл
СӨБ-ын статистикийн маягт	2008	СӨБ-ын тухай хууль
	2017, 2018	Тогтвортой хөгжлийн зорилт, хууль эрх зүйн томоохон өөрчлөлт
БДБ-ын статистикийн маягт	1998, 2008	Хууль эрх зүйн өөрчлөлт, ЕБС-ийн сургалтын тогтолцоог 11-12 жилдшилжүүлэх өөрчлөлт
	2014	Дүрэмт хувцас буюу Засгийн газрын мөрийн хөтөлбөр
МБС-ын статистикийн маягт	2002, 2010, 2012, 2013	МБС-ын тухай хууль батлагдсан
ДБ-ын статистикийн маягт	1999, 2002	

Дэлхийн нийтийн БНБ-ын ахиц дэвшлийг үнэлэх нийтлэг индикаторууд болон аргачлалын хүрээнд улс орнуудын нийгэм, эдийн засгийн нийтлэг болон өвөрмөц онцлогийг харгалзан үзэх шаардлагад нийцүүлэн УИХ-ын 2008 оны 13-р тогтоолоор МУ-ын Мянганы хөгжлийн 9 зорилго, 24 зорилтыг 67 шалгуур индикатораар илрүүлж үнэлэхээр баталсан байдаг бөгөөд тэдгээрээс боловсролд хамаарах дараах 6 индикторыг тооцож ирсэн байна. Үүнд,

- Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин
- 1-р ангид элсэн ороод 5-р анги хүртэл суралцагчдын хувь

- 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын хувь
- Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа
- ЕБ эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа
- Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа

Боловсролын салбарын түвшинд хүртээмж (10), дотоод үр ашиг (8), суралцахуйн үр дүн (13), санхүү, хүний нөөц (10) гэсэн 4 бүлгээр нийт 41 индикатор ашиглан мэдээлэл боловсруулдаг бөгөөд ЮНЕСКО-оос боловсруулсан аргачлалаар тооцох боломжтой бусад индикаторыг ашиглан тооцоолол хийж байна. (ҮСХ-ны даргын 1/145 тушаал, 2013)

Мөн үндэсний болон салбарын хэмжээнд гарсан томоохон баримт бичиг, бодлого хөтөлбөрийн биелэлтэд туссан индикаторуудыг тооцон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг.

2015 онд НҮБ-ын Ерөнхий Асамблейн 70-р чуулганаар 2030 хүртэлх, ТХ-ын 17 зорилго, 169 товлосон зорилтыг баталж, хэрэгжилтийг 244 индикатороор тооцоолохоор тодорхойлсон. Энэхүү ТХЗ-2030-ын хүрээнд “Чанартай боловсрол” гэсэн 4 дэх зорилго, түүнд хүрэх 10 товлосон зорилтын, хэрэгжилтийг нь 11 нийтлэг болон сэдэвчилсэн бусад индикаторуудаар тооцохоор болсон.

ТХЗ-ын хэрэгжилтийг дүгнэх шалгуур, индикаторууд гаргах бэлэн байдлыг тогтоох зорилгоор ҮСХ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран дараах 3 удаагийн үнэлгээ хийгджээ.

1. *НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ҮСХ хамтран хийсэн 2015 оны үнэлгээ* Нийт 11 индикатороос давхардсан байдлаар бэлэн байгаа 1, бага зэрэг хүчин чармайлт гаргах 4, илүү их хүчин чармайлт гаргах 6, мэдээлэл цуглуулалт өөрчлөгдсөн тохиолдолд 3 индикаторыг ашиглах боломжтой гэсэн үнэлгээний дүн гарчээ.
2. *ҮСХ-оос 2016 онд хийсэн үнэлгээ*: Боловсролын 11 үзүүлэлтээс ОУ-ын нэгдсэн аргачлал, арга зүйтэй 5 үзүүлэлт, арга зүй нь тодорхойгүй 6 үзүүлэлт байна. Боловсролын 11 үзүүлэлт нь бүгд МУ-д хамааралтай бөгөөд шууд гарах 3, гарахгүй байгаа 8 үзүүлэлт байна. Цаашид ТХЗ-ын үзүүлэлтийг тооцох, гаргах чиглэлээр дараах хэрэгцээ байгааг тодорхойлжээ. Үүнд:
  - Яамд, холбогдох ТБ-уудтай хамтран ТХЗ-ын Дэлхийн болон үндэсний түвшний үзүүлэлтүүдийг тооцох ОУ-ын аргачлал, арга зүйг судлах, үндэсний онцлогт нийцүүлэн боловсруулах, мөрдүүлэх,
  - Аргачлал, арга зүй нь бэлэн боловч гаргах боломжгүй үзүүлэлтүүдийг тодорхойлж, тусгайлсан судалгаа явуулах, одоо мөрдөгдөж байгаа зарим тооллого, судалгаа, мэдээ, тайлангийн маягтад шаардлагатай нэмэлт асуултыг тусгаж, мэдээллийн эх үүсвэрийг бий болгох.
  - Мөн Сангийн яаманд: ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийн аргачлал, арга зүйг боловсруулах, үндэсний, орон нутгийн түвшний болон салбарын бодлогын баримт бичгүүдтэй уялдуулах, үнэлгээ хийх,
  - Албан ёсны монгол, англи орчуулгыг хийх, ТХЗ-ын биелэлтийг гаргах мэдээллийн эх үүсвэрийг бий болгох шаардлагатай судалгаа, шинжилгээний ажлыг хийхэд санхүүгийн тусламж авах зэрэгт холбогдох байгууллагууд, тухайлбал, олон улсын байгууллагын тусалцааг авах, хамтран ажиллах, тусгайлсан судалгаа явуулахад шаардагдах санхүү, зардлын асуудлыг шийдвэрлэх,
  - ТХЗ-ын дэлхийн болон үндэсний түвшний үзүүлэлтүүд батлагдсаны дараа тодорхой сэдвүүдээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах гэж зөвлөмжилсөн байна.
3. *ҮСХ-оос 2017 онд хийсэн үнэлгээ*: Нийт үзүүлэлтээс 3 индикатор мэдээлэл гарах боломжгүй гэж үнэлэгдсэн байна.

ТХЗ4-ын хэрэгжилтийг үнэлэх индикаторуудын аргачлал арга зүй, мэдээллийн гарах бэлэн байдлыг тус тус дэлхийн нийтийн хэмжээнд баримталж буй үнэлгээний түвшингүүдээр авч үзэхэд I түвшинд 2, II түвшинд 9, III түвшинд 2, II-оос дээш түвшинд хамаарах 2 индикатор байна.

Цаашид эдгээр индикаторуудыг сайжруулахаар тодорхой ажлыг хийх шаардлагатай бөгөөд эхний алхмуудыг хийж эхэлсэн байна. Тухайлбал, СӨБ-ын статистикийн маягтыг сайжруулан 2017, 2018 онд шинэчлэн батлуулснаар СӨБ-д хамаарах ТХЗ-ын шалгуур индикаторууд болон салбарын бодлогын үнэлгээнд шаардлагатай индикаторуудыг хэрэглэн тооцох боломжийг бий болгосон байна.

Мөн ЗГ-аас боловсролын статистикийн мэдээллийн чанарыг сайжруулах, механик ажлыг хөнгөвчлөх, орчин үеийн мэдээллийн технологийг нэвтрүүлэх чиглэлээр ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байна. Үүний нэг илрэл нь БСШУЯ нь ерөнхий боловсролын удирдлагыг оновчтой, үр дүнтэй болгохоор Боловсролын удирдлагын мэдээллийн систем (БУМС)-ийг МУ-ын зөвлөх компаниар гүйцэтгүүлэх, мөн ЮНЕСКО-ийн Нээлттэй удирдлагын мэдээллийн систем (OpenEMIS)-ийг авч хэрэглэх замаар энэ талбарт туршлага хуримтлуулсан. Энэ туршлагадаа тулгуурлан үндэсний баг бүрдүүлж, 2014 оноос БДБ-д, 2018 оноос СӨБ-д, БУМС-ийг нэвтрүүлсэн бөгөөд 2019 оноос дээд боловсролд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна

### Боловсролын салбарын мэдээллийн систем (БСМС)

Боловсролын салбарын үндсэн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц мэдээллийн менежментийн хүрээг бүрдүүлж, мэдээ, мэдээллийн хэрэгцээ шаардлагыг ойлгомжтой тодорхойлж, шаардлагатай тоо мэдээллийг нэгдсэн арга хэлбэрээр бүртгэн үйл ажиллагаанд ашиглах, удирдлагын шийдвэрт дэмжлэг үзүүлэх зорилгоор ерөнхий боловсролын салбарт БУМС-ийг хөгжүүлэх ажлыг АХБ-ны тусламжтайгаар эхлүүлэн, гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

1-р үе шат (2013-2014): Үндсэн үр дүн нь мэдээллийн онлайн системийг бүрэн хэмжээгээр бүрдүүлж, мэдээллийн менежментийн хүрээг эцэслэн боловсруулах;

2-р үе шат (2014-2015): БУМС-ийг төрийн мэдээллийн сүлжээтэй харилцан мэдээлэл солилцох боломжтой болгох, санхүүгийн болон хөрөнгийн удирдлагын гэх мэт дараагийн шатны мэдээллийн системийг нэвтрүүлэх;

3-р үе шат (2015-2020): Мэдээллийн онлайн баазыг бүрэн гүйцэд байгуулахад чиглэсэн мэдээллийн онлайн системийг бүрэн нэвтрүүлж, сургалтын үйл ажиллагааг автоматжуулахад чиглэсэн цахим сургалтын хэрэглэгдэхүүний удирдлагын системийг нэвтрүүлэх;

“Боловсролын салбарт мэдээлэл, харилцаа холбооны технологийн талаар баримтлах бодлого 2012-2016” (БШУ-ны Сайдын А/24 дугаар тушаал, 2012)-ын дагуу боловсролын салбарын энтерпрайз архитектурыг боловсруулж, програм хангамж, техник хангамжийн шаардлага болон системийн тогтвортой ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, боловсролын салбарт интернетэд суурилсан өдөр тутмын үйл ажиллагааг бүртгэн удирдах “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийг боловсруулан туршиж, нэвтрүүлсэн бөгөөд тогтвортой ажиллагааг ханган ажиллаж байна.

БСМС нь мэдээллийн технологийг ашиглан боловсролын өгөгдөл мэдээллийг цуглуулах, бүртгэх, дамжуулах, боловсруулах, хадгалах, хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааны үр дүнд мэдээллийн санг бүрдүүлж, удирдлагын үйл ажиллагааг дэмжсэн, хэрэглэгч байгууллагын удирдлагын хэрэгцээ, шаардлагыг хангасан систем юм.

Зураг 2.7.3. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын салбарын мэдээллийн систем



БСМС-ийн *зорилго* нь Боловсролын салбарын менежментийг шинэ шатанд гаргахын тулд мэдээллийн технологид суурилсан нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх замаар удирдлагын түвшинд аналитик шинжилгээ хийж, оновчтой төлөвлөлт-шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхэд оршино.


Энэ зорилгын хүрээнд дараах *зорилтуудыг* хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- БСМС-ийн нэгдсэн платформыг байгуулах
- Боловсролын бүх шатны байгууллагад нэвтрүүлэх
- Үнэн бодит мэдээллээр хангаж, судалгаа шинжилгээ хийх бололцоо олгох
- Системд шинэчлэл, сайжруулалт хийж, тогтвортой ажиллагаа хангах

БСМС-ийг боловсруулахдаа салбарын хэмжээний оролцогч талуудын мэдээллийн хэрэгцээг тодорхойлж бүлэглэх, мэдээллийн анхдагч эх сурвалжуудыг тогтоох, уг мэдээллийг олж авахын тулд оролцогч талуудын хооронд үүсэж байгаа харилцааны төвөгтэй байдлыг өөрчилж, нэг мэдээллийн төвт харилцааны шийдлийг боловсруулсан. Өөрөөр хэлбэл, системийн түвшинд нь томоор харах, мэдээллийн урсгалын ойлгомжгүй байдал, мэдээллийн эх сурвалж, эзэнгүй мэдээлэл, мэдээллийн давхцыг арилгасан. Боловсролын салбарын хэмжээнд нэг мэдээллийн сантай болж, оролцогч бүрүг системийг ашиглан өдөр тутмын ажилдаа шаардлагатай мэдээлэл оруулах ба мэдээлэл олж авах боломжтой болгохын тулд боловсролын бүх түвшинд нэгдсэн нэг системийг бий болгохоор ажилласан ажээ.

2017 оны байдлаар байгууллага, сургалтын нөөц, хүний нөөц, статистик тайлангийн модулиудыг бүрэн дуусгаж нэвтрүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа бөгөөд хэрэглэх явцад тооцоолоогүй асуудлыг илрүүлэн шийдвэрлэхээс гадна элсэлт, төгсөлт, дэвшилт, шалгалт, шилжилт хөдөлгөөний процессуудыг өдөр тутам мэдээлдэг болсон байна.

Зураг 2.7.4. Статистикийн удирдлагын модуль



Боловсролын салбарын сургалтын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, тайлан мэдээг бүхэлд нь хамарсан, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, БСМС-ийг нэвтрүүлж хөгжүүлэх, системийн тогтвортой ажиллагааг ханган ажиллаж байна.

Зураг 2.7.5. БСМС-ийн хамрах хүрээ



БСМС-ийг нэвтрүүлснээр боловсролын статистикийн мэдээлэлд дараах өөрчлөлт, ахиц дэвшил гарсан. Үүнд:


- **Боловсролын статистик мэдээлэлд:** Регистрт суурилан хувийн мэдээлэл болон бодит байдлын мэдээллийг өдөр бүр оруулснаар мэдээллийн ашиглалт нэмэгдэж хүн бүрийн хэрэгцээ шаардлагыг хангасан мэдээллийн сан бүрдэх боломжийг бий болгож дараах эерэг үр дүн гарсан. Үүнд:
  - *Нэгдсэн нэг мэдээллийн системд үндэслэн нэг эх үүсвэрээс мэдээллийг ашиглах боломжийг бий болгосноор мэдээллийн шуурхай, аюулгүй, үнэн зөв бодит байдлыг хангасан байна.*
  - *Мэдээллийн систем нь түвшин бүрд нэвтэрснээрээ статистик мэдээллийн түвшин бүр дэх хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, хүн бүрийн оролцоог дэмжсэн бөгөөд улмаар мэдээний чанарт эерэгээр нөлөөлсөн байна.*
- **Боловсролын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтэд:** Дараах эерэг үр дүн гарсан. Үүнд:
  - Статистик мэдээллийн батлагдсан маягтаар үзүүлэлт болон нэгтгэл маягтад үндэслэн боловсруулалт, төлөвлөлтийг хийдэг хамгийн их цэгэн задаргаагаар сургуулийн удирдлага, дотоод болон гадаад харилцаа холбоо, сургуулийн барилга байгууламж, орчны мэдээлэл, багш, сурагчийн суралцах үйл ажиллагаа, үнэлгээ гэх мэт мэдээлэл болон бодит мэдээлэлд үндэслэн боловсруулалт, төлөвлөлтийг хийх
  - Тусгай зөвшөөрөлд үндэслэн мэдээллийг бүртгэснээр бичиг баримтын зөрчлийг арилган хуулийг чандлан мөрдүүлснээр хамрагдалт илүү сайжирсан.
  - Мэдээлэл хоорондын зөрүү, давхардлыг арилгасан.
  - Хүүхэд бүрийн мэдээллийг оруулснаар тухайн суралцагчийн шилжилт хөдөлгөөн, суралцахуйн түүхийг бичих, сургууль завсардахаас сэргийлэх, үнэлгээг хийхэд ихээхэн дэмжлэг үзүүлж байна. Шилжилт хөдөлгөөнийг хянаснаар хууль бусаар анги алгасах, эрт болон хожуу элсэлт, завсардалт зэргийг хянах боломж бүрдсэн.
  - Боловсролын бичиг баримтыг БСМС-ээс олгодог болсноор бичиг баримтын хяналт сайжирсан.
  - Баримт бичиггүй хүүхдүүдийн сум, дүүрэг, сургуулийн түвшинд компани ажил зохион байгуулж баримт бичигтэй болгох ажлыг зохион байгуулснаар сургуульд хамрагдалт нэмэгдсэн.
- **Эдийн засагт:** Статистик мэдээнд суурилсан хүүхдийн тоонд үндэслэн хувьсах зардлыг сургуулиудад олгодог тул сурагчдын тоог нэмэх, хүүхдийн тоо давхардах зөрчил байсан. Хүүхэд бүрийн регистрт суурилан мэдээллийг нэгтгэснээр давхардлын энэ зөрчлийг арилган, мэдээллийг үнэн зөв байдлыг хангах, улмаар санхүүжилтийнүр ашигт эерэгээр нөлөөлөх болсон.

- *Салбар хоорондын харилцаанд:* УБЕГ-тай мэдээллийг холбосноор суралцагчдын РД-д суурилан суурь мэдээллийг тус газраас авч, баримт бичиггүй болон баримт бичгийн зөрчилтэй иргэдийг илрүүлж, баазыг шинэчлэн сайжруулсан. Салбар хоорондын мэдээллийн уялдаа сайжирсан байна.

Мэдээллийг цуглуулахдаа дараах урсгалаар цуглуулж, хэрэглэж байна. Үүнд:

- *Статистикийн мэдээллийн урсгал:* Боловсролын мэдээлэл нь анхан шатны нэгж болох бүх шатны цэцэрлэгүүд, сургуулиудаас цэцэрлэгээс цуглуулагдан, шат шатны боловсролын байгууллагуудаар хянагдан дамжиж, ҮСХ-д ирүүлдэг бөгөөд ҮСХ-ноос гаргадаг албан ёсны статистикийн болон БСШУСЯ-ны мэдээлэл тархалтын суваг болон орон нутгийн статистикийн байгууллагуудаар дамжин хэрэглэгчдэд буцаж хүрч байна (Зураг 2.7.6).

Зураг 2.7.6. Статистик мэдээллийн урсгал



*Статистикийн мэдээллийн хэрэглээ:* Боловсролын статистикийн мэдээллийг хэрэглэгчдэд дараах байдлаар тархааж байна. Үүнд:

Вэб сайтаар:

- ҮСХ-ны вэб сайт [www.nso.mn](http://www.nso.mn)
- Статистикийн мэдээллийн нэгдсэн сан [www.1212.mn](http://www.1212.mn)
- БСШУСЯ-ны вэб сайт [www.mecss.gov.mn](http://www.mecss.gov.mn)
- Боловсролын статистикийн вэб сайт [www.esis.edu.mn](http://www.esis.edu.mn) одоогоор хийж байгаа.

Хэвлэмэл байдлаар

- ҮСХ-ны жил, улирлын эмхтгэл
- Боловсролын салбарын статистикийн эмхтгэл – I
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын статистикийн эмхтгэл – II
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын статистикийн эмхтгэл (англи хэлээр)
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын статистикийн брошур 95 жилийн динамик үзүүлэлтээр)

Төрийн болон төрийн бус, иргэд олон нийтийн байгууллага болон бусад

- Хүсэлтийн дагуу зөвшөөрөгдөх үзүүлэлтээр мэдээллээр үйлчлэх (файлаар болон цаасаар)

#### 2.7.4. Дүгнэлт, зөвлөмж

##### Ололт, амжилт

1. Боловсролын салбарт статистикийн олон улсын аргачлал, арга зүйг нэвтрүүлснээрээ олон улсын аргачлалаар боловсролын индикаторыг тооцох боломжтой болгосон.



2. 2002 оноос эхлэн ЮНЕСКО-д боловсролын статистикийн маягтаар мэдээллийг гаргаж өгдөг болсон нь Ази, Номхон далайн бүс нутгийн хэмжээнд төдийгүй олон улсад Монгол Улсын албан болон насан туршийн боловсролын талаарх тодорхой мэдээллийг өгч бусад оронтой харьцуулах боломжийг бүрдүүлсэн.
3. Боловсролын статистикт МХХТ-ийг нэвтрүүлснээр хүүхдийн регистрт суурилсан мэдээллийн санг бий болгосон төдийгүй мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, нотолгоонд суурилсан үр дүнг гаргах, бодитой төлөвлөлт хийх боломжийг бүрдүүлж үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх таатай боломжийг бий болгож байна.
4. БСМС-ийг боловсролын салбарт үе шаттайгаар залгамж холбоо бүхий технологийн шийдэлтэйгээр нэвтрүүлж эхэлсэн нь боловсролын түвшин хоорондын мэдээллийн уялдаа холбоог хангах, сургууль завсардалтыг бууруулах, хамран сургалтыг нэмэгдүүлэх төдийгүй санхүүгийн үр ашгийг нэмэгдүүлж байна.
5. БСМС-ийг бусад системтэй холбосноор бусад салбарын хөгжилд эерэгээр нөлөөлж байна.
6. ТХЗ-ын индикаторт дүн шинжилгээ хийж, өнөөгийн нөхцөл байдлаа тодорхойлон цаашид шийдвэрлэх асуудлыг тодорхойлсон нь боловсролын статистикийг хөгжүүлэх чухал хөшүүрэг болж байна.

### Сул тал

1. БСМС-ийг боловсронгуй болгох бодлого, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн болоод санхүүгийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх тууштай, даацтай бодлого үгүйлэгдэж байна.
2. Боловсролын статистикийн хувьд бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, бодлогыг хэрэгжүүлэх бүх түвшний удирдах ажилтнууд, мэргэжилтнүүдийн ойлголт бага, БСМС хэрэглэх мэдлэг, ур чадвар сулаас мэдээллийн зөв зохистой ашиглалт чамлалттай байна.
3. Хүний нөөц дутмаг, үндсэн албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод статистикийн үйл ажиллагааг хавсарга төдий тусгасан, нэгжийн түвшинд боловсролын статистик, хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн байхгүй байгаа нь тухайн ажилтны ажлын ачааллыг нэмэгдүүлж, мэдээлэл цуглуулалт болон боловсруулалтын чанар болон гүйцэтгэлийн хугацаанд сөргөөр нөлөөлж байна.
4. Томоохон хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгждэг ч тэдгээрийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийгдэх нь хомс байна.
5. Боловсролын статистикийн маягт шинэчлэх асуудал удаашралтай, ТХЗ-ын үзүүлэлтийг тооцох боломж хомс байна.

### Зөвлөмж

1. Боловсролын статистикийн чиглэлээр хууль эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж сайжруулах
2. Боловсролын бүх түвшинд статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр хүний нөөц болон байгууллагын техник технологийн чадавхыг бэхжүүлэх
3. Боловсролын салбарын статистикийн мэдээллийн бодлого, ангилал, тооцох аргачлалд сайжруулалт хийх. Тухайлбал, өнөөгийн олон улсын боловсролын стратегийн бодлого төлөвлөлттэй уялдуулж, НТБ, инклюзив боловсрол ба үл алагчлагдах шударга байдал зэрэг боловсролын үйлчилгээний чанарын шинэ шалгууруудыг тодорхойлох боломж олгосон шинэ индикаторуудыг нэмэх, тэдгээрийн тооцоолох арга хэрэгсэлүүдийг боловсруулах, өгөгдөл, мэдээллийн санг бий болгох
4. Мэдээллийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдал, хүний нөөцийн бодлого зэргийг тусгасан бодлогын шинэ баримт бичгийг боловсруулан баталж, тухайн бодлогыг хэрэгжүүлэх, тухайлбал, БСМС-г институтчилан тогтвортой ажиллагааг хангах иж бүрэн эрх зүйн шинэ орчинг бүрдүүлэх
5. БСМС-ийг сургалтад ашиглахаас гадна судалгаа, шинжилгээний ажилд ашиглах, судалгаанд суурилсан үр дүнг тооцдог механизмыг бодлогоор дэмжин хэрэгжүүлэх
6. Салбарын хөгжлийн асуудлаар хийгдсэн эрдэмтэн, судлаачдын томоохон судалгааны үр дүнг нэгтгэн судалгааны сан үүсгэж, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид болон судлаач, хэрэглэгчдэд хүргэх, боловсролын хөгжлийн төрийн ой санамжийг хадгалах, өргөжүүлэх
7. Хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, үйл ажиллагаа болон боловсролын салбарын үйл ажиллагаанд тогтмол хяналт-шинжилгээ хийж, хөгжлийн томоохон баримт бичиг, судалгааны үр дүнд олон төрлийн зориулалттай арга хэрэгсэл бүхий олон хэлбэрийн үнэлгээнүүдийг тогтмол хийдэг болох

8. Боловсролын статистик, хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгийн ашиглалтыг сайжруулахын тулд хэрэглэгчдийн бүх түвшинд үйлчилгээний эргэх холбоог хангаж, тэдэнд судалгаа, шинжилгээний үр дүнг шийдвэр гаргахдаа оновчтой зөв ашиглах мэдлэг, чадвар, хандлага буюу мэдээлэлтэй харьцах шинэ соёлд суралцахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх арга хэлбэрийг хөгжүүлэх. Өөрөөр хэлбэл, мэдээллийн маркетингийн судалгаа, борлуулалтыг нэмэгдүүлэх.


## 2.8. Боловсролын сектор дамнасан бодлого, төлөвлөлт

### 2.8.1. Өмнөтгөл

Бид “Сектор дамнасан бодлого, төлөвлөлт (Sector-wide policy and planning)” болон “Сектор дамнасан арга хандлага (Sector Wide Approaches)”-тай холбоотой дүгнэлт, зөвлөмжийг томъёолохдоо Монголын хувьд боловсролын секторын хөгжлийн орчин үеийн тулгамдаж буй асуудлаар орчинтой нь, ялангуяа, бүсчилсэн байдлаар харьцуулах замаар тохиол хэргийн сэдэвт судалгаа (case study) хийхийг зорьсон ч цаг хугацааны хязгаарлалтаас шалтгаалан зөвхөн байгаа статистик мэдээ, өмнөх нөхцөл байдлын тухай зарим баримт, тухайлбал, УИХ-аас баталсан холбогдох зарим хууль, тогтоомж, ЗГ-ын сонгуульд хугацааны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, мөн БСШУСЯ, Хөдөлмөр, Эрүүл мэндийн гэх мэт тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тайлангууд, Сангийн яамны зарим мэдээ баримт, гадаадын зарим байгууллагаас гүйцэтгэсэн төрөл бүрийн үнэлгээт судалгааны материал зөвлөмж, боловсролын секторт хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр болон гадаад, дотоодын тусламж, ҮСХ-ны жил жилийн тоон өгөгдөл мэдээ зэргийг ашиглаж, өөрөөр хэлбэл, олдсон баримт, мэдээ, өгөгдлөөр суурь мэдээллийн тайлан бэлтгэхийг оролдлоо.


Сектор дамнасан хандлага (sector wide approach)-ын тухайд тодорхойлолт, үзэл баримтлалын олон янзын томъёолол бий. Бид гагцхүү “Боловсролын сектор дамнасан хандлага бүхий бодлого, төлөвлөлт”-ийн хувьд байгаа баримт, өгөгдлөөр өнгөц тойм үнэлгээ (overview) хийхдээ төсөлт арга барилын хөгжил илэрхийлсэн дараах бүдүүвчид тулгуурлав.

Зураг 2.8.1. “Төсөл”-т аргаас “Сектор дамнах” хандлага бүхий төлөвлөлт хүртэлх үе шат



Мөн сектор дамнасан хандлага (СДХ) бүхий “Боловсролын төлөвлөгөө (жишээлбэл, МХЗ, БНБ оруулаад), олон секторыншүтэлцээт төлөвлөлт болон олон улсын хэмжээнд хөгжлийн хорших үйлийн бүтэцчилсэн хүрээ хоорондын харилцан хамаарал”-ын тухайд дараах зургаар илэрхийлэв. Ажлын ийм “бүтэцчилсэн хүрээ”-нд тайлант тойм үнэлгээ (Desk review) хийхийг оролдов.

Зураг 2.8.2. Боловсролын төлөвлөгөө (жишээлбэл МХЗ, БНБ оруулаад), олон секторын төлөвлөлт болон олон улсын хөгжлийн хорших үйлийн бүтэцчилсэн хүрээ хоорондын харилцан хамаарал



### 2.8.2. Хэрэгжилт, үйл явцын хандлага

Энэ дээрх хоёр зурагт илэрхийлсэн утгаар хандвал, үндэсний хэмжээний олон хөтөлбөр (нотлох баримтат үнэлгээний жишээ болгож Монголын боловсролын тогтолцооны дэд секторууд буюу бүрдэл хэсэг бүр дэх бодлогын баримт, өгөгдлийн шинжилгээний тоймыг илтгэх өмнөх бүлгүүдийн бодлогод хамаарах дэд хэсгээс үзнэ үү) хэрэгжсэн, хэрэгжиж байгаа хэдий ч хөтөлбөрүүд тус бүрийн хувьд тусгай зориулалтын, тэгэхдээ Монголын ЗГ-аас дангаар санаачилж гүйцэтгэсэн судалгаа, үнэлгээний тайлан олоогүй. Мөн хэрэгжүүлж буй төслүүд, тухайлбал, “Дээд боловсролын реформ” төсөл хэрэгжүүлэлтийн явцын үнэлгээний, дор хаяад, “Нотлох албан баримтат үнэлгээ (Verification)”-ний материал олоогүйгээс гадна “**тохиролцоо хэлцлийн зардал**” (transaction costs) хэрхэн, ямар үе шаттай өөрчлөгдөж байгаа, сектор дамнасан бодлого, төлөвлөлтийн хувьд ерөөс 1995 оноос хойш төсөлд суурилсан арга барилаас “Сектор дамнасан арга хандлага”-д шилжиж байгаа үе дэх шийдвэр гаргах үйл явц буюу үйл гүйцэтгэх бүтэц механизм, зохион байгуулалт, арга хэлбэр хандлагын тухайд “тохиол хэргийн сэдэвт судалгаа (case study)” хийх хугацаа байсангүй. Гэвч сектор дамнасан бодлого, төлөвлөлт хэрэгжилтийн судалгаа үнэлгээг мэргэжлийн зохих арга зүйн дагуу хийж байгаа жишээ баримтыг Монголын боловсролын тогтолцооны тухайн бүрдэл хэсэг, боловсролын түвшин бүр дэх бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн судалгаа үнэлгээний бүлэгт тусгасан болно. Нэг жишээ дурдвал,

“Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого”-ыг 2005 онд (БСШУЯ, ЭМЯ, НХХЯ, 2005, 116.83.45) баталсан бөгөөд энэхүү бодлогын хэрэгжилтэд БСШУЯ, НҮБ-ын Хүүхдийн сангаас 2007 онд үнэлгээ хийсэн байна. Энэ судалгааны Дүгнэлт болон Зөвлөмж хэсэгт дурдсанаар “хэдийгээр бага насны хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр тавигдсан зорилтууд хэрэгжиж байгаа боловч эдгээр нь урьдын адил салангид хүчин

*чармайлтаар хэрэгжиж байгаа ба Засгийн газар болон орон нутгийн салбарын асуудал хариуцсан агентлагуудын оролцоо, зохицуулалтыг сайжруулах, дэвшүүлсэн зорилтуудад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг тусгах, салбар хоорондын менежмент, зохицуулалтын бүтэц, механизмыг сайжруулах”* гэсэн дүгнэлт хийсэн байна.

Мөн өөр баримтуудаас эшлэвэл, 2000 оноос хойш СӨБ-ын салбарт гадаад орон, олон улсын байгууллагуудын зүгээс буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлсэн төслүүдийн нийт хөрөнгө оруулалтыг оруулаад энэ салбарт нийтдээ 15.1 сая ам долларын санхүүжилттэй төслүүд хэрэгжсэн (ЭЗХЯ, 2014). Гэвч боловсролын түвшин, тогтолцооны бүрдэл хэсгүүдийн хувьд санхүүжилтийн мэдээ тайлан байгаа хэдий ч харин санхүүжилтийн үр өгөөж (effectiveness), үр ашиг (efficiency)-ийн талаар болон дам (outcomes) болон нөлөөт (impacts) үр дүнгийн судалгаа үнэлгээний баримт олоогүй. Түүнчлэн “сектор дамнасан бодлого, төлөвлөлт (sector wide policy and planning)-ийн хувьд боловсролын тогтолцооны бүрдэл хэсэг бүрд энэ илтгэц тайланд хийсэн “Нотлох албан баримтат үнэлгээ (Verification)-ний дүгнэлтээр “Өнгөц оношилгоо (Scanning)” хийхэд одоо байгаа үндэсний хэмжээнд потенциал чадавх бүрэн чадамжтай, гэхдээ ийм үйл гүйцэтгэх төлөвшсөн тогтолцоо буюу энэ зориулалтын бүтэц зохион байгуулалт албажаагүй, энэ чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа тогтмолжоогүй гэсэн үнэлгээ өгч болно. Харин энэ чадавхын хөгжил, ахиц дэвшлийн талаар энэ удаад хугацааны хомсдлоос шалтгаалж бүрэн үнэлгээ дүгнэлт хийх боломжгүй байв.

- Төрийн бодлогын үнэлгээ, судалгааны ажил гүйцэтгэх үндэсний хэмжээн дэх чадавхын хөгжил ахиц-боловсронгуйжилт (Developing national research and evaluation capacities for public policies) ийм төрлийн судалгааг зохих зориулалтын үнэлгээнүүдийг сонгож холбогдох арга зүйгээр хийх шаардлагатай. Үүний тулд: юуны өмнө, “Эталон, стандарт, эсвэл суурь хэмжигдэхүүнтэй харьцуулах үнэлгээ (Benchmarking)”-ний шалгуур (Criteria) ба тодорхой заалтуур (indicators), хэмжээсжүүлсэн үзүүлэлттэй зориулалтын асуумж үнэлгээ (questionnaire survey for benchmarking evaluation), эсвэл Монголын хувьд тохиол хэргийн сэдэвт судалгаа (case study)-ны илтгэл тайлан материал шаардлагатай. Тухайлбал,
  - Явцын үнэлгээний төрөлжсөн байгууллага, зөвлөх үйлчилгээт компани, судалгааны их дээд сургуулиуд гэх мэт мэргэшсэн баг, тэдгээрийн харьяалал байршил, үйл ажиллагааны нийц зохион байгуулалт (Integration, location and organization of the evaluation function)
  - Үнэлгээ хийх санхүүгийн болон хүний нөөц (Evaluation of resources financial and human))
  - Явцын үнэлгээ гүйцэтгэх үйлийн менежментийн үр ашиг (Efficiency of evaluation management)
  - Хяналт-шинжилгээний тогтолцоот ажиллагааны чанар (Quality of monitoring systems);
  - Үнэлгээний тогтолцооны гаднах нийгэм-эдийн засгийн өгөгдөл заалтууд үзүүлэлтийн чанар буюу шууд ашиглах боломж (Quality of external socio-economic data sources);
  - Явцын үнэлгээний судалгаа хийх шинжээчдийн хүрэлцээ ур чадвар, судалгааны чанар (Availability and quality of evaluation expertise) материал олоогүй байна. Ер нь Үндэсний хэмжээний бодлого, хөтөлбөрийн баримт бичиг нийтдээ 480-ыг баталснаас одоо 192 нь хүчинтэй үйлчилж байгаа аж (“Боловсролын Суурь Мэдээллийн Тайлан”-гийн анхны төсөл хэлэлцүүлэг дээр Р.Бандийгийн хийсэн мэдээлэл). Харин “Сектор дамнасан бодлого, төлөвлөлт (SWAp)”- өд хамааралтай УИХ-аас баталсан хууль тогтоомж, ЗГ-аас баталсан дүрэм журам бүхий баримт бичгийг он дараалуулан нарийвчлан үзвэл, ихээхэн ахиц дэвшил байна. Жишээлбэл, “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль-2009.2.13”, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль-2015.11.26”, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлах тухай, УИХ-ын тогтоол, 2016.02.05” зэрэг баримт бичгийг дурдаж болно. Эдгээр баримт бичиг, дүрэм заавар хэрхэн сайн хэрэгжиж байгаагийн тухайд тусгай судалгаа хэрэгтэй. Тухайлбал, хэрэгжилт нь сул байгаа жишээ гэвэл “21.1.Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ” гэж “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”-д заасан боловч энэ заалт хэрэгжээгүйн улмаас сектор дамнасан бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийн үйл ажиллагааг уялдуулах, зохицуулах үүрэг бүхий “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл”-ийн үйл ажиллагаа зүгшрээгүй гэж дүгнэсэн (“Боловсролын Суурь Мэдээллийн Тайлан”-гийн анхны төсөл хэлэлцүүлэг дээр Б.Мишигжавын танилцуулсан мэдээлэл) байна.

- Боловсролын талаар төрөөс баримталж буй бодлогод болон боловсролын сектор дэх инновац дэмжлэгийн ахиц [жишээлбэл, түүнд үзүүлэгч чадавхын хөгжлийн хөтөлбөрийн тусламжтай] (Promoting innovations in education and public policy)-ын талаар тойм үнэлгээ хийхэд, юуны өмнө, “боловсрол дахь инновац” гэсэн ухагдахууны тухай тодорхойлолтыг боловсролын бодлогын баримт бичгүүдэд хэрхэн томъёолсон байна, сургуулийн өмнөхөөс эхлээд ерөнхий боловсролын багшийн мэргэжил эзэмшүүлэх их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөр (curriculum)-т болон зааварчилгаа дүрэм (Curriculum & Instruction)-д, мөн инновацын тодорхойлолт дагуу багшийн гарын авлага, сурах бичигт ямар өөрчлөлт шинэчлэл 2006 оноос хойш гарав гэдгийг баримтжуулах шаардлагатай байв.

Түүнээс гадна, сургуулийн өмнөх боловсролын сургалтаас эхлээд ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын практик, туршлагад, жишээлбэл, “Байгалийн ухаан, Технологи, Инженер, Хүмүүнлэгийн ухаан, Математик (БуТИХуМ)” [Science, Technology, Engineering, Arts, and Mathematics (STEAM)] мэт сургалтын тодорхой арга зүй нэвтрүүлэх төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн эсэх, энэ үед сургалтын агуулгын прагматик, академик түвшинд ямар ахиц гарч, нөлөөт үр дүн (impacts) нь юу байсан тухай судалгаа үнэлгээний тайлан зэрэг мэдээ баримт хэрэгтэй. Энэ нь тусгайлсан ийм зорилго бүхий үнэлгээний ажил тул хугацаа шаардлагатай байлаа. Багш мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдэд энэ чиглэлийн магадлан итгэмжлэлт хийх ажил эхлэл төдийн байна.

Үндэсний, бус нутгийн болон олон улсын хэмжээн дэх үйл хэргийн хөтөлбөрчилсэн төлөвлөгөө болох асуудлуудтай нийцүүлсэн бодлого, төлөвлөлтдөө хэрэглэж буй олон сектор дундын хамаарал тооцогч арга хандлагууд (Inter-sectoral approaches towards policy and planning, aligned with national, regional and international agendas), Тогтвортой хөгжлийн (ТХ) асуудлаар Монгол Улсын хөгжлийн талаар баримтлах тулгуур болон төрөөс баримтлах байгаль орчин, боловсролын талаар баримтлах баримт бичгүүдэд хэрхэн тусгаж ирсэн талаар доор дурдъя.

2016 оны Байгаль орчин, аялал Жуулчлал, Ногоон хөгжлийн яамны (БОНХАЖЯ) “Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжлийн эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлвийн суурь судалгаа”-нд манай улсын байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлогын баримт бичгүүдэд ТХ-ийн асуудал шууд болон дам байдлаар тусгагдаж ирснийг дурдсан байна. Жишээлбэл, “Бүх нийтийн экологийн боловсрол үндэсний хөтөлбөр” (1998-2003)-ийг ЗГ-аас батлан, албан ба албан бус сургалтын хөтөлбөр, олон төрлийн үйл ажиллагааг тусган амжилттай хэрэгжүүлжээ (БОНХАЖЯ, 2016). Мөн УИХ-аас 2014 онд баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын боловсролтой холбоотой хэсэгт ТХ, Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ын үзэл санаа, гол агуулга нь тодорхой тусгагдсан байна (БСШУСЯ, 2018).

Дээр дурдсан БОНХАЖЯ (2016) судалгаанд боловсролын салбар болон дэд секторын сургалтын бодлогын түвшинд гарсан “Бага, дунд боловсролын стандарт ба кикриклүмийг шинэчлэх үзэл баримтлал”, “Бага, дунд боловсролын стандарт”, “12 жилийн сургалттай ЕБС-ийн сургалтын үндэсний болон цөм хөрөлбөр”, СӨБ-ын түвшинд “Сургуулийн өмнөх боловсрол-1,2 Үндэсний хөтөлбөр”, СӨБ-ын сургалт, бодлого (2007, 2013), Бага дунд боловсролын түвшинд “Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам (2008)” зэрэг бодлогын баримт бичгүүдэд ТХ-ийн асуудлууд бол шууд болон дам байдлаар тусгагдаж ирснийг дурдсан болно. Түүнчлэн, дээд боловсролын түвшний “Бакалаврын боловсролын стандартын үлгэрчилсэн загвар (2002)”, “Магистр, докторын сургалт эрхлэх журам (2014)”, “Бакалаврын сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага (2014)” зэрэг баримт бичгүүдэд ТХ-ийн үзэл санаа, агуулга тодорхой хэмжээгээр тусгагдаж ирсэн байна (БОНХАЖЯ, 2016).

Түүнчлэн, 2015 онд БСШУЯ-аас баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг тусган хэрэгжүүлэх үндсэн чиглэл, шаардлага” гэсэн бодлогын баримт бичигт ТХ-ийн агуулга, боловсролын үзэл санаа тодорхой тусгагджээ.

Сектор дамнасан хандлага бүхий бодлого, төлөвлөлтийн хувьд Монгол Улсын ЗГ-ын 2016 онд баталсан “Ногоон эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд “Ногоон хөгжлийн бодлого”-ын хүрээнд тусгасан Тогтвортой хөгжлийн боловсрол (ТХБ)-ын талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг БОНХАЖЯ, БСШУЯ, олон улсын байгууллагууд хамтран хэрэгжүүлэхээр заасан байна (БСШУСЯ, 2018).

Мөн МУ-ын Засгийн газар 2 үе шаттайгаар 5 жилийн хугацаанд (2018-2022 он) хэрэгжүүлэх “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”-ийг 2018 онд батлан гаргаж, сектор дамнасан бодлого, ТХЗ-4 зорилтын хүрээнд хүрэх түвшин, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн, хариуцах байгууллага болон гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлжээ. Тус хөтөлбөр нь ТХБ-ын үзэл баримтлалыг хэрэгжүүлэх чиглэлээр бүх салбарын бодлого, хөтөлбөрийн уялдаа холбоог сайжруулах, салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар бүх нийтэд байгаль орчноо хамгаалах, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах хэрэглээний соёл, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх ТХ-ийн боловсрол эзэмшүүлэх зорилготой юм (МУ Засгийн газар, 2018).

Энд бид “Монгол Улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр МХ-21” (Засгийн газрын 1998 оны тогтоол), “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого” (2008, УИХ, 13 дугаар тогтоол), “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” (2006, УИХ-ын 19 дүгээр тогтоол) зэрэг олон баримт бичгийг “Орчлын нэгдэнг түргэн үнэлгээ [Rapid Integrated Assessment (RIA)-version 10 may 2016]” хэмээх туслах зааварчилгаа зөвлөмжийн дагуу боловсруулсан эсэх тухайд, өөрөөр хэлбэл, олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэмжээний баримт бичгүүд хоорондоо хэрхэн нийлэмжтэй байгаа тухайд авч үзэх боломжтой ч энэ нь ач холбогдолгүй гэж үзлээ. Учир нь эдгээр баримт бичгийн заримынх нь хэрэгжилтийн хугацаа дууссан, зарим нь хэрэгжих шатандаа байв. Харин эдгээр баримт бичигт дэвшүүлсэн бодлого (policies), хөгжлийн зорилго (goals), товлосон зорилтууд (targets)-ын хэрэгжилтийн талаар явцын үнэлгээний илтгэл тайлан, мэдээ баримт олоогүй болно. Харин энд олоогүй баримт бичгүүд болон энэ тухайд тусгайлан судалгаа үнэлгээг одоо манай улсад ЗГ-ын тохируулагч агентлаг ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР “Нотолгоонд суурилсан хөгжлийн төлөвлөлт хийх, үр дүнг хянах арга зүйг Монгол улсад нутагшуулсан чиглэлээр хэрэгжүүлсэн үр дүнг хэлэлцэх” Шалтгаалцлын логик зөв эсэхийг шалгах тохирцын үнэлгээ (validation)-ний судалгаа хийж байна, эцэслэсэн үр дүнгээ албажуулаагүй тул энэ ажилтай танилцах боломж байсангүй. Энэ судалгаа үнэлгээний ажил бол боловсролын шинэ мастер төлөвлөгөө боловсруулах, мөн үүнтэй адил бусад үндэсний хэмжээний сектор дамнасан бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа боловсронгуй болгоход онцгой чухал ач холбогдолтой.

### 2.8.3. Дүгнэлт, Зөвлөмж

2006-2016 оны хоорондох арван жилийн хугацааны хувьд Монгол Улсын боловсролын секторын хөгжил, өөрчлөлтийн заалтуур (indicators), үндсэн үзүүлэлтийн статистик өгөгдөл (main statistical characterizing data), бодлогын болон эрх зүйн баримт бичиг, олон улсын болон дотоодын мэргэжлийн байгууллагын судалгаа, хяналт-шинжилгээ үнэлгээ, дүгнэмж, мөн боловсролын сектор болон дэд сектор дамнасан бодлого, төлөвлөлтийн талаар зарим сэдэвчилсэн судалгаа баримтаар цуглуулсан өгөгдөлд үнэлгээний зохих арга зүйгээр задлан шинжилгээ хийсэн дүгнэмжийг дараах байдлаар хураангуйлан нэгтгэв. Хураангуйлахдаа дараах зурагт үзүүлсэн 5 аспектээр авч үзэв.

*Зураг 2.8.3. Сектор дамнасан арга хандлага бүхий бодлого, стратеги боловсруулалт, төлөвлөлт, хэрэгжилтийн тухай авч үзсэн таван аспект-чиглэл*



## Дүгнэлт

### *Бодлого, Стратеги (Policy and Strategy):*

- Сектор дамнасан бодлого, стратеги гэдэг нь тухайн хөгжлийн асуудлыг авч үзэж шийдвэрлэхээр тухайн асуудлыг эрхэлдэг сектор нь өөрийн бүхий л талбар, дэд сектороор нь хамарч, холбогдох бусад секторууд, тэдгээрийн албан болон албан бус бүтцүүдийн бодлого стратегитэй уялдуулан гаргасан шийдэл, түүнийг хэрэгжүүлэх зарчим, арга зам юм.
- Тухайлбал, боловсрол нь хүний хөгжлийн асуудлыг эрхэлдэг учраас боловсролын сектор дамнасан бодлого, стратеги нь СӨБ-оос эхлээд насан туршийн боловсролын бүх дэд секторын хөгжлийн залгамж холбоог хангасан байхаар, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, байгаль орчин, харилцаа холбоо, материаллаг үйлдвэрлэл зэрэг бусад секторын хөгжлийн бодлого, стратегитэй нягт уялдуулсан байхаар, тэдгээрийн хэрэгжилтэд гадаад, дотоодын сонирхолын болон хувь хүртэгч бүх талуудыг оролцоог дайчилсан байхаар тус тус салбарынхаа хөгжлийн суурь шийдлүүдийг интеграцилан тов тодорхой томъёолж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд баримтлах ёс зүйтэй, эрсдэл багатай, шударга байх зарчмууд, арга замуудыг сонгосон байх шаардлагатай.
- Сектор дамнасан бодлого, стратегийг тодорхойлж, дунд ба урт хугацааны төлөвлөлт хийхдээ “Сектор дамнасан арга хандлага” (Sector wide Approach) гэсэн тусгай арга зүй, арга техникийг хэрэглэдэг бөгөөд сектор дамнасан бодлого, стратегийн хэрэгжилтийг үнэлэхэд ч үнэлгээний тусгай арга зүй шаардагддаг онцлогтой.
- Сектор болон дэд сектор дамнасан иж бүрдэл бодлого, стратеги боловсруулалт, төлөвлөлт нь мөн чанараараа нарийн нийлмэл динамик үйл явц бөгөөд энэ төрлийн баримт бичгүүдэд бол Монголын боловсрол, шинжлэх ухааны салбарын хувьд 2006-2015 онд хэрэгжүүлсэн “Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”, мөн “Монгол Улсын Шинжлэх Ухаан Технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” юм (БОНХАЖЯ, ШХА (SIDA) 2016. “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлвийн суурь судалгаа” Н.Нэргүй, Э.Шинэцэцэг бусад) багтаж байна.
- Сектор дамнах гэдэг бол явцуу утгаараа сектороо бүхий л талбараар нь, дэд секторуудээр нь хамрах гэсэн агуулга бүхий нэр томъёо. Гэхдээ бодит байдал дээрээ боловсролын секторын тухайд шууд холбогдох бодлого тодорхойлоход зайлшгүй байж болзошгүй дутагдал доголдлыг хэрэгжилтийн явцад илрүүлж засах зорилгоор явцын үнэлгээ тусгайлан хийсэн тухай баримт бичиг боловсролын хөгжлийн мастер төлөвлөгөөний хувьд гэхэд л байсангүй.
- Сектор дамнасан арга хандлагат бодлого боловсруулалт, төлөвлөлт нь Монгол Улсын бага дунд боловсролын хүртэц-хүртээмжийг өргөтгөн нэмэгдүүлэх стратеги сонголт, боловсруулалт, хэрэгжилтэд эерэгээр нөлөөлсөн. Харин ерөнхий боловсролын болон түүний дараах үе шат-түвшний боловсролын чанарын ахиц дэвшлийн заалтуур үзүүлэлт бүхий тусгай нарийвчилсан судалгаа, үнэлгээний албажуулсан баримт бичиг байсангүй. Энэ чиглэлийн судалгаа үе үе хийж, цаашид төлөвшил болговол зохино.
- Сектор дамнасан арга хандлага бол Сангийн яам, төрийн захиргааны бусад холбогдох төв байгууллага, Сургалтын төрийн сан, мөн ивээн тэтгэгч болон хамтран ажиллагч бүх түвшний төрийн болон төрийн бус олон байгууллага, агентлаг зэрэг санхүүжүүлэгч, хоршигч (co-operation), дэмжигч талуудын зүгээс бодлого төлөвлөлт болон стратеги боловсруулалтад, ялангуяа, хэрэгжилтэд улам илүү идэвхтэй оролцох, энэ орчил үйл явцад үзүүлэх эерэг нөлөөллийг дэмжих сайн талтай ч, энэ нь заримдаа саад бэрхшээл учруулж болзошгүй байдаг. Энэ талаар ямар нэгэн дүгнэмж, зөвлөмж өгөх боломж байсангүй. Цаашид, ялангуяа, секторын хөгжлийн мастер төлөвлөгөө шинээр боловсруулах явцад онцлох бүлэг (focus groups)-ийн болон зорилтот бүлэг (target groups)-ийн хэлэлцүүлэг судалгаа, онлайн болон бусад төрлийн асуумж үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай.
- Боловсролын сектор дэх жендэрийн “үл алагчлах шударга байдал буюу тэгш боломжийн шударга хангац (equity) ба инклюзив буюу хүн бүрийн боловсролын тусгай онцлох хэрэгцээтэй (inclusion)” тус тус холбогдох асуудлын шийдлийг бодлого төлөвлөлтийн болон менежментийн үйл ажиллагаанд тооцох, хэрэгжүүлэх стратегиа сайжруулах зорилгоор нарийвчилсан, тусгайлан гүйцэтгэсэн жендэрийн стратегийн задлан шинжилгээ-анализ 2006-2016 оны хугацаанд хийгээгүй байна.
- Боловсролын “Менежмент, Мэдээллийн Систем (Management and Information Systems)”-ийн үр өгөөжтэй хэрэглээ, хяналт-шинжилгээ, мөн явцын үнэлгээний түлхүүр заалтуур



үзүүлэлтийн ашиглалт боловсролын бүх шатны захиргааны болон мэргэжлийн байгууллагын удирдлагын түвшин дэх бодлого, төлөвлөлтийн болон шийдвэр гаргах үйл ажиллагаанд нь хэр нэвтэрч байгаа тухай мэдээлэл одоогоор олдоогүй байна.

*Төр засгийн манлайлал, Эзэмшилт эрх бүрдэмж (Government Leadership and Ownership)*

- Сектор дамнасан арга хандлагыг нь улс төрийн түвшинд хүлээн авч дэмжиж буй үүрэг амлалт, төр засгийн хүчтэй манлайллын талаар тусгайлан хийсэн судалгаа үнэлгээний баримт олсонгүй, цаашид ийм судалгаа шаардлагатай.
- Сектор дамнасан арга хандлагыг байнга дэмжих, тасралтгүй хэрэглэх үйл хэрэг төрийн захиргааны бүх түвшин дэх түлхүүр албан тушаалтан–яамдын (нэн ялангуяа, Сангийн яамны) төрийн нарийн бичгийн дарга нараас эхлээд газар хэлтсийн дарга нар ороод бусад захиргааны бүх байгууллагын удирдлага дарга нарын мэдлэг, туршлагаас ямар хамааралтай байгаа талаар онцолж тусгайлан хийсэн судалгаа үнэлгээний баримт олсонгүй, цаашид ийм судалгаа шаардлагатай.

*Санхүүжилтийн хамааралт арга хэрэгсэл, Төрийн зардлын менежмент (Financing Modalities and Public Expenditure Management)*

- Төрийн стратегийн бодлого, төлөвлөлтөд сектор дамнасан арга хандлагыг бүрэн хэрэглэхэд шилжих явцад санхүүжилтийн нөхцөлдөөн, уян хатан сэлгэмэл арга хэлбэр, гаднаас өгч буй тусламж дэмжлэгийг төрийн төсвөөр дамжуулах механизм нь ахиц дэвшилттэйгээр боловсронгуй болж байгаа эсэхийг илрүүлсэн тусгай судалгаа, үнэлгээний тайлан баримт олоогүй. Ийм судалгааны боловсролын хөгжлийн мастер төлөвлөгөө шинээр боловсруулахад зайлшгүй чухал.
- Монголын хувьд төрийн стратегийн бодлого, төлөвлөлтөд “Сектор дамнасан арга хандлага (SWAp)” бүрэн нэвтрэх шилжилтийн хурдац, ажлын чанар нь төр засгийн зардал төсөвлөлт удирдлагын чадавхаас хэрхэн хамаарч байгаа тухай тусгай мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн судалгаа, зөвлөмж бүхий баримт бичиг олсонгүй. Ийм судалгаа нь боловсролын хөгжлийн өмнөх мастер төлөвлөгөө хэрхэн хэрэгжив, дутагдал доголдол байгаа бол ямар шалтгаанаар гэдгийг илрүүлэхэд шаардлагатай бөгөөд энд секторууд хоорондын хамтрах (collaboration), хорших (co-operation), түншлэх (partnership) үйлийн чанар бол секторууд дамнасан үйл ажиллагаа төлөвлөлтийн тогтолцооны чадавхаас хамаарна, энэ хүчин зүйлийн нөлөөлөл ямар байна гэдгийг тодруулах нь шинэ мастер төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, энэ нь шинэ “Мастер төлөвлөгөө”-г бодит үр дүн (relevance) болгох хэрэгжилтийн төлөвлөгөө (implementation plan) боловсруулахад шаардлагатай. Тухайлбал, баталсан мастер төлөвлөгөөгөө бодит ажил эцсийн үр дүн болгохын тулд гүйцэтгэлийн явцад тохиолдох хүндрэл бэрхшээлийг тухайн үед нь шийдэх, түлхүүр товлосон зорилтуудаа хэрэгжүүлэх нэмэлт үйл ажиллагаа, арга хэмжээ, санхүүгийн болон бусад шаардлагад нөөц хуваарилалтын онцлог болон бүхэлдээ тогтолцооны тойм үнэлгээ тусгасан, нарийвчилсан цаг хугацаатай үйлийн график төлөвлөгөө боловсруулахад хэрэгтэй.
- Монголын хувьд төрөөс боловсролын талаар баримталж буй стратегийн бодлого, төлөвлөлтөд сектор дамнасан арга хандлага хэрэглэх болон төрийн байгууллагын төсөв зардал тооцоолох программ хангамж байгаа эсэх, байгаа бол шинэчлэх шаардлагатай эсэхийн судалгаа хийгдээгүй байгаа юм байна. Хийх хэрэгтэй.
- Боловсролын хөгжлийн мастер төлөвлөгөө хэрэгжүүлэхэд гадаад улс орноос буцалтгүй тусламжаар дэмжсэн хөрөнгө мөнгийг улсын төсвөөр дамжуулсан арга механизм хэрхэн үр ашиг (efficiency)-тай, үр өгөөж (effectiveness)-тэй байсан талаар судалгаа алга, энэ нь бас хэрэгтэй.
- Боловсролын сектор дамнасан иж бүрдэл стратеги дахь түлхүүр товлосон зорилтуудаар хүрсэн сайн үр дүнг болон нөөцүүдийн үр ашиг (efficiency)-тай, цаашилбал, үр өгөөж (effectiveness)-тэй ашиглалтыг урамшуулах зорилгоор тусгайлан хэрэгжүүлсэн санхүүжилтийн болон ажлын хөлсний нэмэлт төлбөрийн чиглэлээр ямар үүрэг амлалт байв, гэх мэт урамшууллын арга хэмжээг төрөөс хэрэгжүүлсэн бол үр ашиг болон үр өгөөжийн үнэлгээ судалгааны баримт, илтгэл тайлан олоогүй. Мастер төлөвлөгөө боловсруулахдаа энэ чиглэлээр нэмэлт судалгаа шаардлагатай.
- Боловсролын сектор дамнасан үйлийн стратеги төлөвлөлтийн хувьд “Зарлагын мөшгөх судалгаа болон хөндлөнгийн үнэлгээ” (Expenditure tracking and Audit)-ний тогтолцоогоор нөөцийн үр өгөөжтэй ашиглалт, үр дүнтэй сектор дамнасан төлөвлөлтөд тус болохуйц

- судалгаа үнэлгээ хийлгэж, зөвлөмж өгсөн тайлан баримт олоогүй, цаашид ийм үнэлгээ байнга, үе үе хийх хэрэгтэй, учир нь энэ бол гадаад, дотоодын санхүүжүүлэгч байгууллага, хуулийн этгээдийн зүгээс баттай итгэл үнэмшил хүлээх, мөн олон сектор оролцсон, хамтарсан, хоршсон, түншилсэн ажил үйлийн тэргүүлэх чиглэлийг эрэмбэлэхэд тус дэм болох чухал үйл ажиллагаа болно.
- Дээрх төрлийн судалгаа үнэлгээ хийлгэж байх явдал нь санхүүжүүлэгч байгууллагуудын “дунд хугацааны үүрэг амлалт (medium-term agency funding commitments)” болон санхүүжүүлэх үр дүнтэй механизмын талаар байнга, цаг үеэ олж хэлэлцэх, сектор болон дэд сектор хоорондын, бас дамнасан үйл ажиллагааг уялдуулах, зохицуулах арга хэрэгсэл учир ийм зохицуулалт, хэлэлцүүлгийн баримт хэрэгтэй байв, гэвч олоогүй. Нөөцийн улам илүү тогтвортой, үр ашигтай, үр өгөөжтэй хуваарилалтын манай туршлага нь донор-улс орнуудын зүгээс Монголын Засгийн газарт хандах, хамтрах сонирхол, донор урсгалыг бэхжүүлэх учир боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулах, дутагдсан санхүүжилт хайх болон симуляц тооцоолол хийхэд анхаарах асуудал юм.
- Сектор дамнасан үйл төлөвлөлт, хэрэгжилтийн үйл явц, төлөвлөгөөний түлхүүр зорилтуудын завсрын үр дүнгийн үзүүлэлтийн талаар Сангийн яамтай хамтрах үр ашигтай түншлэл, хамтын зохицуулалтын зорилтот хэлэлцүүлэг, хяналтын уян хатан механизм сонголт, боловсруулалтын тухай, цаашилбал, ийм түншлэл, зохицуулалт боловсролын секторын түвшинд улсын болон орон нутгийн төсөв дэх зарлагын хуваарилалт, гүйцэтгэлийн явцад үр ашиг, үр өгөөжийн хувьд хэрхэн нөлөөлж байсан талаарх судалгаа, үнэлгээний баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх “Секторын орчлын нэгдсэн үнэлгээ (Education Sector Assessment)” хийхэд энэ бол анхаарах чухал хүчин зүйл болно.

*Зохицуулалт, Түншлэл (Co-ordination and Partnership)*

- Сектор дамнасан бодлого, төлөвлөлт, стратеги боловсруулалтын үед, ялангуяа, хэрэгжүүлэх явцад түншлэгч талууд харилцан хүлээсэн үүрэг амлалтын биелэлтэд гарч мэдэх болзошгүй эрсдэлүүдийг ил тод хэлэлцэн хамтын ажиллагааны шинэ арга хэрэгсэл хэрэглэсэн, хэрэглэсэн бол үр ашиг, үр өгөөжийн судалгаа, үнэлгээ тусгайлан хийсэн тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх секторын орчлын нэгдсэн үнэлгээ (СОНУ) хийхэд энэ нь анхаарах ёстой чухал хүчин зүйл болно.
- Сектор дамнасан бодлого, төлөвлөлтийн илүү амжилттай хэрэгжилтэд нөлөөлөх хүчин зүйлүүд бий. Тухайлбал, санхүүжүүлэгч байгууллагууд, донор гадаадын болон дотоодын байгууллагууд хөгжлийн “урт хугацаанд хүрэх хүслийн хүрэх зорилго (longer-term vision)”-ын талаар нэгдсэн ойлголттой болох үүднээс санал хуваалцах, ерөнхий арга хандлагаа зөвшөөрөлцөх явдал юм. Энэ чиглэлээр тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний илтгэл тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйлийн нэг нь бас мөн.
- Сектор дамнасан бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн явцад зохицуулалт, түншлэл болон секторын менежментийн механизмыг харилцан зөвшөөрөлцөх үйл хэрэгжүүлсэн, хэрэгжүүлсэн бол энэ чиглэлээр тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйл болно.
- Сектор дамнасан бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлэлт гүйцэтгэснээр хэсэгчилсэн хөтөлбөр, төслийн арга хандлагаас төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үйл явцын задлан шинжилгээ, тохиролцоо хэлэлцээрийн арга хандлага нэвтрүүлэх ерөнхий тогтолцоонд шилжих үе шатуудад “тохиролцоо хэлцлийн зардал” (transaction costs) багассан эсэх, ингэж шилжсэний сул давуу тал, сургамж, шийдэх ээдрээт асуудлын талаар тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйл болно.
- Засгийн газраас, бас санхүүжүүлэгч байгууллагуудын зүгээс сектор дамнасан бодлого боловсруулалтад төрийн бус байгууллагуудын, мөн хувийн хэвшлийн секторын болон боловсролын үйлчилгээ хэрэглэгчдийн оролцоог хангадаг бол үүний үр өгөөж, сургамж, шийдэх ээдрээт асуудлыг тодруулах үүднээс энэ сэдвээр, чиглэлээр тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйл болно.

*Ядуурал бууруулалт, Улам өргөн хүрээт санаачилга (Poverty Reduction and Wider Initiatives)*

- Монгол Улсын хувьд сектор дамнасан арга хандлага нь “Нийгэм, Технологи, Эдийн засаг, Хүрээлэл орчин, Улс төр (Social, Technological, Economical, Environmental, Political-STEER)”-ийн хүчин зүйлээс хэрхэн хамаарч ахиц дэвшилт байгаа, эсэх тухай мөн удирдлагын реформын өргөн хүрээний сайн санаачилгатай хэрхэн уялдаатай болж байгаа талаар тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний илтгэл тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйл болно.
- Сектор дамнасан арга хандлага нь боловсролын төлөвлөлт, удирдлагын “Төвлөрөл сааруулалт (decentralization)”-тай хэрхэн уялдсан, илэрсэн сул давуу талууд, цаашдын сургамж болон шийдэх ямар ээдрээт асуудал байгаа тухай тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйл болно.
- Монгол Улсын хувьд “Ядуурлыг бууруулах стратеги (Poverty Reduction Strategies)” нь сектор дамнасан бодлого болон төрийн зардал хуваарилалттай хэрхэн уялдсан, боловсролын секторын хөгжлийн стратеги бодлого, төлөвлөлтөд хэрхэн тусаж хэрэгжиж байгаа талаар тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйл болно.
- “Боловсролд зориулсан нөөц (Resources allocated to education)” жилээс жилд сектор дамнасан арга хандлагаар хийсэн боловсролын хөгжлийн стратеги (мастер) төлөвлөгөөний дагуу нэмэгдсэн байдал, өсөлт нь ядуурлыг бууруулах стратегитай нийцсэн байдал, ядуучуудын ашиг сонирхолд үйлчилсэн байдал, ялангуяа, суурь боловсролын хүртээц буюу хүртээмж, тэгш боломжийн шударга хангац буюу үл алагчлах байдал (access and equity)-ын заалтуур үзүүлэлтийн ахиц дэвшлийн тухай тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйл болно.
- Монголын хувьд сектор дамнасан арга, хандлагад баримт бичиг буюу “Боловсролын хөгжлийн мастер төлөвлөгөө (2006-2015 он) болон “Ядуурлыг бууруулах Стратегийн баримт бичиг (PRSP-Poverty Reduction Strategy Papers)” нь “илүү өргөн хөгжлийн санаачилга (wider development initiatives)”, ялангуяа “Мянганы Хөгжлийн Зорилго (the Millennium Development Goals), “Бүх Нийтийн Боловсрол”-ын зорилгод хүрэх үндэслэл болж тэдгээрт хэрхэн чиглэсэн байдал, энд санхүүжүүлэгч түнш байгууллагуудын зохицуулагч үүрэг роль, үр өгөөжийн байдал, мөн ЮНИСЕФ (UNICEF)-ээс хүүхдийн эрх, жендэрийн тэгш боломжийн шударга хангац (gender equity) зэрэг чиглэлээр авсан дэмжлэг боломжийн ашиглалт, үр өгөөжийн талаар, түүнчлэн сектор дамнасан бодлого, төлөвлөлтийн арга хандлага хэрэгжиж буй байдал, нэвтрэлтийн үе шатны үнэлгээ зэргээр тусгайлан хийсэн судалгаа, үнэлгээний тайлан баримт олоогүй. Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхэд энэ нь анхаарах чухал хүчин зүйл болно.

**Зөвлөмж**

- ЗГ-ын сонгуулиас сонгууль дамжих үед, өөрөөр хэлбэл, урт хугацаанд ягштал баримтлах “Сектор дамнасан арга хандлага (SWAp)” бүхий хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хувьд бүх улс төрийн хүчин хүлээн зөвшөөрч тохиролцсон “Ногоон”, бас “Цагаан” (Green and White paper) баримт бичгийг зохих арга зүйгээр нь хэлэлцэн боловсруулж, тэдгээрийгээ хуульчлан баталж хэрэгжүүлэх шаардлага манай улсын хувьд байна.
- Үндэсний боловсролын секторын түвшинд “Тогтвортой Хөгжлийн Зорилго-4”-ийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхүйц, нотолгоонд суурилсан, үр дүнд чиглэсэн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх мэргэшсэн мэргэжилтнүүд (1)-ийн болон орон нутгийн удирдах байгууллага нь тэргүүлэх үүргийг гүйцэтгэж чадах, боловсролын секторын хөгжил төлөвлөх, улмаар хэрэгжүүлэх, зохицуулах, мониторингийн ажлыг тухайн орон нутгийн түвшинд гүйцэтгэх удирдлага (2)-ын чадавхыг бэхжүүлэх хэрэгцээ гарч байна.
- Боловсролын хөгжлийн шинэ мастер төлөвлөгөө боловсруулахын өмнөх СОНУ хийхдээ сектор дамнасан бодлого, төлөвлөлтийн дүгнэлт хэсэг дэх тодорхой дурдсан тусгай зориулалтын нэмэлт судалгаа үнэлгээний дүгнэлт зөвлөмж зайлшгүй хэрэгтэй.

- Бүх хөтөлбөрийг хамтад авч үнэлэх, ер нь, цаашид Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”, гэх зэрэг олон баримт бичгийг “Орчлын нэгдсэн түргэн үнэлгээ [Rapid Integrated Assessment (RIA)- version 10 may 2016]” дагуу боловсруулсан эсэх тухайд, өөрөөр хэлбэл, олон улсын, бүс нутгийн болон үндэсний хэмжээний баримт бичиг хоорондоо хэрхэн нийлэмжтэй байгаа тухайд тусгайлан авч үзэх хэрэгтэй.
- Хэрэгжилтийн төлөвлөгөө боловсруулах ялангуяа, шинэ аливаа “бодлого, төлөвлөгөө”-г бодит үр дүн болгох хэрэгжилтийн төлөвлөгөө (implementation plan) боловсруулж гүйцэтгэх үйл хэвшүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, баталсан аливаа төлөвлөгөөгөө бодит ажил гүйцэтгэл болгохын тулд энэхүү гүйцэтгэлийн явцад тохиолдох хүндрэл бэрхшээлийг тухайн үед нь шийдэх, түлхүүр товлосон зорилтуудаа хэрэгжүүлэх нэмэлт үйл ажиллагаа, арга хэмжээ, санхүүгийн болон бусад шаардлагад нөөц хуваарилалтын онцлог, бүхэлдээ тогтолцооны тойм үнэлгээ тусгасан, нарийвчилсан цаг хугацаатай үйлийн график төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.
- Бүх шатны боловсролын байгууллагууд хяналт-шинжилгээний үр дүнгээ аливаа тогтолцоот үйлийн төрөл бүрийн “Явцын үнэлгээ”-ндээ тогтмол хэрэглэж хэвших, эдгээрийг үндэсний хэмжээнд нэгтгэж дүгнэдэг тогтолцоог байнга боловсронгуй болгож байх шаардлага байна.

## НОМ ЗҮЙ

**Монгол хэлээр:**

- БНМАУ-ын Ардын Их Хурал (1992). *Үндсэн хууль*. УБ.
- УИХ. (1994). *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль*. УБ.
- УИХ. (1999). *Хөдөлмөрийн тухай хууль*. УБ.
- УИХ. (2002). *Бага, дунд боловсролын тухай хууль*. УБ.
- УИХ. (2002). *Боловсролын тухай хууль*. УБ.
- УИХ. (2002). *Дээд боловсролын тухай хууль*. УБ.
- УИХ. (2002). *Сургуулийн өмнөх боловсролын тухай*. УБ.
- УИХ-ын 13 дугаар тогтоол. (2003). *Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам*. УБ.
- УИХ-ын 25-р тогтоол. (2005). *«Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудыг батлах тухай»* УБ.
- УИХ. (2007). *Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө*. УБ.
- УИХ-ын 35 дугаар тогтоол. (2008). *“Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр*. УБ.
- УИХ-ын 12 дугаар тогтоол. (2008). *Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого*. УБ.
- УИХ. (2009). *Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай*. УБ.
- УИХ-ын 37 дугаар тогтоол. (2012). *ЗГ-ын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр*. УБ.
- УИХ-ын 12 дугаар тогтоол. (2015). *Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024 он)*. УБ.
- УИХ. (2015). *Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль*. УБ.
- УИХ-ын 45 дугаар тогтоол. (2016). *ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр*. УБ.
- УИХ-ын 19 дүгээр тогтоол. (2016). *Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай*. УБ.
- УИХ. (2016). *Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030*. УБ.
- УИХ. (2017). *Төрийн албаны тухай (шинэчилсэн найруулга)*. УБ.
- УИХ. (2018). *Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр*. УБ.
- ЗГ -ын 116 дугаар тогтоол. (1997). *Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай*. УБ.
- ЗГ -ын 244 дүгээр тогтоол. (2004). *Бичиг үсгийн үндэсний хөтөлбөр батлах тухай*. УБ.
- ЗГ-ын 216 дугаар тогтоол. (2005). *Цахим Монгол үндэсний хөтөлбөр*. УБ.
- ЗГ-ын 192 дугаар тогтоол. (2006). *Монгол Улсын Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө*. УБ.
- ЗГ -ын 219 дүгээр тогтоол. (2007). *Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь хэмжээг тогтоох тухай*. УБ.
- ЗГ-ын 354 дүгээр тогтоол. (2007). *Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай*. УБ.
- ЗГ. (2008). *Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр*. УБ.
- ЗГ-ын 54 дүгээр тогтоол. (2008). *Төрийн өмчит ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох журам*. УБ.
- ЗГ-ын 31 дүгээр тогтоол. (2010). *“Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021 он)*. УБ.
- ЗГ. (2010). *Дээд боловсролын шинэчлэлийн зураглал*. УБ.
- ЗГ. (2010). *Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэл*. УБ.
- ЗГ-ын 117 дугаар тогтоол. (2011). *«Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих тухай журам»*. УБ.

- ЗГ. (2012). *2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр*.
- ЗГ-ын 180 дугаар тогтоол. (2012). *Багшийн мэргэжил дээшлүүлэх институт байгуулах тухай*. УБ.
- ЗГ-ын 106 дугаар тогтоол. (2012). *Хоолны зардлын дундаж норматив батлах тухай*. УБ.
- ЗГ-ын 295 дугаар тогтоол. (2013). *Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр*. УБ.
- ЗГ. (2009). *Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний гурав дахь илтгэл*. УБ.
- ЗГ. (2013). *Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилт, Үндэсний тав дахь илтгэл*. УБ.
- ЗГ-ын 393 дугаар тогтоол. (2013). *Улирлын ажлын үр дүнгийн урамиуулал олгох журам*. УБ.
- ЗГ-ын 71 дүгээр тогтоол. (2014). *Дээд боловсролын сургалтын суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам*. УБ.
- ЗГ-ын 105 дугаар тогтоол. (2014). *Нээлттэй боловсролын «Нэг Монгол» үндэсний хөтөлбөр*. УБ.
- ЗГ -ын 332 дугаар тогтоол. (2014). *Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишигийг шинэчлэн тогтоох тухай*. УБ.
- ЗГ-ын 346 дугаар тогтоол. (2017). *Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамиуулал олгох журам*. УБ.
- ЗГ. (2017). *Хүүхдийн хөгжил хамгааллын хөтөлбөр 2017-2021*. УБ.
- ЗГ. (2018). *Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр*. УБ.
- ЗГ -ын 382 дугаар тогтоол. (2018). *Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам*. УБ.
- ЗГ -ын 25 дугаар тогтоол. (2019). *Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай*. УБ.
- Гэгээрлийн Сайдын 259 дүгээр тушаал. (1998). *“ЕБС-ийн суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийг үнэлж дүгнэх үлгэрчилсэн журам”, “Бага, дунд боловсролын улсын шалгалтын журам”*. УБ.
- Гэгээрлийн яам. (1998). *Бага, дунд боловсролын сургалтын агуулгын талаар баримтлах чиглэл*. Засгийн газрын тогтоол, Гэгээрлийн Сайдын тушаалын эмхтгэл №6 УБ.
- Гэгээрлийн яам. (1999). *Сургалтын арга зүй*. УБ: Тоонот принт ХХК.
- БШУ-ы Сайдын 36 дугаар тушаал. (1991). *“Тасралтгүй боловсролын тогтолцооны онолын үндэслэл боловсруулах” судалгааны хамтлаг байгуулагдсан*. УБ.
- БСШУ-ы Сайдын 173 дугаар тушаал. (2001). *Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт*. УБ.
- БСШУ-ы 266 дугаар тушаал. (2002). *Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв байгуулах*. УБ.
- БСШУ-ы Сайдын 202 дугаар тушаал. (2002). *Боловсролын шинэ стандарт, кинрикулумын онол, арга зүйг таниулах, тэдгээрийг хэрэгжүүлэх үеийн арга зүй (2002-2006)*. УБ.
- БСШУ-ы Сайдын 392 дугаар тушаал. (2003). *Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт*. УБ.
- БСШУ-ы Сайдын 139 дүгээр тушаал. (2003). *Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаалын орон тоонд тавих нийтлэг шаардлага*. УБ.
- БСШУ-ы Сайдын 321 дүгээр тушаал. (2003). *Шалгуур үзүүлэлт батлах тухай журам*. УБ.
- БСШУ-ы Сайдын 280 дугаар тушаал. (2004). *“Сурах бичгийн арга зүй, менежментийг боловсронгуй болгох”* УБ.
- БСШУ-ы Сайдын 422 дугаар тушаал. (2005). *Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам*. УБ.
- БСШУ-ы Сайдын 450 дугаар тушаал. (2006). *Бага, дунд боловсролын салбарт 2015 он хүртэлх хугацаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндсэн чиглэл*. УБ.
- БСШУ-ы Сайдын 351 дүгээр тушаал. (2007). *Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт*. УБ.
- БСШУ-ы Сайдын 41 дүгээр тушаал. (2007). *ЕБС, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм*. УБ.
- БСШУ-ы Сайдын 440 дүгээр тушаал. (2007). *Улс, аймаг, нийслэлийн “Оны тэргүүний багш” шалгаруулах болзол, түүнийг дүгнэх аргачлал*. УБ.
- БСШУ-ы Сайдын 73 дугаар тушаал. (2008). *Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам*. УБ.
- БСШУ-ы Сайдын 74 дүгээр тушаал. (2008). *Багшлах эрх олгох, хасах журам*. УБ.
- БСШУ-ы Сайдын 72 дугаар тушаал. (2008). *Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам*. УБ.

- БСШУ-ы Сайдын 561 дүгээр тушаал. (2009). *ЕБС-ийн багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл*. УБ.
- БСШУ-ы Сайдын 471 дүгээр тушаал. (2010). *Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм*. УБ.
- БШУ-ы Сайдын А/136 дугаар тушаал. (2012). *Багшийн хөгжил*. УБ.
- Төрийн нарийн бичгийн даргын А/58 дугаар тушаал. (2012). *Боловсрол, шинжлэх ухааны яамны хөдөлмөрийн дотоод журам*. УБ.
- БШУ-ы Сайдын А/178 дугаар тушаал. (2012). *Насан туршийн боловсролын үндэсний төв байгуулах тухай*. УБ.
- БШУ-ы Сайдын А/315 дугаар тушаал. (2013). *Аймаг нийслэлийн боловсролын газрын үлгэрчилсэн журам*. УБ.
- БШУ-ы Сайдын А/155 дугаар тушаал. (2013). *Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, бага, дунд боловсролын үндэсний стандарт, хөтөлбөр шинэчлэх зураглал*. УБ.
- БШУ-ы Сайдын А/305 дугаар тушаал. (2013). *Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам*. УБ.
- БШУ-ы Сайдын А/299 дүгээр тушаал. (2013). *ЕБС-ийн багш ажилтны ажлыг үнэлэх дүгнэхэд баримтлах чиглэл*. УБ.
- БШУ-ы Сайдын А/293 дугаар тушаал. (2013). *ЕБС-ийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам*. УБ.
- БШУ-ы Сайдын А/242 дугаар тушаал. (2013). *Насан туршийн боловсролын тогтолцооны зураглал*. УБ.
- БШУ-ы Сайдын А/287 дугаар тушаал. (2013). *Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам*. УБ.
- БШУ-ы Сайдын А/52 дугаар тушаал. (2014). *СӨБ-ын багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах, арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох, хасахад баримтлах шалгуур үзүүлэлт батлах тухай*. УБ.
- БШУ-ы Сайдын А/112 дугаар тушаал. (2014). *Цэцэрлэгийн ажилтны ажлыг үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл батлах тухай*. УБ.
- БШУ-ы Сайдын А/220-р тушаал. (2015). *Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай*. УБ.
- БСШУС-ын Сайдын А/133 дугаар тушаал. (2016). *Ажлын хэсгийн тайлан*. УБ.
- БСШУС-ын Сайдын А/425 дугаар тушаал. (2018). *ЕБС-ийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам*. УБ.
- БСШУС-ын Сайдын А/243 дугаар тушаал. (2018). *Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн дүрэм*. УБ.
- БСШУС-ын Сайдын А/812 дугаар тушаал. (2018). *Мэргэжлийн зэрэг олгох, хасах журам*. УБ.
- БСШУС-ын Сайдын А/118 дугаар тушаал. (2019). *Хүүхдийн цэцэрлэгчийн үлгэрчилсэн дүрэм*. УБ.
- БСШУЯ, МУИС. (2001). *“Чанартай боловсрол-Хөгжлийн баталгаа” багш нарын бага хурлын илтгэл. Прагматик сургалтын хөгжлийн стратеги*. УБ.
- БСШУЯ, БСХХ. (2001). *Сургалтын менежмент*. УБ.
- БСШУЯ. (2002). *Бага, дунд боловсролын кирикулим, стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал*. УБ.
- БСШУЯ, БСХХ, ЖАЙКА. (2003). *Бага, дунд боловсролын стандартын ерөнхий зөвлөмж*. УБ.
- БСШУЯ, БХХ. (2004). *“Сурах бичгийн арга зүй, менежмент” судалгааны нэгдсэн тайлан*. УБ.
- БСШУ-ы Сайд, НХХ-ийн Сайд, Сангийн Сайдын хамтарсан тушаал 307/91/237. (2007). *Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам*. УБ.
- БСШУЯ, АХБ. (2008). *ЕБС-ийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх бодлого, төлөвлөлт, арга зам*. УБ: ЭКИМТО.
- БСШУЯ, БХ. (2010). *Боловсролын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд мониторинг хийх, орон нутгийн боловсролыг дэмжих Судалгааны тайлан (Баян-өлгий аймаг)*.
- БСШУЯ, (2010, 2011). *Үйл ажиллагааны тайлан*. УБ.
- БСШУЯ, ШХА. (2011). *Тогтвортой хөгжлийн боловсролын үзэл санааг ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын хөтөлбөрт тусгах нь*. УБ: Соёмбо принтинг ХХК.
- БСШУЯ. (2012). *2010-2012 оны үйл ажиллагааны тайлан*. УБ.

- БСШУЯ. (2012). *Сургалтад танилцуулсан БСШУЯ-ны танилцуулга: Бага, дунд боловсролын шинэчлэлийн бодлого, хэрэгжилт (2011-2018)*. УБ.
- БШУЯ. (2013). *“Цэцэрлэг, сургууль, дотуур байр, спорт заалны барилгыг шинээр барих хэрэгцээ шаардлага, шийдвэрлэх арга зам” судалгаа*. УБ.
- БШУЯ, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага. (2013). *Багилахуйн хөгжил багилахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент*. УБ.
- БШУЯ. (2013). *БШУЯ-ны жилийн тайлан*. УБ.
- БШУЯ. (2013). Цахим контент. <http://econtent.edu.mn>. УБ.
- БШУЯ. (2014). *“Хөдөөгийн, нүүдэлчин болон шилжин суурьшсан иргэдийн хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох” төслийн тайлан*. УБ.
- БШУЯ. (2014). Боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого, шинэчлэл 1999-2014 он. УБ.
- БШУЯ. (2014). *Ерөнхий боловсролын сургуулийн I-XII ангийн сурах бичгийн танилцуулга*. Содпресс ХХК, УБ.
- БШУЯ, ШХА. (2014). *Монгол Улс дахь Тогтвортой хөгжлийн боловсрол: Олон түвшинт судалгаа*. УБ.
- БСШУЯ. (2016). *2012-2016 оны ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан*. УБ.
- БСШУЯ. (2016). *Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр*. УБ.
- БСШУСЯ. (2017). *Боловсролын салбарын мэдээллийн систем*. <http://esis.edu.mn/>. УБ.
- БСШУСЯ. (2017). *БСШУСЯ-ны үйл ажиллагааны тайлан*. УБ.
- БСШУСЯ. (2019). *БШУЯ-ны 2006-2019 оны статистик мэдээлэл*. УБ.
- БСШУСЯ, МУБИС. (2018). *“ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрт тогтвортой хөгжлийн үзэл санаа, агуулга, арга зүй тусгагдсан байдлын судалгаа”*. УБ.
- БСШУСЯ, БМДИ, ШХА, ТХБ. (2018). *ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй*. УБ.
- БСШУСЯ, ЖАЙКА. (2018). *Монгол Улсын ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцын тайлан*. УБ: “Би Си Ай” ХХК.
- БСШУСЯ. (2018). *Тогтвортой хөгжил-СӨБ үндэсний чуулганы илтгэл*. УБ.
- БСШУСЯ. (2018). *Тогтвортой хөгжлийн боловсролыг ерөнхий боловсролын сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй-Багишийн гарын авлага*. УБ.
- БСШУСЯ, БМДИ, ШХА. (2018). *ТХБ-ыг ЕБС-ийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй*. УБ.
- БСШУСЯ, БХ. (2019). *Цөм хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа*. УБ.
- БМДИ. (2019). *БМДИ-ийн 2013-2018 оны тайлан*. УБ.
- БМДИ-ийн захирлын А/27 дугаар тушаал. (2015). *Сургалтын хөтөлбөр батлах тухай*. УБ.
- БМДИ. (2016). *“Сургалтад мэдээлэл харилцааны технологи, боловсролын нээлттэй нөөц (БНН)-ийг үр дүнтэй хэрэглэж буй СӨБ ба бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багишийг шалгаруулах үйл ажиллагаа”-ны тайлан*. УБ.
- БМДИ & Тогтвортой хөгжлийн боловсрол төсөл. (2016). *Багиш мэргэжлийн тасралтгүй «хөгжлийн хэрэгцээ» судалгааны тайлан*. УБ.
- БМДИ-ийн захирлын А/34 дүгээр тушаал. (2017). *Төрөлжсөн сургалтын хөтөлбөр батлах тухай*. УБ.
- БМДИ-ийн захирлын А/46 дугаар тушаал. (2018). *Төрөлжсөн сургалтын хөтөлбөр батлах тухай*. УБ.
- БМДИ. (2019). *Багишийн хөгжил*. <http://teacher.itpd.mn>. УБ.
- БМДИ. (2019). *Онлайн зөвлөмж*. Онлайн зөвлөмж: <http://bagsh.itpd.mn>. УБ.
- БМДИ. (2019). *Хичээлийн сайн технологи*. <http://urchadvar.itpd.mn>. УБ.
- БОНХАЖЯ. (2016). *Монгол Улсын тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжлийн эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа*. УБ.
- БОНХАЖЯ. (2016). *Суурь судалгааны тайлан*. УБ.
- БМИҮЗ. (2018). *Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргасан байгууллагууд*. УБ.
- БОМСТ, ТББ. (2018). *Экосургууль хөтөлбөрийн тайлан*.
- АХБ. (2010). *СӨБ-ын нөхцөл байдлын дүн шинжилгээ*. УБ.



- АХБ. (2014). “Боловсролын салбарын шинэчлэл төсөл”-ийн тайлан. УБ.
- АХБ. (2018). “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэмжих” төслийн судалгааны дүн. УБ.
- АББ. (1997). Хөгжлийн үндэсний хөтөлбөр. УБ.
- АХИС. (2001). СӨБҮХ үнэлгээний тайлан. УБ.
- Албан ба АББ-д зайны сургалт. (2004). Насанд хүрэгчдийн боловсролыг дээшлүүлэхэд зайны сургалтыг ашиглах онол, арга зүй, Нээлттэй сургалтын онол, арга зүй. УБ.
- ҮСХ-ны даргын 1/145 тушаал. (2013). Боловсролын статистик үзүүлэлт тооцох аргачлал. УБ.
- ҮСХ-ны даргын А/153 тушаал. “Ангиллын кодыг батлах тухай”. УБ.
- ҮСХ. (2010). Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого боловсрол, бичиг үсгийн мэдлэг. УБ.
- ҮСХ. (2018). Боловсролын статистикийн өнөөгийн байдал. УБ.
- ҮСХ. (2019). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан:www.1212.mn. УБ.
- Төрийн албаны зөвлөлийн 60 дугаар тогтоол. (2013). “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”. УБ.
- Төрийн албаны зөвлөлийн 99 дүгээр тогтоол. (2009). Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам. УБ.
- Төрийн албаны зөвлөлийн 86 дугаар тогтоол. (2013). Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэжилтний шалгалт авах журам, заавар. УБ.
- БҮТ-ийн захирлын 8 дугаар тушаал. (2006). Элсэлтийн ерөнхий шалгалтын журам. УБ.
- БХ. (2013). СБСОСС Ажлын тайлан. УБ.
- БХ. (2018). “21 дүгээр зууны Монгол суралцагчийн компетенцийн загвар” судалгааны тайлан. УБ.
- БХ. (2018). Боловсролын хүрээлэнгийн танилцуулга илтгэл. Тогтвортой хөгжил-СӨБ үндэсний чуулган.
- Дэлхийн банк. (2016). СӨБ-ын үйлчилгээний хүртээмж, чанар, хүүхдийн хөгжлийн үр дүнд хийсэн судалгаа. УБ.
- Дэлхийн Банк (2013). Монгол улс: Хөдөлмөрийн зах зээл дэх жендэрийн тэгш бус байдал, бодлогын зөвлөмж. бодлогын зөвлөмж. УБ.
- ЗХАШШүүх. (2016). Шүүхийн шийдвэр 739. УБ.
- Канадын Гадаад хэргийн яам; Азийн сан; SICA судалгааны байгууллага. (2016). Боловсролын салбарын ил тод байдал, ёс зүй, авилгын асуудал. УБ.
- МБСҮЗ, (2012). МБСҮЗ-ийн 2011 оны тайлан. УБ.
- МУБИС. (2019). “Мультимедиа программ хангамжийг сургалтад хэрэглэх, хөгжүүлэх нь” үндэсний 11 дэх уралдаан. МУБИС: <http://mnue.mn/home/read/f25b051e-78cd-4867-9311-83f27bd0f91c>
- МХЕГ. (2013). МХГ-ын үнэлгээний тайлан. УБ.
- МХЕГ. (2013). Мэргэжлийн хяналтын албаны шалгалтын тайлан. УБ.
- МХЕГ. (2014). Мэргэжлийн хяналтын газрын хяналтын тайлан. УБ.
- Мянганы сорилын сангийн ТМБ-ын төсөл. (2010). Мянганы сорилын сангийн ТМБ-ын төслийн судалгаа. УБ.
- НБГ. (2019). Төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд хийсэн үнэлгээ, шалгалтын үр дүн. УБ.
- ННФ. (2016). Дэлхийн өрсөлдөх чадварын 2016-2017 оны тайлан Монгол Улсын зэрэглэл. Нээлттэй нийгэм форум: <http://forum.mn>. УБ.
- НТБҮТ. (2019). НТБҮТ-ийн статистик мэдээ. УБ.
- НТБҮТ. (2018). НТБҮТ-ийн тайлан. УБ.
- Нээлттэй Мэдлэг Боловсролын Сан. (2018). Нээлттэй боловсролын хийгдсэн ажлуудын тайлан. УБ. (2018). “Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа”. УБ.
- Стандарт, хэмжил зүйн газар. (2008). Ерөнхий боловсролын сургуулийн сурагчийн хэвлэмэл сурах бичгийн стандарт MNS 5318:2008. [www.estandart.gov.mn](http://www.estandart.gov.mn). УБ.
- Стандарт, хэмжил зүйн газар. (2015). Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт MNS 6558: 2015. УБ.
- Стандартчилал хэмжилзүйн үндэсний зөвлөл. (2009). Дээд боловсрол, мэргэжлийн чиглэл: Ерөнхий боловсролын сургуулийн багш. УБ.

- ТХБ төсөл, БОНХАЖЯ. (2016). *Монгол Улсын ТХБ/ТХ/НХ бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлвийн суурь судалгаа*. УБ.
- ХНХСИ М.Алтансүх ба бусад. (2018). *Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа (2015-2016 оны хичээлийн жилд төгсөгчдийн мөшгөх судалгаа)*. УБ.
- ХНХЯ. (2019). *МБС-ын статистик мэдээ*. УБ.
- ХНХЯ. (2019). 2018-2019 оны *статистик мэдээ*. УБ.
- ХНХЯ. (2018). *Үйл ажиллагааны тайлан*. УБ.
- ХНХ-ын Сайдын А/179 тушаал. (2018). *Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт*. УБ.
- Хүүхэд бүрд компьютер хөтөлбөр хэрэгжүүлэх нэгж. (2011). *Хагас жилийн тайлан*. УБ.
- Хөдөлмөрийн яам. (2015). *Мэргэжлийн боловсрол, сургалтын салбарт Мянгань сорилтын сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дараагийн шатны төслийн санал*. УБ.
- Швейцарын хөгжлийн агентлаг IRIM. (2014). *Монгол Улс дахь жендэрийн эрх тэгш байдал*.
- ЭЗХЯ. (2014). “Монгол Улсын боловсролын салбарт үзүүлж буй гадаадын зээл, тусламжийн чиглэл, үр дүн нөлөөллийн судалгаа” эцсийн тайлангийн хураангуй. УБ.
- ЭМХТ. (2017). *Эрүүл мэндийн статистик үзүүлэлт*. УБ.
- ЮНЕСКО, БНБ-ын Хяналт Үнэлгээний Дэлхийн тайлангийн баг. (2014). *БНБ-ын хяналт үнэлгээний 2013/2014 оны тайлан*. УБ.
- ЯХИС. (2018). *Монгол Улс дахь хүүхдийн эрхийн нөхцөл байдлын үнэлгээ*. УБ.
- (2011). *СӨББ-ын сургалтын орчны өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан*. УБ
- Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төсөл. (2012). *Хүүхдэд ээлтэй цэцэрлэг” төслийн гарааны нөхцөл байдлын судалгаа*. УБ.
- Батхүрэл. (2013). “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн өнөөгийн байдал” илтгэл. ЭЗХЯ. УБ.
- Б.Ургамалцэцэг. (2014). *ЕБС-ийн дотуур байрны хөгжил, сургамж*. УБ.
- АХБ, Maxwell Stamp LTD (Bangladesh), & МЭК ХХК (Монгол). (2017). “Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны тайлан. УБ.
- М.Энхболд. (2012). “МБС-ын шилдэг төгсөгчдөд өргөмжлөл гардуулах ёслол”. УБ.
- Н.Багчимэг, Ч.Тамир. (2013). *Дээд боловсролын бодлогын шинжилгээ*. УБ: МУИС.
- С.Батбилэг. (2013). *Дээд боловсролын эрэлт нийлүүлэлтийн шинжилгээ*. УБ: МУИС.
- Г.Батцэнгэл. (2013). *Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах сэтгэл зүйн үндэс*. УБ: “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлж буй сэргээн засах тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх нь” эрдэм шинжилгээний онол практикийн хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ.
- С.Меянатан. (2013). *ТМБС-ын салбарын санхүүжилт*. УБ.
- Саламанкагийн тунхаглал-1994. (2014). *Тэгш хамруулах боловсрол*. ЮНЕСКО Монголын үндэсний комисс: <http://www.unesco.mn/p/48>. УБ.
- М.Мөнхбаатар, О.Дүнжиннамдаг. (2017). *Мэдээлэл, Холбооны Технологи Боловсролд. Мэдээлэл, холбооны технологи боловсролд*. УБ.
- Л.Нацагдорж нар. (2018). *Монгол орны уур амьсгал, түүний өөрчлөлт. Монгол орны байгаль орчин. I боть*. БОАЖЯ УБ: Мөнхийн үсэг.
- Ю.Алтантуяа. (2018). *Монгол Улсын боловсролын салбарт удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлж буйг судлах нь*. УБ.
- Р.Нямцэрэн, Р.Нурбек. (2018). *Орон нутаг дарь их, дээд сургуулийн өнөөгийн байдал, хөгжих хэрэгцээ. Дээд боловсролын шинэчлэл-Багшийн хөгжил*. УБ.
- Д.Цэдэвсүрэн. (2018). *Улс орны бэлэн байдлын судалгааны тайлан*. УБ.
- Н.Эрдэнэхүү. (2018). *Үр дүнд суурилсан боловсрол үндэсний хөтөлбөрийн төслийн нөхцөл байдлын шинжилгээ*. УБ: [www.researchgate.net](http://www.researchgate.net).
- Ш.Оюунцэцэг. (2019). *Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн түүх*. Багшийн мэргэжил дээшлүүлэх институт: <http://www.itpd.mn/introduction/historical>. УБ.
- Н.Норжхорлоо (PhD). (2019). “Багшийн хөгжил” сэтгүүл №1.

- Б.Алтмаа. (2019). *Сэргээн засалт, сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны тайлан 2018-2019 оны хичээлийн жил*. УБ.
- Д.Сарантуяа, & Г.Монголхаган. (УБ). *Сургуулийн өмнөх боловсролын эрх зүйн орчны баримт бичгийн түүхчилсэн судалгаа. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн төв байгууллага үүсч байгуулагдсаны 60 жилийн ойн эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл*, УБ.
- Жо Золл Кусек, Р. С. “Үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх 10 алхам. Дэлхийн банк.
- “PROCESS” төсөл. (2018). *Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцын тайлан*. УБ: Би Си Ай ХХК.
- (2006). *ЕБС, цэцэрлэгийн багшийн ажлын ачаалал, үнэлгээ*. УБ.

**Гадаад хэлээр:**

- Kuuskorpi, Marko. (2012). *Future physical learning environment. User oriented flexible and.*
- A European youth forum report. (2008). *The Sunshine report on Non-Formal Education. P. 10.*
- WB. (2016). *research on access, quality of service delivery and child development outcome in pre-school education.*
- WB, PSE. (2016). *Access, quality, outcome research results.*

## ХАВСРАЛТ

### 1.1. Сургуулийн өмнөх боловсрол

*Хавсралт 1.1.1. Мастер төлөвлөгөөнд туссан СӨБ-ын талаарх зорилтуудын хэрэгжилт 2009, 2015*

2005 Мастер төлөвлөгөөний товчлол зорилт, үр дүн	Гүйцэтгэл 2009 он	Үнэлгээ 2009 он	2015 он
1.1 Хүүхдийн цэцэрлэгийн ор/суудлын тоог 3,650 нэмэгдүүлнэ.	2005 оноос хойш 2,445 цэцэрлэгийн ор/суудал шинээр ашиглалтад орсон ба 66% биелэлттэй байна.	Зорилт хэсэгчлэн биелжээ	<b>Бүрэн биелсэн</b>
1.2 Хотын хүүхдийн 85.0 хувийг цэцэрлэгт, хөдөөгийн хүүхдийн 35.0 хувийг цэцэрлэгт хамруулна. СӨБ-ын хамран сургалтыг 99% хувьд хүргэнэ.	2009 оны мэдээгээр хотын хүүхдийн, 60.6% хөдөөгийн хүүхдийн 55% цэцэрлэгт хамрагджээ.	Зорилт хэсэгчлэн биелсэн	Зорилт хэсэгчлэн биелсэн СӨБ-ын хамран сургалт улсын дунджаар 78,1%, хотод 70,2% байна.
1.3 Хувийн өмчийн цэцэрлэгт хамрагдаж байгаа нийт хүүхдийн эзлэх хувийг 2005 оны түвшнээс 6.2 хувиар нэмэгдүүлнэ.	2009 оны мэдээгээр 6,899 хүүхэд 87 хувийн цэцэрлэгт хамрагдсан. Энэ нь нийт хүүхдийн 6.7% хувь болж байна.	Зорилт бүрэн биелсэн	<b>Зорилт бүрэн биелсэн</b> Нийт СӨБ-ын хамран сургалтад 16,7% хувийн хэвшлийн цэцэрлэгийн хүүхэд эзэлж байна.
1.4 Нэг багшид ногдох хүүхдийг 11.0-д, бүлэг дүүргэлтийг 25.0-д хүргэнэ.	2009 оны мэдээгээр хүүхэд багшийн харьцаа 12.1, бүлэг дүүргэлт 28.4 байна.	Зорилт хэсэгчлэн биелсэн	Зорилт бүрэн биелээгүй Бүлэг дүүргэлт улсын дунджаар 33,2, хотод 44,2 байна
2.1 Хотын хүүхдийн 14.0 хувь, 64.0 хувийг сургуулийн өмнөх боловсролын бусад хэлбэрийн сургалтанд хамруулна.	Хотын хүүхдийн 5.2%, хөдөөгийн хүүхдийн 22% СӨБ-ын хувилбарт сургалтад хамрагдсан.	Зорилт хэсэгчлэн биелсэн	Зорилт хэсэгчлэн биелсэн
2.2. Амьжиргааны баталгаажих орлогоос доогуур орлоготой ядуу өрхийн хүүхдийн хамрагдалтыг 2005 оны үеэс 50% нэмэгдүүлнэ.	2009 оны мэдээгээр цэцэрлэгт хамрагдаж буй хүүхдийн 8.5%, хувилбарт сургалтад хамрагдаж буй хүүхдийн 32% нь ядуу айл өрхийн хүүхэд эзэлж байна.	Зорилт биелсэн	<b>Зорилт бүрэн биелсэн</b>
2.3. Хөдөөгийн малчин өрхийн хүүхдэд зориулсан СӨБ-ын үйлчилгээ институтчлэгдсэн байна.	2008 онд УИХ-аар батлагдан гарсан СӨБ-ын тухай хуулиар СӨБ-ын хувилбарт сургалтыг хуульчилж, шаардагдах санхүүжилтийг жил тутмын төсөвт суулгаж байхыг зааж өгсөн. Жилд 2009 оны байдлаар 2.9 тэрбум төг хувилбарт сургалтын үйлчилгээнд зарцуулсан.	Эрх зүйн зорилт биелсэн  Практик зорилт хэрэгжих шатандаа явж байна.	<b>Зорилт бүрэн биелсэн</b>

2.4 Сургуульд бэлтгэх олон хувилбарт сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, хүүхэд, багш, гэр бүлд ашиглагдах гарын авлага, материалууд бий болсон байна.	ОУБ-ын байгууллагуудын хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд 4 төрлийн хувилбарт сургалтын хөтөлбөр, багш хүүхдийн ном бэлтгэж тараан ашигласан байна.	Зорилт хэрэгжих шатандаа явж байна.	<b>Зорилт бүрэн хэрэгжсэн</b> Нийт 4 төрлийн хувилбарт сургалтын хөтөлбөр, гарын авлага гарсан байна.
2.5. Цэцэрлэгийн бус сургалтыг зохион байгуулах удирдлага, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавхи бий болсон байна.	Нийт багш нарын 52% хувилбарт сургалтыг зохион байгуулах сургалт арга зүйн чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.	Хэрэгжих шатандаа явж байна.	<b>Зорилт бүрэн хэрэгжсэн</b>
3.1. Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийн нийгмийн үйлчилгээний орчин бий болсон байна.	СӨБ-д хамрагдаж буй хүүхдийн 1% хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эзэлж байна.	Зорилт бүрэн биелээгүй	Зорилт хэрэгжих шатандаа байна Хамаарах эрх зүйн заалтууд холбогдох хуулиудад тусгалаа олсон боловч практик хэрэгжилт шаардлагатай
3.2 Ердийн цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулах материаллаг, нийгэм, сэтгэл зүйн орчин болон багшлах хүний нөөцийн чадавхи бий болсон байна.	СӨБ-ын тухай хуульд ердийн цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамруулах тухай заалт орсон.	Эрхзүйн зорилт биелсэн Практик зорилт олон жилийн хугацаа шаардагдах төлөвтэй байна.	Зорилт хэрэгжих шатандаа байна Эрх зүйн заалтууд гарсан боловч тэдгээрийг хэрэгжүүлэх санхүүжилт, хүний нөөцийг тогтмол төлөвлөх шаардлагатай.
4.1 2006-2007 оны хичээлийн жилээс эхлэн хүүхдийн физиологийн нормативт нийцсэн хоол хүнсний хангамж бий болно.	2008 онд батлагдсан СӨБ-ын тухай хуулиар цэцэрлэгийн хүүхдийн хоолны мөнгийг төрөөс бүрэн даасан ба хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 1100 төг байхаар ЗГ-аас баталсан билээ.	Зорилт хэрэгжих шатандаа	Зорилт хэрэгжих шатандаа байна.
4.2 Цэцэрлэгийн ундны цэвэр ус, хоол хүнсний аюулгүй, эрсдэлгүй байдлыг хангах, чанарын баталгааны түвшин стандартын шаардлагад нийцсэн байна.	Хотын захын гэр хорооллын эрүүл ахуйн шаардлага хангаагүй цэцэрлэгүүдийг цэвэр, бохирын сүлжээнд холбох, угаалтуур суултуурын тоог нэмэгдүүлэх ажлыг дэс дараатай хэрэгжүүлж байна.	Хэрэгжих шатандаа явж байна.	Хэрэгжих шатандаа явж байна. Шинээр баригдаж буй цэцэрлэгүүд стандартын шаардлагад нийцэж байна.
4.3. Бүх цэцэрлэгийн бие засах байгууламж стандартын шаардлагад нийцсэн байна.	Цэцэрлэгүүдийн 50% нь стандартын шаардлага хангахгүй байна.	Зорилт бүрэн хэрэгжээгүй байна.	Хэрэгжих шатандаа байна
4.4. Цэцэрлэгийн барилгын болон сургалтын орчны стандарт бий болсон байна.	Орчны болон барилгын стандарт батлагдаж гараагүй байна.	Биелээгүй байна.	<b>Зорилт баримт бичгийн түвшинд бүрэн биелсэн.</b>

4.5. Цэцэрлэгийн тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг 2005 оны түвшнээс 1.7 дахин нэмэгдүүлсэн байна.	Цэцэрлэгүүдийн 60% нь тоглоом, хэрэглэгдэхүүнээр хангах ажил хийгдсэн байна.	Хэрэгжих шатандаа явж байна.	<b>Бүрэн хэрэгжсэн</b>
4.6 Засварлах шаардлагатай нийт цэцэрлэгийн 29.8 хувийг засварласан байна.	2009 оны байдлаар цэцэрлэгүүдийн 30% барилгын их болон урсгал засвар, өргөтгөлд хамрагджээ.	Тоон зорилт биелсэн	<b>Тоон зорилт бүрэн хэрэгжсэн</b>
5.1 Бага насны хүүхдийн хөгжлийн цогц стандарттай болсон байна.	БНХХ стандартыг 2 жилийн турш боловсруулж батлуулан 2011 оноос хэрэгжүүлж эхэлж байна.	Биелсэн	<b>Бүрэн биелсэн</b>
5.2 СӨБ-ын хүүхэд, багш нарт зориулсан 4-өөс доошгүй төрлийн багшийн гарын авлага, сургалтын материалтай болсон байна.	83 нэр төрлийн гарын авлага, материал гарсан байна.	Тоон зорилт биелсэн	<b>Бүрэн Биелсэн</b>
6.1 Жил бүр сургуулийн өмнөх боловсролын багш нарын 50.0-иас доошгүй хувийн мэргэжлийг дээшлүүлнэ.	Мэргэжил дээшлүүлэх сургалтын тайлангуудаас үзвэл нийт багш нарын 60% нь дараах төрлийн сургалтуудад хамрагджээ. (a)киррикулим төлөвлөлт; (b) заах арга зүй; (c) мэргэжлийн ур чадвар.	Тоон зорилт биелсэн	<b>Тоон зорилт биелсэн.</b> Жил тутам 1, 5, 10 дах жилдээ ажиллаж буй багш нарын МД зардлыг улсын төсвөөс дааж байна.
6.2 Цэцэрлэгийн үндсэн багшийг 100 хувь мэргэжлийн багшаар хангана.	Нийт багшийн 93.3% нь мэргэжлийн багш байна.	Хэрэгжих шатандаа байна.	Хэрэгжих шатандаа
6.3. Жил бүр 30 багшийг гадаадад мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах сургалтад хамруулна.	Орон нутгийн БСГ, ОУБ-ын хөтөлбөрийн хүрээнд багш нар цөөн тоогоор сурах аялалд хамрагдаж байна.	25% биелсэн	<b>Тоон зорилт биелсэн</b>
6.4. СӨБ-ын багш бэлтгэх сургуулиудын сургалтын агуулга, хөтөлбөр шинэчлэгдсэн байна.	Сургуулийн өмнөх боловсролын сургуулийн сургалтын үндсэн болон мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд шинэчлэгдсэн.	Биелсэн	<b>Хэрэгжсэн</b>
6.5. Шинэ стандартыг хэрэгжүүлэх сургалтын хөтөлбөр бий болсон байна.	Шинэ стандартыг хэрэгжүүлэх загвар сургалтын хөтөлбөрийг БСШУЯ батлан гаргасан байна.	Хэрэгжих шатандаа явж байна.	<b>Хэрэгжсэн</b> 2015 онд СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсэн
6.6. Цэцэрлэгийн бус СӨБ-ын болон цэцэрлэгийн туслах багш нарт зориулсан сургалтын модулиуд бий болсон байна.	Багш нар болон туслахуудад зориулсан 5 сургалтын модулиуд хэрэгжүүлсэн төслүүдийн хүрээнд боловсруулсан байна.	Хэрэгжих шатандаа явж байна.	<b>Хэрэгжсэн</b>

6.7 СӨБ-ын боловсролын менежментийн сургалтын модулиуд бий болсон байна.	Тусгайлан СӨБ менежментийн модулиуд боловсруулаагүй байна.	Биелээгүй	<b>Хэрэгжсэн</b> АХБ, ЯХИС-ийн төслийн хүрээнд 2 модуль боловсруулсан байна
7.1 Бага насны хүүхдэд зориулсан хүүхэд асрах төв, хүүхдийг ажил дээр нь болон гэрт нь харах, асаргаа сувилгаа, зөвлөгөө өгөх гэх мэт үйлчилгээний төрөл, хэлбэр, тоо олширсон байна.	Хүүхэд асрах болон тоглоомын төвүүд ийн тоо өсөж байгаа боловч энэ талаарх мэдээлэл хангалтгүй байна.	Хэрэгжих шатандаа	Зорилт хэсэгчлэн хэрэгжсэн 2015 оны байдлаар хүүхэд харах үйлчилгээний хууль батлагдсан гарч нийгэмд энэ төрлийн үйлчилгээ бий болсон.
7.2 Бага насны хүүхдийн үйлчилгээний стандарт, хяналтын механизм бий болсон байна.	2008 онд Стандарт хэмжилзүйн төв 0-17 насны хүүхдийн халамжийн байгууллагад тавигдах шаардлага стандарт баталсан.	Хэрэгжих шатандаа	БНХХ стандарт батлагдсан боловч хэрэгжилт зогссон.
7.3 Бага насны хүүхдийн салбар дундын удирдлага, мэдээлэл, үйл ажиллагааны нэгдмэл байдал бий болсон байна.	БСШУЯ-наас Бага насны хүүхдийн хөгжлийн цогц бодлого батлагдан гарсан боловч яам хоорондын удирдлага мэдээллийн нэгдмэл тогтолцоо бүрдэж чадаагүй байна.	Биелээгүй.	Зорилт хэсэгчлэн биелсэн  Салбар дундын мэдээллийн сан бий болсон

Хавсралт 1.1.2. “Төгсгөртэй хөгжил - Сургуулийн өмнөх боловсрол” үндэсний зөвлөгөөнөөс гарсан саналын матриц

Хугацаа	Сургуулийн өмнөх боловсролын санхүүжилт	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж	Стандарт, хөтөлбөр	Багшийн хөгжил	Сургалтын орчин, барилга байгууламж	Хүүхдийн хоол тэжээл, эрүүл мэнд, аюулгүй байдал	Үнэлгээ
